

САЙШААЛ ЗОХИОВ



**ЧИНГИС ХААНЫ
ТОВЧООН**

Чингис хааны товчоон I

Зохиолч: Б.Сайшаал

ISBN: 978-99929-4-662-8


© Энэхүү бүтээлийн эрх нь Монгол Улсын Зохиогчийн Эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг цахим хэлбэрээр түгээх эрхийг bookstore.mn цахим хуудас эзэмших бөгөөд зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн хувилах болон бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулах, ашиглахыг хориглоно.

www.bookstore.mn


Чингис хааны товчоон



Чингис хааны эш хөрөг




Монгол хааны төрийн бичиг




Их монгол улсын дайны хааны тамга - Чингис хааны хэрэглэж байсан аяга



Чингис хааны алтан дөрөө - Чингис хааны авд хэрэглэх эмээл



Чингис хаанд унд барьж байгаа зураг



С.Юй Баяны буулгавар



Төр захирагч гүнжийн тамга



Зарлигийн элчийн тамга





Юань улсын их жанжны дуулга

Хөрвүүлэгчийн үг

Үндэсний бахархал хэмээх тэр ард түмний өөрийн ухамсрыг хөгжөөн дэгжээж, эв нэгдлийг бататгагч хүчирхэг зүйл бий. Монгол туургатан үеийн үед цог алдар нь даяарт үл бүдгэрэх Их Чингис хааныхаа суу билигт шүтэж, хэзээ ямагт омог бахдал нэгдэж ирсэн билээ. Манай үндэсний бахархал болсон өөр олон гайхамшиг байх бөгөөд тэдгээрээс их хаантай шууд ба дам холбогдох нь цөөнгүй буюу. Эзэн богд Чингисийн суу алдар түүхэн туршид монгол үндэстний нэгдмэл зориг санааг тэтгэн мандаж байх гэгээн сүлд болон мөнхөд мөнхөрсөөр.

...

Тиймээс, бид Тэмүжин хэмээх нэгэн бодгаль хүний амьдрал, зорьсон гүйцэлдүүлсэн их үйл хэрэг, учир шалтгаан, дэлхийн түүхийг бүтээлцсэн хувь оролцоо зэргийг нь тодорхой зөв мэдэж байвал зохилтой. Ийм хэрэгцээг хангахуйц зохиол бүтээлийг манай өргөн олон уншигч эрэлхийлсээр байдаг билээ.

Чингис хааны тухайт ном зохиол, өгүүлэл нийтлэл дотоод гадаадад үлэмжхэн гарсны дээр нэг талыг барин өрөөсгөлөөр авч үзсэн зүйл цөөнгүй байх авч, мөн тухайн үеийн түүх нийгмийн их, бага учир холбогдлыг нарийвчлан шинжилж, голч нуруутай хандсан ном зохиол ялангуяа сүүлийн үес хэдэнтээ гарсан.

Чухам үнэнд ойртож, уншигчдын хэрэгцээнд нийцсэн, хамгийн дорвитой далайцтай бүтээлийн нэгийг Өвөр Монголын эрдэмтэн Сайшаал хорь гаруй жилийн өмнө бичиж “Чингис хааны товчоон” нэрээр хэвлүүлжээ. Тэр бээр Чингис хаан болон түүний орчмын

түүхэнд холбогдох бүхий л мэдээ сурвалж, дурсгалт бичиг хийгээд монгол, хятад, япон, орос хэлээрх судалгааны зохиол зэрэг нийт 210 илүү ном бичгийг шүүн нягталж, өөрийн нь тэмдэглэснээр “...хуудас бүрт нь хөлсөө дуслааж, үг бүрт нь эсээ шингээн” байж эл төгс зохиолыг туурвисан байна. Хэрэв мэдэгдээгүй байсан бичгийн дурсгал шинээр олдохгүй л бол, Сайшаал агсны шавхан үзсэнээс илүү Чингис хаанд холбогдох түүхийн баримт, мэдээ сэлт бараг үгүй л болов уу. Үүнийг тодотгох үүднээс, манай нэрт түүхч, академич Ш.Нацагдорж уг зохиолын талаар дэлгэрэнгүй үнэлж бичсэнийг дор эшлэсү.

Тэр бээр: Чингисийн тухай тун сүүлийн үед гарсан зохиолын дотор Өвөр Монголын эрдэмтэн Сайшаалын 1987 онд нийтлүүлсэн “Чингис хааны товчоон” хэмээх хоёр боть зохиол юм. Эрдэмтэн Сайшаалын энэхүү зохиол бол Чингисийн урьд хожид гарсан зохиолын дотроос хамгийн дэлгэрэнгүй том зохиол болно. Сайшаал Чингисийн намтар түүхэнд холбогдох бүх сурвалж, шинжилгээний зохиолыг бараг үлдээлгүй шавхан үзэж Чингис хааны намтрыг нарийвлан судалж, Чингис хааны Монголын ба дэлхий дахины түүхэнд гүйцэтгэсэн түүхэн үүрэг, эзлэх байр суурийг үнэн зөвөөр тайларлажээ. Сайшаалын зохиолын бас нэг сайн тал бол түүхэн он цаг, газар усны нэр зэргийг мөшгин мөрдөж тодруулан тайлбарлах, засаж залруулах талаар туйлын их чимхлүүр ажил хийжээ. “Чингис хааны товчоон” бол Чингис хааны судлалд гарсан асар томхон амжилт хэмээн зүй ёсоор үзэх зохиол болсныг сайшааж тэмдэглүүштэй (Ш.Нацагдорж, Чингис хааны цадиг, Улаанбаатар, 1991, оршилд) гэжээ.

Уг зохиолыг Өвөр Монголд нийт 5 удаа хэвлэсэн ба тэр бүрт хагас түмээс доошгүй хувиар гаргаж байжээ. Ийнхүү, нэгэнтээгүүр үнэхээр өргөн олны төдийгүй судлаачдын эрэлт сонирхолд нийцэж зохих ёсоор үнэлэгдсэн чамбай бүтээл болсон, нөгөөтэйгүүр манай уншигч олон энэ зохиолыг кирилл үсгээр хөрвүүлэн нийтлүүлэхийг олонтаа санал болгосоор ирсэн тул бид энэ удаагийн хэвлэлийг бэлтгэлээ.

Эл хөрвүүлгийг хийхэд баримтлал болгосон хэдэн зүйлийн талаар тодруулья. Үүнд,

Зохиогчийн найруулга, бичгийн ур чадварыг хадгалах үүднээс уг эхийг хөндөөгүй болно. Харин “Чингис хаан бол агуу их тун-шуай мөн” гэх мэт өгүүлбэрт оруулсан хятад үг өвөрлөгчдөд нэн ойлгомжтой боловч манай уншигчдад танил бусын дээр зохиогчийн илэрхийлэх гэсэн санаа зөв буухгүйд хүрэх тул бид утгачлан “их удирдагч” хэмээн сольж эхийг өөрчлөх ганц нэг тохиолдол гаргаснаа зориуд тэмдэглэе.

Манай уншигчдад ойлгомжтой болгох үүднээс нэлээд үгэнд хөрвүүлэгчийн тайлбар хийлээ. Тухайлбал, SireeeO буюу ширах гэсэн үгийг Өвөр Монголын зарим нутгийнхины ярианд “өв ширах” гэх мэтээр одоо хэрэглэсээр буй агаад бусад монгол хэл аялгуутан энэ үгийг хэрэглэдэггүй. Гэтэл, энэ нь манж хэлний “сираку” буюу үгчилбэл залгамжлагч, залгагч гэсэн үг юм. Мөн бодосч үзэл - материализм, хувьсангуй бодосч үзэл - диалектик материализм гэх мэт нэр томъёоны зүйлд тайлбар хийв.

Түүхэн сурвалжид гарах монгол газар ус болон хүний нэрийг хэвлэл нийтлэлд өөр өөрөөр бичсэн байдгийг бид “Монголын нууц товчоон”-ыг голлон барьж буулгав. Тухайлбал, Боорчи, Боорч, Зүчи, Зүч, Зөчи гэхчлэн бичдэг нэрийг Боорчу, Жочи хэмээх мэт.

Манай зөв бичих зүйн ээдрээтэй асуудал болон тулгамдаад өнөөг хүрсэн нэгэн зүйл бол гадаад үгийг зөв тэмдэглэх явдал юм. Ялангуяа, хятад үгийн бичлэг нэг мөр болоогүйн улмаас уншигч хүн угтаа нэг нэрийг хэдэн өөр нэр мэт ойлгох, эсхүл ойролцоо дуудлагатай өөр нэрсийг нэг ижил мэт хутган ухаарахад хүрдэг. Хятад хэлнээ амьсгалын түрэлттэй ба амьсгалын түрэлтгүй хамжих гийгүүлэгчид гэхэд л сийгэх, исгэрэх, исгэрч сийгэх гэсэн тус тус утга ялгадаг гурван өөр авиатай аж. Түүнийг орос, түрэгийн кирилл бичигтэн ц, ч, ж, цз, чж гэхчлэн ялган тэмдэглэжээ. Гэтэл, бид наад зах нь хэлний урдуур ба хойгуур үе хааж хэлэх “-нь” ба “-н” гийгүүлэгч, “и” ба “ы” эгшгийг ч ялгалгүй дур зор мэдэн бичсээр байна.

Монголчууд үндэснийнхээ бичгээр хятад үгийг эртнээс жигд цэгцтэй тэмдэглэж хэвшсэн байдаг бол өрнө дахинд хятад судлал хөгжихийн хамт латин ба кирилл үсэгтэн нар мөн л хятад үгийг бичих тогтсон журамтай болсон билээ. Харин манай үед “шинэ” үсгээр бичихүйд хараахан энэ талаар нэг мөр болж журамшсан зүйлгүй тул, бид одоохондоо бусад кирилл үсэгтний хэрэглэдэг журмыг барих нь зүйтэй гэж үзэв.

Зарим оноосон нэрийн хойно тийн ялгалын нөхцөлийг зурдасаар зааглан бичлээ. Жишээ нь, Ту Цзи-гийн, Шаньси-д гэх мэт. Учир нь зааглаж бичихэд зарим газар тухайн нэрийн эцсийн богино эгшгийг гээх, эсвэл үсэг нэмэх болж, тэгснээр мөнөөх нэрийн уг хэлбэр нь эвдрэх, ташаа ойлгогдох бэрхшээл бий. Ялангуяа, өөртөө танил бус харь хэлний оноосон нэрийн тийн ялгалтай хэлбэрийг уншсан хүн үндэс хэлбэрээр нь яаж бичих тухайд алдахгүй гэх газаргүй. Тухайлбал, Балхад гэж уншсан хойно энэ үг угтаа Балх юм уу, Балха-(г)ийн алинд нь өгөх оршихын тийн ялгалын нөхцөл залгасныг ялгахгүй, Варягийн гэдгээс цаад үг нь Варяг, Варя хоёрын аль нь байсныг харуут үл таних гэхчилэнг бодолцсон билээ.

Түүхэн хэрэг явдлыг үнэлж цэгнэхэд Марксч-Ленинч үзэл суртлын үүднээс хандсан үг өгүүлбэрийг арга буюу түлхэж оруулан тухайн нийгэм, цагийн аясыг дагуулсхийсэн зүйл эл зохиолд бий. Чингэхгүйгээр, ийм номыг хэвлүүлэхэд эрх мөхөстөхөөс аваад өчнөөн бэрхшээл учрах байсан нь гарцаагүй. Гэвч, энэ бол Чингис хааны тухай сэдэв Монголд хаалттай байсаар асан цаг үед Сайшаал агсан чин санааг барьж, зориглон эл их бүтээлээ туурвисан гавьяаг нь огтхон ч бууруулах зүйл биш ээ. Үүнийг мэргэн уншигчид зөвөөр тунгаах буй за.

Өдгөөгөөс арван хэдэн жилийн тэртээ, Хөх хотноо болсон Монгол судлалын Олон улсын эрдэм шинжилгээний нэгэн хурлын үеэр миний бие (Ш.Чоймаа) Сайшаал гуайтай нүүр учирч, Монгол судлалын тухай сэтгэл дэлгэж ярилцахуйд, тэр бээр хэвлэгдээд удаагүй байсан “Чингис хааны товчоон”-оо алд цэнхэр хадгийн хамт хайрлаж, энэ номыг Монгол улсад хөрвүүлж хэвлүүлбэл нэн сайнсан хэмээн дотночлон хэлж байж билээ. Түүнээс хойш хэдий он удсан боловч, мөхөс миний бие завдан ядсаар, сая л нэг хүндэлдэг эрдэмтнийхээ чухаг захиасы нь ёсоор болгож буй нь энэ ээ. Эрдэмтэн Сайшаал гуай маань тэнгэрт халиад цөөнгүй жил болсон хэдий ч сүнс сүлдэр нь монгол “за” андагарыг минь болгоох буй заа. Энэ тухай саяхан гэр бүл, үр хүүхдэд нь мэдэгдэж албан ёсны зөвшөөрөл авснаа хэлэх хэрэгтэй. Эл хөрвүүлгийг хийхдээ дээр дурдсанчлан зохиогчийн бичлэг найруулгын онцлогийг хадгалж, үг үсгийн алдаа мадаг гаргахгүйг хичээхийн сацуу уг зохиолд нэр дурдагдах аливаа түүхэн хүмүүсийн нэр цол, Монгол, Хятад, Тангуд, Дундад Ази, Кавказын орчмын олон газар усны нэр зэргийг кирилл үсгээр хэрхэн буулгаваас зохихыг эрэн, үүний тул “Монголын Нууц товчоон”, Рашид-ад-Диний “Судрын чуулган” хийгээд Чингис хаан болон Монголын их Эзэнт

гүрний үеийн түүхэнд холбогдох бусад сурвалж бичиг, судалгааны зохиолыг ашиглан, тэдгээрт буй латин, кирилл, монгол бичгээрх тэмдэглэл, галиглал зэргийг нэг бүрчлэн харгуулан нягтлах, түүхэн үйл хэргийг мөшгих зэргээр багагүй хүч хөдөлмөр зарцуулсан болно.

Ард түмнийхээ түүх соёлыг дээдлэгч - эрхэм уншигч та бүхэндээ Богд Чингис хааны тухай нэгэн гарамгай туурвилыг толилуулах боломж олдсонд туйлын баяртай буйгаа илэрхийлье.

Мөнх тэнгэрт мөр өгтөж

Монгол нэрийг даянд дархалсан

Эзэн Богд Чингис хааны

Энгүй их суу билиг

Уншигч абугай та бүхний

Удмын авьяасыг сэргээх болтугай

Кирилл үсэгт хөрвүүлсэн

МУИС-ийн профессор Шаравын Чоймаа

МУИС-ийн багш Магсаржавын Баярсайхан

МУИС-ийн багш Сангидоржийн Батхишиг

Зохиогчийн товч тодорхойлол

“Өмнөх үг” гэвэл зохиолын гол агуулга, зохион бичсэн өнгөрөлт буюу уншигчиддаа мэдэгдвээс зохих зүйлсээ бичдэг л шиг билээ. Харин миний энэ “Товч тодорхойлол” бол үнэн сэтгэлээ илтгэе гэсэн жирийн хэдэн үг болно.

Дэлхий ертөнцөд алдар нэрээ дуурсгасан монгол үндэстний агуу их баатар Чингис хааны түүх намтар миний гараар бичигдсэн явдал хэдийгээр надад авч хэлбэл энэ насны минь алдартай сайхан ажиллагаа болох боловч, үүнийгээ үй түмэн уншигчдын гарт бариулахад, хүндэт багш нар, ахмад түүхчид болон эрхэм олон эрдэмтдийн хасын ширээн дээр толилуулахад өөрийн эрхгүй зүрх түгшиж байна. Үнэнийг хэлэхэд, би түүхийн эрдэм мэдлэгийн хичээлийг сонсоогүй, түүхийн тусгай судлах ажлыг эрхлээгүй бөгөөд нэн ч түүх бичих төлөвлөгөө уулаас байгаагүй. Надад байдаг нэг л зүйл бол, зовж мунгинасан өлгий нутгаа, золтой заяасан монгол үндэстнээ хайрлах, түүнийхээ түүхийг бахархах сэтгэл хэзээд халуун цусанд минь уусч, хамаг судлаар минь эргэлдэн, амь насны минь цог зориг болж байдаг! Ийм нэгэн хүч зоригжуулал доор, түүх шастирыг, ялангуяа монгол үндэстнийхээ түүх шастирыг анхааран цуглуулж, чармайн суралцаар байж бага сага юм олж мэджээ. Ингээд “Монгол үндэстний түүхэн хүмүүсийн толь” маягтай юмыг оролдьё гэж, нөхөр Н.Алтанша бид хоёр далаад оны дунджаар туурвиж, карт бичих зэрэг ажлаас гардан хийсэн билээ. Энэ бол “Чингис хааны товчоон” гэсэн нэрээр уншигч та бүхэнд толилуулж бүхий тус номын эхлэлт ч болж мэднэ.

Бид хоёр, гурван жил шахмын цагийг зарцуулж, Монголын түүхэнд холбогдох гол гол бичиг материалыг урвуулж (орчуулж, сийрүүлж, харьцуулан нягтлаж – хө.), хэдэн мянган хүмүүсийн үйл явдлыг картлав. Энэхүү ажлынхаа явцад, бид нэг зүйлийн байдлыг олж анхаарчээ. Харин мань(бидний – хө.) картласан түүхэн хүмүүсийн үйл явдал нь хоорондоо маш тэнцүүргүй байлаа. Тухайлбал, заримынхи нь үйл явдал хэдхэн бадаг буюу хэдхэн үг төдий байхад зарим нь хэдэн арав, хэдэн зуун карт буюу хэдэн уут материалтай байв. Энэхүү бодот байдлыг үндэслэж, бид уулын төлөвлөгөөгөө цаг тухайд нь өөрчлөн, урт хугацаагаар материал хуримтлуулж, нөхцөл бүрэлдүүлэхийн хамт, материал нэлээд бүрэн болсон, гол бологч түүхэн хүмүүсийн намтарыг нь урьдаар бичвэл өргөн олон монгол уншигчдын тулгам хэрэгцээг ямар нэгэн хэмжээгээр ч болтугай түргэн шиг хангаж болох болов уу гэж үзэв. Түүнчлэн анх алхамд Юань улс байгуулагдахаас өмнөх гол хэдэн түүхэн хүмүүсийн намтрыг бичихээр шийдэв. Ингээд Чингис хааны намтарыг бичих ажлыг би гардан авч, Өгөөдэй, Гүюг, Мөнх гурван ханы намтарыг бичих ажлыг нөхөр Алтаншаа гардан авав. Энэ бол “Чингис хааны товчоон” гэгч номыг эхлэн бичсэн явц болно.

Чингис хааны намтар мэт тусгай зохиол харь хэл дээр, улсын дотоод гадаадад багагүй хэвлэгдэн тархагдсаар иржээ. Ялангуяа Чингис хааны тухай судлал аль эртнээс эхэлж, явах тутам гүнзгийрэн өргөжиж, одоо нэгэнтээ дэлхий нийтийн хэмжээний судлал болоод, Чингис хаан бол гагцхүү Монголын түүх, Дундад улсын түүхтэй холбогдох түүхэн хүн болохоор барахгүй, дэлхийн түүхтэй холбогдох түүхэн хүн гэдгийг тоо томшгүй судалгааны үр дүнгээр гэрчилжээ. Харин Чингисийн үрс болсон Монголчууд бидний хийвээс зохих явдлыг өөр хүн бидэнд хийж өгсөн байна. Санаа сайтай Монголчууд эдгээр харийн багш нарыг хэзээд мартдаггүй бөгөөд бахархан талархах сэтгэл маань баян сүргийн сүү шиг тал

нутаг даяарт цалгилж байдаг аа! Энд манийг зүхэн харааж, занан хорсох үүднээс бичсэн зүйлсийг багтаахгүй нь ч мөн ч зүйтэй хэрэг билээ. Гэвч харь хүмүүсийн судалж зохиосон зохиолын олонхи нь бараг товч намтар, товч танилцуулгын хувиар нийтлэгдэж байснаар үл барам, тэдгээр нь адил бус цаг үед адил бусын хүмүүс зохион бүтээсэн тул бүр өөр өөрийн үзэлт зорилго ба ашиг сонирхолоо тусгаж байжээ.

Монголын судалгаа дэлхий даяарт өрнөсөн тэр цагаас Монголчууд ч өөрийн түүхээ өөрөө бичих зориг санаагаа илтгэж байсан бөгөөд олон арвин ажлыг хийж байсан юм. Өвөр Монголд, чөлөөлөгдсөнөөс нааш, ялангуяа ойрын арваад жилд энэ талын ажиллагаа нь зуны сайхан цэцэг шиг өнгө мяралзуулан бадраад дэлгэрч байна. Урьдахи хүмүүсийн шургуу ажилласан эдгээр амжилт бол миний ажлын эхлэлт болсон бөгөөд толь болжээ. Өөрөөр хэлбэл, миний энэхүү өчүүхэн чармайлга бол дотоод гадаадын олон багш нар, эрдэмтэн нарын судалгааны үр бүтээлийг ашиглаж, монгол үндэстний соёлын далайд нэмэрлэсэн нэгэн дусал төдий билээ.

Өнөөдрийн монгол үндэстний гарамгай сэхээтэд Чингис мэтийн түүхэн хүнийг багтаасан монгол үндэстний түүхийг Марксын үзлийн онолоор жолоодуулж, шинжлэх ухааны аргаар задлан судалж, үнэн голч зөв оновчтойгоор тусгасан, дэлхий нийтийн судалгаанд хувь нэмүүр болохуйц бүрэн дэлгэрэнгүй түүхийн зохиолыг өөрийн хэлээрээ зохион бүтээх нь дамжиггүй бөгөөд энэ цаг ч мань өмнө харагдаж байна. Гэвч “Сүүлчийн ууцнаас урьдаарын уушги” гэсэнчлэн, соёлыг хүссэн монгол уншигчиддаа “ууц” барихаас өмнө, “уушги” ч болтугай дээжлүүлье гэж, хэдийгээр хир хэмжээнээс нэлээд хэтэрсэн ажиллагаа боловч өөрийн чадлыг гололгүй, багш эрдэмтэд ч дооглож домоглолгүй бурууг нь сургаж богиныг нь дээшлүүлэх байлгүй гэж бат итгэж, арай чамай эвлүүлснээ зоригтойхон хэвлэлд дэвшүүлж байгаа минь энэ билээ.

Тус номыг Чингис хааны “намтар” буюу “шастир” гэсэнгүй, “Чингис хааны товчоон” гэсэн учир буюу зохиолоо туурвин тохируулахад доорхи хэдэн талыг бодолхийлжээ.

“Намтар” буюу “шастир” гэдэг нь их төлөвдөө түүхийн явдлаар нь гол болгож, мөн түүний дэс дараагаар тэмдэглэдэг “он дараалсан хэлбэрийн намтар” гэж байдаг бөгөөд түүхэн хүмүүсийн үйл ажиллагаа, цог зориг ба орчин тойрныг нь түүхэн хэргээр нь гол баримт болгож, нэлээд дүрслэнгүй аргаар бичсэн “урлагчилсан намтар” гэж байдаг, бас цул эрдэм шинжилгээний судлалт, магадлалт дээр суурилагдсан “шүүмжлэл намтар” (буюу шастир) гэж байдаг байна. Энэ гурван зүйлийн хэлбэр бол бүр тус тусын тусгай тавилантай тул өөр өөрийн зорилго, голдлого(голлох тал - хө.), онцлог нь тодорхой байдаг бөгөөд уншигчдын хүрээ хэмжээ нь ч адилгүй байдаг аа. Монголчууд эрт дээд үеэс эхлэн түүх шастираа бичихэд өөрийн замаар замнаж, дурайсан мөрийг үлдээжээ. Энэ бол монгол үндэстний соёлын “гурван том оргил”-ын нэг гэж үнэлэгдсэн “Монголын Нууц товчоон”-оор үлгэр дууриал болгож, сүүл сүүлчийн түүхийн зохиолуудад уламжлагдаж байсан өвөрмөц хэлбэр болно. Тухайлбал, түүхийн бодот хэргийг уянгалж дүрслэх уран зохиолын аргаар тэмдэглэх, үлгэр домгийг түүхэн хэрэгтэй уран хавлагаар уялдуулж, ардын аман зохиолын хэлбэрийг түүхийн зохиолд шингээн ашиглах зэрэг арга хэлбэр болно. Хэн бүхний мэдэж байх ёсоор, эдгээр арга хэлбэрт бас хязгаартай тал байх нь ч дамжиггүй юм.

Энэхүү “Чингис хааны товчоон” гэдэг зохиолоо би түүх шастир бичих энгийн жам хуулийг

үндэстнийнхээ өв уламжлалтай уялдуулах явдлаар гол харалт болгож, нэгэн шинэ арга замыг сүвэгчилэхээр чармайжээ.

Энэ чармайлгын минь бодтой арга гэвэл, түүхэн хэргийг үнэн зөвөөр тусгахыг баг журамлаж магадлалт, тодлолтыг аль болохоор нарийн хянамгай хийж, түүхчлэн тэмдэглэх, үлгэрлэн дүрслэх, уянгалан чимэглэх, шүүмжлэн өгүүлэх, үүсгэл төгсгөлийг танилцуулах зэрэг аргыг уялдуулахаар чармайн ажилласан явдал болно.

Агуулгын талаар, Чингис хаан ба түүний нэгэн үеийн бүхий л түүхэн явдлыг бүрэн бүтэн шиг илтгэхийн төлөө, Чингис хаан ганц хүний үйл ажиллагаагаар хязгаарласангүй, харин түүний бүх үйл ажиллагаагаар гол хэлхээс болгож, түүнд холбогдох улс гүрэн, аймаг угсаа болон гол гол түүхэн хүмүүс жич чухал чухал газар орны нэрст хүртэл аль болохоор тодорхой ухагдахуунаар товч дөхөм бичиж танилцуулахаар чармайв. Энэ ач холбогдолоос авч хэлбэл тус зохиол нь “намтар”-ын хэмжээнээс өргөн шиг болох нь дамжиггүй хэрэг билээ.

Хэлбэрийн талаар, зохиолынхоо гол агуулгыг товойлгохын тулд зохиолоо гол түүх, дагалдвар (дэлгэрүүлсэн тайлбар - хө.) ба хавсраас (хавсралт болгон нэмсэн зүйл - хө.) ийм гурван байгууллаар тохируулав.

Энэхүү “дагалдвар” гэдгийг энгийн ном бичигт байнга хийдэг зүүлт тайлбараас баахан өргөн шиг туурвиж, зохиолын гол агуулгыг нөхвөрлөн төгөлдөржүүлэх нэгэн бүрэлдэхүүн болгов. Үүнд ууган баримт, судалгааны нарийн байдал, ээдрээтэй зүйл, чухал тайлбар жич зохиогчийн үзэлт зэргийг багтаав. Ийм зүйлийг тусгай байгууламжаар тохируулсан сайнтай газар бол, гол агуулгаа сунжруулалгүйгээр төвлөрүүлж, нөхвөрийн чанартай зүйлээ ч биеэ даасан байдлаар төгөлдөр шиг бичихэд ашигтай бөгөөд энгийн уншигчид ба тусгай судлан сонирхогчдын хэрэгцээ ба анхаарлыг аль нэгэн хэмжээнээ хамтад нь харгалзахад тустай юм. Энэхүү “дагалдвар”-ыг бүлэг тус бүрийн хойно нь тусгай сэдвээр байрлуулав.

Ийм нэгэн санааг илтгэхэд, хэрвээ түүхэн хүний намтар шастирыг бичдэг энгийн жам ёсны аль нэгийг нь шууд мөрдвөл, зорилгод хүрч чадахгүй нь ч мөн мэдээжийн хэрэг ээ.

Тиймээс, Чингис хааны “намтар” буюу “шастир” гэвэл арай явцуухан болох мэт. Ингээд “Чингис хааны товчоон” гэж нэрлэлээ. Энэ “товчоон” гэсэн үгийг “Монголын Нууц товчоон” гэснээс сэдэж, мөн түүнийг нь улируулан хэрэглэв. “Товчоон”

гэдэг үг бол эрт дээр үедээ “түүх” гэсэн ухагдахуунтай түрэг гарлын үг байсан нь одоо манай үе болтол “Нууц товчоон”, “Алтан товч”, “Эрдэнийн товч” мэт нэрээр хадгалагдаж иржээ. Орчин үеийн монгол хэлэнд энэ үг нь уг хэлбэрээрээ “хураангуй” гэсэн шинэ ухагдахуун өөд хэлбийсэн шинжтэй болоод байвч, Чингис хааны түүх адил өвөрмөц орчинд хэрэглэвэл, харин бас нэгэн онцгой ухагдахууныг оруулах мэт.

“Үг олдвол үхэр холдоно” гэсэнчлэн, товч тодорхойлол болох тул хэмжээндээ зогсвол хэрэгцээгээ хангаж, хэтэрхий нуршвал улиг болох байлгүй, за ингээд дуусгая.

Болхи зохиолыг минь унших уншигч бүхэнд чин сэтгэлийн талархлаа дэвшүүлье.

Зохиогчоос

1982 оны 8 сарын арван таванд,

Хөх хотноо

Нэгдүгээр бүлэг



Чингис хааны мэндэлсэн цаг үе

Нийтийн он тооллын мянга нэг зуун жаран хоёрдугаар он буюу хар морин жилийн зуны тэргүүн сарын арван зургааны улаан тэргэл өдөр¹, монгол угсааны² хиюуд ястан, боржигин овогтны язгууртан Есүхэй баатарын гэр Онон мөрний дэргэдэх Дэлүүн Болдог³ гэдэг газар нутаглаж байхад, түүний авааль гэргий Өгэлүн үжин ууган хөвгүүнээ төрүүлсэн байв.

Энэ хөвгүүн төрөхдөө баруун гартаа шагайн чинээ нөж атгаж төржээ. Үүнийг монгол хүний уламжлал заншлаар тайлбал, дайчин баатар хүний бэлгэ дэмбэрэл болно. Энэ хөвгүүнийг төрөхөд Есүхэй баатар Татар аймагтай байлдаж дийлээд Татарын түрүү Тэмүжин үгэ, Хори буха хоёрыг олзлон ирсэн явдалтай тохиолдсон тул энэхүү ялалтаа дурсгах зорилгоор сая төрсөн хөвгүүндээ “Тэмүжин” гэдэг нэрийг өгчээ.

Энэ хөвгүүн бол өөр хүн биш, харин Монголын тархай бутархай аймгуудыг анх удаа нэгтгэн, Дундад Азийн тэнэгэр уудам нутагт нүүдэлчин Монголын Хаант Улсыг тунхаглан байгуулж дундад зууны үе дэх дэлхий ертөнцийг монгол морины туурайгаар донсолгосон, монгол үндэстний агуу их баатар, “нэгэн үеийн тэнгэрлэг хөвгүүн” Чингис хаан гэгч мөн билээ.

1. Орчин дэлхийн байдал

Тэмүжиний төрсөн тэр цаг үе бол нийтийн он тооллын арван хоёрдугаар зууны сүүлчийн хагас үе байлаа. Энэ үеийг дэлхийн түүхэн хувиараар дундад зууны үе гэдэг. Дундад зууны үе бол хүн төрөлхтний нийгмийн үйлдвэрлэлийн хүчин маш хоцронгуй байсан бөгөөд олонхи улс үндэстэн нь феодалын байгуулалын ноёрхол доор, тархай бутархай балар бөглүү амьдарч байжээ. Ингээд улс үндэстэн, аймаг бүлгүүдийн хооронд алаан хядаанаар дүүрч байсан юм.

Арван нэгдүгээр зууны сүүлчийн үе (1095 он)-ээс үүсгэсэн загалмайн цэргийн дайралдаан Европ дахинд дэгдэж Христосын шашныхан ба Исламын шашныхан хоёул хоёулаа хохирсон байна. Мөн түүнчлэн Дорнод Ромын эзэнт улс доройтсоноос нааш, Европод хүчирхэг их нэгдмэл улс хараахан гарч илрээгүй байлаа. Оросын хязгаарт үй олон угсаа аймаг тус тусын

улс гүрнийг босгож, дайн дажин, дээрэм талхилаар дүүрч байлаа. Дундад дорнод ба баруун Азид мөн ч харилцан дайсагнасан Исламын шашинтан тус тус ноёрхож байжээ. Жишээлбэл, Туркийн Сельджук вант улс саяхан Гректэй бага Азийг булаалдан дайтаж байв. Дэлхийн эртний боловсон соёлт дөрвөн улсаар тооцогдогч алдарт “пирамид”-ийг бүтээсэн Египедийн ноёрхогчид Сири-ийг байлдан дагуулахаар цус урсгаж байв. Шагимунигийн мэндэлсэн орон Энэтхэгт шашны мөргөлдөөн ширүүнээр явагдаж байв.

Луужин, цаас хийх арга, хэвлэх арга ба дарь зэргийг хүн төрөлхтний түүхэнд анх үүдэн бүтээж, дэлхийн эртний боловсон соёлт улсын нэгээр алдаршсан дорно дахины том гүрэн Дундад улсын нутаг дэвсгэр дээр арван хоёрдугаар зууны сүүлчийн үеэр өмнөд Сүн улс, Алтан улс, Тангуд улс (баруун Ся улс), Хар Хятан (баруун Ляо улс), Төвд, Да Ли зэрэг төр гүрнүүд харилцан дайсагнан, бага буурай үндэстнийг доромжлон талхидаж, ард түмнийг гаслан зовлонгийн далайд тунаажээ.

Харин соёл боловсноор балар мунхгийг ялах, дайн дажныг зогсоож иргэний энх тайван амьдралыг батлах, улс гүрэн найрамдаж соёл боловсноо солилцох явдал, нэг л үгээр хэлбэл хүн төрөлхтний нийгмийг цаашид давшуулах явдлыг аль нэгэн улс үндэстний ард түмэн ч бүр хүсэж байдаг юм. Энэ бол хүн төрөлхтөний нийгмийн давших чиглэл болно.

Тэмүжиний төрсөн цаг үе - Монголын орчин тойрон ертөнц нь ийм л байлаа.

2. Чингисийн язгуур ба угсаа төрөл

Персийн алдарт түүхч Рашид-ад-Диний зохиосон “Судрын чуулган”⁴ (ойроос түүхч Иринчин нарын зохиолд “Түүхсийн чуулган” гэж бичих болжээ. Хэлэлгээнгүй, энэ нь судалгааны суурь дээр засагдсан нь яриангүй юм. Гэвч олонхи хүмүүс “Судрын чуулган” гэсэн нэрээр хэрэглэж нэлээд удсан тул уул нэрээр нь тэмдэглэв)-ы тэмдэглэлийг үндэслэвэл эрт урьдын цагт монгол үндэстэн нь өөр үндэстэн лүгээ ихээр дайтаж бүх цэргээрээ мөхөөсөн гэнэ (Үүнийг Түнгүс ван болон Хүннүгийн Мэ-доу Чан Юй-гийн хооронд болсон дайралдаан гэж түүхч Ту Цзи дурджээ). Ингээд Нуху (“Судрын чуулган”-д “Нүхүс - Нукуз” гэж, “Өмнөд Монголын хэргийн эх адаг” гэдэгт “Нуху” гэж, “Д’Оссоны Монголын түүх”⁵-д “Төгс” гэжээ), Хиюун гэдэг хоёр эр хүн хоёр эмтэйгээ үлдэж, Эргүнэ хунб гэдэг өн шимлэг бэлчээр, ус сайтай аглаг бартаат уул оронд нүүж нутаглан амьдарчээ. Тэр Хиюун гэгчийн үр хүүхэд нь өнөр олон болж, үе улиран олон зуун жил хөгжин үржиж, овог аймаг нь болсноос эднийг нийтэд нь хиюуд гэдэг гэлээ. Энэ бол “хиюуд ястан” гэсний ирэл болно. Хятад түүхэнд “Чи Во Вэнь” гэж нилээд ондоогоор галигладаг байна.

Хиюуд ястны аймгууд үржиж дэлгэрээд Эргүнэ хуны өлгий нутагтаа багтахгүй болж, тэдний доторхи нэгэн алдарт тэргүү Бөртэ чоно гэгч гэргий Гуа марал⁷-тайгаа аймаг угсаагаа дагуулж Онон мөрний эх ундрал болсон Бурхан халдун ууланд⁸ ирж нутаглан суужээ. Энэ бол Монгол үндэстний түүхийн ууган тулгар бичгийн нэгээр тооцогддог “Монголын Нууц товчоон” (хойш “Нууц товчоон” гэж товчлов)⁹-ыг дэлгэмэгц харагддаг “Чингис хааны язгуур, дээр тэнгэрээс заяат төрсөн Бөртэ чоно ажгуу, гэргий нь Гуа марал аж” гэсний ирэл (үүдэл – хө.) бөгөөд Тэмүжиний язгуур гарлыг харуулсан тэмдэглэл болно. Энэ тэмдэглэл нь хэдийгээр домгийн шинжийг хадгалж байвч одоохондоо бүр Чингисийн удам хэлхээ ба түүхэн хүний хувиар тооцогдож байна. “Нийтийн он тооллын долдугаар зууны үед, монгол

аймгийн хүмүүс түүний удирдагч Бөртэ чонын удирдлага доор, Хөлөн нуурыг гэтлэн баруунш нүүж, одоогийн Монголын өндөрлөгийн Хэрлэн гол, Онон мөрний сав газраар малжин нутаглажээ. Үүнээс хойш Хэнтий уулын орон нь Монгол аймгийн ажиллагааны төв болов” гэж Наньцзин Их Сургуулийн багш Цю Шу Сэнь түүхэн баримтаар үзэж тэмдэглэжээ.

Бөртэ чоно, Гуа марал тэргүүтэн Онон мөрний эхэнд ирж нутаглан суугаад бас олон зуун жил (зарим тэмдэглэлд таван зуун жил гэдэг) болж, түүний арван хоёрдугаар үе10 болоход Дува Сохор, Добун мэргэн гэдэг ах дүү хоёр байжээ. Энэхүү Добун мэргэн гэдэг дүү нь Алун гуа нэрт гэргийг авч Бүгүнүтэй, Бэлгүнүтэй гэгч хоёр хөвгүүнтэй болоод нас баржээ. Добун мэргэнийг нас барснаас хойно бэлэвсэн хоцорсон Алун гуа эр үгүй байгаад жирэмсэлж11, бас Бугу хатаги, Бугту салжи, Бодончар мунхаг гэдэг гурван хөвгүүнийг төрүүлжээ. Алун гуа хатнаас төрсөн энэ гурван хөвгүүнээс үүссэн аймаг төрлийг түүхчид “Ниругун Монголчууд” гэж нэрлэдэг байна. Эдгээр Монголчууд нь “Алун гуа-гийн ариун нуруунаас үүссэн болохоор Ниругун (Нуруун) гэж гэнэ. Энэ нь ардын аман зохиолын хэлбэртэй тайлбар байсан нь илхэн” гэж Өвөр Монголын Их Сургуулийн дэд профессор Иринчин орчимд дурдаж байсан (“Дундад улсын умар дахины угсаатнууд болон Монголчуудын угсаа язгуур”). Добун мэргэнээс төрсөн хоёр хөвгүүн (Бүгүнүтэй, Бэлгүнүтэй)-ий хойч үрс ба Монголын бусад угсаа овогтныг “Дүрлүгин Монголчууд”12 гэж нэрлэдэг юм. “Ниругун Монголчууд” гэж уул даваан дээрх Монголыг, “Дэрлэгин Монголчууд” гэж даваан доорхи Монголыг зааж байсан бололтой. “Дэрлэгин” гэдэг нь дэр гэснээс гаралтай магадгүй гэж мөн Иринчин болон Чю Шу Сэнь (“Юань улсын түүхийн тухай яриа”) нар үзжээ. Энэ бол шинэхэн дурдсан үзэлт бөгөөд нэлээд суурьтай сэдэлт гэж болмоор байна. “Дэрлэгин” гэдэг үгийг хятадаар “Дуо-лэ-жин” (Ту Цзи-гийн номд), “Та-эл-лэ-жин” (Юй баян-ы номд) гэж тус тус галигладаг. “Судрын чуулган”-ы оросчлогод “Дарлекин” гэж галиглажээ. Энэхүү эртний монгол үг нь харь хэлтний олон удаагийн галиглалтыг дамжаад дуудлага нь хувирсан байж ч бүр болох юм. Харин “Дүрлүгин Монголчууд” гэдэг нь Монголын эх газар - Онон, Хэрлэн, Туулын сав газар ба Алтай Хэнтийгээр нутагтай (“Даваан доор” буюу тал газар гэсэн ч болно) Монголчуудыг нэрлэдэг үг байсан ч магадгүй гэж би үзээд Ту Цзи-гийн галиглалыг баримтлав. Ингэж шууд нэрлэсэн нэр “Нууц товчоон”-д харагддагүй тул түүнийг сүүлчийн хүмүүс, тухайлбал Рашидийн үед нэрлэсэн нэр ч байж мэднэ. Монгол хэлний “Ниругун” гэдэг үг ариун гэсэн утгатай бөгөөд хувилгааны хойч хэмээн үлэтхэжээ(адилтгажээ – хө.). “Дүрлүгин” гэдэг үг энгийн хүн гэсэн утгатай, “Ниругун”-аас бусад Монголчуудыг бүр Дүрлүгин гэдэг байна” гэж Дундад улсын Тайвань мужийн түүхч Ли Цзэ Фэнь авгайн зохиосон “Чингис хааны шинэ намтар” (1970 оны хэвлэл) гэдэгт тэмдэглэсэн нь дээрх тэмдэглэл лүгээ эедэж байна.

Алун гуа хатны отгон хөвгүүн Бодончар бол Бөртэ чоноос доромш арван гуравдугаар үеийнх нь ач болох бөгөөд Чингисээс дээш арван хоёрдугаар үеийнх нь өвөг болно. Энэ Бодончар гэгч хэд хэдэн хатан буулган авч бас олон арван овог төрөл13 болон салбарласан байна. Үүнд, Бодончарын авааль гэргийгээс төрсөн хөвгүүн Хабичи баатар гэдгээс хойш уламжилсан залган төрлийг Монголын боржигин овогтон гэдэг. Энэ бол Тэмүжиний овог нь болох бөгөөд яваа яваандаа нийт Монголын хаан язгууртны гол овог нь болжээ.

Боржигин овогтны гол төрөл нь ийм байна. Хабичи баатарын ганц хөвгүүн нь Мэнэн Тудун, Мэнэн Тудуны ахмад хөвгүүн нь Хачи Хүлүгү, Хачи Хүлүгү-гийн ганц хөвгүүн нь Хайду, Хайду-гийн ахмад хөвгүүн нь Байшинхор догшин, Байшинхор догшины ганц хөвгүүн нь

Тумбиной сэцэн, Тумбиной сэцэний ахмад хөвгүүн нь Хабул хаан.

Хабул хаан долоон хөвгүүнтэй. Ахмад нь Охин Бархаг, хоёрдугаар нь Бартанбаатар, гутгаар нь Хутугту Мөнгүр, дөтгөөр нь Хотала хаан, тавдугаар нь Хулан баатар, зургадугаар нь Хадаан, долдугаар нь Төдүгэн Отчигин гэдэг.

Бартан баатар бол Тэмүжиний төрсөн өвөг эцэг нь болно. Бартан баатар дөрвөн хөвгүүнтэй, ахмад нь Мөнгэтү хиюун, хоёрдугаар нь Нэгүн тайж, гуравдугаар нь Есүхэй баатар, дөрөвдүгээр нь Даритай Отчигин гэдэг. Есүхэй баатар бол Тэмүжиний төрсөн эцэг мөн.

Бөртэ чоноос дорогш хорьдугаар үе, Тэмүжиний элэнц өвөг бол Хабул хаан болно. “Хамаг Монголыг Хабул хаан мэдэв” гэж “Нууц товчоон”-д гардаг билээ. Хэрэг дээрээ арван хоёрдугаар зууны эхээр Хабул хаан зөвхөн “Ниругун Монголчууд”-ыг анх удаа нэгтгэж, “хаан” цолыг эхлэн өргөмжилжээ. Нийтийн он тооллын 1137 онд, Хабул хаан 14 нас барах үедээ хаан ороо өөрийн долоон хөвгүүндээ уламжилсангүй, харин түүний төрлийн дүү Амбагай 15-д уламжлахаар гэрээслэсэн юм гэнэ. Амбагай хааны үе болж, Хабул хааны долоон хөвгүүн нь Татарчуудтай хичнээн удаа дайн байлдаан хийжээ. Тэр үед Алтан улсын ноёрхогчид “харийг хариар захирах” харгис төрийн бодлогоо хэрэгжүүлэхийн тулд Татар аймгийг өдөөн, Монгол аймгуудыг хооронд нь дайсагнуулж байснаар үл барам, зусар зальхай аргаар Амбагай хааныг баривчлуулж хэрцгий харгисаар тамлан алжээ (нарийн учрыг сүүлчийн бүлэгт үз). Амбагай хаан хорлогдсоны хойно, “Ниругун Монголчууд” Хабул хааны дөрөвдүгээр хөвгүүн Хотала-г хаан өргөмжилжээ. Хотала “Ниругун Монголчууд”-ын хаан орыг залгамжласан хойно, Амбагай хааны өшөөг авахын төлөө 1143 он (“Цзянь Янь-аас нааших жил бүрийн чухал тэмдэглэл” гэдэгт: Хуан-тун-ы долдугаар он 1147 он гэдэг)-д Алтан улсад биеэрээ цэрэглэж, Алтан улсыг ихээр ялж, хүчирхэглэлээр Алтан улстай эвсэн, Алтан улсаас жил бүр адуу мал, амуу будаа зэргийг татварлан авахаар болзож, Алтан улсын дарлалаас нэгэн үе ангижирсан байна. Хотала хаан бол “Бархирах дуу нь долоон нурууг донсолгодог, барилдах хүч нь амьд хүнийг салгадаг” тун их эрэлхэг баатар хүн байсан болохоор, тэр үед ард түмэн түүнийг магтан дуулж байжээ. Тэр бас Амбагай хааны өшөөгөөр Татар аймгийн нэг салбар болох Жүйн Татартай урьд хожид арван гурван удаа байлдсан боловч ер амжилт олсонгүй аж. Гагцхүү хар морин жил (нийтийн он тооллын 1162 он)-ийн байлдаанд ихээр ялж, Татарын түрүү Тэмүжин Үгэ, Хори Буха хоёрыг нь Есүхэй баатар олзолж ирэхэд нь Тэмүжин мэндлээд байсан нь тэр билээ.

Гэвч арван хоёрдугаар зууны дундуур, Алтан улсын ноёрхогчид нь “харийг хариар захирах” бодлогоо цаашид хэрэгжүүлж, Татарчуудыг их хүчээр өдөөн ашиглаж, монгол аймгийг довлон сарниулсан тул монгол аймгийн хаан ор нь тасарчээ. Ингээд Хабул хааны нэгтгэсэн “Ниругун Монголчууд” дахин сарнин бутарсан байна.

3. Чингисийн гэр бүл

Хотала хааны үед, Тэмүжиний эцэг Есүхэй баатар бол Хотала хааны цэргийн аравны ноён байж, олон удаагийн дайн байлдаанд гавьяа зүтгэлтэй явсан учраас сүүлдээ зууны ноён, мянганы ноён боллоо гэж зарим түүх шастирт тэмдэглэсэн харагддаг. Гэтэл түүхч Ту Цзи, түүний зохиосон “Монголын түүхэн тэмдэглэл” 16 (хойш “Ту Цзи-гийн тэмдэглэл” гэж товчлов) гэдэгтээ “Есүхэй бол эрэлхэг бөгөөд чадамгай дайчин болохоор баатар цолтой юм.

Есүхэй бол Хотала хааны үе дэх их жанжин нь бөгөөд `Ниругун` аймгийн бүх цэрэг дайны явдлыг тэр захирч байсан” гэж тэмдэглэжээ. Чингисийн эцэг Есүхэй баатар, уулын овог аймгийн бусад салбараас салж, тусгаараа овог болов. Түүний тойронд маш олон иргэн цугларчээ. ...Есүхэй баатар чухам ямар хүн бэ? Эрдэм боловсролтой нэгэн хятад түшмэлийн үзэхээр тэр бол “Аравтын ноён” болно. ...Рашид-ад-Диний үзэхээр, Есүхэй бол нэгэн “хаан” мэт байсан аж. Үнэндээ, энэ түүхч баахан ихэсгэн бичих арга (хэдийгээр тодорхой магадласан биш ч гэсэн)-аар Есүхэйг “хаан суусан”-аар өгүүлсэн байна. Тэгвэл Монголчууд өөрснөө юу гэж хэлдэг вэ? “Нууц товчоон”-д хэлснээр бол Есүхэй “хаан” биш бөгөөд “аравтын ноён” ч биш, харин нэгэн “баатар” байсан аж. Өөрөөр хэлбэл, өөрийг нь харшлагчдаас зоригтой хагацаж, хэрэгцээтэй хүмүүсээ орчин тойрондоо цуглуулан чаддаг хээр нутгийн язгууртан овгийн гаралтай баатар мөн гэж Зөвлөлтийн монголч эрдэмтэн Б.Я.Владимирцов тэмдэглэж байв. Хэдийгээр Есүхэй баатарын зэрэг тушаалын тухай өөр хангалттай тэмдэглэл хараахан харагдаагүй боловч, Есүхэй бол баатар хүн гэдэг нь маргаангүй юм. Есүхэй баатар бол арван гурван насандаа өвч хуягт хүмүүнийг шувт харван, унасан морийг нь авч унаж дутаан явдаг чадалтай гэдэг тэмдэглэл байдаг (“Хаадын үндэсний Эрдэнийн товч”). Харин Есүхэй баатар нэгэн эрэлхэг дайчин хүн болохоор барахгүй мөн ч төв голч, арга бодлоготой бөгөөд бусадтай бүлгэмдэж чаддаг хүн тул маш олон төрөл аймаг бүлэг нь ирж түүнд харьяалагдсан ба цөөн бус “гэрийн хүмүүс”-тэй болжээ (Ши Вэй: “Чингис хаан”, Сянган-ы хэвлэл, 4-р нүүр).

Хотала хаанаас хойш, түүний мандал хөгжилд нь харш тотгор бологч хэвшмэл хоцронгуй этгээдтэй тэмцэхийн төлөө, Есүхэй баатар удаан түүхтэй хуучны Боржигин овогтоосоо салан гарч, Боржигидын шинэ овог төрлийг өөрийн тойронд бүрэлдүүлжээ. Тэр өдий төдий анд нөхрийг холбоолж, ард иргэдийг хураан цуглуулаад, Онон мөрний эх дагуу тал нутгийн хамгийн хүчирхэг язгууртны нэг нь болсон байлаа. Ингээд Тайчигуд зэрэг түүний төрөл угсааны овог ястан ба ураг садан ах дүү нар нь бүр Есүхэй баатарыг аймгийн тэргүүлэгчээр өргөн дагаснаар барахгүй, Есүхэй баатар бас хүчирхэг их Хэрэйд аймгийн түрүү Тоорил хан (хожмын Ван хан) гэгчийг аюулаас аварсан (нарийн учрыг дараачийн бүлэгт үз)-аас Тоорил хантай анд болжээ.

Есүхэй баатарын айл гэрийнх нь байдлаас үздэг бол, хотондоо хотлох нэлээд мал сүрэгтэй, гэртээ зарах хэд хэдэн боол зардастай чинээлэг баян өрх байсан бөгөөд хэдэн гэргий авчээ.

Есүхэй баатарын авааль гэргий, Тэмүжиний төрсөн эх Өгэлүн үжин 17 бол Хонгирад аймгийн салбар Олхунуд овогтон болно. Анхандаа Мэргид аймгийн Их Чилэдү гэгч хүн Өгэлүн үжинийг Олхунудаас ураглан авч явах зам зуур нь Есүхэй баатар булаан авсан байна. Ингээд энэ нь Мэргид овогтон Боржигидтой өштөн болсны нэгэн шалтгаан болжээ.

Өгэлүн хатан Есүхэй баатартай ураглаад дөрвөн хөвгүүн, нэгэн охин төржээ. Ахмад хөвгүүн нь Тэмүжин, хар морин жилтэй, 1162 онд төржээ. Хоёрдугаар хөвгүүн нь Хасар (бас Жочи Хасар, Хавг Хасар гэдэг), Тэмүжинээс хоёр дүү, хөх бичин жилтэй, 1164 онд төржээ. Гуравдугаар хөвгүүн нь Хачигун, Тэмүжинээс дөрөв дүү, улаан нохой жилтэй, 1166 онд төржээ. Отгон хөвгүүн нь Тэмүгэ Отчигин 18 (түүх бичигт ердөө Отчигин буюу Отчигин ноён гэдэг), Тэмүжинээс зургаа дүү, шар хулгана жилтэй, 1168 онд төржээ. Ганц охин нь Тэмүлүн (бас “Тэмүлүн гуа” буюу “Түмүл-үн гуа - “Эрдэнийн товч” гэдэг). Тэмүжинээс долоо дүү,

шарагчин үхэр жилтэй, 1169 онд төржээ. Тэмүлүн гуа-г хожим нь Хонгирадийн салбар Ихирэс овгийн Буту-д мордуулсан байна.

Есүхэй баатарт бас нэгэн татвар хатан байжээ. Түүнийг “Нууц товчоон”-д зөвхөн Бэлгүтэйн эх гэснээс биш, нэр цол, нас жил, төрөл овгийнхи нь тухай тодорхой мэдээ байдаггүй билээ. Гэтэл манай түүхийн тулгар бичгийн нэг болох Лувсанданзаны зохиосон “Алтан товч” (хойш “Лу. Алтан товч” гэж товчлов)19-д “Есүхэй баатарын нөгөө гэргий Сочигил эх” гэжээ. Энэ Сочигил хатнаас хоёр хөвгүүн төржээ. Ахмад нь Бэгтэр, дүү нь Бэлгүтэй гэдэг. “Богд Чингис хааны цэдиг (одоогийн зөв бичлэг нь цадиг - эшлэгч)” (хойш “Чингисийн цадиг” гэж товчлов) гэдэг номд “Есүхэй баатар эцэг минү бөлгөө... Сүлжигин хатнаас Бэгтэр, Бэлгүтэй хоёр билээ. ...” гэжээ. Энд бичлэг жаахан зөрөөтэй боловч учир нь бүр адил байна(харин “Асрагч нэртийн түүх”-д “Мангил-ун” гэж нэлээд зөрөөтэй тэмдэглэж байв). Энэ Сочигил хатан хожим нь гурван Мэргидэд баригдаж, доромжлогдон зарцлагдсаар байв. Дараа нь Тэмүжин, Бэлгүтэй нар гурван Мэргидийг дарж, Бэлгүтэй эхийгээ аврахаар очтол, тэр зүүн үүдээр нь гарч: “Хөвгүүд минь хаад болж хэмээгдмүй. Би энд муу хүнд түгээж (өгөгдөж - хө.), өдгөө хөвгүүдээ нүүр хэр (хэрхэн) үзэх би” гэж гаднахи хүнд хэлээд шугуй дотор шургаж, эрж эс оллоо гэдэг билээ. Энд бас нэгэн тэмдэглүүштэй зүйл гэвэл түүхч Ту Цзигээс Бэгтэр, Бэлгүтэйн эхийг тайлбарлахдаа “Эрдэнийн товч”-ийн тэмдэглэлийг бүрмөсөн буруу ойлгож, буруугаар тайлжээ. “Эрдэнийн товч”-д: “Тэр Тэмүжин лүгээ нэгэн эхгэй Хасар, Хачигин, Отчигин дөрвөн хөвгүүн, Түмүл-үн гуа авхай ба Дагаши хатнаас төрсөн Бэгтэр, Бэлгүтэй хоёр лугаа зургуул болой” (“Эрдэнийн товч”, 57-р нүүр) гэжээ. Энд дурдсан “Гуа авхай” бол даруй Тэмүжиний охин дүү “Тэмүлүн гуа” болох нь огт сэжлэлгүй билээ. Гэтэл “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д: “Есүхэй баатарын авааль гэргий нь Түмүлэтэ гуа авхай хатан, Бэгтэр, Бэлгүтэй хоёрыг төржээ гэж “Эрдэнийн товч”-д өгүүлжээ. ... Энэхүү “Түмүлэтэ” гэдэг нь “Түмэд” гэсний өөр орчуулга болно. “Гуа авхай” гэдгийг “Нууц товчоон”-ы орчуулгын системээр бол (хобахай гэвэл зохино, 2-р боть, 5-р нүүр гэжээ) энд “гуа, авхай” гэсэн хоёр үгийг нийлүүлж “хобахай” гэсэн сонихон үг болгон, охиныг нь “гэргий” болгожээ. “Авхай” гэдгийг “охин” гэсэн утгаар одоо болтол хэрэглэж буй. Харин 1962 онд Тайвань-д хэвлүүлсэн “Чингис хааны дуулал” гэдэг уянгын хэлбэрт намтарт Есүхэй баатарын татвар хатныг “хобахай” (тус номын 437-р нүүр) гэсэн нь “Ту Цзи-гийн тэмдэглэл”-ээс ирэлтэй нь илхэн байна.

4. Монгол хэлтэн аймгуудын тойм байдал

Тэмүжиний төрсөн арван хоёрдугаар зууны сүүлчийн хагас үеэр, монгол үндэстний гол цогц болж байсан “Ниругун”, “Дүрлүгин” хоёр бүлэг Монголчууд Онон, Хэрлэн, Туул гурван мөрний дээд урсгал дагуу сав газраар нутаглаж байснаар үл барам Татар, Хонгирад, Жалайр, Хэрэйд, Онгуд, Мэргид, Ойрад, Найман зэрэг гол гол монгол хэлтэн аймгууд зүүнш Эргүнэ голын сав газар - одоогийн Өвөр Монголын Өөртөө Засах Орны Хөлөн Буйр аймаг, өрнөш Алтай нурууны баруун салбарууд дагуу өргөн удам нутаг, умарш одоогийн Зөвлөлт Холбоот Улсын Байгал нуур, Енисей мөрөн ба Эрчис мөрөн, өмнөш Гажил нуруу20 ба Урт цагаан хэрэм21 хүртэлх өргөн удам нутгаар эрт дээдээсээ олон мянган жил оршин тогтнож, аж төрөн амьдарч байжээ.

Монгол үндэстний өлгий нутаг болсон энэхүү Монголын өндөрлөг гэгч орон бол Азийн

дотоод хуурай болох тул уур амьсгал тэсгим хүйтэн, чийг бороон бага, салхи шуурга их байдаг ба байнга газар хөдлөх, умард туйлын гилбэлгээн үзэгдэх мэтийн байгалийн бэрхшээлтэй орон юм. Энд амьдарч байсан ард түмэн энэхүү байгалийн хүч бэрхшээлтэй үе улиран тэмцэж, шаргуу хатуу зориг, уян хатан аргаар өөрийн амьдралаа цогцлон байгуулсан билээ. Эдгээр гол хэдэн аймгуудын бодот нутаг байр нь ийм байна: Боржигин, Тайчигуд зэрэг Монголын төв аймгууд (дорогш “монгол төв аймаг” гэж товчлов)-ын зүүн талд Эргүнэ голын баруун эрэг ба Хөлөн, Буйр нуур орчмоос өмнөш Татар, Хонгирад зэрэг аймаг, “Монголын төв аймаг”-ийн өмнө талд Урт цагаан хэрэмээс хойш Онгуд аймаг, “Монголын төв аймаг”-ийн баруун өмнө талд Орхон, Туул хоёр голын урсгал дагуу Хэрэйд аймаг, Хэрэйдээс цааш Алтай дагуу Найман аймаг, “Монголын төв аймаг”-ийн баруун талд Сэлэнгэ мөрний урсгал дагуу Мэргид аймаг, “Монголын төв аймаг”-ийн баруун хойд тал буюу хойд талд Байгал нуураас баруунш Ойрад аймаг, “Монголын төв аймаг”-аас хойш буюу зүүн хойд шиг талаар Жалайр аймаг, Байгал нуураас зүүн тийш Баргужин Төхөмөөр Баргуд зэрэг аймгууд тус тус байрлан нутаглаж байжээ (зураг 15-ыг лавлаарай). Эдгээр аймгуудыг түүх шастирт ерөнхийд нь хоёр зүйлээр ялгадаг билээ. Тал газраар нутагласныг нь “Талын иргэн” (буюу талын ард), ой шугуйд газраар нутагласныг нь “Ойн иргэд” (буюу ойн ард) гэдэг. Талын иргэд нь их төлөв мал аж ахуйг, цөөвтөр нь тариаланг эрхэлдэг бөгөөд зарим мал сүрэггүй Монголчууд нь загас жараахай шүүх, зурам тарвага агнах, таана мангир түүх зэргээр амь зуудаг байна. Тэд бараг бүр эсгий туургат монгол гэрт сууж бэлчээр усыг даган нүүдэллэн малжиж явдаг бөгөөд Алтан улсын хил орчим суусан ард нь тогтсон газарт Алтан улс лугаа зах дэлгүүр нээж, адуу мал ба малын ашиг шим жич тал нутгийн гаралтаараа дотор газраас ялангуяа хятад үндэстнээс бөс бараа, торго дурдан, цай идээ ба төмөрлөг багаж хэрэгсэл зэргийг арилжин авчирч үйлдвэрлэл амьдралдаа хэрэглэдэг болохоор Талын иргэд нь Ойн иргэдээс нэлээд соёлжингуй байсан нь ч зүйтэй юм.

Ойн иргэд нь голдуу умард этгээдийн балар шугуйт орнуудад нутаглаж байжээ. Тэд их төлөв ан гөрөө хийх ба загас жараахай шүүхээр амьдралын гол ирэлтээ болгодог. Зарим нь буга хандгайг сурган эдэлж унаа хөлбөрөө болгодог. Тэдний олонхи нь үйс (цагаан хус модны хальс)-ээр бүрхсэн овоохой буюу гөрмөл бүрхээ (хөнгөн оромж - хө.)-д суудаг, нүхэн гэрт суух ч буй. Тэд байнгадаа ан гөрөөний арьс ширээрээ талын иргэдийн мал аж ахуйн шим гаралтыг арилжин хэрэглэдэг. Тэд соёлын талаар талын иргэдийг бодвол нэлээд хоцронгуй байжээ.

Эдгээр аймгийн бүлгүүдийн удам угсаа ба үүсэл гарлын талаар дотоод гадаадын эрдэмтэд янз бүрээр сүвэгчилцгээсээр буй. Гэтэл арван хоёрдугаар зууны сүүлээр, эдгээр аймаг бүлгүүд нь их төлөвтөө бүр монгол хэлний янз бүрийн нутгийн аялгуунуудаар хэлэлцэж байсан нь тодорхой байна. Ингээд бид түүнийг монгол хэлтэн гэжээ. Орчин үеийн хэлний шинжлэлийн аймаглалаар бол эдгээр аймгууд бүр алтай язгуурын монгол төрлийн хэлтэн болно.

Монголын олон аймгууд нь тэдний нийгмийн байгууллын нөлөөнөөс болж, хоор хоорондоо хэрцгий балмад дайн байлдааныг урт хугацаагаар үргэлжлүүлжээ. Ийм дайн байлдааны улмаас хүн ам тоо томшгүй үрэгдэн сүйдэж, аж ахуйн гол цогц болсон мал хөрөнгө их хэмжээгээр хохирч, Монголын нийгмийн үйлдвэрлэлийн хүчний хөгжлийг ноцтойгоор саатуулан, эл аймгуудыг мөхөл доройтлын ирмэгт хүргэжээ.

Монголын эл аймгийн хооронд урт хугацаагаар явагдсан энэхүү дайны шинж шалтгааныг багцлаад хэлбэл:

Нэгд, овгийн байгуулалаас үлдэгдэж ирсэн зөвхөн өшөө хорслын төлөө алан дайсагнах явдал мөн ул мөрөө үлдээж байжээ.

Хоёрт, тухайн үеийн Монголын нийгмийн хөгжлийн шат үеэр тайлбарлагдана:

Арван хоёрдугаар зууны үед Монголын нийгмийн овгийн байгуулал задарч, хувийн өмчлөл буй болж, ангийн ялгал илрэн, тал нутагт анхны феодал язгууртан буй болсноос ийм дайн үүсэхгүй байж үл чадах бөгөөд тэр дайн нь энэ үед улс төр, аж ахуйн шинж чанартай болжээ.

Гуравт, Монголын эл аймгийн хоорондохи дайн тасраагүй үргэлжилж, түүнчлэн явах тутам гүнзгийрч байсны бас нэг тун чухал шалтгаан гэвэл, тухайн үед Дундад улсын умар хагас шахмыг ноёрхож байсан Жүрчин үндэстний ноёрхогч ангийн төр - Алтан улсын харгис төрийн бодлоготой шууд холбогдолтой юм. Тэр үед Алтан улсаас умар дахины үндэс угсаатанд хэрэгжүүлж байсан төрийн бодлого бол “харийг хариар захирах” явдал болно. Тэд монгол аймгуудыг мөхөөн, өөрийн хүчээ ихэтгэхийн төлөө, үргэлж эл аймаг бүлгийг хатган завсардуулж, өдөөн дайсагнуулдаг байна.

“Одтой тэнгэр орчиж

Олон улс байлдаж

Орондоо унтах завгүй

Олзлон булаалдаж байв.

Хөрст дэлхий хөрвөж

Хөвчин улс хямралдаж

Хөнжилдөө унтах завгүй

Хөнөөлдөн тэмцэж байв”

(“Нууц товчоон”, 254-р зүйл) гэсэнчлэн Тэмүжиний төрсөн цаг үеийн онцлог яг ийм л байсан юм.

Тиймээс, эл халыг (бэрхшээлийг – хө.) ханатал амссан Монголын ард түмэн дайн дажинаас жигшиж, улс аймаг нэгдэн найрамдаж, энх тайвнаар аж төрөхийг хүсэн эрмэлзэж байлаа. Энгийн харц иргэд байтугай, тэр үед шинэхэн мандсан феодал язгууртан ч өөрийн ашиг сонирхол ба цаашдын хөгжлийнхөө төлөө мөн ч улс төрийн талаар нэгдэж хүчирхэг их улс төрийн төвийг байгуулахыг зорьж байв.


Багцлаад хэлбэл, Монголын эл аймгийг нэгтгэх явдал бол тухайн үеийн нийгмийн хөгжлийн хэрэгцээ ба гол шаардлага нь болжээ. Энэхүү агуу их үйлсийг бүтээхэд юуны урьд их

бодлогыг бүрдүүлсэн, хүчирхэг их сүр хүчин бүхий шалгарсан удирдагч хэрэгтэй байлаа. Есүхэй баатарын гэрт саяхан төрсөн нярай хөвгүүн Тэмүжин харин энэхүү эрин үеийн баатар төлөөлөгч нь болжээ.

Дагалдвар

1 Энд Чингис хааны төрсөн цагийг Лувсанданзаны зохиосон “Алтан товч” (Монгол Улсын 17 дугаар он - 1937 оны Улаанбаатарын хэвлэл)-ийг баримталж тэмдэглэв.

Түүх шастирт Чингис хааны нас барсан цаг нь бүр зөрөөгүй бөгөөд тодорхой баримттай юм. Тэр нь улаагчин гахай жил буюу нийтийн он тооллын 1227 он болно. Гэтэл Чингис хааны төрсөн цагийн тухай хэд хэдэн зүйлээр тэмдэглэж байна. Гол нь 1162 он буюу 1155 он гэдэг. Бас 1154 он (“Монгол Татарын тухай бүрэн тэмдэглэл”-д) болон 1167 он (П.Пеллиогийн өгүүлэлд) гэдэг ч буй. Дундад улсын тэмдэглэлд олонхи нь бүр 1162 оныг баримтладаг байна. Үүний ирэл гэвэл, “Юань улсын түүх, Тайцзу-гийн шастир”-т: “Хорин хоёр он, улаагчин гахай жил (1227 он), намрын долоон сар, шарагчин үхэр өдөр хаан халив. Насан сүүдэр жаран зургаа” гэсэн тэмдэглэл байдаг. Үүнээс ухруулж бодоод Чингис хааныг 1162 онд төрлөө гэсэн тэмдэглэл үүсчээ. Бас “Монголын нууц товчоон”-д Тэмүжиний насны тухай нэгэн тэмдэглэл гэвэл, Есүхэй баатар нас барахад Тэмүжин есөн настай байсан гэжээ. Үүнийг Сүн улсын Шоцзун хааны Цянь Дао-гийн зургадугаар он (1170 он) гэж Ли Вэнь Тянь “Нууц товчоон”-ыхоо тайлбарт тэмдэглэжээ. Үүнээс ухруулж бодвол мөн ч 1162 он болно. Бас “Богд баатарын биеэр дайлсан тэмдэглэл” (энэ бол Юань улсын үед нэрээ үлдээгээгүй нэгэн түүхчийн зохиосон “Чингис хааны цэрэг дайны товч түүх” болно. Хятадаар “Шэн У Чин Жэн Лү” гэдэг. Манжийн хааны бас “Шэн У Жи” гэж буй. Тиймээс “Богд баатар” гэж орчуулсан нь арай тодорхойгүй болжээ. Гэвч тус товчоонд Манжийн хааныхыг ашигласангүй болохоор уул орчуулгын нэрийг үлдээж, дорогш “Биеэр дайлсан тэмдэглэл” гэж товчлов) гэдэгт, харагчин гахай жил (1203 он), Хэрэйдийн Ван ханыг мөхөөсөн тэр жил Тэмүжин дөчин хоёр настай байсан гэжээ. Үүнээс ухруулж бодсон ч мөн л 1162 он болно.



Монгол аймгуудын нутаг байрын тойм зураг

【据新华社莫斯科6日电】蒙古历史上最著名的人物成吉思汗的诞生地，蒙古早期历史文学巨著“蒙古秘史”上所說的翰难河畔的迭里温李勒答黑，已經由苏联科学院通讯院士基谢廖夫率领的一支考察队找到了。考察队在这里还发现了許多可以作为证明的古代文物。他們的發現初步解答了这个长期以来沒有确定答案的問題。

水流充沛、奔腾迅疾的翰难河就在苏联赤塔州，离蒙古人民共和国东北边界不远的地方，現在在中国被譯为鄂嫩河。去年在这条河兩岸出現了一支由通讯院士基谢廖夫领导的考察队，他們在这里探寻了蒙古国家形成的历史和蒙古偉大軍事統帥成吉思汗生活有关的历史遺迹。

19世紀中叶布里亚特一蒙古著名学者多尔济·班项罗夫在研究了地名的历史来源之后，曾經肯定成吉思汗是誕生在鄂嫩河区域，在一个名叫迭里温李勒答

苏联一支考察队

找到了成吉思汗誕生地

黑的地方。考察队决定証明这个意見是否正确，試圖找出成吉思汗出生的地方。

在鄂嫩区中心一个叫奈苏色伊的村庄里，考察队遇到一个叫华西里耶夫的老人，他出生的地方叫做洪里温。这和班哈罗夫所說的成吉思汗誕生地名的前半节完全一样。迭里温在鄂嫩河畔，离区中心有6公里。

到了这个地方，考察队一下就了解了迭里温李勒答黑这个名称后半截的来历。“李勒答黑”在布里亚特語的意义是起伏不平的意思。这一带的确都是起伏的山嶺，山崗上長着許多松林。和当地的居民一談，考察队立即听到許多关于成吉思汗的傳說。这些傳說数量很多，而且是一代代傳下来的。

在鄂嫩河岸上有一座山，名叫巴圖尔，意思是勇士山，山上有一塊石头，上面有一个形如茶杯的深窩，随时都蓄满了雨水，这个茶杯叫做“成吉思汗茶杯”。

Чингис хааны мэндэлсэн газрыг олсон мэдээ

کتاب

جوامع التواريخ

تالیف

رشتیدالدین فیض اللہ وزیر اعلیٰ ہندوستان اور سابق وزیر اعلیٰ ہندوستان
بن موقوفہ دولت علیہ دہلی سنہ ۷۰۴ ہجری

جلد دوم


دربار پنج بادشاہان مغول از لوگانی تا آنگا تیمور قانات

بسمی و اہتمام و تصنیف اقل التعداد

از کاتب بلوچ شرف نسوی

در مطبعہ بریل دہلی دہلی آریلا دہلا ند تبیع رسید
سنہ ۱۳۲۹ ہجری مطابق سنہ ۱۹۱۱ مسیحی

"Судрын чуулган"-ы перс хэвлэлийн нүүр



"Монголын нууц товчоон"-ы хятад галигийн нэгэн хуудас

Тэмүжинийг 1155 онд төрлөө гэдгийн уг ирэл нь “Судрын чуулган”-ы тэмдэглэл болно. “Чингис хаан ба түүний эцгийн үед зурхайчид одон орныг шинжлэх аргаар цагийг тогтоож чаддаггүй байсан болохоор түүхчид он, сар, өдрийг тэмдэглэсэнгүй. Тиймээс түүний (Чингисийн - эшлэгч) төрсөн өдөр цагийг лавтай мэдэхийн аргагүй, зөвхөн Монголын ван нар, ноён сайд нарын яриа ба хүмүүсийн яриаг үндэслэвэл, тэр далан хоёр жил амьд сэрүүн явсан бөгөөд далан гурван настайдаа үхжээ. Зурхайчдын хэлэхээр түүний нас барсан нь гахай жилийн намрын хоёрдугаар сарын арван таван гэлээ. Энэ жил бол түүний төрсөн далан гуравдахи гахай жил болно” (О.Н.Смирновын дэвтэр, 75 нүүр) гэж Рашид-ад-Дин тэмдэглэжээ. Харин Рашидын тэмдэглэл ба Пеллиогийн “шинэ ололт” нь баримтгүй гэдгийг 1962 онд Өвөр Монголын Их Сургуулийн нөхөр Чжоу Цин Шоу нарийн магадлаж, тодорхой задалж бичсэн.

Бид энд “Лу. Алтан товч”-ийн тэмдэглэлийг баримтласан учир гэвэл, “Лу. Алтан товч” нь хэдийгээр нилээд сүүл үед зохиогдсон зохиол боловч, түүнд “Нууц товчоон”-оос бараг гуравны хоёр хувь шахам (1-176, 201-264, 266, 268 зэрэг зүйлүүд)-ын уг агуулгыг бүрэн

тэмдэглэж байхыг үзвэл, “Лу. Алтан товч”-ийн зохиогчид “Нууц товчоон”-ы нэлээд төгөлдөр шиг уйгуржин хуулбар байсан нь илэрхий байна. Тиймээс хятад үсгээр галигласан эхэд байгаагүй зүйлийг бидэнд тэмдэглэн үлдээжээ. Бас монгол хүн өөрөө зохиосон Саган сэцэний “Хаадын үндэсний Эрдэнийн товч”-д Тэмүжин шим морин жил төрлөө гэж тодорхой тэмдэглэж байна.

“Шим” гэдэг бол хятад хэлний “жэнь” үсгийг тэр үеийн жамаар авиачилсан бичлэг байна. Энэ нь хар морин жил буюу нийтийн тооллын 1162 он болно. Эдгээр монгол тэмдэглэл нь бүр хятад тэмдэглэлтэй нийцэж байдаг юм. Үзэмчин түүхч Гомбожавын зохиосон “Гангын урсгал”-д: “Суут богд Чингис хаан усан морин жилтэй, дөчин таван өлзийдээ гал барс жил ... хаан суув” гэжээ. “Асрагч нэртийн түүх”-д:

“Үүдэн ирсэн Чингис нэрт хөвгүүн. Усан морин жилийн зуны тэргүүн сарын арван зургаанаа. Ононы Дэлүүн Болдогт төрсөн болой” гэжээ. Энэхүү “усан морин жил” гэдэг нь бас “хар морин жил”, нийтийн он тооллын 1162 он болно. “Гал барс жил” нь даруй “улаан барс жил” буюу 1206 он болно. “Ус”, “гал” гэж таван махбодоор жилийн өнгийг ялгах нь төвд ёсны тоолол болно. “Улаан тэргэл” өдөр гэсэн нь билгийн улирлын сар бүрийн арван тавны орчим наран саран хоёр 180 градуст зэрэгцэж, бие биеэ үздэг болохоор сар бүрийн тэр өдрийг “тэргэл өдөр” гэдэг юм. Чингисийн төрсөн цагийн тухай 1962 онд Чжоу Цин Шоу, Шао Сюань Чжэн хоёр нөхөр тусгай өгүүлэл бичиж, “Соёл, түүх” сэтгүүл ба “Түүхийн судлал” сэтгүүлд тус тус нийтлүүлж байсан нь манай үзэлтэй бүр адил юм.

2 “Монгол” гэдэг нэрийг эрт өдгөө, дотоод гадаадын эрдэмтэд тун сонирхон судалж, янз бүрийн хэллэгүүд дурдагдсаар байна. Эдгээр хэллэг нь бүр өөр өөрийн “үндэс баримтлал”-тай боловч ерөнхийдөө зүйчилсэн жишилтийн хүрээнээс мултраагүй гэлтэй. Эдгээр хэллэгийг энд нэг нэгээр нуршихыг больё. Харин энэ тухай төвлөрөнгүй дурдсан одоо үеийн судлагчдын зохиол гэвэл: Тогтохын зохиосон “Өвөр Монголын хөгжлийн тойм” (Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 1957 оны хятад хэвлэл), Дорнотивийн шинээр орчуулж тайлбарласан “Монголын Нууц товчоон” (Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 1979 оны хятад хэвлэл), Монгол улсын Ц.Хасдоржийн зохиосон “Монгол гэдэг нэрийн тухай” (“Монгол хэл бичиг” сэтгүүлийн 1980 оны тавдугаар хугацаа) зэргийг дурдаж болно.

“Монгол” гэдэг нэрийн тухай судалгаа нь ерөнхийдөө тус үгийн гарал, үгийн утга ба хэдийд буй болсон зэрэг гурван талыг хамарч байна. Түүхчид янз бүрийн бодтой асуудал дээр, ялангуяа зангилаа чанартай асуудал дээр ингэж нарийн судлах нь эрдэм шинжилгээний ажилтны нарийн хянамгай шинжлэх ухаанч овор суртал ба арга барилыг харуулж байх нь дамжиггүй хэрэг ээ. Гэвч ийм нэгэн бодтой асуудал дээр, янз бүрийн жишилтийг хязгааргүйгээр үргэлжлүүлэх явдал ямар их ач холбогдолтой болох нь хараахан үзэгдэхгүй байна. Харин дотоод гадаадын улс аймаг ба үндэс угсаатны нэр дуудлагыг анхаарч байвал, зарим нь ямар нэгэн түүхэн тэмдэглэл ба домог яриагаар тайлбарлагддаг, гэтэл зарим нь тийм тодорхой тайлбарлалгүй, зөвхөн заншлын хуулиар уламжлагддаг байна. Зарим нь үүсэхийн үедээ ямар нэгэн бодтой утга агуулгыг харуулж байсан боловч, түүхийн урт удаан урсгал дунд яваа яваандаа хийсвэржсээр зөвхөн нэгэн нэрийдлийн төдий болоод хоцордог юм. Аль олон судлалын дүнгээс үзвэл, “Монгол” гэдэг нэр харин иймэрхүү шинжтэй болоод байх мэт. Тиймээс бид тус товчоонд үүний тухай олон материалыг дахин нэг сийрүүлж,

түүний дээр бас өөрийн жишилтийг нэмэрлэе гэж зорьсонгүй шалтгаан нь энэ билээ.

3 Чингисийн төрсөн газрыг хэдийгээр “Онон мөрний Дэлүүн Болдог” гэж тэмдэглэж байдаг боловч энэ газрын бодтой байр нь чухам хаагуурхан байдгийг түүх сударт ер тодорхой тэмдэглээгүй юм. Урьд Монгол Улсын Судар Бичгийн Хүрээлэнгийн дарга Жамьян 1928 онд Чингисийн төрсөн газрыг эрэн олохоор Онон мөрнийг даган сурвалжилж “Дэлүүн Болдогийг сурвалжилсан нь” гэсэн тэмдэглэл үлдээжээ. Үүнд одоогийн Хэнтий аймгийн Дадал сумын “Турван нуур” гэдэг газрыг анхааран тэмдэглэжээ. “Болдог” гэдэг бол “Довцог” гэж Б.Я.Владимирцов тайлжээ.

Онон мөрөн бол одоогийн БНМАУ-ын зүүн хойд хэсэг ба ЗХУ-ын Чита мужаас өмнөш хөндөл урсч бүхий Номхон далайн усан системийн том голыг хэлдэг. Түүний бүх урт нь 808 км. Харин Чингисийн мэндлэсэн Дэлүүн Болдогийг Зөвлөлтийн ШУА-гийн сурвалжлагч гишүүн Киселев түрүүтэй шинжилгээний анги шинжилж олов гэж 1958 оны 4 сарын 7-нд Дундад улсын Синхуа хороо мэдээлсэн байна (зураг 16-г лавлаарай). Тус мэдээнд тэмдэглэсэн нь:

Дэлүүн Болдог гэдэг газар бол Онон мөрний хөвөө, төв районоос зургаан километр зайтай байна. Шинжилгээний анги нь тэр газар хүрмэгц Дэлүүн Болдог гэдгийг “Болдог” гэсэн үг бол дов толгойг заасан нэр болохыг олж мэдэв. Энэ газар үнэхээр арвин довцог байх бөгөөд довцогууд дээр нь нарс мод арвин ургаж байна. Шинжилгээний анги, энд оршин суугчидтай ярилцаж байгаад Чингис хаанд холбогдох домгийг арвин олж сонсов. ... Онон мөрний хөвөөнд Баатар гэдэг нэг уул байдаг. Уул дээрх нэг хаданд аяга шиг ором хонхор буй бөгөөд хурын ус тогтож байдаг. Түүнийг “Чингис хааны цом” гэдэг. Шинжилгээний анги тэндээс түүхийн дурсгалт зүйлийг нэлээд малтаж гаргасан бөгөөд эртний үеийн нүхэн гэрийн үлдэц ба дундад эртний шавар сав, жад, хутга зэргийг нэлээд олов. Энэхүү орны тойрон байдал, домог яриа ба малтаж гаргасан түүхийн дурсгалт зүйл нь цөм эртний үеийн Персийн түүхч Рашид-ад-Диний зохиосон “Монголын түүх” (“Судрын чуулган”-ыг хэлж байна) болон Монголын эртний түүхийн алдарт зохиол болох “Монголын нууц товчоон”-д тэмдэглэсэнтэй нийцэж байна. Шинжилгээний анги эдгээр байдлыг үндэслэж энэ газрыг Чингис хааны мэндэлсэн газар мөн гэж нотлов гэжээ.

Дээрх тэмдэглэлийг “Монгол түүх хэл бичиг”-ийн 1958 оны 6 дугаар хугацаанаас дам эшлэв (Тус мэдээг 1958 оны 4 сарын 7-ны өдрийн “Вэнь Хуй Бао” сонины дөрөвдүгээр нүүрт бас нийтлэжээ).

4 Рашид-ад-Дин бол Перс (одоогийн Иран)-ийн түүхч болно. Тэр бол 1247-1318 оны хооронд амьдарч байсан хүн бөгөөд тэр үеийн Монголын дөрвөн хаант улсын нэг нь болох Персэд байгуулсан Ил хант улсын хоёрдугаар хаан Абаха (1265-1281)-гийн ордонд эмчээр ажиллаж байжээ. Долдугаар Ил хан Газан (1295-1304)-ны үед тэр Ил хант улсын сайдаар томилогдож, Монголын түүхийн гурван чухал тулгар баримтын нэг болох “Судрын чуулган” (зураг-17) гэдэг бичгийг нийтийн он тооллын 1300 онд, Газан хааны зарлигаар хааны номын санд хадгалж байсан “Алтан дэвтэр” гэдэг монгол түүх зэрэг ууган материалыг ашиглан бичлээ гэдэг. Энэ “Алтан дэвтэр” гэдэг нь харин “Нууц товчоон”-ы нэг эх байсан ч байж мэднэ. Харамсалтай нь тэр “Алтан дэвтэр” одоо хүртэл хадгалагдсангүй. Рашид-ад-Дин перс, араб хэлэнд нэвтэрсэн боловч монгол хэл мэддэггүй гэлээ. Ингээд тэр “Судрын чуулган”-аа зохиох

үед, Газан хаан ба Юань улсаас Ил хант улсад томилсон элч Болод чинсан гэдэг монгол эрдэмтэн түүнийг хавсарч (түүнтэй хамтарч - хө.) монгол түүхэн материалыг нь уншиж өгдөг гэлээ.

“Судрын чуулган”-ыг Газан хааны үед бичиж дуусгасангүй, түүний дүү Өлзийт хааны үе (1310 он)-д бичиж дуусгажээ. Түүнд мэдээлсэн зүйл их төлөв “Нууц товчоон”-ы мэдээнүүдтэй харилцан тохирдог. Монголчуудын овог угсаа, аж байдал, Чинис хаан ба түүний сайд нарын түүх намтрыг нарийн дэлгэрэнгүй бичжээ. Бас Чингисийн билиг сургаалаас гучаад зүйлийг орчуулж “Судрын чуулган”-даа оруулсан байна. Энэ зохиол нь орос, англи зэрэг хэлнээ орчуулагдаж дэлхий дахинд өргөн тархаагджээ.

5 Д’Оссон (D’ohsson) бол Арменийн алдарт дорно дахинч юм. Тэр 1780 оноо Константинополь хотод төржээ. Хожим нь Шведийн гадаад явдлын түшмэлээр ажиллаж байсан бөгөөд 1855 онд Берлинд нас баржээ. Тэр турк, араб, перс хэл өрнө дахины олон улсын хэл бичгийг төгс мэддэг гэлээ. Манай ашиглаж бүхий энэхүү “Монголын түүх” (ердөө “Д’Оссоны Монголын түүх” гэдэг)-ийг тэр франц хэлээр бичжээ. Энэ түүхийг бичихдээ тэр олон хэл мэддэг баялаг мэдлэгээ хангамжтай бадруулан, араб, перс хэлний олон материалыг ашиглаж, дундад зууны үед Дундад Ази ба Европоор байж байсан Монголчуудын түүхийг маш нарийн тодорхой өгүүлжээ. Бүх ном нь дөрвөн дэвтэр, нэгдүгээр дэвтэр нь 1824 онд анх хэвлэгдэж, 1852 онд дөрвөн дэвтрийг нь бүрэн гаргаж дахин хэвлүүлжээ.

6 “Эргүнэ хун” гэдгийг одоо эрдэмтэд “Эргүнэ гол” гэж үзэцгээж байна. Эргүнэ гол бол Хөлөн нуураас эх авч Хар мөрөнд нийлж бүхий Номхон далайн усан системийн нэгэн гол юм. Нутгийн ардын уламжлалт яриа нь “Өргөн гол” гэдэг үгээс үүссэн нэр гэдэг. Уртраг нь 117° , өргөрөг нь 49° -т буй. Орчимд Өвөр Монголын Нийгмийн Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн ахмад эрдэмтэн Элдэндэй багш “Хөлөн буйр аймгийн доторхи зарим монгол түүхэн газрын нэрсийн тухай магадлалт” гэсэн өгүүлэлдээ:

Өвөр Монголын Хөлөн буйр аймгийн нутаг дахи Биньчжоу төмөр зам (Харбинаас Манжуур хүрэх) дээр нэгэн “Жа-лө-мү-дэ” гэдэг галт тэрэгний өртөө буй. Түүнээс баруунш бараг найм, есөн км зайтай арван зургадугаар халааны өртөө гэж байдаг. Энэхүү халааны өртөөнөөс хойгуур, Хайлар гол зүүнээс баруунш урсч байна. Голын араар нь уул нуруу үргэлжилсэн довлог газар юм. Түүний дотор нэгэн хорь, гучин метр өндөр цавчим хад буй. Нутгийн ард үүнийг “Эргин хад” гэдэг.голын арын довлог газраар тарвага арвин байдаг билээ.

“Монголын нууц товчоон” дахи хада буюу хун (бүр “хун” гэдэг монгол үгийн авиачлал болно) гэсний хажуугийн орчуулга нь бүр эрэг гэж буй. Тиймээс арван гуравдугаар зууны үеийн монгол хэлэнд “хад”, “хун” хоёр үг бол дуудлага өөр, утга адил хоёр үг гэж мэдэж болно. Гэвч орчин үеийн хэлэнд “хун” гэдэг үг нэгэнтээ замарч, “хад” гэдгийг л хэрэглэх болжээ. Хэрвээ монгол хэлний “хун”-аар “хад” гэснийг орлуулвал “Эргин хад” гэдэг нь “Эргин хун” болох юм. Энэ нэгэн газрын нэрийн ойртож байх нь бидэнд монгол үндэстний үүссэн газрыг цаашид зөвлөхөд сүвэгчийг ханган өгчээ гэжээ.

7 “Монголын нууц товчоон”-ы хятад галигийн уг дэвтэрт, “Бөртэ чоно” гэсний хажуугаар “Хөх өнгөт чоно”, “Гуа марал” гэсний хажуугаар “Ухаа өнгөт буга” гэж, тэрчлэн ерөнхий

орчуулгад нь:

Тэнгэрээс төрүүлсэн нэгэн хөх өнгөт чоно, нэгэн ухаа өнгөт буга лугаа залгалдаж гэж бичиж байна. Энэ бол түүхийг гажуудуулж, монгол хүнийг зориуд доромжилсон явдал болно. Учир нь зөвхөн Монголын дээд болсон Бөртэ чоно, Гуа марал хоёрхон нэрийг л утгачилан орчуулаад, бус хэдэн зуун нэрийг огт орчуулсангүйгээр “хүний нэр” гэсэн хажуугийн зүүлт хийжээ. Харин “Нууц товчоон”-д адгуус амьтны нэрээр нэрлэдэг нь зөндөө буй. Сонирхолтой нь орчмын хэдэн жилд зарим улсад “Хөх чоно” гэдэг нэрээр бичиг, кино мэтийг зохиож, овоо довоогоор саригалж(завшин наймаалж – хө.) байна. Хэрэг дээрээ амьтны нэрээр хүнийг нэрлэх явдал нүүдэлчин үндэстний дотор байнга харагддагаар барахгүй, соёл бичигтэй суурьшмал үндэстний дотор ч байнга харагддаг билээ. Хятад хүний “Зуун төрлийн овог” дахи “ма, ноу, ян, хоу, янь” зэрэг үсэг ба япон хүний овог дахи аошика (хөх буга), акайико (улаан гахай) зэрэг бол тэр биеэрээ адгуус мал, араатан амьтныг нэрлэдэг үг юм. Харин Бөртэ чоно, Гуа маралыг эрдэм шинжилгээний хувиар тотем гэж үздэг нь энэ жишээнд үл багтана.

“Бөртэ чоно” гэдэг нэрийн бичлэг бараг бүр нэгдэлтэй байна. Гэтэл “Гуа марал” гэснийг хэд хэдэн янзаар бичиж буй. Саган сэцэний “Хаадын үндэсний Эрдэнийн товч” ба “Лу. Алтан товч”-д “Хоо марал”, “Хаадын үндэсний хураангуй Алтан товч” ба Ц.Дамдинсүрэнгийн өдгөөчилсэн “Монголын Нууц товчоон”-д “Гуа-Марал” гэж тус тус бичиж байна. Харин Өвөр Монголын Багшийн Их Сургуулийн дэд профессор Баярын шинэхэн галигласан “Монголын Нууц товчоон”-д “Ухаа Марал” гэж Иринчин нөхрийн “Дундад улсын умар дахины угсаатнууд болон Монголчуудын угсаа язгуур” гэдэг өгүүлэлд “Хугай Марал” гэж бичсэн харагдана. “Нууц товчоон”-ы хятад галиглалтын бүх системээс авч үзэхүл, сүүлчийн энэ хоёр бичлэгийг таарахгүй гэж хэлэхийн аргагүй. Гэвч би олонд ижил дасал болсноор нь “Гуа марал” гэдгийг нь баримтлав.

8 “Бурхан Халдун” бол уулын нэр болно. Энэ нь одоогийн БНМАУ-ын нийслэл Улаанбаатараас зүүн хойш, Хэнтий, Сэлэнгэ хоёр аймгийн уулзвар дахи (уртраг нь 109°, өргөрөг нь 49°) бага Хэнтий уулын нэгэн салбар уул болно. Энэ тухай нөхөр Дорнотивийн “Нууц товчоон”-ы шинэ хятадчилгад “бурхан” гэдэг бол “бурхай” гэсэн хуланц өвгийг нэрлэсэн үгээс гаралтай, “халдун” гэдэг бол “хадан” гэсэн үгийн эртний хэлбэр (энэ нь сөлсүн - сөсүн, мөлсүн - мөсүн, үйлсүн - үйсүн мэт “л” авиа сугарч бүтсэн үзэгдэл) гэж тайлбарлажээ. Бас Монгол улсын түүхч Хөдөөгийн Пэрлээ(хойш Х.Пэрлээ гэж товчлов)-гийн зохиосон “Монголын Нууц товчооны газар усны нэрийн тухай урьдчилсан мэдээ” гэдэг өгүүллийг лавлаарай.

9 “Монголын Нууц товчоон”-ыг дэлхий дахинаараа Монголын түүхийн гурван их тулгар бичгийн нэгээр тооцдог юм. Түүнийг хятадаар “Юань-чао би-ши” (Юань улсын нууц шастир) гэж нэрлэж байжээ. Энэ бол манай үе хүртэл хадгалагдаж ирсэн монгол үндэстэний түүхийн нууц шастир болно. Түүнд арван гуравдугаар зууны тавиад оноос өмнөх Монголын түүхийг тэмдэглэж байна. Тэр нь түүхийн шинжлэл, утга зохиолын шинжлэл ба хэлний шинжлэлийн талаар ховор чухал материалыг хангасаар байна.

“Монголын Нууц товчоон”-ыг 1240 он (хулгана жил - үүнийг зарим хүмүүс 1228 он гэж үздэг)-д нэрээ үлдээгээгүй түүхч зохиожээ. Энэ ном уулдаа(угтаа) уйгуржин монгол үсгээр

бичигдэж байсан нь яриангүй хэрэг ээ. Гэтэл энэ эх хэдийн үрэгдэн сүйджээ. Одоо дотоод гадаадад нандигнан судалж бүхий “Нууц товчоон” бол Мин улсын эхний үед Сы И Гуань-ий бичгийн хүмүүс нийт 563 хятад дөрвөлжин үсгийг ашиглаж, уул монгол үгийг нь үсэг дараалан галиглаад, үг бүрийн хажууд нь үсэгчилсэн орчуулга, бүлэг бүрийн хойно нь утгачилсан орчуулгыг хадаж хадгалсан дэвтэр болно(зураг 18-ыг лавлаарай). Энэ дэвтрийн чухал нэгэн хуулбар болох “Дөрвөн их цуврал бичиг” дэх Гу Гуань Ци-гийн хуулбарыг орчимд Өвөр Монголын Нийгмийн Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн ахмад судлагч бөгөөд товчоончин Элдэндэй, Оюундалай хоёр багш харгуулан хянаж, Өвөр Монголын ардын хэвлэлийн хорооноос анх удаа хэвлэн нийтэлжээ.

10 Бөртэ чоноос Добун мэргэн хүртэл хоорондоо арван нэгэн үе залгамжилжээ.

Тус товчооны гол хэсэгт голдлогоо товойлгохын төлөө энэ арван нэгэн үеийг товчлов. Энд тайлбар болгон тэмдэглэе. Бөртэ чоноос төрсөн Батачихан, Батачиханы хөвгүүн Тамача, Тамача-ын хөвгүүн Хоричар мэргэн, Хоричар мэргэний хөвгүүн Агужам богурул, Агужам боругулын хөвгүүн Сали хачагу, Сали хачагу-гийн хөвгүүн Их нүдэн, Их нүдэн-гийн хөвгүүн Сэм сочи, Сэм сочи-гийн хөвгүүн Харчу, Харчу-гийн хөвгүүн Боржигидай мэргэн, Боржигидай мэргэний хөвгүүн Торгулжин баян ийм арван нэгэн үе юм.

“Нууц товчоон”-д зөвхөн эдгээр хүмүүсийг л дурдсанаар нь өөр хүмүүн үгүй гэж үзэж болохгүй. Харин эдгээр хүмүүс бол ахмад хөвгүүн байсан тул нэр нь түүхнээ үлдсэн гэж үзэж болох мэт.

11 Добун мэргэн нас барсан хойно, түүний бэлэвсэн хатан Алун гуа эр “үгүй”-гээр бас гурван хөвгүүн төржээ. Хэрэг дээрээ энэ бол Алун гуа-гийн баталбаргүй эр - түүний зарц байсан Малиг Баядай овогтон лугаа нийлж төрсөн гэдэг нь илэрхий юм. Гэтэл үүнийг шөнө бүр цагаан шар хүн гэрийнх нь өрх тотгоор гэрэл болон орж ирээд хэвлийд нь шингэснээс жирэмслэжээ гэж “Нууц товчоон”-д үнэнхүү “нууц” болгон тэмдэглэжээ. Эртний үед аль ч улс үндэстний дотор ийм тотемийн шинжтэй домог олон байдаг юм. Дорнотив нөхөр энэ зурвасыг тайлбарлахдаа:

Хараацайн өндгийг залгиснаас, сахиулсны мөр дээр гишгэснээс, Чан Пу хуарыг залгиснаас, нисээ хараацай өвөрт орсноос жирэмслэжээ гэдгээр жишээлжээ.

Миний мэдэж байхаар, Манжийн анхдугаар хаан Нурхачи-гийн эх нь охиноороо явж байгаад, нэгэн шаазгайн зуун авчирч хаясан аршийн жимсийг идээд жирэмсэлж, Нурхачи-г төрлөө гэдэг. Шагимуни бурхныг ч эхийнхээ баруун суганаас мэндэлсэн. Бас Лю Бан эх нь Лю Чи нуураар зоогхийн (зугаацан – хө.) явж байтал, нэгэн эрдэнийн тахиа гэрэл сацарсан сувд зуусаар ирсэнд, түүнийг залгиад Гауцзу хааныг төрөв гэдэг билээ.

12 Монгол үндэстний хоёр их салаа - “Ниругун Монголчууд” ба “Дүрлүгин Монголчууд”-д чухам ямар ямар овог аймаг багтаж байсан тухай нэгдэлтэй тэмдэглэл байдаггүй. Жишээлбэл, “Ниругун Монголчууд”-ын овог аймгийг “Нууц товчоон”-д хорин долоогоор, “Судрын чуулган”-д арван зургаагаар, “Д’Оссоны тэмдэглэл”-д хорин нэгээр, “Дүрлүгин Монголчууд”-ын овог аймгийг “Нууц товчоон”-д гурваар, “Судрын чуулган”-д наймаар, “Д’Оссоны тэмдэглэл”-д арван гурваар тус тус тэмдэглэж байдаг байна. Одоо их төлөв “Нууц

товчоон”-оор баримт болгодог. Гэвч “Нууц товчоон”-ы тэмдэглэлийг бас бүрэн гэж хэлэхийн аргагүй. Харин “Нууц товчоон”-оор гол болгож, “Д`Оссоны тэмдэглэл”-ээр нөхвөр болговол нэлээд бүрэн болох бөгөөд “Судрын чуулган”-ыхийг ч хамарч чадна. Доор “Нууц товчоон” болон “Д`Оссоны тэмдэглэл” хоёрт тэмдэглэж бүхий Монголын овог аймгийг хураангуйлан жагсаасугай.

“Нууц товчоон” дахи “Ниругун Монгол”-ын эл овог аймаг нь:

- (1) Боржигин овогтон
- (2) Жүрхин овогтон
- (3) Тайчигуд овогтон
- (4) Бэсүд овогтон
- (5) Орунар овогтон
- (6) Хонхотан овогтон
- (7) Арулад овогтон
- (8) Сөнид овогтон
- (9) Хабтурхас овогтон
- (10) Гэнигэс овогтон
- (11) Ноёхин овогтон
- (12) Барулас овогтон
- (13) Их барулас овогтон
- (14) Өчүүхэн барулас овогтон
- (15) Эрдэмт барулас овогтон
- (16) Төдүгэн барулас овогтон
- (17) Адархин овогтон
- (18) Будагад овогтон
- (19) Уругуд овогтон
- (20) Мангуд овогтон

- (21) Шижигүд овогтон
- (22) Тохурагуд овогтон
- (23) Багарин овогтон
- (24) Жэгүрэйд овогтон
- (25) Жадаран овогтон
- (26) Хатагин овогтон
- (27) Салжигуд овогтон

“Дүрлүгин Монгол”-ын эл овог аймаг нь:

- (1) Бэлгүнүд овогтон
- (2) Бүгүнүд овогтон
- (3) Дөрвөн овогтон.

Д‘Оссоны “Монголын түүх” дэх “Ниругун монгол”-ын овог аймаг нь:

- (1) Хатагин аймаг
- (2) Салжигуд аймаг
- (3) Тайчигуд аймаг
- (4) Эриган аймаг
- (5) Шижигүд аймаг
- (6) Чонос аймаг
- (7) Ноёхан аймаг
- (8) Уругуд аймаг
- (9) Мангуд аймаг
- (10) Багарин аймаг
- (11) Дөрвөн аймаг
- (12) Хануд аймаг

- (13) Сүхэтү аймаг
- (14) Барулас аймаг
- (15) Адархин аймаг
- (16) Жажарад аймаг (Жадараныг хэлж буй)
- (17) Будаган аймаг
- (18) Тохурагуд аймаг
- (19) Есүд аймаг (Бэсүдийг хэлж буй)
- (20) Суган аймаг
- (21) Хонхотан аймаг

“Дүрлүгүн Монгол”-ын эл овог аймаг нь:

- (1) Урианхад аймаг
- (2) Хонгирад аймаг
- (3) Ихирэс аймаг
- (4) Олхунуд аймаг
- (5) Харануд аймаг
- (6) Хөнхүлигүд аймаг
- (7) Горлос аймаг
- (8) Элжигэн аймаг
- (9) Осбагуд аймаг ба түүнд гурван салбартай гэжээ.

А. Хунхамар аймаг

Б. Эрлад аймаг

В. Хэлэнгүд аймаг

(10) Үгүшин аймаг

(11) Сүлдүс аймаг

(12) Илдүрхин аймаг

(13) Баягуд аймаг

13 Тус товчоонд зөвхөн Бодончарын ахмад хөвгүүний залган төрлөөс хойш залгамжласан боржигин овогтныг тэмдэглэв. Энэхүү залган төрөл гэдэг бол овог угсаагаа удирдах эрх мэдлийг ахмад хөвгүүндээ уламжилдаг явдлыг зааж байна. Гэтэл Бодончарын үр хойч ач нар нь өөр өөр овогтон болсон нь олон байдаг. Бодончарын барьж авсан эмээс нь Жадаран, Мэнэн багарин хоёр овогтон, татвар эмээс нь Жэгүрэйд нэгэн овогтон салбарлажээ. Бодончараас дорогш таван үе Хайду-д залгамжлахад Хайду-гийн Боржигин овогтой зэрэгцсэн Ноёхин, Барулас, Адархин, Будагад, Уругуд, Мангуд зэрэг зургаан овогтон салбарлажээ. Бас Хайдугаас дорогш гурван үе Тумбиной сэцэнд залгамжлахад Тумбиной-тай зэрэгцэн Бэсүд, Тайчигуд, Орунар, Хонхотан, Арулад, Сөнид, Хабтурхас, Гэнигэс зэрэг найман овогтон болон салбарлажээ. Энэ бүхэн бүр Бодончарын хойч “Ниругун Монголчууд”-ын гол бүрэлдэхүүн нь болж байжээ.

14 “Монголын нууц товчоон”-ыг үндэслэвэл, Тумбиной сэцэн хоёр хөвгүүнтэй, ахмад нь Хабул хаан, хоёрдугаар нь Сэм сэчүлэ гэдэг. Гэтэл “Юань улсын түүх”-д Тумбиной сэцэнд зургаан хөвгүүнтэй, Хабул хаан бол зургадугаар хөвгүүн нь гэжээ. Энэ зургаагийн олонхийн нэр нь Хабул хааны зургадугаар үеийн өвөг Мэнэн Тудуны долоон хөвгүүний олонхийн нэртэй нь адил байна.

“Судрын чуулган”-д Тумбиной сэцэн есөн хөвгүүнтэй, зургадугаараас дорогш нь татвар эмээс нь төрсөн, Хабул хаан бол татвар эмийнх нь ахмад хөвгүүн гэжээ. Үүний тухай Хун Цзюнь-ий зохиосон “Юань улсын түүхийн нөхвөр орчуулга” гэдэг зохиолд, Рашид-ад-Дины мэдээг “Юань улсын түүх”-тэй харьцуулан судалж, “Нууц товчоон”-ы тэмдэглэлийг ташаарсан гэж нотолжээ. Хабул хааныг Тумбиной сэцэний татвар эмийн хөвгүүн гэсэн “Судрын чуулган”-ы тэмдэглэл бол сэжиглэлтэй гэж түүхч Ту Цзи үзжээ. Тэр тэмдэглэсэн нь:

Монголын хуучин заншлыг баримталбал, залган төрөл ба салаан төрлийн ялгал нь чанга тодорхой тул татвар эмээс төрсөн хөвгүүн суурь залгамжлах ёс байдаггүй. Хабул хэрвээ татвар эмийн хөвгүүн болсон бол төрөл төрөгсдийнхөө дотор доромжлогдохоос биш, хэрхэн хаан цол өргөмжлөгдөж, Сэнгүм Билгэ-ийн суурийг орлох аж. Тиймээс “Нууц товчоон”-д Хабулыг Тумбиной-н ахмад хөвгүүн гэсэн нь ортой байж мэднэ гэжээ.

Хабул хаанаас Хотала хаан хүртэлх гурван үеийн хаадыг “Нууц товчоон”-д хэдийгээр “хаан” гэж Чингис хаантай адил бичиж байвч, тэд нар нь зөвхөн “Хамаг Монгол Улс”-ын хан буюу ахмад нь болно.

Хабул хааны тухай түүхч Ту Цзи-гийн тэмдэглэл нэлээд сонирхолтой бөгөөд чухал мэдээг үлдээжээ:

Хабул хаан бол олондоо онцгой итгэл хүндтэй тул аймаг угсаагаараа түүнийг хүрээлдэг. Сэнгүм Билгэ үхсэн хойно, түүний аймгийг нь Хабул удирдсан бөгөөд Хамаг Монголыг захирч, хаан цолыг нь эхлэн өргөмжилжээ. Ингээд Алтан улсын эзэн түүний нэрийг нь сонсч, урин ирээд хүндэт зочны ёсоор зочилж гэнэ. Гэвч Жүрчин хүмүүс хулжин зусар гэдгийг

Хабул хаан мэдэх тул идшинд нь хор байгуузай хэмээн болгоомжилж, дайллага хийх бүрд нь нүүр гараа угаана гэж шалтаглан идэж уусан бүхнээ бөөлжиж хаяад дахин ширээнд суудаг гэнэ. Ингээд түүний идэж уух нь бусдаас хэтэрхий гэж хурагсад цочин гайхалдсан юм гэлээ. Нэгэн өдөр, Хабул хаан ихэд согтож, алга таших таширмаа, Жүрчин хааны сахлыг нь шувтраад авсанд, ёс бусаар аашлав гэж Жүрчин хааны түшмэд нүд эрийн (эргэлдүүлэн - хө.) гар хөдөлмөөр байхад харин Жүрчин хаан нь инээж байв гэлээ. Хабул хаан осолдлоо гэж буруу мэдсэнд, өчүүхэн осол гэж Жүрчин хаан хэлж, ял асуусангүй мөртөө хүнд бэлэг сэлт хүргэж буцаажээ. Энэ хүнийг тавьж явуулбал хил хязгаарын түгшүүр гэж нэгэн сайд нь Жүрчин хаанд айлтгасанд, буцаан авчрахаар элч томилжээ. Гэтэл Хабул хаан Жүрчин хааныг доромжилж зарлигийг эс хүлээв. Жүрчин хаан бас оруулан авахаар дахин элч томилсонд, Хабул хаан зайлж, өөр газар явсан тул элч нь буцжээ. Гэтэл Хабул хаан буруу замаар явж баригдан хүргэгдлээ. Замдаа анд Сайжудай гэдэг лүгээ учирч энэ учраа хэлсэнд, эд нар сайн санаагаар хүргэж байх биш гэж Сайжудай хэлсэн бөгөөд эдний чөлөө завьг үзэж мултарсугай гэж нэгэн сайн морь хүргэж өгчээ. Шөнө болоход Алтан улсын элчид Хабул хааны хөлийг нь тушиж амар унтуулсангүй гэлээ. Маргааш өдөр нь зав чөлөө олоод Хабул хаан довлон дутаажээ. Элчид нэхэн хүрэхэд, Хабул хааны Горлос овогт Мадай гэдэг хатан нь шинэ гэртээ далдалжээ. Энэ муусайныг эс албал би хэзээд хэлтэрч чадахгүй гэж Хабул хаан хатан ба анд нөхөдтэйгээ зөвлөж, Алтан улсын элчийг алсан юм гэнэ. Түүнчлэн Алтан улсын түмний ноён Хушаху гэгч бээр их цэрэг дайчлуулан ирж довглуулжээ. Алтан улсын цэрэг нь амуу хүнсээ дуусч буцахад, Хабул хаан нэхэн байлдаж Хайлин гэдэг газар (энэ Хайлин бол Хайлар буюу Хянган нуруу мэт) Алтан улсын цэргийг ихэд дайджээ. Энэ нь Сүн улсын Шао Сингийн долдугаар он (1137 он)-ы явдал болно гэжээ. “Д’Оссоны түүх”-д бас ийм тэмдэглэл байдаг, гэвч ийм нарийнгүй билээ.

15 Амбагай хаан бол Чингисийн зургадугаар үеийн өвөг Байшинхор догшины дүү Чарахай Линху-гийн хөвгүүн Сэнгүм Билгэ-гийн ганц хөвгүүн болно. Тэр нь Тайчигуд овогтны дүү юм. “Ниругун Монголчууд”-ын ахлагч Хабул хаан нас барсан хойно, тэр Хабул хааны гэрээсээр хаан орыг нь залгамжилжээ. Сүүлээр нь тэр өөрийн биеэр охиноо Татар аймагт хүргэж очоод өшөөтөн Жүйн Татар иргэнд баригдаж, Алтан улсад хүргэгджээ. Тэр Алтан улсын хааны харгис тамлалыг амсаж, үхэхийн өмнөхөн өөрийн дагасан Бэсүд овгийн Балхачи гэдэг хүнийг томилон буцааж, хаан орыг Хабул хааны долоон хөвгүүний дундахи Хотала (Чингисийн төрсөн өвөг эцэг Бартан баатарын дүү) болон өөрийн арван хөвгүүний дундахи Хадаан (Амбагай хааны арван хөвгүүний нэр тэмдэглэгдсэнгүй) хоёрын нэгнээр залгамжлуул гэж гэрээслэжээ. Ингээд Тайчигуд нар их хуралдаан хийж, Хабул хааны дөрөвдүгээр хөвгүүн Хотала-г өргөмжилжээ.

16 Ту Цзи (1856-1921) авгай бол орчин үеийн түүхч, Цзянсу мужийн У-гийн газрын хүн юм. Тэр бол Чин улсын Бадаргуулт төрийн орогсодоор шалгагдаж, бичгийн яамны харцсын цогтон, нийслэлийн их Сүйтан-гийн сургагч түшмэл зэрэг тушаалд ажиллаж байжээ. Цагаагчин гахай жилийн хувьсгалаас хойно, улсын түүхийн сангийн ерөнхий найруулагчаар байв. Түүх газарзүйн ухаанд мэргэжсэн бөгөөд Монголын түүхийг тусгай судлажээ. Тэр хэдэн арван жилийн шургуу хөдөлмөрийг зарцуулж, эрт өдгөөгийн ба гадаад хэлний маш олон түүхэн материалыг цуглуулан, зуун жаран боть (үүний дотор арван боть нь гарчиг байвч агуулгагүй) том зохиол “Монголын түүхэн тэмдэглэл” гэдгийг зохион бүтээжээ. Ту Цзи тус зохиолдоо Хубилай сэцэн хаанаас өмнөх Монголын түүхийг голчилж, бас Монголын баруун

хэдэн хаант улсын түүхийг нэлээд нарийн бичжээ. Бүх зохиолдоо олон арван нарийн магадлалт тодорхойлолтыг дагалдуулсан байна. Тус зохиол 1934 онд хэвлэгджээ. Энэ зохиол нь хэдийгээр бичиж дуусгаагүй бүтээл бөгөөд өдий төдий асуудалтай боловч “Юань улсын түүх”-д оршиж байсан өчнөөн төчнөөн алдаа бурууг залруулснаар барахгүй, Монголын түүхийн судлалд олон арван чухал материал баримтыг ханган өгчээ.

17 “Үжин” гэдэг үгийг Ц.Дамдинсүрэн “Монголын уран зохиолын түүх” гэдэг зохиолдоо: “Хятадаар фүжин буюу хатан гэсэн үг юм” гэж тайлж бичив.

Өвөр Монголын Нийгмийн Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн Түүх судлах газрын хариуцлагатан, Монголын түүхийн эрдэмтэн нөхөр Лю Цзинь Со-гоос шинээр галиглаж тайлбарласан “Монголын Нууц товчоон” (санал хураах эх бичиг)-д:

Энэхүү “үжин” гэдэг үгийг хятад үгийн “фү-жэнь” гэсэн үг гэж тайлсан байв. Бас зарим түүхийн номуудад энэхүү “үжин” гэсэн үгийг “зүсин” (“Хаадын үндэсний Эрдэнийн товч”-д), “geljin” (“Богд Чингис хааны цадиг”-т “Бөртэ үжин”-ийг Бөртэгэлжин гэжээ) мэт янз янзаар тэмдэглэсэн бичлэг харагдаж байхаар барахгүй, “Юань улсын түүх”-ийн 114 дүгээр боть “Хатад татварын намтар”-т: “Тайцзу хааны Богдын түшээ гэгээн сэцэн ивээлт хуанхүүгийн алдар Үжин хэмээмүй” гэжээ. Энэ үгийн утгаар нь үзвэл “хатан” гэсэн үг биш гэж ойлгож бүр болох юм. Бас “Нууц товчоон”-д “хатан” гэсэн үг байтал Өгэлүн, Бөртэ хоёрыг “хатан” гэсэнгүй “үжин” гэдэг, бус хатдыг “үжин” гэсэнгүй “хатан” гэдэг, тэрчлэн “Юань улсын түүх”-д “үжин” гэснийг цаашид хүний нэр болгосон энэ явдал харин сонирхолтой зүйл юм. Тиймээс “үжин” гэдэг үг өөр утгатай ч байж мэднэ. Цаашдын судалгаанд анхаарал болгож энд тэмдэглэлээ.

18 “Отчигин” гэж хамгийн бага хөвгүүнийг нэрлэдэг байна. “Нууц товчоон”-д “Төдүгэн отчигин”, “Даритай отчигин” ба “Тэмүгэ отчигин” гэж бүр хамгийн бага хөвгүүнийг нэрлэжээ. “От” гэдэг нь “гал” гэсэн утгатай, “чигин буюу тигин” гэдэг нь “эзэн” гэсэн утгатай түрэг үг гэлээ. Отчигин - “галын эзэн” гэсэн нь “голомт сахих эзэн” гэсэн санааг харуулжээ. Одоо энэ үг бяцхан хувирч “отгон” гэж хэлэгдэх болсон байна. “Галын тэнгэр”-ийг сүүлчийн үед “Отхан тэнгэр” гэдэг. Энэ тухай ЗХУ-ын монголч эрдэмтэн Б.Я.Владимирцовын “Монголчуудын нийгмийн байгуулалын түүх” гэдэгт:

Отгон хөвгүүн бол гал голомтыг сахидаг болохоор отчигин гэж нэрлэдэг. Отгон хүү нь эцгийнхээ дэргэд үлдэж эцгийнхээ гол өмч хөрөнгийг залгамжлах заншил бол нүүдлийн малчдын дунд байгаа анчин байдлын үлдэгдэл мөн гэжээ.

19 Лувсанданзаны зохиосон “Алтан товч”-ийн дэлгэрэнгүй нэр бол “Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан алтан товч хэмээх оршив” гэдэг (товчлоод “Лу. Алтан товч” буюу “Алтан товч” гэдэг). Энэ зохиолыг “Нууц товчоон”, “Эрдэнийн товч”-той зэрэгцүүлж, монгол үндэстний өөрийн хэлээрээ зохиосон түүхийн гурван их тулгар бичиг гэж үнэлдэг юм. Ялангуяа “Лу. Алтан товч”-ийн нэгэн олдошгүй нандин зүйл гэвэл, түүнд “Нууц товчоон”-ы 282 зүйлээс 234 зүйлийг нь бараг уг ёсоор нь буюу үндсэндээ уг дүрсээр нь хадгалж байна. Тиймээс хэрэг дээрээ манд олдсон “Нууц товчоон”-ы уйгуржин үсгийн эх гэж үзэж болох юм. Харин “Нууц товчоон”-д байдаггүй зарим сонирхолтой мэдээнүүд “Лу. Алтан товч”-д байдаг бөгөөд тэр нь “Судрын чуулган”-ы тэмдэглэлтэй

нийцэж байдаг байна. Үүгээр үзвэл, эртний монгол түүхчдийн дотор Лувсанданзанд л “Нууц товчоон”-ы бүрэн шахам эх байснаа өөрийн зохиолдоо сийрүүлэн оруулсан нь илэрхий бөгөөд Рашид-ад-Диний баримтласан “Алтан дэвтэр” гэдэг нь Лувсанданзаны хэрэглэсэн баримт лугаа гарал нэг гэдэг нь ч мөн тодорхой байна.

Зохиогч Лувсанданзаны тухай гэвэл, орчимхон хэвлэгдсэн “Үгсийн далай” гэдэг хятад бүрэн тольд Ордос аймгийн лам Лувсанданзан “Алтан товч”-ийг Тэнгэр тэтгэгчийн дунд үед зохиолоо гэснээс өөр тодорхой мэдээгүй. Тэнгэр тэтгэгчийн дунд үе бол хэлэлгээнгүй 1736-1795 оны хооронд, арван наймдугаар зууны үе болно.

Харин Ц.Дамдинсүрэнгээс арван долдугаар зууны эхэн үеийн түүхч гэж тэмдэглэсэн бөгөөд “Дэлхийн дайлан дагуулагчдын түүх”-ийн англи орчуулагч Бойл тус номын 29 дүгээр бүлгийн зүүлт тайлбарт “1601 он” гэж бодтой тэмдэглэж байна. Гэтэл Бельгийн монголч эрдэмтэн Мостэрт (Mostaert) 1649-1736 оны хооронд зохиогдлоо гэж жишээ бичжээ. Ингээд зохиогчийн амьдарч байсан цаг ба “Лу. Алтан товч”-ийн зохиогдсон цагийг одоо болтол бодтой тодолж чадаагүйг эдгээр тэмдэглэлүүд харуулж байна. Одоо манай ашиглаж байгаа “Лу. Алтан товч” бол 1937 онд Улаанбаатар хотод хорголжин бараар хэвлүүлсэн дэвтэр болно. Түүний ганцхан хувь хуулбар эх (177 хуудастай сударчилсан хуулбар, одоо Улаанбаатарын Улсын номын санд хадгалж буй)-ийг Монгол улсын Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн анхны дарга эрдэмтэн Жамьян, Монголын зүүн аймгийн Юншээбү овгийн нэгэн тайжийнхаас 1926 онд олж авлаа гэдэг. “Лу. Алтан товч”-ийн тухай нөхөр Лю Цзинь Со-гийн “Арван гурав - арван долдугаар зууны Монголын түүхийн бичлэг” гэдэг тусгай зохиолын 219-245 нүүрт нэлээд нарийн гүнзгий танилцуулж буй.

20 “Гажил нуруу” гэж “Их Чин улсын нэгтгэсэн ойллогын бичиг” гэдэгт Мони нурууг нэрлэжээ. “Гажил нуруу” бол одоогийн Өвөр Монголын Өөртөө Засах Орны баруун дахи хоёр Богд, Мони-ийн уулаас эхлэн, дундаа Далан хар уул, Хүйтэн давааны уултай залгалдаж, зүүнш Их сүргийн уул хүрдэг. Уртаараа бараг 1.200 км. Өндрөөрөө далайн төвшингөөс 1.500-2.000 метрийн хооронд буй. Гажил нуруун дахи Онгон даваа болон Хөндлөний ам зэрэг нь өмнө умрын зам харилцааны чухал боомт болж байсан юм.

21 “Урт цагаан хэрэм” бол Эртний Хятадын хөдөлмөрчин ард түмний цус хөлсөөр гагнагдсан түмэн газрын урт сүрлэг их барилга юм. Түүний зүүн эх нь Шанаа боомт (“Эрдэнийн товч”-д “Хардай хот” гэдэг)-оос эхэлж, баруунш Ганьсу мужийн Цзя Юй Гуань боомт хүрдэг. Энэ барилгыг Хятадын эртний Цинь улсын анхдугаар хаан Цинь Ши Хуан гэгч Ци, Чу, Вэй, Янь, Чжао, Хань зургаан улсыг нэгтгэсний хойно умар дахины Хүннүгийн довтлолыг сэргийлэхийн тулд манай тооллын цаадахы 214 оноос эхэлж, уулын зургаан улсын тус тусын байгуулсан хэрмийн суурь дээр сэлбэн засаж үргэлжлүүлэн холбосон юм. Үүнээс хойно, Хань, Умард Вэй, Умард Ци, Умард Чжоу ба Суй улсын үед, умар дахиндаа нүүдэлчин малчин үндэстэн лүгээ зах залгалдсан хэсгээрээ бүр урт хэрмийг байгуулжээ. Хожим нь Мин улсын үе болж, Татар (Зүүн Монголыг хэлж байна), Вала(Ойрадыг хэлж байна)-г сэргийлэхийн төлөө, Хунхуа (Хун У)-гийн үеэс Вань Ли-гийн үе (1368-1620 он) хүртэл Урт цагаан хэрэмийг урьд хожид арван найман удаа сэлбэн заслаа гэдэг билээ.

Хоёрдугаар бүлэг



ЧИНГИС ХААНЫ БАГА ЗАЛУУ НАСНЫ ҮЕ

5. Тэмүжиний төрсөн дүр жавхлан

Тэмүжин чухам ямархуу дүр байдалтай төрснийг мэдэх асуудал ерөөс хүмүүсийн анхаарлыг татсаар иржээ. Гэтэл Тэмүжиний дүр жавхланг шууд тэмдэглэсэн ууган мэдээ гэвэл, түүний хожмын хадам эцэг Дэй сэцэний хэлсэн:

Энэ хөвгүүн чинь нүдэндээ галтай, нүүрэндээ гэрэлтэй хөвгүүн буй гэсэн нэгэн бадаг үг “Нууц товчоон”-д хэдэнтээ дурдагддаг. Бас “Юань улсын түүх, Елюй Ахай-н намтар”-т: “Тайцзу (Чингисийг хэлж буй - эшлэгч)-гийн төрсөн байдал дүр ер бус” гэсэн нэгэн бадаг үг байдаг, гэтэл тэр “ер бус”-ын бодтой байдлыг дурдсангүй. Харин өмнөд Сүн улсын элч Чжао Хун-ы зохиосон “Монгол Татарын тухай бүрэн тэмдэглэл” гэдэгт:

Татар (монгол хүнийг тухайн үед ерөнхийд нь Татар гэдэг - эшлэгч)-ын эзэн Тэмүжин гэгч бие байдал том хүдэр, магнай өргөн, сахал урт, төрсөн нь сүрлэг агуу тул ер бус болой гэж тэмдэглэжээ. Өөр нэгэн дам тэмдэглэл гэвэл, Чингис хааныг нас барснаас хойно дөчин хэдэн жилийн дараа Хубилай сэцэн хааны төрд ирсэн анх нэгэн европ хүн - алдарт жуулчин Марко Поло¹ өөрийн сонсноо:

Түүний (Чингисийг зааж буй - эшлэгч) төрсөн нь арван хувийн бүрэн чийрэг, билиг ухаан хурц сэргэлэн, үг өгүүлэлд гарамгай бөгөөд нэн баатар эрэлхгээр алдаршжээ гэж тэмдэглэж байсан бөгөөд бас бусдаас Хубилай их хааны төрсөн байдал нь түүний өвөг эцэг Чингис хаан лугаа адил гэж сонсч гэлээ. Чингэвэл Хубилай хааны дүр байдлын тухай, түүний дэргэд арван долоон жил хамт байсан Марко Поло өөрийн ажиглалтаараа: Хубилай болбоос нэгэн өндөргүй, нэгэн богиногүй тэнцүүхэн сайхан биетэй бөгөөд дөрвөн мөч төв тэгш, бүх биеийн байдал дүр тэнцэж нийцсэн нь маш сайхан ажгуу. Түүний царай зүс ариун хээнцэр, заримдаа нүүр дүүрэн улаан гэрэл бадарч сарнай цэцэг дэлгэрсэн мэт сүр жавхлан нь улам нэмэгдмүй. Нүд нь мойл хар бөгөөд хурц тунгалаг. Хамар нь тэгш бөгөөд өндөр гэж дүрслэн тэмдэглэжээ. Хубилай хааны тухай дүрслэл бол Марко Поло нүдээрээ үзсэн суугдал

(сэтгэгдэл – хө.) болно. Чингисийн тухай сонссон ч зүйл ч мөн Чингисийн хамт үеийн хүмүүс буюу Чингисээс дэмий хол амьдраагүй хүмүүсээс сонссон нь дамжиггүй юм. Тиймээс Марко Поло-гийн энэхүү бодтой дүрслэл нь үнэн байдалтай ойртож байна гэдгийг Дэй сэцэний дүрсэлсэн тэр хэдэн үгээр гэрчилж болох мэт. Тэрчлэн Дэй сэцэний тэрхүү дүрслэл нь хэдийгээр тун гарамгай хийсвэржүүлсэн боловч маш оновчтой дүр гэдгийг мэдэж болно.

Сүүлчийн үеийн түүхчид ба уран зурагчид ч Тэмүжиний чухам дүр жавхланг нь бүтээхээр уран дүрслэг үг буюу авьяаслаг сайхан хөрөг зургийг үлдээж байв. Жишээлбэл, Оросын дорно дахинч Березин (1818 - 1896), түүний зохиосон “Чингис хаан” гэдэг номдоо Тайчигудын түүрүү Таргутаг Хирилтуг бээр: (Тэмүжин бол) үнсэн бор нүдтэй, хар хүрэвтэр үстэй, улаан ягаан царайтай төрсөн, хурц сэргэлэн бөгөөд үл тоох харцаар хүнийг хардаг (хөвгүүн билээ). Энэ сая ёстой боржигид хүний дүр бөгөөд шилдэг байлдагчийн дүр юмсанжээ гэж тэмдэглэж байсан. Энэ нь Сорхан шарын хэлсэн (“Нууц товчоон”, 82 дугаар зүйл) ба Таргутаг Хирилтуг-ийн хэлсэн (“Нууц товчоон”, 149 дүгээр зүйл) лүгээ баахан зөрөөнтэй шиг боловч учир нь таарч байна. Бас Зөвлөлтийн монголч эрдэмтэн В.Я.Владимирцов:

Нань Сюань Тянь харшийн хадгаламж хөрөг болон түүний хувиралууд



1-Тайвань-д хадгалж бүхий ордны зураг, 2-Японд дамжигдаж бүхий хуулбар 3-"Өвөр Монгол" зурагт сэтгүүлийн хөрөг




Зураг 20. Их мэргэн
Чингис хаан




Зураг 21.
"Хайр найргүй байлдагч"
Чингис хаан



Кап хоршооны хөрөг



Балгадын сүмийн хөрөг - Юнь Нань Монголчуудын сүмийн хөрөг



Өвөр Монголын музейн шуумал хөрөг - Зүүх хөрөг - Чингисийн онгоны шуумал хөрөг



1-Чингисийн хааны одоо үеийн зурмал хөрөг, 2-Будаггүй зурмал хөрөг, 3-Мусульманчуудын зурсан хөрөг



Мүнлэй-гийн зурмал хөрөг



Өгэлүн эх хөвгүүдээ сургаж байгаа зураг



Чингисийн найман шарга

Тэмүжин бол хүдэр өндөр биетэй, гэрэл гялбаат нүдтэй, үнэнхүү төрөлх нэгэн гайхамшиг эр юм гэжээ. Дундад улсын гучаад оны үеийн түүхч Чжан Чжэнь Пэй, мөн Дэй сэцэний үгийг дэлгэрүүлж, хятад үндэстнийхээ баатар хүнийг дүрслэх заншлаар:

Энэ хөвгүүн бол хасын нүүр, луугийн нүд, гарьдын хөмсөгтэй, хамар тэгш, чих их, уруул

улаан, шүд цагаан, нуруу өндөр, цээж өргөн, баатар сүрлэг эзэн хүний авиртай гэжээ. Энэ нь хэлэлгээнгүй хэнд ч тохирох магтаалын чанартай хэвшмэл дүр юм.

Эдгээр шууд ба дам тэмдэглэлийг үндэслэвэл, Тэмүжиний төрсөн дүр жавхланг их төлөв ойлгож болно.

Залуу үеийн Тэмүжин бол өргөн тэнэгэр магнайтай, улаан цагаан ялгарсан хээнцэр дөрвөлжин царайтай, өтгөн хар хөмсөгтэй, өндрөвтөр тэгш хамартай, хоёр нүд нь хар бор өнгөөр ялгарч гэрэлтсэн, хоёр чих нь халбагар их. Биеийн байдал нь ханагар өргөн цээжтэй, хавтгай дөрвөлжин мөртэй, хатан идрүүн гартай, хатуу чийрэг том сүрлэг биетэй, сүр жавхлан төгс эзэн түрүүлэгчийн шинжтэй хүн байсан юм байна. Тэр дунд насны үедээ гоё сайхан битүү хар сахалтай байжээ. Өтлөх үед нь өвч толгой нь цал буурал болж, өтгөн хар сахал нь ч мөнгө мэт цайж, өргөн тэнэгэр магнайд нь тэгш хэдэн атираатай болжээ. Юань улсын үеийн ордны монгол зурагчин Хорихусун олон талын материалыг үндэслэж зурсан зураг (тус товчоонд баримтласан ба танилцуулсан эш хөрөг) яг ийм л дүрийг бүтээсэн юм. Гэтэл бас сүүлчийн үед янз бүрийн хөрөг зургууд дэлгэрч байсан тул тэдгээрийг хавсралт болгон эш хөргийн тухай тусгай тэмдэглэв.

Тэмүжин төрөлх хурц сэргэлэн эрэлхэг чийрэг тул агт мориндоо мордож, алс холыг намнах эрийн чадлыг бүрэлдүүлжээ. Бас Тэмүжин хүүхэд байхдаа нарсан шугуйд “хурим хийх”, “хаан суух” мэтээр нааддаг бөгөөд өөр хүүхдүүдээр өмнө хойноо хамгаалуулан бургас унаж дайн байлдаан хийж нааддаг гэлээ. Эдгээр нь мөн ч Тэмүжиний хархан багаасаа эзэн болж эрхэм ихэрхэг сэтгэлтэйг нь харуулж байна.

6. Чингис хааны эш хөрөг

Сүүлчийн үеийн зурагчид олон талын яриа домог буюу түүхэн тэмдэглэлийг үндэслэж, эсхүл өөрийн сэдэлт дүрслэлээрээ Чингис хааны дүрийг бүтээх зорилгоор янз бүрийн хөрөг зургийг бүтээжээ. Манай мэдэж байх хөргүүд гэвэл зураг 19-27-д танилцуулсан зургууд болно. Чингэвэл эдгээрийн дотор чухам аль нь Чингис хааны үнэн дүр байдалтай ойртох буй? гэсэн асуулт тавигдана. Энэ бол зүйтэй хэрэг юм. Гэвч энэ асуудлыг тодлоход нарийн хянамгай шинжлэх ухаанч овроор хандах хэрэгтэй. Тиймээс бид нийгэм дээр дэлгэрч байсан ба байгаа хөргийг аль болохоор хураан эмхэтгэж хяналт болгосны хамт, эш хөргийн тухай саналаа доор тэмдэглэжээ. Тус товчоонд эш баримжаа болгон хэрэглэсэн энэ хөргийг одоо Бээжин дэх Дундад улсын түүхийн музейд хадгалж байна. Уул хөрөг нь өндрөөрөө 58.3 сантиметр, өргөнөөрөө 40.8 сантиметр хэмжээтэй, нарийлаг цагаан цаасан дээр гүехэн будгаар өнгө ялган зурсан цээжин хөрөг болно. Чингис хааны тус хөрөг нь толгойдоо цагаан арьсан гадартай, хар арьсан дотортой өвлийн малгай (булгын арьсаар үйлдсэн бололтой)-г дарж, биедээ гүехэн хулавгар шар ноосон нэхмэл (эсхүл хамба торго) урт дээл өмсжээ. Царайн өнгө нь боровгор улаан, битүү буурал сахалтай, зулайнх нь үс магнай руу нь бултайж хоёр тийшээ салсан бөгөөд гөрмөл (сүлжмэл) гэзэг нь хоёр чихнийнх нь араар гогцоорон харагдаж буй. Хөргийн зүүн мөрний дээр өнцөгт “Тайцзу хаан буюу Чингис хаан, алдар Тэмүжин” гэсэн бичээстэй.

Чингис хааны энэхүү зурмал хөргийг 1953 оны 9 сард, уулын Бээжингийн Түүхийн музейхэн, Хэбэй мужийн Аньло газрын Чэнь Хуань (1869 - ?) гэгчийн хойчисоос элсэн олсон гэнэ. Энэ

Чэнь Хуань гэгч бол тус зууны хориод он буюу Иргэн улсын эхний үе дэх цэргийн эрхтэн Юань Ши Кай-гийн цэргийн дэд штабын даргаар ажиллаж байсан бөгөөд тэр үед монгол орноор тойрон байцааж байхад нь Монголын нэгэн ван ноёноос энэхүү хөргийг түүнд хүргэсэн гэнэ. Ингээд энэхүү хөрөг нь Чэнь Хуань-ий хойчист хадгалагдаж байжээ.

1962 оны эхээр Чжан Хан, Сэ Чжи Лю, Хань Шэнь Сянь зэрэг мэргэжилтнээр бүрэлдсэн хянан тогтоох дугуйлан Бүгд Найрамдах Дундад Ард Улсын Соёлын Яамны даалгавраар Дундад улсын Түүхийн музей дэх зураг, бичээсүүдэд хянан тогтоолт хийх үед Чингис хааны энэхүү зурмал хөрөгт ч шинжлэх ухааны хянан тогтоолт хийжээ. Мэргэжилтэн нар тус хөргийн цаас, будаг, хүний дүр, нэрлэсэн бичээс ба зураглалын арга хэлбэр зэргийг нь нарийн хянамгай байцааж үзээд, тус хөрөг бол Юань улсын үеийн зурагчны бүтээл гэж нотолжээ. Мин улсын зурагчид “Юань улсын хаадын хөрөг”-ийг дууриан зураглахдаа эшлэсэн хөрөг нь тус хөрөг мөн гэж хэлэх баримтгүй боловч харин үүнтэй адил зурсан Юань улсын үеийн зураг болох нь дамжиггүй гэж хянан тогтоох дугуйлангаас үзсэн бөгөөд тус хөргийг Чингис хааны амьд сэрүүн байхад нь зурсан биш боловч түүнийг нас барсан хойно дэмий удаагүйгээр зурсан өтгөс насныхи нь хөрөг болох нь лав гэж үзжээ. Энэ хөрөг нь харин “Юань улсын түүх, тайлга тахилгын тэмдэглэл”-д дурдагддаг Хорихусун-ы зурсан хөрөг байж мэдэх бөгөөд Юань улсын сүүлчээр Монголын язгууртад Дайду хотоосоо ялагдан ухарч гарах үед умарш авч яваад, нэгэн язгууртан (Ван ноён)-ыхан үе улиран хадгалж уламжилсан зүйл ч байж мэднэ гэж хянан тодотгох дугуйлангаас бас үзжээ.

Чингис хааны хөргийг Хорихусун гэгчээр зуруулсан мэдээг “Юань улсын түүх, тайлга тахилгын тэмдэглэл” (шинэ хэвлэл 1876 нүүр)-д: “Чжи Юань-ий 15 дугаар он (1278 он)-ы 11 сард, Тайцзу-гийн гэгээн дүрийг зурах зарлигийг Хорихусунд тушаав” гэж тэмдэглэж буй.

Энэ Хорихусун бол монгол үндэстний хөрөг зурагч бөгөөд Юань улсын үеийн ордны зурагч байв. Тэр, 1278-1279 онд Юань улсын Тайцзу болон өвөг хаан (Есүхэй баатарыг хэлж буй - эшлэгч) жич Тайцзун хаан (Өгөөдэй хаан – эшлэгч)-ы хөргийг зурсан гэдэг билээ. Чин улсын үеийн Дүн Тан Сянь-шэн гэгч магадлалдаа:

Улсын дотоодод хадгалагдаж бүхий Чингис хааны зурмал хөрөг нь хэв дүр ба урлал онцлогоороо Хорихусун-ы бүтээл болох ёстой гэж үзжээ (1981 оны 12 сарын 10-ны өдрийн “Өвөр Монголын өдрийн сонин”) гэж нөхөр Сүртэй танилцуулж байсан.

Бас Юань улсын эцсийн хаан Тогоонтөмөрийн шастирт: “Зургадугаар он (сүүлчийн Чжи Юань-ий хамаг сүүлчийн он-1340 он)-ы цагаан сард Тайцзу, Тайцзун, Жуйцзун (Тулуйн сүмийн цол-эшлэгч) гурван ханы гэгээн дүр (хөргийг нь хэлж байна – эшлэгч)-ийг чулуун бурхны сүмд тахив” гэж тэмдэглэж буй. Эдгээр тэмдэглэлүүдээс үзэхүл, Чингис хааны хөргийг Юань улсын үед зурсан бөгөөд Тогоонтөмөр хааны үе хүртэл хадгалж байсан нь тодорхой байна. Тогоонтөмөр хаан 1368 онд Дайду хотоосоо умарш ухран явахдаа энэхүү шүтээн болсон дээдийн хөргөө найман цагаан гэрийнхээ хамт авч явсан нь ч тэмдэглэлтэй юм. Ухаант хаан явахаасаа гурван хоногийн өмнө (1368 оны билгийн улирлын илүү 7 сарын 26-д), “Дээдийн ёслолын хорооны түшмэл Арухуныг дээдийн сүмийн эл гэрийн шүтээн ба тайж нарыг авч умарш одтугай” гэж зүүн мөрийн түшмэл Ширэмүн-ээр зарлиг уламжлуулж байсан бөгөөд “Арухун нар даруй дээдсийн сүмд очиж, ёслолын тушаалтан ван Сы Цзун, тайж түшмэл (тахилгын сайд) Харбуха-гийн хамт шүтээнийг хамгаалан явах бэлтгэлийг

дуусгаж, гэрт нь хүлээн байв” гэж “Юань улсын түүх, Тогоонтөмөр хааны шастир”-т тэмдэглэж байна.

Чэнь Хуань-ий хойчисын хадгалж байсан Чингис хааны энэ хөрөг нь Тогоонтөмөр хааны авч явсан тэр хөрөг биш байж ч мэднэ. Гэвч тэр нь бас тэр үед умарш авч гарсан адил хөрөг болох нь дамжиггүй гэж үзэлтэй. Учир нь Юань улсын үед Чингис хааны хөргийг хэд хэд зурж, хэд хэдэн газар тахиж байсан тэмдэглэлтэй юм. Жишээлбэл, “Чжи Юань-ийн хоёрдугаар он (1322 он)-ы 10 сард Богд сахиулс Тайцзу хааны тахилгын харшийг шашныг мандуулагч сүмд байгуулав” гэж Юань улсын гэгээн хаан (Инь-цзун) Содбалын шастирт: “Дай Тин-гийн анхдугаар он (1324 он)-ы 8 сард бичгийн утгач эрхин сайдыг томилж, Хотол буянт сүм дэх Тайцзу, Тайцзун хааны гэгээн дүрийг очоор тахиулах зарлигийг тушаав” гэж Есөнтөмөр хааны шастирт, “(Сүүлчийн Чжи Юань-ий) зургадугаар он (1340 он)-ы цагаан сард Тайцзу, Тайцзун, Жуйцзун гурван ханы гэгээн дүрийг чулуун бурхны сүмд тахив” гэж Тогоонтөмөр хааны шастирт тус тус тэмдэглэж байдаг билээ. Тиймээс дээр дурдсан хянан тогтоох дугуйлангийн жишилт нэлээд баримттай гэдгийг эдгээр тэмдэглэлүүд нуталж байна.

Чэнь Хуань-ий хадгалалтыг олдохоос өмнө уламжилж байсан Чингис хааны хөрөг бол Манжийн хааны ордны Нань Сюань Дянь харшийн хуучин хадгаламж болно. Энэхүү хадгалалтад эртний хаад хатад, богд мэргэд ба алдарт сайд түшмэдийн хөрөг таван зуугаад байжээ. Тэдгээр нь бүр өрмөг нэхмэлийн дээр өнгө ялган зурсан, өндрөөрөө 59.4 сантиметр, өргөнөөрөө 47 сантиметр хэмжээтэй цээж хөрөг болно. Эдгээр хөргүүдийг Тэнгэр тэтгэгчийн арван хоёрдугаар он (1748 он)-д хаан зарлигаар бүхнийг дахин цардаж хүрээлсэн гэдэг билээ. “Юань улсын хаад хатадын хөрөг” дэх Чингис хааны хөргийн хэмжээ ч бусад хөргүүдтэй адил бөгөөд бүхнийг хамтад нь дэвгэрлэжээ. Эдгээр хөргүүд бүр адил хэмжээ хэлбэртэй байхыг үзвэл, энэ нь бүр Мин улсын үеийн зурагчид эш хөргөөс нь хуулбарлан зурсан хөрөг болох бөгөөд Нань Сюань Дянь-ий хадгалалт ч энэ хуулбар болох нь дамжиггүй байна. Харин уулын эш хөрөг нь харагдахгүй болсон боловч сүүлчийн үед Монголын язгууртны гэрээс олдсон, Чэнь Хуань-ий энэхүү хадгалалтыг эш хөргөөр үзэхэд нэлээд баримттай юм.

Энд тэмдэглүүштэй нэгэн явдал гэвэл, зарим зурагчид Чингис хааны хөргийг хуулбарлан зурахдаа хар дотортой цагаан арьсан малгайг нь өнгө ялгасан будагтай малгай болгож, ялангуяа чихний нь араар унжиж байсан гэзгийг нь ээмэг болгон зурсан хэвлэл орчимд харагдах боллоо (Хубилайгаас бусад Юань улсын хаадын малгайн сагалдрагыг бас бүр ээмэг болгон зуржээ). Энэ бол түүх ба соёл дурсгалын өвд хянамгай бусаар хандсан овор болно.

Тус товчоонд дагалдуулсан бусад хөргүүд бол нэн ч эш баримтгүйгээр зурсан зүйл гэдгийг зааж гаргах хэрэгтэй бөгөөд ийм хөргийг дахин шинээр үл зурвал зохино.

7. Тэмүжинд сүй тогтоосон нь

1170 он, Тэмүжинийг есөн настай байхад, Есүхэй баатар эцэг нь хөвгүүнээ дагуулж, Өгэлүн эхийн төрүхүд (төрхөм), Тэмүжиний нагац Олхунуд иргэнээс охин (бэр) гуйсугай гээд явжээ. Явсаар байгаад Чэгчэр, Чихургу2 гэдэг хоёр газрын хооронд хүрч чорго (худаг)-оос морио услаж байхад Хонгирад аймгийн Дэй сэцэнтэй уулзав.

Хонгирад аймаг бол эртний “Дүрлүгин Монголчууд”-ын нэгэн аймаг болно. Хонгирадын тухай ийм нэгэн домог байдаг билээ:

Эрт урьдын цагт Хонгирадын дээдэс (Мөн ч Нуху, Хиюун хоёрын салаа салбар гэлээ) Эргүнэ хуны уулаас урьдаар гарахдаа өөр аймгийн гал тулгыг нь хийсгэж хөлөө халаацсан (дулаацсан – хө.) юм гэнэ. Ингээд хожмын үр хүүхдийнх нь олонхи нь хөлийн өвчинтэй байдаг гэнэ. Энэ овогтон алтан цөгцөөс үүссэн (энэ мөн ч тотемийн шинжтэй яриа болох нь илэрхий билээ) тул охид нь гуа үзэсгэлэн төрж эрхэм гэрт морддог гэж өөрсдөө ярьдаг бөгөөд айл өрх алтан бошгоо эрхэмлэн хүндэтгэдэг билээ. Тэр үед энэхүү “Алтан цөгц”-өөс төрсөн ах дүү гурав байж гэнэ. Ахмадынхи нь нэр Зөрлөг мэргэн (Хонгирадын дээд нь болно) гэдэг, хоёрдугаарынхи нь нэр Хувайшар гэдэг, гутгаар нь Түсүбуду гэдэг нэртэй. Их ах нь хоёрдугаар дүүтэйгээ эвгүй тул нэг удаа уур хүрч хоёрдугаар дүү Хувайшараа харваж ална гэсэнд дүү нь айгаад мориныхоо элгэн доор орж хэвтэж гэнэ, ах нь өр өвдөөд ээмгийнх нь нүхээр харваж, чихэнд нь шарх сорви хүргэсэнгүй байв. Ингээд Зөрлөг-ийн мэргэн цол нь улам алдаршжээ. Хувайшараас хоёр хөвгүүн төрж, түүний хойч нь Ихирэс, Олхунуд хоёр овогтон болжээ. Түсүбуду-гаас олон хөвгүүн төрж, түүний хойч нь Харануд (Арануд), Хонгирад, Горлос, Элжигэдэй зэрэг овогтон болжээ. Эдгээр бол эртний Хонгирадын салбарууд гэдэг билээ.

Арван хоёрдугаарзууны үеэс Хонгирад аймаг нь Татар аймгаас өмнүүр байж, хойд тал нь Эргүнэ голын урсгал тулж, өмнөд тал нь Халх голын урсгал хүрч, одоогийн Өвөр Монголын өөртөө засах орны Хөлөн буйр хавиар нүүдэллэн нутаглаж байсан бөгөөд “Нууц товчоон”-оос үзэхүл Эмэл Тан (“Лу. Алтан товч”-д “ор малтай” гэжээ), Тэргэн, Алхуй зэрэг гурван Хонгирад Халх голын Буйр нуурт цуггах уулзар орчим нутаглаж байжээ. Дэй сэцэний тэр бүлэг Хонгирадыг “Бусхур Хонгирад” гэж “Юань улсын түүх”, “Ту Цзи-гийн тэмдэглэл” зэрэгт тэмдэглэж буй. “Нууц товчоон”-д дурдсангүй. Бас зарим Хонгирад нар буга малладаг байжээ. Тэд бас Хятан болон Алтан улсад урьд хожид харьяалагдаж байсан түүхтэй бөгөөд эртнээсээ Боржигин овогтонтой ургийн холбоотой юм.

Алтан улсын үед Хонгирад, Татар зэрэг аймаг нь хүчирхэг аймаг байсан болохоор Алтан улсын хилийг байн байн халдаж байжээ. Ингээд Алтан улс нь бэхлэлт цайз барьж сэргийлж байв. 1196 онд Хонгирад нар Да Цзянь нуур гэдэг газар довтлон орж, Алтан улсын цэргийг нь дайлсан (“Алтан улсын түүх”, 10 дугаар боть) тул Алтан улс бас их цэрэг томилон Хонгирадыг дарсан байна.

Хонгирадын байдал их төлөв ийм л билээ.

Дэй сэцэн Есүхэй баатартай учирч, Есүхэй баатар хөвгүүн Тэмүжиндээ бэр гуйхаар явж байхыг нь ойлгож мэдээд ингэж хэлжээ:

Би энэ шөнө цагаан шонхор наран саран хоёрыг атган нисч ирээд миний гар дээр буув гэж зүүдлэв. Наран саран нь үзэгдэж харагддаг боловч шонхор шувуу атган ирсэн нь ямар сайн тохиол болох буюу гэж бид хэлэлцэцгээсэн юм. Шонхор шувуу бол танай хиюуд иргэний сүлд болох тул Есүхэй худ та хөвгүүнээ дагуулан ирсэн нь энэхүү бэлгэ болов гэжээ.

Дараа нь Дэй сэцэн Хонгирад аймгийнхаа тухай: “Бидний Хонгирад иргэн эрт өдрөөс:

Харь улсыг үл тэмцэн,

Хацар гуа охидоо,

Хаан болсон танд

Хасаг тэргэнд суулгаж,

Хар буур хөлгөж,

Хатируулж одож,

Хатдын сууринд,

Хамт суулган бөлгөө.

Улс иргэнийг үл тэмцэн,

Өнгө сайн охидоо

Өлжигтэй тэргэнд суулгаж,

Өл буур хөлгөж,

Үүсгэж одож,

Өндөр суурины

Өрөөл этгээд тану суулган бөлгөө.

Эрт өдрөөс Хонгирад иргэн бид,

Хацар гуа хатадтай,

Өнгө сайхан охидтой бөлгөө.

Зээ зүстэн, охин өнгөтөн бөлгөө”

гэж шүлэглэн танилцуулжээ (“Лу. Алтан товч”).

Дэй сэцэн Хонгирад аймгаа танилцуулж бараад Есүхэй баатарыг өөрийн гэртээ урьжээ:

“Нуган (хүү) хүүхэд минь,

Нутгаа харюу.

Охин ураг (хүүхэд) минь,

Өнгөө үзүүлжюү.

Есүхэй худ гэрт минь од,

Өчүүхэн охиныг минь үзтүгэй”

гэж Есүхэй баатарыг өөрийн гэртээ урин буулгав.

Дэй сэцэний чухам нэр нь Дайз гэдэг. Тэр нь төрөлх сэцэн мэргэн болохоор “сэцэн” гэсэн цолтой болсон гэх буюу “цэрэг дайнд гавьяатай учир сэцэн цолыг шагнажээ” гэж “Юань улсын түүх”⁴-д тэмдэглэж байна. Гэвч Монгол хүний нэрийн дотор дан үеэр бүтсэн нэр бараг харагддаггүй. Тиймээс энэ “дай” гэдэг нь хятад хэлний “да” (их) гэсэн үг байж мэднэ. Хонгирадад хятад худалдаачид байнга ирдэг тул хэд хэдэн “сэцэн” гэсэн нэртнийг ялгахын тул “их”, “бага”-аар тодотгож бүр болох юм. Дэй сэцэний гэргий нь Чотан гэдэг. Чотаны тухай зөвхөн нэрээс өөр мэдээгүй байсаар билээ.

Дэй сэцэний охин нь Бөртэ (зарим тэмдэглэлд Бөртэгэлжин гэж бичдэг ч буй) буюу Бөртэ үжин гэдэг. Дэй сэцэнд гурван хөвгүүнтэй. Ахмад нь Алчи гэдэг (төрийн нагац Алчи ноён), хоёрдугаар нь Ахудай гэдэг, гуравдугаар нь Чэ гэдэг. Тэд хожим нь бүр Чингис хааны доор үйлчилж байсан бөгөөд Алчи нь мянганы ноёноор өргөмжлөгдөж, Хонгирадын гурван мянган өрхөө захирч байжээ. Бөртэ үжинийг эцэг нь “өчүүхэн охин” гэж дуудаж байснаар үзэхүл, тэр нь Дэй сэцэний хүүхдүүдийн дотор хамгийн бага нь болох бололтой бөгөөд Дэй сэцэний намтарт ганц охиноор тэмдэглэжээ.

Бөртэ үжин цагагчин могой жилтэй, 1161 онд төрсөн тул Тэмүжинээс нэг ах. Есүхэй баатар хөвгүүн Тэмүжинээ дагуулан хүрэхэд Бөртэ арван настай байсан билээ. Энэ бол “Нууц товчоон”-ы тэмдэглэл болно. Харин “Хаадын үндсэн хураангуй Алтан товч” (“Хураангуй Алтан товч” гэж товчлов) ба “Хаадын үндсэн Эрдэнийн товч” (хойш “Эрдэнийн товч” гэж товчлов)⁵-д есөн настай гэжээ. Энэ охины төрсөн нь “нүдэндээ галтай, нүүрэндээ гэрэлтэй” гуа хээнцэр, цог жавхлан төгс бүрэн тул Есүхэй баатар үзэж санаанд нь нийлжээ.

Түүхэн тэмдэглэлийг задалж үзвэл, тухайн үед Монголчууд сүй тогтооход их төлөв доорхи заншил журмыг мөрдөж байжээ. Нэгд, охины гэрт хүрч нэг хоноод сая охиныг нь гуйдаг юм байна. Есүхэй баатар Дэй сэцэний гэрт “шөнө хонож маргааш нь гуйваас” гэж “Нууц товчоон”, “Лу. Алтан товч”-д тэмдэглэж буй. Хоёрт, нэг л удаа гуйгаад болдоггүй, харин байн дахин гуйдаг юм байна. Дэй сэцэн: “Олонтоо гуйлгаж өгвөөс дээжлэгдэх, цөөнтэй гуйлгаж өгвөөс доромжлогдох” гэжээ. Ийм болохоор Есүхэй баатар ч лав олон дахин гуйсан байлгүй. Дэй сэцэн Охин хүний заяа төрсөн үүдэнд өтлөх ёсон үгүй, охиноо өгсүгэй би гэжээ. Гуравт, хоёр этгээд ургийн сүйг тогтоосон хойно, хөвгүүнээ охины гэрт үлдээгээд нэг хугацаа суулгадаг юм байна. Энэ бол эхийн эрхэт ёсны үлдэгдэл бас оршсоор гэснийг харуулж байна. Дэй сэцэн охиноо өгье гэж зөвшөөрсөн хойно, “хөвгүүнээ та тавьж од” гэжээ. Дөрөвт, сүй тогтоосон хойно, хөвгүүний талаас охины талд ургийн бэлэг хүргэдэг юм байна. Дараа нь Есүхэй баатараас “за, худ бололцлоо” гэж хөвгүүн Тэмүжинээ үлдээж, хөтлөө морь (“Хураангуй алтан товч”-д “хос морь” гэжээ)-оо сүй тогтсон бэлэг болгон хүргэж, буцаж харьжээ.

Есүхэй баатар юуны учир хол замын алжаалыг хайхралгүй, Тэмүжиний нагац Олхунудын газар очиж Тэмүжинд бэр гуйсан буй гэвэл, тухайн тэр үеийн Монголчууд “овгийн гадна ураглах дүрэм”-тэй юм. Өөрөөр хэлбэл эр эм бологсод нэг овгийн дотроо буюу төрөл овгийн дотроо ураг холбож үл болдог билээ. Тухайн үед ургийн асуудлыг шийдвэрлэхэд хоёр зүйлийн арга байжээ. Нэг нь булаах арга. Тиймээс Тэмүжиний эх Өгэлүн үжинийг анхандаа Мэргид аймгийн Их Чилэдү ураглан авч явж байхад нь замаас нь Есүхэй баатар булаан авсан юм. Энэхүү дүрмийн үр дүнгээр аймаг бүлгийн хоорондоо өрсөлдөн тэмцэх, түүнчлэн байлдаан тулалдаан хийх явдал байнга гардаг байна. Энэ дүрмийн ул мөр нь сүүлдээ Монгол үндэстний нэгэн заншил болж, хурим хийж бэр буулгахдаа шинэ хүргэндээ нум саадаг буюу буу зэвсэг агсуулж очдог. Энэ заншил чөлөөлөгдөхийн өмнөхөн хүртэл уламжлагдаж байжээ. Хоёр нь гэрээ тогтоох арга болно. Өөрөөр хэлбэл төрөл бус овог аймгийн хооронд ураг тогтоох гэрээ тогтоодог бөгөөд хүүгээ охины гэрт хүргэн өгдөг заншилтай билээ. Хоёр овог аймаг ийм гэрээг тогтоосон хойно бие биесээ “хүд” гэж дууддаг. Хонгирад аймгийн Дэй сэцэн Есүхэй баатартай уулзаад “Есүхэй хүд” гэж дуудсан учир нь энэ билээ.

Хонгирад аймаг болон “Ниругун Монголчууд” эртнээсээ аваад урт хугацааны ургийн гэрээтэй байсан гэдэг. Энэ тухай Мин улсын эхэн үеийн хүн Е Цзи Цу-гийн зохиосон “Цао Му Цзи” бичгийн гуравдугаар боть, “Элдэв дүрэм” гэсэн зохиолд: Юань улсын хаадын гол хатад бүр Хонгирад овогтон болох ёс нь Тайцзу хааны үед тэрхүү аймаг лугаа тангараг байгуулж, дэлхийг эзэлсэн хойно үеийн үедээ тус аймгийн охидоор хатан болгоно гэжээ. Бас “Юань улсын түүх”-ийн 114 дүгээр боть “Хатад татварын намтар”-т: Тайцзу хааны Богдын түшээ гэгээн сэцэн ивээлт хуанхүү-гийн алдар Үжин хэмээмүй, Хонгирад овогтны Дэй сэцэний охин... (Хонгирадад) охин төрвөөс хатан болгомуй, хөвгүүн төрвөөс гүнжийг богтломуй, энэ ёсыг үеийн үед таслаж үл болмуй хэмээн зарлиг буулгажээ гэж дээрхтэй адилаар тэмдэглэж буй.

8. Есүхэй баатар нас барсан нь

Есүхэй баатар хөвгүүн Тэмүжиндээ сүй тогтож, Тэмүжинийг Хонгирадын Дэй сэцэний гэрт Монголчуудын ураг барилдах заншлаар хоцоргож, өөрөө гэр өөдөө буцжээ.

Есүхэй баатар харьж явах зам зуураа Чэгчэрийн шар хээрб гэдэг газар хүрэхэд, Жүйн Татар иргэн хурим хийж байх лугаа тааралдав. Тэр зам яваад баахан ундаасч байсан тул Татарчуудын хуримд нь буужээ. Энэ бол “Нууц товчоон”-ы тэмдэглэл болно. Гэтэл энэ явдлыг бас эртний монгол үндэстний зан заншилтай холбогдуулж тайлсан хүмүүс ч байсан билээ. Тэр нь хэдийгээр тодорхой баримтгүй боловч зүйгүй гэж хэлэхийн аргагүй.

Татарчууд Есүхэй баатарыг үзэж таниад, урьд Есүхэй баатар тэднийг байлдан дийлж, тэдний түрүү Тэмүжин үгэ зэргийг барьсан өшөө хорслыг сөхөж, идшинд нь хор хольж идүүлжээ. Есүхэй баатар хортой идээнийг идээд мордон гарч, явах тутам муужирч, гурван хоног яваад арай чамай гэртээ ирж ихэд чилээрхэв. Энэхүү амь насны эцсийн чухал бачим үед, Есүхэй баатар дэргэдээ байсан Хонхотаны Чараха өвгөний хөвгүүн Мүнлиг гэгчийг дуудун ирүүлж гэрээс үлдээжээ. Есүхэй баатарын гэрээс нь:

Нэгд, тэр Тэмүжин хөвгүүнээ хүргэж, Хонгирадын Дэй сэцэн хадамд нь тавиад ирэх зам зуур Татарчуудын хуримд бууж өшөөлөгдөн хороогдоод одоо эдгэрэхээс өнгөрлөө гэжээ.

Хоёрт, өөрийн биеийг үхсэн хойно, өнчин хоцорсон дүү нар, бэлэвсэн бэргэн ба гэр бүлээ асархуйг чи мэд гэж Мүнлигт найджээ.

Гуравт, Тэмүжинийг хурдхан дуудаж авчир гэжээ. Ингээд Есүхэй баатар нас барав.

Есүхэй баатарын төрсөн он жил нь тэмдэглэсэнгүй боловч түүний нас барсан жилийг Тэмүжиний есөн нас, цагаан барс жил гэдэг тул нийтийн он тооллын 1170 он болох ёстой. Есүхэй баатар Хотала хааны үед цэрэг дайнд олон удаа мордож, эрэлхэг гарамгай байлдаж, баатар цолыг олсон юм. Хотала хаанаас хойш, “Ниругун Монголчууд”-ын дотор оройлон шалгарсан ахлагч нь байжээ. Ялангуяа бүх Монголын анхдагч их хаан Чингис хаан Есүхэй баатарын гэрт төрж, мөн түүний гар дор торнин бойжсон тул, тэр монгол туургатандаа үрийн үрд баларшгүй гавьяа зүтгэлийг байгуулжээ. Ингээд Есүхэй баатарыг нас барсны хойнохи ерэн зургаан жил - Чжи Юань-ий гуравдугаар он (1266 он)-ы 10 сарын шарагчин бичин өдөр, түүний жич хөвгүүн, Их Юань улсыг анх байгуулсан эзэн Хубилай сэцэн хаан дээдсийн сүм найман цагаан ордныг байгуулж, Есүхэй баатарт “Шэнь Юань Хуан-ди” цолыг нэхэмжлэн өргөмжлөж, Ля Цзу гэжээ.

Хонхотаны Мүнлиг, Есүхэй баатарыг нас барсан хойно, түүний гэрээсээр Хонгирадын Дэй сэцэний гэрт очиж Тэмүжинийг дуудун авчирсан гэдэг билээ. Бодоход, ямар нэгэн ер бусын учир гарахаас болгоомжилсон бололтой. Мүнлиг, Есүхэй баатарын завшаан бус нас барсан явдлыг Дэй сэцэнд хэлсэнгүй, зөвхөн Есүхэй баатар хүүгээ санаж байна гэсэн шалтагаар Тэмүжинийг авчирчээ. Тиймээс Дэй сэцэн нь Тэмүжинийг түргэн буцаж ир гэж байн дахин захиж байсан гэлээ. Энэ тухай “Нууц товчоон”-ы мэдээ ийм л байжээ. Гэтэл “Лу. Алтан товч”-д: “Мэнлиг (одоогийн галиглал Мүнлиг - эшлэгч) Тэмүжинийг аваад ирвээс, Есүхэй баатар тэнгэр болсонд, Тэмүжин газарт уруу унан хэвтэж, маш гаслахуйд, Хонхотаны Чирхан (одоо Чараха гэж галигладаг - эшлэгч) сэргээн өгүүлсэн ажгуу:

Тул загас мэт яахин,

Тулбиран гасламуй чи?

Туурга цэрэг юүгээ бэхэлье

Эс хү хэмээлдлээ юү?

Лагар загас мэт яахин

Лайвран гасламуй чи?

Нармай олноо байгуулахуй

Эс хэмээлдлүгэй юү?

хэмээн өгүүлбээс хайлахуй (уйлах)-гаа утсан (зогссон) ажгуу” гэсэн тодорхой бөгөөд урнаар өгүүлсэн зүй ёсноо нийцэх тэмдэглэл байдаг юм.

Хонхотан бол “Ниругун Монголчууд”-ын нэгэн салбар овогтон болно. Чингис хааны

зургадугаар үеийн өвөг Хайдугийн гуравдугаар хөвгүүн нь Чаужин Өртэгэй гэдэг, Чаужин Өртэгэй-н хоёрдугаар хөвгүүн нь Төрлүйт (“Нууц товчоон”-д Хонхотан гэжээ) гэдэг. Түүний зам явах нь туйлын хурдан, хамраараа амьсгалах нь хонх дуугарахтай адил тул түүний хойч үрс нь Хонхотан овогтой болсон юм гэлээ. “Эрдэнийн товч”-д “Долоон Хонхотан” гэж гардаг, бодвол Мүнлиг эцгийн долоон хөвгүүнээс үүссэн салбар ч байж мэднэ.

Есүхэй баатарын гэрээсийг хүлээн авсан энэ Мүнлиг-ийг Тэмүжин хэзээд “Мүнлиг эцэг” гэдэг. Энэ тухай Д’Оссоны зохиолд, Есүхэй баатарыг нас барсан хойно, Тэмүжиний эх Өгэлүн үжинтэй энэ Мүнлиг залган суулаа гэжээ. Дүү нь бэргэнээ залгаж болох заншил Эртний Монголд байдаг боловч, Мүнлиг Өгүлэнийг залгасангүй гэдгийг Кобаяши Такаширо болон Владимирцов нар бүр нотолсон бөгөөд бусад тулгар бичгүүдэд ер дурдсангүй, харин Мүнлиг хожим нь салж явснаар үзвэл энэ явдал байх ёсгүй.

Есүхэй баатар завшаан бусаар Татарчуудад хорлогдож нас болсон явдлаас болж, Тэмүжин хадам эцэг Дэй сэцэний гэрт уг тогтоолоор удаан сууж чадсангүй билээ. Гэтэл Чжан Чжэнь Пэй-гийн зохиосон “Чингис хааны шүүмжлэл шастир” гэдэг номд Тэмүжинийг Дэй сэцэний гэрт жил шахам суулаа гэж тэмдэглэж буй. Энэ нь юунаас эшлэсэн гэдгийг үл мэдлээ⁷. Гэвч Тэмүжин нь энэ охорхон хугацаанд, боловсон давшингүй Хонгирад аймаг ба Дэй сэцэний гэрт олон юмыг үзэж сонссон нь дамжиггүй бөгөөд энэ нь мөн Тэмүжиний билиг ухааныг нээгдүүлэхэд зохих үйлдлийг үзүүлсэн нь ч яриангүй юм.

9. Аймаг угсаа нь бутарсан нь

Есүхэй баатар нас барсны дараа жил - 1171 оноос эхэлж, тал нутгийн аймгийг захирч байсан түүний гэр бүлийн байр нь тун түргэн ноцтой их хувиралт гарчээ. Өөрийг байтугай, Есүхэй баатарын төрөл овог асан Тайчигуд хүртэл “Цээлийн ус ширгэв, Цэгээн чулуу хагарав” гээд Онон мөрөн өөд нүүн явжээ. Тайчигуд нарын нүүж явсан явдлыг гадар талаас нь үзэхүл, Амбагай хааны бэлэвсэн хатад ба Өгэлүн эхийн хооронд гарсан ийм тийм зөрчилдөөнөөс болсон мэт боловч хэрэг дээрээ Тайчигуд нар Есүхэй баатарын нас барсан завшааныг далимдуулж, аймаг овгийнхоо тусгаар хөгжлийг олж, аймгийн түрүүгийн ноёрхох эрхээ өргөтгөх оролдлого байсныг сүүл сүүлчийнх нь ажиллагаануудаас мэдэж болно. Тайчигуд аймаг бол Тэмүжиний зургадугаар үеийн өвөг Хайду-гийн хоёрдугаар хөвгүүн Чарахай Линху⁸-гийн хойч болно. Амбагай хаан бол яг энэ аймгийн дээд нь болох тул Тэмүжинд төрөл овог болох юм. Тайчигуд нар арван хоёр, арван гуравдугаар зууны үеэр Онон мөрөн, Хэрлэн гол⁹-ын орчмоор нутаглаж байв. Энэ үед Тайчигудыг тэргүүлж байсан хүн бол Таргутаи Хирилтуг, Төдүгэн Гиртэн¹⁰ гэдэг билээ.

Тайчигуд нар өөртөө тусгаарлаж явснаар барахгүй, Есүхэй баатарын амьд байхдаа захирч байсан бүх иргэдийг нь авч явжээ. Энэ үед Хонхотан овгийн Мүнлигийн эцэг Чараха өвгөн очиж нүүж явагсадыг ятгахад нь Төдүгэн Гиртэн, Чараха өвгөний үгийг хайхарсангүй мөртөө өвгөнийг араас нь жадалж зоо нурууг нь шархдуулжээ.

Ийм байдалд, Есүхэй баатарын бэлэвсэн гэргий ухаан зоригтой Өгэлүн үжин, нүүн явсан иргэдээ хураан авахаар тэднийг үнэнч шударгаар дагаж байсан цөөн хүмүүсийг цуглуулан, Есүхэй баатарын дайчин тугийг¹¹ өргөн мордож, заримыг нь буцааж авчирсан гэлээ. Хэдийгээр Өгэлүн үжин бол нэгэн зоригтой, чадалтай хүн боловч, хэдэн өнчин хүүхдийг

сахисан бэлэвсэн эмэгтэй хүн болох юм чинь хэрхэн Есүхэй баатарын мандуулсан үйл хэргийг нь сэргээж чадах аж. Ингээд буцаж ирсэн иргэд нь бас тогтсонгүй, Тайчигудын хойноос нүүжээ. Эдгээр нүүж явагсад нь Есүхэй баатарын өнчин хүүхэд, бэлэвсэн гэргийг нь хаяж явснаар ч тогтохгүй, тэдний хамаарч байсан Есүхэй баатарын мал хөрөнгийг нь хүртэл цөмийг аваад явсан юм гэлээ. Тэмүжиний гэр ийм хүчир гачигдалд тулгарсан байдал доор, Есүхэй баатарын анд нөхөр нь ба өтгөс боол нь хүртэл хувь хувийн замаа эрж явжээ. Эцэстээ, Есүхэй баатарын гэрээсийг хүлээн авсан Мүнлиг эцэг ч айл өрхөө салаан асын (өөр чигийн – хө.) амьдралаа хийсэн гэдэг билээ.

10. Өгэлүн эхийн өршөөл хайр

Есүхэй баатарын харьяат иргэд, анд нөхөр, зарц боол нь хүртэл зайлж явснаас нааш, Өгэлүн эх тэргүүтэй өнчин хэдэн хүүхдийн амьдрал нь өдрөөс өдөр муудаж, мөхөл доройтлын зовлон энэхүү тал нутгийн язгууртан байсан эрхэм гэрт гэнэт тулгарлаа. Энэ үед Өгэлүн эхийн дэргэд зөвхөн Есүхэй баатарын татвар хатан ба түүний хүүхэд жич нэг хоёр зарц, цөөн тооны мал сүрэг л үлдсэн байна.

Ийм хүчиртэй байдал доор, чадамгай төрсөн Өгэлүн эх өчүүхэн ч гутарч гунисангүйгээр амьдралын гачигдалтай тэмцжээ. Тэр шургуугаар ажиллаж, олирс мойл, сөд гичигэнэ, гогод мангир түүх буюу загас жараахай шүүн, тарвага зурам агнаж, амь гол залгаж байсан юм.

Өнчин өрөөсөн хүүхдээ тэжээн өсгөх, сурган хүмүүжүүлэх аль бүхий айл гэрийн явдал цөм ганц хүн Өгэлүн эхийн мөрөн дээр тавигдлаа. Өгэлүн эхийн өршөөл хайрыг “Нууц товчоон”, “Лу. Алтан товч” зэрэг тулгар бичгүүдэд бүр шүлэглэн магтсан тэмдэглэл байдаг билээ. Доорхи хэдэн бадгийг Ц.Дамдинсүрэнгийн одоочилгыг (орчин цагийн монгол хэлэнд найруулан хөрвүүлснийг) үндэслэж сийрүүлэв:

Оюунтай төрсөн Өэлүн эх

Оёдолт дээлийг огшуулан өмсч

Огтор хормойг шуун бүсэлж

Онон мөрнийг өгсөж уруудаж

Олирс (өлирсүн А. Т) мойл

(мойлсун А. Т)-ыг түүж явж

Өчүүхэн хөвүүдээ хайрлан тэжээж

Өдөр шөнийг аргацаан өнгөрүүлэв.

Чадалтай төрсөн үжин эх

Царсан шорыг барин явж

Цавчим газрыг өгсөж уруудаж

Сөдөн хичгэнийн үндсийг малтаж

Шөнө өдрийг хатамжин өнгөрүүлж

Суут хөвүүдээ тэжээн өсгөв.

Хатан төрсөн үжин эх

Хайлаасан шор барин явж

Халдун уулыг өгсөж уруудаж

Хавийн мангирыг малтан түүж

Хаад хөвүүдээ хайрлан тэжээж

Ханатал цадтал идүүлж өсгөв (А. то).

Гоо төрсөн Өэлүн эх

Гох дэгээ барин явж

Гол завьг өгсөж уруудаж

Гогод мангирыг түүн явж

Хутагтан хөвүүдээ тэжээж өсгөв.

Өгэлүн эхийн хүчир бэрхшээлтэй амьдрал ба түүний хатуу шургуу зориг, ажилч хөдөлмөрч зан авир, ариун цагаан эхийн хайрыг нь “Нууц товчоон”-ы зохиогч хэдхэн бадаг шүлгээр нарийн гүнзгий дүрслэн чаджээ. Энэ бол монгол түүхчдийн товойсон өвөрмөц онцлог болно. Түүхэн хэргийг уран цохилготой шүлгийн хэлбэрээр уянгалан бичсэнийг “Монголын Нууц товчоон”-оос л олж хардаг. Өгэлүн эх хэдийгээр ногоо цагаагаар тэжээсэн боловч өсгөж бойжуулсан хүүхэд нь түмний манлай төрийн зүтгэлтэн, хамаг олны сод, хан дэлхийн аварга болсныг бас хэдэн бадаг шүлгээр дүрсэлжээ.

“Зарчимтай төрсөн үжин эхийн

Затгас төмсөөр тэжээсэн хөвүүд

Засагтан сайд болж өсөв.

Гоо төрсөн үжин эхийн

Гогод мангираар тэжээсэн хөвүүд

Хутагтан сайд болж өсөв”.

Өршөөлт эх Өгэлүн үжин өөрөө идэж өмсөхөө арвилж байгаад өнчин хэдэн хөвгүүдээ идүүлж өмсгөсөнөөр зогсоогүй, хөвгүүдийнхээ сайн сайхан явахыг сааргүй, цөхрөлгүй сургаж байжээ (зураг 28-ыг лавлаарай). Өгэлүн эх хүүхдээ юуны урьд өвөг дээд Хабул хаан, Хотала хаан ба эцэг Есүхэй баатарын дайчин зоригоор дууриалал болгож, өстөн дайсан, ялангуяа Тайчигуд, Татар, тэрчлэн Алтан улсаас эвлэрч болшгүй өшөө хорслоо авахыг мартаж болохгүй гэж сургадаг. Дараад нь тэр эртний Алун гуа эхийн ёсоор хүүхдээ эв бүлгэмдэлтэй яв гэж сургадаг бөгөөд одоо бол “Сүүдрээс бус нөхөргүй, сүүлээс бус цацаагүй”¹² гэж хүчир бэрх байдлыг сануулж байдаг билээ.

Ажилч хөдөлмөрч, асвар (эрс) шулуун, өршөөлч энэрэнгүй монгол эхийн сайн сайхан зан авирыг төгс бүрэлдүүлсэн Өгэлүн эх, өөрийн өнчин хэдэн хүүхдээ ингэж өсгөснөөр барахгүй, тэр бол үгээгүй ядууг тусалж, өнчин өрөөснийг тэтгэн хүмүүжүүлж байсан манлай гэж хэлж болно. Хожим нь Тэмүжин Монголын олон аймгийг нэгтгэх явцад Мэргидийн нутгаас олж авсан Хүчү, Тайчигудын Бэсүд овогтны нутгаас олж авсан Хөхэчү, Татарын нутгаас олж авсан Шигихутуху, Жүрхиний нутгаас олж авсан Борухул энэ дөрвөн хөвгүүнийг бүр Өгэлүн эх өөрийн хүүхэдтэйгээ адил үзэж, хөвгүүдийнхээ “өдөр үзэх нүд, шөнө сонсох чих болгоё” гэж өсгөн бойжуулж, хөлийг нь дөрөөнд, гарыг нь ганзганд хүргэснээр барахгүй, тэд ч цөм бүх Монголыг нэгтгэсэн агуу их үйлсийн дунд Тэмүжиний үнэнч найдвартай анд, өрлөг баатар жанжин, үсэд (хэтэрхий, онцгой – хө.) мэргэн сайд нь болсон юм.

11. Тэмүжин гачигдлын дунд өсөн бойжсон нь

Тэмүжин хэдийгээр нэгэн тал нутгийн язгууртан боржигин овогтны алдарт жанжин Есүхэй баатарын гэрт төрсөн боловч, хар бага насандаа эцгээсээ салж, аймаг угсаатандаа орхигдож туйлын хүчир гачигдалтай амьдралын дунд, бусдын дарлал, доромжлол ба халдлага доор, “сүүдрээс бус нөхөргүй, сүүлээс бус цацаагүй” байдал доор өсч бойжсон юм. Энэхүү орчин тойрон нь Тэмүжиний бойжилтод, ялангуяа түүний зан чанарынхи нь тогтолтод бодтой үйлдлэг болж, гүн нөлөөг өгчээ.

Тэмүжиний бага залуу үеийн товойм харагддаг зан чанар гэвэл доорхи бодтой ажиллагаагаар нь илэрч байв. Юуны урьд шургуу даамгай, ажилч хөдөлмөрч байдагт нь оршино.

Эхийн ачийг мартдаггүй, энгийн хөдөлмөрийг жигшдэггүй Тэмүжиний сайн сайхан зан чанарыг “Нууц товчоон”-д магтан тэмдэглэсэн хэдэн бадаг шүлэг буй:

“Эх үжиний тэжээсэн хөвгүүд

Эрс сайд болон өсч

Эрх омог төгөлдөр болж

Эх Ононы эрэгт сууж

Өлгүүр гох усанд хаяж

Эрэмдэг загасыг шүүн барьж

Эх үжинийг тэжээх болов.

Зарчимт үжиний тэжээсэн хөвгүүд

Засагт эрс болон өсч

Замагтай усыг шүүрдэн байж

Загас жараахайг гөхийдөн барьж

Заяат эхээ тэжээх болов”.

Хаант Монгол Улсын анхдагч их хаан, дэлхий дахиныг донсолгосон алдарт хүний бага насныхи нь амьдрал өв үнэнхүү ийм байв. Энэ бол түүний зан чанарынхи нь нэгэн тал болно.

Гэвч, Тэмүжиний зан чанарын нөгөө нэгэн талын илрэл гэвэл, аюулаас мятрахгүй, алахаас айхгүй, халдагсдад хайргүй хандах догшин ширүүн цөс зоригийг алхам алхмаар бүрэлдүүлжээ. Энэхүү зан чанарынхи нь анхны нэгэн аймшигтай хэрцгий илрэл бол Тэмүжин арван хоёр настай (1173 он) байхдаа эцэг нэг, эх өөр төрсөн дүү Бэгтэрийг алсан явдал болно.

Энэ явдлын өнгөрөлт нь ийм байна. Түүрүү өдөр нь Тэмүжиний харваж алсан нэгэн болжморыг Бэгтэр, Бэлгүтэй хоёр булааж аваад, дараа өдөр нь бас Тэмүжин, Хасар хоёрын гөхийдсөн нэгэн цайвар загасыг нь булаан авсан байлаа. Энэ явдал нь гаднахийн дарлалыг амсаад тэсдэшгүй байсан Тэмүжинд хилэнгийн галыг ноцоожээ. Ингээд тэр өөрийн уураа дарж чадсангүй, өршөөлт эхийн сурааль ятгалыг сонсч авсангүй, Хасартай хоёул далдуур очиж дүү Бэгтэрээ харван алжээ. Энэ явдал гарсан хойно, Өгэлүн эх туйлаар хилэгнэн донгодсон байна.

“Хавиргаа хазах

Хар нохой мэт

Хаданд довтлох

Харцага шонхор мэт

Уураа даран ядах

Омогт арслан мэт

Амьдыг залгих

Аюулт мангас мэт

Сүүдрээ довтлох

Сүрхий араатан мэт

Цугийг залгих

Цурхай загас мэт

...

Барьж идэх

Барс араатан мэт

Балмад амьтан буюу.

Сүүдрээс бус нөхөргүй

Сүүлээс бус цуцаагүй

байхад Тайчигуд нарын хөнөөлийг хүлээж өшөөгөө хэн яахин авах буй гэж эртний үгийг эш татаж, өвгөдийн сургаалийг үндэс болгож, Тэмүжин нарыг ихэд буруушаан зэмлэв.

Энэ явдал нь хэлэлгээнгүй туйлын хэрцгий балмад ажиллагаа юм. Гэвч түүнийг одоогийн байдлаар биш, арван хоёрдугаар зууны нүүдэлчин үндэстний хууль цаазын баталгаагүй балмад хэрцгий нийгэмлэгийнх нь байгуулал ба Тэмүжиний хувь биеийн бодтой орчин тойрноор үздэг бол тийм ч айхавтар хүнд ноцтой явдал биш байсан байх аа.

Энэ явдал нь Тэмүжиний зан чанарын нэгэн нугаршгүй талыг харуулсан боловч үүнээс бас нэлээд сургамжийг хүлээжээ. Нөхөр хань үгүй бол дайснаа дарж чадахгүй гэсэн ёсыг мэджээ.

Тийнхүү залуу бага Тэмүжин, амьдралын будлиантай явц дундаа үнэнч шударгыг эрхэмлэх, анд нөхрийг хайрлах монгол хүний өвөрмөц зан чанарыг алхам алхмаар бүрэлдүүлжээ. Эдгээр зан чанар нь сүүл сүүлчийн түүхэн хэргүүд дээр илэрч байсан бөгөөд цаашдаа хөгжин товойж байсан юм.

Энэ үед, Тэмүжиний оюун санааны хүрээнд түүний бие махбод ба зориг санаанаас нь давсан нэгэн итгэл бишрэл үүссэн байв. Энэ нь даруй “Мөнх тэнгэрийн хүч”-ийг хамгийн дээд сахиулсаар шүтэх итгэл бишрэл болно. Энэхүү үзэл ухамсрын буй болсон нь, Монголчуудын эрт язгуураас бөөгийн шашныг шүтэж байсан уламжлалтай нь холбогдох бөгөөд энэ хэдэн жилийн завшаан бус учралууд нь үүнийг нэн гүнзгийрүүлсэнд оршино.

12. Тайчигудад баригдаж Сорхан шартай нөхөрлөсөн нь

Тэмүжин бага залуу насандаа гурван удаа аюул түгшүүрт учирсан байв. Түрүү нэгэн удаагийн аюул бол Есүхэй баатар нас барсны долоон жилийн дараахи 1177 онд Тайчигуд аймгийн гэнэтийн дайралт ба тэдэнд баригдсан явдал болно.

Мөн энэхүү аюул түгшүүртэй өдрүүдэд Сорхан шар ба түүний хөвгүүд Чулуун, Чимбай нарын халуун тусламжийг олж, тэдэн лүгээ анх удаа анд бололцжээ.

Энэ хэдэн жилийн дотор Тэмүжин бэрх хүчиртэй амьдралын дунд шургуугаар бойжиж, хөл нь дөрөөнд, гар нь ганзаганд хүрснээр ч барахгүй, өд сөд нь урган дууссан өрлөг бүргэдийн зулзага мэт, асга хаданд хальж, алс хол нисэх чадалтай болмоор болоод байжээ. Тэмүжин дэгжирвэл өшөөтнөө өслөх нь зайлшгүй гэснийг Тайчигудын ноёрхогчид мэдэж байсан тул түүнийг бүрмөсөн хүчирхэгжиж бойжихоос өмнө амжиж устгахаар Таргутаг Хирилтуг түүртэй Тайчигуд нар “Гулухад гуужжуху, шилүхэд шивэржүхү”¹³ гээд шадар цэргээ дайчилж довтлохоор иржээ. Энэ бол Тайчигуд нар Тэмүжинийг энэ үед дайрсан гол зорилт нь болно.

Тайчигудад довтлогдсон Өгэлүн эх хэдэн хүүхдээ авч ой шугуйд дутаан зайлаад, Бэлгүтэй мод хугалж шивээ хашилга барьж сэргийлэн, хар багаас харвалга намнаанд бахтай Хасар, дайсантай харвалдаж байхад Тайчигуд нар: “Ахыгаа Тэмүжинийг илгээ, бусад тань хэрэггүй” гэж бархирч байсан гэлээ. Ингээд Тэмүжин Тэргүүнээ өндөрийн шугуй¹⁴ гэдэгт шурган орж далдалсан тул Тайчигуд нар нэвтрэн орж чадсангүй хүрээлэн бүсэлж сахижээ.

Тэмүжин тэнд ес хоногийг өнгөрөөлөө. Хооронд нь хоёр удаа гарахаар оролджээ. Түүрүү удаа эмээл нь битүүгээрээ мултарч, дараа удаа нь гэрийн чинээ нэгэн цагаан чулуу гарах замыг нь бөглөсөнөөс “Тэнгэр минь ятган аху юу” гэж мухар бишрэлийн үүднээс “Мөнх тэнгэр”-ээ итгэж гарч одсонгүй байна. Ингэж есөн хоног хоол ундгүй суугаад тэсч ядахдаа “Энэ мэт нэргүй үхэхээр гарья” гэж зориглон, анх удаа өөрийн бишрэлээ зөрчиж гараад Тайчигудад баригджээ.

Тайчигудын түүрүү Таргутаг Хирилтуг Тэмүжинийг барьж аваачаад засаглан шийтгэж, гарт нь гав, хүзүүнд нь дөнгө зүүлгэж, айл бүрийг өрх дараалан хэсүүлж сүр үзүүлж байсан билээ. Энэ үед яг зуны тэргүүн сар байжээ. Дөрвөн сарын арван зургааны улаан тэргэл өдөр, бодоход тэдний овог аймгийнхаа заншлаар Онон мөрний эх дээр хуримласан байжээ. Хуримын хооронд Тэмүжинийг нэгэн бядуу дорой хүүхдээр сахиулж байв. Завшаан эрэн цаг ямагт дутаахыг хүсч байсан Тэмүжинд энэ хурим нь сайхан тохиол болжээ. Тэр, гаваараа өнө сахиж байсан хүүхдийг цохиж унагаагаад дутаан гарч Ононы шугуй дахи нэгэн тогтмол усан дотор орж, зөвхөн нүүрээ ил гаргаж биеэ далдлажээ.

Тайчигуд нар Тэмүжинийг дутаасныг мэдмэгц шөнө дүлээр Ононы шугуйг нэгжиж эрэл сураг болов. Үүний дотор, Сүлдүс овгийн Сорхан шар¹⁵ гэгч олж үзээд, Тэмүжиний ухаан сэргэлэн, зориг хатуу, жавхлан төгөлдөрийг нь биширч авран туслахаар шийджээ. Чингээд тэр Сорхан шар: “Чи ийм аргатай бөгөөд нүдэндээ галтай, нүүртээ гэрэлтэй хүн тул Тайчигуд ийнхүү атаархах ажгуу. Чи ингээд хэвтэж бай. Би чамайг зааж өгөхгүй” гэж хэлсэн бөгөөд эрж яваа Тайчигуд нарыг мэхлэн явуулжээ.

Сорхан шарын ачаар, Тайчигуд нарын эрлээс мултарсан Тэмүжин, бас Сорхан шарыг эрж түүний тусламжийг дахин олохыг зорьжээ. Түүрүү хэдэн өдөр, Тайчигуд нар Тэмүжинийг айл хэсүүлэн хонуулахад, Сорхан шарын хөвгүүн Чимбай, Чулуун хоёр Тэмүжинийг өр өвдөн хайрлаж шөнө гав гинжийг нь суллаж байсан юмсан. Одоо Сорхан шар олж үзээд Тайчигудад зааж өгсөнгүйг үзэхүл, заавал аврах байлгүй гэж Тэмүжин бодоод явжээ.

Энэ үед Сорхан шарын гэр нь Онон мөрний дэргэд байсан бөгөөд шөнө турш өр цуцтал сүү самарч, эсүг (айраг) бүлдэг нэлээд баян чинээлэг айл байв. “Нууц товчоон” ба “Лу. Алтан товч”-ийн мэдээнээс үзэхүл, Сорхан шард нэр дурдсангүй гэргийгээс нь гадна Чимбай, Чулуун нэртэй хоёр хөвгүүнтэй, Хадаан нэртэй ганц охинтой билээ. Гэтэл “Чингисийн цадиг”-т бас Сорхан шарын ах “Хөшигүн” гэдэг нэгэн хүнийг тэмдэглэжээ.

Тэмүжин Сорхан шарын гэрт хүрсэн хойно, Сорхан шар бүх гэрээрээ эцэг хөвгүүнтэйгээ түүнийг унгас ачсан хар тэрэг (мухлаг тэрэг)-д нууж, нэгжихээр ирсэн Тайчигудыг бас мэхэлж явуулаад, Тэмүжинийг аюулаас хэлтрүүлжээ. Нэгжүүл явсан хойно, Сорхан шар Тэмүжинд амуу хүнс бэлтгэн өгч, нэг нум хоёр сум агсуулж, ам цагаан эрмэг хулагч гүүгээ унуулан, эх ба дүү нарынхаа зүг яв гэж мордуулжээ.

Сорхан шар бол Тайчигуд аймгийн Төдүгэ-гийн харьяат (“Ту Цзи-гийн тэмдэглэл”-д “гэрийн сайд” гэжээ) байжээ. Хожим нь 1202 онд Тэмүжин Тайчигудыг дайлан оруулсан үед, Сорхан шар Зэвийг дагуулж Тэмүжин лүгээ нийлэхээр ирсэн бөгөөд Тэмүжиний Монголыг нэгтгэх их үйлсэд нь олон удаа гавьяа зүтгэл байгуулсан тул Чингисийн дотоод есөн сайдынхи нь нэг болж, 1206 онд Хаант Монгол Улсын наян найман гавьяатны хорин долдугаар мянганы ноёноор томилогдсон байв. Бас Сорхан шар эцэг хүүгийн гуйчлалаар Мэргидийн нутаг Сэлэнгэ 16 дагуу дураар нутаглахыг Чингис хаан зөвшөөрсөн бөгөөд есөн удаа осолдоход нь үл яллах “дархан” цолыг олгожээ.

Чимбай бол Сорхан шарын ахмад хөвгүүн (“Эрдэнийн товч” ба “Чингисийн цадиг”-т Чулууныг ахмад, Чимбайг хоёрдугаар гэдэг бөгөөд цадигт Чимбайн нэрийг “Чимбур” гэжээ) билээ. Хожим нь 1204 оны намар, урьд орж өгсөн Удуйд Мэргидийн хагас нь дахин урваж, Тайхал хороо 17 гэдэг газар нутаглаж байхад, Чимбай Чингисийн зарлигаар зүүн гарын (Ту Цзи баруун гар гэжээ) цэргийг дайчилж очоод дарсан билээ. 1205 оны хавар Маудан, Түдаглин, Жэгүн зэрэг олон Мэргидийг цөм дайлан оруулж, Чингис хаанд ялалтын мэдээ хүргэж байсан юм. мөн энэ 1205 онд, нэгэнтээ орж өгсөн Увас Мэргидийн түрүү Дайр усун гэгч дахин урваж явсанд Чимбай Борухул ноёны хамт баруун гарын цэргийг дайчилж очоод дарав гэж “Нууц товчоон”-д тэмдэглэж байдаг. Гэтэл Японы монголч эрдэмтэн Накамичиё энэ тэмдэглэлийг сэжиглэлтэй гэж үзсэн бөгөөд Чингис хааны 95 мянганы доторхи гучин долдугаар мянганы ноён Дайр гэгч даруй Хулан хатны эцэг Дайр усун мөн гэж үзжээ. “Монголын түүхэн тэмдэглэл”-ийн зохиогч Ту Цзи болон “Чингис хааны шинэ намтар”-ын зохиогч Ли Цзэ Фэнь нар бүр энэ үзэлт лүгээ нэгджээ. Үүнийг цаашид судлууштай гэж би үзэж байна. Сүүлд нь Чимбай бас Хубилай ноёны хамт Харлугуудыг дайлж, түүний түрүү Арслан ханыг нь оруулан авчээ. 1206 онд Хаант Монгол Улсыг байгуулсан тэр үед Чингис хаан түүнд хааны захад биеэр очиж санаснаа хэлэх, дутсанаа гуйх бүрэн эрхийг өгчээ.

Чулуун бол Сорхан шарын хоёрдугаар хөвгүүн нь юм. Хожим нь тэр Тэмүжиний доор эцгээ орлон цэрэг дайчилж, насаараа дайн байлдаанд явж байжээ. Чингисийн дөрвөн хүлгийн нэг нь болно. Нэг удаагийн байлдаанд Чулуун мориноосоо ойчсонд, дайсны жанжин жадламаар байтал, Чулуун дэвхрэн босч дайсны жанжинг жадлан алжээ. Ингээд Чингис хаан эрхий гозойлгон магтаж, баатар цол шагнасан гэлээ. 1206 онд Чингис хаан түүнд Чимбай лугаа адил хааны захад биеэрээ ирж, санаснаа хэлэх, дутсанаа гуйх бүрэн эрхийг өгчээ.

Сүүлд нь Өгөөдэй хааны үед их жанжин Чулуун Алтан улсад дайлаар явж байсан билээ.

Гэвч Чимбай, Чулуун хоёрыг хожим нь ерэн таван мянганы ноёдын дотор нэр дурдсангүй билээ. Үүнийг “Эцэг Сорхан шар нь амьд байсаар бөгөөд мянганы ноён болсон учраас тэр хоёрын нэрийг дурдсангүй биз” гэж Японы монголч эрдэмтэн Накаичиё тэмдэглэжээ.

Сорхан шарын охин нь Хадаан гэдэг. Тэмүжинийг тэдний гэрт нууж байхад энэ охин асарч байв. Хожим нь Тэмүжин Тайчигуд лугаа байлдахад байлдааны талбар дээр нэгэн улаан дээлтэй эм хүн “Тэмүжин, Тэмүжин” гэж их дуугаар уйлан бархирахыг Тэмүжин сонсоод, хүн илгээж асуулгахад Хадаан байсан бөгөөд “Эрийг минь энд цэргүүд барьж алах гэж баймуй” гэжээ. “Чингис хаан сонсоод давхин очиж мориноосоо буугаад Хадаан лугаа тэврэлдэв. Гэтэл эрийг нь цэргүүд тэр завсар нэгэнтээ алжээ. Тэр улсыг хурааж аваад, Чингис хаан их цэргийн хамт мөн тэнд бууж хонов. Хадааныг урин ирж дэргэдээ суулгав”. Энэ бол Хадааны тухай “Нууц товчоон” дахи тэмдэглэл болно. Гэтэл Чжан Чжэнь Пэй-гийн зохиосон “Чингис хааны шүүмжлэл шастир” гэдэгт:

Хожим нь Чулууны гэр аюулд учирч хаанд нийлж ирэв. Хаан, ах дүү хоёрыг дотноор хэрэглэсэн бөгөөд Хадааныг татвар хатан болгожээ гэж тэмдэглэж буй. Ирлийг (анх юунд заасныг - хө.) нь эс мэдлээ.

Тэмүжин бага залуу насандаа түрүү удаа аюулд учирсан ба Сорхан шар нартай нөхөрлөсөн учир ийм билээ.

Тэмүжин, Сорхан шарын нэгэн гэрийн харамгүй дотно дэмжлэгээр дайсан Тайчигудын гараас мултарч Онон мөрөн өөд явж, Химурга горхины Бэдэр хошууны Хурчухуй болдог18 гэдэг газар хүрч, Өгэлүн эх ба дүү нартайгаа учирчээ.

Дараа нь Тэмүжиний гэр хотлоороо нийлэлдэж, Бурхан Халдуны өвөр Хүрэлхү дотор урсах Сэнгүр горхи19-ны Хар зүрхний Хөх нуур гэдэг газар очиж нутаглаад тарвага зурам алж идэн амьдрал. Энэ газар бол эртнээс Боржигин овогтны эх нутаг нь юм.

13. Найман шаргаа дээрэмдүүлж Боорчу лугаа нөхөрлөсөн нь

Тэмүжин бага залуу насандаа хоёрдахи удаа учирсан гол аюул бол найман шарга агтаа дээрэмдэгдсэн явдал болно. Энэ нь мөн 1177 онд гарсан хэрэг бололтой. Зарим номд Мэргидтэй байлдсанаас сүүлд болсноор тэмдэглэж буй. Энэ нь арай таарахгүй мэт.

Тэмүжин энэ удаагийн аюулыг ялах явцад Боорчу-гийн тусламжийг олж түүнтэй нөхөрлөжээ.

Тэмүжиний гэр мөн Бурхан Халдуны өвөр Сэнгүр горхинд нутаглаж байлаа. Нэгэн өдөр, нэг бүлэг дээрэм ирж, гэрийнх нь дэргэд байсан найман шарга агтыг нь үзэж байтал дээрэмдээд явжээ. Одоо Тэмүжиний гэрт ганцхан огтор хонгор морь үлдэв. Гэтэл түүнийг нь энэ өдөр Бэлгүтэй унаад тарвага агнахаар явсан болохоор Тэмүжин явган зогсож яахын ч аргагүй харсаар хоцров.

Орой наран шингэсэн хойно, Бэлгүтэй огтор хонгор мориндоо дааж ядтал тарвага ачаад морио хөтлөсөөр харьж ирлээ. Найман шарга агтаа дээрэмдэгдсэн чимээг сонсоод Бэлгүтэй,

Хасар нар нэхэж явахыг гуйчилжээ. Гэтэл Тэмүжин дүү нараа чадахгүй гээд өөрөө огтор хонгор морио унаад явсан билээ.

Гурван хоногийн зам яваад нэгэн өглөө олон адуун сүрэг хүрэхэд нэгэн гавшгай сэргэлэн хөвгүүн гүү сааж байж билээ. Тэр хөвгүүнээс найман шаргынхаа сургийг асуусанд, энэ өглөө наран гарахаас өмнө үүгээр хөөгөөд гарлаа гэдгийг сонсчээ.

Энэ хөвгүүн бол Арулад овогтны Наху баяны хөвгүүн Боорчу гэгч тэр билээ. “Нөхөр чи их мунгинаж яваа ажгуу. Эрийн мун (бэрхшээл - хө.) нэг адил буй. Би чамд нөхөр больё” гэж Боорчу хэлээд Тэмүжиний огтор хонгор морийг нь тавиулж, орог шунхал морио Тэмүжинд унуулан, өөрөө хурдан ухаа морийг унаж, гэртээ ч харьсангүй, суулгаа хээр боож тавиад, Тэмүжиний хамт найман шаргыг нь нэхэхээр явав.

Тэмүжин Боорчу хоёул найман шаргынхаа мөрийг нь мөрдөж бас гурван хоног явжээ. Нэгэн өдөр наран баруунш ташиж уулын ард орох үес, нэгэн хүрээ айлын дэргэд хүрэхэд найман шарга агт нь тэр хүрээний захад өвс идэж байжээ. Ингээд Тэмүжин ганцаар орон хөөж авчирья гэсэн боловч Боорчу зөвшөөрсөнгүй, хоёул хамт довтолж ороод найман шарга агтаа хөөн гарав.

Тэмүжин, Боорчу хоёрын хойноос олон дээрэмчид цувалдан гарч нэхлээ. Түүний дотор нэгэн саарал морьтой, улаан дээлтэй хүн уурга барьж, үзтэл гүйцэн ирэв. Нөхөр чи нум сумаа над өг, би харвалдья гэж Боорчу хэлсэнд Тэмүжин: Миний төлөө чи эрсдүүзэй (үрэгдүүзэй – хө.), би харвалдья гээд Тэмүжин тэр дээрэмтэй бүрий болтол тулалджээ. Олон дээрмүүд уван цуван нэхэж ирсэн боловч, тэнгэр нэгэнтээ харанхуй болсон тул, цаашид нэхэж чадсангүй хоцров.

Тэмүжин Боорчу хоёр гурван шөнө гурван өдрийн хол замыг аялж Боорчу-гийн гэрт хүрч иржээ. Ингээд Тэмүжин Боорчу-д талархаж, найман шарга агтаас түүнд талархал хүргэе гэсэнд Боорчу: “Би сайн нөхөр чамайг мунгинаж явмуй хэмээн тус больё гэж ханилж явсан билээ. Би олзыг эрсэнгүй” гээд авсангүй. Боорчу-гийн эцэг Наху баян хөвгүүнийхээ үгийг сонсч эсрэг хандан инээж, этгээд хандан уйлж, “уутай (уртыг туулах - хө.) эрийн мун нэгэн буй, үүнийгээ бүү умартагтун” хэмээгээд тэл (тэлээ) хурга алж хүнс өгч хариулав. Энэ бол “Эрдэнийн товч”-ийн тэмдэглэл болно. “Нууц товчоон”-д: Хоёр залуус үүнээс хойш сайхан нөхөрлө, бие биеэ битгий орхи” хэмээв. Ингээд Тэмүжинд тэлээ хурга (хоёр эхийг хөхдөг хурга) алж хүнс амуу бэлтгэн өгөөд явуулжээ гэж тэмдэглэж буй.

Боорчу-тай нөхөрлөсөн учир ийм билээ.

Боорчу-гийн эцэг нь Наху гэдэг, тэр бол Арулад овогтны нэгэн баян чинээлэг айл болох учраас хүмүүс түүнийг “Наху баян” гэж дууддаг байна.

Арулад овогтон бол Тэмүжиний зургадугаар үеийн өвөг Хайду-гийн гуравдугаар хөвгүүн Чаужин Өртэгэй-н гуравдугаар хөвгүүн нь Арулад гэдэг тул түүний хойч нь Арулад овогтон болжээ.

Боорчу бол Наху баяны ахмад хөвгүүн нь болно. Тэр Тэмүжинтэй анх нөхөрлөхөд арван

гурван настай байлаа гэдэг. Тэр, эрэлхэг баатар, хянамгай лавдуун, цэрэг дайнд дадамгай бөгөөд элбэрэл журмыг эрхэмлэж, хувь биеийг боддоггүй. Тэр удалгүй Тэмүжинд нийлэн ирж, бүх Монголыг нэгтгэх их үйлсэд нь хоцролгүйгээр оролцсон бөгөөд Тэмүжиний амийг нь гурван удаа аварсан юм. 1189 онд Тэмүжин анх удаа “Хамаг Монгол Улс”-ын хаан өргөмжлөгдөөд Боорчу-г “хамгийг ахлах” нийтийн захирагч болгожээ. Боорчу дараа нь Чингисийн дөрвөн хүлэг, есөн өрлөгийнх нь нэг нь болсон бөгөөд 1206 онд Хаант Монгол Улсын 88 гавьяатны хоёрдугаараар шагнагдсаны хамт баруун гарын Алтай орчмын түмний ноён болжээ. Тэр мөн есөн удаа осол гаргавч ял үл хэлэлцэх онц эрхтэй юм²⁰.

Тэмүжин Боорчу-тай нөхөрлөснөөс бага залуу наснаа учирсан хоёрдохи удаагийн аюулыг ялалттайгаар даван гарчээ.

14. Бөртэ үжинтэй урагласан нь

Тэмүжин хоёр удаа аюулд учирч, Сорхан шар, Боорчу нарын харамгүй дэмжлэгээр сая атаатан дайсны гараас мултарсан буюу алдсан агтаа буцаан авчирч чаджээ. Ингээд тэр өөрийн хүчиндээ нэлээд итгэлтэй болов.

Одоо тэр нэгэнтээ эрийн насанд хүрсэн тул эцэг Есүхэй баатарын үед сүй тогтсон Бөртэ үжинийг хуримлан авчирахаар шийджээ. Гэвч Бөртэ үжинтэй ураглаж, Дэй сэцэн болон дөрвөн түмэн өрхтэй Хонгирад аймгийн дэмжлэгийг олох явдал бол зөвхөн ураг садан бололцохоос нэн илүү улс төрийн ач холбогдолтой хэрэг болох юм. Ингээд тэр эцэг нэгтэй дүү Бэлгүтэйг дагуулж, Дэй сэцэнийхийг эрэхээр Хэрлэн гол руу явав. Чэгчэр, Чихургу хоёрын хооронд Дэй сэцэн нутаглаж байжээ. Дэй сэцэн Тэмүжинийг үзэж маш их баярлан:

Ах дүү Тайчигуд нар чамд атаархан хорсохыг би мэдэх тул чиний тухай сэтгэл зовнисоор цөхрөхөд хүрсэн билээ. Одоо чамтай уулзав гээд охин Бөртэ үжинээ ураглан өгчээ. Тэмүжин Бөртэ үжинийг авч хамт буцахад, монгол үндэстний удамшилт заншлаар хадам эцэг, хадам эх жич ойр садан нь хүргэлцэн ирсэн байлаа. Гэтэл, Хэрлэнгийн Ураг цөл²¹ гэдэг газар хүрч Дэй сэцэн гэдрэг буцсан байна. Ямар учраас буцсаныг “Нууц товчоон”-д тэмдэглээгүй. Өөр түүх бичигт өвчинтэй болоод буцлаа гэж тэмдэглэж байдаг. “Лу. Алтан товч”-д: “Мариан (мах мариа, бие - хө.) халуун болж Хэрлэн өөд харив” гэжээ. “Чингисийн цадиг”-т: “Бие мариа нь халуун өвчин хүрснээр харьж одов” гэжээ. Ц.Дамдинсүрэн “Алтан товч”-ийг үндэслэж, “Халуунд ядрах тул Хэрлэн рүү гэдрэг буцав” гэж тайлбарлан тэмдэглэжээ. Юу болсон ч хүргэж эс чадах нэгэн ер бусын шалтгаанаас болж буцсан нь лавтай юм.

Тэрхүү охиныг хүргэх явдлыг Дэй сэцэний гэргий Чотан дааж аван, Тэмүжиний нутаглаж байсан Сэнгүр горхинд хүртэл хүргэж өгсөн гэлээ.

Бөртэ үжин Тэмүжинд мордон ирэхэд “эхийн шитхүл” гэж Монголын заншлаар хүргэнд мордох охиныг дагуулан өгдөг бэлэг сэлтийг олон арвин авчирсан нь лавтай хэрэг юм. Тэр “шитхүл”-ийн дотроос өмсгөл болгон авчирсан нэгэн маш ховор үнэт хар булган дахыг манай гол тулгар бичиг “Нууц товчоон”-д тэмдэглэжээ.

Тэмүжин, Бөртэ үжин лүгээ урагласан явдлыг бараг бүр ингэж л тэмдэглэж байдаг. Энэ үед Тэмүжин хэдий настай байсныг олонхи баримт бичигт ер мэдээ үгүй. Гэтэл Саган сэцэний

“Эрдэнийн товч”-д Тэмүжин арван долоон насандаа уу нохой жилд (шар нохой жил, 1178 он) Бөртэ үжинийг авсан гэж тодорхой тэмдэглэж буй. Өөр бат баримттай мэдээ олдохоос өмнө энэ мэдээг үнэн гэж болох мэт.

15. Мэргид аймаг довтолж Бөртэ үжинийг барьж явсан нь

Тэмүжин Бөртэ үжинийг хуримлан авчирсан хойно, Сэнгүр горхиноос нүүж, Хэрлэн голын эх Бүрги эрэг²² гэдэг газар нутаглаж байлаа. Одоо Тэмүжиний өмнө тулгарсан бас нэгэн аюул - түүний бага залуу насандаа учирсан гуравдахи аюул бол Мэргид аймгийн гэнэтийн дайралт болно.

Мэргид аймгийг түүхч Ту Цзи “Цагаан Татар угсааны аймаг”²³ болох бөгөөд Удуйд, Увас, Хаад, Маудан, Түдаглин, Жэгүн²⁴ зэрэг зургаан салбартай гэжээ. Үүний дотор тэргүүний гурвыг нь “Нууц товчоон”-д дурдаж буй.

Мэргид аймгийг бас түрэг гарлын угсаатан гэж Чжан Чжэнь Пэй авгай тэмдэглэжээ. Гэвч манай анхаарснаар бол, Мэргид аймаг нь энэ үед монгол хэлтэн аймгуудын дунд нутаглаж байсан бөгөөд Хонгирад овогтон лугаа ургийн холбоотой байжээ. Тиймээс арван хоёрдугаар зууны үед түүнийг монгол хэлтнээр үзэхэд зүйтэй юм. “Нууц товчоон”-ы тэмдэглэлээс үзэхүл, арван хоёрдугаар зууны үед Мэргид аймаг нь Сэлэнгэ мөрний сав газраар, Жалайр аймгаас өрнөш, умарддаа Ойн иргэд лүгээ зах залган нутаглаж байжээ. Удуйд Мэргид нь Буур Хээр (одоо Байгал нуураас өмнөш буй)-ээр нутагтай байлаа гэдэг. Ц.Дамдинсүрэнгийн “Монголын уран зохиолын түүх”-ийн тэмдэглэлээс үзэхүл, Сэлэнгэ мөрний хавиар нутаглаж байсан Монголчууд бага сага тарианы ажил хийдэг байжээ. Хэрэйдийн Ван хан бага насандаа Мэргидийн газар будаа нүдэж амьдарч явсан гэдэг тэмдэглэл ч буй. Тиймээс Мэргид аймгийн аж ахуй нэлээд хөгжсөн байна. Бас “Монголын олон аймгийн дотроос Мэргид нь их дайчин зоригтой хүчирхэг цэрэгтэй байжээ” гэж “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Түүх” (1956 оны Бээжингийн хэвлэл)-д мэдээлж байв. Арван хоёрдугаар зууны үед Мэргидийн язгууртадын дотор несторианы Христосын шашныг шүтдэг гэлээ. Энэ нь Хэрэйд нараас уламжилсан ч байж мэднэ. Учир нь монгол хэлтний дотор Хэрэйд, Найман, Онгуд зэрэг аймаг несторианыг нэлээд эрт шүтэж байсан нь дамжиггүй юм.

Энэ үед Удуйд Мэргидийн түрүү Тогтуга гэдэг билээ. Тэр нь “бэхи”²⁵ цолтой болохоор Тогтуга бэхи гэж нэрлэдэг байна. Энэ Тогтуга бэхи бол даруй Их Чилэдү гэгчийн ах нь болно. Урьд энэ Их Чилэдү Өгэлүн үжинийг Хонгирадын Олхунудаас ураглан авч явж байхад нь Тэмүжиний эцэг Есүхэй баатар зам зуураас нь булаан авсан юм. Ингээд Мэргид болон Боржигид хоорондоо өшөөтөн болжээ.

Мэргидүүд энэ өшөөгөө авахын төлөө, ялангуяа Тогтуга бэхи дүүгийнхээ өшөөг авахын төлөө, Увас Мэргидийн түрүү Дайр усун, Хаад Мэргидийн түрүү Хаатай Дармала нартай холбоолж, гурван зуун шилдэг цэрэг дайчилж, Хэрлэн голын Бүрги эрэгт саяхан нүүн ирээд байсан Тэмүжиний гэрийг шөнө харанхуйгаар гэнэт дайрчээ.

Энэ үед Тэмүжин Бөртэ үжин лүгээ хуримлан дэмий удаагүй байсан тул мөн л Тэмүжиний арван долоон нас, шар нохой жил (1178 он) байсан бололтой. Мэргидийн довлон ирэх чимээг хамгийн урьд Өгэлүн эхэд удаан жил зарагдаж байсан Хуагчин эмгэн гэгч олж

сонсоод, эхэндээ өшөөтөн Тайчигуд ирлээ гэж бодоцгоож байв. Ингээд Тэмүжин ах дүү нар тун бачим сандруу байдал дор тус бүр нэг морь унаад, үүрийн харанхуйгаар Бурхан Халдуны зүг дутаав.

Гагцхүү Бөртэ үжин болон Хуагчин эмгэнд л морьгүй үлджээ. Ингээд үнэнч шударга хөдөлмөрчин эмгэн Хуагчин, Бөртэ үжинийг бүхээтэй тэргэнд нууж Түнхэлиг горхи26 өөд явж байтал тэрэгнийх нь тэнхлэг нь хугарч Мэргидэд баригджээ. Бөртэ үжин, Хуагчин эмгэнээс гадна, Бэлгүтэйн эх, Есүхэй баатарын татвар хатан Сочигилыг бас барьж явжээ.

Мэргидүүд Тэмүжинийг нэхэж Бурхан Халдуныг гурав тойрон нэгжээд олсонгүй, чингээд “Өгэлүнийг булаагдсан өшөөг авахаар ирээд өдгөө эмсийг нь булааж авав. Өвөг эцгийн өшөөг авав бид гэж гэртээ буцав”. “Нууц товчоон”, “Лу. Алтан товч”-ийн мэдээнээс үзэхүл, Мэргид нар Бөртэ үжинийг барьж авчраад Их Чилэдү-гийн дүү Чилэгэр бөх гэгчид өгсөн гэлээ.

Тэмүжин хэдийгээр нэгэн тал нутгийн язгууртны гэрт төрсөн хөвгүүн боловч түүний бага залуу нас нь энэ мэт өнчин өрөөсөн, хүчир зовлон, аюул түгшүүрийн дунд өнгөрчээ. Ингээд залуу бага Тэмүжиний зан чанар нь тал нутгийн занал хорсол, алалдаан дэвжээний далайд дэвтгээгдэж, өвөрмөц агуулгаа хараахан багаасаа бүрдүүлсэн юм. Тэр нь эрх хүчийг төвлөрүүлж, албадал дарлалыг эсэргүүцэх, өшөө хорслоо авах, өвөг дээдсийн үйл явдлаа сэргээх их сэтгэл ба догшин ширүүн зан чанраар илэрч байв.

Тэр бага залуу насандаа гурван удаа учирсан аюул түгшүүр ба анд нөхөр Сорхан шар, Боорчу нарын дэмжлэгийг олсноос тал нутгийн ертөнцөд оршин тогтнож, ялангуяа өвөг дээдсийнхээ үйл явдлыг сэргээе гэвэл өөрийн найдвартай хүчийг зохион байгуулж, тархай бутархай аймаг угсаагаа хураан нэгтгэхгүй бол болохгүй гэдгийг ухаж мэдсэн байжээ. Нэн ч Мэргидэд гэнэт довглуулж, саяхан урагласан гэргий Бөртэ үжинээ булаагдсан явдал нь Тэмүжинд тун их цохилт болсон бөгөөд энэ өшөөгөө заавал авах зоригийг нь тогтоожээ. Энэ нь хэдийгээр түүний хувийн ашиг сонирхлын үзэл ухамсраас үүссэн боловч нийт үндэстэн нэгдэн, балмад хэрцгийг устгаж, боловсон амьдралаа цогцлоох цаг үеийн шаардлагатай нийцэж байсан юм.

Дагалдвар

1 Марко Поло (1254-1325) гэгч бол арван гуравдугаар зууны үеийн Италийн алдарт жуулчин юм. Тэр Итали улсын Венеци хотын нэгэн баян худалдаачин Николо Поло-гийн гэрт төржээ. Түүний эцэг Николо Поло болон авга эцэг Мафиё Поло хоёр арван гуравдугаар зууны жараад оны эхээр Юань улсын Хубилай хааны төрд анх удаа ирж, Хубилай хааны хүнд их хайр хишгийг олсноор барахгүй, түүний тусгай зарлигаар Европтоо буцаж, хоёрдугаар удаа ирэхдээ өөрийн арван таван настай хөвгүүн Марко Поло-гоо дагуулж ирсэн билээ.

Марко Поло, 1271 оны зунаас эхлэн, эцэг авга хоёроо дагаж, таван жил шахмын хатуу шаргуу, бэрх бартаат аян замыг өнгөрөөгөөд 1275 онд Юань улсын дээд нийслэл Шаньду хот (одоогийн Өвөр Монголын Өөртөө Засах Орны Шулуун хөх хошуунд буй)-д хүрч ирсэн юм. Ингээд тэр Хубилай хааны онцгой итгэл хүндийг олж, 1292 он болтол Юань улсын төрд чухал албан тушаалыг гүйцэтгэжээ. Түүний алдарт зохиол “Марко Поло-гийн аяллын тэмдэглэл” гэдэг нь даруй энэ үеийн үзэж сонссон маш олон сонирхолтой зүйлээ

тэмдэглэсэн зохиол болно. Энэхүү аяллын тэмдэглэл нь тухайн үеийн түүх, ялангуяа Монголын түүх ба нийгмийн байдал - улс төр, цэрэг дайн, аж ахуй болон Дундад улсын үндэстнүүдийн харьцаа зэргийг судлахад лавлууштай чухал материал болох бөгөөд нэлээд ховор зүйлсийг ууган баримтын хувиар бидэнд бэлтгэн өгчээ.

2 “Чэгчэр Чихургу” гэсэн газар нь Хэрлэн голын адгаар байдаг эртний “Үнэгэн гүйлт, Чугулаху буюу Чугурху”-гийн хооронд байжээ. “Цоргоос морь усалж байхад уулзав” гэсэн нь Г.Галсангийн хэвлүүлсэн “Алтан товч”-д байдаг байна. “Чихургу” гэснийг “Нууц товчоон”-д “чихурху”, “чихургу” гэж хоёр янзаар галиглажээ.

3 Дэй сэцэний нэрийг “Нууц товчоон”-ы хятад галигийн эх дэвтэрт “Дэ” гэж, “Лу. Алтан товч”-д “Дайи” гэж, “Юань улсын түүх”-д “Тэ” гэж, “Биеэр дайлсан тэмдэглэл”-д “Дэ-и” гэж, Ц.Дамдинсүрэнгийн орчуулсан “Нууц товчоон”-д “Дэй” гэж, Японы монголч эрдэмтэн Кобаяши Такаширо-гийн зохиосон “Чингис хаан” гэдэг бичигт “Дэй сэчин” гэж тус тус тэмдэглэж байна. Үүнээс гадна, 1943 онд Чуулалт хаалга хотноо хэвлүүлсэн “Богд Чингис хааны байлдааны бичиг” гэдэгт “Дэ сэцэн” гэсэн нь “Юань улсын түүх”-ийг баримтласан нь илт билээ.

Дэй сэцэний гэргийн нэрийн тухай мөн хэд хэдэн янзаар бичдэгийг энд хамтатган тэмдэглэе. Тус товчоонд ерөнхийдөө Баярын шинэ галигласан “Нууц товчоон”-ы нэрсийн бичлэгийг үндэслэсэн (хаяа заримыг нь өөрчлөв) тул “Чотан” гэж бичлээ. Харин “Лу. Алтан товч”-д “Жотан” гэж, “Хураангуй Алтан товч”-д “Жүтэй” гэж, Ц.Дамдинсүрэнгийн орчуулсан “Нууц товчоон”-д “Цотан”) гэж, Кобаяши Такаширо-гийн бичигт “Сотан” гэж, “Асрагч нэртийн түүх”-д “Ёота” гэж тус тус адилгүй тэмдэглэж буй.

4 “Юань улсын түүх” бол Дундад улсын хорин дөрвөн түүхийн нэг нь болно. Тус номын тухай 1976 оны 4 сард Чжунхуа бичгийн товчооноос хэвлүүлсэн шинэ хэвлэлийн “Юань улсын түүх”-ийн “Хэвлэлийн тодорхойлолт”-д танилцуулсныг доор товчлон сийрүүлбэ: “Юань улсын түүх” бол нийт 210 ботитой. Тэр нь манай улсын түүхэн дэх Юань улсын нэгэн үеийн мандал мөхлийн өнгөрөлтийг нэлээд системтэйгээр тэмдэглэсэн феодалын түүхэн бичиг юм. Хунхуа (Хун У)-гийн тэргүүн он (1368 он), даруй Юань улс мөхсөн тэр жил, “Юань улсын түүх”-ийг найруулан бичих тухай Мин улсын Тайцзу хаан Чжу Юань Чжан зарлиг буулгажээ. Дараа жилд нь Ли Шань Чан гэгчээр хянагч болгож, Сун Лянь, Ван Вэй хоёроор ерөнхий туслагч болгож, Чжао Сюань зэрэг арван зургаан хүнээр найруулагч болгож эхлэн найруулаад зөвхөн 188 өдрийн дотор, Юань улсын эцсийн хаан Тогоонтөмөр хааны нэгэн төрөөс бусдынхи нь шастир, тэмдэглэл, илтгэл, намтар зэрэг 159 боть түүхийг найруулан дуусгажээ. Залгаад У Янь Ю зэрэг арван хоёр хүнээр Тогоонтөмөрийн төрийн материалыг газар болгоноос ирүүлэн цуглуулж, Хун-хуа-гийн гуравдугаар он (1370 он)-оос эхлэн, мөн Сун Лянь зэрэг арван таван хүн 143 өдрийн дотор нийт тавин гурван боть түүхийг залган найруулжээ. Ингээд өмнөх найруулсантайгаа нийлж нийт 210 боть бүх түүхийг урьд хожид 331 өдрийн дотор найруулан дуусгажээ.

“Юань улсын түүх” нь жил хүрэхгүй охорхон хугацаанд бичигдсэн учраас бүдүүлэг тал нэлээд оршиж байдаг боловч, тэр нь Юань улсын эл төрийн үнэн тэмдэглэл мэт одоо нэгэнтээ үрэгдсэн чухал түүхэн материалыг нэлээд бүрэн бүтнээр хадгалж үлдээжээ. Тиймээс “Нууц товчоон”-оос хойшихи зуу гаруй жилийн Монголын түүхийг судлахад

омтгойлж болшгүй ууган чухал баримт болно.

5 “Хаадын үндсэн хураангуй алтан товч” ба “Хаадын үндэсний эрдэнийн товч” гэдэг хоёр ном бол мөн монгол хүн монгол хэлээрээ зохиосон Эртний Монголын түүх болно. “Эрдэнийн товч”-ийг “Нууц товчоон”, “Лу. Алтан товч” лугаа зэрэгцүүлж, Монголоор зохиогдсон Монголын түүхийн гурван тулгар бичгийн нэгээр үнэлж, дотоод гадаадад нэлээд алдартай юм. Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хорооноос 1979 онд хэвлэгдсэн нөхөр Лю Цзинь Со-гийн “Арван гурав - арван долдугаар зууны Монголын түүх бичлэг” гэдэг тусгай зохиолд энэ хоёр зохиолыг нэлээд нарийн ойлгох боломжийг хангажээ.

“Хураангуй Алтан товч”-ийг чухам хэдийд ямар хүн зохиосон гэдэг тодорхой тэмдэглэл ерөөс үгүй байсан болохоор сүүлчийн үед эрдэмтэд янз бүрээр судлаж байна. “1630 онд Өвөр Монголын Мэргэн гэгээн зохиосон” гэж Японы монголч эрдэмтэн Кобаяши Такаширо үзжээ. “1604-1627 оны хооронд зохиогдсон магадгүй” гэж Зөвлөлтийн дорно дахиныг судлагч Н.П.Шастина үзжээ. Монгол улсын түүхч Х.Пэрлээ “1604 онд зохиогдсон” гэжээ. Нөхөр Лю Цзинь Со-гийн санал бол цагийн талаар 1604-1634 оны хооронд бичигдсэн гэж тойм цагийг нь нуталжээ. Зохиогчийг нь Мэргэн гэгээн лав биш гэжээ. Харин 1618-1634 оны хооронд Сарва хутагтын зохиосон “Хаадын үндэсний тууж” бол энэхүү “Хаадын үндэсний хураангуй Алтан товч” мөн болов уу гэж нөхөр Лю Цзинь Со үзжээ.

“Хураангуй Алтан товч”-д арван дөрөв - арван зургадугаар зууны үе дэх эртний Монголын түүхийг “хураангуй”-гаар тэмдэглэж байхаар үл барам, өөр сурвалж бичгүүдэд байгаагүй чухал чухал мэдээнүүдийг тэмдэглэж байна.

“Хураангуй Алтан товч”-ийн анх хэвлэлийг 1858 онд Буриад Монголын эрдэмтэн Гомбоевын орос орчуулгын хамт “Монголын он дараалсан тэмдэглэл” гэдэг нэрээр оросын Казань хотод хэвлүүлжээ гэдэг. Хоёрдугаар хэвлэлийг нь 1925 онд Тэмгэт (хятад нэр нь Ван Жуй Чан гэдэг. Энэ Тэмгэт гэсэн нь “мэнгэ” гэсэн үгийн манж хэллэг байна. Харин манайхны байнга бичдэг “Тэмээт” биш. Үүнийг Б.Ринчин, Нагойсайнхүү нар тайлж өнгөрөв)-ийн эрхэлсэн Бээжингийн Монгол Бичгийн Хорооноос “Богд Чингис хааны цадиг” гэсэн нэрээр түрүүчийн хагасыг нь хэвлүүлжээ. Үүнийг Монгол улсын Шинжлэх Ухааны Хүрээлэнгээс сүйтгэл гаргаж хэвлүүлснийг бид Ц.Дамдинсүрэнгийн “Нууц товчоон”-ы оршлоос мэдэж болно. Гуравдугаар хэвлэлийг нь 1940 онд Чуулалт хаалга хотод “Алтан товч” гэсэн нэрээр хэвлүүлжээ. 1980 онд Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хорооноос хэвлүүлсэн нөхөр Лю Цзинь Со-гийн тулган харьцуулж тайлбар зүүлт хийсэн “Хаадын үндэсний хураангуй Алтан товч” бол одоо манай ашиглаж бүхий хамгийн төгөлдөр нэгэн хэвлэл болно.

“Эрдэнийн товч” бол Монголоор зохиосон монгол түүхийн гурван тулгар бичгийн нэг гэж дотоод гадаадын олон эрдэмтэн үнэлдгийг дээр нэгэнтээ дурдсан билээ. Тус номын тухай нөхөр Лю Цзинь Со-гийн зохиолын 283-317 дугаар хуудсанд нарийн танилцуулсан болохоор энд би олон зүйлийг нуршихгүй, зөвхөн бодогдож байсан нэг хоёр зүйлийг нөхвөрлөн тэмдэглэе.

“Эрдэнийн товч”-ийг Чин улсын Энх-Амгалангийн анхдугаар он буюу нийтийн он тооллын 1662 онд зохиогдсон гэж үзсээр ирсэн юм. Энэ үзэлт бол “Эрдэнийн товч”-ийн төгсгөлд “Энх-Амгалан хааны анхдугаар онд болсон хэрэг явдлыг бичиж, түүний зохиолын түүхийн

хэсгээ төгсгөжээ” гэсэн (Лю Цзинь Со)-ээр нь 1662 он гэж нотолжээ. Гэвч би хувьдаа 1663 он болов уу гэж ердөө бодоод байдаг. Учир нь Саган сэцэний бичсэн ёгт утга бүхий он сарыг хэрхэн үзэх дээр суурилж байна. Саган сэцэний номын сүүлд:

Ургамал төрсөн жил есөн улаан хилэнт хэмээхийн тавин есдүгээр. Ургасан огторгуйн жил найман цагааныг үүсгэгчийн хоёрдугаар. Ударибалгүни (Үхээр хар зардасун одон) сарын арван нэгэн модон гараг ялгуусан одон өдөр эхлэн. Учирч Бурвасад (долоон өлзийт баян одон) сарын нэгэн шинэ гадсан (пүрэв) гараг Бус (ганц өнчин улсын эзэн одон) одны өдрөө төгсгөв” гэж зохиолоо зохиогдсон цагийг тэмдэглэжээ.

Миний танилтаар эхний нэг бадаг: “Ургамал төрсөн жил, есөн улаан хилэнт хэмээхийн тавин есдүгээр” гэснийг “ургамал төрсөн жил” гэсэн нь Саган сэцэний “өөрийн төрсөн жил” гэсэн утгыг харуулсан бололтой, өөрөөр хэлбэл Саган сэцэн зохиолоо бичиж төгсгөхөд “тавин есөн настай байснаа хэлсэн мэт. Саган сэцэн бол хөх луу жил (1604 он)-д төрсөн нь лав үнэн юм. Тэгвэл түүний жаран насан дээр бас нэг хөх луу жил болох ёстой, энэ хөх луу жил нь яг 1664 он болох тул түүний тавин есөн нас нь хэлэлгээнгүй 1663 он болох юм. “Ургасан огторгуйн жил, найман цагааныг үүсгэгчийн хоёрдугаар” гэдэг нь “тэнгэрийн заяат гүрэн төрийн он бол Монголын хаан мэт найман цагаан гэрийг үүсгэн байгуулсан хааны хоёрдугаар он” гэсэн ёгт утгыг харуулсан мэт. Энэ бол Чин улсын Энх Амгалангийн хоёрдугаар оныг хэлж байна. Энх Амгалангийн хоёрдугаар он нь мөн ч яг 1663 он болно. Тиймээс тус номын зохиогдсон он нь 1662 он биш харин 1663 он гэж би үзэж байна. Мөн Саган сэцэн зохиолынхоо сүүлд Энх Амгалангийн анхдугаар оны учрыг тэмдэглэсэн явдал нь хоёрдугаар онд бичсэн гэдгийг тэр биеэрээ харуулж байна.

Тэгвэл зохиогчийн нэрийн тухай санал болно. Энэ тухай би 1979 оны 12 сард бичсэн “Цахарын тойм байдал” гэдэг өгүүлэл (“Монгол хэл бичиг” сэтгүүл, 1980 оны гуравдугаар хугацаа)-д өөрийн үзэлтээ дурдсан юм. Түүнийг доор хураангуйлан сийрүүлье:

1962 онд Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хорооноос гэрэл зургаар хэвлүүлсэн “Хаадын үндэсний Эрдэнийн товч”-ийн хэвлэлийн мэдэгдэхүүнд зохиогчийн нэрийг “Сананг сэцэн” (Са-нанг Сэ-цэн) гэж бичжээ (харин 1980 онд хэвлүүлсэн өөр нэгэн хэвлэлд “Саганг сэцэн” гэж бичжээ). Энэ нь хятад орчуулгыг нь баримтласан нь илт байна. Миний үзэлтээр “Саган сэцэн” гэвэл зохих мэт. Учир нь зохиогчийн нэрийг өөрийн зохиолдоо урьд хожид найман удаа илэрчээ. Түүний дотор таван удаа нь “Сахан”, хоёр удаа нь “Саханг”, нэг удаа нь “Саганг” гэж тус тус тэмдэглэж буй. Монгол үсгийн хуучин бичлэгээс анхаарвал, “на”, “га”-гийн дуслыг олонхидоо бүр тавьдаггүй байжээ. Түүнийг голдуу ацгийн тоогоор нь буюу дээр доорхи үг өгүүлбэрээр нь зөв нэрлэж болох юм. Уул зохиолд зохиогчийн нэр нь “Са + га + н” ба “Са + хан + нг”-аар бүрэлджээ. Энэ нь (ha) “ха” буюу (ga) “га” гэсэн дүнг олохоос биш (na) “на” гэсэн дүнг яавч олох ёсгүй юм. Чингэвэл би яагаад “ха”-г “га” гэж буй гэвэл, мөн зохиогчийн өөрийнх нь бичлэгийг үндэслэжээ. Зохиогч нэрээ найман удаа бичсэний доор нэг удаа нь дусалтай “га”-гаар бичжээ. Чингэвэл яагаад “Саганг” гэхгүй “Саган” гэх буй гэвэл, зохиогч таван удаа хэлний үзүүрийн “н” (n)-ээр бичсэн болохоор энэ нь зөв гэж үзнэ. Утга зүйн талаар үзсэн ч энэ нь “цагаан” гэсэн үгийн эртний дуудлага “саган” байж мэднэ. Барга буриадад “цагаан” гэдгийг одоо ч “саган” гэдэг юм. Дахивал хамрын хөндийн “нг” (ng) болон хэлний үзүүрийн “н” (n)-ийг холилдон хэрэглэх явдал монгол хэлний зарим нутгийн

аялгуунд байнга харагддагийг тусгаж байна.

Гутгаарт, “Эрдэнийн товч”-ийн гол үнэ банатай зүйл бол Юань улсаас хойших, ялангуяа Батмөнх даян хааны системийн түүхийг нэлээд нарийн дэлгэрэнгүй тэмдэглэж үлдээсэн явдал болно. Өөрөөр хэлбэл, баруун гурван түмний түүхийн чухал тулгар баримт болно. Гэвч Чингисийн тухай тэмдэглэлийн олонхи нь найдваргүйг тэмдэглэх чухалтай байна.

6 “Чэгцэрийн шар хээр”, энэ газар бол “Чэгчэр” (тус бүлгийн дагалдвар2-ыг лавлаарай)-ээс ойр байсан бололтой. “Нууц товчоон”-ы хятад галигийн эхэд “che-k`e)-che-run, shi-ra-k`e-gie” гэж, “Лу. Алтан товч”-д “Чэгцэрийн шар хээр” гэж тэмдэглэж байна. Зөвхөн Ц.Дамдинсүрэнгийн “Нууц товчоон”-д “Цэгцэрийн шар тал” гэжээ.

7 1221 онд Сүн улсын элч Чжао Хун-гийн бичсэн “Монгол Татарын бүрэн тэмдэглэл” гэдэг зохиолд, “Чингис хаан багадаа Жүрчин хүнд баригдаж, арваад жил боол зардас болоод сая дугаан харьж иржээ. Тиймээс Алтан улсын явдлыг сайн мэддэг” гэжээ. Энэ тэмдэглэл огт таарахгүй гэдгийг аль олон түүх баримт бүр нотолж буй. Энэ тухай Зөвлөлтийн монголч эрдэмтэн Б.Я.Владимирцов: “Тэмүжинийг урт хугацаагаар Дундад улсад сууж байсан гэсэн уламжлал яриа бол харин Тэмүжин Дэй сэцэний гэрт нэгэн хугацаа байсан явдлаас эш авч хэлсэн ч магадгүй” гэж хэлэв. Би бодоход Владимирцовын үзэлт зөв байна.

8 Чарахай Линху-гийн “Линху” гэдгийг Хятанаас Чарахай-д олгосон “Линг Вэн” гэдэг тушаалын нэр гэж түүхч Ту Цзи тайлбарлажээ. Японы монголч эрдэмтэн Накаичиё “Линху” гэдэг үг бол “Линг гүн” гэсэн хятад үгийн хувирал гэжээ. Ляо улсын үед Монголчууд Хятаны харьяат байсан тул өмнөх тайлбар нь зүйтэй мэт.

9 Хэрүлүн мөрөн (одоо Хэрлэн гол гэдэг байна) бол Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Хэнтий нуруунаас ундарч, Өвөр Монголын Өөртөө Засах Орны Хөлөн нуурт цутгадаг Номхон далайн усан системийн гол билээ. Түүний бүх урт нь 1.264 км, 174 км нь Дундад улсын дотоод гол юм.

10 Таргутаи Хирилтуг ба Төдүгэн Гиртэ бол Амбагай хааны хөвгүүд болно. “Д`Оссоны түүх”-д Адал хаан (Adal-Khan)-ы хөвгүүн гэжээ. “Адал” гэдэг нь Амбагайг ташаарсан явдал болно. “Амбагай хаан хорлогдсон хойно, Тайчигуд түрүүгээ (тэргүүлэгчээ - хө.) урт хугацаанд сонгон тогтоож чадахгүй байлаа. Сүүлд нь чухам хэн нь Тайчигудыг даргалж байсныг бүү мэд. Харин Есүхэйг үхсэн хойно, Тайчигуд нар Есүхэйн хөвгүүнийг цэргээр довлох үед Тайчигудын түрүү нь Адал (Амбагай) хааны хөвгүүн Таргутаи байсныг мэдлээ” гэж “Д`Оссоны түүх”-д тэмдэглэж буй.

11 Энэ үед Монголчуудын хэрэглэж байсан “туг” нь одоогийн тугтай адилгүй юм. Үүний тухай “Д`Оссоны түүх”-д, Висделоу (Visdelou)-гийн зохиосон “Татар орны түүх” ба Абел Ремюза (Abel Remusat)-ын зохиосон “Татар хэлний судлал” гэсэн номоос эшлэж доорхи мэтээр тайлбарлажээ.

“Туг” гэдэг бол Дундад улсын сүлдийн нэр юм. Түүнийг нэгэн урт жадны дээр сарлагийн сүүлийг уяж хийдэг бөгөөд Дундад улсын хааны тусгай хэрэглэлт дарцаг болно. Түүнээс Түрэг Татарын харьяат ван нарыг өргөмжлөхөд энэ “туг”-аа хэнгэрэгийн хамт шагнадаг

байна. Тиймээс Түрэг, Тагарчуудад “туг” гэсэн нэртэй болжээ. Гагцхүү сарлаг байдаггүй тул морины сүүлээр орлуулдаг юм. Энэхүү “туг” ба хэнгэрэг бол тушаалд өргөмжлөгдөх буюу цэрэг дайныг дайчлахын тэмдэг болсон билээ гэжээ.

Одоо бид ийм “туг”-ийг Чингисийн сүлд гэж, Өвөр Монголын Эзэн хороон дахи “Чингис хааны онгон”-д тахиж байхыг олж үзлээ. Энэ сүлдийг Чин улсын үед тахин сэргээн үйлдэхэд эртний уламжлал заншлыг үндэслэж, гурван зуун хээр азарганы хур дэлээс авч үйлдсэн гэж нэгэн өвгөн дархадаас би 1959 онд сурвалжлан сонссон юм.

12 “Цацаа” гэдэг үгийг толгой эхэд нь “Чи-чу-а” гэж галиглаж, хажуугаар нь “ташуур” гэсэн орчуулга зүүлгэж байна. “Лу. Алтан товч”-д “чүчигэ” гэжээ. Ц.Дамдинсүрэн “ташуур” гэж буулгажээ. Энэ нь хажуугийнхи нь орчуулгыг үндэслэсэн нь илт байна. Нөхөр Дорнотивийн хятадчилгад “сацаг” гэж орчуулаад, тайлбартаа “ташуур” гэснийг таарсангүй гэжээ. Нөхөр Дорнотивийн тайлалтыг би хувьдаа зөв гэж үзээд уг “чичуга”-г “цацаа” гэж буулгалаа. Энэхүү “Сүүдрээс бус нөхөргүй, сүүлнээс бус цацаагүй” гэсэн бүхэл үгийнх нь утга нь хань нөхөргүй ганцаархан, мал сүрэггүй ядуу гэсэн санааг харуулж байна.

13 “Гулухад гуужижугу, шилүхэд шивэрижүгү” гэсэн энэ нэгэн бадаг үг нь уг эхэд “голухут гу`ужижу`у шилүгэт шибэрижү`ү” гэдэг бөгөөд хажуугийн орчуулгад нь: “Өөдгүй муусайны үс нь гуужиж шүлс нулимсаа татах хэмжээнд хүрчээ” гэжээ. Үүнийг “Лу. Алтан товч”-д “Хулхад хужиж, шилүгэн шивэрчүхү” гэжээ. “Богд Чингис хааны байлдааны бичиг”-т: “Зулзага шувуу боловч жигүүр өдөн сунах, хурга хонь боловч хожим бүдүүжиж сайжирчээ” гэжээ. Ц.Дамдинсүрэнгийн “Нууц товчоон”-д: “Хурганы үс гуужив, Төлгөний бие төлжив” (Өэлүний хөвгүүд тэнхрэв) гэжээ. Нөхөр Дорнотивийн хятадчилгад: “Зулзага шувууны өд сөд нь гуужиж, төлгөн хурган өсч томров” гэжээ. Эдгээр орчуулга арай хангамжгүй мэт. Гэвч өөр оновчтой баримт олсонгүй тул энд асуулт болгон тэмдэглэе.

14 “Тэргүүнээ өндөрийн шугуй” гэсэн газрын нэрийг “Нууц товчоон”-ы хятад галигийн уг эхэд: “хамгийн өндөр уулын оргил дахи шугуй” гэжээ. Ц.Дамдинсүрэнгийн “Нууц товчоон”-д: “Тэргүүн өндрийн шугуй” гэв. Гэтэл Ся Цзай Шань-ий орчуулсан тус номын хятадчилгад: “Хамгийн өндөр уулан дахи шугуй” гэсэн энгийн үг болгожээ. Үүнийг Х.Пэрлээ Онон Хэрлэн хоёрын эхний хооронд буй “Их газрын даваа”-гаар, Тэмүжинийг барьсанд Тайчигуд буцсан газар гэдэг Хэрлэн хавийн нутгийн ардын домгийг үндэслэж, “Тэргүүн өндрийн шугуй” бол Хэрлэн голын эхээр (уртраг нь 109°, өргөрөг нь 49°) байсан бололтой гэжээ.

15 Сүлдүс овогтон бол “Дүрлүгин Монголчууд”-ын аймаг юм. “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д “Сүлдүс” гэдэг бол нэгэн зүйлийн өвсний нэр болох бөгөөд энэ аймгийн нутагт ийм өвс тал дүүрэн ургадаг тул овог аймгаа ингэж нэрлэсэн гэдэг домогтой гэжээ. “Лу. Алтан товч”-д “Сүлдтэй” гэж “Эрдэнийн товч”-д “Сүлдүс, Сүлдсэн, Сүлдүс” гэж тус тус баахан зөрөөтэй бичиж байх бөгөөд Сорхан шарыг “Лу. Алтан товч” ба “Эрдэнийн товч”-д “Торган шар” гэж, “Чингисийн цадиг”-т “Торгон шар” гэж, “Богд Чингис хааны байлдааны бичиг”-т “Соргон шар” гэж тус тус баахан зөрөөтэй тэмдэглэж байхыг энд хяналт болгон тэмдэглэе.

16 “Сэлэнгэ мөрөн”-ийг одоо болтол мөн “Сэлэнгэ”-ээр нэрлэж буй. Тэр нь Байгал далайд цутгадаг Умард мөсөн далайн системийн гол болох бөгөөд бүх урт нь 992 км болно. Баахан сонирхолтой нь энэхүү “сэлэнгэ” гэсэн үг “Төмөртэй” гэсэн манж үг байна. Арван

хоёрдугаар зууны үед Монголын газарзүйн нэрд манж гаралтай үг бараг харагддаггүй юм.

17 “Тайхал хороо”-г “Юань улсын түүх” (монголчилгын нэгдүгээр дэвтэр)-т “Тайхан цайз” гэж, “Судрын чуулган”-д “Тайха хад” гэж бичиж байдаг. Үүнийг Х.Пэрлээ “Тайхал хороо” мөн гэж үзээд, Халхын баруун хагаст байсан нь илэрхий тул одоогийн Орхон голын хөвөөн дэх Эрдэнэ зуугийн хуучин суурь “Тахай балгас” мөн бололтой гэж жишжээ. Энэ нэрийг Ц.Дамдинсүрэнгийн “Нууц товчоон”-д “Тайхал шивээ” гэжээ.

18 “Химурга горхи” бол эртний Бурхан Халдун уулын ард Онон мөрний солгой этгээдээс цутгадаг байжээ. Одоо “Чимүргэ” нэртэй болсон байж мэднэ гэж “Нууц товчоон”-ы оросчилгын тайлбарт П.Кафаров тэмдэглэжээ.

“Бэдэр хошуу” ба “Хурчухай болдог” бол энэ “Химурга горхи”-ноос ойр байжээ.

19 Энд дурдсан “Хүрэлхү” гэдэг бол эртний Бурхан Халдун уулын өвөр (уртраг нь 109°, өргөрөг нь 49°)-т байх уулын нэр юм гэлээ. “Сэнгүр горхи” гэдгийг Ц.Дамдинсүрэн “Цэнхэрийн гол” гэж тайлбарласан байна. Тийм бол энэ нь уртраг нь 110°, өргөрөг нь 47°-д байдаг. “Цэнхэрийн гол”-ыг Монголын хуучин газрын зурагт “Сэнгэр” гэж бичдэг байжээ. Тус зууны хориод оноос сая “Цэнхэрийн гол” гэж халсан гэлээ. Ц.Дамдинсүрэн бараг үүнийг үндэслэсэн маягтай. Харин энэ “Сэнгүр горхи” нь “Нууц товчоон”-д гардгаар үзвэл, Хэнтий уулын ойр (уртраг нь 109°, өргөрөг нь 49°) байлтай гэж Х.Пэрлээ үзжээ.

20 “Боорчу”-г “Биеэр дайлсан тэмдэглэл” болон “Юань улсын түүх”-д “Бо-эр-шу” гэж, “Эрдэнийн товч”-д “Богарчи, Богуржи” гэж адилгүй бичдэг. Бид нөхөр Баярын галигласан “Нууц товчоон”-ы бичлэгийг баримтлав. Бас Боорчу-гийн тухай бус баримт бичгүүдэд гардаггүй нэгэн сонирхолтой үлгэрийг “Эрдэнийн товч”-д тэмдэглэж байдгийг доор хураангуйлан тэмдэглэе: 1206 онд Чингис хаанаас есөн өрлөгүүд түрүүлэн хүчээ өгөгсдөд нармай улсын төрийг засахын тул гүн их цол, хүнд их ям (энэ бол одоогийн “яам” гэсний язгуур болох мэт, энд “тушаал” гэсэн утгатай хэрэглэжээ) хүртэл их өглөгийг, хүнд хөнгөнийнх нь дэсээр шагнан соёрхох зуутан, мянгатан, түмтэн, түг түмтэний ноёныг томилон, нармай их улсад, их шанг түгээхдээ гагцхүү Боорчу ноёныг огт дурдсангүй гэнэ. Шөнө орой болж, хаан нойрсох үед Бөртэ үжин сэцэн суутай хатан нь исэрийн (ор) дотроос ийн хэлж гэнэ.

“Бэлгүртэн (ганцаардан – хө.) явах цагт чинь,

Бэлнээ учирч сайтар нөхцөн,

Бэрх үйлсийг чинь бүтээж өгөн,

Бие амиа эс хайрласан биш билүү?

Хүний эзэн чи, хөвчин бүгдийг хүндэтгэн аж,

Хүчээ өгөн үлтэрсэн (элэгдсэн – хө.)

Хүлэг Боорчу юугаа умартав уу?”

гэсэнд Чингис хаан: “Би түүнийг мартсан биш, харин бус атаархагчдад Боорчу-гийн эрдэм (ухамсар)-ийг үзүүлье гэсэн юм гэлээ”. Ингээд Чингис хаан өөрийн боол Бичин гэдгийг явуулж, Боорчу-гийн юу хэлэлцэж байхыг нь сэмээр сонсуулжээ. Тэр боол Бичин гэдэг нь очоод чагнахад Боорчу-гийн гэргий Тэгүсхэн гуа гэдэг нь ингэж өгүүлж сууж байжээ:

“Бүтэхийн урьд учирч

Бүрэн төрийг нь хашилцаж,

Бүх үйлсийг нь бүтээж,

Бүхнээс үлэмж хүчээ өглөө чи.

Үүдсэн эцэг төрсөн эх юүгээ умартаж,

Өвөрлөсөн гэргий өсгөсөн үр юүгээн орхиж,

Эзэндээ зүтгэж хүчээ өгсү,

Өдгөө зовбоос,

Эцэст жаргамуй за гэм (хэмээнэм – хө.) бөлгөө чи,

Богд эзэн харалмай (нармай - хө.) улстаа хайр хийж,

Болох үл хүүг (болох, эс болохыг - хө.) түмтэн

мянгатаан болгон аж,

Боорчу хэмээн нэгээхэн эс дурдав биш үү чамайг,

Боржигинд хүчээ өгөгчин чамаар хэсэгдэх”.

Түүний хариуд Боорчу ингэж хэлж гэнэ:

“Өлөмлөн үмхэх хэсэгт үл ховдоглох,

Өлөглөн явж хүчээ сайтар өгөгдөх,

Өрсөн авах өглөг дор үл шунхлагдах (шунахайрах - хө.),

Өнөд нөхцөж хүчээ өгөгдөх гэлээ.

Эм хүний жолоо нь охор, санаа нь цухал буюу,

Эзний минь алтан оосор бат болоод,

Эрдэнэ хас их төр нь төвшинд аваас,

Өдгөө эс хүртвээс бээр, хойд үрд хүртэм зэ.

Яарч уурлах юун хэрэг,

Явж бас хүчээ өгье,

Юун өгүүлэх ажгуу хэмээн тэнссэн буй за,

Яахан умартмуй эзэн минь намайг юугаан”.

Эр эм хоёрын ярилцсан эдгээр үгийг нь боол Бичин нэгд нэгээр цээжилж, эзэндээ бүрнээ айлтгасан гэнэ. Чингис хаан түүнийг сонсоод:

Би эс сэрлээ юү (мэдсэнгүй юү), урьд хэмээвээс бусдаас үлэмж хүчээ өглөө, өдгөө хэмээвээс ил эзнээ итгэгдэхүй самбаагаа үл мятан (мохон) өгүүлмүй. Ер зэргийн иргэн атаархахуйяа мэдээгүй буюу. Манагар (маргааш) Боорчу-гийн эдгээр эрдмүүдийг нь хотолд сонсон өгч, хүнд хайр хишгээ хүртүүлэн өгсүгэй гэжээ. Маргааш нь нармай улс хурсанд, эзэн Чингис ингэж зарлиг болжээ:

Өчүгэлдэр (өчигдөр – хө.) би хамаг (т) хайр хийхүйдээ Боорчу-г умартан орхисон ажгуу. Түүний тул Бөртэ жосин гэргий минь зэмлэж суун атал, хөтөч хүүхэд Боорчу-гийн гэрийг дайрч ирэхүйд Боорчу Тэгүсхэн хоёул ийн өгүүлэлдэж суун амуй хэмээн надад өгүүлэв хэмээгээд, урьд Боорчу гэргий хоёрын өгүүлэлдсэн үгсийг тоогоор зарлиг болгоод:

Саарин саадгаа салбаран элтэл,

Сайн үгээ өгүүлсэн Боорчу минь,

Самууран явахуйяа сайтар нөхцөлдөн,

Санаа сэтгэлээ эс мэдсэн Боорчу минь,

Үст саадгаа үлтрэн элтэл,

Үлэмж зовон нөхцөлдсөн Боорчу минь,

Үхэлдэн алалдан явахуйяа үнэхээр нөхцөлдөн,

Үхэхүй амиа эс хайрласан Боорчу минь бөлгөө.

Түүгээр өдгөө ер есөн өрлөгийн тэргүүтэн ноёд сайд минь, ерөнхий албат их улс минь та, үүн лүгээ бүү атаарха. Үлэмж хүчээ өгсөн хүнийг үлхүеэ (илүү - хө.) эс хайрлаваас дахи, хойд хүчээ өгөгчнөө гэсэмж (сургамж - хө.) болму. Түүгээр энэ Боорчу урьд учирч үлэмж хүчээ өгсний тул, өдгөө би үүнийг бусдаас үлэмж хүнд болгохуй учир минь энэ хэмээн зарлиг болсонд хамаг ноён түшмэд нь ... энэ зарлиг бид бүгдийг хайрласан бус буюу хэмээлджээ.

Тэндээс эзэн ийн зарлиг болуу:

Дотоод хас их төрийг минь хадгалан, гадаад таван өнгө улсыг минь эзэлж, хашгираа ихт хатан бүрээг минь хадгалагч, есөн мужийн ноён хүлэг Боорчу хэмээгээд, Тэгүсхэн гуа гэргийд нь бүчин (фүжин) тайбучин цол соёрхож, Боорчу-г есөн өрлөгүүдийн эрхин, есөн мужийн ноён болгон өргөжээ. Энэ бол “Эрдэнийн товч”-ийн зохиогчоос тухайн үедээ зориулсан уран санаа болох нь илт байна.

21 “Хэрлэнгийн ураг цөл”-ийг “Лу. Алтан товч”-д “Хэрлэнгийн зол нугад” гэж, “Чингисийн цадиг”-т: “Хэрлэн нутгийн зул нугуд” гэж, Х.Пэрлээ “Хэрлэнгийн ураг зул нуд” гэж тус тус адил бусаар тэмдэглэж буй. Арван наймдугаар зууны үед зохиогдсон “Монгол Хотон аймгийн ван гүнгийн илтгэл шастир” гэдэг бичигт: “Хэрлэн жич Оорхой хар усны газар” гэж дурджээ. Үүнийг Ц.Дамдинсүрэн “Ураг цөл” гэжээ. Хэрлэнгийн дунд бие (уртраг нь 107° , өргөрөг нь 47°)-д “Бөгтөр хар ус” гэдэг газар байдаг. Үүнийг “Ураг цөл” гэдэг магадгүй гэж Х.Пэрлээ тэмдэглэсэн байв.

22 Энэ “Бүрги эрэг”-ийг одоо “Эрэг Бүрги” гэдэг гэлээ. Тэр нь Хэрлэнгийн зөв этгээдэд тулсан мөрүү (уртраг нь 108° , өргөрөг нь 48°)-г хэлдэг гэнэ. Энэ газраас лам нар үлэг гүрвэлийн яс олдог байсан гэх ба эндэх Хэрлэнгийн усанд нэгэн том ваар (сав) цухуйж байхыг үзсэн хүн буй гэж эндэх нутгийн ардууд ярилцдаг гэж Х.Пэрлээ мэдээлжээ.

23 Энд Мэргидийг “Цагаан Татар” гэж нэрлэж байхыг эртний хятад түүхэнд говийн умар дахи Монголчуудыг “Хар Татар”, Онгуд, Хонгирад, Мэргид зэргийг “Цагаан Татар” гэж хувааж байснаас болсон бөгөөд бас “Болгосон Татар”, “Түүхий Татар” мэтээр хувааж байжээ. Татарын тухай тус товчооны сүүлчийн бүлэгт үзээрэй.

24 Энэхүү “Маудан Мэргид”-ийг “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д: “Май-гу-дан”, “Биеэр дайлсан тэмдэглэл” ба Хун Цзюнь-ий орчуулсан “Аймаг угсааны магадлалт” гэдэгт: “Май-дуан” (энэ нь “Судрын чуулган”-ы “Мудан” гэсэн оросчилгын галиглал болно), Чжан Чжэнь Пэй-н “Чингис хааны шүүмжлэл шастир”-т: “Жудан” гэж адил бусаар тэмдэглэж байна (Энэ “жу” үсэг бол “му” үсгийн ташаарал мэт). “Түдаглин Мэргид” гэдгийг Ту Цзи-гийн номд “Түр-бү-гин” гэж, Чжан Чжэнь Пэй-н номд “Дүтүглин” гэжээ. “Жэгүн Мэргид” (Джиюн) гэдгийг Чжан Чжэнь Пэй-н номд “Чжиюн Чжи-үн” гэж, Ту Цзи-гийн номд “Ца-хун” гэж адил бусаар бичиж байна, эдгээрийг бүр тэмдэглүүштэй юм.

25 “Бэхи” гэдэг цолын тухай, Ойн иргэд “бөө мөргөлтөн”-өөр тэдний удирдагчаа болгодог ... Тиймээс тэдний цолыг “бэхи” гэдэг бөгөөд талын иргэдийн язгууртны дотор ч ийм цол байдаг билээ гэж Б.Я.Владимирцов дурджээ.

Энэхүү “бэхи” гэдэг нь түрэг гарлын “бэг” (beg, язгууртан) гэснээс үүсэлтэй гэж түүхч Хань Жу Линь тайлж байжээ. “Бэхи” гэдэг бол бөө мөргөлийн шашны дээд хувраг гэж Юй Баян тайлбарласан байлаа. Тиймээс манай одоогийн яриан дахи “бөө” гэдэг үг энэ “бэхи”-гээс улирч хувирсан байж ч мэднэ.

26 “Түнхэлиг горхи” гэж “Нууц товчоон”-д хоёр адилгүй газрыг нэрлэдэг. Нэг нь Бурхан Халдуны ойр (уртраг нь 109° , өргөрөг нь 48°) байдаг. Нөгөө нь Ононы Балжуна арлын ойр

(уртраг нь 110° , өргөрөг нь 49°) байдаг. Энд дурдаж байгаа “Түнхэлиг горхи” бол өмнөх нь болно. Үүнийг “Нууц товчоон”-ы хятад галиг “t`ung-ke-li-k`(e) huo-ra-han”-аар үзвэл, “Тэнхэли горхи” буюу “Тэнгэр горхи” гэж бичмээр юм. Гэвч заншлыг баримталж уул ёсоор үлдээжээ.

Гуравдугаар бүлэг



ЧИНГИС ХААНЫ ХҮЧИРХЭГГИЖ ДЭГЖИРСЭН ҮЕ

Тэмүжин хэдийгээр бага залуу насандаа гурван удаагийн аюул түгшүүрт тулгарч, нэлээд хүнд цохилт олсон боловч, энэхүү шургуу тэмцлийн дунд түүний хүч нь нэлээд хүчирхэгжжээ. Хавт Хасар, бөх Бэлгүтэй гэж түүхнээ алдаршсан, Тэмүжиний идэрхэг хоёр дүү нь энэ үед хэдийгээр эрийн чадалд бүрэн хүрээгүй байсан ч тал нутгийн хүмүүсийн анхаарлыг ихээр татаж байлаа. Хүч тамирын талаар Тэмүжин хоёр дүүдээ хүрэхгүй ч гэсэн арга ухаан ба алс холын бодлогын талаар хэнээс ч хэтийдэх тэмдэг бүр тодорхой илэрч байжээ. Энэ нь голдуу хүчир бэрхшээлийн дунд нугарч шантарсангүйгээр үл барам, өшөө хорслынхоо галыг улам ширүүн хөгжөөж, өштөн дайснаа дарж өвөг дээдсийнхээ их үйлсийг сэргээх хатан зоригоор өөрийн хүчээ үтэр түргэн зохион байгуулсан ажиллагаагаар нь илэрч байв.

Гурван удаагийн аюулаас хэлтэрснээс Тэмүжиний нэр тал нутагт, ялангуяа Есүхэй баатарын хуучин харьяатын дотор нийтээр хэлэлцэх сэдэв болжээ. Тэмүжиний нэр хэдий мандах тутам, түүний хүч ч төдий өргөжих тийш хандаж байлаа. Тэмүжин өөрийн аймаг угсаагаа хураан цуглуулж, хүч чадлаа дэгжрүүлэн, өшөөтөн дайснаа дарж, өвөг дээдсийнхээ үйл өвийг мандуулах анхны бодлого нь, шинэ мандсан тал нутгийн феодалчуудын бүх Монголыг

нэгтгэж ихээр хөгжих шаардлагад нь тохирч байсан юм. Тэрчлэн аймаг бүлгийн хоорондохи дайсагналыг устгаж, үндэстнээ нэгтгэн, амар жимрээр аж төрөх гэсэн ард түмний хүсэл шаардлагад нэн ч нийцэж байсан юм.

“Нууц товчоон”-ы дэс дарааллаар бол, Боорчу-г урин ирсэн, Ван хантай холбогдсон ба Зэлмэ лүгээ нөхөрлөсөн явдал нь Мэргидийн довлолтоос өмнө болсон хэрэг юмсанжээ. Гэвч бид бүлэг бүрийн голдлогоо товойлгохын тулд тус бүлэгт шилжүүлснийг энд тэмдэглэсүгэй.

Бэлгүтэйг томилж Боорчу-г урин авч ирсэн нь, Тэмүжин Бөртэ үжинийг хуримлан авч ирээд, мөн хадам эх Чотаныг гэр өөд нь хариулсан тэр үеийн учир болно. Чотан Тэмүжиний гэрт чухам хэдий удаан суусан тухай тодорхой тэмдэглэл ер харагдаагүй. Харин Монгол үндэстний хуримын ёсонд охиноо анх хүргэж ирэгсэд дэмий удаан суудаггүй юм. Тиймээс Боорчу-г урьсан цаг нь мөн л Тэмүжиний арван долоон нас (1178 он)-ны үеийн хэрэг болох мэт. “Нууц товчоон”-ы тэмдэглэлээс үзэхүл, Боорчу ирэхийн үедээ эцэгтээ ч хэлсэнгүйгээр ирсэн байна. Боорчу бол Тэмүжиний дэргэд нөхөрлөхөөр ирсэн түрүү нэгэн хүмүүн болно.

16. Хэрэйдийн Ван хан лугаа холбоолсон нь

Тэмүжин Бөртэ үжинтэй хуримласан тэр жил (1178 он), өөрийн дүү Хасар, Бэлгүтэй хоёрыг дагуулж, Бөртэ үжиний эхийн шитхүл (өмсгөл – хө.) гэж авчирсан үнэт нандин бэлэг хар булган дахыг авч, Хэрэйдийн Ван хан лугаа холбоолохоор явжээ.

Энэ үед Тэмүжин Хэрэйдийн Ван ханыг эрэн холбоолохын учир гэвэл:

Нэгд, Ван хан бол Есүхэй баатарын анд болох бөгөөд Есүхэй баатар Ван ханыг туслан дэмжиж байсанд оршино.

Хоёрт, Хэрэйд аймаг нь тал нутгийн хүчирхэг нэгэн аймаг болоод байсанд оршино. Тэр үед Хэрэйд аймаг нь хорин түмэн хүн амтай байлаа гэж “Д`Оссоны түүх”-д тэмдэглэж байна.

Хэрэйд, Одоогийн Туул, Орхон гол орчмоор нутаглаж байсан Эртний Татар аймгийн холбооны “есөн овгийн татар” гэдэг бол сүүлчийн Хэрэйд аймаг мөн (Цю Шоу Сын “Юань улсын түүхийн тухай яриа”). Түүнийг бас түрэг угсааны аймаг гэж өдий төдий түүх шастирт тэмдэглэж байдаг. Гэвч арван хоёрдугаар зууны сүүлчийн үеэр тэр нь монгол хэлтний харьяанд багтахыг дээр нэгэнтээ тэмдэглэж билээ. Хэрэйдийн чухам нэр нь “хэрээ” гэдэг бөгөөд Ханлин лугаа угсаа нэгтэй гэлээ. Зарим тэмдэглэлд Ханлинаасаа дуудлага хувирчээ гэдэг. Ингээд хятад түүхэнд бүр Кэ Ле-ээр тэмдэглэжээ. Сүүлдээ монгол хэлний нэр үгийн олон тооны дагавар “д”-г бас залгаж “Хэрэйд” гэж нэрлэх болсон байна. Долоогоос есдүгээр зууны үед Хэрэйд аймаг нь Байгал нуураас баруунш Кэм мөрний орчмоор нутаглаж байжээ. Сүүлдээ өмнөшлөсөөр байж, арван хоёроос арван гуравдугаар зууны үед гол төлөв Хангай, Хэнтий хоёр нурууны хоорондуур, Орхон, Туул хоёр голын хөндийгөөр нутагладаг байжээ. Тэмүжинийг очиход Ван ханы ордон нь Туул голын Хар түнд1 байв. Хэрэйдүүд баруунш Наймантай, умарш Мэргид лүгээ Сэлэнгэ мөрнөөр зааглаж, өмнөшөө говийг алслан Онгудтай нүүрлэлдэж (нутаг залгалдаж – хө.) байсан юм. Эдгээр аймгууд хэдийгээр хоорондоо нутаг бэлчээрийн учир байнга дайсагналцдаг боловч, Наймантай нягт харьцаатай бөгөөд Түрэг угсааны дотроос хамгийн соёлжсон Уйгур үндэстэнтэй харилцаж байсан нь Хэрэйдийн дунд

боловсон соёлын хэв заншил дэлгэрэхэд түлхэц болжээ. Ингээд тэр үедээ Хэрэйдийн язгууртны дунд несториан Христосын шашин² дэлгэрч байсан гэдэг билээ.

Арван хоёр, арван гуравдугаар зууны үед, Хэрэйд аймаг нь монгол хэлтэн аймгуудын дотроос маш хүчирхэг нэгэн аймаг байсан бөгөөд түүнд олон Донгайд, Жиргэн (Чирхир), Сахиад, Түмэн Түбэгэн, Эрихэ, Онгужин зэрэг зургаан салбар овог аймаг харьяалагдаж байлаа гэдэг. Хэрэйдийг Түрэг угсааны аймаг гэдэг учраас Чин улсын үеийн Торгууд овогтныг “Түрэгүүд” гэснээс хувирсан бөгөөд Зүлдэс, Ховогсайр, Көрхал ус, Эзнээ, Булган гол, Хөх нуур зэрэг газрын торгууд овогтны түрүү нарыг бүр “Он хаан” (Ван хан)-ы хойч гэдэг байна.

Хэрэйд аймгийн түрүүг “хаан” гэдэг. Арван хоёрдугаар зууны сүүлчээр Хэрэйд аймгийн хаан нь Тоорил³ гэгч байжээ. Тоорил ханд Алтан улсаас 1196 онд Ван цол өргөмжилснөөс хойш сая “Ван хан” (монгол хэлнээ “в” авиа байдаггүй учраас “Нууц товчоон”-д “Он хан” гэжээ) цолтой болсон юм.

Тэмүжин ах дүү гурвуул, Ван ханы дэргэд хүрч, эцгийн минь хуучин анд та, эцэгтэй минь адил байлгүй гэж хар булган дахаа бэлэг болгон хүргэсэн гэлээ. Түүний хариуд Ван хан:

“Хар булган дахын чинь хариу,

Хагацсан улсыг чинь хамтатгаж өгсүгэй.

Булган дахын чинь хариу

Бугарсан улсыг чинь бүтээлгэж,

Бөөрийн бөгс цээрийн цээжинд атугай”⁴ гэж хэллээ гэдэг тэмдэглэл байдаг юм.

Гэтэл Ван хан бол Тэмүжиний үнэнч шударга, өнөдийн түшиг тулгуур биш гэснийг Ван ханы мөн чанараар нь шийдвэрлэгдэж, хожмынхи нь түүх гэрчлэжээ.

“Д’Оссоны Монголын түүх”, “Марко Поло-гийн аяллын тэмдэглэл” зэргээс үзэхүл, Европынхон Ван ханыг “Престер, Йохан” гэдэг гэлээ. “Йохан” гэдэг бол Христосын шашны шүтэгчдийн цол юм. “Престер” гэдэг бол “шашны тэргүүн” буюу “ахмад” гэсэн утгатай үг гэлээ.

Чингэвэл Ван ханд яагаад ийм цолыг өгсөн юм бол гэвэл, эрт урьдын цагт нэгэн эрх сүрт шашны ахмад Йохан гэгч алс холын дорнод зүгт Христосыг шүтэгч иргэдийг захирч шашин төрийг гайхамшигтайгаар мандуулсан гэдэг домог байжээ. Энэхүү домгийг Европынхон үнэн хэрэг гэж үздэгээр барахгүй, сүүлдээ харин Хэрэйдийн Ван ханыг тэр Престер, Йохан мөн гэж үздэг болсон юм гэлээ.

Хэрэг дээрээ Хэрэйдийн Тоорил хан нь тэрхүү “агуу их домог” лугаа огт үл тохирохоор барахгүй, жирийн нэгэн шударга хүний үнэр ч үгүй хүн юм.

Тоорил долоон настай байхдаа Мэргид иргэнд баригдаж, харлаг ишгэн дах өмсөж, Мэргидийн газар будаа нүдэж амьдарч байж гэнэ. Тэр үед Хурчахус Буйруг хан эцэг нь

Мэргидийг байлдан дайлж, Тоорилыг авран гаргажээ. Тэр нь, арван гурван настай байхдаа эхийнхээ хамт Татарын Ажай хаанд баригдаж очоод түүний тэмээг хариулж явсан гэлээ. Тэндээс Ажай хааны хоньны хамт оргож гэртээ харьж иржээ. Түүний хойно, элбэрэл журмыг мартсан Тоорил өөрийн эцэг хаан Хурчахус Буйругийн дүү нар ба дүү нараа алаад авга Гүр хантайгаа эвдрэн тэмцэлдэж, зуун хүн авч арайхийн зугтаж, Тэмүжиний эцэг Есүхэй баатарын дэргэд түшин ирсэн тул Есүхэй баатар түүнийг асран тэтгэж, өөрийн биеэр цэрэг авч мордоод, Гүр ханыг Хашин орон5-д дутаалгаж, албат иргэд ба эд малыг нь Тоорилд авч өгчээ. Ван хан Есүхэй баатартай анд бололцсон учир ийм билээ. Түүний хойно Ван ханы дүү Эрх Хар гэгч ахдаа алагдахаас айж, Найманы Инанча ханд очив (“Нууц товчоон”, 151 дүгээр зүйл).

Дээр хураангуйлан дурдсан явдал бол Тэмүжин дэгжрэхээс өмнөх Ван ханы өнгөрөлт түүх нь болно. Ван хан чухам ямар хүн болох тухай түүний дүү ноёдын хэлэлцсэн ийм хоёр бадаг үг байдаг билээ.

“Энэ хаан ах маань, үр садан биднийг, үнсээр хийсгэж болох, өмхий санаа өвөртлөсөн, үл бүтэх хүн байна. Хайран ах дүүгээ, хамран алж барав. Хар хятадад бас, хамгааллыг гуйж шургав. Хамаг улсаа хайрлахгүй, харгислаж зовоов”.

Ван хан гэдэг нь гарцаагүй ийм л хүн байсан юм. Гэвч Тэмүжин хар булган дахаа хүргэж “Эцгийн минь хуучин анд та, миний эцгийн адил буюу” гэж очихдоо энэхүү мөн чанарыг нь хараахан таниагүй байсан бөгөөд хожмын үйлдэлгэ дундаа алхам алхмаар олж танисан нь мөн ч зүй ёсны хэрэг юм.

17. Зэлмэ ирж нөхөрлөсөн нь

Тэмүжин, Ван хан лугаа холбоолж, гэртээ хариад, Бүрги эрэгт нутаглаж байхад Урианхан овогтны Жарчигудай өвгөн, хөвгүүн Зэлмэ гэгчээ дагуулж Бурхан халдунаас ирээд: “Миний хөвгүүнээр эмээлээ тохуул, үүдээ сөхүүл” гэж Тэмүжинд тушаан өгчээ.

Урианхай овогтон бол “Дүрлүгин Монголчууд”-ын нэгэн салбар болно. Үүнээс гадна ойн Урианхан гэж өөр нэгэн аймаг байжээ. Энэхүү Жарчигудайн Урианхан нь арван хоёрдугаар зууны үед Хэнтий уулаар нутаглаж байсан бөгөөд тэр үедээ Боржигидын боол байжээ. Сүүлдээ арван тавдугаар зууны үед Батмөнх даян хааны зүүн гурван түмний нэг нь Урианхай түмэн гэдэг бөгөөд Хянган нуруунаас өмнөш одоогийн Жуу Од орчмоор нутаглаж байсан гэдэг билээ.

Жарчигудай өвгөн бол нэгэн төмөрчин хүн байсан юм. Уул нь тэр Дэлүүн Болдогт нутаглаж байхдаа Есүхэй баатарын харц иргэн нь байсан тул Тэмүжинийг төрөхөд, энэ Жарчигудай өвгөн Тэмүжинд нэгэн булган өлгий хүргэж өгсөн бөгөөд Зэлмэ хөвгүүнээ бас Тэмүжинд нөхөр болгон өгье гэж амлажээ. Тэр үед Зэлмэ нялх байсан учраас үлдээн өгсөнгүй билээ. Одоо Зэлмэ нэгэнтээ эрийн чадалд хүрсэн тул урьдын тэр амлалаараа хөвгүүнээ хүргэж ирсэн нь энэ билээ. Тэмүжин Зэлмэтэй нөхөрлөсөн учир ийм үлгэртэй юм.

Зэлмэ бол мөн хар бага наснаасаа Тэмүжинийг дагаж үйлчилсэн үнэнч шударга анд нь болох бөгөөд дөрвөн хошууч жанжныи нь тэргүүн нь болно. 1189 онд Тэмүжин нэгдүгээр удаа

“Хамаг Монгол Улс”-ын хаанаар өргөмжлөгдсөн үед Зэлмийг Боорчу-гийн хамт “хамгийн ахлагч”-аар томилжээ. Зэлмэ урьд хожид Тэмүжиний амийг гурван удаа аварсан юм. Бас 1197 онд Жадай, Алтаниб-гийн хамт Тэмүжиний отгон хөвгүүн Тулуйн амийг аварчээ. Ийнхүү гавьяа зүтгэлтэй явсан учир, Зэлмэ Тэмүжиний дотоод есөн сайдынхи нь нэг нь байсан. 1206 онд улс байгуулах үед наян найман гавьяатны есдүгээрээр шагнагдаж, мянганы ноёноор томилогджээ. Бас есөн удаа осол гаргавч үл яллах онц эрхийг олгосон билээ. Түүний хөвгүүн Есөнтэгэ мөн ч Чингисийн алдарт жанжин бөгөөд хорчийн даргаар Чингисийг хамгаалж байв.

18. Жамуха гэгч ямар хүн буй?

Тэмүжин арван нэгэн настай байхдаа ийм нэгэн “анд”-тай болжээ. Түүний нэр нь Жамуха, цол нь “сэцэн” гэдэг, ердөө бол Жамуха гэдэг юм. Энэ Жамуха бол Жадаран овогтны язгууртан болно.

Жадаран овогтоныг бас Жажирадай гэдэг. “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д Жадараныг “Дүрлүгин Монголчууд” гэжээ. Энэ нь зөвхөн харь овогтны хойч гэснийг нь баримталжээ. “Юань улсын шинэ шастир”-т “Ниругун Монголчууд”-д тооцож, “Хар Монгол” гэжээ. Урьд Тэмүжиний аравдугаар үеийн өвөг Бодончар мунхаг нэгэн удаагийн байлдаанд Жарчигуд Аданхан Урианхайжин гэгч нэгэн жирэмсэн эмийг барьж аваад татвар эмээ болгожээ. Тэр жирэмсэн эмээс төрсөн хөвгүүнийг харь овгийн хүн гэж Жажирадай гэдэг нэр өгсөн байна. Тэр Жажирадайн хойч нь Жадаран овогтон болжээ. “Жада” гэдэг бол “харь”, “бусад” гэсэн утгатай үг юм. Арван хоёр, арван гуравдугаар зууны үеэр Жадаран аймаг нь Хөлөн нуураас дээш, Хурхунаг Жубур орчмоор нутаглаж байжээ. Гэтэл зарим түүх шастирт Мэргид аймгаас өмнөш Орхон, Сэлэнгэ хоёр мөрний дунд урсгалаар нутаглаж байсан гэдэг билээ. Сүүлчийн явдлуудаас үзэхүл, энэ нь арай таарахгүй мэт.

“Нууц товчоон”-ы тэмдэглэлээс үзэхүл, Жамуха бол Жажирадайгаас доош тавдугаар үе, Бодончараас бодвол зургадугаар үе болно. Харин Тэмүжин бол Бодончарын арван нэгдүгээр үеийн ач билээ. Гэтэл Жамуха нь Тэмүжин лүгээ нэгэн үеийн хүн байсан нь бас дамжиггүй юм. Тиймээс “Нууц товчоон”-д Жажирадай болон Жамуха-гийн хооронд хэдэн үе гээгдүүлсэн нь мөн илэрхий байна.

Тэмүжин арван нэгэн настай байхдаа Онон мөрний мөсөн дээр Жамуха-тай наадаж байгаад өөрийн гуулиар цутгасан шагай ба арц модон годилоо Жамуха-гийн гурын шагай ба бярууны эврийг нааж хийсэн дуут сумтай солилцож нөхөр бололцжээ. Энэ үед тэр хоёр бие биеэ л танисан хүүхэд болохоос биш, чухам сэтгэл сэтгэлээ мэдэлцсэн анд байгаагүй билээ. Нэн ч хожимдоо улс төрийн талаар эрс дайсагнагч хоёр этгээд болно гэдгийг хэрхэн мэдэх аж.

Хэрэг дээрээ Жамуха-гийн “нөхөрлөл” гэдэг нь дайсагналын эхлэл байсан юм. Гэвч Жамуха бол хэзээд хоёр толгойтой морь унасан улс төрийн завшигч байсан нь яриангүй билээ. Тэмүжинд Жамуха дэмжлэг үзүүлээ гэдэг бол Мэргидийг дарах байлдаанд биеэ гайхуулах үүднээс нэг л удаа туслажээ. Дараа нь Тэмүжинтэй жил хагас хамт нутаглаад, Тэмүжиний бүх Монголыг нэгтгэх гэсэн зорилгыг нь мэдмэгц Тэмүжинээс салан явж, дайсагналын байрт эрс зогсож, хорин дөрвөн жил (1180-1204 он) турш туйлбартай эсрэгцэлджээ. Энэхүү дайсагнал нь таван удаагийн их тэмцлээр илэрч байв. Нэгдүгээр удаа нь, Жамуха гурван

түмэн цэргээр Тэмүжинийг гэнэт дайрсан “Арван гурван хүрээний байлдаан” болно. Тус байлдааны дүнд Тэмүжин ялагджээ. Хоёрдугаар удаа нь, Жамуха нэг бүлэг Монголын язгууртан лугаа сүлбэлдэж, биеэ “Гүр хан” өргөмжлөөд, Чингис хааныг довтолсон “Тэниг горхины байлдаан” болно. Энэ байлдааны дүнд Жамуха нар ялагдав. Гуравдугаар удаа нь, Жамуха-гийн өдөөсөн “Хүйтэний байлдаан” болно. Энэ байлдаанд Жамуха ялагдаж явахдаа түүнийг “Гүр хан” өргөмжлөсөн тэдгээр аймгуудыг дээрэмдэж дутаав. Дөрөвдүгээр удаа нь, Ван хан, Сэнгүм нартай нийлж, Жамуха бүх цэргийг нь захиран хийсэн “Муу өндөрийн байлдаан” болно. Энэ удаагийн байлдааны дүнд Ван хан нар ялагдсанд, Жамуха дороо Хэрэйдээс урван зайлж, Тэмүжинд чимээ хүргэн Ван ханаа худалдаж байв. Тавдугаар удаа нь, Жамуха олонхи харьяатаа дагуулж, Найманы талд зогсож, Найманы Таян хантай хамт Тэмүжин лүгээ байлдсан “Наху гуны байлдаан” болно. Энэ байлдаанд Найман ялагдмагц, Жамуха бас дутаан зайлжээ. Сүүлдээ Жамуха өөрөө туйлбартай ялагдсан боловч, тавхан хамсаатнаа дагуулж, Тагна ууланд гараад, эцэстлээ Тэмүжинийг эсэргүүцэж байсан юм. Тиймээс Тэмүжинийг дайсагнаж байсан Монголын язгууртны дотор Жамуха-гийн адил туйлбартай дайсагнасан этгээд ер байгаагүй.

Гэвч эхлэнгүүтээ Жамуха-гийн энэхүү тэрслүү дүр нь тийм тодорхой илрээгүй учраас Тэмүжин бас л дотно андаар хандаж байсан бөгөөд Жамуха туйлбартай ялагдсан байдал дор бас уучлах овроор хандаж байжээ.

Энд тэмдэглүүштэй нэгэн зүйл бол: Гадаадын зарим судлагчид Жамуха-г “ардчилал”-ын төлөөлөгч гэж үздэг явдал болно. Гэтэл Жамуха-гийн бүх үйл ажиллагаанаас нь үзэхүл, тэр харц иргэдийн ашиг сонирхолыг ерөөс төлөөлсөнгүй мөртөө шинэхэн мандсан феодал язгууртны ашиг сонирхлыг ч төлөөлсөнгүй, харин тэдний эсрэг тэрслүү язгууртны хувиар туйлбартай тулалдаж байсан юм.

Энэ асуудлын тухай Зөвлөлтийн монголч эрдэмтэн Б.Я.Владимирцов өөрийн танилт ба түүний хувиралтыг ярьсан нь нэлээд асуудлыг тодорхойлж болох юм. Тэр хэлсэн нь: “Олны мэдээжээр, Бартольдын үзэхээр бол Жажирадай (буюу Жадарад) овгийн ахлагч Жамуха бол Монголын ардчилсан хөдөлгөөний удирдагч мөн, энэ хөдөлгөөн нь Чингис хааны удирдсан язгууртны хөдөлгөөнтэй эсрэгцэлдэх байрт байв гэнэ. Энэ бол нэгэн маш чухал асуудал мөн. Учир нь, арван хоёрдугаар зууны сүүлч ба арван гуравдугаар зууны эхний Монголын нийгмийн тухай манай ойлгогдохуун энэ асуудлыг зөвөөр шийдвэрлэхэд байгаа юм. Юуны урьд тэр үед Чингисийн язгууртны эсрэг илээр хийх тэмцлийн ардчилсан хөдөлгөөн чухам байсан уу? үгүй юу? Урьд би энэ асуудлын тухай Бартольдын саналыг бүрэн зөвшөөрөхөө илтгэж байсан. Одоо би нэлээд их хэмжээгээр өөрийн үзэлтээ өөрчлөх чухалтай байна. ...

Тэр үед хээр нутгийн язгууртан бол хүч чадалтай бөгөөд хүн бүлээр олон анги юм. Березин бүрэн зөв жагсаасанчлан: “Хээр нутагт Чингис хаантай тохиолдсон тэрхүү язгууртан анги нь түүний хаант улс байгуулахад бүрэн хангалттай юм”. Манай тулгар бичгүүдэд, ямар ч ил тод ардчилсан чанартай хөдөлгөөний тухай огт дурдсангүй. Олны мэдээжээр хэрвээ Монголын хээр нутгийн язгууртан нар Чингисийг өргөн дэмжлээ гэх юм бол, Монголын нийгмийн доод давхарга ангийн маш олон хүмүүс нь Чингисийг мөрдөн дагаж, шударгаар зүтгэсэн юм гэдгийг зааж гаргах хэрэгтэй.

Хүмүүс Чингис хааныг нэгэн “Өршөөл ихтэй хаан мөн” гэж байгаа нь шалтгаангүй учир огт

биш. Энэ асуудлыг доор бас ярина. Тэр үед юуны ардчилсан хөдөлгөөн гэдэг юм байгаагүй гэдгийг дурдах л хэрэгтэй (“Монголчуудын нийгмийн байгууллын түүх”, Үндэстний хэвлэлийн хороо, 1980 оны хэвлэл, 163-164 дүгээр нүүр) гэжээ.

19. Тэмүжиний анхдагч ялалт – Мэргидийг дайлсан “Буур хээрийн байлдаан”

Шарагчин гахай жил (1179 он) Тэмүжин арван найман настай байхдаа Мэргидийг дайлж, булаагдан дагуулагдсан эмс хүүхдээ авран, өслөгдөн дарлагдсан өшөө хорслоо авахаар зориг шийдсэн байна.

“Тэмүжин тэндээс цэрэг үүсгэж” гэж “Нууц товчоон”, “Лу. Алтан товч”-д тэмдэглэж байхыг үзэхүл, энэ үед Тэмүжин өөртөө зохих хэмжээний цэрэгтэй болжээ. Гэвч чухам хэдий цэрэгтэй байсан нь тодорхойгүй юм. Юу ч гэсэн ганц өөрийн хүчээрээ Мэргидтэй байлдах бололцоогүй байв. Ингээд Ван хан ба Жамуха-гаас тусламж гуйжээ.

Ван хан, Жамуха нар ч Мэргидтэй хувь хувийн өшөө хорсолтой болохоор, өөр өөрийн биеэрээ цэрэг дайчилж, Мэргидийг дайлахыг зөвшөөрчээ.

Энэ удаагийн байлдааныг “Буур хээрийн байлдаан” гэдэг юм. Байлдаанд Ван хан хоёр түмэн цэрэг (нэг түм нь түүний дүү Жаха Гомбу⁷-гийн цэрэг болно) авч Тэмүжинтэй нийлэн баруун гар болж, Жамуха хоёр түмэн цэрэг (нэг түмэн цэрэг нь Онон мөрнөөр нутаглаж байсан Тэмүжиний харьяат нарын цэрэг болно) авч зүүн гар болжээ. Энэ байлдааны ерөнхий захирагч нь Жамуха байлаа.

Энэ үед Удуйд Мэргидийн түрүү Тогтуга бэхи-гийн цэрэг нь Буур хээр⁸ гэдэг газар, Увас Мэргидийн түрүү Дайр Усуны цэрэг нь Орхон, СэлэнгийнТалхун арал⁹ гэдэг газар Хаад Мэргидийн түрүү Хаатай Дармала-гийн цэрэг нь Харажи хээр¹⁰ гэдэг газарт тус тус байрлаж байв. Тэр үед Мэргид нар хэдий цэрэгтэй байсан нь тодорхой мэдээгүй. Байлдааны дүнгээс үзэхүл, нэгд, тийм олон цэрэггүй, хоёрт, байлдааны бэлтгэлгүй байсан нь дамжиггүй юм.

Энэ удаагийн байлдаан нь нийтийн он тооллын 1179 оны намрын улирлын дунджаар явагджээ¹¹.

Тэмүжин, Ван хан, Жамуха нарын цэрэг нь Онон мөрний эх дэх Ботуган Богуржи гэдэг газар нийлэлдэж, тэндээс сахал өвсөөр¹² сал уян Хилгу мөрнийг¹³ гэтлээд байлдааны гол талбар Буур хээрт хүрсэн байна. Энэхүү тулалдааны бодтой байдал нь “Нууц товчоон”-д тэмдэглэгдсэн хэдэн бадаг шүлгээр маш гойд дүрслэгджээ:

“Хараат тугаа сацав би,

Хар бухын арьсаар бүрсэн

Бүрхирэн бүхий дуут хэнгэрэгээ дэлдэв би,

Хар хурданаа унав би,

Хатуу дээлээ өмсөв би,

Хатан жадаа барив би,

Хатгуурт сумаа өдлөв би,

Хаад Мэргидэд

Хатгалдан морилоё өдгөө бөгөөд.

Урт хараат тугаа сацав би,

Үхрийн арьсаар бүрсэн

Өтгөн дуут хэнгэрэгээ дэлдэв би,

Орог хурданаа унав би,

Үдээст хуягаа өмсөв би,

Онгит илдээ барив би,

Оныг сумаа онилов би,

Удуйд Мэргидэд

Үхэлдэе би бөгөөд”.

Энэ хэдэн бадаг шүлгийг үнэхээр нэгэн сүр жавхлантай дайчин дуулал гэж үзэж болохын хамт, Эртний Монголчуудын дайн байлдаан хийх зан заншил - юуны урьд туг сүлдээ тахиж (“сацав” гэдэг үг тахина гэсэн утгатай. Бас “сацал сацна” гэдэг), дараа нь бухын арьсаар бүрсэн байлдааны том хэнгэрэгээ нижигнүүлэн дэлдэх ба тэрчлэн ямар янзын хуяг (үдээст хатуу хуяг - цулгай арьсаар хийсэн хуягыг хэлж буй) өмсдөг, ямар ямар зэр зэвсэг (хатан жад, хатгуурт сум, онгит илд, оныг сум зэрэг) хэрэглэж байсныг мөн энэ хэдэн бадаг шүлгээс олж мэджээ. “Марко Поло-гийн аяллын тэмдэглэл”-д арван хоёр, арван гуравдугаар зууны үеийн Монголчуудын дайн байлдааны тухай нарийн тэмдэглэл байдаг юм. Тэр нь “Нууц товчоон”-ы энэхүү тэмдэглэлтэй тун адил байна.

Байлдааны талбарын бэлтгэлээ дуусгамагц, Тэмүжин, Ван хан, Жамуха нарын их цэрэг нь Буур хээрээр гол суурь болгож байсан Тогтуга бэхи-гийн дээрээс шөнө дүлээр гэнэт дайран оржээ.

Мэргид хэдийгээр хүчирхэг их аймаг байсан боловч Тэмүжин, Ван хан, Жамуха нарын ширүүн дайралтад ямар ч няцаалт өгч чадсангүйгээр сарнин дутаажээ. Удуйд Мэргидийн түрүү Тогтуга бэхи болон Увас Мэргидийн түрүү Дайр Усун хоёрт Хилгу мөрөн хавьд нутаглагч загасчид гөрөөчдөөс бачим чимээ хүргэсэн тул цөөн хүмүүсээ авч шөнө дүлээр Сэлэнгэ мөрнийг уруудан Баргужин зүг дутаажээ. Хаад Мэргидийн түрүү Хаатай Дармала-г

барьж аваад хавтсан дөнгө өмсгөж, Бурхан Халдун ууланд цөлж явуулжээ. Урьд Бурхан Халдунд Тэмүжинийг довтолж, Бөртэ үжинийг барьж явсан гурван зуун Мэргидийг үр үндсээр нь устгаж, үлсэн эмс хүүхдийг нь боол зарц болгожээ. Тэрчлэн сарнин дүрвэсэн бусад Мэргидүүдийг Тэмүжин нарын цэрэг сүрхий цөлбөн дээрэмдсэн байна. Үнэхээр:


Эрхин бошгыг нь эвдэртэл дайрч,

Эмс хүүхдийг нь эцэстэл дагуулжээ.

Хутугту бошгыг нь хугартал дайрч,

Хотол улсыг нь хохиртол дагуулжээ¹⁴.

Саруул шөнийн гэгээнд Тэмүжин байлдаж, дуудаж явсаар байгаад, Мэргидэд баригдаж хагас жил илүү болсон авааль гэргий Бөртэ үжин ба сайн санаат эмгэн Хуагчин хоёрыг олж авчээ. Ингээд довтолгоо зогсооё гэж Ван хан, Жамуха нарт чимээ хүргэсэн бөгөөд “Буур хээрийн байлдаан” ч ингээд дууссан.



Тэмүжин энэ удаагийн байлдаанаас их хэмжээний олз ашгийг олсон боловч түүний ихэнхийг нь Ван хан болон Хэрэйд цэрэгт өглөө гэж Березин зохиосон “Чингис хаан” гэдэг товхимолд мэдээлжээ. Ингээд олз ашгаа хувааж дуусаад, Ван хан Бурхан Халдун зэрэг газраар дайран ан гөрөө хийсээр явж өөрийн суурин нутаг Туул голын Хар Түн өөдөө буцжээ.

Тэмүжин Жамуха лугаа хамт явж, түүний нутаг Хурхунаг Жубур¹⁵ гэдэг газар хүрч нийлэн буусан байна.

Энэ үед - нийтийн он тооллын 1179 оны намар өвлийн хооронд, Бөртэ үжин хатнаас нэгэн хөвгүүн төржээ. Энэ бол Тэмүжиний ахмад хөвгүүн Жочи болно¹⁶.

Энэ удаагийн Мэргидийг сөнөөсөн байлдаан бол Тэмүжиний өөрийн дайчин эгнээгээ ба зохион байгуулах, түүнчлэн бүх Монголыг нэгтгэх их үйлсэд нь зангилааны чанартай чухал ач холбогдлыг үзүүлсэн анх нэгэн байлдаан болно. Тус байлдаанд оролцсон Ван хан өөрийн цэргээ Тэмүжинээр захируулжээ (Березин-ий товхимолд). Ингээд Тэмүжиний нэр алдар нь тал нутаг даяарт, ялангуяа Есүхэй баатарын хуучин харьяат нарын дотор талын догшин салхинаас ч илүү их хүчтэй түргэнээр дэлгэрчээ. Үзсэн бүхэн гайхалдаж, сонссон бүхэн шуугилдах болов. Багцлаад хэлбэл, Тэмүжин энэхүү ялгуусан үйлдлэгээрээ дамжиж, нэгд, шинэ мандсан феодал язгууртан ба ард иргэд, нэн ч Монгол залуусын хүрээллийг олж чаджээ. Хоёрт, цэрэг аяныг хэрхэн зохион байгуулж, дайн байлдааныг яаж хийх, ялангуяа яаж удирдан захирах зэрэг чухал мэдлэгийг анх удаа сурч мэджээ. Гуравт, зэр зэвсэг ба аж ахуйн талаар өөрийн хүчээ ихээхэн сайжруулсан байна.

20. Тэмүжин Жамуха хоёр бие биеэ мэдэлцэж салж явсан нь

Тэмүжин Жамуха хоёр Мэргидийг сөнөөсөн “Буур хээрийн байлдаан”-ы дараа, Хурхунаг Жубурт нийлэн буугаад харилцан бэлэг сэлт хүргэж, багын үеийн эв найраа дурсалцаж, өдөр хамт найралдаж, шөнө хамт унтах дотно “анд” болж нэг жил хагас суужээ. Энэ учрыг “Нууц товчоон” зэрэг тулгар бичгүүдэд бүр ингэж бичиж буй.

Гэвч энэ нэг жил хагасын явцад нэлээд будлиантай хэргүүд багтаж байсан бөгөөд тэр нь шинэ нөхөр дайснаа таньсан жинхэнэ явц байжээ. Тэмүжин анхандаа Жамуха-г даган ирж хамт буугаад, бэлэг сэлт хүргэж, эв найртай байсан явдлаас нь үзэхүл, Жамуха-г өөрийн зүгээ татаж, өнөдийн андаа болгон, өнөр хүчээ холбоолж, өстөн дайснаа даръя гэсэн сайн санаа, сайхан оролдлого байсан нь лав юм. Тиймээс Жамуха-г салан явтал Тэмүжиний энэ горьдлого ер тасраагүй байсан нь ч үнэн хэрэг юм. Нөгөө талаар, Жамуха-гийн харьяат цэрэгт нь Есүхэй баатарын хуучин харьяат нар тун олон байсныг энэ удаагийн хамтын байлдааны дунд Тэмүжин олж мэджээ. Ингээд эдгээр харьяат нараа нөлөөлөн татахын төлөө Жамухатай хамт буусан бас нэгэн шалтгаан болно. Тиймээс энэ жил хагасын охор бус хугацаанд, Тэмүжин болон эдгээр харьяатадын хооронд, ялангуяа тэдгээрийн шинэ шинэ дэгжирч бүхүй феодал язгууртадын хооронд нэлээд харилцаа холбоотой болсон бөгөөд Тэмүжиний нөлөө тэдний дотор нэн гүнзгий болсон нь яриангүй мөртөө энэ нь хожмын явдлуудаар гэрчлэгдсэн байлаа.

Энэ явдлыг Жамуха-гийн хувиас үзэхүл, бас өөрийнх нь зорилготой байсан нь мэдээжийн хэрэг билээ.

Энэ удаа Тэмүжин, Ван хан нартай холбоолж, Мэргидийг сөнөөсөн байлдааны жинхэнэ ач холбогдол ба Тэмүжиний нөлөөг Жамуха анхандаа ер мэдэхгүй байсан бөгөөд тэр мөн ч энэхүү байлдааныг нүүдэлчин язгууртадын хооронд явагддаг өшөө хорслын мөргөлдөөн буюу уулгаллын дайн гэж үзэж байжээ. Ингээд тэр, Тэмүжинийг дэмжиж, өшөөтөн Мэргидийг нь даран, булаагдсан эмс хүүхдийг нь буцаан авч өгвөл, Тэмүжин энэ ачийг нь марталгүйгээр түүнийг даган, түүнд харьяалагдах хүчин болно гэж бодсон байлгүй. Эхлэнгүүтээ тэр ямар ч сэжиг ажиггүйгээр бэлэг сэлт солилцож, өөрийн өв байр, өмөг хүчиндээ эрдэж байв. Гэвч олон өдөр, зузаан хоног, жил хагасын явцаас үзэхүл, харин түүний санасантай нь эрс эсрэгээр, Тэмүжиний нөлөө өдрөөс өдөр өргөжиж, хүчин чадал нь улам улмаар бузгайрч байсан бөгөөд аль олон аймаг бүлэг, ард иргэд ялангуяа хүч нөлөөтэй язгууртан бүр

Тэмүжиний тийш хандах болжээ. Ингээд хашир хулжин Жамуха, түр цагийн “анд”-аасаа өнөд зайлж, өрсөлдөн тэмцэлдэхийг толгойдоо бясалгаж, дотроо занаж эхэлжээ.

Тэмүжин, Жамуха хоёр Хурхунаг Жубур-т жил хагас хамт нутагласны дараа, нийтийн он тооллын 1181 оны билгийн улирлын зуны тэргүүн сарын арван зургааны улаан тэргэл өдөр тэндээс нүүн хөдөлжээ. Энэ үед Тэмүжин хорин настай байв.

Жамуха, Тэмүжинээс салж явья гэж олон өдөр бодолхийлснээ энэ нүүдлийн ташрамыг ашиглаж, битүү хэдэн үгээр хэлж гаргасан байлаа:

“Тэмүжин анд, анд!

Уул шахан бууя,

Адуучин бидний

Алчуха хүртүгэй!

Голд шахан бууя,

Хоньчид хургачид бидний

Хоолойд хүртүгэй!”

Жамуха-гийн энэ үгийг Тэмүжин сонсоод ухаж мэдсэнгүй байсанд сэцэн сэргэлэн Бөртэ үжин: Жамуха анд уйданга хэмээгдэн бөлгөө. Өдгөө биднээс уйдаг цаг болов гэж “Даравч дарайтал, далдлавч бултайтал” Жамуха-гийн мөн санааг нь нэг л үгээр зааж гаргажээ. Энэ тухай Төвийн Үндэстний Дээд Сургуулийн залуу багш Ц.Хишигтогтох “Чингис хаан хийгээд Жамуха сэцэн” гэсэн тусгай өгүүлэлдээ:

Бүр тодорхой хэлбэл, Жамуха, Тэмүжин андаасаа уйдсан болохоор өөр итгэж түшиж болмоор анд нөхдийг эрж сонгох чухалтай болжээ. Тэдгээр эрж сонгож байгаа анд нөхдөө уул усаар зүйрлэсэн бөгөөд өөрийгөө адуучин, хоньчин, хургачнаар, нэг л үгээр хэлбэл малчнаар зүйрлэсэн байв. Тиймээс Жамуха-гийн үгийг: “Тэмүжин андаа, Тэмүжин анд! Уул шиг нөхөр олж үзье, надад гэр тэрэм мэт хамгаалал болтугай! Ус шиг нөхөр олж үзье, надад хоол унд мэт тэжээл болтугай!” гэж орчуулан ойлговол зохих юм. Тэмүжинтэй тийм сайхан амраг найртай анд байлцсан атал ингэж хамгаалал түшиг болмоор, тэжээл шим хүртээмээр өөр анд эрэх тухай үг хэлж байгаа нь илэрхийеэ Тэмүжинээс уйдлаа гэсэн хэрэг биш үү! Ингэж ойлгож, ингэж тайлбарлавал сая Бөртэ үжиний ойлгосон ба тайлбарласантай нийцэж очих юм гэж зүйтэй тайлбарлажээ.

Тэмүжин Жамуха хоёр энэ мэт салан явжээ. Энэ салалт нь өнөдийн салалт болсон бөгөөд Тэмүжин Жамуха хоёрын эвлэршгүй дайсагнал ч ингээд эхэлсэн юм.

21. Тэмүжин тал нутгийн язгууртан лугаа холбоолсон нь

Тэмүжин нар Жамуха-гаас салаад, хүн цөөсч, хүчин мөхөсдөөгүй, харин аймаг бүлэг нь

олшрон, анд нөхөд нь өнөржиж, аугаа хүчин нь улам улмаар бузгайрч байв. Тал нутгийн шинэ мандсан язгууртан ч Тэмүжинийг түшин иржээ.

Тэмүжин тал нутгийн язгууртан нартай холбоолсон явдал нь хэрэг дээрээ Жамухатай хамт байсан жил хагасын хугацаанд биелэгдсэн юм. Гэтэл эдгээр язгууртнууд яг Тэмүжинийг даган ирсэн бодтой явц нь Тэмүжин Жамуха хоёрын салсан тэр жил - 1181 оноос Тэмүжин анх удаа “Хамаг Монгол”-ын хаанаар өргөмжлөгдсөн тэр жил - 1189 оны хоорондохи долоо, найман жилийн дотор урьд хожид биелэгдсэн байна. Манай ууган тулгар бичиг “Нууц товчоон”-ы тэмдэглэлээс үзэхүл, доорхи аймаг бүлэг ба язгууртад Жамуха-гаас урьд хожид хагацан салж, Тэмүжинийг дагахаар иржээ:

(1) Жалайр овогтны Хачигун Тохурагун, Харахан Тохурагун, Харалдай Тохурагун ах дүү гурвуул 17 ирэв.

(2) Дархад овогтны Хадаан-Далдурхан ах дүү тавуул 18 ирэв.

(3) Мөнгэтү Хиюуны хөвгүүн Өнгүр нар Чаншигуд, Баягуд овогтноо дагуулж ирэв.

(4) Барулас овогтноос Хубилай, Худус ах дүү нар ирэв.

(5) Мангуд овогтноос Жадай, Догулху чэрби ах дүү хоёул ирэв.

(6) Арулад овогтноос Өгэлэн чэрби (Боорчу-гийн дүү) ахдаа нийлэн ирэв.

(7) Урианхай овогтноос Чагурхан (Зэлмэ-гийн дүү), Сүбээдэй баатар нар Зэлмэ-д нийлэн ирэв.

(8) Бэсүд овогтноос Дэгэй, Хүчүгүр ах дүү хоёул ирэв.

(9) Сүлдүс овогтноос Чилгүтэй (энэ бол “Нууц товчоон”-ы 120 дугаар зүйл дэхи бичлэг, гэтэл 202 дугаар зүйлд нь “Чилгэдэй” гэжээ. Хэрэг дээрээ нэг хүн юм) Тахи, Тайчигудай ах дүү нар ирэв.

(10) Жалайр овогтны Сача Домуг гэгч Архай Хасар, Бала хоёр хөвгүүнээ дагуулж ирэв.

(11) Хонхотан овогтноос Сүйхэтү чэрби ирэв.

(12) Сүхэчин (Сүхэхэн)-ий Жэгэй Хондагар-ын хөвгүүн Сүхэгэйжэгүн 19 нар ирэв.

(13) Нэгүдэйн Цагаан гуа (Баярын галиглалд энэ газар “Цагаан ува” гэж, хойш “гуа” гэжээ. Би бүр “гуа”-гаар нэгтгэв) 20 нар ирэв.

(14) Олхунуд овогтны Хингиадай ирэв.

(15) Горлос овогтны Сэчэгүр ирэв.

(16) Дөрвөн овогтноос Мөчи Бүдүгүн ирэв.

- (17) Ихирэс овогтны Буту хүргэн энд хүргэн болоод байсан тул дагалдан ирэв.
- (18) Ноёхин (Ноёхин) овогтноос Жунсуй (Жунсу) ирэв.
- (19) Орунар овогтноос Жиргуган ирэв.
- (20) Барулас овогтноос Соху Сэцэн хөвгүүн Карачартайгаа ирэв.
- (21) Багарин овогтны Хорчи, Усун өвгөн, Хөхэчүс нар Мэнэн багаринаараа нэгэн хүрээ болж ирэв²¹.
- (22) Хунан зэрэг Гэнигэс овогтон нэгэн хүрээ болж ирэв.
- (23) Бас Есүхэй баатарын дүү Даритай Отчигин нэгэн хүрээ болж ирэв.
- (24) Жадаран овогтноос Мулхалху хүрч ирэв.
- (25) Унжин, Сахайд овогтнууд нэгэн хүрээ болж ирэв²².
- (26) Жүрхин овогтны Сорхату Жүрхи-гийн хөвгүүн Сача бэхи, Тайчу хоёр нэгэн хүрээ болж ирэв²³.
- (27) Есүхэй баатарын ах Нэгүн тайжийн хөвгүүн Хучар Бэхи нэгэн хүрээ болж ирэв.
- (28) Бас Хотала хааны хөвгүүн Алтан Отчигин (Есүхэй баатарын бөл дүү) нэгэн хүрээ болж ирэв.

Дээр дурдсан аймаг овог ба язгууртадын нэг хэсэг нь (21 -ээс өмнөх нь) Тэмүжин, Жамухагаас салах үед дагалдан иржээ. Нөгөө нэг хэсэг нь (22-оос хойшхи нь) Тэмүжин Химурга горхины Айл харгана гэдэг газар бууж бүхүйд нийлэн иржээ. Энэ хоёр удаа нийлэн ирсэн язгууртад нь барагхорин гурван овог аймгийг²⁴ төлөөлж байсан юм. Эдний харьяат ард иргэд нь чухам хэдий байсан гэдэг тоо баримтыг манай гол тулгар бичиг “Нууц товчоон” зэрэгт дурдсангүй. Гэвч Березиний зохиосон “Чингис хаан” гэдэг товхимолд “Түм гурван мянган өрх айл Тэмүжиний тойронд цугларан иржээ” гэж тэмдэглэж байна. Энэ тоо баримт нь чухам хэдий бодтой гэдгийг тодлохын аргагүй ч гэсэн, тал нутгийн олонхи тооны хүмүүсийн сэтгэл нэгэнтээ Тэмүжиний тийш хандаж, Тэмүжиний хүч энэ хэдэн жилийн дотор ирмүүн хөгжсөн гэдгийг мэдэж болно.

Хэлэлгээнгүй, эдгээр язгууртадын хувиас авч үзэхүл, тус тусынхи нь ашиг сонирхол ба тус тусынхи нь зорилго байх юм. Зарим язгууртан нь Тэмүжиний их үйлсийг бүтээж чадах үнэнхүү чадварыг нь үзэж мэдээд, хэрвээ эртнээс Тэмүжинийг дагавал хожим тэдний удирдан ялж, тэдэнд газар нутаг ба эд бодосын ашгийг олгох болно гэж бодсон байна. Зарим нь жишээлбэл Сача бэхи мэтийн ахмад үеийн язгууртад Жамуха-д захирагдах дургүй байж, хэрвээ Тэмүжин мэт залуу хүнийг өргөн гаргавал, түүнийг захирч өөрийн ашиг сонирхлоо хангаж чадах бөгөөд өөрийн хэрэгцээний багажаа болгож болно гэж бодсон байна. Зарим нь Тэмүжинийг өргөн гаргахаар нөхцөл болгож, өөрөө хязгааргүй эрх ашиг олохын төлөө юм. Жишээлбэл, Багарины Бөө Хорчи илээр солилцоо хийжээ. Тэмүжин түүнийг түмний ноён

болгоё гэсэн боловч, тэр бас гучин гуа үзэсгэлэн эм авах ба түүний үгийг сонсох нөхцөлийг дурджээ.

22. Тэмүжин “Хамаг Монгол Улс”-ын хаанаар өргөмжлөгдсөн нь

Шарагчин тахиа жил буюу нийтийн он тооллын 1189 онд Тэмүжин хорин найман настай байсан бөгөөд түүний гэр нь Хэнтий уулын өвөр, Хэрлэн голын эхэнд Сэнгүр горхины Хар зүрхний Хөх нуур гэдэг газар ирж нутаглаж байлаа.

Тэмүжин, Жамуха-гаас салаад найман жил гаруй болжээ. Энэ найман жилийн дотор, “Ниругун Монголчууд”-ын олонхи язгууртад ба нэр төртэй хүмүүс бүр Тэмүжиний тойронд төвлөрчээ.

“Ниругун Монголчууд” Хотала хааныг үхсэнээс нааш хэдэн арван жилийн турш сарнин бутарч, гадаад дотоодын дарлал талхидлыг ханатал амсч, эзэн төргүйн зовлонг эрхгүй мэдсэн байна. Ингээд Монголчуудын хувь заяа ба эрмэлзлэлээ Тэмүжиний дээр тавилаа.

Энэхүү түүхэн тавилан нь зайлшгүй Тэмүжиний бие дээр тавигдсан нөхцөл гэвэл: нэгд, Тэмүжин бол “Ниругун Монголчууд”-ын удамшилт язгууртан Боржигин овогтны хууль ёсны залгамжлагч мөн. Хоёрт, Тэмүжин нь эцгээ нас барснаас хойнохи энэ хориод жилийн туйлын хүчир бэрхшээлтэй амьдрал ба аюул түгшүүртэй тойрон байдлыг өнгөрөөж, сүрдэгдэшгүй цөстэй, нугарашгүй зоригтой, мохошгүй хүчтэй, ууланд тоглох арслан мэт чадалтай, хаданд халих шонхор адил хилэнтэй, агаарт нижигнэх аянга шиг сүртэй монгол эрийн цог жавхааг бүрдүүлжээ. Гуравт, Тэмүжиний анхны ажиллагаа - тархаж бутарсан аймаг угсаагаа нэгтгэж, өмөг хүчээ мандуулан, өстөн дайснаа дарж, өлгий нутгаа амаржуулах явдал нь үндэстэн нийтийн ашиг сонирхолтой нийцэж байжээ. Дөрөвт, Тэмүжин санаснаа биелүүлж, зорьсноо гүйцээх их бодлоготой бөгөөд хүчээ нэгтгэж, нийтийг захирах гарамгай чадварыг бүрдүүлжээ.

Тэмүжинийг хүрээлэн дагаж байсан “Хамаг Монголчууд”-ын язгууртан нар зөвлөлдөж, Тэмүжинийг хаан өргөмжлөхөөр тогтжээ. Ингээд тэдний доторхи ахмад үеийн итгэл хүндэт гурван язгууртан - Хотала хааны гутгаар хөвгүүн Алтан Отчигин, Есүхэй баатарын ах Нэгүн тайжийн хөвгүүн Хучар Бэхи болон Бартан баатарын ах Охин Бархагийн ач хөвгүүн Сача бэхи нар төлөөлөн Тэмүжинд “Чингис хаан”²⁵ гэдэг цолыг өргөмжилжээ. Энэ үед Тэмүжин, хаан орыг ахмад үе болох Даритай Отчигин (Есүхэй баатарын отгон дүү, Тэмүжиний бага авга) болон Алтан Отчигин, Хучар Бэхи, Сача бэхи нарт дараалан найр тавьсан боловч тэд дөрөв хүлээн авсангүй бөгөөд хаанд шударга байх гүйцэтгэх андгайлал хийжээ. Энэ нь “Хаадын үндэсний эрдэнийн товч”-ийн тэмдэглэлийг үндэслэвэл, шарагчин тахиа жил, нийтийн он тооллын 1189 оны явдал болно. Энэ үед Тэмүжин хий насаараа хорин найман настай байв. Гэвч, энэ нь бүх Монголын их хаан биш, Хабул хаан, Амбагай хаан, Хотала хаан адил “Хамаг Монгол Улс”-ын хаан нь болох юм. Тиймээс үүнийг нь түүх сударт нэгдүгээр удаагийн хаан суурь залгамжлалт гэдэг билээ. Тэмүжин хаан өргөмжлөгдсөний дараа түрүү нэг хийсэн ажил бол өөрийн “Өлзийт нөхөд” - (гавьяа зүтгэлтэй анд)-дөө ажил тушаал хувиарлаж, хожмын монгол төрийн байгууламжийн ууган зохион байгуулалтын төлвийг босгожээ.

(Нэг) Цэрэг дайны зохион байгуулалт:

(1) Холбооч, туршуулч, газарч гэж тусгай тушаал тогтоож, Архай Хасар, Тахай, Сүхэгэй (Сүхэгэйжэгүн-ийг товчилжээ), Чагурхан дөрвийг томилов.

(2) Хааныг хамгаалах ба харвалгын тусгай тушаалтныг тогтоож, Өгэлэн чэрби, Хачигун Тохурагун ба Жадай, Догулху чэрби (ах дүү хоёр) дөрөвт хоромсго агсуулав.

(3) Тулгам байлдаан хийх тусгай тушаалтнаар Хубилай, Чилгүтэй, Харахай Тохурагун гуравт илд агсуулж томилсон бөгөөд эднийг Хасараар захируулав.

(Хоёр) Аж ахуй буюу ар талын зохион байгуулалт

(1) Цэргийн агт морийг хамааран хариулах агтачаар Бэлгүтэй, Харалдай Тохурагун хоёрыг томилов.

(2) Энгийн адуун сүргийг хамааран адуулах адуучнаар Тайчигудай, Худуморичи, Мулхалху гурвыг томилов²⁶.

(3) Хонин сүргийг хамааран хариулах хоньчноор Дэгэй томилов.

(4) Хөсөг тэргийг хамааран захирах тэрэгчийн тушаалд Хүчүгүрийг томилов.

(Гурав) Хүнс хоол ба эзэгнэн хамаарах

зохион байгуулалт:

(1) Амуу хүнс, хоол идшийг хамаарах буурчийн²⁷ тушаалд Өнгүр, Сүйхэтү чэрби, Хадаан-Далдурхан гурвыг томилов.

(2) Эд хөрөнгө, гэр орон зэргийг хамаарах тушаалд Сүбээдэй баатарыг томилов.

(3) Гэр доторхи гэргий хүүхэд ба зарц нарыг захирах тушаалд Дөдэй чэрби-г томилов.

(Дөрөв) Хамгийг ахлах ерөнхий захирал:

Энэ тушаалд Боорчу, Зэлмэ хоёрыг томилов.

Тэмүжин хаан өргөмжлөгдсөний дараа бас нэгэн хийсэн ажил бол Хэрэйдийн Тоорил ханд холбооч Тахай, Сүхэгэй-г, Жадараны Жамуха-д холбооч Архай Хасар, Чугурханыг тус тус элч болгон томилж, хаан ор суусан явдлаа албан ёсоор мэдэгджээ. Гэтэл, Ван хан Жамуха хоёр энэ явдалд адил бусын овроор хандаж байв. Ван ханы хэлсэн нь:

Тэмүжин хөвгүүнийг минь хаан болгох нь зөв, Монголд хаан үгүй хэрхэн болох аж гэв. Жамуха-гийн хэлсэн нь, Алтан Хучар хоёрт очиж хэл: Тэмүжин анд бид хоёрын зуур, сүвээг сүлбэж, хавиргыг хатгаж яахин хагацуулав. Бид хоёр үл хагацаагүй бүхийд, яахин Тэмүжин андыг хаан эс болгов? Өдгөө ямар сэтгэлийг сэтгэж хаан болгов? (дээрхийг “Нууц товчоон”-ы 126, 127 дугаар зүйлээс эшлэн найруулав) гэжээ.

Гуравдугаар бүлгийг багцлаад хэлбэл, Тэмүжин бүлгэмдэн ашиглаж болохуйц хүч бүхэн (Тоорил хан, Жамуха)-ийг ашиглаж, тухайн үеийн гол өстөн дайсан Мэргидэд сөнөөгч цохилт өгч, өөрийн улс төрийн нөлөөгөө улам өргөтгөж, цэрэг дайны ба аж ахуйн хүчээ ихээр дээшлүүлжээ. Ингээд “Хамаг Монгол Улс”-ын шинэ мандсан феодал язгууртны олонхи ба тэдний харьяат нарыг өөрийн бие зүгээ татан авч, “Хамаг Монгол Улс”-ыг анх алхам нэгтгэн чадсан бөгөөд нэгдүгээр удаа хаан орноо өргөмжлөгдсөн байна. Түүнчлэн бүх Монгол туургатныг хураан тогтоох их үйлстээ улс төр үзэл санааны талаар, зохион байгуулалтын талаар, цэрэг дайны талаар ба эд бодосын талаар анхны суурийг тавьж өгчээ.

Дагалдвар

1 “Туулын хар түн” гэдгийг Ц.Дамдинсүрэнгийн “Нууц товчоон”-д “Туул голын хар шугуй” гэжээ. “Түн” гэдгийг “Нууц товчоон”-ы уг эхийн хажуугийн хятадчилгад “ой шугуй” гэж орчуулснаар үзэхүл “шугуй” болох нь илт байна. Одоо “Туулын шугуй” гэсэн газар (уртраг нь 111°, өргөрөг нь 47°) байдаг гэлээ. “Халхын Түшээт хан аймаг дахи Туул голын өмнө, ой шугуй арвин Хан уул гэж байдаг. Энэ бол “хар шугуй” болно. Хан уул гэдэг нь Ван хан байснаас нэрлэсэн бололтой” (“Ту Цзи-гийн тэмдэглэл”, 2 дугаар боть). “Туул мөрөн”-ийг одоо “Туул гол” гэж нэрлэж буй. Тэр нь одоогийн Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Хэнтий нуруунаас ундарч, Улаанбаатар хотыг дайран, Сэлэнгэ мөрнөө нийлдэг умард мөсөн далайн усан системийн дотоод хуурай дахи гол болно. Бүх урт нь 819 км. “Туул гол”-ыг эртний хөшөө, сударт “Тоганла”, “Тогула” мэтээр бичдэг байжээ.

2 Хэрэйд аймаг арван нэгдүгээр зууны эхэн үеэр несториан-ы Христосын шашныг шүтжээ. Энэ тухай “Д’Оссоны түүх”-д нэгэн сонирхолтой үлгэрийг мэдээлж байхыг доор товчлон тэмдэглэе:

Түрэгээс зүүн хойш нэгэн Хэрэй гэгч аймаг буй. Нэгэн өдөр тэр аймгийн ван нь ууланд гарч ав хийж байгаад, их цасанд зам төөрч, уулнаас гарч чадахгүй байсан гэнэ. Энэ үед нь нэгэн богд хүн учирч, чи хэрвээ Есүс Христосыг шүтэх дуртай бол би чамайг аюулаас гэтэлгэж, замд чинь оруулж өгье гэж хэлсэнд, Хэрэйд ван зөвшөөрсөн бөгөөд тэр богд замд нь оруулж өгсөн гэнэ. Ингээд энэ ван нь ордондоо хариад, тэр аймагт байсан Христосыг шүтэгч худалдаачдыг цуглуулан, шашны ёсыг асуун “Угаалын ёсныг эс үйлдвээс Христосын шавь болж үл болмуй” гэснийг мэдсэн бөгөөд “буяны сонсгол” гэдэг Христосын номыг олж, өдөр бүр ёслолыг хийх болсон гэнэ. Бас Хорезмын Мароу (marou - Мерв) хот дахи шашны Их мэдэгчийн захад элч зарж, багш томилохыг гуйчилсны хамт ард иргэдийг нь мах сүү иддэг тул бацгийг хэрхэн барих тухай заавар авсан гэлээ. Түүний хариуд их мэдэгчийн хоёр багшаар адист бумба илгээж, угаалын ёслолыг гүйцэтгэсэн бөгөөд тус аймагт мах сүүгээс өөр идэх зүйлгүй тул бацгийн өдөр мах идэж болно гэж зөвшөөрсөн гэнэ. Энэ мэдээг нийтийн он тооллын 1007 онд Абуфара гэгчийн зохиосон “Дорно дахины гүрнүүдийн түүх” гэдэг номд тэмдэглэсэн гэдэг билээ.

3 “Тоорил” (Ван хан)-ы тухай “Д’Оссоны түүх”-д тэмдэглэсэн мэдээг энд хяналт болгон тэмдэглэе.

Ван ханы өвөг нь Маркус Буйруг (Marcouz - Воуоуоуоус) гэдэг. Энэ Буйруг гэдэг бол түрэг хэлний захирагч гэсэн утгатай үг гэлээ. Түүнийг Татарын түрүү Нуур Буйруг (Naour -

Вовуогус) гэгч барьж аваад Хятадын умар дахины хаан (Алтан улсын хааныг хэлж буй – эшлэгч)-д хүргэж, модон илжгэн дээр хадаж алсан юм гэлээ. Маркус Буйругийн бэлэвсэн гэргий нь эрийнхээ өшөөг авахын төлөө, Нуур Буйругт хуурмагаар бууж өгөн, зуун хонь, арван гүү, зуун тулам цэгээг өргөл болгон барихуйдаа тулам бүрийн дотор нэгэн зэвсэгт цэргийг нууж, хурим найрыг нь далимдуулан гарч ирээд Татарын хаан болон найрт оролцсон Татарчуудыг бүр алсан гэнэ.

Энэ Маркус Буйругаас хоёр хөвгүүн үлджээ. Нэг нь Хурчакус Буйруг гэдэг, нөгөө нь Гүр хан гэдэг. Хурчакус нь Хэрэйдийн хаан орыг залгамжилжээ. Түүнийг үхсэн хойно, зургаан хөвгүүнийх нь нэг болох Тоорил хоёр ахаа болон ач хүүхдээ хэд хэдийг алж, Хэрэйдийн хаан орыг нь булаан авсан гэнэ. Ингээд Хятадын хаан (Алтан улсын хааныг хэлжээ – эшлэгч)-аас Ван хан цол өргөмжилж, “Ван хан” гэсэн цолтой болжээ. Түүний авга эцэг Гүр хан нь дутааж, зэргэлдээ аймаг Найманы түрүү Инанча гэгчийг түшиглэжээ. Ингээд Инанча-гаас Гүр ханыг цэргээр дэмжин, Тоорилыг мөхөөсөн учраас Тоорил зуугаадхан морьтноо дагуулан, Тэмүжиний эцэг Есүхэй баатарт орж өгсөн байна. Есүхэй баатар биеэрээ цэрэг дайчлаж, Гүр ханыг Тангудын газар хөөн явуулж, аймаг угсаа ба ард иргэдийг нь Ван ханд буцаан өгчээ. Ван хан Есүхэй баатарт талархлаа илтгэхийн тулд өнид найрамдан явна гэж тангараглан анд болоцсон юм.

Ван хан Тоорил Хэрэйд аймгийн хаан орыг удаан жил эзлэн суужээ. Хожим нь Найман аймгийнхан, Ван ханы дүү Эрх Хар гэгчийг цэргийн хүчнээр дэмжиж, (Ван ханыг мөхөөн) Хар Хятан (Баруун Ляо улс)-д үлдэн явуулжээ. Ван хан Хар Хятанаас тусламж гуйгаад олсонгүй бөгөөд амуу хүнсээ бүр барж, үлдсэн хэдэн ямааныхаа сүүгээр өл хийн явж байв. Тэр үед Тэмүжин нэгэнтээ дэгжрэн мандаж хэд хэдэн аймаг угсааг харьяалж байсан тул Тэмүжинийг түшиглэхийг зорьж 1196 оны хавар Хүсэгү нуур (“Нууц товчоон”-д “Гүсэгүр нуур” гэжээ) гэдэг газар ирээд, Тэмүжиний дэргэд хүн илгээжээ. Ингээд Тэмүжин Хэрлэн голын эхнээс биеэрээ угтаж тохинуулсан бөгөөд (өөрийн харьяатаасаа) мал хөрөнгө татварлан авч дэмжжээ. Тэр намар нь Ван хан Тэмүжин хоёул Туул голд хүрч эцэг хөвгүүн бололцсон гэдэг билээ.

4 Ван ханаас Тэмүжинд хариулсан шүлгийг “Лу. Алтан товч”-оор баримт болгов. Гэхдээ бичлэгийн алдааг нь залруулжээ. “Бөөрийн бөгс, Цээрийн цээжинд атугай” гэсэн хамаг сүүлчийн хоёр бадгийг Ц.Дамдинсүрэнгээс “Бөөр нь бөгсөнд байг, цэр нь цээжинд байг” гэж одоочлоод, “Ах захтай болог” гэж тайлбарласан байна.

5 “Хашин орон” гэдэг бол Хэ Си (голын баруун) гэсэн хятад үгээс хувирч бүтсэн нэр гэдэг. Энэ орон нь Хатан голоос баруунш байдгаараа ийм нэртэй болжээ. Энэ орон бол тэр үеийн Тангуд улс болно. Монголчууд анхандаа Тангуд улсыг “Хашин орон” гэж нэрлэж байгаад сүүлдээ сая Тангуд гэж нэрлэжээ.

6 Энэхүү Алтани гэгчийг “Нууц товчоон”-ы 214 дүгээр зүйлд “Борухулын гэргий” гэж тодорхой тэмдэглэж байх бөгөөд Зэлмэ, Алтани нар Тулуйг аврах үед Тулуй таван настай байсан бөгөөд Тулуйг хорлох гэсэн Харгил шар бол Чингис хаан Татарыг дараад тэрэгний цүү (тэнхлэг)-д хэмжээлж дарангуйлах үед дутааж гарсан хүн гэж бас тодорхой тэмдэглэж байна. Одоо бид цаашид хэдэн асуудлыг тодорхойлье.

(1) Тулуйн төрсөн оныг олонхи материалд 1193 он (“Плано Карпини-гийн аяллын тэмдэглэл”-ийн оросчлогын тайлбарт 1192 он гэжээ) гэдэг билээ. Тиймээс түүний таван нас нь 1197 он болно.

(2) Борухулыг Жүрхиний нутгаас Жэбхэ олж авсан цаг бол бас энэ 1197 оны өвөл болох бөгөөд тэр үед Борухул нь бяцхан хүүхэд байсан тул Өгэлүн эхэд өгч асруулав гэдэг.

(3) Чингис хаан татар иргэнийг мөхөөж, тэргэн цүү (тэнхлэг)-д хэмжээлэн дарангуйлсан цаг бол “Нохой жилийн намар” (1202 он) болох нь мөн тодорхой тэмдэглэлтэй юм (“Нууц товчоон”-ы 153 дугаар зүйл).

Учир иймээс эрхгүй доорхи асуулт тавигдана.

(1) 1202 онд дутаасан Харгил шар хэрхэн 1197 онд Тулуйг хорлож болох вэ?

(2) 1197 оны өвөл сая олж авсан хүүхэд Борухулд яагаад гэргий байж болох вэ?

Тулуйг Харгил шар сугандаа хавчиж гарснаар үзэхүл, таван настай байсан нь зохих мэт. Тийм бол Харгил шар лавтайяа 1202 онд дутаасан хүн биш, Алтани ч энэ үедээ Борухулын гэргий лав биш. Хэрвээ Алтани энэ үед лав Борухулын гэргий, Харгил шар ч лав 1202 онд дутаасан гэж үздэг бол Тулуйг аварсан явдал нь татаж хэлэхдээ 1202 оны хэрэг болох бөгөөд Тулуй таван настай биш, харин арван настай байвал зохино. Хэрвээ Тулуй 1202 онд таван настай байсан бол түүний төрсөн цаг нь 1198 он болно. Ийм бол бас нэгэн асуулт тавигдана. 1203 онд Чингис хаан Хэрэйдийг мөхөөгөөд Жаха Гомбу-гийн бага охин Сорхугтани-г Тулуйд хатан болгон өгсөн гэдэг. Чингэвэл Тулуй зургаан настайдаа урагласан явдал болох биш үү? Тиймээс үүнийг энд асуулт үлдээн, цаашид судлууштай байна.

7 Жаха Гомбу – энэ галиглал бол нөхөр Баярын шинэхэн галигласан “Нууц товчоон”-ы бичлэг болно. “Лу. Алтан товч”-д “Жага Камбуу” гэж, Ц.Дамдинсүрэнгийн одоочлогод “Жаха хамбу” гэж бичиж байна. Тэр бол Хэрэйдийн Хурчхус Буйруг ханы гутгаар хөвгүүн нь болно. Багадаа Тангуд хүнд баригдаж, Тангуд улсад удаан жил суугаад Тангуд хүнд хайрлагдаж “Жага Гамбу” гэдэг нэрийг өгчээ. Рашидийн хэлэхээр “Жаха” гэдэг бол газар гэсэн утгатай үг, “Гамбу” гэдэг бол их жанжин гэсэн үг гэжээ. – тайлбар: Гамбу бол Төвдийн вангийн цол болно (“Д`Оссоны Монголын түүх”, дээд дэвтэр, 40 дүгээр нүүр, тайлбар 4).

8 “Буур хээр”-ийг одоо “Буурын гол” (уртраг нь 106°, өргөрөг нь 50°) гэдэг. Арван хоёрдугаар зууны үед Мэргидүүд энэ газар тариа тарьж байсныг бид “Нууц товчоон”-ы 152 дугаар зүйлд дурдсан Ван хан долоон настайдаа Мэргид иргэнд баригдаж, Сэлэнгийн Буур хээрт очоод будаа нүдэж амьдарч явсан гэсэн тэмдэглэлээс мэдэж болно. Түүхч Ту Цзи биеэрээ энэ “Буур Хээр” гэдэг газар хүрч байцаасан тул тэр нь “Харь нутгийн тэмдэглэл” гэдэгт бичиж байх лугаа адил байна. Энэ газар бол хуучин Халхын Түшээт хан аймгийн зүүн гарын дундад хойд хошуу буюу Чигуй, Сэлэнгэ хоёр голын хоорондох, тухайн үеийн Дундад ба Орос хоёр улсын хуурайн дамын арилжааны хот Хиагтаас өмнө байх Буур харуул гэдэг лавтай мөн гэжээ.

9 “Талхун арал” гэдэг нь Орхон, Сэлэнгийн бэлчээрээс ойр (уртраг нь 106°, өргөрөг нь 50°) байжээ. “Одоогийн Орхон, Сэлэнгэ хоёр усны хооронд байдаг булан уул бол энэ Талхун арал

мөн” гэж Ту Цзи тэмдэглэжээ. Бас энэ үгийг хамниган (манж) гаралтай үг болов уу гэж Х.Пэрлээ жишиж байлаа. Арван наймдугаар зууны үеийн манж албан бичигт “Сэлэнгийн Улиаст арал, Цагаан арал” гэдэг нэр байжээ. Энэ “Цагаан арал” нь эртний “Талхун арал” байж мэднэ. “Лу. Алтан товч”-д “Талун арал” гэжээ.

10 “Харажи хээр” гэдэг нь Сэлэнгийн ич (баруун гар тал - хө.), Хялга-ын солгой этгээд (уртраг нь 107°, өргөрөг нь 51°)-д байжээ. Өвлийн цагт хөлддөггүй урсах усыг “харз” гэж нэрлэдэг байна. Үүнийг “Лу. Алтан товч”-д “Харж хээр”, Ц.Дамдинсүрэн “Харжийн тал” гэжээ.

11 Энэ удаагийн байлдааны цагийг төсөвлөсөн баримт гэвэл ийм байна. Тэмүжин Ван хан лугаа анх холбоолсон цаг бол Бөртэ үжинтэй хуримласан тэр жил билээ. Тэр жилийг “Эрдэнийн товч”-д 1178 он (шар нохой жил) гэдэг тэмдэглэлтэй юм. Энэ удаа тусламж гуйхад нь Ван хан “ноднин жил чамд хэлсэн биш үү” гэснээр үзэхүл, 1179 он болох юм. Сахал өвс ургаж байх ба гол мөрнийг гэтэлж болохоос нь үзэхүл зун буюу намрын нэгэн сар байсан нь ч илхэн байна. Гэтэл энэ удаагийн байлдаанаас хойших жил хагас нь яг зуны тэргүүн сар байлаа гэж “Нууц товчоон” (118 дугаар зүйл)-д тэмдэглэж байхыг үзэхүл бараг намар болж, тэндээс нүүдэллэн явж Хурхунаг Жубурт хүрэхэд бараг өвөл болсон байж мэднэ. Бас байлдааны дунд “Бөртэ үжин, Хуагчин жирин (хоёр) Тэмүжиний жолоо цулбуур шөнө таньж барьжээ. Саруул бөлгөө” (“Нууц товчоон”-ы 110 дугаар зүйл) гэснийг үзэхүл тус сарын арвад байсан нь дамжиггүй юм.

12 “Сахал өвс” гэдгийг “Нууц товчоон”-ы уул эхийн хажуугийн орчуулгад “гахайн зогдор өвс” гэж тэмдэглэж буй. Тус зууны хориод онд Бээжин дэх Монгол Бичгийн Хорооноос хэвлүүлсэн “Монгол утгын зүйл хуваасан толь бичиг”-т “улалж”, “сахал өвс” гэж хоёр зүйлээр хятадчилж байна. “Нууц товчоон”-оос үзэхүл, энэ “сахал өвс”-өөр сал хийж болдог нь яриангүй хэрэг. Үүнийг “Лу. Алтан товч”-д “сахал” гэж бичиж буй. Дорнотив нөхрийн шинээр хятадчилж дөхмөөр тайлбарласан “Монголын Нууц товчоон”-д “сахал өвс” гэж орчуулжээ (70 нүүр). Гэтэл “сахал өвс”-ийг “шанг фү цэ” гэж “Үгсийн далай”-д тайлж, “шанг фү цэ” бол халуун буюу долоон оронд ургадаг, хятад эмд орох ургамал мөн гэжээ. Тиймээс үүнээр сал хийж үл болох мэт. “Монгол утгын зүйл хуваасан толь бичиг”-т “сахал”-ыг “хөлийн улны өвс” гэж нэрлэжээ. Энэ нь зүүн хойд оронд их ургадаг бөгөөд морины дал адил, гутал шаахайд дэвсч болдог. “Нууц товчоон”-д “гахайн зогдор” гэснээр үзэхүл, энэ “сахал өвс” нь зүүн хойт орны “гурван эрдэнэ (орхоодой, булгын арьс, сахал өвс)” гэж тооцдогийнхи нь нэг болох сахал өвс байж мэднэ.

13 “Хилгу мөрөн” бол Чихуй (чи-хүй буюу чи-кү) гол мөн гэж Ту Цзи авгай тэмдэглэжээ. “Ботуган богуржи”-г Ц.Дамдинсүрэн “Ботохан-бооржи” гэж, “Лу. Алтан товч”-д “Ботухан бохуржи” гэж, Х.Пэрлээ “Ботугун бугуржу” гэжээ. Энд бид нөхөр Баярын галиглалыг баримтлав.

Одоо энэ газрыг “Ботухан горхи” (уртраг нь 101°, өргөрөг нь 50°) гэдэг гэнэ. Тэр нь Минж голын солгой этгээдээс цутгадаг байна. “Минж гол” нь “Нууц товчоон”-д дурдсангүй. Одоо Хэрлэн, Ононы эхээр “Хилгу гол”-д хүрэх цорын ганц зам нь энэ “Ботухан горхи”-ийг өгсөж гардаг бөгөөд энэ нь Тэмүжин нар Мэргид аймгийг довтолсон зам болно. Тиймээс “Минж гол” (тэр үед өөр нэртэй ч байж мэднэ) нь “Нууц товчоон”-д орхигдсон бололтой.

4 Энэ бадаг шүлэглэлийг нөхөр Баярын галиглалд:

“Эрхин ээд

Эмбүри дайран орж,

Эм хүүг нь

Эцэстэл дагуулав.

Хутаг ээд нь

Хоор дайрч, хотол улсыг нь

Хохиртол дагуулав” гэжээ.

Лу. “Алтан товч”-д:

“Эрхин эгэ-дэ нь эмбүрү дайрч,

Эм хөвгүүнийг нь эцэлтэл дагуулав.

Хутаг эгэ-дэ нь хугуру дайрч,

Хотол улсыг нь хоосон болтол дагуулав” гэжээ.

Ц.Дамдинсүрэнгийн “Нууц товчоон”-д:

“Эрхэм шүтээний нь эвдэн сүйтгэж,

Эм хүүхдийг нь эзлэн булаав.

Хутагт сахиусы нь хуга дайрч,

Хотол улсы нь хомрон довтолж хоосон болгов” гэжээ.

15 “Хурхунаг Жубур” гэдэг бол Онон мөрний эхэнд байсан гэж Х.Пэрлээ тэмдэглэжээ. Гэтэл Жамуха-гийн гол нутгаар үздэг бол Онон мөрний эх биш, харин Хөлөн нуураас дээш Ононы адаг орчим байвал зүйтэй. “Нууц товчоон”-ы 117 дугаар зүйлд:

“Хурхунаг Жубурын Хулдагар гуны өвөр саглагар модноо анд хэмээлдэж” гэж байдаг. Бас “Хар сүлдний өчиг оршив” гэсэн сударт: “Дэвсэх саглагар модны үзүүр туг бүрээгээ түшин босгож сууж...” гэж тус тус тэмдэглэж буй. Үүнээс үзэхүл, энэ “саглагар модон” гэдэг нь Эртний Монголчуудын бөө мөргөлийн онгон тахилгын “саглагар мод” байсан нь дамжиггүй байна. Гэтэл “Лу. Алтан товч”-д энэхүү “Хурхунаг Жубур”-ыг “Хорхуг Жибур, Хорхус Жибур” гэж нэгдэлгүй бөгөөд баахан сонихоноор бичиж байхыг энд тэмдэглэе. Хурхунаг Жубурын “жубур” гэдэг үгийг Японы монголч эрдэмтэн Накаичиё авгай “толын ундрал” гэсэн

утгатай гэж тайлсан харагддаг бөгөөд “Хурхунаг Жубур” гэснийг Ли Че Пин “Өргөнөө гол” гэж тайлжээ.

16 Тэмүжиний ахмад хөвгүүн Жочи-гийн төрсөн жил сарыг хэд хэдэн янзаар тэмдэглэж байна. “Нууц товчоон”-ы 254 дүгээр зүйлд, хаан орыг хэн залгамжлах тухай ярилцахад Чагаадайгаас: “...Энэ Мэргидэй чул улжагураа гэр мэдүүлхүн бид?” (энэ бол нөхөр Баярын галиглал болно) гэжээ. Асуудал бол энэ “чул улжагур” гэсэн үгэнд байна. Энэ үгийг “Нууц товчоон”-ы хятад галиглалд: “chu-l(e)-wu-l(e) cha-wu-ra” гэж, хажуугийн орчуулгагүйгээр тэмдэглэж байна. Энэ үгийг Элдэндэй, Оюундалай нарын “Монголын Нууц товчоон”-ы харгуулан хянасан дэвтэр (737 нүүр)-т “chu-l(e)-wu-l(e)”, “cha-wu-ra” гэж салган залруулжээ. Тиймээс “чул улжагур” биш, харин “цөлүүл зуур” гэдэг үг болжээ. Энэ бадаг үгийг Ц.Дамдинсүрэнгийн өдгөөчилсөн “Нууц товчоон”-д: “Энэ Мэргидийн орхидост бид захирагдах гэж үү?” гэжээ. Миний үзэхээр энэ бадаг үг нь “Энэ Мэргидийн цөлүүл зуураар хэрхэн мэдүүлэх (захируулах) буй бид” гэсэн утгатай мэт. “Цөлүүл зуур” гэсэн нь зуурд нь цөлж орхисон гэдэг санааг хариулж байна. Нэг л үгээр хэлбэл, Жочи бол Мэргидийг сөнөөсөн тэр жил төрлөө гэдгийг харуулж байна. Мэргидийг сөнөөсөн тэр жил бол 1179 он гэж би дээр дурдсан билээ. Бөртэ үжин баригдах үедээ бие хүнд байгаад, чөлөөлөгдөх үедээ төрлөө гэж үзэх нь зүйтэй юм. Бөртэ үжин урьд Мэргидэд баригдахдаа жирэмсэн байсан гэдгийг “Д’Оссоны түүх”-д: Жочи гучаад насандаа нас баржээ. ...Түүний эх Бөртэ үжин анх жирэмслээд байхад Мэргид нар Тэмүжин гэртээ байсангүйг далимдуулан Бөртэ-г булаан явсан билээ. Ван хан Мэргид вангаас авч, (Тэмүжинд)буцаан өгчээ. Замдаа нэгэн хөвгүүн төрснийг Жочи гэв. “Жочи” гэдэг нь монгол үгийн “зочин” гэсэн утгатай үг юм гэжээ. Үүний ирэл нь чухамдаа “Судрын чуулган”-ы тэмдэглэл болно. Энэ нь хэдийгээр “Нууц товчоон”-тай баахан зөрөөтэй боловч, Бөртэ үжин баригдах үедээ бие хүнд байсныг гэрчилж байна. 1963 онд хэвлүүлсэн “Үгсийн далай” гэдэг хятад хэлний бүрэн тайлбар толь бичигт Жочи-г 1177 онд төрлөө гэжээ. Энэ бол Тэмүжиний төрсөн цаг (1162 он) ба урагласан цаг (1178 он) лугаа тохирохгүй байна. Бас Зөвлөлт Холбоот Улсын монголч эрдэмтэн Н.П.Шастина “Плано Карпинийн аяллын тэмдэглэл”-ийн оросчилгод хавсруулсан зүүлт тайлбар (67 дугаар зурвас)-даа Жочи-г 1185 (4 ?) онд төрлөө гэжээ. Энэ нь манай эшлэлтэй нэн ч зөрөөтэй байгаа бөгөөд ямар баримтлалтайг нь мэдээгүй.

17 Энд Хачигун, Харахай, Харалдай гурван нэрийн дараагаар “Тохурагуд” гэдэг үгийг дагалдуулжээ. Энэ тухай Б.Я.Владимирцовын “Монголчуудын нийгмийн байгууллын түүх” гэдэг зохиолд:

Энд хэлж байгаа Тохурагудын тухай хэн ч бүр мэдэж байгаагаар, тэд бол Жалайр аймгаас салж гаргасан нэг салбар нь мөн бөгөөд Жалайр аймаг бол харин Чингис хааны овгийнхи нь унаган (өтгөс) боол мөн билээ гэжээ. “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д бас: “Жалайрын салбар Тохурагудын Хачигун, Харахай, Харалдай ах дүү гурвуул” гэжээ. Тиймээс энэ “Тохурагуд”-ыг овгийн нэр гэх нь зүйтэй.

18 “Нууц товчоон”-ы 120 дугаар зүйлд: “Хадаан, Далдурхан” гэж хоёр нэрээр бичиж байх нь ил хэвлэлд бүр адил байна. Гэтэл, “Нууц товчоон”-ы 124, 174 дүгээр зүйлд бүр “Хадаан Далдурхан” гэж ганц хүн болгожээ. Энэ нь мөн эл хэвлэлд зөрөөнгүй юм. Японы монголч эрдэмтэн Хонда Санаинобу-гийн зохиосон “Чингис хааны арван гурван хүрээний тухай”

гэдэг өгүүлэл (“Дорно дахин” сэтгүүлийн дөрөвдүгээр найруулал, 1952 оны 3 сар)-д “Хадаан - Далдурхан” гэж ганц хүнээр тэмдэглэжээ. “Ту Ци-гийн тэмдэглэл”-д бас нэг л хүнээр тэмдэглэжээ. Ингээд би бас нэг хүнээр бичив. Энд тэмдэглэх нь нөхөр Дорнотивийн “Шинэ хятадчилга”-д: “бас Дархадын Хадаан, Далдурхан ах дүү хоёр, таван Дархад нар иржээ” гэж нэлээд хавируулан орчуулжээ. Баримтыг нь эс мэдлээ.

19 Энэ нэгэн зурвас “Нууц товчоон”-ы хэдэн хэвлэлд адилгүй байна. Нөхөр Баярын галигласан хэвлэлд Сүхэхэн гэдгийн (хөвгүүн) Жэгэй, Хундагур гэдгийн хөвгүүн Сүхэгэй, Жэгүн хоёр гэсэн санаагаар (Жэгэй, Сүхэгэй, Жэгүн гурван хүн иржээ) илтгэжээ. Гэтэл тус галиглалын 177 дугаар зүйлд “Архай Хасар, Сүхэгэй Жэгүн хоёр оо” гэж “Сүхэгэй Жэгүн”-ийг нэг л хүнээр үзжээ (эл хэвлэл бүр адил). Гу Гуань Ци-гийн хятад галиглалд: “su`k`e-k`e-ne che-kai huang-ta-huo-run ke-uen su-k`e-kai che-u” гэжээ. Энэ нь нөхөр Баярын галиглалтай адил байна. Үүнийг Элдэндэй, Оюундалай нарын галиглалд: “Сүхэхэн Жэгэйхүн, Дагурын хөвгүүн Сүхэгэйжэгүн” гэжээ. Энэ нь яриангүй Сүхэхэний (хөвгүүн) Сүхэхэй Жэгүн (нийт хоёр хүн) гэсэн санааг харуулж байна. Ц.Дамдинсүрэнгийн монголчилго нь: “Сүхэгэнээс Жэгэй хондгарын хөвүүн Сүхэхэй-Жаун ирэв” гэжээ. Энд “Сүхэхэн” гэдэг нь хүний нэр биш, харин овог аймгийн нэр мэт болжээ. Тэрчлэн “Жэгэй Хондагар” гэдэг хүний хөвгүүн “Сүхэхэй Жэгүн” гэсэн (нэгэлхэн хүн болжээ) санааг харуулжээ. “Лу. Алтан товч”-д “Сүхэхэний Жэгэй. Хундагарын хөвгүүн Сүхий Жэгүн ирэв” гэжээ. Энд бичлэг жаахан зөрөөнтэй боловч үндсэндээ нөхөр Баярын галиглалтай адил байна. “Ту Ци-гийн тэмдэглэл”-д “Сүхэхэн”-ийг “Сүхэчин овог” гэж овгийн нэрээр тодолж байх бөгөөд түүнээ арван хоёр ботийн “Нууц товчоон”-оос эшлэл хийжээ. Дорнотивийн шинэ хятадчилгад “Сүхчин” гэж орчуулжээ. Үүнээс гадна Японы монголч эрдэмтэн Хонда Санаинобу-гийн өгүүлэлд: “Сүхэхэний Жэгэй Хундагурын хөвгүүн Сүхэгэйжэгүн” гэж байх нь Ц.Дамдинсүрэнгийхтэй адил байна. Эдгээр байдлуудыг би “Нууц товчоон”-ы 180 дугаар зүйлд дурдагдах “Егэй Хондагар” гэдэгтэй харьцуулж үзээд, “Сүхэхэн” гэснийг “Сүхэчин” овгоор, “Жэгэй Хондагар”-ыг нэг хүнээр, “Сүхэгэй Жэгүн”-ийг нэг хүнээр үзэх нь зүйтэй мэт санагджээ. Ингээд бас “Сүхэгэй Жэгүн”-ийг нийлүүлэн бичив.

20 “Нууц товчоон”-ы уг эх ба нөхөр Баярын галиглалаас үзэхүл, энэ зурваст “Нэгүдэй”, “Цагаан гуа” гэсэн хоёр хүн иржээ. Гэтэл тэр хоёр чухам аль аймгийн, хэний хөвгүүн гэснийг бүр тодорхойлсонгүй байна. Энэ зурвасыг Ц.Дамдинсүрэнгийн монголчилгод: “Нэгүдэйн Цагаан гоо ирэв” гэжээ. Үүнээс үзэхүл, Цагаан гуа нь “Нэгүдэй” гэдэг хүний хүү болно. Мөн Хонда Санаинобу-гийн өгүүлэлд: “Нэгүсийн Цагаан гуа” гэжээ. Дорнотивийн шинэ хятадчилгын 86 дугаар нүүрийн тайлбарт “Нэгүдэй, Цагаан гуа: Даруй Нэгүдэй угсааны Цагаан гуа гэгч болно” гэж дайлжээ. Энэ нь зүйтэй юм. “Нэгүдэй”-г бас “Чонос овогтон” гэдэг. Энэ Чонос овогтон нь Чархай Линху бэргэнтэйгээ сууж төрсөн хөвгүүн Гэндү чоно-ын хойч болно. “Арван гурван хүрээний байлдаан”-ы дараа Жамуха энэ овогтныг сүрхий дарангуйлсан юм.

21 Нөхөр Баярын галиглал ба Элдэндэй, Оюундалайн дэвтэрт бүр “Хорчи усун өвгөн” гэж нэг л хүнээр үзжээ. “Нууц товчоон”-ы 121 ба 202 дугаар зүйлд “Хорчи” гэж Усун өвгөнөөс салган бичив. “Лу. Алтан товч”-д: “Хорчи, Усун өвгөн, Хөх цос” гэж, нөхөр Дорнотив болон Ц.Дамдинсүрэн мөн “Хорчи, Үсүн өвгөн, Хөхөчөс” гэж гурван нэрээр тэмдэглэжээ. Ингээд би бас сүүлчийнхийг баримтлав.

22 “Унжин” гэдгийг Нууц товчооны хажуугийн орчуулгад бүр “хүний нэр” гэж бичиж байна. Гэтэл “Биеэр дайлсан тэмдэглэл”-д “Нунжин аймаг”, “Сахай аймаг” гэж овог аймаг болгон тэмдэглэжээ. Нөхөр Дорнотивийн шинэ хятадчилгын 87 нүүрийн тайлбар 12-т: “Унжин, Сахайд: даруй Сахайд аймгийн Унжин гэгч болно” гэжээ. Энэ нь “Унжин”-ийг хүний нэр, “Сахайд”-ыг овгийн нэр болгосон нь илт байна.

Миний үзэхээр, энэ, “Унжин” гэдэг бол “Чо Гэн Лу” гэдэг ном дахи Монголын далан хоёр овгийн “Вэй Шэнь” ба “Юань улсын түүх”-ийн “Борухулын намтар” дахи “шү-ү-жэнь” гэдэг овгийн нэрийн хувирал болох мэт. Үүний ирлийг хэлбэл, энэ овогтноос Нун мөрнөөр нутаглаж байснаараа “Нунжин” овогтон болж, энэ “Нунжин”-ыг дусалгүй бичсэнээс хятадаар “Унжин” болжээ. Энэ “Унжин” гэснийг “Эрдэнийн товч”-д “Үгүшин” гэж тэмдэглэж байна. Бид овог гэснийг нь баримтлал болгов.

23 Энд (“Нууц товчоон”-ы 122 дугаар зүйлд) “Сорхату Жүрхи” гэж байхад “Нууц товчоон”-ы 49 дүгээр зүйлд: “Охин Бархагийн хөвгүүн Хутугту Жүрхи бөлгөө, Хутугту Жүрхи-гийн хөвгүүн Сача бэхи, Тайчу хоёр бөлгөө. Жүрхи овогтон тэд болов” гэжээ. Энэ нь яриангүй нэг хүнийг хоёр янзаар бичиж байх бөгөөд хэд хэдэн хэвлэлд бүр адил байна.

24 Энд дурдсан хорин гурван овог аймгийн дотроос Арулад, Урианхад, Сүлдүс, Хонхотан, Олхунуд, Ихирэс, Тайчигуд, Жадараны тухай түрүүчийн бүлгүүдэд нэгэнтээ танилцуулсан билээ. Жалайрыг дөрөвдүгээр бүлэгт тусгай танилцуулах болно. Бусдыг нь доор дөхөм танилцуулья.

Дархадыг “Нууц товчоон”-ы хажуугийн орчуулгад “овгийн нэр” гэж тэмдэглэж байна. Б.Я.Владимирцовын “Монголчуудын нийгмийн байгууллын түүх” гэдэг зохиолд: Даргуд (бичлэг зөрөөтэй байна – эшлэгч)-ын тухай гэвэл, хэн бүхний мэдээжээр тэд бол “ой”-н аймаг болох юм. Чингис хааны өвөг Бартан баатарын гэргий бол даруй энэ аймгийн хүүхэн билээ. Рашид-ад-Дин ч энэхүү салбар овгийн байдлыг ярьсан юм. Энэхүү салбар овгийн нэлээд гэр төрөл нь, уулдаа Чингис хааны эмээ эхэд нь инж болж, Чингисийн овогт ирсэн байж мэднэ (Үндэстний Хэвлэлийн Хорооны 1980 оны хэвлэлийн 134 нүүр) гэжээ. Тэр үеийн монгол аймгууд мод, төмрийн гар үйлдвэртэй байсан нь баримттай юм. Тиймээс энэ “Дархад овогтон” нь гар урчуудаас удамтай ч байж мэднэ. Энэ бол зөвхөн таамаглал төдий л билээ.

Чаншигуд овогтон бол “Дүрлүгин Монголчууд”-ын нэгэн салбар болно. Тэр нь арван хоёрдугаар зууны сүүлчийн үеэр хиюуд овогтны Мэнгитэ-гийн хөвгүүн Өнгүрийн харьяат байжээ. Хожим нь Чингис хаан энэ аймгаас дөрвөн мянган хүн салгаж Жочи-д захируулсан гэдэг билээ.

Баягуд овогтон бол мөн “Дүрлүгин Монголчууд”-ын нэгэн салбар болно. Түүний дээдэс нь Малиг Баягудай гэдэг. Эрт цагт тэр идэх үгүй өлсч явахдаа хөвгүүнээрээ Добун мэргэнээс бугын мах арилжиж авсан билээ. Ингээд түүний үрс нь хиюуд овогтны унаган (өтгөс) боол болжээ. Тэдний хойч үрс өнөр олон болж, өөртөө аймаг бүлэг болсон бөгөөд Жадын баягуд, Гэр баягуд гэж хоёр салбар овогтонтой болжээ. Тэмүжиний мандлын эхний үед Чаншигудын хамт Тэмүжинийг дагаж иржээ. Түүний түрүү нь Бэхи гэдэг өргөмжлөлтэй билээ.

Барулас овогтныг Их Барулас, Өчүүхэн Барулас гэж хуваадаг. Их Барулас бол Тэмүжиний наймдугаар үеийн өвөг Мэнэн Тудуны гутгаар хөвгүүн Хачигу, түүний хөвгүүн Баруладай гэдэг бие их бөгөөд идээн барах ховдог тул түүний үр хойч нь их Барулас овогтон болжээ. Мөн Хачугу-гийн дүү нь Хачула гэдэг, түүний үр хойч нь өчүүхэн Барулас овогтон болжээ. Харин “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д Тумбинай сэцэний хоёрдугаар, гуравдугаар хөвгүүний үр хойч гэжээ. Гэтэл Тумбинай сэцэн бол Тэмүжиний хуланц өвөг (дөрөвдүгээр үе) мөн, “Нууц товчоон”-д түүнд хоёрхон хөвгүүнтэй гэсэн юм.

Мангуд овогтон бол Тэмүжиний наймдугаар үеийн өвөг Мэнэн тудуны долдугаар хөвгүүн Начин баатар, Начин баатарын хөвгүүн Манху-гийн үе хойч болно. Үүний долдугаар үеийн ач Хуйлдар сэцэн гэгч бол алдартай баатар хүн байсан бөгөөд Чингис хаанд насаараа шударга үйлчилжээ.

Бэсүд овогтон, Тэмүжиний тавдугаар үеийн өвөг Байшинхор догшины дүү Чарахай Линху, ах Байшинхорыг үхсэний хойно бэргэнтэйгээ сууж нэгэн хөвгүүн төржээ. Нэр нь Бэсүдэй гэдэг. Түүний үр хойч нь Бэсүд овогтон болжээ. “Судрын чуулган”-ы аймаг угсааны магадлалтад Бэсүд овогтон бол Тумбинай сэцэний есдүгээр хөвгүүн Хияудай Отчигины үр хойч мөн гэжээ. Энд “Нууц товчоон”-ыг баримтлав.

Горлос овогтон бол Хонгирад аймгийн салбар гэдэг билээ. Эдний дээдэс нь Түсүбуду гэдэг (тус товчооны хоёрдугаар бүлэг дэх Хонгирадын зурвасыг лавлаарай) юм. Хорилардай Мэргэн гэгч Хори Түмэдийн ноён байжээ. “Ниругун Монголчууд”-ын дээд Бодончарын эх Алун гуа бол энэ Хорилардай Мэргэний охин юм. Урьд Хорилардай Мэргэн ан гөрөөгөөр аж төрж байсан билээ. Тэр үе Хорь Түмэдэд булга, хэрэм авлахыг хорьсон тул Хорилдой мэргэн Бурхан Халдун ууланд нүүж иржээ. Түүний үр хойч нь Хорилар овогтон болов. Энэ “Хорилар” гэсэн үг нь хожимдоо хувирч “Горлос” боллоо гэдэг бас нэгэн тэмдэглэл буй.

Дөрвөн овогтон бол Добун мэргэний ах Дува Сохорын дөрвөн хөвгүүн эцгээ үхсэн хойно авга Добун мэргэнээс салж яваад Дөрвөн буюу Дөрвөд овогтон боллоо гэдэг билээ. Эд мөн “Дүрлүгин Монголчууд”-ын нэгэн аймаг болно. Тэмүжиний үед Дөрвөн овогтны түрүү нь Хажигун бэхи гэсэн хүн байжээ. “Эрдэнийн товч”-д Дува Сохорын ахмад хөвгүүн нь Донуй, хоёрдугаар хөвгүүн нь Догшин, гутгаар хөвгүүн нь Эмлиг, дөтгөөр хөвгүүн нь Эрх гэдэг, эдний үр хойч нь тус тус Өөлд, Баатуд, Хойду, Хэржүгүд дөрвөн овогтон болсон бөгөөд дөрвөн Ойрадын удам тэд гэж “Нууц товчоон”-той нэлээд адилгүй тэмдэглэж буй. Бид “Нууц товчоон”-ы тэмдэглэлийг баримтлав. Энд дурдаж бүхий дөрвөн овогтон нь одоогийн Өвөр Монголын Өөртөө Засах Орон ба Хар мөрний мужид байх Дөрвөд хошуутай өөр нэгэн учир болох юм.

Ноёхин овогтны тухай гэвэл, Тэмүжиний наймдугаар үеийн дээд Мэнэн Тудуны хоёрдугаар хөвгүүн нь Хачин гэдэг, Хачины хөвгүүн нь Ноёгидай гэдэг. Тэр нь ноёмсог авиртай болохоор Ноёхин овогтон болов гэж “Нууц товчоон”-д тэмдэглэжээ. Гэтэл “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д түүнийг Тумбинай сэцэний үр хойч гэсэн нь мөн “Судрын чуулган”-аас эшлэсэн явдал болно.

Орунар овогтон, Тэмүжиний долдугаар үеийн өвөг Хайду-гийн гутгаар хөвгүүн нь Чаужин Өртэгэй-н үр хойч нь Орунар овогтон болжээ.

Багарин овогтон, Бодончар мунхагийн барьж авсан эм Жарчигуд Аданхан Урианхажин Бодончартай суугаад төрсөн хөвгүүнийг Багаритай гэж нэрлэжээ. Энэ Багаритай нь Багарин овогтны дээдэс болжээ. Тэд нь улам олшроод Багарин, Мэнэн Багарин, Нүцгэн Багарин гэдэг гурван салбар овогтон болсон байна.

Гэнигэс овогтон бол Чаужин Өртэгэй-н зургадугаар хөвгүүн Гэнигэс (Ц.Дамдинсүрэн Гэнигэс гэжээ)-ийн үр хойч болно. Түүний түрүү нь Хунан гэдэг, хожим нь Чингис хааны төрийн гавьяатны мянганы ноён болсон юм.

Сахайд овогтны гарлын тухай мэдээ харагдаагүй. “Дүрлүгин Монголчууд”-ын нэгэн салбар гэж Ту Цзи тэмдэглэжээ.

Жүрхин овогтон бол Тэмүжиний өвөг эцэг Бартан баатарын ах Охин Бархагийн үр хойч нь болно. Охин Бархагийн хөвгүүн Хутугту Жүрхи (“Нууц товчоон”-ы 122 дугаар зүйлд “Сорхату Жүрхи” гэжээ), түүний хөвгүүн нь Сача бэхи, Тайчу хоёр, түүний үр хойч нь Жүрхин овогтон боллоо гэдэг билээ. Энэ “Жүрхин”-ийг “Эрдэнийн товч”-д “Жоргин”, “Судрын чуулган”-д “Юркин” гэж өөр өөрөөр бичжээ. Энэ Жүрхииний тухай “Нууц товчоон”-ы 139 дүгээр зүйлд нэлээд нарийн тэмдэглэжээ:

Жүрхииний эцэг, Хабул хааны хөвгүүдийн ахмад тул харьяат иргэдийн дотроос эрхийдээ эрчимтэй, элгэндээ шүүстэй, уушгиндаа ууртай, урууландаа хилэнтэй хүчит бөх ба эрдэмт эрсийг ялгаж хөвгүүндээ өгөв. Ийнхүү уур омогтой, чанга зүрхтэй хүмүүс нийлсэн тул Жүрхин хэмээн нэрлэжээ. Чингис хаан ийм омогт Жүрхин нарыг доройтуулан дарж, олон ардыг нь өөрийн өмч иргэн болгов гэжээ.

25 Чингис хааны “Чингис” гэдэг цолын тухай дотоод гадаадын эрдэмтэд зүйл зүйлээр судалж зөвлөж байсан бөгөөд мөн ч цөхрөлгүй судалсаар байна. Одоо би эдгээр байдлыг хураангуйлан танилцуулахын хамт зарим асуудлыг цаашид зөвлөө.

(А) Юуны урьд тавигдах нь “Чингис” гэдэг цолыг хэдийд хэнээс өргөмжлөв гэсэн асуудал болно. Энд бид шувуу донгодсон дууныг үндэслэн ийм цол олголоо гэсэн мэтийн сэтгэлч үзлийн домгийг нуршихыг больё, зөвхөн түүхэн тэмдэглэл, баримтлалтай гэсэн зүйлийг судалж үзье.

Нэгэн нийтэм ярьдаг яриа бол Хэрэйдийн Ван ханыг мөхөөсөн (Дундад улсын тэмдэглэлд харагчин гахай жил - 1203 он, Джувейнийн тэмдэглэлд 1202 он) хойно, Хонхотаны Мүнлигийн хөвгүүн Дэв тэнгэр - Хөхэчү бөөгөөс өргөмжлөв гэдэг. Үүнийг дотоод гадаадад нэлээд чухал баримтаар үзэж байна. Үүний ирэл бол Джувейнийн зохиосон “Дэлхийг байлдан дагуулагчдийн түүх” (Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хорооны 1980 оны хятад хэвлэл, дээд дэвтэр, 40 нүүр)-д ийм нэгэн тэмдэглэл буй:

Энэ үед (Ван ханыг мөхөөсөн үе - эшлэгч), өвлийн тэсгим хүйтэнд нүцгэн биеэрээ хээр хөдөө уул талгүй явдаг нэгэн хүн байжээ. Тэр харьж ирээд хэлсэн нь: “Хурмаст тэнгэр надтай хэлэлцлээ”, тэнгэр хэлсэн нь: “Би бүх дэлхийг Тэмүжин болон түүний үр хөвгүүдэд соёрхосугай, түүнийг Чингис хаан гэж нэрлэтүгэй, түүнээр өршөөлт засгийг энэ мэт ёсоор биелүүлсүгэй” гэжээ. Хүмүүс энэ хүнийг Дэв тэнгэр гэдэг бөгөөд тэр яаж хэлбэл Чингис

хаан чингэж хийдэг гэлээ гэж би найдвартай монгол хүнээс сонссон билээ . Энэ тэмдэглэлд хэдийд хэнээс өргөмжиллөө гэдгийг хуумгайгүй тэмдэглэж байх боловч, энэ нь Джувейнигийн “найдвартай монгол хүн”-ээс сонссон домог төдий гэдгийг онцгой анхаарах хэрэгтэй.

Ван ханыг мөхөөсөн хойно ба Чингис хаан 1206 онд хоёрдугаар удаа бүх Монголын их хаан болоход ч гэсэн, Дэв тэнгэрийн ингэж хэлсэн баримт манай тулгар бичгүүдэд ер тэмдэглэгдээгүй билээ.

Тэмүжинийг анх удаа “Хамаг Монгол Улс”-ын хаанаар өргөмжлөгдөх тэр үеийг “Монголын Нууц товчоон”-ы 123 дугаар зүйлд: “Өдий үг барилдаж, ийн ам алдаж, Тэмүжинийг “Чингис хаан” хэмээн нэрийдэж, хаан болгов” гэжээ. Энэ бол шарагчин тахиа жил - 1189 оны хэрэг билээ. Энэ тухай хөндлөнгийн нэгэн гэрч гэвэл: Алтан улсын Чжанцзун хааны Мин Чангийн хоёрдугаар он, цагаагчин гахай жил (1191 он)-ийн доор “Их төрийн Чингис хаан энэ жил цэрэг хөдөлгөв” (“Бурхан багшийн үе улирлын ерөнхий тэмдэглэл”, 31 дүгээр боть - Цзя Цзин Янь-ий өгүүллээс дам эшлэв) гэсэн тэмдэглэл болно. Энэ бол 1206 оноос арван таван жилийн өмнөх тэмдэглэл болно. Энэ үед “Чингис” гэсэн цол нэгэнтээ дэлгэрчээ. Чингэвэл үүнийг хэн өргөмжлөв? гэвэл тухайн үеийн шинэ мандсан феодал язгууртны төлөөлөгч - хиюуд ястны Алтан, Хучар, Сача бэхи гурав болно. Тиймээс Чингис хааны “Чингис” гэсэн цолыг Ван ханыг мөхөөсөн хойно Дэв тэнгэр (Хөхэчү) өргөмжиллөө гэдэг Джувейни-гийн тэмдэглэл бол баталгаагүй гэж би хувьдаа үзэж байна.

(В) Дараад нь “Чингис” гэдэг нь ямар ухагдахуунтай үг болох буй гэсэн асуудал болно. Энэ тухай олон зуун жилийн турш их бахархалтай ярилцаар байна. Ялангуяа ойрын зуун жилээс нааш нэн хөгжөөнтэй ярилцаж иржээ. Эдгээр ярилцаанд анхаарууштай гэсэн нь гурван зүйлийн хэллэг болно.

Нэгдүгээр нь, бат гэсэн утга бүхий “чин” гэдэг үндсэн үгэнд “гис” гэсэн нэр үгийн олон тооны дагаварыг залгаж бүтсэн гэдэг. Энэ бол арван дөрөвдүгээр зууны үеийн Персийн түүхч Рашид-ад-Диний тайлбарлал болно. Дараа нь Буриад Монголын эрдэмтэн Хар Даваа гэгч Ойрад халимагийн амьд яриагаар Рашид-ад-Диний тайлбарлал зөв гэж нутлажээ (Б.Я.Владимирцов: “Чингис хаан”).

Хоёрдугаар нь, бөө мөргөлийн догшин тэнгэр “Хажир Чингис тэнгэр” гэснээр нэрлэлээ гэдэг. Үүний уг ирэл нь бодоход Джувейни-гийн тэр тэмдэглэл байлгүй, гэвч ийм бодтойгоор анх дурдсан хүн бол Буриад Монголын Доржийн Банзаров юм. Дараа нь Оросын монголч эрдэмтэн Козин жич орчин үеийн зарим эрдэмтэн бас ингэж үзэцгээж байна.

Гуравдугаар нь, монгол түрэг хэлэн дэх “тэнгис далай” гэсэн үгийн “тэнгис” буюу “тенгис” гэснээс хувирч “Чингис” боллоо гэдэг. “Далай хаан” (их хаан) бол үүнээс ирэлтэй гэж үзжээ. Үүнийг эхэлж дурдсан хүн бол Францын дорно дахинч эрдэмтэн Паул Пеллио (Paul Pelliot, 1878 - 1945) болох ёстой. Дараа нь Монгол улсын Ц.Дамдинсүрэн зэрэг эрдэмтэн бүр ингэж үзэж байсан юм.

Монголын их хааныг “Далай хаан” гэдэг, “Нууц товчоон”-ы 280 дугаар зүйлд Өгөөдэйг “Далай хаан” гэж тэмдэглэж байхаар барахгүй, Хаант Монгол Улсын их хааны тамга (Гүюг хааны тамга гэдэг)-д хүртэл сийлэгдэж, манай үед хүрч иртэл үлдсэн түүхийн баримттай

юм. “Тенгис” гэдэг үгийг түрэг гаралтай үг гэдэг боловч их эртнээс Монгол аймгуудад хэрэглэгдэж байсныг “Нууц товчоон” (1 дүгээр, 199 дүгээр зүйл)-д бүрэн тусгаж байх бөгөөд далай, тенгис хоёр адил утгатай гэдгийг тусгаж байна. Жишээлбэл, “загас болж, тэнгис далайд орвоос, чи Сүбээдэй гөлми гувчуур болж шүүж гувчиж...” гэж “Нууц товчоон”-ы 199 дүгээр зүйлд тэмдэглэж буй. Тиймээс “Чингис хаан”-ыг “Далай хаан” гэж үзэх нь харин бодослиг суурьтай боловч уу гэж би болхи бодолдоо боддог юмсан. Энэхүү “тенгис” буюу “далай” бол ус гэсэн утгыг харуулахаас гадна, харин хэмжээгүй их гэсэн санааг харуулж байдаг. Баахан сүүлчийн үед Монголчуудаас өргөмжилсөн “Далай лам” гэдэг цол ч мөн ийм утгатай юм. “Хажир Чингис тэнгэр” гэдэг үг чухам аль үед үүссэн баримтыг би олж хараагүй. Гэвч бид, Чингис хаанаас өмнө үүссэнээр бодовч, энэ гурван үг нь үгсийн сангийн хувьд тус тус ямар ухагдахуунтай гэснийг мухар бишрэлийн үүднээс биш, үгийн судлалын талаас анхаарах хэрэгтэй юм. Энэ тухай миний хувийн танилт бол “Чингис тэнгэр” гэдэг нь бас л “тэнгис тэнгэр” - “их тэнгэр” гэсэн үг болох мэт. “Хажир” гэдэг үг чухам ямар утгатай гэсэн тухай баримтгүй. Эртний монгол хэлэнд “а” авиаг хоолойн “ха”-гаар хэлж байсан түүхээс сэдэвлэвэл, энэ нь манай одоогийн үгсийн сан дахи “ажир” гэсэн үг байж мэднэ. Хэрвээ ийм болдог бол үүний баримтыг олж болох юм. Шашны ухагдахуунаар хэлбэл, лам нарын цамын дотор “дөрвөн ажар” гэдэг их догшин дүртэй бурхад байдаг. Энгийн үгсийн сангийн утгаар нь хэлбэл:

(1) Энэтхэг газрын их багш, (2) Энэтхэг зан үйлд багш нарт бараалхах ёслолын үес эртний сургаалт шүлэг уншин номлогч, (3) Вед (Эртний Энэтхэгийн сонгодог судрыг хэлж байна)-ийн ном судар уншигч багш, (4) Их эрдэмтэн гэсэн үг болно. Бас толгойдоо сахлаг их үстэй үхрийг “Ажар үхэр” гэдэг (дээрх тайлбарыг Цэвэлийн “Монгол хэлний товч тайлбар толь”-д үз).

26 “Нууц товчоон”-ы 120 дугаар зүйлд: “Сүлдүсээс Чөлгэтэй, Дахи, Тайчигудай ах нар дүү нар ирэв” гэснээр үзэхүл, “Тайчигудай” бол яриангүй Сүлдүс овгийн хүн байна. Үүнийг нөхөр Дорнотивийн тайлбарт, “Тайчигудай. Энэ бол хүний нэр. Тухайлбал, тайчигуд овгийн хүн гэсэн утгатай. Гэвч хэн гэснийг нь хэлээгүй. Дараа зохиолын утгаас утга нь үндэслэвэл, Худу, Моричи хоёр хүн бол Тайчигуд овогт харьяалагдах Сүлдүс овгоос ирсэн гэх” (тус номын 86 нүүр) гэжээ. Гэтэл “Нууц товчоон”-ы 124 дүгээр зүйлд: “Тайчигудай Худу, Моричи, Мулхалху гурвыг адуу адуултугай хэмээв” гэжээ. Үүнээс үзвэл, “Тайчигудай Худу” гэдэг нь Тайчигуд овогтны Худу гэсэн нэг хүнийг заасан мэт. Үүнийг нөхөр Дорнотивийн “шинэ хятадчилга”-д: “Тайчигудай, Худу, Моричи, Сүлдүс 3 хүнийг морь алдуултугай хэмээн зарлиг болов” (тус номын 89 нүүр) гэж хятадчилжээ. Энд тоо нь гурав боловч нэр нь дөрөв байна. “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д: “Тайчу (Сүлдүс овогтон гэж өмнө дурдсан), Худуморичи, Мулхалху гурав адуучин болжээ” гэв. “Лу. Алтан товч”-д: “Тайчигудай Ходу, Мориту, Булхалху (өмнө Мухула хуа гэж бичиж байв) гурвуулыг адуу адуултугай хэмээв” гэжээ. Эдгээр байдлыг үндэслэж, энд би Ту Цзи авгайнхийг баримтлав.

27 “Буурч” гэдгийг Ц.Дамдинсүрэн “тогооч” гэж тайлжээ. Гэтэл энэ үгэнд “тогооч” гэсэн ухагдахуун байхгүйгээс гадна, “зоогийн түшмэл”, “гал тогооны ахлагч” гэсэн утгатай юм (“Түрэг хэлний нутгийн аялгууны туршин хэрэглэх толь”). Эртний Монголын “буурч” бол эзний торгон цэрэг дэх хоол хүнсийг тусгай хамаарах дотоод зоогийн гэрийн дарга мөн гэж Элдэнтэй нарын зохиосон Монгол Нууц товчоон”-ы үгсийн тайлбар гэдэг зохиолд дурдсан



ЧИНГИС ХААН БҮХ МОНГОЛЫГ НЭГТГЭСЭН ҮЕ

Тэмүжин хорин найман насандаа анх удаа “Хамаг Монгол Улс”-ын хаан - Чингис хаанаар өргөмжлөгдөөд, цаашид улам их эрх хүч, олз ашгийг олох – эсгий туургатан монгол хэлтэн аймаг угсааг хураан нэгтгэхийн төлөө, өөрийн хүчээ чанга зохион байгуулжээ. Энэ байдлыг манай тулгар бичгүүдэд бүр тэмдэглэж байна. Бас өөрийн цэргээ арван гурван хүрээ хувааж, цэргийн сургуулийг маш нарийн хянамгайгаар хийлээ гэж Березин мэдээлж байсан бөгөөд энэ сургуулилаа ан гөрөө хийх, ав шувуу тавих мэтийн нүүдэлчин аймгийн үйлдвэрлэлтэй уялдуулсан гэжээ. Энэ ч мөн байж болох хэрэг юм.

Бид Эртний Монголчуудын амьдралыг нарийн тэмдэглэсэн мэдээнүүдээс¹ үзэхүл, ан гөрөө хийх нь үнэхээр маш нарийн чанга зохион байгуулалт ба сахилга баттай ажиллагаа байсан билээ. Энэ нь тайван үед тал нутгийн малчдын гол ажиллагааны нэг нь болох юм.

Эртний Монголчууд мал маллаж, нүүдэллэн аж төрөхдөө бүр овог төрлөөрөө нэг хүрээ болж, овгийн ахмад нь дунд нь байрлаж, овгийн гишүүн нь тойрон байрладаг байна. Энэ нь Монголын нийгмийн овгийн байгууллын чухал нэгэн онцлог болж байжээ. Сүүлдээ овгийн байгуулал эвдэгдэж, айл өрхөөр тэмдэг болгосон хувийн аж ахуйд шилжсэн боловч, тэрхүү хүрээний зохион байгуулалт нь ан гөрөөр хийх ба дайн байлдаан хийх удамшилт зохион байгуулалтын хэлбэрээрээ үлдэгдэж байжээ. Сүүлдээ энэ нь Чингис хааны цэргийн зохион байгуулалтынхи нь суурь болж байв.

23. Арван гурван хүрээний байлдаан


“Арван гурван хүрээний байлдаан” гэдэг нь Жамуха болон Чингис хааны хооронд Далан Балжуд² гэдэг газар явагдсан нэг удаагийн их байлдаан болно.

Түүнийг “Арван гурван хүрээ” гэсний учир гэвэл, Жамуха арван гурван харь (харьяат аймаг)-


ийнхаа гурван түмэн цэргийг цуглуулж, Чингис хааныг довтолсонд, Чингис хаан мөн арван гурван хүрээнийхээ гурван түмэн цэрэг (энэ тоо бол “Нууц товчоон”-ы 129 дүгээр зүйлд тэмдэглэж бүхий тоо болно. Гэтэл Д’Оссон, Эрдманн, Березин, Абул-Хжи нар түм гурван мянгаас хэтрэхгүй гэжээ. Энэ ч мөн нэг хүрээг мянган хүнээр жишсэн тоо болно)-ийг дайчилж байлдсан болохоор “Арван гурван хүрээний байлдаан” гэж сүүлчийн хүмүүс нэрлэх болсон юм.

“Арван гурван хүрээний байлдаан” чухам хэдийд болсон цагийн тухай тэмдэглэл хараахан адилгүй байна. “Судрын чуулган”, “Чингис хааны шастир”, “Биеэр дайлсан тэмдэглэл”, “Юань улсын түүх, Тайцзу-гийн шастир” зэрэгт Есүхэй баатарын нас барсны дараа залган тэмдэглэж буй. Ийм бол арван хоёрдугаар зууны далаад оны эхний явдал болно. “Нууц товчоон”-д бол Тэмүжин анхдугаар удаа хаан ор суусны дараа залгаад тэмдэглэж буй. Ийм бол 1189 он буюу үүнээс баахан сүүлчийн явдал болно. Харин Чжан Чжэнь Пэй авгайн зохиосон “Чингис хааны шүүмжлэл шастир” гэдэг тэмдэглэлд:

Сүн улсын Гуаньцзун хааны Шао Си-гийн тэргүүн он, цагаан нохой жил буюу нийтийн он тооллын 1190 он, (Чингис) хаан гучин зургаан нас сүүдэр (энэ бол Чингисийг 1155 онд төрснөөр тоолжээ - эшлэгч)-тэй, Тайчигуд, Жажирадай (Жадараныг бас Жажирадай гэдэг, гэтэл энд “Жажирадай” гэснийг “Жайирадай” гэж илэрхийеэ буруу болгожээ – эшлэгч) зэрэг арван гурван аймаг дахин халдсаныг арван гурван хүрээнээр тосон байлдаад дийлэгдэж, Онон мөрөн өөд ухрав гэж тэмдэглэж буй. Энэ цагийг 1190 он гэсэн нь “Нууц товчоон” лугаа нийцэж байна. Өөр бодтой баримт олдохоос өмнө, бид энэхүү 1190 оныг “Арван гурван хүрээний байлдаан” болсон цаг гэж тэмдэглэе. Энэ үед Чингис хаан хорин есөн настай байв.



“Арван гурван хүрээний байлдаан” - ы зураг




Хүйтний байлдаан-ы зураг



Морио унавал байлдагч



Монголын хааны аяны бараа




Чингис хааны цэргийн хүрээ




Байлдаж бүхий Монголын морьт цэрэг




Арван дөрөвдүгээр зууны үеийн Монголын морьт байлдагч




Юань улсын үеийн монгол цэргийн хэрэглэж байсан хөнгөн нум сум



Монголын морьт цэргийн хөнгөн сэлэм




Монголын цэргийн их буу чөдөр оньс




Тэсрэгч бөмбөг , Чулуун бөмбөг



Юань улсын үеийн Монгол цэргийн хуяг дуулга




Юань улсын үед монгол цэргийн хэрэглэж байсан дөрөө




Одоохи дөрөө



Онгод аймгийн несторианчуудын загалмайт хөшөө чулуу



Хөшөө чулууны хэмжээ хэлбэр



Одоо “Арван гурван хүрээний байлдаан” үүссэн шалтгааныг дурдья. Ерөнхий шалтгаан нь хэлэлгээнгүй, Чингис хааны хүчийг бүрэн дэгжрээгүй үед нь устгаж, монгол аймгуудыг Жамуха өөрөө ноёрхохыг зорьсон явдал болно. Ингээд Жамуха Хурхунаг Жубурт Тэмүжинтэй хамт байгаад, салснаас нааш нэгд; өөрийн хүчээ зохион байгуулж, хоёрт; байлдаан үүсгэх бодот шалтгааныг хүлээж байсан юм. Одоо энэ шалтгаан буй болжээ.

Жамуха-гийн дүү Тайчир гэгч, Саарь хээрээр³ нутаглаж байсан Чингисийн харьяат Жалайр овогтны Жочи Дармала-гийн адууг нь дээрэмдэж явжээ. Ингээд Жочи Дармала ганцаараа нэхэж, шөнө болоход адууныхаа захад хүрч, морин дэл дээрээ элгээрээ хэвтэж очоод, Тайчирын нурууг нь хуга харваж алаад адуугаа авч иржээ. Энэ бол “Арван гурван хүрээний байлдаан” үүссэний шууд шалтгаан болно.

Жамуха энэ үед чухам хаа байсныг шууд тэмдэглэсэн мэдээгүй. Гэвч Жамуха-гийн дүү Тайчир бол Жалам (уул)-ын Өвөр Өлгий Булаг⁴ гэдэг газар байжээ. Жамуха эсхүл хамт байсан, эсхүл ойролцоо байсан нь магад юм. Чингис хааны ордон нь Хүрэлхү⁵ гэсэн газар байжээ.

Жамуха дүүгээ алагдав гэж Жадараны харь (энэ бол харьяат гэсэн үгийн балас (уг – хө.) язгуур “харь” болох мэт) Тайчигуд, Ихирэс, Уругу (Уругуд бололтой), Ноёхин, Барулас, Горлос, Багарин, Хонгирад, Хатагин, Салжигуд, Дөрвөн, Татар зэрэг арван гурван аймгийн³ гурван түмэн цэргийг цуглуулж, Алгугуд, Турхагуд гэдэг хоёр уулыг давж, Чингис хааныг халдахаар ирэв.

Энэ чимээг Чингисийн охин дүү Тэмүлүн гуа-гийн хүргэн Буту-гийн эцэг Ихирэс овогтны Нэгүн (Тэр үед Тайчигудын харьяат байжээ) гэгч, хөвгүүн Буту-тайгаа зөвлөж, түүний шадар Мүдхэ Тутаг, Борулдай⁷ хоёрыг Тэмүлүний гэрээс эцэгт бараалхах учиртай гэж Чингисийн

дэргэд томилон, Жамуха-гийн мэдээг хүргүүлжээ.

Чингис хаан энэхүү мэдээг олж аваад, өөрийн арван гурван хүрээнээсээ мөн гурван түмэн цэргийг дайчилж, Жамуха-гийн эсрэг зүүнш морилж, Далан Балжуд гэдэг газар угтан ширүүнээр байлдав. Чингисийн арван гурван хүрээнийг “Нууц товчоон”-д бодтой дурдаагүй. Энд би “Судрын чуулган”, “Биеэр дайлсан тэмдэглэл”, “Ту Цзи-гийн тэмдэглэл”, “Хань Жу Линь-ий өгүүлэл” ба Хонда Санаинобу-гийн өгүүлэл зэргийг үндэслэж жагсаалаа:

Нэгдүгээр хүрээ нь: Чингис хааны эх Өгэлүн хатан болон түүний төрхөмийн аймаг Олхунуд, ойр төрөл, гэрийн хамаарагч жич ордны хүүхэд зарц зэрэг хүмүүсээр бүрэлджээ.

Хоёрдугаар хүрээ нь: Чингис хааны өөрийн бие болон хааны хөвгүүд, анд нөхөд, ноёд нарын дагагсад, язгууртад жич ойр төрлөөр нь бүрэлдсэн хишигтэн нараар бүрэлджээ8.

Гуравдугаар хүрээ нь: Хабул хааны ах Сэм Сэчүлэ, түүний хөвгүүн Бүлтэчү баатар болон Адархины ахлагч Мухар Хулан түрүүтэй Адархин, Түмэн Түбэгэн Хэрэйд (“Судрын чуулган”-д Жирхин гэжээ, Хэрэйдийн салбар), Сэчэгүр түрүүтэй Горлос нараар бүрэлджээ9.

Дөрөвдүгээр хүрээ нь: Сүйхэтү чэрби-гийн хөвгүүд Даран жич Хонхотан нар, түүний төрлийн Хоридай жич Будагад10 нар бүрэлджээ.

Тавдугаар хүрээ нь: Архай Хасар жич Жалайр овогтноор бүрэлджээ11.

Зургадугаар хүрээ нь: Сорхату Жүрхи (Хутугту Жүрхи)-гийн хөвгүүн Сача бэхи болон түүний дүү Тайчу жич Хиюуд Жүрхин овогтноор бүрэлджээ12.

Долдугаар хүрээ нь: Бартан Баатарын дүү Хутугту Мөнгүрийн хөвгүүн Бүри бөх болон Хутугту Мөнгүрийн дүү Хулан баатарын хөвгүүн Их Чэрэн жич тэдний харьяат, их Чэрэний авга эцэг Төдүгэн отчигиний харьяат хиюуд ястнаар бүрэлджээ.

Наймдугаар хүрээ нь: Бартан баатарын ахмад хөвгүүн Мөнгэтү хиюун, түүний хөвгүүн Өнгүр болон түүний дүү жич Чаншигуд, Баягуд овогтноор бүрэлджээ.

Есдүгээр хүрээ нь: Бартан баатарын отгон хөвгүүн Даритай Отчигин болон түүний ах Нэгүн тайж (МНТ-д тайш гэж буй – хө.)-ийн хөвгүүн Хучар бэхи нар жич Тугулдай, Нэгүс Хорихан, Сахайд, Унжин, Дөрвөн овогтны хүмүүсээр бүрэлджээ13.

Аравдугаар хүрээ нь: Хотала хааны ахмад хөвгүүн Жочи жич түүний харьяат нараар бүрэлджээ.

Арван нэгдүгээр хүрээ нь: Хотала хааны отгон хөвгүүн Алтан Отчигин жич түүний харьяат нараар бүрэлджээ.

Арван хоёрдугаар хүрээ нь: Тахай баатар жич Сүлдүс нар, Жэгэй Хондагарын хөвгүүн Сүхэгэйжэгүн жич Сүхэчин (Сүхэхэн) нараар бүрэлджээ14.

Арван гуравдугаар хүрээ нь: Гэндү чоно, Өлөгчин чонын үр хойч Цагаан гуа жич Нэгүдэй

буюу Нэгүс овогтноор бүрэлджээ15.

“Арван гурван хүрээний байлдаан” нь хоёр этгээдээрээ зургаан түмэн хүн оролцож байлдсан болохоор их хэмжээний дайралдаан болох бөгөөд маш ширүүнээр явагджээ. Бодтой байлдааны тухай манай тулгар бичгүүдэд шууд тэмдэглэл харагдаагүй байна. Гэтэл Березиний “Чингис хаан”гэдэг тэмдэглэлд тус байлдааны байлдах аргыг хүртэл нэлээд нарийн тэмдэглэжээ. Тодорхой магадлалгүй болохоор дагалдварт тэмдэглэв16.

Энэ удаагийн байлдаанд Чингис хааны цэрэг дийлэгдэж, “Өрхэ”-гээс гаран хойш Ононы Жэрэнэ Хавцгай17 гэдэг газар ухран явжээ. Ингээд Жамуха дийлсэн сүрээ мандуулж, Чоносын нутгаар дайран буцахдаа, Чингис хааныг дагасан Чоносын ахлагч ба хүүхдийг барьж алан далан тогоонд буцалгаж, бас Нэгүдэйн Цагаан гуа-гийн толгойг нь огтолж, морины сүүлдээ чирч явсан гэдэг. Жамуха-гийн энэхүү жигшүүрт хэрцгий балмад ажиллагаа нь түүнд талхигдсан аймаг угсаа байтугай, түүнийг дагаж байсан аймаг бүлэгтээ ч жигшигдэн эсэргүүцэгджээ. Ингээд Жамуха-г харьсан хойно, Уругуд аймгийн Жүрчидэй, Мангуд аймгийн Хуйлдар нар харьяат аймгаа дагуулж, Жамуха-гаас салан Чингис хааныг дагаар ирэв. Хонхотаны Мүнлиг эцэг мөн долоон хөвгүүнээ дагуулж, Жамуха-гаас хагацан Чингис хаанд нийлэв.

“Арван гурван хүрээний байлдаан”-ы төгсгөлтийн тухай хүмүүс адил бусаар ярилцацгаадаг байлаа. Жишээлбэл, “Биеэр дайласан тэмдэглэл”-д: “Далан Балжуд хэмээх газар их л байлдаж Жамуха ялагдаж буруулав” гэж тэмдэглэж байна. Хонда Санаинобу авгай: Далан Балжуна гэгч газар явагдсан “Арван гурван хүрээний байлдаан”-ы ялж ялагдсан нь үнэхээр тодорхойгүй гэжээ. Гэтэл, Березин харин: Хүмүүжил сургуулилттай Тэмүжиний эл хүрээ нь ... тархаж бутарсан дайсан цуглараад жагсаалаа зохиохын явцад нь дайсныг толгой өндийлгөлгүйгээр, яг ч жагсаалаар довлон дайрч, бутарган сарниулжээ гэж тэмдэглэж буй. Эдгээр тэмдэглэлүүд аль хир бат баримттай гэснийг мөн ч олж мэдээгүй. Гэвч хүмүүс энэ явдлыг нэгэн чухал хэргээр анхаарч байхыг дамжиггүй харуулж байна. Манай өөрийн ууган тулгар баримт “Нууц товчоон”-ы тэмдэглэлээр үзвэл, Чингис хааны цэрэг түр цаг ялагдсан нь тодорхой гэж хэлж болох юм. Энэ удаагийн байлдаанд Чингис ялагдаж, хойш гурван зуу шахам газар ухарчээ. Энэ бол хааны нэгэн насны анх удаагийн их нугарал болох учраас улсын түүхэнд ялагдлыг нь цээрлэж, ялалт болгон тэмдэглэжээ. Гагцхүү товчоонд шуудаар бичив гэж Ту Цзи авгай тайлбарласан байдаг.

Энэ удаагийн байлдаан бол Чингис хааны түүхэн дээр хоёрдахи удаагийн их байлдаан болох бөгөөд өөрийн хүчиндээ бүрэн түшиглэж хийснээр бодвол анхдагч байлдаан нь болно. Энэ удаагийн байлдаанд амжилт олсонгүй явдал нь Тэмүжиний бүх үйлст авч хэлбэл, харин ялалт олсноос ч ашигтай байсан магадгүй. Хожим нь Чингис хаан мохошгүй тэмцэснийг мөн түүх бүрмөсөн гэрчилснээр барахгүй, халдсан бүхнийг мөхөөж, хандсан зүгт дайсангүй тэмцэснийг түүх бүрмөсөн гэрчлэв. Чингис хаан анх удаагийн ялагдлаасаа дайсан олон бид цөөн, дайсан хүчирхэг бид буурай гэснийг олж мэджээ. Түүнчлэн хүчирхэг их дайсныг яльа гэвэл, өөрийн хүчээ заавал хурцлахгүй болохгүй гэдгийг бас олж мэдсэн бөгөөд энэ талаар их хэмжээний шаргуу ажил хийсэн нь лавтай юм. Эдгээр нь түүх шастирт нарийн тэмдэглэсэнгүй ба манай үе болтол хадгалагдаж үлдсэнгүй нь харамсалтай хэрэг билээ.

24. Татар лугаа анх удаа байлдсан нь

Арван хоёрдугаар зууны сүүлчээрх монгол хэлтэн аймгийн нэгэн хүчирхэг бүрэлдэхүүн болох Татар аймаг бол Түнгүс төрлийн угсаа болно. Тэд эртнээсээ одоогийн Өвөр Монголын Өөртөө Засах Орны Хөлөн Буйр орчмоор нутаглаж, гол ордон нь Буйр нуур хавиар байжээ.

Дундад улсын түүхэнд, Тан улсын дунд үеэс хойш Татар аймаг улам улмаар хүчирхэгжсэн тэмдэглэл харагддаг байна.

Нийтийн он тооллын 840 онд Уйгур Хаант Улс мөхсөний дараа, есдүгээр зууны сүүлчээр, Татар аймаг хүчирхэгжин босч, их хэмжээгээр баруунш нүүж, Уйгурын уул нутгийг эзэлсэн бөгөөд говийн өмнө умрын олон аймгууд – Монгол, Жалайр, Хэрэйд, Онгуд, Мэргид, Хонгирадтай нийлж Татар аймгийн холбооныг байгуулжээ. Ингээд түүний эрх сүр нь Гажил нуруу (Инь Шань) ба Алшаа уул хүрч байв. Туул, Орхоноор нутаглаж байсан “Есөн овгийн Татар” гэдэг нь Хэрэйд аймаг болох ба Гажил нурууны араар нутаглаж байсан “Гажилын Татар” гэдэг бол Онгуд аймаг болох бөгөөд Хөлөн буйраар нутаглаж байсан “Гучин овгийн Татар” (“Юань улсын түүхийн тухай яриа”) гэдэг нь чухам Татар аймгийн гол угсаа нь болно. Гэтэл нийтийн он тооллын 732 онд Орхон голын зүүн эрэгт босгосон Түрэгийн хөшөөнд “Арван гурван овогтон Татар” гэж тэмдэглэж байлаа. “Нууц товчоон” зэрэг тулгар бичигт тэмдэглэгдсэн Татарын гол гол салбар нь:

- (1) Айригуд Татар;
- (2) Буйругуд Татар;
- (3) Жүйн Татар;
- (4) Цагаан Татар;
- (5) Алчи Татар;
- (6) Дутагуд Татар;
- (7) Алухай Татар;
- (8) Алтан Татар 18 зэрэг болно.

Дээр дурдсан Татар аймгийн холбоо гэдэг нь хэрэг дээрээ Монголын эл аймгийн анхны холбоо болох нь тодорхой байна. Ингээд Татартай холбоолсон аймгууд ч өөрийгөө гадагш бүр Татар гэж нэрлэдэг байжээ. Сүүлд нь Хятан үндэстэнд дийлэгдэж, аймгийн холбоо нь задарсан боловч монгол аймгуудын дотор мөн Татарчууд хамгийн хүчирхэг байжээ. “Д`Оссоны тэмдэглэл”-ийг үндэслэвэл, Чингисийн үед Татар аймаг нь долоон түмэн өрхтэй байсан гэдэг билээ. Татар аймаг нь дотроо дорой буурай овог аймгаа үргэлж цөлбөн дээрэмдэж, дарлан талхиддаг байжээ. Ялангуяа Жүрчин үндэстэн Хятаныг мөхөөж, Алтан улсыг байгуулсны дараа, Татарчууд нийтийн он тооллын 1127 онд Алтан улстай харьцаа холбоо байгуулснаас хойш, “харийг хариар захирах” Алтан улсын тэрслүү төрийн бодлогыг нь хэрэгжүүлэх хамгийн найдвартай хүч болж, бүх Монгол аймгуудын ашиг сонирхлыг

худалдаж, харийн ноёрхогчдын өчүүхэн тамшаалал доор өвдөг нугалан бууж өгсөн жигшүүрт урвагч этгээд болсон байна. Хэрэйдийн Маркус Буйруг хан (Ван ханы өвөг эцэг)-ыг Татарчууд барьж, Алтан улсад хүргэн алуулсан; Монголын Амбагай хааныг Татарчууд барьж Алтан улсад хүргэн алуулсан; Чингис хааны их өвөг Охин Бархаг-ийг мөн Татарчууд барьж Алтан улсад хүргэн алуулсан; бас Чингис хааны эцэг Есүхэй баатарыг Татарчууд хор идүүлэн алсан юм. Ингээд Татар аймаг нь Монгол аймгуудын дотор үеийн үедээ өшөө хорслыг тавьжээ.

Татар аймаг нь Алтан улстай айл хөрш байсан болохоор дотор газартай арилжаа худалдаа хийж, тэндэх хөгжингүй аж ахуй, соёлоос олон юм сурч, нэлээд эрт үеэс эхлэн төмөр эдлэл, бөс бараа, цай зэргийг өргөнөөр хэрэглэдэг байжээ. Энэ нь нүүдэлчин аймгийн хөгжилд идэвхтэй үйлдлийг үзүүлсний зэргээр Татарын хүчний эрмүүн өсөлтөд ахиц болсон нь ч яриангүй хэрэг юм.

Гэвч Татар аймгийн хүч даанч их өсөн нэмэгдэхийг Алтан улсын ноёрхогчид хэрхэвч зөвшөөрөхгүй юм. Жүрчин хааны бодлогоч түшмэд нь Татарын байдлыг тодорхой сайхан мэдэж байснаар барахгүй, өө сэвийг эрэн, гар хөдлөх зохистой цагийг хүлээж байжээ.

Чингис хаан Татар аймагтай анх удаа байлдсан явдал хэрэг дээрээ Алтан улсын энэхүү бодлоготой нь тохиролцсон байв. Дээр дурдсан мэтээр Татар аймаг бол хиюуд ястны хэдэн төрлийн цусан хорсолт дайсан болохоор Тэмүжин хэзээд энэ өшөө хорслыг мартдаггүй байсан. Гэвч өөрийн хүч хүрэлцэхгүйдээ өдий болтол гар хөдөлгөөгүй байсан юм. Алтан улс ч мөн Монгол аймгуудын доторхи хагарал завсардлыг ашиглах нь түүний зайлшгүй тогтоосон төрийн бодлого болно.

Нийтийн он тооллын 1194 оноо19 Монголын Хатагин, Салжигуд зэрэг аймаг Алтан улсын хилд халджээ. Ингээд Алтан улсын Чжанцзун хаан, Цзя Гу Цин Чэнь түшмэлээр тэргүүлүүлсэн Дээд нийслэл20 зэрэг есөн замын хязгаарын аймаг угсаагаар бүрэлдсэн Цзюй Цзюнь21 гэдэг цэргийг гурван түмэн хүн сонгож томилсон бөгөөд бас Татар аймагт цэргийн хүчээр тусла гэж тушаажээ. Дараа жил (1195 он) нь Иламин, Ваньгинь Аньго гэгч хоёр жанжнаар цэрэг дайчлуулан Хөлөн нуур хавьд довтолж Хатагин, Салжигуд зэрэг аймгийн арван дөрвөн хүрээнийг эзлэн авсан байна. Энэ удаагийн байлдаанд Татар аймгийн түрүү Мэгүжин Сүүлт22 бас цэрэг томилж, Алтан улстай хамтран байлдаад хонь ямаа, адуу морь болон эд бодосыг их тоогоор цөлбөн дэрэмджээ. Энэ явдлыг нь Цзя Гу Цин Чэнь буруушаалаа гэдэг. Хэрэг дээрээ Алтан улсын цэргийн дээрэмдэн олсон нь бага болж, Татарчууд тэдний ашиг олзод нь халдсан учраас хоорондоо зөрчил үүсчээ. Ингээд Татарчууд цэрэг хөдөлгөж Алтан улсыг эсэргүүцэв. Татар аймаг Алтан улсаас урвалаа гэдэг нь үүнийг хэлж байна.

1196 онд Алтан улсын Чжанцзун хаан баруун мөрийн түшмэл Ваньгинь Сян (“Нууц товчоон”-д “Онгин Чинсан” гэдэг, дорогш би заншлыг баримтлаж Ваньгинь Чинсан гэж бичив)-аар их цэрэг дайчлуулж, Линь Хуан хот23-оос мордож Татар аймгийг довтолжээ. Ваньгинь Чинсан болон Ваньгинь Аньго тус тус хоёр замаар довтолж, Хэрлэн голд хүрээд Татарчуудад бүслэгдэж, гурван хоног хөдөлж чадахгүй байсан гэлээ. Дараа нь Ваньгинь Чинсан Татарыг далимдуулж, шөнө дөлөөр шувтлан гараад, Татарын хөсөг тэрэг, үхэр хонийг булаан дээрэмджээ. Татарчууд ялагдаж, ухран явсанд Алтан улсын жанжин Ваньгинь Аньго, Мэгүжин сүүлтийг нэхэж Улз гол24 хэмээх газар зүг ирсэн байв. “Нууц товчоон”-ы 132

дугаар зүйлд даруй эндээс эхэлж дурдсан.

Чингис хаан энэ чимээг сонсоод, Хэрэйд аймгийн Тоорил ханд элч илгээж, Татарчууд бол манай өвгөс эцэгсийг алсан өшөөтөн дайсан болох юм. Одоо Татарын Мэгүжин Сүүлт Алтан улсын цэрэгт дийлэгдэн баруунш дутааж, Улз өөд ирж байна гэлээ. Бид өшөө авах цаг болов. Тоорил хан эцэг цэрэг гарган хавсрах болов уу гэж хэлүүлжээ. Үүнийг нь Тоорил хан бас зөвшөөрч, өөрийн цэргээ цуглуулан, гуравдугаар өдөр дээрээ хааныг угтан хүрч иржээ. Ингээд Чингис хаан болон Тоорил ханаас Сача бэхи, Тайчу түрүүтэн Жүрхин нарт элч илгээж цэрэг хавсрахыг шаарджээ. Гэтэл зургаан өдөр хүлээсэн боловч Жүрхин нар ер ирсэнгүй юм.

Дараа нь Чингис хаан ба Тоорил ханы цэрэг Алтан улсын жанжин Ваньгинь Аньго-гийн цэрэгтэй хамтран, Татар аймаг лугаа байлдав. Энэ үед Татарын Мэгүжин Сүүлт Улз голын Хошуут Шүтээн, Нарт Шүтээн гэдэг газар²⁵ хороо бэхлэлт байгуулан хориглож байв.

Чингис хаан, Тоорил хан хоёул Татарчуудын бэхлэлтийг нь эвдэлж шувтлан ороод, Мэгүжин сүүлтийг барьж тэнд нь алсан бөгөөд мөнгөн өлгий, тана эрдэнийн чимэгт хөнжил зэргийг нь олзлон авчээ. Мөн Татарын хоргодож байсан Нарт Шүтээн гэдэг нутаг дээр гээгдэн орхигдсон алтан ээмэг дөрөвчтэй, булган дотортой торгон элгэвч өмссөн бяцхан хүүг манай цэрэг олж авсан тул Чингис хаан түүнийг Өгэлүн эхэд хүргэн өгчээ. Өгэлүн эх “Сайн хүний хөвгүүн ажгуу, язгуур сайт хүний ураг буй за, таван хөвгүүнийхээ дүү, зургадугаар хөвгүүнээ болгоё” гэж Шигихутуху гэсэн нэр өгч тэжээн асарчээ.

Шигихутуху бүх Монголыг нэгтгэхэд Чингис хаанд шударгаар зүтгэснээс дотоод есөн сайдынхи нь нэг болсон бөгөөд 1206 онд 88 гавьяатны арван зургадугаараар шагнагджээ. Тэр сахилга батыг чанга сахидаг, хэрэг явдлыг хянамгай шийдвэрлэдэг тул бүх улсын дээд заргач (шүүгч)-аар томилогджээ. “Тэр хэрэг шүүхдээ төв голч, ялтанд маш олон өршөөл халамжийг үзүүлсэн” бөгөөд ялтныг “сүрдэгдэл доор өчил өгч болохгүй”, “айж болохгүй, худал хэлж болохгүй” (“Судрын чуулган”) гэж шаарддаг гэлээ. 1214 онд Чингис хаан хоёрдугаар удаа Алтан улс лугаа байлдаж, Тунгуань боомтноо, Алтан улсын цэргийг дайлж Алтан улсын хаан Чжунду хот (одоогийн Бээжин)-оо орхин өмнөш дутаажээ. Чингис хаан Шигихутуху, Өнгүр, Архай Хасар гурвыг Чжунду хотын алтан, мөнгөн эд агуурсыг тоолуулахаар илгээжээ. Энэ үед Чжунду хотын сахигч Хада ноён алттай, хээтэй эд агуурсыг барьж утсанд:

“Урьд энэ Чжунду хот ба Чжунду-гийн эд юм Алтан хааныхи байв. Одоо Чжунду Чингис хааныхи болов. Чингис хааны эд агуурсыг чи яагаад далдуур хулгайлан авчирч өгч байна? Үүнийг би авахгүй” гэж Шигихутуху авсангүй гэнэ. Үүнийг Чингис хаан сонсч, “Чи их ёсыг сэтгэжээ” гэж сайшаажээ. Энэ бол “Нууц товчоон”-ы тэмдэглэл болно. Хэрэг дээрээ монгол цэрэг Чжунду хотыг эзэлсэн цаг бол 1215 оноо Чингис хаан Чжунду-г гуравдугаар удаа довтолсон үе болно. Чингис хаан Хорезм улсыг дайлахад Шигихутуху мөн явалцсан байв. Сүүлд нь Өгөөдэй хааны үед Чжуньчжоу мужийн их заргач байсан бөгөөд 1236 оны зургаан сард хятад өрхийг данслах явдлыг эрхэлж зуун арван түмэн өрхийг дансалжээ. Шигихутуху Өгөөдэй хааны үед үхсэн байна. Чжунтун-гийн хоёрдугаар он буюу 1261 онд Хутуху ноёны ордноор төв бичгийн мужийн яам болгов гэдэг. Үүнээс үзэхэд Шигихутуху-д үр үгүй мэт.

Чингис хаан Тоорил хан хоёр Татар аймгийг ялж, Мэгүжин Сүүлтийг алсан чимээг Ваньгинь чинсан сонсч, гавьяа зүтгэлээр нь цол шагнажээ. Чингис хаанд “Жүйтхури”²⁶ гэдэг цол

өргөмжилж, Тоорил ханд “Ван” цол өргөмжилжээ. Тоорил ханыг “Ван хан” гэсэн нь энэ үеэс эхэлжээ. Бас Алтан улсын хаандаа мэдүүлж, Чингист үүнээс их Чжао Тао Ши гэгч цолыг шагнана гэсэн гэлээ. Ингээд Алтан улсын цэрэг буцав. Энэ удаагийн байлдаан - Чингис хаан анх удаа Татар аймаг лугаа байлдсан байлдаан ч энэ мэт дууссан юм.

25. Жүрхин ба Чингис хааны тэмцэл

Жүрхиний тухай бид тус товчооны гуравдугаар бөлөгт танилцуулсан билээ. Жүрхин бол Чингис хааны төрөл овогтон болно. Чингисийн үед Сача бэхи, Тайчу хоёр Жүрхинийг тэргүүлж байв. Тэр 1181-1189 оны хооронд Жамуха-гаас салж, Тэмүжинийг дагаар ирсэн бөгөөд Тэмүжинийг 1189 онд анх удаа “Хамаг Монгол Улс”-ын хаан өргөмжлөхөд Сача бэхи нь язгууртны төлөөлөгчөөр оролцсон юм. “Арван гурван хүрээний байлдаан”-д эд мөн нэгэн хүрээнээр оролцов.

Чингис хаан болон Жүрхиний хооронд тэмцэлдээн үүссэн гол шалтгаан нь Жүрхин бол Хабул хааны ахмад хөвгүүн Охин Бархаг-ийн үр хойч болохоор Жүрхиний язгууртад Сача бэхи, Тайчу нар хэдийгээр Жамуха-д дургүйцэн Чингисийг дагаж байвч, биеэ дээр үетэн хэмээн өргөж, залуу хаан Чингисийг нэр төдий болгох гэсэн ба Чингис хаан овог аймгийн тусгаарлалыг эвдэж, бүх монгол аймгуудыг өөрийн зориг санаагаараа захирах гэсний хоорондохи зөрчлөөс болжээ. Нэг л үгээр хэлбэл, Монгол аймгуудыг нэгтгэнэ үү, бутаргана уу гэсэн асуудал болно. Бодтой шалтгаан нь ийм дөрвөн зүйлийн явдлаас үүсчээ.

Нэгд, Чингисийн буурч түшмэл Сэчэгүр27-ийг Жүрхин нар барьж занчив. Энэ учир бол “Арван гурван хүрээний байлдаан”-ы дараахан үүсчээ. Дээр дурдсан мэтээр тэр байлдааны дараа, Уругуд, Мангуд овогтон ба Хонхотаны Мүнлиг эцэг зэрэг хүмүүс Жамуха-гаас жигшиж, Чингис хааныг дагаар ирсэн тул Чингис хаан баярлаж Хасар, Отчигин, Бэлгүтэй зэрэг дүү нартайгаа Өгэлүн эхийн хамт, Сача бэхи, Тайчу түрүүтэй Жүрхин нартай нийлэн, “тус тус хөхөл тугтай хасагтаа цэгээ ачиж”, Ононы түн28-д хуримлан найралджээ. Найр дээр Чингис хаан, Өгэлүн эх, Хасар, Сача бэхи нарын дэс дараагаар нэжгээд хэм (архины хундага – хө.) цэгээ барьж, дараа нь Сача бэхи-гийн бага эх Эбэгэй29-д хэм барьжээ. Энэ явдалд найрт суулцсан Хорижин хатан, Хугурчин хатан30 хоёр, Эбэгэй-г хүндлээд биднийг хүндэлсэнгүй гэж уурлан, Чингис хааны буурч түшмэл Сэчэгүрийг сэжиглэж, хацрыг нь алгаджээ. Сэчэгүр занчигдаад “Есүхэй баатар, Нэгүн тайж үхсэн учраас ийн занчигдав” гэж дуу тавин уйлсан гэнэ.

Хоёрт, Бэлгүтэйн мөрийг цавчив. Мөн удаа Ононы шугуйд болсон хуримыг Чингисийн талаас Бэлгүтэй эрхлэж, хааны морийг барин зогсож байв. Жүрхин талаас Бүри Бөх эрхлэн засаж байв. Энэ Бүри бөх гэгч бол Хабул хааны гуравдугаар хөвгүүн Хутугту Мөнгүрийн хөвгүүн (Хабул хааны ахмад хөвгүүн Охин бархаг бол Сача бэхи-гийн өвөг эцэг, хоёрдугаар хөвгүүн Бартан баатар бол Чингисийн өвөг эцэг юм) болох тул Чингисээс дээр нэгэн үе болно. Хурим явагдаж байх үед Бүри бөхийн нэгэн дагалт Хатагин овогтон (энэ хүний нэрийг “Хатгибай” гэж Рашид л тэмдэглэж буй) Чингисийнхний нь морин уяанаас нэгэн цулбуур хулгайлж, Бэлгүтэйд баригдсан байв. Бүри бөх тэр хүнээ өмөөрөн Бэлгүтэй лүгээ хэрэлдэж, Бэлгүтэйн нүцгэн байсан мөрийг нь илдээр хага цавчив. Бэлгүтэй цусаа гоожуулан байхыг Чингис хаан модны сүүдэрт сууж байгаад олж үзсэн бөгөөд учрыг асуусанд, миний шарх дэмий хүндгүй, энэ учраас ах дүүгийн найрыг бүү эвдээрэй гэж Бэлгүтэй ятгасан боловч хаан машид

хилэнлэж, дагагсадын хамт модны салаа гишүүдийг хуга татах нь хуга татаж, айргийн бүлүүрийг сугачих нь сугачиж аваад хоёр этгээдээрээ ширүүн зодоон болж, Жүрхинийг дийлэн Хорижин, Хугурчин хоёр хатныг нь булааж авчээ. Дараа нь Сача бэхи элч илгээж найрамдая гэж гуйсанд хоёр хатныг нь буцаан өгөв гэдэг. Тиймээс Жүрхин нар өс зангидаж далдуур хорсч байв. Энэ хоёр учир бол “Арван гурван хүрээний байлдаан”-ы дараа, 1196 онд Татар аймагтай байлдахаас өмнө гарсан явдал болно.

Гуравт, Татар аймагтай байлдахад Жүрхин тусласангүй байв. 1196 онд Чингис хаан, Хэрэйдийн Ван хантай хамтран Алтан улсыг хавсарч өстөн Татар аймагтай анх байлдахад, Сача бэхи, Тайчу нарт элч илгээж, Жүрхин нарыг цэрэг авч хамтран байлдая гээд зургаан хоног хүлээсэн боловч Жүрхин нар ер ирсэнгүй тул Чингис, Ван хан хоёул хамтран байлджээ.

Дөрөвт, Жүрхин нар Чингис хааны ар тал (Агураг гэр)-ыг нь довтлов. Чингис хаан Татар аймаг лугаа байлдахаар цэрэг мордохдоо хөгшин зэмдэг, хүүхэд нялхас, агураг гэрээ Харилт нуур³¹ гэдэг газар үлдээжээ. Энэ үед Сачу бэхи, Тайчу түрүүтэй Жүрхин нар Чингис хааныг тусласангүй мөртөө завшааныг далимдуулж, Чингис хааны ар талыг нь довтолж, арван хүнийг алж, тавин хүний хувцас хунарыг нь тонон дээрэмдээд явсан байна. Чингис хаан энэхүү чимээг сонсч туйлаар хилэнлэн, Жүрхиний аливаа ёс бус явдлыг нь тоочин, одоо харин дайсантай хамтарч дайсан болов гэж Жүрхинийг дайлахаар морилов.

Жүрхин овогтон ба Чингис хааны хоорондохи тэмцэл бол энэ мэтээр “Арван гурван хүрээний байлдаан”-аас 1196 он болтолхи тав зургаан жилийн дотор явагдаж, улам улмаар гүнзгийрэн дайн байлдаан хийх хэмжээнд хүрчээ.

Сача бэхи, Тайчу түрүүтэй Жүрхин нар Хэрлэнгийн хөдөө арлын Долоон болдог³² гэсэн газар нутаглаж байхад Чингисийн цэрэг шувт дайран орж, ард иргэдийг нь ихээр талхидав. Сача бэхи, Тайчу хоёр эмс хүүхэд түрүүтэн цөөн хүмүүсээ авч дутаав. Чингисийн цэрэг хойноос нь нэхэж, 1197 оны өвөл Тэрсүд³³ гэдэг газар хүрч, Хэрэйдийн Ван ханы дүү Жаха Гомбу Цагаан Онгудын газар тэнэн явж байхыг сонсчээ. Түүнийг оруулж авахаар хүн томиллов. Энэ үед Жүрхин нар Далт Амсар³⁴ гэдэг газраар тархан нутаглаж байсан тул замыг нь хориглож, ирэх аргагүй байв. Ингээд Чингис хаан цэрэг томилж, Жаха Гомбу лугаа Жүрхинийг хавчин байлдаж дийлээд Сача бэхи, Тайчуг тэнд алжээ³⁵. Энэ үед Хэрэйдийн салбар Түмэн Түбэгэн, олон Тунгайд бутарсан иргэдээ авч Чингис хаанд даган нийлэв.

Чингис хаан, омогт Жүрхинийг доройтуулан, олон иргэдийг нь өмч болгон эзэлжээ³⁶. Гэвч Жүрхинийг бүрэн номхотгон авахад бас нэгэн саад байв. Энэ нь Бүри Бөх болно. Энэ Бүри Бөх бол дээр хэлсэнчлэн, Есүхэй баатарын нэг үеийн хүн болохоор үл барам, барилдахдаа Бартан баатарын хөвгүүдээс илүү хүчтэй бөгөөд Охин Бархагийн зоригт хөвгүүн лүгээ нөхөрлөж явдаг, улсын бөх гэсэн алдартай учраас “бөх” гэсэн цолтой юм.

Чингис хаан нэгэн өдөр Бүри бөх, Бэлгүтэй хоёрыг барилдуулжээ. Чухамдаа Бүри бөх Бэлгүтэйг өрөөсөн гараараа барьж, өрөөсөн хөлөөрөө ташиж унагаагаад хөдөлгөлгүй дарж чаддаг юм. Гэтэл энэ өдөр Бүри Бөх Бэлгүтэйд унаж өгчээ. Энэ явдал түүх шастирт шүүмжлэгдээгүй билээ. Бодоход Жүрхин овогтны хувь заяатай холбогдсон гэхэд дэмий буруугүй биз. Ингээд Бэлгүтэй Чингис хааны дохиогоор Бүри бөхийн нурууг нь хугалан алж орхив.

26. Мухулай, Борухул лугаа нөхөрлөсөн нь

Чингис хаан Жүрхин аймгийн язгууртан Сача бэхи, Тайчу нарыг устгаж, ард иргэдийг нь хураан цуглуулсанд, түүний дотор Жалайр аймгийн Тэлэгэтү баяны хөвгүүн Хүн гуа, Чулуун, Хайчи, Жэбхэ гурав байв.

Жалайр аймаг бол “Монголын төв аймаг”-аас хойш буюу зүүн хойш шиг Онон мөрөн орчмоор нутаглаж, хүн амаар нэлээд олон байсан нэгэн аймаг болно. “Судрын чуулган”д түүнийг түрэг угсааны аймаг гэсэн бөгөөд Жалайр аймагт арван их салбартай, салбар бүрд цөм өөрийн ноёдтой гэжээ. Жалайр нь Монголын олон аймгийн дунд оршиж байсан болохоор Монголд хайлагдсан түрэг угсааны аймаг болов уу гэж зарим эрдэмтэн таамаглаж байсан юм. Жалайрын тухай ийм нэгэн домог байдаг:

Урьд Чингис хааны наймдугаар үеийн өвөг Хачи Хүлүгү-гийн бэлэвсэн гэргий Номулун гэгч долоон хөвгүүнтэй³⁷, тоо томшгүй адуутай, боол эзэмшигч баян айл байжээ. Нэгэн удаа Хэрлэн орчмоор нутаглаж байсан Жалайр аймаг нь Хятан цэрэгт ялагдаж, Номулуны нутагт ухран ирж байжээ. Ингээд Номулун зургаан хөвгүүнээ авч, Жалайр аймаг лугаа ширүүн тулалдаан хийсэн юм гэнэ. Энэ тулалдаанд Номулун ба зургаан хөвгүүн нь бүр алагдаж, айл гэр нь мөхжээ. Гагц долдугаар хөвгүүн Начин баатар гэгч нь Баргужин аймагт хүргэн сууж байсан болохоор аюулаас хэлтэрсэн бөгөөд ахмад ач хөвгүүн Хайду нь нялх байсан учраас хөхүүлж байсан эх нь нууж гаргасан юм гэнэ. Хожим Хайду их болоод олон харьяаттай болсон тул Жалайр аймгийг байлдан дагуулж, үеийн үе боол зарц болгожээ. Тиймээс Жалайр аймаг нь хожимдоо хэдийгээр баян эрхэм болж, Мухулай мэтийн олон арвин жанжин түшмэлтэй болсон боловч, ер Боржигин овогтон лугаа ураглаж болдоггүй нь ийм ёстой гэдэг билээ. Жалайр аймаг нь арван салбар овог төрөлтэй³⁸ гэдэг бөгөөд энэ Тэлэгэтү баян бол жад Жалайр овогтон гэдэг билээ. Тэлэгэтү баяны их хөвгүүн Хүн гуа өөрийн хоёр хөвгүүн Мухулай,

Буха гэгчийг дагуулан авчирч:

“Босгын чинь боол болтугай,

Босгоос чинь булзваас,

Борвийг нь огтло.

Үүдний чинь эмчү (өмч) боол болтугай.

Үүднээс чинь гийлбээс (оргон зайлах - хө.),

Элгэдийг нь этгэж гээд хүн”

гэж хэлээд хөвгүүнээ Чингис хаанд тушаан өгчээ.

Тэлэгэтү баяны хоёрдугаар хөвгүүн Чулуун Хайчи бас өөрийн хоёр хөвгүүн Түнгэ Хаши гэгчээ дагуулан авчирч:

“Алтан босго сахиж атугай хэмээн өгөв би,

Алтан босгоос чинь ангид одвоос,

Амийг нь тасалж гээдхүн.

Өргөн үүдийг өргөж өгтүгэй хэмээн өгөв би,

Өргөн үүдээс чинь өөр одвоос,

Өрийг нь мятарч гээгтүн”

гэж хэлээд хөвгүүнээ Чингис хаанд тушаан өгчээ.

Чингис хаан Мухулай лугаа нөхөрлөсөн учир ийм билээ. Энэ үе бол Жүрхиний Сача бэхи, Тайчу нарыг мөхөөсөн тэр жил – 1197 оны өвөл байх ёстой.

Мухулай бол Жалайрын Хүн гуа-гийн гуравдугаар хөвгүүн, цагаан барс жил буюу 1170 онд төржээ. Чингисийг дагаар ирэхэд хорин найман настай байв. Биеийн өндөр нь долоон тохой, төрсөн зүс харавтар, битүү хар сахалтай, даруу шулуун, үнэхээр шударга, баатар эрэлхэг, арга бодлогоор мэргэн, харваж намнахдаа гайхамшиг гэсэн алдартай юм. Тэр Чингисийг дагаар ирснээс нааш бүх Монголыг нэгтгэх байлдаанд гарамгайгаар оролцсоноороо хожим нь Чингисийн дөрвөн хүлгийн нэг, Хаант Монгол Улсын их жанжин болж, 1206 онд нэгдүгээр мянганы ноён ба Чингисийн гурван түмний зүүн гарын түмний ноёноор томилогджээ. Алтан улсыг дайлах үед Мухулай, Чингис хааны гол замын цэргийг дагалдан, Шаньдун мужийг гавшгайлан дайрч, хандсан зүг дайсангүй байв. Сүүлд нь 1214 оноос ганцаараа цэрэг захирч, Ляодун, Ляоси өөд довтлон, Алтан улсын умард нийслэл ба зүүн нийслэлийг урьд хожид эзлэн авчээ. Хаант Монгол Улсын арван хоёрдугаар он (1217 он)-д тайш, улсын ван (Го Ун - “Нууц товчоон”-д 1206 онд өргөмжлөгдсөнөөр тэмдэглэгдсэн нь өөр тэмдэглэлүүдтэй нэлээд зөрөх юм), мужийн захирагчаар өргөмжлөгдөж, Тайханшань уулаас өмнөш орныг дайлах үүрэг, тухайлбал Хаант Монгол Улсаас Алтан улсыг дайлсан хоёрдугаар шатны дайралдааны үүргийг хариуцан, Хэбэй, Хэдун (одоогийн Шаньси муж), Шаньдун зэрэг газрыг дараа дараагаар эзлэн авчээ. Тавин дөрвөн настайдаа 1223 оны гуравдугаар сард Шаньси мужийн Вэньси сянь-ий газар өвчнөөр нас баржээ. Тэр үед Чингис хаан Хорезмд дайлж байхдаа энэхүү мэдээг сонсч туйлаар гашуудсан бөгөөд Мухулайн хөвгүүн Бору-г зүүнш буцааж Мухулайн орыг залгамжлуулжээ. Тэлэгэтү баяны нөгөө нэг хөвгүүн Жэбхэ-г Чингисийн дүү Хасарт харьяалуулсан билээ.

Бас Жүрхиний нутгаас Жэбхэ-гийн олж авсан Борухул нэрт хөвгүүнийг Өгэлүн эхэд өгөв. Өгэлүн эхийн “өдөр үзэх нүд, шөнө сонсох чих” болгон асарсан өнчин дөрвөн хөвгүүн (Мэргидийн нутгаас олж авсан Хүчү, Тайчигуд, Бэсүдын нутгаас олж авсан Хөхэчү, Татарын нутгаас олж авсан Шигихутуху)-ий нэг нь даруй энэ Борухул болно.

Борухул бол Жүрхиний харьяат Үгүшин овгийн хүн мөн. Тэр Өгэлүн эхийн хайр халамжаар өсч, Чингисийн их үйлст шударгаар зүтгэж, эс явсан аянгүй, эс хийсэн байлдаангүй учраас Чингисийн дотоод есөн сайдын нэг нь ба Мухулай, Боорчу, Чулуун лугаа нэр зэрэгцэн дөрвөн

хүлгийнх нь нэг нь байжээ. 1206 онд Мянганы ноёноор томилогдов. Бас түүгээр буурч, түгээгч зэрэг ажлыг хариуцуулжээ. Сүүлд нь Хорь Түмэдийн бослогыг дарангуйлах байлдаанд алагдав. Түмэдийг дарсан хойно, Чингис хаан зуун өрх Түмэдийг Борухулын гэр бүлд боол болгон өгчээ. Борухулд хоёр хөвгүүнтэй, ахмадыг нь жаран нэгдүгээр мянганы ноён Тохун мөн бололтой гэж Ли Цзэ Фэнь авгай үзжээ. Хоёрдугаар нь Тачар гэдэг. Энэхүү зуун өрх Түмэдүүдийг Тачар авч өмнөш шилжин, Гуаньшань ууланд²⁹ нутаглажээ. Ингээд энэхүү зуун өрх түмэд нь сүүлчийн үеийн Хөх хотын Түмэдийн дээдэс болов гэдэг билээ. Хэлэлгээнгүй тэдгээр нь урт хугацаанаа Онгуд аймаг лугаа нэгсэн, сүүлээр нь Түмэд болон салбарласан байх ёстой.

27. Ван хан “Хоёр толгойт морь унасан” ба Чингис хаан үнэнчээр дэмжсэн нь

1178 оноо Тэмүжин Хэрэйдийн Ван хантай холбоолж, 1179 онд Мэргидийг сөнөөснөөс 1196 онд Татар аймаг лугаа байлдах хүртэлх арван найм, есөн жилийн хугацаа бол Ван хан, Чингис хаан хоёрын харьцааны эхэн үе - харилцан туслалцсан үе болно. 1196 оноос 1202 он болтолхи зургаа, долоон жилийн хугацаа бол Ван хан, Чингис хаан хоёрын харьцааны дунд үе - Ван хан “хоёр толгойт морь унасан” ба Чингис хаан үнэнчээр дэмжсэн үе болно. 1202 оноос хойш бол дайсагнасан үе болно. Тус хэсэгт энэхүү дунд үеийг нь тэмдэглэв.

Ван хан тэнэн явсан ба Чингис хаан тусалсан нь

Бид тус товчооны гуравдугаар бүлэгт Ван ханыг танилцуулахад, түүний нэгэн дүү Эрх хар гэгч нь ах Ван хандаа алагдахаас айж, зэргэлдээ Найман аймгийн Инанча ханд дагаар очив гэж тэмдэглэсэн билээ. Эрх Хар чухам хэдийд Найманд очсон тухай түүх сударт бодтой тэмдэглэл харагддаггүй. Гэвч түүний буцаж ирсэн цаг нь тодорхой тэмдэглэлтэй билээ.

1196 онд Ван хан Тэмүжиний урилгаар зүүнш цэрэг мордож, Татарын Мэгүжин Сүүлт лүгээ байлджээ. Энэ хооронд Найманы хан Инанча билгэ, Хэрэйдийн нутагт цэрэггүй байсныг далимдуулж, Ван ханы дүү Эрх харыг цэргээр хүргэн, Хэрэйдийг нь эзлүүлжээ. Дэмий удсангүй, Ван хан Чингис хаантай хамтран Татарыг мөхөөж, Алтан улсаас ван цол олоод Агураг нутаг Хэрэйддээ буцаж ирэхэд яг Найманы Инанча хан болон дүү Эрх Хартайгаа тааралдаж, нэгэн зэрэг ширүүн байлдаан хийж, Ван хан бүх цэрэг морио устгагдаж, Хар Хятан зүг дутаажээ⁴⁰. Түүний дутаасан цаг нь бараг 1196 оны долоо, найман сарын хооронд байсан бололтой.

Тэрхүү омог сүр ихтэй Ван хан цөөн хэдэн хүнээ авч, гурван хот дамжин тэнэж, Хар Хятаны эзэн Гүр хан⁴¹-д очив. Удалгүй бас эв тасран урван одож, Уйгур, Тангудын олон хот балгасаар хэсүүчлэн явж, зам зуур хоол хүнс тасарч, таван ямаа сааж, тэмээний цусыг ханаж идсээр 1198 оны намар арай гэж Гүсэгүр нуурт⁴² хүрч ирэн, Чингис хаанд мэдээ хүргэжээ. Чингис хаан, урьд эцэг Есүхэй баатар лугаа анд барилдсаныг нь бодож, Тахай баатар, Сүхэгэйжэгүн хоёрыг элч болгон Ван ханыг угтуулж, өөрөө Хэрлэнгийн эхнээс биеэрээ тосч аваад, өлсч даарч ирэв гэж харьяат иргэдээсээ гувчуур татаж тэжээсэн бөгөөд “урьд дагаар ирсэн Хэрэйдийн иргэдийг буцаан өгчээ” (“Ту Цзи-гийн тэмдэглэл”). Дараа нь Туулын Хуба хаяа⁴³ гэдэг газар хурж эцэг хөвгүүний ёсоор андгайлалцсан явдлаа дахин дурдалцав.

Ван хан Мэргидийн олзыг ганцаараа залгисан нь

1198 оны намар, Чингис хаан Харасу бургас гэдэг газраар дайрч, Хатиглаг нурууны Мөрүчэ сэгүл⁴⁴ гэдэг газар Удуйд Мэргидийн Тогтуга бэхи лүгээ байлдаж, Тогтуга бэхи-г Баргужин Төхөмийн зүг хөөж, Мэргид иргэдийг эзлэн, адуу мал, орд гэр, хүнс тариаг нь хүртэл цөмийг авч Ван ханд өгсөн байна (“Нууц товчоон”-ы 177 дугаар зүйл). Ингээд Ван ханы хүч дахин дэгжрэв.

Мөн энэ жил (1198 он)⁴⁵, Ван хан, Чингис хаантай зөвлөсөнгүйгээр ганцаараа өөрийн цэргээ авч Мэргидийн үлдэгдлийг Буур хээрт дайрч, Тогтуга бэхи-г Баргужин Төхөм өөд үлдэн хөөж, түүний их хөвгүүн Төгс бэхи-г алж, Тогтуга бэхи-гийн Хутугтай, Чагарун гэдэг хоёр охин⁴⁶ ба хатдыг нь олзлон авч, Тогтуга бэхи-гийн бяцхан хөвгүүн Худу, Чулуун хоёрыг харьяатынхи нь хамт эзлэн их олз олсон боловч, энэ олзоос Чингис хаанд өчүүхэн төдий ч өгсөнгүй (“Нууц товчоон”-ы 157 дугаар зүйл).

Ван хан байлдааны талбайгаас шөнөөр дутааж,

ганцаар байлдан дийлэгдсэнд Чингис хаан

цэрэг томилон тусласан нь

Шарагчин хонин жил буюу 1199 онд Чингис хаан гучин найман настай байв. Чингис хаан, Ван хантай хамтран умард Найман аймаг лугаа байлдав. Энэ бол Чингис хаан Наймантай байлдсан нэгдүгээр удаагийн байлдаан болно.

Найман аймаг бол Монголын эл аймгийн дотор хүн амаар хамгийн олон нэгэн аймаг болно. Тэр нь уулдаа Кэм мөрний эхээр нутаглаж байжээ. Дараа нь аравдугаар зууны үеэр өмнөш нүүж, Алтай, Хангай хоёр нурууны хоорондхи Түрэгийн хуучин газраар нутаглалаа гэдэг юм. Тэд зүүншээ Хэрэйд, барууншаа Уйгур, умаршаа Ойрад аймагтай зах нийлэн суудаг бөгөөд өмнөшөө их говийг алсалж Онгуд, Тангудтай бараа бараагаа үзэлцдэг билээ.

Найманыг “Чо Гэн Лу” гэдэг бичигт “Эрээн нүдтэн”⁴⁷-ий харьяанд тооцжээ. Энэ нь арай зохисгүй, “эрээн нүдтэн” гэж Сартуулынхыг хэлдэг. “Ту Цзи-гийн тэмдэглэл” ба “Чингис хааны шүүмжлэл шастир”, “Юань улсын түүхийн тухай яриа” зэрэгт харин түрэг угсааны аймаг гэжээ. Гэтэл Б.Я.Владимирцов монгол угсаатан гэжээ. “Найман” гэдэг үг бол түрэг, монгол хэлэнд бүр адил утгатай тооны нэр юм. Найман нар 1204 онд Монголд жинхэнээр нэгэнтээ орохоос хол өмнө монгол аймгуудтай нягт харьцаатай байсан бөгөөд монгол хэлээр хэлэлцэж байсан нь ч тодорхой юм. Тиймээс энэ үед түүнийг монгол хэлтэн аймгаар тооцох нь зүйтэй билээ. Найман нь арван нэгдүгээр зууны үеэс несторианы Христосын шашныг шүтсэн байна. Найманчууд гол төлөв мал аж ахуйг эрхэлдэг боловч зарим газарт нь тариалан аж ахуйг эрхэлдэг юм. Соёлын талаар Монголын нүүдэлчин аймгуудын дотор хамгийн өндөр байжээ. Энэ нь голдуу нэлээд их хөгжсөн Түрэгийн соёлыг ихээхэн шингээн авснаас болсон юм. Ялангуяа уйгур үндэстнээр дамжиж (зарим эрдэмтэн Согдоос шууд авсан гэдэг) эртний согд үсгийг монгол төрлийн хэлтний дотор хамгийн тэргүүнд хэрэглэсний нэг нь мөн Найман аймаг байсан юм. Нийгмийн талаар ангийн ялгаа тодорхой байж, Найманы эрхтэн, мэдэлтэн нар уйгур бичээч хэрэглэдэг байв. Арван хоёрдугаар зууны сүүлчээр (бараг 1197 он болов уу гэж Ту Цзи жишжээ), Инанча үхсэн хойно, түүний ахмад хөвгүүн Тайбуха гэгч Найманы хан орыг залгамжилж, мөн “Таян хан”⁴⁸ гэдэг. Энэ үед түүний дүү Хүчүгүд гэгч

эцгийн татвар хаган Гүрбэсү гэгчийг ахтайгаа булаалдан (хэрэг дээрээ эрх булаалдсан явдал болно) дийлэгдэж, Найманы умард хэсгийг хэсэглэн захирч, биеэ “Буйруг хан” гэдэг байжээ.

Энэ удаа Чингис хаан болон Ван ханы цэрэг умард Найман (одоогийн Монгол улсын Ховд аймгаас ойр байжээ)-ы түрүү Хүчүгүд Буйруг ханыг Улуг тагийн Сохог усун гэдэг газар дайрчээ. Буйруг хан бэлтгэлгүй байсан тул эсэргүүцэж чадсангүйгээр Алтай нурууг давж баруунш дутаав. Чингисийн цэрэг Буйруг ханыг нэхэж Хоншингирын Өрөнгү уруу хөөж явав. Тэндээс тэдний харуулын цэргийн ноён Яди Товлог гэгчийг барьж авсан бөгөөд цаашид нэгэн Кызылбаш нуурт хүрч Буйруг ханыг гүйцэн авч байлдав. Буйруг хан дийлэгдэж, Кэм Кэм чжоу⁴⁹ өөд дутаажээ. Энэ бол Чингис хаан нэгдүгээр удаа Найман лугаа байлдсаны түрүү шаг үе болно.

Тус оны өвөл, Чингис хаан болон Ван ханы цэрэг буцаж ирэхэд, өмнөд Найманы Көксэгү Сабраг (Инанча-гийн үеийн эрэлхэг жанжин) гэгч Байдраг бэлчирт цэрэг засан байлдахаар тосон хүлээж байжээ. Ван хан болон Чингис хааны цэрэг урьд хожид хүрч ирээд байлдахаар бэлтгэсэн боловч нэгэнтээ үдэш болсон тул, маргааш байлдаж гэж цэргээ засаж хонов.

Гэтэл, Ван хан тэр шөнөдөө буусан газартаа гал түлж орхиод, Хар сүүл голыг өгсөн дутаасан байна. Тэр шөнө Жамуха бас Ван хан лугаа хамт хөдөлж явсан бөгөөд “Тэмүжин анд миний урьдаас Найманд элчит (харьцаатай) бөлгөө, өдгөө эс ирсэн биш үү” гэж цуурхал тавьж, хутган завсардуулав. Энэ нь хэрэг дээрээ Жамуха, Ван хан нар сүлбээлдэж, Чингис хааныг хүчирхэг дайсны өмнө орхиод, дайсны хүчээр устгуулах гэсэн оролдлого болох нь илэрхий билээ.

Дараа өглөө нь Чингис хаан босоод үзсэнд Ван ханы буусан газар нь хов хоосон болсон тул, “Эд чинь биднийг түшлэн (хорлох) ажгуу” (биднийг энэ орхисон гал мэт хаясан ажгуу - Ц.Дамдинсүрэн) гээд бас тэндээс хөдөлж, Эдэр Алтайн бэлчир⁵⁰-ээр гэтэлж, Саарь хээрт очиж цэрэг буужээ. Чингис хаан нэгэнтээ Найманы цэргийн байдлыг мэдсэн болохоор, тэр нь дэмий сүрдүүлэлгүй байв.

Энэ бол Чингис хаан нэгдүгээр удаа Найман лугаа байлдсаны хоёрдугаар шаг үе болно.

Энэ үед Ван хан нэгэнт Туул голын нутагтаа буцаж ирсэн байв. Гэтэл Ван ханы хөвгүүн Нилха Сэнгүм болон дүү Жаха Гомбу нар ар талын ачаа хөсгөө аван аажмаар явж, мөн Эдэр Алтайн ой шугуй, ус голтой хавцал газар хүрч ирсэнд, Найманы Көксэгү Сабраг сүүлдэн нэхэж ирээд эмс хүүхэд, эд хөрөнгө, өрх иргэдийг нь цөм булаан авсан тул, Нилха Сэнгүм болон Жаха Гомбу хоёул ганц биеэрээ дугаан гарч, Ван ханд мэдээ хүргэтэл, Көксэгү Сабраг бас Ван ханыг Тэлэгэтү Амсарт нэхэн хүрч ирээд албат иргэд, адуу мал, амуу хүнсийг нь булаан аваад буцжээ. Энэхүү бутралдаж бүхий ташрамыг завшин, урьд Ван ханы дайлан дагуулсан Мэргидийн Тогтуга бэхи-гийн хөвгүүн Худу, Чулуун хоёр албат иргэдээ авч дугаан гарч, Сэлэнгэ мөрнөөр дамжин Баргужин төхөмд хүрэн эцэгтээ нийлсэн байна.

Ван хан энэ мэт дийлэгдэж, нэг талаар өөрийн гол цэргээ хөвгүүн Нилха Сэнгүмээрээ захируулж, дигихури тушаалт жанжин Идүргэн ба Баргудайн Жамдау нарыг томилж Көксэгү Сабрагийн цэргийг нэхүүлсэн бөгөөд нөгөө талаар Чингис хаанд элч томилж: “Найманаа өрх иргэдээ, эм хөвгүүдээ дагуулагдав (булаагдав) би, хөвгүүн (Чингисийг хэлж буй - эшлэгч)-ээс

дөрвөн хүлгийг чинь гуйж илгээв би. Иргэд өрхийг минь аварч өгтүгэй” гэж хэлүүлжээ.

Чингис хаан энэ чимээг олж авмагц цэрэг засан, Боорчу, Мухулай нараар 51 их цэрэг дайчлуулан Ван ханыг туслахаар илгээв. Энэ үед Нилха Сэнгүмийн цэрэг урьдаар Көксэгү Сабрагийг нэхэн хүрч Улаан худ 52 гэдэг газар байлдан, Жамдау нь баригдаж, Нилха Сэнгүм мориныхоо гуяыг шархдуулж баригдахад хүрч байтал, Чингисийн жанжин Боорчу, Мухулай нар хүрч, Нилха Сэнгүмийг авран гаргасан бөгөөд өрх иргэд, эмс хүүхэд бүгдийг нь аварч өгөв.

Ван хан, Чингис хааны ачид талархан, бас элч томилж: “Эрт сайн эцэг чинь, энэ мэт одон барсан (бутарсан) улсыг минь аварч өгөв, өдгөө хөвгүүн минь, одон барсан улсыг минь дөрвөн хүлгүүдээ илгээж аварч өгөв. Ач хариулахыг тэнгэр газрын ивээл мэдтүгэй” гэж хэлүүлсэн бөгөөд Туул голын Жоргал гуны Улаан нуга болдог гэдэг газар андгайлалаа бас нэгэн удаа давталцав.

Энэ бол Чингис хаан нэгдүгээр удаа Найман лугаа байлдсаны сүүлчийн шат үе - Ван ханыг авран тусалсан үе болно. Энэ өвөл (1199 он), Мэргидийн Тогтуга бэхи Баргужин төхөмөөсөө гарч, Тунгалаг нуурт 53 ирээд Тайчигуд нартай сүлбээлдэн, Чингис хааныг халдахаар тогтолцов. Чингис хаан энэхүү чимээг сонсч, дайлалдах явдлыг дүү Хасартайгаа зөвлөжээ.

Ван хан, Чингис хаан хоёрын эцсийн хамтралт

Цагаан бичин жил буюу 1200 оны хавар, Чингис хаан гучин есөн настайдаа Хэрэйдийн Ван хантай Саарь Хээрт нийлэлдэж, Тайчигудтай байлдахаар мориллов. Тэд Бурхан Халдуныг дайран, шууд Онон мөрний элсэнд хүрчээ. Энэ бол тус удаагийн байлдааны явагдсан газар болно.

Байлдааны нөгөө талын гол гол хүмүүс гэвэл, Тайчигудын түрүү Хотун Өрчэн, Агучу баатар, Хорилар баатар, Хутугудар, Таргутаи Хирилтуг нар ба Мэргидийн түрүү Тогтуга бэхи нар болно. Тэд харилцан сүлбээлдэж, Чингис хааныг довтолохоор бэлтгэж байжээ. Гэвч Чингис хаан энэ чимээг эртээс мэдэж, Ван хантай холбоолон урьдаар гар хөдөлгөсөн нь энэ билээ.

Байлдаан эхэлмэгц Чингис хааны их цэрэг ширүүнээр дайран орсонд, дайсан эсэргүүцэж чадсангүй дутаасан тул, хойноос нь нэхэж, Онгуд Тулас 54 гэдэг газар хүрч, Хутугударыг барьж алжээ. Агучу баатар, Хотун Өрчэн нар Баргужин төхөм өөд, Хорилар найман өөд тус тус дутаав.

Энэ үед Татар, Хонгирадын хооронд ч харьяалагдалгүйгээр Алтан улсын хилээр байн дахин халддаг байсан Хатагин, Салжигуд хоёр аймаг, Тайчигуд нарын ялагдсан чимээг сонсоод тэд бас дэвжээн болжээ. Энэ хоёр аймаг урьд Жамуха, Тайчигудтай хамт Чингис хааныг довтолж байсныг тус бүлгийн “Арван гурван хүрээний байлдаан”-ы хэсэгт дурдсан билээ. Одоо Хатагины түрүү Баху Чурги, Салжигудын түрүү Чиргидай баатар ба Дөрвөний түрүү Хажигун бэхи, Татарын түрүү Алчи, Жалин Буха (Дамдинсүрэн “Жали буха” гэжээ), Ихирэсийн түрүү Түгэ Маха, Хонгирадын түрүү Тэрэг, Эмэл, Алхуй, Горлосын түрүү Чунаг, Цагаан (энд Элдэндэй, Баяр нарын галиглалыг баримтлав. Дорнотив “Чунаг Цахан”, Дамдинсүрэн “Цоос-цагаан” гэсэн нэг хүнээр тус тус тэмдэглэжээ. Бас “Нууц товчоон”-ы

182 дугаар зүйлд “Чугус Цагаан” гэдэг), Найманы Буйруг хан Хүчүгүд, Мэргидийн түрүү Тогтуга бэхи-гийн хөвгүүн Худу, Ойрадын түрүү Хутуга бэхи, Тайчигудын түрүү Таргутаи Хирилтуг, Ходун Өрчэн, Агучу баатар зэрэг монгол үндэстний нэгдэл ба Монголын нийгмийн феодалжлыг эсэргүүцэгч арван нэгэн аймгийн тэрслүү хэвшмэл язгууртад Алхуй булаг гэдэг газар цугларч, азарга гүүг цавчин алж, андгайлан тангараглаад бас Чингис хааныг халдаар ирэв⁵⁵.

Энэхүү бачим чимээг Чингис хааны хадам эцэг, Хонгирадын Дэй Сэцэн Чингис хаанд элч илгээж хэлж өгөв.

Чингис хаан, Ван хан хоёр цэрэг нийлж Хойт нуур⁵⁶ гэдэг газраас хөдөлж Буйр нуурт хүрэхэд Дэй сэцэн өөрийн цэргээ дагуулан ирж нийлэв. Ингээд дайсан аймгууд лугаа дараа дараагаар байлдаж, ихэд ялжээ.

1200 оны өвөл, Ван хан Чингис хаанаас салж, Хэрлэн голыг сөрөн баруунш явж Хуба хаяа-д буужээ. Чингисийн цэрэг зүүнш явж Чэгчэрийн ууланд буужээ.

28. Татартай хоёрдугаар удаа байлдсан нь

Чингис хаан 1200 оны өвөл Буйр нуурын орчим арван нэгэн аймгийн тэрслүү язгууртад лугаа байлдаж ялаад, зүүнш ирж Чэгчэрийн ууланд буусан тэр үед, Алагудур, Хадаан тайш, Чахугин, Төмөр нар түрүүтэй Цагаан, Дутагуд, Алчи, Алухай дөрвөн Татарчууд нийлэн, чуулган болж, Алагудурыг чуулган дарга (бас Гүр хан гэдэг)-аар сонгосон байна. Татарчууд бол эртнээс Тэмүжиний аймаг угсаагаар удирдуулсан Монголын бусад аймгуудтай дайсагнаж байсан бөгөөд 1196 онд Мэгүжин Сүүлт түрүүтэй Татарчууд устгагдсанаас нэн хорсолтой болжээ. Ингээд тэд бас дахин халдаар ирэв.

Чингис хааны цэрэг баруун хойноос нь довтолж, Далан Нөмөргөс гэдэг газар⁵⁷ ширүүн байлдаж, ихээр сөнөөв.

Энд тэмдэглүүштэй өөр нэгэн учир гэвэл, тэр үед Чингисийн дүү Хасар өөр нэгэн салаа цэргийг захирч бус газар байв. Тэр доорхи хүн Зэвээс Хонгирад урван явлаа гэдэг чимээг сонсч, хаан ахдаа мэдүүлсэнгүйгээр өөрийн цэргээ дагуулан очиж талхидсан гэлээ. Ингээд Хонгирад нь ёс бус талхидагдсандаа хорсч, үнэнхүү урван гараад Жамуха лугаа нийлжээ.

29. Тэниг горхиноо Жамухатай байлдсан нь

Цагаагчин тахиа жил буюу 1201 онд, Чингис хаан дөчин настай байв. Энэ онд Хонгирад, Ихирэс, Горлос, Дөрвөн, Татар, Хатагин, Салжигуд зэрэг аймгууд Эргүнэ голыг уруудан, Кан мөрний шанаа⁵⁸ Нагу нуга гэдэг газар хуралдаж, Жамуха-г “Гүр хан” (бүгдийн хаан) өргөмжлөв. Энэ бол Жамуха түрүүтэй эл аймгийн тэрслүү язгууртадын Чингис хааны бүх Монголыг нэгтгэх үйлсийг эсэргүүцсэн ажиллагаа болох бөгөөд аливаа тэрслүүчүүдийн баримталдаг мөхөхийн өмнөх тэлчлэлт болно.

Тэд, Жамуха-г “Гүр хан” өргөмжлөөд Талбар голын эрмэг дээр бүгдээрээ эргийг дэвсэн егүүрүүлж (нурааж – хө.), сэлэм эргүүлэн ой модыг цавчин, “Манай байгуулсан холбоог

илрүүлэх ийм хуйвалдагчид байваас эрэг мэт юүрч, ой мэт хядагдмуй” (“Биеэр дайлсан тэмдэглэл”) гэж андгайлал хийгээд Чингис хааныг довглохоор ирэв.

Энэ үед Чингис хааны харьяат Жэгүридэй (энэ бол Баярын галиглал, Ц.Дамдинсүрэн Жаурьдай гэжээ) овогтны Чугур гэгч тэдний энэхүү ов явууллагын живтэрээ (алдуул чимээ – хө.) олж мэдмэгц, Горлосын Хоридай гэгчтэй хоёул, Чингис хааныг Хүрэлхү гэдэг газар байхад морин давхиагаар ирж бачим мэдээ хүргэжээ⁵⁹.

Чингис хаан энэхүү бачим чимээг олоод, дайсныг гар хөдлөхөөс өмнө замд нь устгахаар шийдэж, өөрийн цэрэг морио аван Хүрэлхүгээс хөдөлж, Хэрлэн голыг уруудан зүүнш ирж, Хайларын Тэниг горхины талд дайсан лугаа золгодож, хоёр этгээдээрээ ширүүнээр байлдав. Энэ удаагийн байлдааныг “Тэниг горхины байлдаан” гэдэг.

Энэ удаагийн байлдааны дүнд Жамуха-гийн цэрэг дийлэгдэж, Жамуха зугатан дутаав. Хонгирад аймаг Чингис хааныг дагаж иржээ.

30. Татартай гуравдугаар удаа байлдаж мөхөөсөн нь

Хар нохой жил буюу 1202 оны намар, Чингис хаан өшөөтөн Татартай дахин байлдахаар шийдэв. Энэ удаа Татартай байлдсан нь гуравдугаар удаа болно. Байлдаан эхлэхээс өмнө, Чингис хаан өөрийн цэрэгтээ гурван зурвас цааз сахилгыг зарлажээ:

- (1) Дайсныг дарсан хойно, олзонд нь бүү хоргодон саат, байлдаан дууссан хойно хуваалцах хэрэгтэй.
- (2) Хэрвээ дийлэгдэн ухарвал, эхний довтолсон байртаа буцаж ирэх хэрэгтэй.
- (3) Өөрийн байртаа үл буцаж ирэгсэдийг алах ялаар шийтгэнэ.

Энэ үед Цагаан Татар, Алчи Татар, Дутагуд Татар, Алухай Татар зэрэг дөрвөн Татарууд Далан Нөмөргөст цэрэг цугларан байжээ. Чингис хаан цэргийн чанд зарлигаа тогтоож байлдааны бэлтгэлээ хийж дуусаад цэрэг үүсгэн Далан Нөмөргөсийг дайран довтолж, ширүүнээр байлдсан тул Татар нар дийлэгдэн дутаав. Чингис хааны цэрэг салшгүй нэхэн байлдаж, Улхуй Шилүгэлжид⁶⁰ гэдэг газар хүрч харгис түрүүг нь барьж, харьяат иргэдийг нь дагуулж, хамаг Татарыг мөхөөв.

Энэ удаагийн байлдаанд Алтан (Хотала хааны хөвгүүн), Хучар (Нэгүн тайжийн хөвгүүн), Даритай (Чингисийн авга) гурав байлдааны өмнө тогтоосон цаазыг зөрчиж, олзонд шунан байлдаанаас саатсан байв. Чингис хаан цэргийн цаазыг чанга биелүүлэхийн тулд Хубилай ноён нарыг⁶¹ томилж, эдний бүх олзолсон зүйлийг нь хураан авч олонд хуваан өгчээ. Тиймээс тэд гурвуул ч урван тэрслэх сэтгэлийг өвөрлөсөн билээ.

“Нууц товчоон”-ы тэмдэглэлийг үндэслэвэл, Татар аймгийг мөхөөсөн хойно, Чингис хаан сүрхий догшноор хариу авсан байна. Жишээлбэл, эрсийг нь тэргэн тэнхлэгийн цүүд хэмжээлж алаад, эмс хүүхдийг нь өрх бүрд боол болгон өглөө гэдэг. Энэ нь лавтайяа хэт өшөөлсөн явдал болох бөгөөд хэрцгий ажиллагаа болох тул буруушаагууштай юм. Гэвч тэр

үеийн Монголын нийгмийн ахуй байдал доор, Боржигид болон Татар нарын хооронд үе улиран зангидсан гүн хорслыг Чингис мэтийн түүхэн хүн ингэж шийдвэрлэсэн нь харин тэрхүү цаг үеийн байдлыг тусгажээ гэж үзэх хэрэгтэй. Түүх шастирыг ажиглаж байвал, ангит нийгэмд аливаа ноёрхогч этгээд буюу ялагч этгээд нь ноёрхогдогч этгээд буюу ялагдагч этгээддээ ерөөс өршөөлт засаг явуулах биш, харин дарангуйлах засаг явуулдаг юм.

Чингис хаан Татар аймгийг бүрмөсөн мөхөөснөөс Монголын зүүн хэсгийг бүрэн нэгтгэж, ар талаа бэхжүүлсэн бөгөөд байлдааны голдлогоо ч баруунш шилжүүлжээ.

31. Жамуха-гийн өдөөсөн “Хүйтэний байлдаан”

Энэ байлдааныг “Нууц товчоон”-д 1201 онд болсон “Тэниг горхины байлдаан” лугаа хамтруулан ганц “Хүйтэний байлдаан”-аар тэмдэглэжээ. Одоо бид “Биеэр дайлан тэмдэглэл” ба “Ту Цзи-гийн тэмдэглэл”, “Д`Оссоны Монголын түүх” зэргийг үндэслэж, ас асад нь (тус тусад нь – хө.) тэмдэглэв.

Энэ удаагийн гол байлдаан нь “Хүйтэн” гэдэг газар⁶² явагдсан болохоор “Хүйтэний байлдаан” гэдэг юм. Энэ удаагийн байлдаан нь хар нохой жил буюу 1202 оны намар, өвлийн үесээр явагджээ. Энэ үед Чингис хаан дөчин нэгэн настай байв.

Энэ удаагийн байлдааныг 1201 оноо “Тэниг горхины байлдаан”-д ялагдсан тэдгээр аймгууд, тухайлбал Найманы Буйруг хан, Мэргидийн Тогтуга бэхи-гийн хөвгүүн Худу, Тайчигудын Агучу баатар, Ойрадын Хутуга бэхи болон Дөрвөн, Татарын үлдэгдэл⁶³, Хатагин, Салжигуд зэрэг аймгууд мөн Жамуха-гийн өдөлтөөр Чингис хаан, Ван хан хоёрын зүг хөдөлжээ. Тиймээс энэ удаагийн байлдааны үүссэн шалтгаан нь ч илэрхий байна. Нэг л үгээр хэлбэл, Чингис хааны Монгол аймгуудыг нэгтгэх үйлсийг эсэргүүцэгчид мөхөн мөхтөлөө зүрх үхэхгүй байж, эцсийн нэг тэлчлэлт хийжээ. Энэ удаагийн байлдаан нь ийм шалтгаанаас үүссэн бөгөөд ийм шинжийг агуулж байна.

Чингис хаан дайсны цэргийн мэдээг олж авмагц Ван ханд мэдэгдэж, түүний цэргийг хүрч ирсэн хойно, хоёр цэрэг хамтарч, Хэрлэн голыг уруудан зүүнш ирж байлдав.

Энэ удаагийн байлдааныг гурван шатаар зохион тохируулсан байна. Их цэргийнхээ өмнө, манлай цэрэг буюу шувтлан дайрах ангийг байрлуулжээ. Чингисийн цэргээс Алтан, Хучар, Даритай гурвыг манлай ангиар томилжээ. Ван ханы цэргээс Нилха Сэнгүм, Жаха Гомбу, Билгэ бэхи гурвыг манлай ангиар томилжээ. Бас энэ манлай ангийнхаа өмнө суурин харуул буюу тагнан байцаах морьт харуулыг томилжээ. Энэ харуул нь бас гурван давхар харуул болно. Энэхэн Хүйлт гэдэг газар, түүний цаад Чэгчэр гэдэг газар, бас түүний цаад Чихургу гэдэг газар⁶⁴ тус тус нэгэн суурин харуул тавьжээ.

Чингисийн цэргийн манлай анги Алтан, Сэнгүм нар их цэргийн өмнө урагшилж, Удхи гэдэг газар хүрч, цэрэг бууя гэж байтал, Чихургу-д тавьсан харуулаас хүн давхин ирж, “дайсан ирлээ” гэсэн мэдээг хүргэж иржээ. Алтан нар чимээг олмогц дайснаас хэл авья гэж, буулгүйгээр цааш орж дайсан лугаа учран асуусанд, Тайчигудын Агучу баатар, Найманы Буйруг хан, Мэргидийн Тогтуга бэхи-гийн хөвгүүн Худу, Ойрадын Хутуга бэхи дөрвүүл Жамуха-гийн манлай ангиар явж байжээ. Тэд учралдаж, овгоо асуулцан, учир явдлаа

мэдэлцэж, өдөр нэгэнт орой болсон тул маргааш байлдая гэж байр байртаа буужээ65.

“Хүйтэний байлдаан”-ы хөшиг ингэж нээгдлээ. Энэ үед Чингис хаан ба Ван ханы их цэрэг Улхуй Шилүгэлжидэд ирээд байсан тул тэндээс Удхи зүг хөдөлж, Харагун жидүн-ий66 ойр буужээ. Дараа нь Ван ханы хөвгүүн Нилха Сэнгүмийн цэрэг умраас ирж, давааг барьж цэрэг буудаллав.

Чингисийн цэргийн энэ байдлыг умар Найманы Буйруг хан үзээд: “Чингисийн цэрэг тархай байх тул бид төвлөрөнгүй хүчээр устгахуйяа хялбар” гэж бардамнан хэлж, Агучу, Худу хоёрын цэргийг байлдуулахаар томилов. Гэтэл тэр хоёр Нилха Сэнгүмийн цэргийг холоос үзэж, халдашгүй их хүчтэй гэж айгаад ухран буцав.

Энэ үед Чингисийн цэрэг ар талын ачаа хөсгөө өөр газар шилжүүлж, Нилха Сэнгүмийн цэрэг давааг гэтэлж Удхи (“Монголын Нууц товчоон”-д “utkiya” гэж буй - хө.)-д байлдахаар бэлтгэв. Чингис хаан ба Ван ханы их цэрэг арын бэхлэлт (Кан мөрнөөс баруунш байдаг Бор хэрэмийн уул дээрх бэхлэлт)-ээр түшиг болгож цэргээ байрлуулжээ.

Энэ үед хүйтэн бороо цутгалж, догшин салхи салхилан, сүүлээр нь их цас шуурга болон хувирч, тэнгэр газар урван харангуйтаж, дайсны цэрэг шуурганы эсрэг хандаж чадахгүй байв67. Гэтэл Чингисийн их жанжин Урианханы Хорухун (Сүбээдэйн ах) гэгч дайсны эсрэг шуурга мэт сум харваж байлаа. Ингээд дайсны цэрэг “Тэнгэрт эс таалагдав бид” хэмээлдээд эсэргүүцэж чадалгүй Хүйтэний хээр өөд ухран явж, цэрэг морь нь хөлдөн, бутран тархаад цэрэг нь цэргийн янзгүй болов.

Энэ үед Жамуха цэргээ авч туслахаар ирсэн боловч, түүний хамсаатныхаа нэгэнтээ дийлэгдэн бутарсныг үзээд, байлдааны талбарт орсон ч үгүйгээр “Жамуха өөрөө хаан өргөгсөд иргэнийг дагуулаад (дээрэмдээд – хө.), Эргүнэ уруу харин хөдөлжээ”. Найманы Буйруг хан Алтайн өвөр Олуг тагийг зорин, Мэргидийн Тогтуга бэхи-гийн хөвгүүн Худу Сэлэнгийг зорин, Ойрадын Хутуга бэхи ой дамжин Шишгисийг зорин, Тайчигудын Агучу баатар Ононыг зорин тус тус хагацан дутаасан байна. Ван хан, Жамуха-г нэхэн боомт (Хөлөн Буйрын Бор хэрэмийн боомт)-оос гарав. Чингис хаан өөрийн Агучу баатарыг нэхэн мөн боомт (энэ боомт бол Амбан хотоос баруун хойш байх Чоно шавардах нуур орчмын хос бэхлэлт бололтой)-оос гарав.

Хүйтэний голын байлдаан ингээд дуусчээ.

32. Тайчигудыг дарсан ба Зэв лүгээ нөхөрлөсөн нь

Чингис хаан Тайчигудыг дарсан байлдаан нь Хүйтэний байлдааныг залгаад, 1202 оны өвөл явагджээ.

Тайчигудын түрүү Агучу баатар, Ходун Өрчэн нар Хүйтэний байлдаанаас Онон мөрөндөө дутаан ирж, үлдсэн дурстан (шилдэг) цэргүүдээ засаж, Ононы чанад талд байлдааны бэлтгэлийг хийж хүлээн байжээ. Чингисийн цэрэг мөн хүйтнээс нэхэн ирээд байлдаан эхэлсэн байв.

Энэ удаагийн байлдаан нь хоёр этгээд зууралдан маш ширүүн явагдсан бөгөөд нэлээд хэдэн хоног үргэлжилжээ. Энэ байлдаанд Чингис хаан хүзүүгээрээ шархдаж, цус нь зогсолгүй гоожиж байсанд, Чингисийн дотоод есөн сайд, дөрвөн хошуучийнхи нь нэг болох Урианхайн Зэлмэ амаараа шимж байгаад цусыг нь зогсоосон бөгөөд дайсны дотор амь цөлөн орж, тараг олж ирж уулгаад амийг нь аврав.

Хэдэн өдөр ширүүн байлдаад дайсны цэрэг дийлэгдэж, айл өрх ард иргэдээ орхиод шөнө дүлэн дутаасан байлаа.

Чингис хааны цэрэг Тайчигудыг нэхэн довтолж, Агучу баатар, Хотон Өрчэн, Хутугудар зэрэг Тайчигудын язгууртадыг ургийн ураг хүртэл үнэсээр хийсгэн хядав гэдэг.

Тайчигудын өөр нэгэн түрүү Таргутай Хирилтуг ой шугуй дотор ганцаараа дутааж бүхийд, Нүцгэн Багарины Ширгүгэтү өвгөн Алаг, Наяа гэдэг хоёр хөвгүүнтэйгээ хамт барьж аваад тэргэнд тээж, Чингист хүргээр ирсэн боловч, бид өөрийн эзнээ барьж хүргэвэл, Чингис хаан биднийг эзэндээ халдсан ард гэж үл итгэх нь лав гэж зөвлөлдөөд, Таргутай Хирилтуг-ийг зам зуураа тавьж явуулан, эцэг хөвгүүн гурвуулаа Чингис хааныг дагаар иржээ. Үүнийг нь Чингис хаан эзэндээ шударга хүн гэж сайшаан магтаж дотночлон нөхөрлөжээ.

Тайчигуд аймгийг энэ мэт мөхөөсөн билээ68.

Байлдааны дараа, дүрвэсэн ардыг хураан цуглуулж байхад, Чингисийн ачит хүн Сорхан шарын охин Хадааныг Чингис хаан биеэрээ очиж авран авав.

Дараа өдөр нь Тайчигудын Төдүгэ-гийн харьяат байсан Сорхан шар, Зэв хоёр хаанд нийлээр хүрч ирэв. Сорхан шар, Чингисийг бага залуу насны үед нь туслан нөхөрлөсөн бөгөөтөл, яагаад одоо сая хүрч ирсэн учрыг нь асуухын тул, Чингис хаан урьд Сорхан шарын тусалсан ач гавьяаг нь тоочин:

“Хүзүүн дэх

Хүнд модыг

Хөсөр огооруулсан

Зах дахи

Зарбиял модыг (дөнгө мод)

Зайлуулсан”

та эцгэс хөвгүүдийн тус ажээ. Та яахин удав та?” гэж магтан талархаж асуужээ. Үүнд Сорхан шар: “Би дотроо бэлэн итгэл сэтгэж болой. Яахин яарах би? Яарч урьд ирвээс Тайчигуд ноёд миний хоцорсон эм хөвгүүн адуу идээнийг минь үнсээр хийсгэхүүн тэд хэмээж үл яаран өдгөө хаандаа нийлэн үтэрч ирэв ба (би)” гэж хэлжээ. Үүнийг нь Чингис хаан зөв гэж зөвшөөрөв.

Дараа нь Чингис хаан Зэвээс: Тэр өдөр зууралдан байлдаж байхад уулан дээрээс миний дайчин ам цагаан хул морийн аман хүзүүг хэн хуга харвалаа? гэж өөрийн биеэ нэг дайчин агтаар далдлан асуужээ. Үүний хариуд Зэв: “Уулан дээрээс би харвалаа. Өдгөө хаанаа үхүүлбээс алганы төдий газар өгч хоцорсу. Соёрхогдвоос хааны өмнө

Цээл усыг огтолтол

Цэгээн чулууныг цууртал довтолж өгсү.

Хүр хэмээсэн газраа

Хүдэр чулууг хэмхэртэл довтолж өгсү”

гэж ам тангарагаа өгөв. Үүнд Чингис хаан маш биширч: Дайсан хүн дайсагнаж хорлосноо нуудаг атал, чи үнэнч шударгаар хэлсэн тул ийм хүнтэй нөхөрлөж болно гэж уулын Зургаадай нэрийг нь халж, “Дайчин ам цагаан хул морин”-ы аман хүзүүг зэвээр харвасны тул “Зэв” гэдэг нэр өгсөн бөгөөд миний дэргэд Зэв мэт хамгаалж яв гэж зарлиг болжээ. Зэв Тайчигудаас ирж нөхөрлөсөн ёс ийм билээ.

Зэв бол Бэсүд овгийн хүн юм, анхнаасаа Тайчигудын гарамгай жанжин бөгөөд мэргэн харвагч байжээ. Тэр Чингис хааныг дагаж нөхөрлөсөнөөс хойш олон удаагийн байлдаан тулалдаанд онц гарамгайгаар зүтгэсэн тул, Чингисийн есөн өрлөг, дөрвөн хошуучийнхи нь нэг нь болсон бөгөөд 1206 онд дөчин долдугаар мянганы ноёноор томилогджээ. Чингис хааны зургадугаар он (1211 он)-д Монголын их цэрэг Алтан улсыг дайлахад Зэв хошуучлан довтолж, Цавчаал боомтыг эвдлэн, Хэбэй мужид гүнзгийрч, эрэлхэг баатар, мэргэн харваачаараа алдаршжээ. Чингис хааны арван гуравдугаар он (1218 он)-д Зэвийн удирдсан цэрэг Найманы Хүчүлүг-ийг нэхэж устгаад, түүний булаан эзэлсэн хар Хятан улсыг охорхон хугацаанд эзлэн авав. Дараа жил нь Чингисийн цэрэг Дундад Ази өөд дайлахад, Зэвийн удирдсан цэрэг, Памирын өндөрлөгөөр хошуучлан орсон бөгөөд 1220 онд Чингисийн их цэрэг Самаркандыг эзэлсний дараа, Зэв, Сүбээдэй нарын удирдсан гурван түмэн цэрэг Хорезмын Султан хан Мухаммедийг нэхэн умарш довтолжээ. Тэд Каспийн тэнгисийн умарш нэвтрэн, Кавказын нурууг даван, Кипчакын эл газар довтолж, Калка голын хөвөөнд Орос Кипчакийн холбоот цэргийг сөнөөгөөд, Булгар аймаг өөд довтлов. 1224 оноо цэрэг буцах замдаа Ханлинь-ий нутагт өвчнөөр нас нөгчив гэдэг билээ.

33. Ван хан дайсагнасан ба Хэрэйдийг мөхөөсөн нь

Ван хан хэдийнээс “Хоёр толгойтой морь” унаж, өөрийн хүч нь доройтох үед Чингис хааныг “хөвгүүн” гээд түшиж ирдэг, өөрийн хүч нь бага л дэгжирвэл салан яваад астаа туг босгохоор зорьдог бөгөөд Чингис хаан, Жамуха хоёрын хооронд чуйвж байсан юм.

Ван хан, Чингис хааны эвдэрсэн шалтгаан ба бодтой явц

1202 оны өвөл, “Хүйтэний байлдаан”-ы дараа, Ван ханы цэрэг Жамуха-г нэхэж яваад Жамуха-г оруулан авч, Кэн мөрний шанаад бууж цэргээ цэгцэлсэн байна.

Чингис хаан мөн энэ өвөл Тайчигудыг дарсан хойно, цэргээ авч Кан мөрний шанаа орчим ирж, Аруг Хонгирад⁶⁹ гэсэн газар ордноо барьж өвөлжжээ.

Чингис хаан, Ван хантай улам ойр больё гэж, Ван ханы охин (Сэнгүмийн охин дүү) Чагур бэхи-г Жочи-д гуйж, өөрийн охин Хожин бэхи-г Сэнгүмийн хөвгүүн Тусахад өгье гэж дурдсан билээ.

Гэтэл Ван ханы хөвгүүн Нилха Сэнгүм “Өөрөө ихчлэн сэтгэж, биднийг доромжлон өгүүлж, Чагур бэхи-г үл өгөн эс таалжээ. Тэр үгэнд Чингис хаан дотроо Ван хан Нилха Сэнгүм хоёрт дур хоцорчугу (дур үгүй болжээ)” (“Нууц товчоон”-ы 165 дугаар зүйл).

Энэ бол Ван хан, Чингис хаан хоёрын эвдрэлцсэний өнгөн талын шалтгаан болно. Хэрэг дээрээ тэд хоёрын эвдрэлийг бол Ван ханы гуйвамтгай чанар шийдвэрлэж, Жамуха-гийн хувилдлага түргэтгэсэн юм. Энэ явдлыг Чингис хааны талаас авч үзэхүл, тэр хоёрын хамтралцсан хорин хэдэн жилийн дотор Чингис хаан, Ван ханаас эвдрэн салах ажиллагааг ер хийсэнгүй, харин Ван ханы гачигдлыг нь шийдвэрлэж, гуйвалтыг нь уучилж байсан билээ.

Ингээд Чингис хаан цэрэг шилжиж, Абжига Хөтэгэрт буужээ. Ван хан бас баруунш нүүж Жэжэгэр өндөрийн Жэр хавцгайд буужээ. Ван ханы хөвгүүн Сэнгүм Жэжэгэр өндөрийн ар бэл дэх Бэрх Элэдэд нүүв⁷⁰.

Ван хан, Жамуха нар хувилдаж, Чингис хааныг хорлох аргыг үүсгэсэн ба Бадай, Хишилиг хоёр Чингис хааныг тусласан нь

Харагчин гахай жил буюу 1203 оны хавар, Чингис хаан дөчин хоёр настай байлаа. Бүх Монголыг нэгтгэх үйлсийг дайсагнасаар ирсэн Жамуха нар, Чингис хаан болон Ван ханы эвдэрснийг мэдэж, Алтан Хучар болон Хардахидай, Өвөгжин, Ноёхины Хин⁷¹, Сүхэгэдэй, Тоорил, Хачигун бэхи нартай сүлбээлдэн нэгдэж, Ван ханы хөвгүүн Нилха Сэнгүмийн өргөө байсан Бэрх Элэдэд нүүн очиж, Чингис хаан ба Ван ханы хооронд улам дайсагнуулах хувилдалга хийжээ. Жамуха: “Тэмүжин анд бол Найманы Таян хан лугаа холбоотой билээ. Тэр хэдийгээр аман дээрээ эцэг хүү хэмээж байвч, авир санаа нь өөр юм. Та бас итгэсээр байна уу, эс түргэлвээс та нарт юу болох буй? Та нар Тэмүжин андыг байлдаар морилбоос хөндлөнгөөс чинь хавсарч өгье” гэж Сэнгүмд хэлжээ. Алтан, Хучар хоёр: “Бид Өгэлүн эхийн хөвгүүний ахыг нь алж, дүүг нь тэвчиж өгсүгэй” гэж бас Сэнгүмд хэлжээ. Өвөгжин, Ноёхин, Хардахидайнхан: “(Бид) гарыг нь гартаж, хөлийг нь хөлдөж өгсүгэй” гэж хэлэв. Тоорил: “Аргацаан очиж, Тэмүжиний улсыг нь авья, тэр улсаа алдваас яаж чадах аж?” гэж хэлжээ. Хачигун бэхи: “Нилха Сэнгүм хөвгүүн чи тэнгэрийн үзүүрт хүрч далайн ёроолд оровч би хэзээд хамт явна” гэж хэлэв.

Эдгээрийн хэлэлцээ бол Чингисийн эсрэг хандсан тангараг болно.

Нилха Сэнгүм эцэг Ван хандаа энэ санаагаа урьдаар бусдаар, сүүлд нь биеэрээ очиж мэдэгджээ. Ван хан хэдийгээр “Тэнгэрийн таалал”-аас айж баахан гуйвалзсан боловч хамгийн эцэст нь: “Тэнгэрт үл таалагдахаас айж хөвгүүн (Сэнгүмийг зааж буй)-ээ яахин хөнөөх буй? Та нар чадах аваас юун үйлдэхээ өөрөө мэдэгтүн” гэжээ. Энэ бол Ван ханы эцсийн зориг шийдвэр болно.

Тэд нар Чингис хааныг далдуур хорлох заль мэхийг энэ мэт сүвэгчилжээ. “Тэд саяхан манай Чагур бэхи-г гуйж байсан бөлгөө. Өдгөө багалзуур идээр⁷² (идэхээр - хө.) ирэгтүн хэмээн өдөр болзож, урьж ирүүлээд, тэднийг барьж авья” гэж хэлэлцэн тогтоод “Чагур бэхи-г өгье, багалзуур идээр ирэгтүн” гэж Чингис хаанд хүн илгээжээ.

Тэдний энэ үгийг нь Чингис хаан бас итгэж, арван хүн дагуулаад “багалзуур идэхээр” Ван ханы гэрт очих замдаа Мүнлиг эцгийн гэрт хоножээ. Мүнлиг эцэг бол олон юмыг өнгөрөөсөн дадамгай хэрсүү хүн тул Чингист: “Бид Чагур бэхи-г гуйваас, тэд саяхан биднийг доромжилж өгсөнгүй бөлгөө. Өдгөө хэрхэн багалзуур ид хэмээн урих аж? ... Үүнд сэжиглэлтэй явдал буй. Хөвгүүн чи очихыг болгоомжлох хэрэгтэй. Өдгөө хавар болов. Бидний адуу туранхай буй. Адуугаа таргалуулж байгаад очье хэмээн шалтаглаж хариулья” гэж сануулсан байлаа.

Чингис хаан, Мүнлигийн энэ үгийг бүрэн зөвшөөрч, Бухадай, Хиратай гэгч хоёр элчийг “багалзуур ид” хэмээн явуулаад өөрөө Мүнлиг эцгийн гэрээс буцаж харьжээ.

Бухадай, Хиратай хоёр очмогц, Сэнгүм нар: “Бидний арга сэрэгдэв, маргааш эрт хүрээлэн очиж барьж авья” гэж дахин хэлэлцэв. Ингэж хэлэлцэн тогтсоноо Алтаны төрлийн дүү Их Чэрэн (Чингисийн өвөг эцэг Бартан баатарын дүү Хулан баатарын хүү) гэгч гэртээ ирээд эмдээ ярьж байхыг нь тэдний адуучин Бадай гэгч сонсч хариад, түүний нөхөр нөгөө нэг адуучин Хишилигт хэлжээ. Тэрчлэн Хишилиг бас очиж цаашид лавлаад, тэдний хувилдлага үнэн магад тул Бадай, Хишилиг хоёул шөнө дүлин явж энэхүү бачим мэдээг Чингис хаанд нарийн тодорхой мэдүүлсэн байна.

Ван хан, Чингис хаан хоёрын тулалдсан “Муу өндөрийн байлдаан”

Энэ удаагийн байлдааныг Муу өндөр⁷³ гэдэг газар хийсэн болохоор “Муу өндөрийн байлдаан” гэдэг билээ. Гэтэл зарим ном бичигт “Хар халжан элсний байлдаан” гэдэг. Ли Цзэ Фэнь авгайн номд “Хан уулын байлдаан” гэсэн бөгөөд түүний байрыг Хөлөн нуураас хойш байхаар жишжээ. Энэ нь манай жишилтгэй нэлээд зөрж байна. Энэ удаагийн байлдаан нь мөн 1203 оны хавар, зуны хооронд явагджээ.

Чингис хаан, Бадай болон Хишилиг хоёрын хүргэж ирсэн чимээг олмогц шөнө дүлин харьяат цэрэгтээ хэл чимээ хүргэх, ачаа хөсгөө хөнгөлж уулын ар өөд шилжих мэтийн байлдааны бэлтгэл хийж дуусаад, дайсныг хөдөлгөөний дунд нь устгахаар цэрэг мордов. Гэхдээ итгэлт нөхөр Урианханы Зэлмэ-г ар цагдуулс (тагнагч - хө.) болгож, Муу өндөрийн ард харуул тавьжээ. Дараа өдрийн үд хэлбийх үед Хар халжан элс гэдэг газар хүрч үдлэв. Алчидайн адуучин Чихидай, Ядир⁷⁴ хоёр Муу өндөрийн өмнө агтаа адуулж байгаад, хойноос Муу өндөрийн өвөр дэх Улаан бургад-ыг дайран ирж яваа дайсны тоосыг олж үзээд агтаа түргэн хөөж ирж мэдүүлжээ.

Энэ үед Чингис хааны цэрэг сая гурван мянгаад л⁷⁵ байсан бөгөөд Ван ханы цэрэг нь хэд дахин илүү байжээ. Байлдааны өмнө Чингис хаан өөрийн цэргээ хоёр шатаар байрлуулав. Түрүү байранд Уругуд, Мангуд хоёр аймгийн цэргийг байрлуулав.

Ван ханы цэрэг морь нь олон болохоор таван шатаар байрлуулж, хойно хойноосоо хүч залган довтолсон байлаа. Хошууч ангиар Хадахи (дараа дурдагдах Хадаг баатар болох мэт) түрүүтэй

Жирхиний 76 баатаруудаар довтлуулжээ. Түүний гээг хоёрдугаар шатанд Ачиг Ширүн түрүүтэй Түмэн Түбэгэнчүүдээр довтлуулжээ. Түүний гээг гуравдугаар шатанд олон Донгайдын баатруудаар довтлуулжээ.

Донгайдын гээг дөрөвдүгээр шатанд Хори Шилэмүн тайжаар Ван ханы мянган турхагуудыг удирдуулан довтлуулжээ. Хамаг сүүлд нь Ван ханы гол цэрэг нь довтолжээ. Ван хан энэ удаагийн байлдаанд өөрийн бүх цэргээ Жамуха-гаар захируулсан байв.

Байлдан эхэлмэгц хоёр этгээдийн цэрэг ширүүнээр тулалдав. Чингисийн талаас Уругудын Жүрчидэй, Мангудын Хуйлдар сэцэн түрүүлэн харагчиг, алагчиг туг (хар сүлд, алаг сүлд)-аа мандуулан орж Жирхинийг дарав. Дараа нь Түмэн Түбэгэний Ачиг Ширүн довтлон ирж ширүүнээр байлдан Хуйлдарыг шархдуулж, мориноос нь унагаав. Ингээд Мангуд нар буцаж Хуйлдарыг хамгаалахын хамт, Жүрчидэй Уругуд цэргээ удирдан байлдаж, Түмэн Түбэгэнийг дараад цааш нэхэхэд Ван ханы гуравдугаар шатны цэрэг олон Донгайд эсэргүүцэн довтолов. Жүрчидэй бас олон Донгайдыг дарав. Дараа нь Хори Шилэмүн тайж Ван ханы мянган турхагуудыг удирдаж довтолов. Жүрчидэй бас Хори Шилэмүн тайжийг няцааж, цааш ороход Ван ханы хөвгүүн Сэнгүм эцгээсээ зөвшөөрөлгүйгээр довтолон ирж байлдаад, энгэсэг хацраа шархдуулж мориноосоо унасан байв. Чингээд Хэрэйд бүгдээр Сэнгүмийн дээр цуглаж очив.

Энэ үед наран нэгэнтээ шингэх шахаж орой болсон тул, Чингисийн цэрэг буцаж шархтай Хуйлдарыг хамгаалан их байртаа харьж ирэв. Энэ үдэш хоёр этгээдийн цэрэг байлдааны талбайгаас тус тус ухран хоноглов.

“Муу өндөрийн байлдаан” ч ингээд дуусчээ. Энэ удаагийн байлдаанд Чингис хаан цөөн цэргээр олон дайсныг дийлсэн боловч, өөрөө бас нэлээд хохирол олжээ. Чингисийн эрэлхэг баатар Хуйлдар шархдав. Боорчу морио алуулж, дайсны ачаагаа хөглүүлсэн (замбараагүй болгосон – хө.) мориог барьж унаад амь гарчээ. Чингис хааны гуравдугаар хөвгүүн Өгөөдэй хүзүүгээрээ шархдаж, Борухул амийг нь аварч маргааш нь сая харьж иржээ. Байлдааны дараа Чингис хаан өөрийн цэргээ бүртгэж үзэхэд сая, хоёр мянга зургаан зуу байв.

Ван ханы цэрэг дийлэгдэж, ашиггүй байдалд тулгарсан үед Жамуха, Чингис хааны тэнд хүн илгээж, Ван ханы цэргийн байрлуулалтын нууцыг задруулсан бөгөөд “Ван хан бол чадалгүй, надаар цэргээ захируулсан билээ, Тэмүжин анд чи хатуужин байлд” гэж Ван ханыг далдуур худалджээ. Гэвч “Нууц товчоон”-д энэ үгийг байлдаан эхлэхээс өмнө хэлүүлсэн мэт тэмдэглэж буй. Энэ нь арай зүйд нийцэхгүй юм. Жамуха хэрвээ үнэн санаанаасаа Чингисийг туслая гэсэн юм бол яахин Ван ханыг өдөөн байлдах аж? Дийлэгдэх үедээ ингэж хэлүүлэх бол Жамуха-гийн ашдач (уг – хө.) мөн чанар нь юм. Тиймээс би залруулан тэмдэглэсэнээ энд тодорхойлъя.

Чингис хаан өөрийн хүчээ цаашид цэгцэлж, Ван хан нарыг буруушаан донгодсон нь

“Дайсан хэрвээ ирвээс байлдая. Дайсан дутаасан аваас бид цэргээ цэгцлээд нэхэн байлдая” гэж Чингис хаан тэндээс хөдлөөд Улхуй Шилүгэлжидийг чиглэн явж, Далан Нөмөргөст хүрэв. Гэтэл Ван ханы цэрэг баруунш Улаан Бургадын зүг ухран явжээ. Чингис хаан хоёр мянга зургаан зуун цэргийнхээ хагасыг нь өөрөө дагуулж Халх голын баруун хөвөөгөөр, хагасыг нь Жүрчидэй, Хуйлдараар захируулж Халх голын зүүн хөвөөгөөр уруудан, амуу хүнс

нөхвөрлөхийн тул ав хийж явав. Хуйлдар шарх нь эдгээгүй байтал, хааны ятгалгыг сонссонгүйгээр гөрөөсөнд довтлон яваад, шарх нь үгдэрч нас нөгчив.

Чингис хаан түүний ясыг нь Халх голын Орнугугийн хэлтгий хаданд оршуулжээ. Хуйлдарын энэхүү гавьяа зүтгэлийг сайшаахын тулд, сүүлд нь Хэрэйдийг мөхөөсөн хойно, Ван ханы их жанжин Хадаг баатар (Чингист буун өгчээ)-ыг Жирхин овгийн зуун хүний хамт Хуйлдарын эм хөвгүүнд зарц болгож өгсөн бөгөөд Хуйлдарын зүтгэл гавьяаг хүндэтгэхийн тул түүний ургийн ураг хүртэл өнчнийг тэтгэх хишгээс хүртэж яв гэж Чингис хаан зарлиг буулгажээ.

Энэ Халх голын Буйр нуур⁷⁷-т цутгах адаг газраар Дэргэг, Эмэл⁷⁸ нар түрүүтэй Хонгирадууд нутагладгийг хаан сонсч, “Хонгирад иргэн эрт өдрөөс зээгийн зүсээр, охины өнгөөр” явдаг билээ. Тэднийг элсэн дагуулъя, хэрвээ эсэргүүцвээс байлдан эзлэгтүн гэж Жүрчидэй түрүүтэй Уругудыг илгээжээ. Хонгирад нар Жүрчидэйд элсэгдсэн тул, Чингис хаан тэднийг огт хөндсөнгүй.

Чингис хаан Хонгирадыг оруулан авсны дараа, тэндээс нүүж Түнгэ горхины зүүн биед очиж буугаад, Архай Хасар, Сүхэгэйжэгүн хоёр элчээр, Ван ханы эрт урьдын түүхээс нь аваад одоо болтол хэрхэн гуйвалзаж байсныг нь нэгд нэгээр донгодон тоочсон дуу (амаар илгээх нот) бариулан илгээжээ.

Дараа нь Чингис хаан бас хоёр элчээр дуу бариулан Жамуха, Алтан, Хучар, Сэнгүм жич Тоорил⁷⁹ нарт тус тус хүргэлгэж, тэдний ов мэхийг нь илчилж донгодсон билээ.

Хоёр элч Чингис хааны зарлигийг биелүүлээд, Архай Хасар ганцаар буцан ирж ирж хариу мэдүүлжээ. Сүхэгэйжэгүний гэр хотлоор Ван ханы хүрээнд байсан болохоор буцаж чадсангүй хоцорчээ.

Чингис хаан энэ үед цэргийн хүчээр тэднийг дарж чадах байдал доор ингэж “дуу бариулсан” явдал бол бас нэгэн зүйлийн тэмцлийн арга болно. Өөрөөр хэлбэл, тэдний хооронд болсон дайныг Чингис хаан өдөөсөн биш, харин тэд өдөөсөн гэснийг илчилжээ. Бас Чингис хаан тэдэнтэй дайсагнан байлдах дургүй гэдгээ илэрхийлжээ. Тиймээс, энэ нь олны сэтгэлийг татан, өөрийгөө бүлгэмдүүлж, дайсныг задруулах үйлдэлтэй юм. Мөн ч Чингис хааны нэгэн их бодлого болно.

“Балжуна нуурын тангараг”

Чингис хаан Түнгэ горхинд дэмий удсангүйгээр Балжуна нуурт буусан байна. Энэ үед Горлосын Чунаг, Цагаан тэнд Чингис хаан лугаа учирч, Горлосууд дагаж орсон билээ.

Чингис хаан Балжуна нуурт хүрч ирэх үед, бас нэгэн хүн цагаан тэмээ унаж, мянган ирэг хонь тууж ирэн Балжуна нуурт усалж байжээ. Энэ хүн бол Асан⁸⁰ гэгч Сартагтай (Сартуулын) худалдаачин ажээ. Тэр Онгудын Алахуши Дигит Хуригаас мянган иргэ худалдаж аваад, Эргүнэ мөрөн⁸¹ орчим нутаглах ардаас булга, хэрэм худалдан авахаар явж байсан нь энэ билээ.

Тэр үед Балжуна нуурын ус булингартаж байсан юм гэлээ. Чингис хаан анд нөхөдтэйгээ өнөд

найрамдан тэмцэхээ илэрхийлж, Балжуна-ы усыг ууж тангараглажээ. Энэ бол “Балжуна-ы тангарагтан”⁸² гэж түүх шастирт тэмдэглэгдсэн нэгэн явдал болно. Тэр үед тангараг хийсэн нь нийт арав есөн хүн гэдэг юм.

Хэрэйдийг мөхөөсөн “Жэжэгэр өндөрийн байлдаан”

Энэ удаагийн байлдаан нь мөн харагчин гахай жил буюу 1203 оны намар явагджээ.

Энэ байлдаанаас өмнө гарсан хоёр явдлыг энд тэмдэглүүштэй байна.

Нэг нь, Ван хан “Муу өндөрийн байлдаан”-аас дараа Жад Горхин Элэд⁸³ гэдэг газар буугаад байхад, Чингис хаанаас урван тэрсэлсэн хааны төрлийн Даритай Отчигин, Алтан, Хучар болон Жамуха, Хулбари, Сүхэгэйжэгүн, Тоорил, Тахайхурхай жич Ойрадын түрүү Хутуга бэхи нийлэлдэн Ван ханыг хорлож урван явахаар нь сүлбээлджээ. Гэвч хэрэг нь лэврээд (лэврэх – нууцалсан хэрэг илрэх, задрах – хө.) Ван ханд цохигдсон байв. Ингээд Даритай Отчигин, Хулбари нар Сахайд, Унжин (Үгүшин) аймгийн хүмүүсийг авч Чингис хаанд дагаар ирсэн юм. Алтан, Хучар, Хутуга бэхи, Жамуха нар Найманы Таян ханыг түшихээр дутаасан байна. Дараа нь Ван ханы цэрэг Жэжэгэр өндөрийн Жэр хавцгай-д хүрч байрлав.

Нөгөө нэг нь, Чингис хаан Балжуна нуурт буугаад байхад, хааны дүү Хасар өөрийн эмс хөвгүүд - Ехү, Есүнгэ, Тоху нарыг Ван ханы тэнд орхиж (“орхиж” гэдэг бол “Нууц товчоон”-ы тэмдэглэл болно. Гэтэл Ли Цзэ Фэнь авгайн номд: Муу өндөрийн байлдаанд Хасар Хэрэйдэд дийлэгдэж, хамгаа алдсан бөгөөд эмс хүүхдийг нь Ван хан олзлон авч явжээ гэж тэмдэглэж буй. Ирлийг нь мэдээгүй), өөрөө цөөн хэдэн нөхдөө дагуулаад, ах Чингис хааныг эрэн, Харагун Жидүний нуруугаар хэсэж эс олон, шороо шөрмөс идэн зовон зүдсээр явж, сая энд ирж ах хаандаа нийлсэн байна. Чингис хаан баясч угтав.

“Жэжэгэр өндөрийн байлдаан”-ы хөшиг ч эндээс эхэлсэн юм. Чингис хаан байлдааны өмнөх тагнуулын ажлыг хийхдээ Хасарын нэрийг ашиглаж хийсэн байна. Ван ханы цэргийн байдлыг ойлгохоор Жэгүрээдэйн Халигудар, Урианхадайн Чагурхан хоёрыг томилж:

“Хаан ахаа

Харж яваад би

Хараа бараа ч үгүй

Хайж эрээд эс олов.

Хайлж дуудаад эс сонсдов.

Одоо би ододыг харан

Орвон (дов – хө.)-ыг дэрлэн хэвтмүй.

Эм хөвгүүн минь эцэг хаанд буй.

Итгэмжтэй хүнийг илгээвээс,

Эцэг хаанд нийлэн одох би”

гэж Хасарын үг болгон Ван ханд хэлүүлжээ. Бас Халигудар, Чагурхан хоёрыг буцаж ирэхдээ Хэрлэнгийн Аргал Хөхи84-д ир гэж болзож, тэр хоёрыг явуулаад Чингис хаан Жүрчидэй, Архай Хасар хоёрыг хайгуул болгож, Аргал Хөхи-д нүүн очжээ.

Халигудар, Чагурхан хоёр Ван ханы дэргэд хүрэхэд, Ван хан алтан тэрэм (гэр - ханат гэр, асар - хө.) босгон, ажиг сэжиггүй хуримлан сууж байжээ. Тэр, хоёр элчийн үгийг сонсоод “Тийн бөгөөс Хасар иртүгэй” гэж итгэмжтэй хүн Идүргэн гэгчийг хоёр элчийн хамт илгээсэн билээ. Эд болзсон ёсоор Аргал Хөхид ирэхэд, цэрэг мориор дүүрч байхыг үзээд, Идүргэн сэжиглэж буцан дутаав. Халигударын морь хурдан тул гүйцэн очиж, өмнө хойно нь орон саатуулж байхад, Чагурхан нэхэж ирээд Идүргэний алтан эмээлт хар моринынхи нь гуяыг хуга харваж унагаад, Идүргэнийг барьж аван Чингис хаанд хүргэв. Чингис хаан Идүргэн лүгээ юу ч хэлсэнгүйгээр, “Хасарт авч одогтун! Хасар мэдтүгэй” гэв. Хасарт хүргэн өгсөнд, Хасар ч мөн юу ч асуусангүйгээр цавчин алсан гэлээ.

Тагнуулын үүргийг даан явсан Халигудар, Чагурхан хоёр үүрэг тушаалаа амжилттай биелүүлж: “Ван хан ажиг сэжиггүй алтан тэрмээ босгож, хурим найр хийж байна. Бид одоо түргэлэн мордож, шөнө дүлээр бүслэн дайрья” гэж хаанд мэдүүлсэн байлаа.

Чингис хаан дайсны нарийн байдлыг олж мэдмэгц, Жүрчидэй, Архай Хасар хоёроор түрүү хайгуул болгон шөнө дүлээр цэрэг мордон, Ван ханыг Жэжэгэр өндөрийн Жэр хавцгайн аманд байхад гэнэтээр бүслэн авч ширүүн дайралт хийв.

Энэ удаагийн байлдаан нь арван гурван шөнө гурван өдөр үргэлжилж, гуравдугаар өдөр дээрээ тэд сая бууж өгөв. Гэтэл Ван хан, Нилха Сэнгүм эцэг хүү хоёр шөнийн харангуйг далимдуулан оргон дутаажээ. Дайсны талаас энэ байлдааныг удирдан хийсэн хүн бол Ван ханы их жанжин Жирхиний Хадаг баатар байв. Тэр бууж өгөөд: “Тус хаанаа үзсээр хэрхэн алуулах хэмээн тэвчин ядаж, амь оргон хол дутаалгахын тулд гурван шөнө гурван өдөр үхэн байлдав. Өдгөө үхүүлбээс үхсүгэй, соёрхогдвоос Чингис хаан танаа хүчээ өгсү” гэжээ. Чингис хаан түүний үгийг зөвшөөрч, тус хаанаа аврахын тул байлдсан эрийг хэн буруушаах буй? Нөхөрлөж болох хүн байна гэж соёрхож, Мангудын баатар Хуйлдарын гэр бүлд өгснийг дээр нэгэнтээ тэмдэглэж билээ.

“Жэжэгэр өндөрийн байлдаан” нь Хэрэйд аймгийн хүчийг бүрмөсөн мөхөөн дуусгаж, ард иргэдийг нь зүг зүг хуваав. Сүлдүсийн Тахай баатарын тус гавьяаг нь сайшааж зуун Жирхинийг хуваан өгсөн билээ. Ван ханы дүү Жаха Гомбу (Хамбу – хө.)-гийн хоёр охины эгч Ибага бэхи-г Чингис хаан өөртөө татвар болгон авч, дүү Сорхагтани бэхи-г Тулуйд өгөв. Иймээс, Жаха Гомбу-гийн харьяат өмч иргэдийг нь халдсангүй бөгөөд “тэрэгний нөгөө арал” мэт тус болж яв гэж соёрхсон гэлээ.

Урьд “Муу өндөрийн байлдаан”-ы бачим чимээг Бадай, Хишилиг хоёр Чингис хаанд хүргэж их ач тус хийсэн тул Ван ханы суудаг алтан тэрэм, хэрэглэдэг алтан завьяа, аяга сав болон Ван ханыг асрагч ард сэлт жич Онгужин Хэрэйдийг цөм Бадай, Хишилиг хоёрт олгон өгчээ.

Бас тэр хоёрыг “ургийн ураг хүртэл дархлан жаргагтун” гэж зарлиг болов.

Хэрэйдийн бусад салбар Түмэн Түбэгэн, олон Донгайд, Жирхиний баатарчуудыг “хэнээр эс дутгал түгээлдэв”.

Ван хан, Сэнгүм эцэг хөвгүүн хоёул дутааж гараад, Дидиг сахлын Нэгүн усан⁸⁵ гэдэг газар хүрч, Ван хан ангахдаа усан дээр очоод Найманы харуулын Хори Сүбэчи-д баригдаж тэндээ алагджээ. Сэнгүм усан дээр хүрсэнгүй тул амь зугтан гарч, Тангудын Чал хотыг дайран, бүлүнгир Төвдөд хүрч, тэднийг дээрэмдэн булаагаад хөөгдөв. Ингээд баруун оронд дутааж, Хотон, Кашгарт хүрч, Хүсан Киргизманы газар сууж байгаад Харачи аймгийн түрүү Кэрилчи Хара (Рашид-ад-Динд Кылыч Кара гэж буй – хө.) гэгчид алагдлаа гэдэг сэн.

Хэрэйд аймгийг туйлбартай мөхөөсөн учир ийм билээ. Хэрэйдийг мөхөөсөн явдал бол Чингис хаан бүх Монголыг нэгтгэх зам дээрх хамгийн их саадыг цэвэрлэжээ. Тиймээс, энэ нь зангилааны чанартай дайралдаан болно.

Хэрэйдийг мөхөөсний хойно, 1203 оны өвөл Чингис хааны цэрэг зүүнш буцаж Абжига Хөтэгэрт өвөлжжээ.

34. Онгуд аймаг нэгдэн ирсэн нь

Чингис хаанд Онгуд аймаг нэгдэн ирсэн нэгэн шууд шалтгаан бол Найман лугаа холбогдох юм. Анхандаа Найман болон Чингис хааны хооронд хүчирхэг их Хэрэйд аймаг халхалж байжээ. Гэтэл 1203 оны намар, Чингис хааны цэрэг Ван ханы цэргийг мөхөөж, Хэрэйдийг нэгтгэн авсан хойно, Монголын хязгаар нэгэнтээ Найман лугаа зах нийлж, Найманы язгууртдад их сүрдүүлэл болов.

Ингээд “шувуулах авлах”-аас өөр эрдэмгүй боловч, ихэрхэг зантай Найманы Таян хан “Тэнгэр дээр наран саран хоёр гэрэлтэн гэгээн болтугай хэмээн наран саран хоёр буй за. Газар дээр хоёр хаад хэр (хэрхэн байж) болох? Бид одож тэдгээр Монголыг авчирья” гэж Юхунан⁸⁶ нэрт элчээ Онгуд аймгийн түрүү Алахуши Дигит Хури-д илгээж, “энэ дорно цөөн монгол буй хэмээлдмүй. Чи баруун гар бол, би эндээс хамсаж тэдгэд (тэдгээр) Монголын хор (хоромсгыг) нь авья” гэж хэлүүлжээ.

Гэтэл Алахуши Дигит Хури түрүүтэй Онгуд аймгийнхан Найманы доройтсон байдал ба Чингис хаан бүх Монголыг нэгтгэж чадах байдлыг үзэж гарсан болохоор Найман лугаа хамсан Чингис хааныг эсэргүүцсэнгүй мөртөө Чингис хааныг дэмжин Найманыг оруулан авсан юм. Ингээд тэр даруй Алахуши Дигит Хури Найманы Таян ханд “баруун гар болон үл чадах би” гэж хариу илгээгээд, бас Торбиташ нэрт элчээ Чингис хаанд илгээж: “Найманы Таян хан хор чиний аваар ирнэ. Намайг баруун гар бол хэмээж иржээ. Би эс болов. Өдгөө би чамд сэрүүлж (сануулж – хө.) илгээв. Ирж хороо авгуузай чи” гэж хэлүүлснийг “Нууц товчоон”-ы 109 дүгээр зүйл тэмдэглэж буй.

Онгуд аймгийг Монголын тухай түүх шастирт бүр “Онгуд” гэж хэлдэг. Гэтэл “Ляо улсын түүх”-д “Цагаан Татар” гэж, “Хятан улсын тэмдэглэл”-д “Гажилын шивээ” гэж, Цю Шо Сэнь “Гажилын Татар” гэж тус тус адил бус нэрлэдэг билээ. Тэрчлэн Онгудын угсаа гарлын тухай

бас хэд хэдэн хэллэг буй. Зарим нь Онгуд бол умард Хүннүгийн Вэнь У Ту вангийн үр хойч нь дээдсийнхээ нэрээр аймаг угсаагаа “Онгуд” аймаг гэж нэрлэх болжээ гэдэг (“Хойт Хань улсын түүх, өмнөд Хүннүгийн намтар”). Гэтэл бусад олонхи тэмдэглэлд Онгудыг эртний өрнөд түрэг угсааны аймаг гэдэг билээ. “Татар” гэдэг нь бусад үндэстнээс Монголчуудыг ерөнхийлөн нэрлэсэн нэр болно. Онгуд, Хонгирад, Татар нарыг “Цагаан Татар” гэж, говийн умард Монголчуудыг “Хар Татар” гэж ангилдгаар үл барам, бас “Болгосон Татар”, “Түүхий Татар”, “Зэрлэг Татар” мэтийн доромжлонгуй ялгал ч буй.

“Онгуд” гэдэг нэрийг бас хоёр янзаар тайлдаг байна. Нэг нь, Онгуд аймаг нь Ляо улс ба Алтан улсын умард хилийн “Цагаан хэрэм”-ийг сахиж байснаас “Цагаан хэрэм”-ийн нэрээр нэрлэжээ гэдэг. “Цагаан хэрэм”-ийг монголоор “оогу” буюу “огу” гэдэг тул энэ үг нь хувираад “Онгуд” болжээ гэдэг. Энэ бол Д’Оссоны хэллэг болно. Гэтэл Монголын түүхэн материал буюу Монголчуудын ойлгогод “Цагаан хэрэм”-ийг “оогу”, “огу” гэсэн ухагдахуун баримтгүй юм. Харин Хөлөн Буйраар байдаг “Бор хэрэм”-ийг Монголчууд эртний үед “өрх” гэж нэрлэж байсан тухай тус бүлгийн дагалдвар “17”-д тэмдэглэв. Энд “Цагаан хэрэм” гэсэн нь харин тэр “Бор хэрэм”-ийг хэлсэн ч магадгүй. Гэтэл Онгуд аймаг Хөлөн Буйр орчим нутаглалаа гэдэг тэмдэглэл ер харагддаггүй. Нөгөө нь, Далан хар уулын ноён оргил болох одоогийн “У Гун даваа”-г эртний үед “Онгон даваа” гэдэг гэлээ. Онгуд аймаг нь Далан хар дагуу нутаглаж байсан болохоор газар усны нэрээр аймгаа нэрийдэв гэдэг билээ. Монголчууд уул хайрханыг “онгон” гэх нь зөндөө байдаг. Гэвч “Онгуд” гэсэн нэрийн ирэл чухам юу гэдгийг баттай тодлоход одоохондоо баримтгүй байсаар билээ.

Онгуд аймаг нь арван хоёр, арван гуравдугаар зууны үеэр одоогийн Өвөр Монголын Өөртөө Засах Орны Төв Хөх хотын араар Далан хар уул дагуу Монголын говь газраар нутаглаж байжээ.

Онгуд аймаг нь олон зуун жилийн турш Хятад, Хятан, Уйгур зэрэг соёлжсон үндэстнүүдтэй зах зэрэглэн нутагшиж байсан болохоор, аж ахуй, соёл боловсролын талаар Монголын эл аймгуудын дотор нэлээд өндөр хөгжилттэй аймгийн нэгээр тооцогдож болох юм. Хот балгас олон, тариа төмс тарьж байсан, гар үйлдвэр нэлээд хөгжсөн ба несторианы Христосын шашныг шүтэж байсан нь одоо болтол археологийн маш олон баримттай байсаар байна (зураг 46-д үз).

Онгуд аймаг нь Наймантай онц харьцаатай байсныг элчийн явалцаанаас мэдэж болохоор барахгүй, газар нутаг нь залгалдаж байсан ба соёлын талын харьцаанаас нь бас мэдэж болно.

Монголын олон аймгуудын дотор “уйгуржин монгол үсэг”-ийг Найман хамгийн тэргүүнд эхлэн хэрэглэсэн гэж одоо болтол нийтийн ойлголт болсныг хэн ч бүр мэдэж байх юм. Харин Онгуд аймаг ч Наймантай адилаар “уйгуржин монгол үсэг”-ийг монгол аймгуудын дотор эхлэн хэрэглэсэн аймгийн нэг нь болно гэж хэлэхэд хүмүүс арай итгэхгүй байгаа. Би энэ тухай археологийн баримтыг тус товчооны тавдугаар бүлэгт танилцуулах болно.

Чингис хаан монголыг нэгтгэх үед, Онгуд аймгийн түрүү нь Алахуши Дигит Хури гэсэн хүн байжээ. Хожим нь Юань улсын хоёрдугаар хаан Төмөр хаан (цол Өлзийт)-ы Да Дэй-н есдүгээр он (1305 он)-д Алахуши Дигит Хури-д “Гао Тан Чжун У ван” цол нэхэмжлэн өргөмжилжээ.

Энэ үе (Найманы элч Онгудад чимээ хүргэсэн нь 1203 оны өвөл буюу 1204 оны хавар болно)-д, Онгуд болон Чингис хааны хоорондох харьцаа нь зөвхөн Найманы мэдээг дамжуулсан харьцаа биш, харин Монголын бусад аймгуудтайгаа сайн дураараа нэгдэн холбоолж, Найманыг нэгтгэх зэрэг Чингис хааны их үйлст идэвхитэй зүтгэсэн явдал болно. Үүнийг бид “Гао Тан Чжун Сянь ван хүргэний хөшөө”-ний тэмдэглэлээс мэдэж болно. Түүнд: Тайцзу (Чингис хаан - эшлэгч) богд баатар хаан умардад мандаж, эл аймгийг хураан нэгтгэжээ. Баруун хойдод бүхий нэгэн улс (Найманыг хэл буй - эшлэгч) (ийн түрүү) Таян хан хэмээгч Жухунан нэрт элчийг томилж, Чжун У (Алахуши Дигит Хури-г хэлж буй - эшлэгч)-д өгүүлсэн нь: “Тэнгэрт хоёр наран байж үл болмуй, дэлхийд хоёр эзэн байж үл болмуй. Чи хэрвээ миний баруун гар болбоос, умар дахиныг төвшитгөхүйеэ бэрх бус болой” хэмээжээ. Тайцзу болбоос билиг баатар хосолсон бөгөөд их үйлийг бүтээж чадахыг Чжун У урьдаас мэдэх тул нэгдэн дагахыг шийджээ. Аймаг харьяатад нь үл зөвшөөрөгсөд буй асан ч Чжун У түүнийг хайхарсангүй, шадар харьяат Торбиташи-ийг томилон Тайцзу-д зургаан балбан архи бэлэглэн, Жухунан-ыг хүргэн өгсөн бөгөөд Таян ханы ов хувилдлагыг мэдэгджээ. Энэ үед умар дахинд архи хүргэх ёсгүй ажгуу, Тайцзу урьдаар сацал өргөж, дараагаар зоогловой. Хэмийг гурвантаа өргөж: “Энэ юмыг бага эдэлбээс чанарыг хөгжөөмүй, их эдэлбээс чанарыг өдөөмүй” хэмээжээ. Элч буцахууд адуу, хонь тус бүр хоёр мянгыг шагнасан ажгуу.

Хаанаас: “Нэгэн өдөр дэлхий дахин миний болбоос чиний ач тусыг хэрхэн хариулахуйг мөнх тэнгэр мэдтүгэй хэмээн зарлиг буулгаж, тогтсон газар учралдаж Таян (хан)-ыг хамтаар дайлахыг болзолдов. Чжун У хугацанаас урьдаар хүрчээ” гэж тэмдэглэж байдаг билээ (“Юань улсын зүйл хуваасан шастир”, 23 дугаар боть). Бас “Биеэр дайлсан тэмдэглэл”-д: “Алахуши даруй Чингист Торбиташи хэмээгч элч илгээж тэрхүү хувилдлагыг мэдүүлэв. Дараагаар аймаг хотлоороо авч дагаар ирэв. Бид Онгуд аймагтай эв найрамдалтай болсон нь үүнээс эхэлсэн ажгуу” гэжээ.

Найманыг дайлсан байлдаан бол Чингис хаан Монголын бүх аймгуудыг нэгтгэсэн сүүлчийн нэгэн их байлдаан болно. Онгуд аймаг болон түүний түрүү Алахуши Дигит Хури энэ байлдаанд гавьяа зүтгэл үзүүлсэн тул, Хаант Монгол Улсыг тунхагласны дараа, Алахуши Дигит Хури-г наян найман гавьяатны нэгээр шагнаж, мянганы ноёноор томилсон байна. Бас хааны гүнжийг шагнаж хүргэн болгожээ. Ингээд Онгуд аймаг нь хаан язгууртны боржигин овогтон лугааургийн холбоотой болсон байна.

Онгуд аймаг нь өөрийн сайн дураасаа Чингис хааныг дагаж, Монголын эл аймаг лугаа нэгдсэн явдал нь Чингис хаанаас Найманыг нэгтгэхэд, хожим нь Алтан улсыг дайлахад идэвхтэй үйлдлийг үзүүлснээр барахгүй, ялангуяа монгол үндэсний аж ахуй ба соёлын хөгжилд ч гүн гүнзгий ач холбогдолтой хэрэг байжээ.

Арван тав, арван зургадугаар зууны үед, Онгуд аймгийн нэг хэсэг нь Батмөнх даян хааны залган түмэн - Цахар түмний нэгэн бүрэлдэхүүн нь боллоо гэдэг бөгөөд түүний ихэнх хэсэг нь одоогийн Ордос, Түмэд зэрэг Монголчууд болон хувирсан боломж ихээхэн байх мэт.

Онгуд аймагт Италийн алдарт жуулчин Марко Поло ирж, тэндэх байдлыг нарийн сайхан тэмдэглэжээ: “Тиньдун (энэ бол “Тянь Дэ Цзюнь” гэсэн нэрийн хувирал болно. Тухай үеийн Тянь Дэ Цзюнь бол одоогийн Урадын өмнөд хошууны Улаан сухай орчимд байсан Онгудын нутаг юм - эшлэгч) муж болбоос зүүн этгээдийн нэгэн муж болой. Мужийн дотор маш олон

хот худалдаа хийгээд цайз хайгуул буй бөгөөд их хаан (Хубилай хааныг хэлж буй - эшлэгч)-ы харьяат болой. Анхдугаар Чингис хаан энэ улсыг дайлан авснаас нааш, эндэх аливаа үе улирах эзэн нь даруй үүрд тэдний харьяат болжээ. Түүний нийслэл хотыг бас Тиньдун хэмээмүй. Суугуул ардын олонхи нь Христосын шавь. Тэр эзэн эзэмшиж бүхий энэ улсын бүх бээр даруй их хааны өргөмжилсөн газар буй. ...Их хаан түүнд хааны гэрийн бусад ван гүн лүгээ адил үргэлж гүнж буюу хааны гэрийн бусад охидыг буулгаж өгмүй.

Энэ мужид маш арвин сайхан чулуу гармуй. Түүнийг бас хөх өнгөтэй болгон үйлдэж болмуй. Энд бас тэмээний унгасаар нэхсэн бөс үйлдмүй. Хүн ард нь худалдааны ажил, тариалангийн ажил хийгээд гар үйлдвэр ба хөлс хүчээр амьдралгаа эргэцүүлмүй. Гэвч суугуул ардын дотор шуумал хөрөг шүтэгч (бөө мөргөлийг хэлж буй - эшлэгч) хийгээд Хотонгийн мөргөлтөн, жич Христосын шавь нар цөм баймуй. Мужийн доторхи захирах эрх нь Христосын мөргөлтний гарт буй. ...

Тиньдун муж болбоос Престер, Йохан (Ван ханыг Европынхан ингэж нэрлэдэг. Энд дурдаж бүхий Престер, Йохан гэдэг нь Хэрэйдийн Ван хан биш, Онгудын түрүү байвал зохих мэт - эшлэгч) хэмээх энэ тэргүүлэгчийн засгийн ордны аху газар хэмээхүй. ...Өдгөөгийн сууринаа бүхий ван Жорж (George) болбоос Престер, Йоханаас уламжлан ирсэн дөрөвдүгээр үе болой гэжээ. Энэхүү Жорж гэдэг нь “Юань улсын түүх, гүнжийн илтгэл”-д дурдсан Зуунбухын хөвгүүн Жорилча болох мэт. Тэр бол яг Онгуд аймгийн дөрөвдүгээр үеийн эзэн Чжао Кан Си ван гэгч билээ. Марко Поло-гийн ирсэн үед, Онгудын дөрөвдүгээр үе болох нь цагийн талаар ч ойртож байна.

35. “Наху гуны байлдаан” ба

Найманыг нэгтгэн авсан нь

Хөх хулгана жил (1204 он)-д, Чингис хаан дөчин гурван настай байв. Найманыг нэгтгэн авсан байлдааныг Наху гун⁸⁷ гэдэг газар хийсэн болохоор, түүх шастирт “Наху гуны байлдаан” гэдэг билээ. Энэ удаагийн байлдаан бол Чингис хаан Наймантай хоёрдугаар удаа байлдсан байлдаан болох бөгөөд Монголын олон аймгуудыг хураан нэгтгэсэн олон байлдааныхи нь бараг сүүлчийн нэгэн их байлдаан (сүүлээр нь бага сага байлдаан байсан боловч цөм шүүрдэлтийн чанартай байлдаан болно) болох тул энэ удаагийн байлдааныг “Нууц товчоон”-д нарийн тодорхой, амьд дүрслэг бөгөөд охи урнаар тэмдэглэсэн юм. Тус байлдаан нь доорхи хэдэн шатаар явагджээ.

Байлдааны бэлтгэлийн шат үе

1204 оны хавар, Чингис хаан Тэмээн хээр⁸⁸ гэдэг газар их ав тавьж байхад, Онгудын элч Торбиташ ирж, Найманы хуйвалдлагыг мэдэгдэв.

Чингис хаан энэхүү мэдээг сонсмогц, энэ байдлыг хэрхэн аргацаах тухай авын газартаа хуралдай (дээд зөвлөгөөн) хийв. Хуралдай дээр хоёр янзын санал гарчээ. Нэг зүйлийн санал нь: Хаврын цаг бидний агт туранхай тул одоо яахын ч аргагүй, намар агт таргалсан хойно байлдаа гэсэн олонхи хүмүүсийн санал болно. Нөгөө нэг зүйлийн санал нь: Завшааныг алдалгүй дайснаас амжин гар хөдөлж, дайсныг санамсаргүй байхад нь гэнэтээр дайрах гэсэн

санал болно. Энэ нь голдуу хааны дүү Отчигин ноён болон Бэлгүтэй ноёны санал билээ. Отчигин ноёны хэлсэн нь: “Агтыг туранхай хэмээн яахин шалтаглах буй? Миний агтас тарган буй, ийм мэдээг сонсоод яахин зүгээр суух буй?” гэжээ. Бэлгүтэйн хэлсэн нь:

“Амьд яваа байтал

Алтан хоромсгоо алдваас

Амьдарсан хэрэг юун?

Сайн эр үхвээс

Саадаг нумтайгаа

Салшгүй оршуулах болой.

Харьтан Найманы ноёд

Харьяа нутгаа өргөн хэмээн

Харц иргэдээ олон хэмээн

Хамаг их үгийг өгүүлэн ажгуу.

Бардам үгт дайсныг

Бачим дайран одвоос бид

Багаж хорыг нь авахуйяа бэрх бус.

Одож бид довтолбоос

Олон адуудыг нь хурааж

Орд гэрийг олзолж

Омогт цэргийг нь дутаалгүй

Ор мөргүй устгах ажгуу.

Ашигт завшааныг

Алдаж өнгөрөөлгүй

Адбиш түргэн морилтугай!”

гэжээ (энэ хэдэн бадгийг зохиогчоос баримжаа дэвтэрийг үндэслэн шинээр тайлан орчуулсан байна). Отчигин, Бэлгүтэйн эдгээр сануулгыг Чингис хаан бүрмөсөн зөвшөөрч, тэр даруй аваас бууж, Абжига Хөтэгэрээс хөдлөн, Халх голын Орнугу-гийн хэлтгий хаданд бууж, цэрэг морио бүртгэн тоолж, байлдааны зохион байгуулалтын бэлтгэлийг хийжээ.

Чингис хааны цэргийн зохион байгуулалт нь анхандаа “хүрээ”-гээр зохион байгуулж байжээ. Одоо тэр, олон удаагийн дайн байлдааны бодтой үйлдлэгээ дүгнэж, цэрэг дайны зохион байгуулалтаа арав, зуу, мянгаар хувиарлаж, бас наян хэвтүүл (шөнийн манаач - хө.), далан турхагууд(өдрийн харуул – хө.)-аар бүрэлдсэн хишигтэн цэргийг зохион байгуулжээ. Тэрчлэн мянганы ноёд, зууны ноёд, арваны ноёдыг тус тус томилсон бөгөөд түрүүлэн захирах түшмэл зургаан чэрби-г томилжээ. Энэ нь даруй Дөдэй чэрби, Догулху чэрби, Өгэлэн чэрби, Толун чэрби, Бучаран чэрби, Сүйхэтү чэрби болно. Бас мянган шилдэг баатарыг сонгож Архай Хасараар захируулж, далан турхагуудыг Өгэлэн чэрби, Хотус халчан хоёроор ахлуулжээ.

Бас хорчин, турхагууд, буурч, үүдэч, агтач жич хэвтүүл зэрэг хишигтний тушаал хариуцлагыг нь нарийн хувиарласан бөгөөд засаг цаазыг тунхаглав.

Цэрэг мордсон шат үе

Чингис хаан байлдааны бэлтгэлээ хийж дуусаад, хулгана жил (1204 он)-ийн зуны тэргүүн сарын шинийн арван зургааны улаан тэргэл өдөр туг сүлдээ тахиж, Халх голын Орнугу-гийн Хэлтгий хаднаас Найманыг байлдахаар цэрэг мордлоо.

Чингис хааны цэргийн өмнө хайгуулд Зэв, Хубилай хоёрыг томилж, Хэрлэн өөд явуулав. Тэд Саарь Хээрт хүрч, Хангар ханы эхэнд байсан Найманы харуул лугаа учрав. Зэв, Хубилайн хайгуул цэрэг нь Найманы харуултай тулалдаж, Найманы харуул нь Чингисийн хайгуулын нэгэн эмээлтэй эцэнхий саарал морийг олзлон авч, “Монголын агт туранхай ажгуу” гэж хэлэлцсэн гэлээ.

Тэр үед дайсны талын байдал ямар байсан буй гэвэл, Мэргидийн Тогтуга бэхи, Хэрэйдийн ноёдын нэг болох бөгөөд дутааж ирсэн Арин тайж, Хутуга бэхи-гээр толгойлуулсан Ойрад аймаг, Жадараны Жамуха болон Дөрвөн, Татар, Хатагин, Салжигуд аймгийн үлдэгдлүүд цөм Найман лугаа нэгдсэн байлаа. Нэг л үгээр хэлбэл, Чингисийн мужууд дайснууд бүр энд цуглаад байсан юм.

Чингисийн их цэрэг Саарь хээрт хүрч буудаллаад байлдааныг “хэрхэн хийх” тухай зөвлөлджээ. Энэ зөвлөгөөн дээр Дөдэй чэрби: Бидний цэрэг цөөн бөгөөд замд чилж ирэв. Иймээс энд баахан саатаж, агтаа цатгая. Цэргүүдийг энэ Саарь Хээрт дэлгэн тархааж, шөнө болохуйд хүн бүр таван анги (овоо – хө.) гал түлж, галаар сүр бадруулья. Найман нар хэдийгээр олон боловч, тэдний хан нь гэрээс гарч үзээгүй танхи хүн билээ. Бид галаар сүрдүүлж, тэднийг үлэрхийлтэл (гайхалдаж байх завсар – хө.) бидний агт цадах билээ. Агтаа цатгаад, бид даруй Найманы харуулыг дайрч, гол хүчинд нь хүртэл хөөж оруулаад, тэдний самуурах далимд байлдан орвол болох юм гэж Чингис хаанд дуртган айлтгажээ. Чингис хаан энэ дуртгалыг зөвшөөн авч, “Тийн бөгөөс галуудыг түлэгтүн!” гэж цэрэгтээ засаг тунхаглажээ. Төдий Саарь хээрийг дүүртэл дэлгэн бууж, хүн бүр таван анги гал түлэв.

Байлдааны өмнөх Найманы цэргийн байдал

Шөнө болоход, Найманы харуул Хангар ханы тэргүүнээс олон галыг олж үзээд “Монголыг цөөн гэсэн биш бил үү? Яахин одноос олон гал ноцох буй” хэмээн гайхалдаж, өнөөх барьсан эмээлтэй муу саарал морийг хүргүүлж: “Монголын цэргүүд Саарь хээрийг дүүртэл буужээ.

Өдөр бүр ундрэн (нэмэн) ирж байх нь магад, шөнөдөө одноос олон гал ноцож буй” гэж мэдүүлжээ.

Энэ мэдээг хүргэхэд Найманы Таян хан Хангайн Хачир усун гэдэг газар байж билээ. Таян хан тэр мэдээг олж аваад, Хүчүлүг хан хөвгүүндээ: “Монголын агт туранхай ажгуу, гэвч одноос олон гал ноцож байна гэнэ, Монгол олон ажгуу. Одоо бид улсаа Алтайг давуулан ухарч, тэнд цэргээ засаж, Монголчуудыг өдөөн Алтайн үлгэс (доор) хүртэл чирэлдүүлэн ухарвал, Монголын агт улам туранхлан ядрах тул тэр үед бид тарган цатгалан агтаараа өмнөөс нь довлон орвол дийлж болно” гэж хэлүүлжээ. Гэтэл Хүчүлүг болон Найманы жанжин Хорисүбэчи нар: “Монголчууд хаанаас олон байх буй, Монголын олон Жамуха-г дагаж энд бидэнд баймуй” гэсэн бөгөөд бас Таян ханыг чадалгүй, сөсгүй гэж доромжилж:

“Хүнд эмийн шээх газраа эс гарсан

Хүрдний тугалын бэлчээрт эс хүрсэн

Анай эмс мэт Таян хан

Айж зүрх нь ядран буй за”

гэж хараан элч илгээв гэдэг билээ. Үүнд Таян хан уурлаж, “Тийм бөгөөс хатгалдая” гэж Хачир уснаас хөдөлж, Тамир⁸⁹ уруу явж, Орхон голыг гэтэлж, Наху гуны зүүн хормойд байлдааны фронтод хүрэв.

“Наху гуны байлдаан”-ы сүр жавхаатай

явагдсан байдал

Найманы цэрэг хүрч ирснийг Чингис хааны харуулын цэрэг олж үзэж, “Найман хүрч айсуй” хэмээн мэдүүлсэнд Чингис хаан: “Олноос олон, цөөнөөс цөөн хохирол болмуй” гэж зарлиг болоод, “явахуйдаа харгана мэт нягт, байрлахуйдаа нуур мэт бат, байлдахдаа цүүц мэт хурц” гэж байлдах аргаа тогтоож зарлав. Ингээд цэргээ гурав шатлан ангилжээ.

Нэгдүгээр шатанд Чингис хаан өөрөө манлайлж, хамгийн өмнө Зэв, Хубилай, Зэлмэ, Сүбээдэй дөрвөн хошуучаа, дараагаар нь Уругуд, Мангудын Хадан баатараа тус тус довглуулж, хойноос нь хаан биеэрээ оржээ.

Хоёрдугаар шатанд хааны дүү Хасараар гол цэргээ захируулж байлдуулжээ.

Гуравдугаар шатанд хааны дүү Отчигин ноёноор хөтөлгөө агт зэрэг ар талаа захируулан явуулжээ.

Ингээд Чингисийн хошууч цэрэг Найманы харуулын цэргийг Наху гуны өвөрт бүхий гол хүчинд нь хүртэл хөөж орсон байлаа.

Энэ удаагийн байлдааныг “Нууц товчоон”-д Таян хан, Жамуха хоёрын асууж хариулсан хэлбэрээр үзэгдэм дүрслэг тэмдэглэсэн юм. Хэрэг дээрээ байлдааны явцад чингэж хэлэлцэх

боллолцоогүй юм. Тиймээс тэр нь “Нууц товчоон”-ы зохиогчдоос энэ удаагийн байлдааныг дүрсэлсэн тэмдэглэл болох нь дамжиггүй билээ.

Чингисийн дөрвөн хошууч Найманы харуулыг хөөн довтолсныг “тэр чоно мэт олон хонидыг хотонд хүртэл үлдэн хөөж яваа ямар хүмүүс буй?” гэж Таян хан асуусанд: “Тэнд бидний харуулыг үлдэн ирж бүхий бол Тэмүжин андын дөрвөн нохос бөлгөө. Тэд дөрвөн нохос бол:

Ширмэн магнайтан

Цүүц хошуутан

Шөвөг хэлтэн

Төмөр өртөн

Илд малгайтан

Сүүдэр идэж хий унаж яван тэд.

Алалдахуй өдөр

Аран (хүн)-ы мах идэн тэд.

Хүрэлцэх өдөр

Хүний мах хүнслэн тэд”

гэж Жамуха хариулжээ. “Хэрвээ тийм бол тэр доордуудаас хол байя” гэж Таян хан хойш ухарч уулын хярд хүрэв.

Чингисийн дөрвөн хошуучийн хойноос Уругуд, Мангудын баатарчууд довтлон оров.

Эднийг Таян хан үзээд:

“Эрт тавьсан унага

Эхийнхээ сүүг хөхөж

Эрхлэн торлон наадах мэт

Эрчлэн тоглогч хэн болов?” гэж асуусанд:

“Идэт эрийг хөөж

Илдэт эрийг унагадаг

Цуст хуягийг шувталж

Зэвсэгт эрийг алдаг

Өв тоногийг авагч

Уругуд Мангуд тэд мөн”

гэж Жамуха хариулжээ. “Хэрвээ тийм бол тэр доордуудаас хол байя” гэж Таян хан бас ухран уулын өөд авирав.

Уругуд, Мангудын хойноос хаан биеэр цэргээ авч дайран оров. Түүнийг Таян хан үзээд: “Тэр өөөссөн бүргэд мэт шилмэлжин хошуурч ирэх хэн буюу?” гэж асуусанд:

“Тэр хойноос ирэгч

Тэмүжин анд минь бөлгөө.

Түүний хөвчин бие нь

Ширмээр ширэгдсэн мэт

Шөвөг хатгах завсаргүй

Төмрөөр давтсан мэт

Тэвнэ шивэх зайгүй

Өвч биеэ хуягласан өлөн бүргэд мэт ирэгч

Өмөгт түрүү Тэмүжин буюу”

гэж Жамуха хариулав. “Ай тийн бол аймшигтай байна! Уул өөд авирья” гэж Таян хан бас уул өөд авирч байв.

Чингис хааны хойноос Хасар гол их цэргээ удирдан довтолсон байлаа. Түүнийг Таян хан үзээд: “Бас тэр хойноос нь овооролдсон олон цэргийг удирдан яваа хэн буй?” гэж асуусанд:

“Гурван бухаар зүтгүүлээд

Гуйвашгүй хүчтэй

Гунжин бодыг идээд

Гулгишгүй ходоодтой

Давхарлаж гурав хуяглавч

Дааж чадах биетэй

Хоромсготныг хотлоор залгивч

Хоолойд нь тордоггүй

Өвч хуягт эрийг үмхэвч

Өрц цээж нь өвддөггүй

Өгэлүн эхээс төрсөн

Өөр нэгэн хөвгүүн нь болох

Хүний махаар тэжээсэн

Хүчит Хасар тэр бөлгөө.

Анхаа сумаа тэлж тавибаас

Уул нурууны ар дахийг

Арав хориор нь унагадаг

Уур ихтэй Хасар бөлгөө.

Хийвэр сумаа тэлж тавибаас

Хээр талын хэдэс дэхийг

Хэлхгэл үлхгэл харвадаг

Хэдэр догшин Хасар бөлгөө.

Их шиг тэлж харваваас

Есөн зуун алдад унагадаг

Татан тэлж харваваас

Таван зуун алдад унагадаг

Хүн хүнтэй адилгүй

Хүрэлхү мангас мэт төрсөн

Хүдэр өндөр биетэй

Хүчит Хасар тэр бөлгөө”

гэж Жамуха хариулав. “Ай тийн бөгөөс уулын өндөрт хоргодоё, дээш авирагтун!” гэж Таян хан бас дээш авирав.

Хасарын хойноос, хааны цэргийн ар талыг захирч асан Отчигин ноён урагшилбай. Түүнийг Таян хан үзээд: “Түүний хойноос ирж яваа хэн буй?” гэж асуусанд:

“Эрт унтдаг эрх танхи ч

Эрийн бараанаас хоцордоггүй

Орой босдог отгон танхи ч

Олны байрнаас хожиддоггүй

Өгэлүн эхийн элгэн хайрт

Отчигин гэгч хөвгүүн тэр бөлгөө”

гэж Жамуха хариулав. “Тийн бөгөөс уулын оргил дээр гарья” гэж Таян хан давж дээшээ мацжээ.

Энэ үед, Найманы цэрэг нэгэнтээ шахагдаж, Наху гуны ууланд бүслэгдсэн тул, зусар хулжин Жамуха хэдийн Найманаас салж амь зугатан дутаажээ.

“Наху гуны байлдаан”-ы үр дүн

Чингисийн цэрэг нь Таян ханы цэргийг шат шатаар шахаж, Наху гун уулын оройд гаргаад, орой болсон тул давхар давхар бүсэлж хонов. Шөнө харангуй болсон хойно, Найманы цэрэг бүслэлтийг шувтлан дутаах гээд Наху гуны уул дээрээс халтиран унаж, дээр дээрээсээ даралцаж, ясаа хугалан, амь алдсан нь цөөнгүй байв.

Маргааш нь Таян ханыг мохоож барив (“Судрын чуулган”-д хүнд шархдаж үхэв гэжээ). Хүчүлүг хан астаа (тусдаа – хө.) байсан тул цөөн хүн авч дутаан, Тамир гол хүрч нэхсэн цэрэгт гүйцэгджээ. Ингээд тэр тэнд хүрээ бэхлэлт барин эсэргүүцсэн боловч тэсвэрлэж чадсангүй цааш дутааж Буйруг хан авгадаа очив.

Чингис хааны цэрэг, Найманы улс иргэнийг Алтайн өлгийд мохоож цөмийг эрхтээ оруулж авав.

Жамуха-г дагаж байсан Жадаран, Хатагин, Салжигуд, Дөрвөн, Тайчигуд, Хонгирад түрүүтэн аймгуудын үлдэгдэл цөм Чингис хааныг дагав.

Энэ удаагийн байлдааны онцгой нэгэн амжилт гэвэл, Таян ханы тамгын түшмэл, Уйгурын бичгийн хүн Тататунгаа гэгчийг барьж авсан явдал болно. Түүнийг олзолсноос Чингис хаан тамгын хэрэглэхүүнийг мэдэж, үүнээс хойш тамга хэрэглэснээр барахгүй, уйгуржин монгол үсгийг бүх Монголд дэлгэрүүлсэн явдлыг ч түүнтэй холбож үздэг юм. Хэлэлгээнгүй, монгол хүн үсэг бичигтэй болсон нь үүнээс хол өмнө гэдгийг одоо бараг олноороо санал нэгтэй үзэж

байна. Гэвч уйгуржин үсэг нэгдмэл монгол үндэстний үсэг бичиг болсон явдал энэ үеэс эхлэлээ гэх нь зүйтэй бөгөөд баримттай юм. Энэхүү туйлын чухал түүхэн тэмдэглэл нь “Лу. Алтан товч”-д хадгалагдаж, “Юань улсын түүх” зэргээр нотлогджээ. Манай одоогийн хадгалж бүхий “Нууц товчоон”-д энэ мэдээ байдаггүй нь, “Нууц товчоон”-д тэмдэглэсэнгүй биш, харин манай үед хүртэл хадгалагдсан эх бүрэн биш гэдгийг харуулж байна.

36. Эл аймгийн тэрслүү үлдэгдэл хүчийг устгасан нь

Монгол аймгуудын доторхи хамаг сүүлчийн нэгэн хүчирхэг дайсан Таян ханыг дарж, Найман аймгийг нэгтгэн авсны хойно, Чингис хаан бас морин жолоог таталгүйгээр мохсон дайсны үлдэгдлийг устгахаар газар газарт довтолгож ганц зарим дайсныг дарлаа, зүг зүгт морилж зүйл бүрийн иргэдийг хураалаа.

1204 оны намар, Чингисийн их цэрэг Хар талын язгуурт90 хүрч, Удуйд Мэргидийн түрүү Тогтуга бэхи лүгээ байлдаж дийлэв. Тогтуга бэхи хуучин нутаг Буур хээр өөдөө дутаах гэж Саарь хээрт хүрч иртэл, Чингисийн цэрэг сүүлдэн нэхэж ирээд, ард иргэд, ачаа хөсгийг нь булаан авав. Тогтуга бэхи, Худу Чулуун хоёр хөвгүүнтэйгээ цөөн хүн авч, умард Найманы Буйруг ханы зүг амь зугатан дутаажээ.

Увас Мэргидийн түрүү Дайр усун өөрийн охин Хулан гэгчийг Чингис хаанд татвар хатан болгон өргөж дагав.

Мэргидийг устгасны дараа, Тогтуга бэхи-гийн их хөвгүүн Худу-гийн хатан Түгэй, Дөрэгэнэ хоёроос Дөрэгэнэ-г91 Чингис хаан Өгөөдэй хөвгүүндээ өгчээ.

Энэ үед урьд нэгэнтээ орж өгсөн Удуйд Мэргидийн хагас нь урван явж Тайхал хороо92 гэдэг газар хороолон эсэргүүцэв. Чингис хаан Сорхан шарын хөвгүүн Чимбай-гаар зүүн гар (“Биеэр дайлсан тэмдэглэл”-д баруун гар гэжээ)-ын цэргийг ноёлуулж довглуулав.

Хаан өөрөө баруунш Тогтуга бэхи-г нэхэж, Алтайн өвөр өвөлжив.

Хөхөгчин үхэр жил (1205 он), Чингис хаан дөчин дөрвөн настай байв. Хавар, хааны их цэрэг Алтайн өлгийгээс мордож Улуг тагт хүрэв.

Энэ үед умард Найманы Хүчүгүд Буйруг хан Сохог усны орчим холхин дээрэмдэж байжээ. Чингис хааны их цэрэг гэнэтээр дайрч устгав93. Умард Найманыг мөхөөсөн учир энэ билээ.

Энэ үед Хүчүлүг түшиг тулгуургүй болж, Мэргидийн Тогтуга бэхи-гийн хамт баруунш дутаасан билээ. Чингисийн их цэрэг Арайн даваагаар94 давж, Эрчисийн Бухдурамын95 эхэнд нэхэн гүйцэж байлдан сөнөөв. Тогтуга бэхи-гийн шавын сум (зэрлэг сум)-д оногдож үхсэн тул, түүний хөвгүүн Худу, Чулуун, Мэжэр, Сэтүгэн96 дөрвүүл ясыг нь авч завдсангүй, толгойг нь огтлон авч дутаалаа гэдэг билээ. Энэхүү амь зугтан бүхий Мэргид, Найманы үлдэгдлүүд Эрчис мөрнийг гэтлэхэд хагас илүү нь усанд живэн үхсэн бөгөөд бусад нь бутарч, Хүчүлүг Хар Хятан өөд, Тогтуга-гийн хөвгүүн Кипчак өөд тус тус амь зугтсан байв. Тэндээс Чингис хааны цэрэг Арайн даваагаар буцаж агураг (уг нутаг)-таа буужээ.

Ноднин өвөл Тайхал хороо дахи урвасан Мэргидийг дайлахаар томилсон Чимбай, энэ үед Тайхал хороог байлдан эзэлж, Маудан, Түдаглин, Жэгүн зэрэг Мэргидийг эзлэн авсан мэдээг хаанд хүргэсэн байв.

Урьд Увас Мэргидийн Дайр усун охин Хулангаа хаанд өргөж бууж өгсний дараа, агт үгүй учраас аян дайнд дагалцан явж чадахгүй гэхэд, түүний иргэдийг нь ар талд зуу зуун хүмүүсээр тархан байрлуулсан билээ. Гэтэл эдгээр орж өгөгсөд нь их цэрэг мордсон хойно, ар талын ачаа хөсгийг дээрэмдэж, дахин урвасан байжээ. Үүнд хааны ар талын сахиул цэрэг доор нь дарангуйлж, дээрэмдэгдсэн эдсээ буцаан авсан билээ. Дайр усун Сэлэнгэ мөрний Горхи халуун хавцалд дутаан очиж бэхлэлт барин суужээ (гэтэл ерэн таван мянганы ноёдын гучин зургадугаар дахи Дайр гэгч бол энэ Дайр усун мөн гэж Накамичиё, Ту Цзи, Ли Цзэ Фэнь нар үзжээ. Хун Цзюнь-ий үзэхээр гучин зургадугаар мянганы ноён бол Бухара-гийн дайнд хошуучлан орсон Дайр баатар мөн, харин Хулангийн эцэг биш гэжээ). Үүнийг хаан сонсоод хилэнлэж, Борухул ноён болон Чимбай түрүүтэй баруун гарын цэргээ томилж, Дайр усуныг дарсан бөгөөд Мэргид иргэнийг зүг зүгт нь салган хуваажээ.

37. Жамуха-г эцэслэсэн ба

бүх Монголыг нэгтгэсэн нь

1205 он бол Чингис хаан үлдэгдэл дайсны олонхийг нь дарж, бүх Монголын эл аймгуудыг хураан нэгтгэсэн түүхэн эргэлтийн цаг үе болно.

Энэ үед, ноднин намар “Наху гуны байлдаан”-аас дутаан зугтаасан Жамуха, ард иргэдээ алдаж, цэрэг морио устгагдаад, тавхан нөхөртэйгээ тэнүүчлэн явсаар Тагна ууланд гарч, нэгэн угалз алаад: “Хэний хөвгүүд энэ өдөр угалз алж ийн идмүй?” гэж мухардлын үгээ хэлж, амь гол залган байтал, анд таван нөхөр нь гар хөдлөлцөн барьж аваад Чингис хаанд хүргэн иржээ.

Жамуха нөхөддөө баригдаж ирээд:

“Хар хэрээ халтар нугасыг барих болов.

Харц боол хаан эзэндээ халдах болов.

Бор Хулд⁹⁷ борчин соныг барих болов

Боол зарц босч эзнээ халдах болов.

Богд анд минь юун эндэх”

гэж Чингис хаанд хэлүүлжээ. Жамуха-гийн тэр үгийг Чингис хаан сонсоод: “Өөрийн эзэндээ гар хүрсэн хүнийг хэрхэн уучлах буй? Тийм хүн хэнтэй нөхөрлөх буй? Хаан эзэндээ халдсан харц иргэдийг ураг төрлийг нь хүртэл устга!” гэж зарлиг болов. Ингээд Жамуха-гийн нүд өмнө тэр таван зарцыг нь эцэслүүлжээ.

Чингис хаан бас Жамуха-д: “Өдгөө бид хоёр хамтдав, нөхцөө” гэж хэлүүлжээ. Энэ бол

Чингис хааны уудам цээж, уучлангуй сэтгэлийг нь харуулжээ. Гэвч эцэстлээ дайсагнасан Жамуха эргэх санаагүй байж, түргэн үхүүлэхийг гуйчлав. Ингээд түүнийг өөрийнх нь гуйчлалаар эцэслүүлж, язгууртны заншлаар оршууллаа гэдэг билээ. Гэвч “Нууц товчоон”-оос бусад түүх шастирт Жамуха-г үхүүлсэн тухай тэмдэглэл байдаггүйг энд бас тэмдэглүүштэй билээ.

Багцлаад хэлбэл, тус бүлэгт 1190 оноос 1205 он хүртэлх арван таван жилийн түүхэн явдлуудыг тэмдэглэсэн юм. Энэ арван таван жил бол Чингис хааны хүч буурай байснаасаа хүчирхэгжиж, цөөн байснаасаа олширч, цөөнөөр олныг ялсан дайн байлдааны цаг үе болно. Энэ арван таван жилийн дотор, Чингис хаан дайчин анд нөхөдтэйгээ хамт:

Хурц зэвсгээ тавьсангүй,

Хуяг дуулгаа тайлсангүй,

Хурдан агтнаасаа буусангүй,

Хотол олноо шударгатгажээ.

Хатуу бэрхшээлээс ухарсангүй,

Харгис дайснаас сүрдсэнгүй,

Халуун цусаа хайрласангүй,

Хамаг Монголоо нэгтгэжээ!

Дагалдвар

1 Марко Поло бол Хубилай сэцэн хааны их авд биеэр оролцож явсан бөгөөд түүний тухай маш нарийн ууган тэмдэглэлийг үлдээсэн хүн юм. Түүнээс заримыг нь сийрүүлбэл: Их хаан ангийн цагт нийслэл хотдоо сууж, гурван сард тэндээсээ гарч, зүүн хойд зүгт далайн хөвөөнөөс хоёр өдрийн зайтай газар эчмүй. Нэг түмэн харцгай тавигч хүмүүс дагаж, тэд бас их олон цагаан шонхор, ерийн шонхор ба маш арвин хар харцгай авч яван голын хөвөө дагуу хээрийн амьтныг авламуй. ...Хаан энэ олон хүмүүсийг цөм нэгэн газарт цуглуулах нь бус, харин тоогүй олон бага анги болгон, анги бүрд хоёр зуун хүн буюу эсхүл түүнээс илүү хүмүүсийг хуваамуй. Тэд нь зүг бүрт явж ...авласан амьтны их олонхийг хаанд хүргэн өргөмүй. Үүнээс гадна бас нэгэн түмэн хүмүүс буй ... тэдний тушаал нь харан сахих үүрэгтэй ...энэ үүргээ гүйцэтгэхийн учир хоёр гурван хүмүүсээр нэг бага анги хувааж, харилцан ойр ойрхноор уудам их газарт тархан зогсож хармуй. ...Харцгай тавих зарлиг гарсны хойно, харцгай тавигч нь харцгайгаа дагаж явахын хэрэггүй, юун хэмээвээс өөр нэгэн бүлэг хүмүүсийн тушаал үүрэг болбоос энэ шувуудыг сэтгэл тавин харж, аливаа хураан авч үл болохын газарт нисүүлэхгүйгээр харж буй гэжээ. Ийм их авыг зохион байгуулахад чанга сургуулилгүй бол үнэндээ болохгүй гэдгийг мэдэж болох бөгөөд энэ нь эртээсээ уламжлалтай нь дамжиггүй юм.

2 “Далан Балжигуд” гэдэг газрын тухай Ту Цзи авгай тэмдэглэсэн нь: “Далан” гэдэг үг бол “тал” гэсэн утгатай, “балжуна” гэдэг бол “өмнө” гэсэн утгатай гэжээ. Энэ тайлбар нь ойлгомжгүй мөртөө ямар баримттайг мэдсэнгүй. Энэ газар нь шинэ зурагласан Хар мөрөн мужийн зурагт, Хөлөн нуураас баруун өмнөш байдаг нэгэн бяцхан нуур болно. Түүний нэр нь “Балжуна ус аму” гэдэг. “Өмнөд нуур” гэсэн утгатай. Хэрлэн голын доод урсгалаас салбарлаж, зүүн өмнөш урсдаг “Өргөн Жарам” гэдэг гол энэ нуурт цутгаж буй. Бас энэ нуурын зүүн хойд булгийн амаас мөн “Балжуна” гэдэг гол урсч, Хөлөн нуурт цутгаж буй. Үүнийг “Биеэр дайлсан тэмдэглэл”-д “Худу нуур” гэж, Рашид-ад-Диний номд “Хотон нуур” гэлээ гэж Хун Чжюнь тэмдэглэжээ. Энэ бүр “Хойд нуур” гэсэн монгол үг болно. Нэг нь баруун өмнө, нэг нь зүүн хойно буй, тиймээс өмнө, хойно гэжээ. Энэ удаагийн байлдаан (Арван гурван хүрээний байлдаан) нь “Ба-лэ-чжу-на у-су-э мо”-гоос өмнө талд явагдсан тул “Далан Балжуна” гэжээ. ... Хожим нь Чингис хаан Ван хан лугаа байлдаж, арав есөн хүн мөн энэ нуурын усыг ууж тангараг хийсэн юм гэжээ. Гэтэл зарим тэмдэглэлд “Далан Балжигуд”-ыг одоогийн буриад Монголын доторхи “Балжин нуур”-ын сав газраар байлаа гэжээ. Энэ нь арай хавьтахгүй мэт.

3 “Саарь хээр”-ийг “Биеэр дайлсан тэмдэглэл”-д “Саарь гол” гэсэн нь таарахгүй, харин “Сали-чуань” гэж орчуулбал зохино гэж Накаичиё авгай тайлж байсан бөгөөд Цзинь Ю Цзигийн зохиосон “Умарш дайлсан тэмдэглэл” дэх “Шуан Цюань Хай” гэдэг газар бол даруй Чингис хааны дэгжирсэн газар “Саарь хээр” мөн, анхандаа ордон харш байгуулжээ. Эргэн тойрондоо уул талтай, хоёр нуур байдаг, түүний баруун хойно нь гурван хавцал буй, тэр нь Морин гол гэдэг, Туул гол лугаа нэвгэрдэг гэжээ. Энэхүү ордон харш бол “Тайцзу-гийн шастир”-т гардаг “Саарь хээрийн харилтын аяны ордон” мөн бөгөөд хоёр нуурын нэг нь лав одоогийн газрын зурагт бүхий Хэрлэн голын тохойн баруун өмнөх Харилт нуур мөн гэж Ту Цзи авгай тэмдэглэжээ. “Биеэр дайлсан тэмдэглэл”-ийн монголчлогын тайлбар (11)-д: “Нууц товчоон”-д Саарь хээр гэдэг. Тус тэмдэглэлд хээрийг бүр голоор тэмдэглэжээ. Энэ Саарь Хээр бол Чингис Найман аймгийг байлдахад хоёр удаа буусан Саарь Хээртэй нэр нэг боловч газар адилгүй. Бас Саарь голын Бурхан уул гэдэг нь “Нууц товчоон”-д гардаг Бурхан Халдун уул мөн. Онон, Хэрлэн хоёр мөрний эх авсан уул мөн. “Юань улсын түүх”-ийн “Тайцзу Чингис хааны шастир”-т: Саарь хээрийн Халиутын ордонд нас барсан гэдгийн энэ газар бол одоогийн Хэрлэн голын дээд урсгалын баруун биеэр байх Халиутын даваа, Халиутын гол, Халиутын нуур гэдгийн Халиут болно. Хэрлэнгийн эх авсан газрыг Саарь Хээр гэдэг билээ” гэжээ. Энд дурдаж бүхий “Халиут” гэдэг бол “Нууц товчоон” дахи “Харилт нуур” (“Харилт”-ыг “Аралт” гэж унших ёстой) болно.

Чингис хаан Найман лугаа байлдахад дурдагддаг “Саарь Хээр” бол Х.Пэрлээгийн дурдсан “Идэр, Чулуут” хоёр голоос дороз, Сэлэнгэ Хануйн бэлчээрээс дээш байсан Хунгаржилын хөндий (уртраг нь 101°, өргөрөг нь 49°) мөн байж мэднэ.

4 “Жаламын өвөр өлгий булаг” гэдэг энэ газрыг Ту Цзи: Жалам гэдэг бол бяцхан загас гэсэн утгатай монгол үг юм (энд Жаламыг жарам гэж ойлгон буруу тайлжээ - эшлэгч). Энэ уул бол одоогийн Хөлөн буйрын дэд амбаны цайзаас зүүнш далан газар, Хянган давааны баруун бэлд Жаламтай гэдэг нэгэн эртний цэрэг жагсах ширээ байдаг, Чичигар хотод хүрэх төмөр зам яг энэ газраар өнгөрдөг билээ. Уулын доогуур нь мөн “Жаламтай” гэдэг бяцхан гол умарш урсч Хайлар голд нийлдэг. Энэ бяцхан гол бол даруй “Өлгий булаг”-ийн эрт ба өдгөөгийн адил бус

нэр болно гэжээ. Орчимд Өвөр Монголын нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн ахмад судлаач Элдэндэй багш “Хөлөн Буйр аймгийн доторхи зарим монгол түүхэн газрын нэрсийн тухай магадлалт” гэсэн өгүүлэл (“Өвөр Монголын Нийгмийн Шинжлэх Ухаан” сэтгүүлийн 1980 оны 2 дугаар хугацаа)-дээ: Өвөр Монголын Хөлөн Буйр аймгийн нутаг дахи Биньчжоу төмөр зам (Харбинаас Манжуур хүрэх) дээр нэгэн Жалумт гэдэг галт тэрэгний өртөө буй. Түүнээс баруунш бараг найм, есөн км зайтай арван зургадугаар халааны өртөө гэж байдаг. Энэхүү хаалганы өртөөнөөс Хуйгур, Хайлар гол зүүнээс баруунш урсч байна. Голын араар нь уул нуруу үргэлжилсэн довтог газар юм. Түүний дотор нэгэн хорь, гучин метр өндөр цавчим хад буй. Нутгийн ард үүнийг “Эргэн хад” гэдэг. ... Голын арын довтог газраар тарвага арвин байдаг билээ. ... “Биеэр дайлсан тэмдэглэл” ба “Юань улсын түүх, Тайцзу-гийн шастир” дахи Тэмүжин болон Жамуха-гийн байлдсан Хайлар бол одоогийн Хайлар голыг хэлж байх бөгөөд одоогийн “Тэ-ни Хэ” Тэни гол, “Хо-люэ Хань” гэдэг бол “горхи” (бяцхан гол) гэсэн үг юм. Энэ нь бүр “Жалумт” өртөө ба “Эргин хад”-аас хэдхэн км зайтай байна гэжээ. Ту Цзи-гийн тэмдэглэл дэх “Жаламтай” бол Элдэндэй авгайн хэлж байгаа “Жалумт” гал тэрэгний өртөө болох нь илт байна. Ялангуяа Элдэндэй авгайн өгүүлэлд хавсруулсан газрын зураг нь Ту Цзи авгайн хэлж байхтай бараг адил юм.

Бас нэгэн тэмдэглүүштэй зүйл гэвэл, энэ “Жалам уул”-ыг “Жалам хан” гэдэг бөгөөд Монголын эртний аман зохиол ба бичгийн зохиолд олон хэрэглэдэг байна. Жишээ нь: “Зах нутаг нутаглаж, Чихарай ханыг арлаж, Жалам ханыг өлгийлж ... “ (“Лу. Алтан товч”-д), “Даруйд Адай хаан, Ажай тайж, Аругтай тайш гурвуул эрхлэн морилж, Жалман ханаа Дөрвөн Ойрадыг довтолж олз болгоод” (“Эрдэнийн товч”, 1962 оны хэвлэл, 109 нүүр) гэж бичсэн байдаг бөгөөд баатарлаг туульсуудад ч олон хэлэгддэг билээ.

5 “Хүрэлхү” гэдэг газар бол “Далан Балжус” (Балжигуд)-аас баруунш Сэнгүрийн голын орчим буй. Далан Балжус бол Хөлөн нуураас өмнө байх юм гэж Ту Цзи авгай тэмдэглэжээ.

6 Жамуха-гийн арван гурван аймгийг “Нууц товчоон”-д тоо л байхаас биш нэрийг нь дурдсангүй. “Биеэр дайлсан тэмдэглэл”-д Тайчигуд, Ихирэс, Уругу (Уругуд), Ноёхин, Барулас, Багарин зэрэг зургааг дурджээ. “Судрын чуулган”-д Горлосыг нэмээд долоог дурдав. Гэтэл “Нууц товчоон”-ы сүүлчийн бүлэгт Хонгирад, Хатагин, Салжигуд, Дөрвөн, Татар таван аймаг нь Жамуха-гийн хамт гардаг бөгөөд Хатагин зэрэг дөрвөн аймаг бол Жамуха-гийн шадар болох тул тулалдаан байлдаанаас хоцордоггүй. Тиймээс арван гурвын дотор эд бас байх ёстой. Ингээд бодвол Жадарантай нийт арван гурав болж байна.

Энэ арван гурван аймгийн дотроос Жадаран, Тайчигуд, Ихирэс, Ноёхин, Барулас, Горлос, Багарин, Хонгирад, Дөрвөн зэрэг есөн аймгийг нэгэнтээ түрүүчийн бүлгүүдэд танилцуулсан бөгөөд Татарыг дараагаар тусгай сэдвээр танилцуулна. Одоо Уругуд, Хатагин, Салжигудын тухай доор дөхөм танилцуулъя:

Уругуд овогтон (“Биеэр дайлсан тэмдэглэл”-д “У-лу у” гэж бичжээ) - Чингис хааны наймдугаар үеийн дээд Мэнэн Тудуны долдугаар хөвгүүн нь Начин баатар гэдэг, Начин баатарын ахмад хөвгүүн нь Уругудай гэдэг, түүний үр ач нь Уругуд овогтон болжээ. Энэ Уругудайн зургадугаар үе(Есүхэй баатартай нэг үе)-ийн ач нь Жүрчидэй гэдэг алдартай жанжин байсан юм. Түүний хөвгүүн Гэтэй бол Чингисийн наян найман гавьяатны нэг нь болно. Энэ аймаг хожим нь Мухулайд захируулжээ.

Хатагин, Салжигуд хоёр овогтон - Бугу хатаги-ийн хойч үе нь Хатагин овогтон болжээ. Бухуту Салжи-гийн хойч үе нь Салжигуд овогтон болжээ. Хатагин аймаг нь Хөлөн нуураас дээш нутаглаж байв. Тэмүжиний үед, Хатагины ахлагч нь Баху Салхи гэгч байжээ, тэр Тайчигуд, Жадаран зэрэг аймгууд лугаа холбоолж, Чингис хаантай өшөөлдөн байлдаж байсан бөгөөд Жамуха-г мөхөөсөн хойно, Чингис хаанд орж өгчээ. Бас Хатагин-ы салбар Хардахитай (энэ нэрийн тухай тус бүлгийн дагалдвар71-д лавлаарай) нь анхандаа Хэрэйдийн Ван ханыг дагаж байгаад, сүүлд нь Чингис хааныг дагажээ. Хатагин, Салжигуд аймаг нь Татар аймагтай ойр зэргэлдээ байсан болохоор Татарын холбооны нэгэн гишүүн байжээ. “Алтан улсын түүх” (93 дугаар боть)-д: “Хатагин, Салжигуд зэрэг аймгууд Чжанцзун хааны Мин Чан-гийн тавдугаар он (1194 он)-д Алтан улсын хилийг удаа дараагаар халдсан тул, Хонгирадаас түмэн дөрвөн мянган морьт цэрэг элсэж дайлсанд Хатагин, Салжигуд зэрэг аймаг бууж өгөв” гэжээ.

Салжигуд аймгийн ахлагч нь Чиргидай баатар гэдэг.

Салжигуд аймаг нь Хөлөн нуураас дээш Хатагин аймаг лугаа залгалдан нутаглаж байсан бөгөөд Хатагин, Салжигуд хоёр аймаг нь ер хамтдаа явцгаадаг байна.

7 “Нууц товчоон”-д: “Ихирэсээс Мүдхэ тутаг, Борулдай хоёр Чингис хааныг Хүрэлхү-д бүхийд хэл хүргэн иржээ” гэжээ. Гэтэл Рашид-ад-Диний номд: “Баруласын Мүдхэ, Тутаг хоёр урьдаар өөр учраар ирж, буцахуйд нүүн завшаанаа томилон ирүүлж чимээ хүргэсэн билээ” гэжээ. Энд “Борулдай” гэсэн хүний нэрийг овгийн нэр “Барулас” болгожээ. Бид “Нууц товчоон”-ы тэмдэглэлийг баримтлав.

8 “Биеэр дайлсан тэмдэглэл”-д: “Өгэлүн эх хатан хийгээд Чингисийн дүү нартай нийлж гурван хүрээ болж” гэж тэмдэглэж байна. Энд Рашид-ад-Диний номыг үндэслэж нэгдүгээр хоёрдугаар хүрээ болгожээ.

9 “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д: “Хачигуны хойч Бүлтэчү баатар” гэж, Хонда Санаинобу-гийн өгүүлэлд: “Хабул хааны ах (Хачигун, Сэм Сэчүлэ)” гэжээ. “Нууц товчоон”-ы тэмдэглэлээр бол Хабул хаанд ахгүй бөгөөд ганц дүү нь Сэм Сэчүлэ юм. “Хачигун” бол Хабул хаанаас дээр дөрвөн үе болно. Тиймээс би “Нууц товчоон”-оор баримтлал болгов.

10 Дөрөвдүгээр хүрээн дэх “Сүйхэтү ноёны хөвгүүн Даран” гэснийг Хонда Санаинобу-гийн өгүүлэлд “Сорхату ноён”, “Дэлэнги” гэж хоёр өөр хүн болгожээ. Энэ нь овогтойгоо таарахгүй юм. Тиймээс бид Ту Цзи авгайн тэмдэглэлийг баримтлал болгов.

“Будагад” овогтон бол Мэнэн Тудуны зургадугаар хөвгүүн Харандай-н үр ачаар бүрэлдэв. Харандай-н хөвгүүн нь будаад хутгалдах адил эх түрүүгүй тул Будаган овогтон гэж нэрлэжээ.

11 “Биеэр дайлсан тэмдэглэл”-д: “Жалайр, Ахад аймаг нийлж нэг хүрээ болж” гэж тэмдэглэж байна. Гэтэл Монголын овог аймгийн дотор “Ахад” аймаг гэж ер харагддаггүй билээ. Тиймээс энэ нь Жалайрын Архай Хасар гэсний “Архай” гэдэг үгийг эндүү бичсэнээс боллоо гэж Хун Цзюнь авгай залруулжээ.

12 Зургадугаар хүрээнийг “Биеэр дайлсан тэмдэглэл”-д бүр орхигдуулжээ. Рашид-ад-Диний номд тав, зургадугаар хоёр хүрээнийг нийлүүлэн бичжээ. “Сорхату” гэснийг биедээ мэнгэт

хүн гэж тайлжээ. Энэ нь таарч байна. Тиймээс “Нууц товчоон”-д Охин Бархаг-ийн хөвгүүнийг “Хутугту Жүрхи”, “Сорхату Жүрхи” гэж хоёр янзаар тэмдэглэсэн учир энэ билээ.

13 “Нэгүс Хорихан” гэдэг нь чухамдаа “Нэгүс горхи” гэсэн усны нэр билээ. Энэ нь Хөлөн нуураас баруун хойш далан газарт байдаг. Одоо “Чоно шавартах” гэдэг. Бодоход Чонос овогтон нутаглаж байснаар ингэж нэрлэсэн ч байж мэднэ. “Нэгүс Хорихан” гэдэг нь сүүлдээ чонос овогтны нэг салбар болжээ.

“Тугулдай” овогтон бол Мэнэн Тудуны отгон хөвгүүн Начин баатарын хөвгүүн Тугулдайн үр ачаар бүрэлджээ.

14 Арван хоёрдугаар хүрээнийг “Биеэр дайлсан тэмдэглэл”-д бүр орхигдуулжээ. Энд тэмдэглэж бүхий “Тахай баатар” ба “Нууц товчоон”-ы дөрөвдүгээр ботид гардаг Сүлдүс овогтны Тахи, долдугаар ботид гардаг “Тахай баатар” гэдэг нь бүр нэг л хүн болох мэт.

15 “Гэндү чоно” гэдэг бол азарган чоно гэсэн үг юм. Гэвч энд “Гэндү чоно”, “Өлөгчин чоно” гэдэг нь “Бөртэ чоно”-той адилаар хүний нэр болно. Тиймээс утгачлан орчуулж болохгүй билээ. Эд бол Чонос овогтон, даруй Нэгүс овогтны дээдэс болно. Энэ Чонос овогтон бол анхандаа Тайчигудын харьяат байсан бөгөөд Жамуха-гийн ноёрхлоос салж Чингис хааны талд орсон болохоор Жамуха болон Тайчигуд нар тэднийг туйлаар хорсч байв. Энэ удаагийн байлдаанд Чингис хаан дийлэгдэж, Жамуха-д баригдсан Чонос (нэгүс) овогтныг туйлын харгис хэрцгийгээр тамлаж алжээ. Гэвч “Биеэр дайлсан тэмдэглэл”-д: “Түүний (Жамуха-гийн) цэрэг хоёр уулыг даваад зам зуураа далан хоёр зуух галлаж” чоно (Чонос овогтныг хэлж буй - эшлэгч) чанаж идэв” (Б.Баганын монголчилго, 15 нүүр) гэсэн нь хэтэрхий бүдүүлэг тэмдэглэл болох бөгөөд монголчлогч ч түүнийг анхааран залруулсангүй нь харамсалтай.

16 Березин “Арван гурван хүрээний байлдаан”-ы байлдах аргыг доорхи мэт дурджээ. Энэхүү туйлын аюул түгшүүртэй хоромхон үед, Тэмүжин хэзээд хэрэглэж байдаг энгийн байлдах аргаа бүрмөсөн орхив. ...Монголын залуу командлагч Тэмүжин, түүний байлдааны журмаа бүрэн өөрчлөв. Энгийн байлдах арга бол бүх тэрэг хөсгөө жагсаалынхаа төвд төвлөрүүлэн, давхар давхар бэхлэлт болгож, гэр малаа энэхүү тэргэн жагсаалынхаа дунд тавьж, байлдагчид нь энэ жагсаалаасаа гарч байлддаг буюу эсхүл ухран ирээд энэ жагсаалаараа хамгаалалт болгон хориглолт хийдэг юм. Гэтэл энэ удаа Тэмүжин зарлиг буулгаж, тэргэн жагсаалыг түүний нэгэн жигүүрийнхээ захад байрлуулж, тэндэхийн хориглолтыг голдуу нум сумаар зэвсэглэсэн эмс хүүхдэд найдсан бөгөөд өөрийн командлаж байсан арван гурван хүрээний гол цэргээ зэрэгцээ эгнээгээр жагсааж, цэргийн хүрээнийнхээ нөгөө жигүүрийг дайсны морьт цэрэг ойртож үл чадах ой шугуйт бартаа бүхий газар байрлуулсан байв. ...Зуун морьт цэргийг фронтоороо ба гүн тийш бүр арав арваар жагсаажээ. Фронтдоо ба хажуу талдаа хүнд бэх морьт цэргийг байрлуулжээ. Энэхүү хүнд бэх морьт цэрэг гэдэг нь биедээ төмөр хайрст арьсан хуяг өмссөн, мориндоо цулгуй арьсан нөмрөг нөмөргөсөн цэргийг хэлж байна.

Тайчигуд нар гүн тийш таван мөрөөр жагсаасан өргөн фронтын байлдааны журмаар ойртож ирлээ. Түүний нэгдүгээр, хоёрдугаар эгнээ нь хуягт морьт цэргээр зохион байгуулагджээ. Жагсаалаасаа хөнгөн морьт цэргээ тавин явуулахын тулд, хуягт морьт цэрэг нь түргэн зогсох хэрэгтэй болжээ. Хөнгөн морьт цэрэг гэдэг нь зөвхөн зөөлөн сур хуяг өмсч байдаг. Эдгээр хөнгөн морьт цэрэг нь үүрээсээ салсан зөгий мэт овооролдон ирж, монгол цэргийн өөд цас

лавс мэт сум харвахын зэрэгцээгээр жад сэрээ явуулж байв.

Тэмүжиний цэрэг самууралгүйгээр байраасаа жад сэрээ явуулах ба нум сум харваж, хөдлөшгүй эсэргүүцэн байлдаж байв. Монгол цэрэг нь тогтсон байрнаас харваж байсан болохоор нэг л адил зэвсэг боловч, Тэмүжиний цэргийн онолт сайн, алж шархдуулсан нь олон тул Тайчигуд нар хариуцаж чадахгүй болмогцоо хойш ухарчээ (“Их удирдагч Чингис хааны нууц” гэдэг япон номоос дам эшлэв).

17 Энд дурдаж бүхий “өрхэ” (oroh) бол зүүн тал нь Кэнь голын эхээс эхэлж, баруунш Улаанбаатар хот хүрдэг юм. Одоогийн Эргүнэ голоос барууншихи Дундад Зөвлөлт хоёр улсын хилийн харуулын овоог их төлөв энэхүү “өрхэ”-гийн шугамаар байрлуулжээ. Гучин газар бүрд нэг буюу хоёр цайз зэргэцэж байдаг, цайз бүрд хорин өрх айлыг багтаадаг. Умард Вэй улсын “У-лу-ху”, Тан улсын “У-люэ-хо” ба Ляо улсын гаднахи “У-гу” гэдэг нь цөм үүнийг уламжлан нэрлэжээ. Монголчууд “өрхэ” буюу “бор хэрэм” гэж нэрлэдэг.

“Ононы Жэрэнэ Хавцгай” гэдгийг Ц.Дамдинсүрэн “Ононы Зээрэн хавчил” гэж, “Лу. Алтан товч”-д “Ононы Чирэнэн хавцгай” гэж, Дорнотив “no-no-ne che-rie-nie ha-p(h) ch'i-ha-ia” гэж, Ту Цзи “во-нань ту-лянь чжэ-ле-не-ай” гэж тэмдэглэцгээж байна. Энд “хавцгай-а” гэдэг эртний монгол үг бол “хавцгайд” гэсэн утгатай үг болох нь тодорхой бөгөөд одоогийн ухагдахуунаар “хавцал” гэсэн үг болох нь ч илэрхий байна. “Энэ газрын бодтой байрыг одоогийн Хөлөн буйрын баруун хойд хил дээрх тавин гуравдугаар овоог “Жэрэнтү” гэдэг, энэ нь харин эртний “Жэрэнээ” (энэ “жэрнэ” гэдэг нь бас “жэрэнэ-д” гэсэн үг мэт. Тиймээс уул нэр нь “жэрэн” гэсэн байж мэднэ)-гийн хавцал бололтой” гэж түүхч Ту Цзи тэмдэглэв.

18 Татар аймгийн салбаруудыг түүх шастир, ялангуяа хятад түүх шастирт нэлээд будлиантайгаар бичиж буй. Энд бид голдуу “Нууц товчоон” ба “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д дурдсанаар баримтлал болгов. Айригуд Татар, Буйругуд Татарыг “Нууц товчоон”-ы 53 дугаар зүйлд, Цагаан Татар, Алчи Татар, Дутагуд Татар, алухай Татарыг “Нууц товчоон”-ы 153 дугаар зүйлд тус тус дурдаж буй. Жүйн Татар ба Алтан Татарыг “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д дурдаж буй. “Ту Цзи-гийн тэмдэглэл”-ийн 153 дугаар ботийн Монголын овог аймгийн бүлэгт нэгэн “Гуй-ань” гэдэг Татарын салбарыг тэмдэглэжээ. Гэвч энэ нь гол зохиолдоо ер харагддаггүй бөгөөд гол зохиол дахи “Жүйн Татар” нь овог аймгийн бүлэгтээ дурдагдсангүйг үзэхүл, энэ нь нэг нэрийн хоёр янзын бичлэг бололтой.

19 Чингис хаан Алтан улсын цэрэгтэй хамтран, нэгдүгээр удаа Татар аймаг лугаа байлдсан цагийг “Судрын чуулган” ба “Д`Оссоны түүх”-д бүр хөх барс жил - 1194 оноор тэмдэглэж байна. Энэ нь бараг Алтан улсаас Хатагин, Салжигуд аймгийг дайлсан цагийг хэлж байх мэт. Бид энд 1196 он гэж байх нь “Алтан улсын түүх”-ийн Чжанцзун хааны шастир болон Онгин Чинсаны намтрын тэмдэглэлээр баримтлал болгов.

20 “Дээд нийслэл” гэдэг бол Алтан улсын эхний үеийн нийслэл Хуй Нин Фу-г хэлж байна. Түүний хуучин ор нь одоогийн Хармөрөн мужийн А Чэн-ээс өмнөх Цагаан балгас болно. Алтан улсын эхний үед Хятаны журмаар Лин Хуан Фу-г дээд нийслэл гэж байв. Сүүлд нь 1138 онд үүнээ Умард нийслэл гэж нэрлээд, уулын нийслэл Хуй Нин Фу-гээ Дээд нийслэл гэж нэрлэжээ. 1157 онд дээд нийслэл гэдэг нэрээ үгүйсгэж, 1173 онд дахин сэргээжээ.

21 “Жүйн цэрэг” гэдэг бол Хятан болон Алтан улсын үед хил хязгаар дахи аймаг угсаатнаар зохион байгуулсан нутгийн цэрэг болно. “Алтан улсын түүх, түшмэдийн тэмдэглэл”-д: эл Жүйн цэрэгт Сэнгүм (Сян Вэнь) тушаалтан нэгэн нэр тавьж, ... хилийн цайзыг сэргийлэн сахина гэсэн тэмдэглэл байдаг бөгөөд “Алтан улсын түүх, газарзүйн тэмдэглэл”-д: Есөн газар Сяан Вэнь-ий байгуулалтай гэж тэмдэглэж буй. Алтан улсын энэхүү жүйн цэрэг нь 1214 онд Монгол улсад бууж өгсөн бөгөөд Чингис хаанаас түүнийг Боорчу, Мухулай хоёрт хуваан өгч захируулжээ.

22 “Дундад улсын нэвтэрхий түүх”-ийн зургадугаар дэвтэрт Татар аймгийн түрүүг “Се Чу” гэж тэмдэглэж буй. Бид “Алтан улсын түүх, Чжанцзун хааны шастир”-аас: “Чэн Ань-ий гуравдугаар оны хоёрдугаар сарын улаан нохой өдөр Се Чу бууж өгөв” гэдэг тэмдэглэлийг олж үзлээ. Энэ Чэн Ань-ий гуравдугаар он бол 1198 он болно. Энд хэлж байгаа “Се Чу” бол Жүрхиний Сача бэхи мөн. Тиймээс Се Чу бол Сюэ Чу-гийн ондоо бичлэг болох нь илэрхий байна. Татарт Се Чу гэдэг түрүү ер байгаагүй тул энэ нь лав ташаа болжээ. Бид бас л Мэгүжин сүүлтээр тэмдэглэв.

23 “Лин Хуан” гэдэг бол Фу-гийн нэр мөн. Түүний эртний ор нь одоогийн Өвөр Монголын Өөртөө Засах Орны Багарин зүүн хошуунаас зүүн өмнө байдаг бор хот болно. Энэ нь Хятаны дээд нийслэл байжээ. Хот нь Шар мөрний захад байснаас Лин Хуан гэдэг нэртэй болжээ. Энэ бол Елюй Абужи (Хятаны анхдагч хаан)-гийн үүсгэсэн газар юм. Хот нь Алтан улсын сүүлчээр эвдрэн сүйджээ.

24 “Улз гол” гэдэг, нэрийг “Онгин Чинсаний намтар”-т: “Ва Ли Чжа” гэж, тус зууны хориод оны газрын зурагт: “У Эр Цзай” гэж тэмдэглэж байдаг бөгөөд Халхын угийн Цэцэн хан аймгийн баруун гарын зүүн хошууны газар гэжээ. Х.Пэрлээгийн мэдээлснийг үндэслэвэл, одоо “Улзын гол” буюу “Улзын бүрд” гэдэг байна. Ц.Дамдинсүрэн “Улз” гэж галиглажээ. Бодтой байрын уртраг нь 112°, өргөрөг нь 48°-т буй.

25 “Хуст шүтээн” ба “Нарт шүтээн” гэдгийг Ц.Дамдинсүрэн “Хусуту шитүэн” “Нарату шитүэн” гэж галиглажээ. “Биеэр дайлсан тэмдэглэл”-д: “Нарт шүтээн, хорьт шүтээн” “ху-ла-ту ши-ту” гэжээ. Энэ нэр дэх “ла” гэсэн нь “си” гэсний ташаарал болно. Монголчилго нь мөн бурууджээ. Үүний бодтой газар нь мөн Халхын угийн Цэцэн хан аймгийн баруун гарын зүүн хошуунд байжээ. Үүний тухай Х.Пэрлээгийн “Монгол улсын хуучин дурсгалт зүйлийн картын сан”-д:

Зүүн Монголчууд, цаг цагт хурал хурдаг бяцхан хийдийг шүтээн гэдэг бөгөөд мөн одоо дотоод Монголд бөөгийн мөргөлийг шүтээн гэдэг гэнэ. Үүнээр үзэхэд, арван гуравдугаар зууны үеийн зарим монгол аймгуудад бөө мөргөлийн ёсыг гүйцэтгэдэг суурин газар байсан нь илэрхий. Арав есдүгээр зууны сүүлчээр, “улз”-ын хөвөөн дээр “мөст шүтээн” гэдэг сууриныг байгуулж орос, хятадын худалдаачид сууж байсан ба хоёрдугаар зууны эхээр орос нутагт гаргах экспортын мал тушаах газар болгож байсан байна. Энэхүү суурины ойр нэгэн чулуун барилгын үлдэгдэл буй гэдэг гэж тэмдэглэж буй.

26 Алтан улсаас Чингис хаанд өргөмжилсөн “Жүйтхури” гэдэг цолыг Ц.Дамдинсүрэн “Чаутхури” гэж, Баяр “Зууд хури” гэж тус тус галиглажээ. Энэ цолын чухам ухагдахууны тухай өдий болтол нэгдэлтэй тайлбар үгүй байсаар бөгөөд янз бүрээр таамаглан жишиж байна.

Янз бүрийн бодтой хэллэгийг нөхөр Дорнотивийн “Нууц товчоон”-ы шинэ хятадчилгын 10 дугаар нүүрт нэлээд өргөн тэмдэглэж байна. Багцлаад хэлбэл, “Хүчит ноён”, “Чжао Тао Ши”, “Зуутын дарга”, “Цзе Дү Ши”, “Хан Хэн Дуй Чжан”, “Жүйн цэргийн захирагч” - “Дундад улсын нэвтэрхий түүх”-ийн зургадугаар дэвтэр, “Хошууч Селин ноён” (Владимирцов, Цю Шу Сэнь) гэх зэрэг олон хэллэг буй. “Чжо То Ши” гэдгийг Ту Цзи авгай үгүйсгэжээ. Учир нь Онгин Чинсан буцахдаа: Чингис хаанаа үүнээс их нэр нэмэхийг, Чжао Тао нэр өгөхийг Алтан хаан мэдтүгэй гэж хэлснээс үзэхүл “Чжа-у-ти, ху ли” нь “чжо-то-ши”-гаас бага тушаал байжээ гэв. “Зуутын дарга” гэдэг монгол цолыг нөхөр Дорнотив үгүйсгэж: “Алтан улс нь монгол үгээр цол өргөмжлөх явдал сэтгэгдэшгүй юм. Тиймээс энэ бол монгол дуудлагатай болсон хятад үг болно гэжээ. Ту Цзи болон Дорнотив нарын үгүйсгэлийг би зүйтэй гэж үзэж байна. Тиймээс энэ нь нэгд монгол үг биш, хоёрт дэмий их цол биш. Тийм их цол бол Онгин мэтийн түшмэл өгч чадахгүй юм. “Дундад улсын нэвтэрхий түүх”-д дурдаж бүхий “цзю цзюнь тун сюэ” гэдэг нь нэлээд ойртож байх мэт. Энэ “цзю” үсгийн авиа бол (jiu) (Жю буюу жюй) гэдэг бөгөөд “Нууц товчоон”-ы “чжа у” гэсэн лүгээ ойртож байна. “Ху-ли” гэдэг бол Жүрчин үг, “Алтан улсын түүх, түшмэдийн тэмдэглэл”-д “хэдэн аймгийг захирах тушаалтныг “ху-лу” гэнэ” гэжээ. Тэрчлэн энэ “Жүйн цэрэг” гэдэг нь хил хязгаарын аймаг угсаатнаар зохион байгуулагдсан цэргийг нэрлэдэг. “Жүйн Татар” ч ийм шинжтэй мэт. Тиймээс Чингисийг “Жүйн цэргийн захирагч” гэсэн утгаар нэрлэх нь зүй ёсны хэрэг мэт. Ингээд би “жахудхури” гэсэнгүй, харин “жүйтхури” гэж галиглав.

27 “Нууц товчоон”-ы 130 дугаар зүйлд “Буурч Шихигүр” (Ши-ги У-ли энэ “ли” үсэг бол “эр” үсэг “и” тийн ялгалтай нийлээд бүтжээ) гэдэг хүн илэрлээ. Гэтэл 120 дугаар зүйлд Тэмүжинд дагаар ирсэн хүмүүсийн дотор Горлос аймгийн “Сэчэгүр” гэдэг нэгэн хүн байжээ. Өмнө бас “Шихигүр” гэдэг хүн дурдсангүй тул, энэ буурч бол “Сэчэгүр” болов уу гэж нэгтгэн бичээд, энд хяналт болгон тэмдэглэв.

28 “Ононы түн” гэдэг нь “Ононы шугуй” (Ц.Дамдинсүрэн) гэсэн үг болно. Энэ газар “Ононы жэрэнэ хавцгай”-гаас ойр байх ёстой.

29 Эбэгэй-г “Нууц товчоон”-ы баримжаа дэвтэрт “Сача бэхи-гийн бага эх Эбэгэй” гэж, Ц.Дамдинсүрэн “Сача бэхи-гийн бага эхнэр Эбэхэй” гэж, “Биеэр дайлсан тэмдэглэл”-д “Түүний хоёрдугаар эх хаган Ибэхэй” гэж, “Юань улсын түүх”-д “Хоёрдугаар эх Ебэхэй” гэж ондоо ондоогоор тэмдэглэж буй. “Эбэгэй бол Сорхату Жүрхи (Хутугту Жүрхи - эшлэгч)-гийн татвар эм, Сача бэхи-гийн төрсөн эх нь хэмээвээс зохих мэт” гэж Накамичиё авгай үзжээ. Миний үзэхээр мөн ч Сача бэхи-гийн эх гэх нь зүйтэй.

30 Хорижин хатан, Хугурчин хатан чухам хэний хатан гэдгийг манай тулгар бичигт дурдаагүй. “Биеэр дайлсан тэмдэглэл” ба “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д: “Сача бэхи ба түүний эх Хорижин хатан” гэжээ. Ту Цзи-гийн тэмдэглэл нь “Биеэр дайлсан тэмдэглэл”-ээс эшлэсэн нь илхэн байна. Гэтэл түрүүчийн тэмдэглэл нь ямар баримттайг мэдсэнгүй. “Бичигт тэмдэглэгдэж байгаа байдлаас нь үзэхүл, Хорижин Хугурчин хоёр хатны алин ч Сача бэхи-гийн төрсөн эх биш, хэрвээ түүний нэг нь Сача бэхи-гийн төрсөн эх байсан бол тэр хэрүүл үүсэхгүй” гэж нөхөр Дорнотив тайлжээ.

31 “Харилт нуур” (Ха-линь-лэ-ту на-у-ла)-ыг Ту Цзи “ха ли лэ ту на у эр” гэж, “Биеэр дайлсан тэмдэглэл”-д “ха лянх ту цзэ” (монгол нь “Халиут нуур” гэж буруу орчуулсан мэт)

гэж, хориод оны газрын зурагт “хэ ло тай бо” гэж бичигдэж буй. Энэ газрыг Бурхан Халдуны өвөр, эртний “Хүрэлхү”-д байсан бөгөөд Хэнтийн уулс дунд байсан хэдэн нуурын нэг нь мөн бололтой гэж Х.Пэрлээ мэдээлжээ. “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д: “Харилт нуур” бол Хэрлэн голын тохойноос баруун өмнө байна, анхандаа Жочи Дармала (Жамуха-гийн дүү) нутаглаж байсан, сүүлд нь Чингис хааны хоёрдугаар ордныг энд байгуулжээ. “Юань улсын түүх”-д “Саарь Хээрийн харилт дахи ордон” гэдэг нь үүнийг хэлжээ гэв.

32 “Хэрлэнгийн хөдөө арлын долоон болдог” гэдгийн хөдөө арал бол Халхын угийн Цэцэн хан аймгийн тус хошуун дахи Баян-Улаан уул мөн бөгөөд түүний өмнө бэл дэх долоон толгойн нэгийг нь “то линь шань” гэдэг. Энэ нь даруй “Долоон болдог” буюу “Биеэр дайлсан тэмдэглэл” дэх “до-лянш пань-то шань” мөн. Хожим нь Чингис хааны нэгдүгээр их ордныг энд байгуулсан юм гэж Ту Цзи тайлбарлав. Гэтэл Ту Цзи авгайгаас бараг дөчин жилийн сүүлд, ялангуяа Ту Цзи-гийн зохиолыг олж ашиглаагүй Монголын алдарт эрдэмтэн Ц.Дамдинсүрэн түүнийг орчин цагийн монгол хэлээр орчуулсан “Нууц товчоон”-ы оршилдоо энэхүү “Хэрлэнгийн хөдөө арал”-ын тухай ингэж дурдсан байна:

“Миний санаваас Хэрлэнгийн хөдөө арал гэдэг нь Улаанбаатараас зүүн өмнө Баян-Улаан гэдэг уул мөн бололтой. Энэ уул, Монголын дунд хээр талын бүслүүрт урагш шургаж орсон өндөрлөг их уул бөгөөд өвс усаар маш элбэг. Хэрлэн бол Хэнтийгээс гарч баруун урагш урсаад зүүн тийш эргэсэний доторхи нэгэн их тохойд орших бөгөөд дотроо хэд хэдэн булаг ус буй. ...Хэрлэнгийн тохойд буй энэ уулын зүүн сугаар Цэнхэрийн гол(урьдын Сэнхүр горхи) урсч урагш явсаар Хэрлэнд нийлэх тул тэр уулыг нэгэн их арлын хэлбэртэй болгоно. Түүнээс гадна ой модтой Хангай газраас ялгаварлаж, тал хээр газрыг Монголчууд хөдөө газар гэж нэрлэдэг удаа байна. Ийм учраас хөдөө арал гэдгийг хээрийн арал, талын арал гэж ухаж болмоор. Ингэвээс энэ уулыг хөдөө арал гэж хэлэхэд бүр ч зохимжтой байна. Хөдөө арал гэдэг Баян-Улаан уул мөн болохын тухай өөр нэгэн ташрамын баримтыг хэлбээс, нэгэн мянган есөн зуун хорин хэдэн оны үед Данжин хэмээгчийн зохиосон “Эрдэнэ чандманийн хүү сан” хэмээх бичмэл цагаан толгойн дотор хэлсэн нь:

“Тэмүжин хорин найман насандаа Хэрлэнгийн хөдөө арал Дэлгэр хаан хэмээх газраа нийслэл орд байгуулж, бүх Монголын хаан ширээнээ суув” хэмээжээ.

Үнэхээр Баян-Улаан уулын хоёр оргилын нэгийг Баян хаан, нөгөөг нь Дэлгэр хаан гэдэг байна. ...Тэндэх ардууд өөрийн сумыг Дэлгэрхан гэж нэрлэжээ. Данжин, өөрийн цагаан толгойн эцэст бичсэн нь: “Монгол судар дэвтрүүдээс эвлүүлэн холбож бичив” хэмээжээ.

Дээрх хоёр тайлбарлал, нэг нь дөхөмхөн, нэг нь нэлээд нарийн тодорхой боловч хоёрын гол учир нь нэг л адил байна.

33 “Тэрсүд” гэдэг газар бол Халхын угийн Түшээт хан аймгийн Хан уулаас өмнө, Ав далан уулын орчим байсан бололтой гэж Ту Цзи тэмдэглэжээ.

34 “Тэлэтү амсар” гэдэг газрыг “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д: “Халхын Түшээт хан аймгаас Чуулалт хаалга орох цэргийн өртөө замд байвал зохих билээ” гэжээ. Х.Пэрлээгийн тэмдэглэлийг үндэслэвэл: уртраг нь 112°, өргөрөг нь 47°-ын уулзварт “Тэлүтү” гэдэг газар байдаг гэнэ. Энд Тэлүтү-гийн хийд гэж байсан ба одоо Баян овоо сумын төв болжээ. Энэ

газраар Монголын дорнод их зам өнгөрдөг. Тиймээс энэ “Тэлүтү” гэдэг газар харин эртний “Тэлэтү амсар” байж мэдэх юм гэлээ. Х.Пэрлээгийн мэдээлсэн Монголын дорнод их зам гэдэг нь Түшээт хан аймгаас Чуулалт хаалга орох өртөө замыг хэлжээ.

35 Чингис хаан Жүрхинтэй байлдаж Сача бэхи, Тайчу-г алсан тухай бид “Ту Цзи-гийн тэмдэглэл”-ийг баримтлав. Энэ тухай өөр тэмдэглэлүүдэд баахан зөрөөтэй бичиж буй. Энд лавлалт болгон тэмдэглэв. “Судрын чуулган”-д “Луу жил (1196 он)-ийн өвөл, Жүрхиний Сача бэхи, Тайчу нар Тэлэтү амсар гэдэг газар тархан нутаглаж байх үед хаан (Чингисийг хэлж буй - эшлэгч) болон Ван хан цэрэг нийлэн довтлож эчээд алав” гэжээ. Гэтэл Жүрхинийг устгах үед Ван хан нэгэнтээ Хар Хятанд дутаагаад байсан тул хэрхэн Чингистэй хамтарч байлдах аж. Тиймээс нь энэ нь харин Ван ханы дүү Жаха Гомбу-гийн хамтран байлдсаныг тэмдэглэхдээ “дүү Жаха Гомбу” гэдгийг нь гээгдүүлсэн магадгүй. Энэ тухай “Нууц товчоон”-ы тэмдэглэл бол: “Жүрхин нарыг Хэрлэний Хөдөө арлын Долоон болдог гэдэг газар байхад дайран орвол Сача бэхи Тайчу хоёр цөөн хүмүүсийг авч дутаав. Хойноос нь нэхэж Тэлэтү ам хэмээх газраа гүйцэж, Сача бэхи Тайчу хоёрыг барив. ... Тэдний урьд хэлсэн үгийг сануулж, хэлсэн үгэнд нь хүргэж тэднийг бүтээж алав” (Ц.Дамдинсүрэнгийн одоочлогоор сийрүүлэв) гэжээ. “Биеэр дайлсан тэмдэглэл”-д: “(Чингис хаан) Их хээр хэмээх газраас мордож Долоон болдог хэмээх газар хүрч Жүрхин аймгийг их л уулгалж, ганц Сача бэхи, Тайчу эхнэр хүүхэдтэйгээ хэдүүлхэн бултран дутаажээ” гэсний дараа, Жаха Гомбу дагаар ирж хамтран Мэргидтэй байлдсан ба Ван хан яаж дутааж, яаж ирсэн хүртэл олон бичиж, “мөн жилийн өвөл Чингис Жүрхиний аймгийг дайлахуйд урьдаар Сача бэхи, Тайчу дутаажээ. Тэлэгэтү-гийн хавцал хүртэл нэхэж сөнөөжээ” гэж тэмдэглэж буй. Энэ нь “Нууц товчоон”-ы 136 болон 150 дугаар зүйлийг нийлүүлэн тэмдэглэсэн явдал болно. “Нууц товчоон” ч нэг явдлыг хоёр явдал болгон бичсэн шиг байна. Жаха Гомбу-гийн дагаар ирсэн цагийг 1202 оны явдал болгожээ (150 дугаар зүйлд). Тиймээс Ту Цзи-гийн залруулалт нь зүйтэй мэт.

36 “Алтан улсын түүх, Чжанцзун хааны шастир”-т: “Чэн Ань-ий гуравдугаар он (1198 он)-ы хоёр сарын улаан нохой өдөр, Сача дотогш дагав. Өвлийн арван сарын харагчин хонин өдөр, Шу Ми Юань-ий мэдүүлсэн нь, Сача нар захын дэлгүүр нээхийг Ша Ли Няо-гоос гуйчилжээ, зөвшөөрөв” гэж тэмдэглэж байх бөгөөд “Онгин Чинсаны намтар”-т: “Түүний хойно Сача-гийн аймаг Фу чжоу-д очиж бууж өгөв” гэж тэмдэглэж буй. Энэ Фу чжоу гэдэг бол Алтан улсын нэгэн чжоу болно. Захиргаа нь одоогийн Хэбэй мужийн Чжанбэй-д байжээ. Түүний харьяат газар нь Чжанбэй-ээс баруунш, одоогийн Цзинин хотоос зүүнших орнууд болно. Дээрх тэмдэглэлээс бид Сача бэхи, Тайчу нар Чэн Ань-ий хоёрдугаар он (1197 он)-д үхсэн бөгөөд түүний харьяат Жүрхиний зарим үлдэгдэл нь 1198 оны хоёр сард Алтан улсад орж өгөн ба арван сард нь Алтан улс лугаа арилжаа хийснийг мэдэж болно.

37 Энд Номулунаас долоон хөвгүүнтэй гэсэн нь “Нууц товчоон”-ы тэмдэглэлтэй таарахгүй юм. Энэ нь Чингисийн наймдугаар үеийн өвөг Мэнэн Тудуны долоон хөвгүүнийг хэлжээ. Бас Хайду-г ахмад ач хөвгүүн гэсэн нь үүнийг гэрчилж байна. Учир нь Хайду бол Хачи хүлүг-ийн ахмад хөвгүүн нь юм. Харин Номулун зургаан дүү нартайгаа хамт Жалайр лугаа байлдсан байж мэднэ. Гэвч энэ нь Жалайр аймгийн тухай домог болохоор уул ёсоор нь тэмдэглэснийг мэдэгдье.

38 Жалайр аймгийн арван салбар овог төрлийг олон материалд баахан адилгүй тэмдэглэж

буй. Доор “Судрын чуулган” болон “Ту Цзи-гийн тэмдэглэл”-ийг баримтлан тэмдэглэв:

(1) Джат, (2) Тукараун, (3) Кунсаут, (4) Кумсаут, (5) Урьят, (6) Нилкан, (7) Куркин, (8) Тулангит, (9) Тури (бүр Бури), (10) Шанкут.

39 “Гуаньшань уул” бол Гажил нурууны систем дэх уулын нэр болно. Ийм нэртэй газар хоёр байна. Нэг нь Муумянган хошуу (одоогийн Өвөр Монголын Өөртөө Засах Орны Улаанцав аймгийн Дархан Муумянган хошуу)-ны хил доторхи Гуаньшань болно. Үүнийг “Их Чин улсын нэгтгэсэн ойллогын бичиг” ба “Монголын нүүдэлчдийн тэмдэглэл” зэрэг номд тэмдэглэж буй. Нөгөө нь “Хуучин Гуй Хуа хот (одоогийн Хөх хот)-оос зүүнш Хуншань (Улаан уул), Хэйшань (Хар уул) гэж байдаг, түүнийг бас “Харагчин уул”, “Гуаньшань уул” гэдэг”. ... Гуаньшань уул бол Гуй Хуа хотоос зүүнш зуугаад газарт буй. Уул доор нь ерэн есөн булагтай, тэр нь хар ус болон урсдаг. Түүний зүүн хойно нь “Улаан хад” ба “Шар дэвсэг” гэдэг хоёр уул байдаг. Цахар баруун гарын Хөвөөт хөх хошуутай зах залгана гэж “Умар дахиныг тэгшитгэх Фу-гийн тэмдэглэл”-д тэмдэглэж буй” гэж “Суйюань мужийн ерөнхий тэмдэглэлийн эх” гэдэг номд тэмдэглэсэн байна. Энэхүү “Гуаньшань уул”-ыг “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д: “Одоогийн Шань Си мужийн Хөх борын тэнхмээс баруунш, Хол дахиныг төвшитгөгч тэнхмээс хойш, Цахарын хөвөөт улаан хошууны нүүдлийн газар байдаг. Уулын орой дээр нь байх ерэн есөн булаг даруй Хар усны ундрал болно” гэжээ. Энэ нь их төлөв түрүүчийн тэмдэглэл лүгээ нийцэж байна. Гэтэл зуун өрх түмэд чухам аль Гуаньшань-д нүүн ирсэн тухай тодорхой тэмдэглэл харагддаггүй. Хэрвээ Онгудыг Түмэдийн дээдэс гэж үздэг бол түрүүчийн Гуаньшань нь зүйтэй. Юу болсон ч Далан хар уулын орчмоор ирсэн нь дамжиггүй юм.

40 Ван хан 1196 онд Хар Хятан өөд дутаахад ямар шиг байдал доор явсан тухай түүхэн тэмдэглэлүүдэд хараахан адилгүй байдаг. “Нууц товчоон”-д: “Инанча хан цэргүүд илгээж жич Ван хан гурван балгад бядан (тэнэх - эшлэгч) зорчиж ...” (151 дүгээр зүйл) гэжээ. Чухам хэдий хүн дутаасныг хэлсэнгүй. “Биеэр дайлсан тэмдэглэл”-д. “Инанча хан цэрэг мордуулж Ван ханыг дайчилж, Хэрэйд аймгийн бүх иргэдийг булаан авч Эрх хард өгөв. Ван хан сугулдар биеэр дутаан гарч...” гэжээ. “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д: “Ван хан зүүнш Татарыг дайлахаар явсан ташрамд Найманы Инанча хан цэргээр Эрх харыг улсад нь хүргэн иржээ. Ван хан ялалтайгаар баруунш буцахад яг тааралдаж, байлдаад ялагдаж Хар Хятан өөд дутаав” гэжээ. Би үндсэндээ “Ту Цзи-гийн тэмдэглэл”-ийг баримталжээ. Түрүү хоёр тэмдэглэлээр бол Ван хан байлдсангүйгээр дутаасан мэт болжээ. Гэтэл Ван хан Татарыг сөнөөгөөд ялалттай буцаж ирсэн атал байлдахгүй байх ёсгүй бөгөөд түүний бүх цэрэг морио устгагдсаныг үзэхүл харин энгийн бага сага байлдаан биш гэдэг нь илхэн байна. Ингээд би “Ширүүн байлдаан хийж, Ван хан бүх цэрэг морио устгагдаж” гэж зүйчлэн бичив. Бас түрүүчийн тэмдэглэлд Ван ханыг “Сугулдур биеэр дутаалаа” гэдэг нь арай үнэн байдалтай тохирохгүй мэт. “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д: Ван хан ядаж зүдэж явсаар байгаад 1198 онд Гүсэгүр нуурт хүрч ирээд Чингис хаанд хүн томилж чимээ хүргэв гэж тэмдэглэж байдаг бөгөөд “Нууц товчоон”-ы 177 дугаар зүйлд “Цөөн хүнтэй амь хоргодон дутааж” гэж тэмдэглэж буй. Иймээс би “цөөн хэдэн хүн авч дутаав” гэж бичив.

41 Энд Ван хан дутааж Хар Хятаны Гүр ханд очлоо гэжээ. Энэ бол “Нууц товчоон”-ы тэмдэглэл болно. “Гүр хан” гэсэн нь их хаан буюу нийтийн хаан гэсэн цол болно. “Биеэр

дайлсан тэмдэглэл”-д хятадаар “Цзюй-люй кэ-хань” гэжээ. Энэ бол “Гүр хан” гэснийг авиачлан галигласан нь тодорхой байна.

42 “Гүсэгүр нуур”-ын байр чухам хаагуур байсан тухай тэмдэглэлүүд нь нэлээд зөрөөнтэй байна. “Судрын чуулган”-д: “Гүсэгүр нуур бол орчим хаан(Чингисийг хэлж буй - эшлэгч)-ы сууж байсан газар” гэжээ. Хун Цзюнь үүний тухай тайлбарлахдаа:

“Урьд Ван хан болон Есүхэй баатар хамтдаа сууж байсан газар гэсэн бөгөөд Ван хан энэ нуурт ирлээ гэдэг нь Хэрлэнгийн наадахи этгээд болно. Хаан (Чингисийг хэлж буй - эшлэгч) бол голын тэртээх этгээдэд байжээ” гэв. “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д: “Гүсэгүр нуур” гэдэг нь “Толь нуур” гэсэн утгатай түрэг үг юм. Одоогийн Тагна уриахайн нутагт буй. Тэр нуур нь хааны (Чингисийг хэлж буй - эшлэгч) сууж байсан Хэрлэнгийн урсгалаас тун хол, хоорондоо Сэлэнгэ, Туул хоёр голыг дамжиж буй. Хэрлэн голын эндэх, тэртээх гэсэн нь өрнө дахинынхан Монголын газар байцыг нарийн ойлгохгүй учраас барагцааж хэлсэн явдал болно. Ван хан буцаж ирэхдээ одоогийн өртөө замаар явсангүй, Тагна уулын араар явсан учир нь Найманаас зайлсан явдал болно гэжээ. “Биеэр дайлсан тэмдэглэл” (Монгол хэвлэлийн тайлбар, 55)-д: “Ту Цзи энэ нуурыг Тагна урианхайн Гүсэгүр нуур мөн гэж тэмдэглэжээ. Адил нэртэй нуур болно. Ван хан Уйгур, Тангудаас ирэхэд энүүгээр өнгөрөхгүй билээ” гэжээ. Гэтэл Х.Пэрлээ: “Ван хан Тоорил, Тангуд газраас Хэрлэнд ирсэн газрын баримжааг бодоход одоогийн “Гурван Хөвсгөл уул”, эртний Гүсэгүр нуурын газар байж мэдэх (уртраг нь 109°, өргөрөг нь 43°). Долоон зуу гаруй жилийн өмнө байсан нуур одоо ширгэж, уг нэр нь уулын нэрд шилжсэн байж болно” гэжээ. Дээрх тэмдэглэлүүдээс үзэхүл, энэ нь хоорондоо хавьтахгүй гурван ондоо газар болжээ. “Хэрлэнгийн наана цаана” гэдэг нь одоогийн Бүгд Найрамдах Монгол Ард Улсын зүүн хэсэгт байна. “Тагна Урианхайн нутаг” гэсэн нь одоогийн Монгол Улсын умар дахи (жаахан баруун хойгуур шиг) зах нутаг болно. “Гурван Хөвсгөл уул” гэсэн нь одоогийн Монгол Улсын өмнөд зах, Өвөр Монголын Өөртөө Засах Орны Дархан Муумянган хошуутай залгалдах хил орчмын орон болно. Тиймээс энэ хэдэн тэмдэглэлийн аль нь оновчтой гэдгийг батлах баримт одоохондоо олдоогүй байсаар тул асуудал болгон тэмдэглэв.

43 “Хуба хаяа” гэдэг нь “Нууц товчоон”-ы шинэ бичлэг болно. Энэ газрыг “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д: ”Халуун хавцал” гэсэн газрын нэр “Нууц товчоон”-д байх бөгөөд “халуун рашааны уулын хавцал” гэсэн утгатай гэж тайлжээ. Гэвч “Нууц товчоон”-ы 150, 177 дугаар зүйлд “Харуун хавцал” гэдэг газар байх биш, “Халуун хавцал” гэж үгүй. Ван хан “Харуун хавцал”-д шургасан явдал бол энэ удаа биш, харин Есүхэй баатарыг түшин ирэх тэр үе, үүнээс хэдэн арван жилийн өмнөх явдал болно. Үүнээс гадна, “Биеэр дайлсан тэмдэглэл”-д “Туул голын түн хар шугуй” гэжээ. Би “Нууц товчоон”-ыг баримтлав. Үүнийг Ц.Дамдинсүрэн “Хубахаяа” гэж тайлбарлав (148 дугаар зүйлд).

44 Чингис хааны Удуйд Мэргидийг Мөрүчэ сэгүлд дахин дайлсан явдлыг “Нууц товчоон”-ы 177 дугаар зүйлд дурдсан боловч цагийг нь дурдсангүй, “Биеэр дайлсан тэмдэглэл”-д “Дараа жилийнх нь намар” гэжээ. Энэ бол Ван хан Тангудаас буцаж ирсний дараа жил (1199 он)-ийг заасан бололтой. “Судрын чуулган”-д “могой жил” гэжээ. Энэ нь 1197 онд Ван ханы дүү Жаха Гомбу Чингис хааныг дагаар ирж, мөн хаантай хамтран Жүрхинийг дарсан явдлыг ташаарчээ. Тиймээс энэ нь Ван хан буцаж ирсэн 1198 оны намар болох нь нэлээд баримттай юм. Тус

удаагийн байлдааныг хийсэн газар - Хатиглиг нурууны Мөрүчэ сэгүлийг Цүхүр гол болон Сэлэнгэ мөрний хоорондуур одоогийн Оросын хил орчим байсан бололтой гэж түүхч Ту Цзи тэмдэглэжээ. Х.Пэрлээгийн тайлбарт: “Сэлэнгэ, Хилгу”-гийн бэлчрээс дорогш Сэлэнгийн солгой этгээдэд байсан бололтой гэжээ. Энэ хоёр тэмдэглэл нэлээд ойртож байна.

45 Ван хан Мэргидтэй ганцаар байлдсан цагийг “Нууц товчоон”-д: “мөн нохой жил Чингис хааныг татар иргэнд морилсонд. ...” гэжээ. Энэ бол 1202 он болно. “Судрын чуулган”-д: морин жил гэжээ. Энэ бол 1198 он болно. Энэ тухай Ту Цзи хэлсэн нь: “нарийн магадлаж үзэхүйеэ, энэ удаагийн байлдаан нь шарагчин хонин жил (1199 он)-ийн Улаан худгийн байлдаанаас өмнө болсон нь тодорхой болой” гэжээ. “Биеэр дайлсан тэмдэглэл”-д бас энэ дэс дараагаар тэмдэглэжээ. Ингээд би мөн үүнийг нь баримтлав.

46 Мэргидийн Тогтуга бэхи-гийн хоёр охин Хутугтай, Чагаруныг “Биеэр дайлсан тэмдэглэл” (хятад хэвлэл)-д: “Худутай, Чалхун хоёр хатан” гэжээ. “Судрын чуулган”-д: түрүү нэг нь “Нууц товчоон”-ыхтой адил, сүүлчийнх нь “Биеэр дайлсан тэмдэглэл”-тэй адил бөгөөд “хатан” гэсэнгүй, “охин” гэжээ. Нэрийн бичлэгийн асуудал бол хятад үсгээр галиглахад тохиолддог асуудал болно. Тиймээс “Нууц товчоон”-г баримтлав.

47 “Чо Гэнь Лу” бичгийг бас “Нань Цзунь-ий тариалалын завсарлал дахи тэмдэглэл” гэдэг. Түүний Юань улсын сүүлчийн үеийн бичгийн хүн Тао Цзун Эй (цол Нань Цзунь, өргөсөн нэр нь Чжоу Чэн гэдэг) гэгч зохиосон юм. Нийт гучин ботиор бүрэлджээ. Тэр нь Юань улсын үеийн үлгэр тэмдэглэл, тогтоол дүрэм, дурсгалт зүйлс ба цагийн байдлын тухай чөлөөт тэмдэглэл болох бөгөөд бас түүх, газар зүйн магадлалт жич утга урлагийн талаар ч тэмдэглэжээ. Үүнд дурдсан “эрээн нүдтэн” гэдэг бол Юань улсын феодал ноёрхогчдоос түүний харьяатаа “Монгол хүн”, “эрээн нүдтэн”, “хятад хүн” ба “нанхиад хүн” гэж дөрөв хувааж, үндэстнийг доромжлох төрийн бодлогыг хэрэгжүүлдэг байсныг тэмдэглэжээ. Энэхүү “Эрээн нүдтэн”-д нь Харлуг, Кипчак, Тангуд, Асу, Дов (Төвд), Ханлин, Уйгур, Сартуул, Найман, Архун, Саркис (энэ бараг Киргиз магадгүй - зохиогч), Орос, Онгуд, Гамли, Кашмир зэргийг багтаадаг байжээ.

48 “Таян хан” гэсэн нь “Дай-ван” (Их ван) гэсэн үгийн хувирал гэдэг. Энэ нь Алтан улсаас Найманы ханд Ван цол өргөмжилж, Их Ван гэж нэрлэж байснаас үүсэлтэй гэдэг билээ. “Буйруг” гэдэг үг бол түрэг гаралтай үг болох бөгөөд Эртний Монголын язгууртны онцгой цол болно гэж Владимирцов тэмдэглэжээ.

49 Энэ хэсэгт дурдсан “Улуг таг” гэдэг бол Алтай нурууны нэгэн салбар Булаг уул (уртраг нь 90°, өргөрөг нь 47°) хавьд байсан бололтой. “Таг” гэдэг нь уулыг хэлдэг, эртний зарим номд “Сүмбэр уул”-ыг бас “Сүмир таг” гэдэг.

“Хоншингирын Өрүнгү” гэдэг бол одоогийн Шинжааны Уйгурын өөртөө засах орны Илийн Казак Үндэстний Өөртөө Засах чжоу нутагт бүхий “Өрүнгү гол”-ыг хэлж байна. Энэ нь Алтайгаас эх авсан “Булган”, “Чингэл” хоёр гол нийлээд Өрүнгү гол болжээ. Чин улсын үед тэр нутгаар Шинэ, Торгууд хоёр хошуу малжиж байв.

“Кызылбаш нуур”-ыг “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д: Одоогийн Ховдоос баруун өмнө бүхий “Хэ-са-лэ Ба-шэнь-бо”-г хэлж буй, Өрүнгү гол үүнд цутгадаг юм гэжээ. Энэ нь “Кызылбаш” гэсэн

үг тэр хэвээрээ байна. Гэтэл одоогийн газрын зурагт ийм нэртэй нуургүй, харин Шинжааны Илийн Казак Үндэстний Өөртөө Засах Чжоу-гийн хязгаар (уртраг нь 87°, өргөрөг нь 47°)-т Өрүнгү голын шууд цутгадаг “Бажия” гэдэг нуур буй. Би бодоход энэ “ji” үсэг харин “xia” гэсний ташаа байж мэднэ. Хэрвээ үүнийг “ба ся” гэж үздэг бол энэ нь “ба-ши”, “ба-шэнь” гэсэнтэй тохиролцох бөгөөд “Кызылбаш” гэсэн үг товчлогдож “баш” болсон гэж ойлгож болно. Хэрвээ Кызылбаш нуурт Өрүнгү гол цутгадаг бол энэ “Бажия” нуур лав эртний “Кызылбаш нуур” болно. “Кызылбаш” гэсэн нь “Улаан толгой” гэсэн утгатай түрэг үг гэдэг билээ.

“Кэм Кэм чжоу” гэдэг бол одоогийн Зөвлөлт Холбоот улсын “Кэм чжоу”-г хэлж байна. Тэр нь Ениссей мөрний эх Тагна уулын араар буй. Кэм голоос нэр авчээ. Хүчүгүд Буйруг ханыг “Кэм Кэм чжоу өөд дутаалаа” гэсэн нэгэн үг бол “Судрын чуулган”-ы тэмдэглэл болно. “Нууц товчоон”-д харин “Кызылбаш нуурт гүйцэж түүнийг тэнд сөнөөв” гэж тэмдэглэж буй.

50 “Байдраг бэлчир” гэдгийг “Судрын чуулган”-д: Урьд Найман аймгийн нэгэн хүн Онгуд аймгаас “Байдраг” гэдэг нэгэн охин авчирч “бэлчир” гэсэн газар хуримласнаас Монголчууд хүн газар хоёрынхи нь нэрийг нийлүүлэн дуудсаар хожимдоо газрын нэр болжээ гэж домогчлон тайлбарласан гэлээ. “Монголын нүүдэлчдийн тэмдэглэл” гэдэгт: Байдраг гол бол (халхын) Сайн ноён хан аймгийн баруун гарын баруун адаг хошууны бэлчээрт буй. Тус голын эх бол хөх нурууны өмнө бэлээс ундардаг. Түүний хойд бэлээс нь Тамир гол ундарч буй гэж тэмдэглэжээ. Одоо “Заг байдрагийн бэлчээр” (уртраг нь 99°, өргөрөг нь 47°) гэдэг. Арван наймдугаар зууны эхнээс Халхын угийн Засагт хан аймгийн төв нь Заг голын эхээр төвлөсөн болохоор “Биндэрьяа нуурын чуулган” гэж нэрлэдэг байжээ. 1958 онд Дундад улсаас хэвлүүлсэн дэлхийн газрын зурагт мөн дээрх уртраг, өргөрөгийн байрт “Заг” гэдэг нэгэн суугуул ардын чиг байх бөгөөд хажуугаар нь “Байдраг гол” гэсэн гол өмнөш урсч буй. Эдгээр баримтыг үндэслэвэл эртний “Байдраг бэлчир” гэдэг нь энэ газар болох нь илхэн байна. Газрын байдлаас үзэхүл, энэ нь яг байлдаан хиймээр уулын ам болох мэт.

“Хар сүүл гол” гэдгийг одоо бас “Хар сүүлийн гол” гэдэг бөгөөд тэр нь “Заг Байдрагийн бэлчээр”-ээс зүүн хойш (уртраг нь 100°, өргөрөг нь 47°) байдаг гэлээ. “Эдэр Алтайн бэлчир” гэдэг нь одоо “Идэр гол”, “Чулуут гол” хоёрын солгой этгээд (уртраг нь 100°, өргөрөг нь 49°)-д байх бөгөөд “Идэрийн гол”, “Алтайт гол” гэж салган хэлэцдэг гэлээ.

51 Энэ удаагийн “Улаан худ”-д болсон байлдааныг “Нууц товчоон”-д 1202 онд Чингис хаан Татартай байлдсаны дараа тохируулжээ. Энэ цаг эндүү гэж түүхч Ту Цзи үзсэн бөгөөд энэ байлдаанд Боорчу, Мухулай, Борухул, Чулуун дөрвөн хүлэг оролцлоо гэсэн нь бас сэжиглэлтэй гэжээ. Учир нь Борухулыг 1197 онд Жүрхиний нутгаас олоход бяцхан хүүхэд байсан. Энэ үед Сорхан шар бас ирээгүй байсан тул Чулуун бас ирэх болоогүй гэжээ. Ингээд “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д Боорчу, Мухулай нарыг томилов гэж бөөрөнхийлөн тэмдэглэсэн байв. Би ч мөн үүнийг нь зөв гэж үзээд их төлөв үүнээр баримтлал болгов.

52 “Улаан худ” гэдгийг Ц.Дамдинсүрэн “Улаан хус” гэж, Ту Цзи “Улаан худаг” гэж тайлжээ. Энэ нь хэлбэрийн талаас нь ажигласан нь илхэн байна. Сүүлчийн үед “Улаан хус” гэдэг бөгөөд Монгол улсын Баян-Өлгий аймгийн төв Өлгий хот энд байгуулагджээ. Түүний газар зүйн байрын уртраг нь 89°, өргөрөг нь 49°-т буй.

“Жоргал гуны улаанууд болдог” гэдгийг “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д “hu la an hu t” гэж, Ц.Дамдинсүрэн “Зоргал хоны Улаан болдог” гэж, Х.Пэрлээ “Зоргол хуны улаа нудыг бурхаууд (болдогууд?)” гэж, Дорнотив “Жоргал хуны улаанууд уулнууд” гэж тус тусын ойлголтоороо бичиж буй. Халхын угийн Түшээт хан аймгийн дундад баруун хошууны өмнө байдаг “цзюэ эр го эр шань” гэдэг нь энэ “цзюэ эр хэ лэ кунь шань” мөн гэж Ту Цзи үзжээ. Х.Пэрлээ Хэрлэнгийн солгой этгээдээс цутгасан “Зорголын гол” мөн бололтой гэж үзээд газар зүйн байрын уртраг нь 104°, өргөрөг нь 48° гэж тэмдэглэжээ. Энэ арай таарахгүй мэт. Энэ уртраг нь 104° бол Туул голын солгой тал болно. Хэрвээ Хэрлэн гэвэл бас дөрвөн градус зүүнш 108°-т байвал зохих магадгүй, “Нууц товчоон”-ы 164 дүгээр зүйлд “Туулын Хар Түн д хурж эцэг хөвгүүн гэлдэв” гэж, 177 дугаар зүйлд нь “Хаан эцэг минь бид хоёр юу хэлэлдлээ, Зоргол гуны улаа нугад болдогуудад” гэж нэг учрыг хоёр газраар бичсэн байдаг. Тиймээс энэ газар Хэрлэнгийн орчим биш, Туулын орчимд байх нь зүйтэй мэт.

53 “Тунгалаг нуур” гэдгийг “Биеэр дайлсан тэмдэглэл”-ийн монголчилгод “Түнхэлиг горхи” гэж орчуулжээ. “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д: “Хилийн зургаар үзэхүл, Оросын харьяаны Сабехал мужийн зүүн өмнөд заагт зэрэгцсэн хоёр нуур буй. Зүүн дэхийг нь “Зүүн толь”, баруун дахийг нь “Баруун толь” гэдэг. Газрын зурагт хамтад нь “Дали нуур” гэдэг. Энэхүү “далэй”, “та-лэй”, “ту-лэй” бүр нэг л болох бөгөөд “тунь-лэй” гэсний өөр бичлэг болно. Энэ үг бол “толь” гэсэн утгатай, ус нь толь мэт тунгалаг болохоор ингэж нэрлэсэн билээ. Газар нь Онон голоос өмнө байна” гэжээ.

54 “Онгуд тулас”-т болсон байлдааныг “Ту Цзи-гийн тэмдэглэл”-ийг үндэслэн бичив. Энэ “Онгуд тулас” гэдэг газар бол Хөлөн Буйрын умард хилээр байдаг Кэнь голоос Их Хүрээ (одоогийн Улаанбаатар) хүрэх эртний зааг Бор хэрэмийг хэлж байна. Монголчууд энэ хэрмийг эртдээ “Өрхэ” гэж байсан. Хөлөн Буйрын умард хилд “Эрдэнэ толгой”, “Бор толгой” гэсэн газар байдаг нь харин энэ “Онгуд тулас” байж мэднэ. Гэвч энэ нь Гажил нуруунаар байдаг Онгуд аймагтай нэр адил боловч огт харьцаагүй хоёр ондоо газар болно. Үүнийг “Судрын чуулган”-д “улункут - турас” гэж, “Биеэр дайлсан тэмдэглэл”-д “Юэ-лян ту-ла-си” (монголчилгод нь “Улаанууд турас”) гэж тэмдэглэж буй.

55 Энэ удаа арван нэгэн аймаг Алхуй булагт цугларан, Чингис хааныг халдсан явдал ба тахиа жил (1201 он)-д Кан мөрний шанаад Жамуха-г гүр хан өргөмжилсөн хоёр явдлыг “Нууц товчоон”-д хамтатган нэг л явдлаар тэмдэглэж буй. Энд бид “Биеэр дайлсан тэмдэглэл”, “Ту Цзи-гийн тэмдэглэл” зэргийг үндэслэж салган тэмдэглэв.

“Алхуй булаг” гэдгийг “Биеэр дайлсан тэмдэглэл”-д “А лэй цюань” (монголчилгод нь “Үлэгүй булаг” гэж тайлбарт нь одоогийн Үзэмчин зүүн хошууны Өргөн гол болно) гэжээ. “Ту Цзи-ийн тэмдэглэл”-д Үзэмчин зүүн гарын хошуунд (одоо Үзэмчин зүүн хошуу гэдэг) нэгэн “У-ла гуй-хэ” (одоогийн хятадаар “У-ла-гай Го-лэ”, монголоор “Олгой гол” гэдэг. Уртраг нь 119.6°, өргөрөг нь 46.4°-т буй – эшлэгч) гэдэг гол баруунш урсч, “су-и-лэ-цзи-хэ” (одоо хятадаар “сэ-е-лэ-цинь-го-лэ”), монголоор “Шиелжин гол” гэдэг, уртраг нь 119.2°, өргөрөг нь 46.3°-т буй – эшлэгч) гэдэг голтой нийлэн “Чан-цзи-ту-бу-ли-ху” гэдэг нуур (одоо ийм нэртэй нуур байхгүй, Олгой гол нь “Хошуун нуур”, “Шорнай нуур” хоёрт цутгадаг билээ – эшлэгч)-т цутгадаг юм. Энэ нуурыг хуучин зурагт “У-лэ-хуй нуур” гэдэг. Энэ даруй “А-ла-хуй” булаг мөн гэжээ.

56 “Хойд нуур” гэдэг газрыг “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д: “Үүнийг Рашид-ад-Диний бичигт “Ху-тун но-эр” гэжээ. Энэ нь даруй одоогийн Хөлөн нуур болно. “Ху-ту” гэдэг бол “хойд” гэсэн монгол үг болно. ...Энэ нь Хөлөн буйрын дэд амбаны хотоос баруунш буй. Хар мөрөний бодот газрыг хэмжсэн зурагт Хөлөн нуураас баруун өмнө шиг нэгэн Балжуна ус гэдгийг өмнө нуур гэж дууддаг, тиймээс Хөлөн нуурыг “Хойд нуур” гэсэн байлгүй” гэжээ. Гэтэл “Биеэр дайлсан тэмдэглэл”-ийн монголчилгод: “ху-ту”-г “Халиут” гэж орчуулж байх бөгөөд тайлбарт нь “Ту Цзи-гээс энэ газрыг Хөлөн нуураар үзэж байжээ. Нэр ба байгаа газар нь бүр адилгүй. “Нууц товчоон”-д гардаг “Халиут нуур” мөн. Одоо “Халиутай” гэдэг” гэжээ. Энэ тайлбар нь бусад тэмдэглэлүүдтэй зөрөөнтэй тул би Ту Цзи-гийн тэмдэглэлийг баримтлав.

57 “Нууц товчоон”-д энэ удаагийн байлдаан - Чингис хаан хоёрдугаар удаа Татар лугаа байлдсан байлдааныг 1202 онд Татарыг хамаг эцэс мөхөөсөн байлдаантай хамтатган тэмдэглэжээ.

“Далан Нөмөргөс” гэдэг газрыг “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д: “Хар морины бодтой хэмжсэн зургаас үзэхүл, “Бух”-ын баруун өмнөх хилд нэгэн “Соёолж” гэдэг уул буй, энэ уулын араас “Нөмөргөн” голын эх ундарч буй. Тэр гол баруун хойшоо урсч (Халхын) Цэцэн хан аймгийн зүүн гарын өмнөд хошуунаас далан газар зайтай Халх гол лугаа нийлдэг. Энэ голын хоёр хөвөөгөөр бүр тал газар болохоор “Далан” гэж нэрлэв” гэж тэмдэглэж буй. Үүнийг Х.Пэрлээ “Далан Нөмөргөс” гэж бичээд “одоо “Нөмрөгийн голын сав газар” (уртраг нь 119°, өргөрөг нь 47°) мөн” (Далан гэдэг нь олон тоог тэмдэглэсэн үг юм) гэжээ. Энэ хоёр тэмдэглэл нэрийн талаар ба бодтой байрын талаар бүр адил байна. Бас Дундад улсын газрын зургийн хэвлэлийн хорооноос 1957 онд хэвлүүлсэн “Бүгд Найрамдах Дундад Ард Улсын газрын зургийн нийлбэр” гэдэг дэвтрийн 29-30 дугаар хуудсанд мөн дээрх уртраг, өргөрөгийн байрт нэгэн Халх голтой нийлдэг “Нөмөргөн гол” гэдэг Дундад, Монголын хилийн заагийн гол буй. Энэхүү хятад бичлэг нь хэдийгээр дээрх бичлэгтэй адилгүй боловч авиа нь бүрмөсөн адил юм. Үүнээс гадна Юань Го Фэн гэгч 1959 оны 12 сард “Их хуурай сэтгүүл” дээр нийтлүүлсэн “Юань улсын Тайцзу хаан Балжуна голын усыг ууж тангарагласан тухай товч магадлалт” гэдэг өгүүлэлдээ: “Далан Нөмөргөс гэдэг газар бол одоогийн Олгой голын дээд урсгалаар байжээ” гэж тэмдэглэж байсан нь дээрхтэй адил байна.

58 Жамуха-г “Гүр хан” өргөмжилсөн явдлыг “Нууц товчоон”-д Алхуй булгийн чуулгантай хамтруулж тэмдэглэсэн болохоор, тус ажиллагаанд арван нэгэн аймаг (Хатагин, Салжигуд, Дөрвөн, Татар, Ихирэс, Хонгирад, Горлос, Найман, Мэргид, Ойрад, Тайчигуд мэт) оролцсоноор тэмдэглэж буй. Гэтэл “Биеэр дайлсан тэмдэглэл”-д долоон аймаг (Хонгирад, Ихирэс, Горлос, Дөрвөн, Татар, Хатагин, Салжигуд зэрэг) оролцсоноор тэмдэглэж буй. Жамуха-г “Гүр хан” өргөмжилсөн газар бол “Кан мөрний шанаа” гэдэг газар болно. Энэ бол одоогийн Өвөр Монголын Өөртөө Засах орны Хөлөн Буйр аймгийн Гэнь Хэ гол (энэ бол 1964 онд Өвөр Монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хорооноос хэвлэгдсэн “Дундад ба гадаад газрын нэрс”-ийн бичлэг болно. “Биеэр дайлсан тэмдэглэл”-ийн монголчилгод “Ган мөрөн” гэжээ) болно. Тэр нь Хянган давааны арын Навтартай уулын хавиас ундарч, Эргүнэ голд цутгадаг Дундад улсын дотоод гол билээ.

59 Энэхүү мэдээг хүргэсэн тухай “Биеэр дайлсан тэмдэглэл”-д бусад тэмдэглэлийг бодохул нэлээд нарийн бөгөөд сонирхолтой шиг тэмдэглэж байна. Энд хяналт болгон тэмдэглэе:

“Тэр үед Тахайха хэмээгч хүн тэд (Жамуха нарыг хэлж буй – эшлэгч)-ний дотор байсан ажгуу. Чингисийн харьяат Жулай Чугур (хятад эхэд нь “Чжо-ле-ши чао-у-эр” гэж байна) Чухамдаа “Жэгүүрэйд овогтны Чугур” гэвэл зүйтэй. Гэтэл “Биеэр дайлсан тэмдэглэл”-ийн монголчилгод нь “Жулай Чугур” гэсэн хүний нэр мэт болгожээ - эшлэгч) биеэрээ очиж үзвээс, тэнд хөөгдөж тэдний хувилдлагыг үнэхээр олж мэдэхгүй байжээ. “Тахайха лугаа дайралдаж” Тахахай мялаагаараа түүний сүвээ рүү годолсонд Чугур эргэж ширтвээс Тахайха нь нүд ирмэснийг Чугур ухааж даруй мориноос бууж бие засах янз гаргав. Ган мөрөн (“Нууц товчоон”-ы бичлэг бол “Кан” гэвэл зүйтэй - эшлэгч) дээр холбоо байгуулсныг Тахайха мэдэгдэж өгүүллүүн:

“Хэрэг явдал бачим болой. Чи хаа одмуй” хэмээсэнд Чагур хэрдхийн гайхаж, доороо буцахуйд Хорула овог (Монголын овгийн дотор “Хорула” гэдэг овог ер харагддаггүй, энэ нь бараг “Горлос”-ыг хятадаар галиглахдаа хувиргасныг монголчлохдоо ч эндүүрсэн бололтой – эшлэгч)-гийн Есүхэйтэй учирч, тэр учрыг хэлж, Чингис дор мэдүүлэхээр очмуй хэмээв. Есүхэй өгүүллүүн: “Миний түрүү эхнэрийн хөвгүүн нь Хулан буха-тай хамаагүй явалцдаг болой. Миний дэргэд ганц бага хөвгүүн ба гэрийн хүн Хоридай буй ажгуу” хэмээжээ. Иймээс Хоридай лугаа андгайлан тангараглаж явуулахаар болов. Тэдэнд бор элжиг, саарал морь унуулж, “тэнд хүрвэл ганц Чингис, эх хатан ба миний хүргэн Хасар (уг тайлбар: Рашидын бичигт: Хасарын жинхэнэ хатан бол Горлос овгийн Алтан хатан гэдэг мөн гэсэн нь лав Есүхэйн хүүхэн биз)-тай уулзаж хэлсүгэй. Хэрвээ бусдад мэдэгдсэн байваас нурууг чинь хугалж, нугасыг чинь тасадмуй” хэмээн захиж хэлэв. Андгайлж мордоод замдаа Хулан бат, Хар Мэригидэй-н цэргийн харуулд учирч баригдав. Хуучин танил болох тул тавьж, сайн хүрэн морь өгч өгүүллүүн: “Энэ морь болбоос дутаахад бултран гарч чадах, нэхэхэд гүйцэж чадах морь болох тул унаж одсугай” хэмээжээ. Бас Жамуха-гийн бууц руу явж байх Есүхэйн сүйх тэрэг цагаан цацартай аян лугаа тохиолдов. Аяны дотроос нэг хүн гарч Чугурыг нэхэхүйд Чугурын унасан морь гайхалтай хурдан тул бултран зугатаж, Чингисийн өмнө ирж хувилдсан хэргийг цөм мэдүүлэн хэлбэй” (“Биеэр дайлсан тэмдэглэл”-ийн монголчилго, 27-28 нүүр нэрсийнх нь бичлэгийг залруулав – эшлэгч) гэж нарийн дүрслэгээр тэмдэглэж байна.

60 “Улхуй Шилүгэлжид”-ийн тухай түүхч Ту Цзи-гийн тайлбараас үзэхүл, энэ нь тус бүлгийн дагалдвар55-д тайлбарласан эртний “Алхуй булаг”, одоогийн Өвөр Монголын Үзэмчин зүүн хошууны “Олгой гол” болох нь ч дамжиггүй байна. Гэтэл “Нууц товчоон”-ы 141 дүгээр зүйлд “Алхуй булаг” гэж тэмдэглээд, энд яагаад “Улхуй Шилүгэлжид” (153 дугаар зүйл) болов гэсэн асуулт гарах нь ч лав юм. Тиймээс энэ тухай мэдээнүүдийг доор жагсаан уншигчдад хяналт болгоё.

Энэхүү “Шилүгэлжид” гэдэг нэрийг Ту Цзи авгай “Их Чин улсын нэгтгэсэн ойллогын бичиг”-ийн хавсралт зураг ба “Хил хязгаарын газрын зураг” зэргийг үндэслэж, “Олхуй” (баримжаа товчоонд “У-лэ хуй”) гэдэг бол дээрх зураг дахи “У эр хуй хэ буюу У-ла-гуй хэ”(одоогийн Олгой гол У-ла-гай го-лэ) болох бөгөөд “шилүгэлжид – ши лу гэ лэ жи ти” (баримжаа товчоонд “Ши-лу-гэ-лэ-жи-ти” бол дээрх зураг дахи “Сэ-е-эр-цзи-хэ буюу Су-е-лэ-ци-хэ”одоогийн “Шиелжин гол”-ын дуудлага хувирсан нэр болно гэсэн бөгөөд “Шилүгэлжидийн гол”-ын дуудлага хувирсан нэр болно гэсэн бөгөөд “Шилүгэлжид”-ийн “жид” бол олон тооны дагавар болно гэжээ. Х.Пэрлээ: “Халх, Нөмөргө хоёр голын ойр байжээ” гэж тайлав. П.Кафаровын “Нууц товчоон”-ы оросчлогод “Яр нуур номин” гэж

тайлсан гэлээ. “Биеэр дайлсан тэмдэглэл”-ийн монголчилгод “Өрлэхүй ширүгэлжид” (хятад нь У-лу-хуй Ши-лянь-чжэнь-хэ) гэж бичээд, Ван Го Вэй тайлбартаа “Одоогийн Орхон гол ба Шиянжар гол болно” гэжээ. Энэхүү орчуулга ба Ван Го Вэй-гийн тайлбарыг зүйтэй гэж үзэхийн аргагүй мэт.

Би хувиасаа үзвэл, энэ удаагийн байлдаан нь Татарын нутаг - одоогийн Хөлөн Буйр, Зүүн үзэмчин ба Монгол улсын уулзвар болох газар болсон нь нэлээд баримттай байна. Тиймээс Ту Цзи, Х.Пэрлээгийн тайлбар нэлээд ойртож байх мэт.

61 Алтан, Хучар, Даритай Отчигин нар байлдааны цаазыг зөрчсөнөө олзолсон зүйлийг нь хураалгахаар Зэв Хубилай хоёрыг явуулав гэж “Нууц товчоон”-ы 153 дугаар зүйлд тэмдэглэж байдаг. Гэтэл Зэв бол энэ удаагийн байлдаан (Татарыг мөхөөсөн байлдаан)-аас сүүлд ирсэн нь баримттай юм. Ингээд энд зөвхөн Хубилай ноён нар гэж тэмдэглэсэнд “Зэв” гэснийг нь товчлов. Чингис хааны Татартай гурван удаа байлдсаныг “Нууц товчоон”-д нэг л удаагаар тэмдэглэжээ.

62 “Хүйтэн” гэдэг газрын бодтой байрыг одоо бас хэд хэдэн зүйлээр тайлж байна.

(1) Сөнид зүүн гарын хошуунаас зүүн хойш дөчин газарт бүхий “Ханьшань” уулыг Монголоор “хүйтэн” (“Куй тэн хэ”) гэдэг билээ. Энэ харин эртний “хүйтэн” байж мэднэ гэж Хун Цзюнь тайлбарлажээ.

(2) “Хар мөрөн”-ий шинэ зурагт Хөлөн Буйрын дэд амбаны хотоос 230 газарт “Хүйтэн гол” гэж буй. Тэр нь хойш наян газар урсч, Хуй гол (Хуй хэ)-д нийлдэг. Энэ голын өмнөшөө Алтан улсын хязгаарын цайзаас 240 газар зайтай бөгөөд яг Найманы Буйруг хан зэрэг Удхи-д дийлэгдэн хойш ухарч, Жамуха-гийн туслах цэрэг Кан мөрний шанаанаас орсон ганцхан зам бол энэ “Хүйтэний хээр” болно гэж Ту Цзи тайлбарлажээ.

(3) “Одоогийн Жаруд хошууны өмнө байгаа Хүйтний даваа, Хүйтэн уул даруй энэ газар билээ” гэж Ван Го Вэй тайлбарласан бөгөөд Хун Вэнь Чин(Хун Цзюнь-ийг хэлж байна - эшлэгч), Ту Цзи-гийн тайлбарыг бүр буруу гэжээ.

(4) “Хэрлэн дагуу эртний Чигулху (Чихургу-г хэлж байна - эшлэгч), Удхи-гаас зүүн тийш байсан бололтой. Онон, Хэрлэн хоёрын хооронд “Хүйтэн Шао-су” гэдэг газар (уртраг нь 111°, өргөрөг нь 48°) байна. Энэ газрыг мөн гэх лавтай мэдээгүй боловч, газрын дөтийг бодвол мөн бололтой” гэж Х.Пэрлээ тайлбарлаж байв. Энэхүү тайлбарын бодот орон нь одоогийн Монгол улсын Хэнтий аймгийн хязгаарт байх ёстой. Энэ удаагийн байлдаанд холбогдсон бусад газар, тухайлбал морьт харуул томилсон “Энэхэн хүйлт”, “Чэгчэр”, “Чихургу” зэрэг газар нь их төлөв Хэрлэн голын адгаар байдаг болохоор Х.Пэрлээгийн тайлбар нь нэлээд ойртож байх мэт.

63 Энэ удаагийн байлдаанд Татарыг оролцлоо гэж “Нууц товчоон”-д тэмдэглэж байдаг. Үүнийг би “Татарын үлдэгдэл” гэж тэмдэглэсэн учир гэвэл, жүйн, цагаан, алчи, тудагуд, алухай зэрэг Татарчуудын гол хүчийг Чингис хаан нэгэнтээ гурван удаагийн байлдаанаар дамжиж бүрмөсөн мөхөөсөн юм. Тиймээс Жамуха-г дагаж байсан Татар бол тэдгээрийн үлдэгдэл болно.

64 Энэ удаагийн байлдаанд томилсон гурван суурин харуулын “Энэхэн хүйлт”-ийн харуул нь Чингисийн цэргээс хамгийн ойр нэгэн харуул болно, цааш нь “Чэгчэр”, “Чихургу”-гийн харуул болно. “Удхи” бол Чэгчэр, Чихургу-гийн хооронд байсан нь бас илхэн байна. Чингэвэл Чингисийн цэрэг бол Хэрлэн голыг уруудаж зүүнш явж байсан. Энэ бол эдгээр газрын байцыг жишихийн бүдүүвч чиг болно. Энэ “Энэхэн гүйлт”-ийг Х.Пэрлээгийн мэдээнд “Үнэгэн гүйлт” гэж “Нууц товчоон”-ыхоос ялимгүй зөрөөнтэй тэмдэглэж байх бөгөөд бодтой байц нь “Хэрлэнгийн дунд урсгалаар байсан. ...эртний Чэгчэр, Чигулху, Удхи, Хүйтэн гэдэг газруудад зэргэмжээ ойр байжээ” гэлээ. Ван Го Вэй-н тайлбарт “Энэ гурван уул нь Хэрлэн мөрний зүүн баруун хоёр талд буй” гэж барагцаалан тэмдэглэжээ. Гэтэл “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д: Нэр нь “Хүйлс” (Хүйлтийг хэлжээ – эшлэгч) гэсэн утгатай. Одоогийн Хорчин баруун гарын дундад хошууны нутаг дахи Хүйлэрийн голын эхэнд нэгэн “Хүйлсийн тохой” гэдэг газар буй. Энэ даруй “Энэхэн хүйлт” мөн гэжээ. Миний үзэхээр, энэ тайлбар нэлээд зөрөөнтэй байна. Хэрлэнгийн дундад урсгал буюу түүнээс баахан зүүнш жишвэл зүйтэй мэт. Хэрлэн гол нь бүх уртаараа 1.264 километр байна.

“Удхи” гэснийг манай тулгар баримтад “Удхия” (У ти ги я) гэжээ. Энэ нь “Нууц товчоон”-ы галиглалын системдээ бүрэн зүйтэй юм. Гэвч эртний монгол хэлэнд өгөх оршихын тийн ялгал “дур, тур”-ыг “аа, ээ” (уа, уе)-гээр ч зөндөө харагддаг юм. Тиймээс энэхүү “Удхия хүрч бууя” гэсэн нь “Удхид хүрч бууя” гэсэн үг болно. Ингээд би нэр үгийн хэлбэрээр нь “Удхи” гэж бичлээ. Ц.Дамдинсүрэн, Х.Пэрлээ нар мөн “Утхи” гэсэн хэлбэрээр нь тэмдэглэжээ.

“Удхи”-гийн бодтой байрыг түүх шастирт бас нэлээд чөлөөтэйгээр зөвлөцгөөж байжээ. “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д: “Нэрийн утга нь Цагаан хэрэм гэдэг” гэжээ. Бодоход, энэ нь Ляо улсын үед Хөлөн нуур, Халх голоор нутагладаг Хонгирадыг “Үгү” аймаг гэж, Хэрлэнгийн дунд урсгалаар нутагладаг Татарыг “Диле” аймаг гэж нэрлэдэг бөгөөд нийлүүлж “Диле”-гийн захиргаа гэж нэрлэн, сүүлд нь зүүн хойт замын Чжао Тао Сы гэдэг байсныг хэлсэн бололтой. Энэ бол Тайцзу-гийн газар болно. “Биеэр дайлсан тэмдэглэл” дэх “Арун бэхлэлт” гэдэг нь мөн энэ газрыг хэлж байна. Дээр дурдсан нэрийн утга гэдэг нь ойлгохуйяа бэрх шиг болжээ. “Тайцзу” бол Ляо улсаас байгуулсан чжоу болно. Төв нь Лэ Кан (одоогийн Гирин мужийн Тао Ань-аас зүүнш)-д байжээ. Харьяат газар нь одоогийн Тугурын голын дээд урсгал хавийн орон болно. Алтан улсын Да Дин-гийн хорин тавдугаар он (1185 он)-д хасаж, 1197 онд дахин сэргээж, төвийг нь Чанчунь (одоогийн Гирин мужийн Цянь Ань-аас хойш)-д шилжүүлжээ. Харьяат газар нь одоогийн Тогорын голын доорд урсгал хавиар байсан бөгөөд тухайн үеийн хилийн чухал орон болно (энэ хэсгийг бүрэн тайлбар толь “Үгсийн далай”-гаас эшлэв).

“Удхи”-ийг “Биеэр дайлсан тэмдэглэл”-д “Арун бэхлэлт” гэж нэрлэсэн бөгөөд Ван Го Вэй-н тайлбарт:

Хун Вэнь Чин-гээс Арун бэхлэлт бол Харагун жидүн мөн гэж үзжээ. Ту Цзи-гийн энэ газрыг Уда хиа (Удхиа - эшлэгч) газар мөн одоогийн Хишигтэн хошуунд байна гэжээ (дээр тэмдэглэлд ийм биш байлаа - эшлэгч). Арун бэхлэлт гэдгээр үзвэл, Алтан улсын гадаад бэхлэлт мөн. Линь Хуан (Баарины Бор хот мөн), Цинчжоу (Бааринаас баруун хойно байх Цагаан хот мөн)-гоос умраа байхаас биш, Хар мөрөн, Шар мөрнөөс өмнө байх биш. “Мэн Си Би Тань” гэдэг бичигт үзвэл, Ляо (Хятан) улс нь умард зүгийн аймгуудтай Ил уулаар хил зааг

болгов гэжээ. Одоогийн Үзэмчин баруун хошууны өмнө Улаан даваа гэж байдаг. Түүний зүүн хойно Илан богд гэдэг уул байна. Энэ газар нь Хятан, Алтан улсын үеийн Цинчжоу-гоос умарш байх Алтан улсын гадаад бэхлэлт мөн. Уул нурууг дагуулан барьсан бэхлэлт юм. Арун бэхлэлт гэдэг нь лав энэ бололтой. ... гэжээ.

Үүнээр үзэхүл, энэ “Удхи” буюу “Арун бэхлэлт” нь баруун Үзэмчин орчим байсан нь дамжиггүй байна. Энэ нь Хэрлэн лүгээ нэн ч хавьтахгүй байна. Тиймээс үүнийг зөвхөн цаашдын судалгааны лавлалт болгон тэмдэглэв. Энэ тухай Х.Пэрлээгийн тэмдэглэл гэвэл: “Хэрлэнгийн сав газар (Эртний Чэгчэр, Чигурху ~ Чигулху-аас зүүн тийш) байжээ гэж бүдүүвчлэн тайлжээ. Энэ нь бодтой газрыг нотолсонгүй боловч ерөнхий чиг нь таарч байх юм.

65 Байлдааны талбарт урьдаар нэр овгоо асуулцаж, дараа нь байлддаг ёс бол эртний аль олон улс үндэстэнд бүр байжээ. Энэ нь тухайн үеийн зан заншилтай холбогдохоор барахгүй, үйлдвэрлэлийн хүчний хөгжил - хүйтэн зэвсэг хэрэглэж, гардан тулалддагтай ч холбогдох юм. Энэ удаа Алтан, Хучар нарын дайсны манлай анги лугаа ярилцсаныг “урвах санаа байсан” гэж Ли Вэнь Тянь дурдлаа гэж Ту Цзи тэмдэглэв. Энэ нь сүүлд болсон явдлаар гэрчлэгдэх боловч, энэ удаагийн байлдааны талбар дээр учирсан үед урвалаа гэдэг баримтгүй байна.

66 “Харагун жидүн”-ий бодтой газрын байцын тухай хяналт болохуйц тэмдэглэл гэвэл, “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д: “Тус үг нь “Халуун рашааны түргэн урсгал” гэсэн утгатай. “Монголын нүүдэлчдийн тэмдэглэл” гэдэг бичигт, Хишигтэн хошуудаас хойш наян газар нэгэн “Галт халуун” гэдэг нуур буй, 190 газарт нэгэн халуун рашаан буй. Энэ “Хэ-эр-да-ха-эр-хунь” гэдэг нь “Ха-ла-бэнь-чжи-тунь” гэснийг тонгоруулсан хэрэг болно. Энэ халуун рашаан нь одоогийн Хишигтний даваа шилийн зүүн бэлд буй. ... Энэхүү Даваан шил гэдэг нь Хянган нурууны уулс болно” гэжээ. Өвөр Монголын нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн түүхч Лю Цзинь Со нөхрийн галигласан “Нууц товчоон” (тосон бар)-ы эхэд: “Өнийн Хянган давааг эрт үед Харагун жидүн гэж хэлнэ” гэжээ. Х.Пэрлээ: “Нууц товчоон”-д Зүүн гар буюу Харагун жидүн-ий газрыг Мухулай-аар захиргах болсноор үзвэл, энэ газар дорнод Монголд байх ёстой. “Жидүн” гэдэг үг бол манж хэлэнд “Уулын шанаа” гэсэн үг” гэжээ. Эдгээр байдлаас үзэхүл, энэхүү “Харагун жидүн” гэдэг нь одоогийн Улаанхотоос дээш байх рашаан орчмын Хянган давааг заасан бололтой.

67 Энэ удаагийн байлдааны явцад их бороо цас орсныг Буйруг хан, Хутуга хоёр салхи урьж бороо цас оруулах “шид”-тэй тул тэдний оруулсан бороо биедээ хор хийв гэж түүх шастирт тайлан тэмдэглэж байдаг. Тэр үед их бороо цас орсон нь үнэн хэрэг байж болно. Ингээд би байлдааны явагдсан цагийг намар, өвлийн үе гэж бичив.

68 Тайчигудыг дарсан тухай “Лу. Алтан товч”-д “Гурван зуун Тайчигудыг дарсан” үлгэр гэж нэлээд домогжуулан уран зохиолын аргаар бичсэн үлгэр байдаг байна. Үүнийг Ц.Дамдинсүрэн түүний одоочилсон “Нууц товчоон”-ы 149 дүгээр зүйлийн эхэнд (139-164 дүгээр нүүр) нэмэн жагсаажээ.

69 1202 оны өвөл Чингис хаан Тайчигудыг дарсан хойно хаа өвөлжсөн тухай хэдэн янзын тэмдэглэл байна. “Нууц товчоон” (148 дугаар зүйл)-д “Хуба хаяа өвөлжив” гэжээ, “Биеэр

дайлсан тэмдэглэл”-д “Абжига Хөтэгэр ууланд буув. Ван хан нь Бэрх манханд буужээ” гэж тэмдэглэж байх бөгөөд Ван Го Вэй-н тайлбарт, Хэрлэнгийн өмнө Цэцэн хаан аймгийн зүүн гарын дундад өмнөд хошуу ба Дундад адаг хошууны уулзар газар байдаг “Хөдөө арал” бол энэ “Абжига Хөтэгэр” мөн бололтой гэсэн бөгөөд Ван ханы буусан “Бэрх манхан” гэдэг нь Туул голоос өмнө байх Чэгчэр уул мөн гэжээ. Гэтэл “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д: Хааны өвөлжсөн “Аруг Хонгирад” гэдэг бол “Дэй сэцэний намтар”-т дурдсан “Хүрээн өндөр” гэдэг газар мөн. Тэр нь Кэнь гол, Талбур гол, Эргүнэ гол гурван усны дунд нь байдаг учраас Арал (“Судрын чуулган”-д хаан болон Ван хан Аралд хамт буулаа гэсэн нь үүнийг хэлжээ) гэдэг нэртэй билээ. “Аруг” (а ла хэ) ба “а ла цюэ” гэдэг нь бүр уулын ар гэсэн утгатай үг юм. Энэ газар бол Хонгирад аймгийн өвөлжөөний газар болно гэжээ. Энэ нь яриангүй одоогийн Өвөр Монголын Хөлөн Буйр аймгийн гурван голын уулзар орон болно. Миний үзэхээр, Чингис хаан тэр өвөл Ван хан лугаа ойр буусан нь лав юм. Учир нь, дараагаар нь Сэнгүмийн охин дүүг бэр гуйсан явдал гарах юм. Бас Ван хан Туул өөд ирээгүй нь зүйтэй юм. Учир нь Хүйтний байлдааны дараа Ван хан, Жамуха-г нэхсэн газар нь мөн Кан мөрний орчим байжээ. “Биеэр дайлсан тэмдэглэл”-д дурдсан тэр газрууд бол Ван хан, Чингис хаан хоёр муудалцаж нүүж явсан хойно буусан газар болно. Тиймээс би, Ту Цзи-гийн тайлбарыг зүйтэй болов уу гэж өмнөхийг нь баримтлав.

70 “Абжига Хөтэгэр”-ийг “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д: “Хөлөн Буйраас өмнө Хүйтэн гол (одоогийн Хуй гол бололтой) гэж буй, голоос баруунш гучин газар Хан уул гэж буй, үүнийг Чингис хааны цэрэг сууж байснаас Хан уул гэсэн нэртэй боллоо гэдэг. Уулын доогуур нь Хүйтэн гол, голын хоёр хөвөөгөөр нь бүр тал газар бөгөөд тэр нь даруй Хүйтэн хээр болно. Энэ Абжига Хөтэгэр бол Хан уулын амсар болох ёстой” гэжээ. Х.Пэрлээ түүнийг “Халх голын ойр (уртраг нь 119°, өргөрөг нь 47°) байсан бололтой” гэж байх нь газрын байцаараа Ту Цзи-гийн тайлбартай бүр нийцэж байна.

“Жэжэгэр өндөрийн Жэр хавцгай” бол Ван ханы буусан газар болно. Энэ газрыг “Биеэр дайлсан тэмдэглэл”-д “Чэгчэр өндөр” (чэ чэ юнь ду шань) гэж, “Юань улсын түүх, Тайцзуйн шастир”-т “чжэ чжэ юнь ду шань” гэж, газрын зурагт Түшээт хан аймгийн зүүн гарын хойд хошууны “цэ цэ шань” гэж, “Монголын нүүдэлчдийн тэмдэглэл”-д Түшээт хан амйгийн зүүн гарын хойд хошууны “Хоруха улун нуур”-аас зүүн хойш тавин газарт “Хар хад уул” буй. Түүнээс бас зүүн хойш “Чэ-чэ шань” уул буй гэж тус тус тэмдэглэж байна. Энэхүү “чжэ-чжэ”, “цэ-цэ”, “чжэ-чжэ”, “чэ-чэ” гэдгийг бүр “цэцэг” гэсэн нэг л утгатай гэж Ту Цзи авгай үзжээ. Х.Пэрлээ Хэрлэнгийн дунд биеэр байлтай гэж жишжээ. Ли Цзэ Фэнь авгайн номд Ван ханы байсан Жэжэгэр өндөрийг одоогийн Хар өндөр уул гэсэн бөгөөд тойм зурагт нь Хэрлэнгийн дунд биед зуржээ.

“Бэрх Элэд” гэдэг газрыг дээрх баримтуудад бараг Жэжэгэр Өндөрийн ард байдаг элсэн газар гэжээ.

71 “Нууц товчоон” (166 дугаар зүйл)-д “Хардахитай, Өвөгжин, Ноёхин” гурван нэрийн хажуугийн орчуулга нь бүр “овгийн хүн” гэдэг. Үүнээр үзэхүл, энэ нь бодтой хүний нэр биш, харин тэр овгийн нэгэн нэр тэмдэглэсэнгүй хүн болох мэт. Энэ “Хардахитай”-г бас 166 дугаар зүйлд “Хардагад” гэж тэмдэглэж байна. Би “Хардахитай”-гаар нэгтгэв. “Ноёхин” (на я цинь)-ийг Гу Гуань Цзи-гийн уг эхэд “на бу цинь” гэж тэмдэглэж байжээ. Үүнийг П.Пеллио,

Хэйниш, Лигети нар “на бу цинь” бол “на я цинь”-ий ташаа гэж үзэж байсан бөгөөд Өвөр Монголын товчоочид ч бүр “на я цинь” гэж залруулжээ. Японы монголч Мураками Шёожи гэгч “Хардахитай, Өвөгжин, Ноёхин” гэснийг “Хардахин овгийн удирдагч Ноёхин” гэсэн ондоо үг болгосон бөгөөд “Хардахин” бол “Хатагин” гэсний ташаа үсэг гэжээ. Ц.Дамдинсүрэн “Хардихитай”-г “Хар Хятадын” гэж, “Өвөгжин, Ноёхин”-ыг “ Өвөгжин Ноёхон” гэж ганц хүнээр, “Сүхэгэдэй, Тоорил”-ыг “Сүхээдэй Тоорил” гэж бас ганц хүнээр тэмдэглэж байв. Эдгээр нь бүр нэлээд тааваараа тайлсан тайлбар болох мэт. Дорнотив нөхөр байдлыг танилцуулаад, өөр баримтгүй бол бичлэгийг өөрчлөх хэрэггүй гэж үзсэнийг зүйтэй санал гэж би үзжээ. Би энд Баяр нөхрийн бичлэгээр баримт болгосон боловч, “Хардахитай, Өвөгжин, Ноёхин” гурвыг бодот хүний нэр биш, овгийн нэр гэж үзэж байх бөгөөд “Хардахитай”-г “Хатагин”-аар үзэх нь мөн зүйтэй мэт. Хатагин, Ноёхин овог бол бүр тэмдэглэлтэй юм. Ганц “Өвөгжин” нь бодтой баримтгүй боловч хажуугийн хятадчилгыг нь итгүүштэй.

72 “Багалзуур идэх” ёс бол монгол үндэстний богтлолын тухай уламжлалт заншил юм. Үүнийг “Нууц товчоон”-ы хажуугийн орчуулгад “сүй тогтсон дайллага” гэж тэмдэглэж байна. Нөхөр Дорнотивийн шинэ хятадчилгад: “багалзуур” бол амьтны хоолой хавийн мах, энд хонины багалзуурыг хэлж буй. Сүй тогтох дайллага дээр энэ юмыг хэрэглэдэг учир гэвэл, хоёр этгээдээрээ ургаа буцаж болохгүй гэсэн санааг харуулжээ. Хожимдоо энэ ёс нь сүй тогтох үед биш, харин хурим хийх ёслолдоо энэ агуулгыг багтаадаг болжээ” гэж тайлжээ. Ц.Дамдинсүрэн бас: “багалзуур идэх” гэх нь хонины багалзуур махыг ид гэсэн үг биз. Залуу эр эм гэрлэсэн өдрөөс эхлэн гурван хоног хонины хүзүү багалзуурыг хувааж идэх заншил Монгол газар одоо ч хүртэл байна. Хүзүү багалзуурын яс маш бат хэлхээтэй байдаг тул үүгээр эр эмийн бат холбоог бэлэгджээ. Иймийн тул “Багалзуур ид” гэх нь эр эм болох хурим хийе гэсэн үг биз гэж тэмдэглэжээ.

73 “Муу өндөрийн байлдаан”-д холбогдох газрын нэрс гэвэл: “Муу өндөр”, үүнийг “Халх, Нөмрөг хоёр голын ойр байжээ” гэж Х.Пэрлээ тэмдэглэсэн нь нийт байдалд тохирч байх мэт. Гэвч өөр янзаар тэмдэглэсэн мэдээ бас байдаг. “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д: Өвөр Монголын Хишигтэн хошуунаас баруун өмнөш дөчин гурван газарт бүхий “мо хай инь ду эр” бол энэ удаагийн байлдааны талбар “Муу өндөр” мөн бөгөөд наян хоёр газарт бүхий “У лань бу тун” бол “Улаан бургад” мөн” гэжээ. Энэ газар бол тухайн үед Алтан улсын хилийн дотор байсан тул Ту Цзи-гийн энэ тайлбар бодтой байдлаас нэлээд зөрөөтэй байна. “Биеэр дайлсан тэмдэглэл”-гийн Ван Го Вэй-н тайлбарт: “Одоогийн баруун үзэмчин хошууны өмнө байх улаан даваанаас үргэлжилсэн “Сайн өндөр” гэдэг уул бол эртний “Муу өндөр” уул мөн” гэжээ. Гэтэл Ли Цзэ Фэнь авгай “Муу Өндөр уул бол одоогийн Хан уул” мөн гэсэн бөгөөд харин Хан уулын бодтой байрыг одоогийн Хөлөн нуураас баруун хойш, Манжуураас баруун өмнөхөн байхаар тэмдэглэжээ. Энэ бол бодтой байдалтай нэн ч зөрөөнтэйг тэмдэглэх хэрэгтэй. Учир нь Чингис хаан “Муу өндөрийн байлдаан”-ы дараа Халх гол дагуу ав тавин өмнөөс хойш явж байсан юм.

“Хар халжан элс”, үүнийг Ц.Дамдинсүрэн “Хархалзан элээт” гэжээ. Энэ нь хятад галигийг нь баримтласан явдал болно. Эртний монгол хэлэнд “су” дагаварыг “д” дагавараар хэрэглэх нь цөөнгүй харагддаг (балгас - балгад, элс - элд, бургас - бургад мэт) билээ. Халх, Нөмрөг голоос доош “Нуран элс”, “Утайрд элс”, “Мойлт элс” гэж олон элс байдаг гэлээ. Тиймээс

эртний “Хар Халжан элс” ч тэр хавьд байсан ёстой. Энэ удаагийн байлдааныг Дэн Сян Бинь-ий зохиосон “Чингис хааны дуулал” гэдэг номд “Ха лань чжэнь”-ий байлдаан гэжээ. Энэ нь “Хар Халжан элс”-ийг халгуу(эндүү, ташаа – хө.) тэмдэглэсэн явдал болно.

“Улаан бургад”, Ц.Дамдинсүрэн, Х.Пэрлээ нарын галиглал адил. “Бургад” гэх нь “бургас” гэсэн үг болно. “Судрын чуулган”-д “Хулан Буркаг” (хулан бурхад) гэж бичдэг боловч “Улаан бургас” гэж тайлсан нь зөв юм. Энэ газар Халх, Нөмөргө голоос ойр байжээ.

74 Алчидайн адуучин “Чихидай”, “Ядир” хоёрыг “Нууц товчоон”-д “Чи-цзи-дай”, “Я-дэ-эр”, “Биеэр дайлсан тэмдэглэл”-д “Тай-чу”, “Судрын чуулган”-д “Тайчу, Джабкитай-эдэр”, “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д “Тай-чи-цзи-дай” гэж тус тус адилгүй бичиж байна. Бид “Нууц товчоон”-ыг баримтлав.

75 “Муу өндөрийн байлдаан”-д оролцсон Чингисийн цэргийн тоо нь “Нууц товчоон”-д хоёр мянга зургаан зуу (байлдааны дараагийн бүртгэл), “Биеэр дайлсан тэмдэглэл”-д дөрвөн мянга зургаан зуу, “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д гурван мянга хүрэхгүй, “Д`Оссоны түүх”-д тун цөөн гэж адил бусаар тэмдэглэж буй. Ингээд би гурван мянга гэж барагцаалан бичив.

76 “Жирхин” гэдгийг Ц.Дамдинсүрэн “Жүрхин” гэжээ. “Нууц товчоон”-ы хажуугийн орчуулгад “овог” гэжээ. “Д`Оссоны түүх”-д “Чирхир” гэжээ. Тэр нь бараг энэ Хэрэйдийн зургаан салбарын нэг болох “Жирхин” байж мэднэ.

77 “Буйр нуур” бол одоогийн Өвөр Монголын Өөртөө Засах Орны Хөлөн Буйр аймаг ба Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хилийн зааг (уртраг нь 118°, өргөрөг нь 48°)-т бүхий нуур болно. Тэр нь 615 тэгш дөрвөлжин км хэмжээтэй, 10-11 метр гүн (зарим материалд 50 метр гүн гэдэг). Загасан гаралттай. Халх гол зүүн өмнөөс нь цутгадаг, ердөө Буйр нуурыг Хөлөн нуур (далай нуур)-тай холбож “Хөлөн Буйр” гэдэг бөгөөд хоёр нуурын хооронд нь Оршун голоор холбож байдаг.

“Халх гол”-ыг “Нууц товчоон”-д “гол” гэснийг нь товчилж бичдэг юм. Энэ гол нь Дундад улсын Хөлөн Буйр аймаг болон Монгол улсын хилийн заагаар урсч, Буйр нуурт цутгадаг, 233 км урт, Номхон далайн усан системийн дотоод хуурайн гол болно (уртраг нь 119°, өргөрөг нь 47°).

“Орнугу-гийн хэлтгий хад” гэдгийг “одоогийн Амбан хот (Хайлар)-оос өмнөш, Халх голын хойно нэгэн “Урт уул” гэж байдаг, энэ ууланд “халх вангийн хүүр” гэж буй, энэ нь харин Хуйлдарын ясыг оршуулсан газар байж мэднэ” гэж Ту Цзи авгай тэмдэглэв. Х.Пэрлээ: “Халх голын солгой этгээдэд эртний Абжига Хөтэгэрийн ойр байжээ” гэж тайлав.

“Түнгэ горхи”-ийг “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д одоогийн Хөлөн Буйрын Амбан хотоос өмнө хоёр зуун газар дахи Хан уулын баруун талд байдаг “Түнх нуур” бол энэ “Түнгэ горхи” мөн бөгөөд энэ нуурын ус нь хойш далан газар урсч Хуй голд цутгадаг учраас “горхи” гэжээ. Энэ Хан уул бол мөн Чингис хааны “хаан”-аар нь нэрлэсэн гэлээ. Бас энэ “Түнгэ горхи”-ийг “Буйр нуураас Балжуна нуур орох замд байсан” гэж Х.Пэрлээ тэмдэглэжээ.

78 “Нууц товчоон”-ы 141 дүгээр зүйлд Хонгирадын түрүү “Дэргэг, Эмэл, Алхуй” гэж гурван

хүний нэрээр дурдаж билээ. Дараа нь 176 дугаар зүйлд: “Тэрэг, эмээлтэн Хонгирад буй” гэжээ. Үүнийг “Биеэр дайлсан тэмдэглэл”-д “Түүний (Хонгирадын) ноён Тэмүгэ Амун” гэжээ. Ц.Дамдинсүрэн “Тэргэн эмээлтэй тэнэмэл хонгирад” гэжээ. “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д эдгээр олон хэлбэр бол бүр бичлэгийн ташаа гэж үзээд “Нууц товчоон”-ы 141 дүгээр зүйлээр нэгтгэжээ. Тус товчоонд Ту Цзи авгайн үзэлтийг баримтлав.

79 “Тоорил”-ыг “Нууц товчоон”-ы 180 дугаар зүйлд: Урьд Тумбинай, Чарахай Линху хоёр байлдаанд яваад Огда гэгч боолыг барьж ирэв. Тэр Огда боолын хөвгүүн Сүбэхэй боол бөлгөө, Сүбэхэй боолын хөвгүүн Хөхөчү Хирсаган бөлгөө. Хөхөчү Хирсаганы хөвгүүн Егэй Хондагар бөлгөө, Егэй Хондагарын хөвгүүн Тоорил гэжээ.

Гэтэл манай мэдэж байхаар, “Нууц товчоон”-ы 120 дугаар зүйлд “Сүхэхэний Жэгэй Хондагар” гэсэн хүн байдаг, түүний хөвгүүн бол Сүхэгэйжэгүн болно. Энд дурдаж байгаа Тоорилын эцэг “Егэй Хондагар” гэсэн нь “Жэгэй Хондагар” лугаа нэг л “Ж”, “Е”-гийн зөрөөтэй байж байна. “Муу өндөрийн байлдаан”-ы дараа Чингис хаанаас Архай Хасар, Сүхэгэйжэгүн хоёрыг элч болгон Ван хан нарын тэнд явуулсан билээ. Гэвч ганц Архай Хасар буцаж ирээд Сүхэгэйжэгүн тэнд хоцорчээ. Түүний хоцорсон шалтгаан бол “Сүхэгэйжэгүний эм хөвгүүн тэнд Тоорилд ажгуу” (“Нууц товчоон”, 181 дүгээр зүйлд) гэжээ. Үүнээр үзэхүл, энэ Сүхэгэйжэгүн болон Тоорил хоёр ер бусын харьцаатай гэж мэдэж болно. Тиймээс “Жэгэй Хондагар” “Егэй Хондагар” гэсэн нь нэг л хүн, Сүхэгэйжэгүн, Тоорил хоёр бол ах дүү хоёр гэж хэлж болох мэт. Үүнийг лавлах бас нэгэн шалтгаан гэвэл, эртний түрэг хэлэнд “ж”, “е”-г хутгаж хэлдгийг анхааралтай. Жишээлбэл манай одоогийн хэлдэг “засаг”-ийг эртдээ “зас” буюу “яс” гэдэг. Тэрчлэн “Егэй” гэдэг нь “их” гэсэн үг байж мэднэ.

Дээр дурдсан нь зүйтэй болдог бол тус товчооны гуравдугаар бүлгийн дагалдварт 18 дурдсан “Сүхэчин” (Сүхэхэн) овогтон бол Тумбинай, Чарахай Линху-гийн боол Огда-гийн үр хойч боол зарц болохоор сүх хадуур хэрэглэж ажил хийдгээсээ “Сүхэчин” гэж хэлсэн магадгүй гэж надад төрөгдүүлж байна. Ийм бол энэ овог ч ирэлтэй болно.

80 “Асан” бол Дундад Азийн Сартуул (Хорезм)-ын худалдаачин болно. Үүнийг “Нууц товчоон”-д дурддаг явдал бол энэ хүн Чингис хаанд үйлчилснийг харуулж байна. Гэвч “Нууц товчоон”-д шууд тэмдэглэл харагддаггүй. Өгөөдэй хааны үед Тогучарын хамт өртөө замыг эрхлэн зассан “Арч” болон Чан-чунь аршийн “Баруунш зорчсон тэмдэглэл”-д гардаг “Аришан” гэдэг хүн бүр энэ “Асан”-ыг ондоогоор тэмдэглэсэн явдал болно гэж Ту Цзи авгай үзжээ. Энэ “Асан”-ы тухай нөхөр Дорнотив:

“Энд арьс ноос худалдан авч яваа Хорезмын худалдаачныг гэнэт бичээд доош мэдээгүй тасарчээ. Бодоход агуулга гээдсэн байж мэднэ. Эрдэмтэд энэ асуудлыг олон янзаар хэлэлцдэг билээ. Түүнийг ирэхэд Чингис хаан яг ялагдаж, идэх хүнсгүй байсан тул тэр мянган хониороо Чингисийн цэргийг тохинуулаад Чингис хааны шадар, цаашилбал сайд түшмэл нь ч болсон байж мэдэх бөгөөд хожим нь Хорезмыг дайлахад чухал үйлдлийг үзүүлсэн гэж үзэцгээдэг билээ. Ийм зүйчлэл нь бүр ултай байж болох юм. Гэвч бодтой баримтаар нотлохын аргагүй юм” гэж тэмдэглэжээ. Асан Хорезмын дайнд оролцсон тухай Джувеини-гийн тэмдэглэлд Дженд хотын орчим Сыгнак хотод элчлэн очиж, тэндэхийн ардад алагдсан Хасан Хажиг гэж гардаг Сартуул худалдаачдыг Бартольд “Нууц товчоон”-д гардаг “Асан” мөн гэжээ.

81 “Эргүнэ мөрөн”-ийг одоо “Эргүнэ гол” гэдэг. Тэр бол Хармөрөний өмнөх эх нь болох бөгөөд одоогийн Өвөр Монголын Өөртөө Засах Орны зүүн хойд хил болно. Хянган даваанаас ундарсан Хайлар гол бол Эргүнэ мөрний дээд эх нь болно. Хайлар гол баруунш урсч шинэ Барга зүүн хошууны Авгайт орчим хүрч Эргүнэ голтой нийлж зүүн хойш урсч Хар мөрөн мужийн Мо-хэ голоос баруунш Энх хадын орчим хүрч Шилка голтой нийлснээс эхлэн Хар мөрөн гэж нэрлэдэг билээ. Эргүнэ мөрний бүх урт нь 1.520 км (түүний дотор Хайлар гол 622 км) бөгөөд Номхон далайн усан системийн гол болно.

82 “Балжуна нуур”-ыг хэд хэдэн газар байхаар тайлбарлацгааж байна. Байгалийн Буриадын аг нутагт байх “Балжуна нуур”-ыг эртний Балжуна нуурмөн гэж Х.Пэрлээ үзжээ. Хун Цзюнь-ий “Онон мөрний умард Балжуна гэдэг нуур байдаг” гэсэн нь бараг Х.Пэрлээгийн хэллэгтэй таарч байна. Ту Цзи авгай Хөлөн нуурын баруун өмнө байх жижиг нуурыг мөн гэжээ. Сартуулын худалдаачин Асан Эргүнэ мөрнийг даган явж Балжуна нуурт ирсэн гэсэн “Нууц товчоон”-ы тэмдэглэлээс үзвэл, энэ нуур нь Эргүнэ мөрний доор сав газарт байхаас биш Ононы умарт байж болохгүй гэж Ван Го Вэй үзжээ. Энэ тухай Юань Го Фэнь-гийн өгүүлэлд “Балжуна гол бараг одоогийн Олгой голын эх орчимд байсан бололтой” гэж үзсэн бөгөөд “Оросын хилд байна” гэсэн Хун Цзюнь-ий тайлбарыг буруу гэж, “Хөлөн нуур мөн” гэсэн Ли Вэнь Тянь-ий үзэлтийг ч сэжиглэлтэй гэжээ. Эдгээрийн дотор Ту Цзи-гийн үзэлт бодот байдалтай нэлээд ойртох болохоор би түүнийг нь баримтлав.

“Балжуна нуурын тангараг” гэдэг түүхэн учрыг “Юань улсын түүх, Жабар хорчийн намтар”-т нэлээд нарийн тэмдэглэж буй. Түүнд дурдсан гол агуулга нь: Чингис хаан болон Хэрэйдийн Ван хан муудалцаж, Ван хан гэнэт цэргээр дайрсан тул Чингис хааны цэрэг бэлтгэлгүй байснаас ихээр дийлэгдэж, хааныг дагаж гарсан нь арав есхөн хүн байжээ. Эд Балжуна нуурт ирж, хүнс хоолгүй гачигдаж байхад хойноос нэгэн хулан чихтэй ирснийг харван алаад амь гол залгасан тул хаан тэнгэр өөд хандан, анд нөхөдтэйгээ зовол жаргалаа хамтатгана гэж тангараглалаа гэжээ. Тэр үед арав есхөн хүн үлдлээ гэдэг нь таарахгүй юм. “Нууц товчоон”-ы тэмдэглэлээр бол хоёр мянга зургаан зуун хүн болно. Удалгүй Хэрэйдийг мөхөөснөөс үзэхүл, энэ удаа Чингис ялагдсан биш, харин тангараг хийсэн нь арав есхөн хүн байж болно. Гэвч хэн хэн болох тухай тодорхойлох бодтой баримтгүй. “Шинэ найруулсан Юань улсын түүх” гэдэгт арван хэдэн нэр дурдаж буй. Энэ тухай Цзя Цзин Янь нар “Жабар хорчийн намтар” зэргийг үндэслэж дурдсан арван зургаан хүн бол: “Жабараас гадна Чингисийн дүү Хасар, хүргэн дүү Буту, Мангудын түрүү Хуйлдар (хятадаар Шу-чи-тай гэжээ), Уругудын түрүү Жүрчидэй, Чингисийг төлөөлж Ван ханыг угтан ирсэн Тахай баатар, дайралдаан бүхнээс хоцордоггүй Сүбээдэй болон түүний эцэг Хабал, ах Хорухун, хэзээд хошуучилж явдаг арван хоёр тамачи (морьт туршуул – хө.) цэргийн ноёны нэг нь болох Ажуру, хожим нь Өгөөдэй хааны баруун мөрийн түшмэл болсон Хингай, тайфу цолоор өргөмжлөгдсөн Елюй Ахай болон түүний дүү Елюй Тохуа, бас Сэчэгүр болон Май Ли-гийн дээд Хасана, Сюэ Ли Цзянь На Янь” (“Чингис хааны түүхийн тухай хэдэн асуудал” гэдэг өгүүлэл, Монголын түүхийн 1980 оны ээлжит хурлын түүвэр) зэрэг болно. “Юань улсын Тайцзу Балжуна голын усыг ууж тангарагласан тухай товч магадлалт” (Тайвань-ий “Их хуурай сэтгүүл”-ийн 19 дүгээр боть, 12 дугаар хугацааны 358 (26) дугаар нүүр) гэсэн тусгай сэдвээр нийтлүүлсэн Юань Го Фэний өгүүлэлд: “Юань Ши”, “Синь Янь Ши”, “Хуань Вэнь Сянь Цза”, “Мо Ань Цзи”, “До Юань Сюэ Бу Лу”, “Юань чао минь чэнь ши юэ”, “чжань Жань цзюй ши цзи” зэрэг номыг үндэслэж, “Балжуна-ын тангарагт оролцогсдын арван дөрвийг нь магадлаж болно гэж үзжээ. Тэр нь: (1) Хасана,

Хэрэйд овогтон; (2) Шогур, Мэргидэй овогтон; (3) Арачан (Асан, Жабарыг нэг л хүн гэдэг - эшлэгч), баруун орны Сайюн овогтон; (4) Ажинай, Орунардай овогтон; (5) Тахай, Сүлдүс овогтон; (6) Буту, Ихирэс овогтон; (7) Хингай (Чинхай – хө.), Хэрэйд овогтон; (8) Елюй Ахай, Хятан угсаатан; (9) Тохуа (Елюй Ахайн дүү) ; (10) Хувайту, Хэрэйд овогтон; (11) Шилугай, Жэгүүрэдэй (Жэгүүрэйд) овогтон; (12) Сүрихэн, Чэгүдэй; (Цахад бололтой, энэ нэр өөр ер харагдсангүй - эшлэгч) овогтон; (13) Хабал, Монголын урианхадай овогтон, Сүбээдэйн эцэг; (14) Хасар; хааны дүү зэрэг болно. Эдгээр арван дөрвөн хүнийг оролцсон гэж Юань Го Фэн тус тусын баримтыг нь эшлэж тэмдэглэжээ. Дээрх хоёр өгүүлэлийг харьцуулж үзвэл, Цзя Цзин Янь-ий дурдсан Хуйлдар, Жүрчидэй, Сүбээдэй, Хорухун дөрвийг Юань Го Фэн-гийн өгүүлэлд дурдсангүй бөгөөд Хувайду, Силугай хоёрыг Цзя Цзин Янь дурдсангүй байна. Харин Юань Го Фэн-гийн өгүүлэл дэх Арачан болон Ажинай бол хэрэг дээрээ Цзя Цзин Янь-ий өгүүлэл дэх Жабар болон Ажуру гэгч болно. Нөхөр Дорнотив “Юань улсын шинэ түүх”-ийг үндэслэвэл арван дөрвөн нэр тэмдэглэжээ (“Нууц товчоон”-ы шинэ хятадчилга, 169 нүүр).

83 “Жад горхи элэд” гэдэг газрыг “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д Өвөр Монголын Хуучид хошууны элсээр урсдаг Шилийн гол бол Ван ханы баруунш цэрэг ухрах зам мөн гэж тэмдэглэжээ.

84 “Аргал хөхи”-г Ц.Дамдинсүрэн “Аргал хохи” гэжээ. Энэ газар бол Хэрлэн мөрний тохойгоос өмнө байдаг Ижияр Чинаг уул болон голын умардахи Тооно уул лугаа зэргэцдэг. Энэ нь Балжуна нуураас баруун өмнөш явах зам болох бөгөөд Аргал Хөхи гэдэг газар энд байлтай гэж Ту Цзи авгай тэмдэглэжээ. “Монголын нүүдэлчдийн тэмдэглэл”-д: Цэцэн хан аймгийн Дундад адаг хошууны баруун хойно байх “Эрэгнэг” гэдэг газар бол эртний “Аргал хөхи” мөн гэжээ.

85 “Дидиг сахалын Нэгүн усан”-ыг “Юань улсын түүх, Өгөөдэй хааны шастир”-т “Жижиг цагаан нуур” гэж тэмдэглэжээ. Газрын зурагт Халхын Сайн ноён хан аймгийн Өөлд хошууны баруун хойно “Жирэмтэй” гэдэг гол “Цагаан нуур”-т цутгаж буй. Энэ нуурын ус нь зүүн хойш урсч Орхон голд цутгадаг. Энэхүү “Цагаан нуур” гэдэг нь даруй Дидиг Сахалын Нэгүн Усан мөн гэжээ.

86 “Нууц товчоон”-ы 190 дугаар зүйлд “Торбиташ”-ийг Найманы элч, “Юхунан”-ыг Онгудын элч гэж тэмдэглэж байхад “Биеэр дайлсан тэмдэглэл”, “Судрын чуулган” болон “Гао Тан Чжун Сянь ван хүргэний хөшөө” зэргэд яг эсрэгээр, Юхунан-ыг Найманы элчээр, Торбиташ-ийг Онгудын элчээр тэмдэглэж байна. Бид “Нууц товчоон”-ы тэмдэглэлийг баримтласангүй бөгөөд энэ “Юхунан”-ы бичлэгийг жаахан өөрчилжээ. “Нууц товчоон”-ы хятад галиг “Юэ-хунань” гэснийг Ц.Дамдинсүрэн “Ю-Хунан” гэж, “Биеэр дайлсан тэмдэглэл”-ийн монголчилгод “Жухунан” гэж, хөшөөний бичээст “чжоу-ху-нань” гэж, Баяр нөхрийн галиглалд “Ухунан” гэж галиглацгааж байна. Энэхүү “ню” ба “чжо” бол бас л эртний монгол хэлний “ж” “е”-гийн асуудал болно. Одоо бид ерөнхийдөө “Нууц товчоон”-оор баримтлал болгож байх тул “юэ” нь “юу”-тайгаа ойртох болохоор “Юхунан” гэж галигласнаа мэдэгдье.

87 “Наху гун” гэдгийг Орхон голын баруун эрэгт байдаг “Хөх чулуут” мөн бололтой гэж “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д дурдсан бөгөөд “Наху” гэдгийг “ногоо” гэсний хувирал гэж үзжээ. “Уртраг нь 104°, өргөрөг нь 47°-т байдаг Лаху баян гэдэг уул мөн болов уу” гэж Х.Пэрлээ тэмдэглэжээ.

88 “Тэмээн хээр”-ийг Х.Пэрлээ Халх голын ойр байсан гэжээ. “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д: Хар мөрөний шинэ зурагласан зураг дээр, Хөлөн Буйрын Амбан хотоос өмнө гурван зуу жаран газарт “Тэ-мо тэ-ни”-гийн даваа гэж байдаг, давааны өмнө бас тийм нэртэй арваад газрын урт гуу байдаг, түүний дундуур их, бага “Турал гол” баруун өмнөш урсч Халх голд нийлдэг билээ. Энэ “тэ-мо тэ-ни” гэдэг бол “тэ-ме янь” гэсний хувирал болно гэжээ.

89 “Тамир”-ыг одоо “Тамир гол” гэдэг. Энэ бол Хангайн нуруунаас эх авсан дотоод хуурайн гол мөн бөгөөд өмнө, хойно хоёр Тамир гол нийлж Орхон гол (уртраг нь 102°, өргөрөг нь 47°)-д цутгаж буй.

90 “Хар талын язгуур” гэдгийг Х.Пэрлээ “Хар тал хужагур ~ ужагур” гэж бичээд Сэлэнгэ Хануйн бэлчээр (уртраг нь 101°, өргөрөг нь 49°)-ээс дээш байсан гэжээ. “Биеэр дайлсан тэмдэглэл”-д “Э ши эр хэ” голын язгуур гэжээ. “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д: Газрын зургаар үзвэл, Сайн ноён хан аймгийн баруун гарын хойд хошууны Эдэр голын дээд урсгалд “Хужагур ~ ужагур” гэдэг гол хойш урсч Эдэр голтой нийлдэг юм. Энэхүү “Э-де-эр-хэ” гэдэг нь “Нууц товчоон”-ы “Хо-жи-ма-эр-хэ” гэсэнтэй, “Хо-жи-у-эр” гэдэг нь “Биеэр дайлсан тэмдэглэл”-ийн “Э-де-эр” гэсэнтэй тус тус нэг л газрыг тэмдэглэж байна. Гэвч одоогийн газрын зурагт “Хар тал” гэснийг тэмдэглэдэг үгүйг бодоход энэ Эдэр гол нь “Хар тал”-аар урсан гардаг учраас эхийг нь тэмдэглэж өнгөрөх газрыг нь тэмдэглэсэнгүй байж мэднэ гэжээ.

91 “Дөрэгэнэ хатан”-ыг “Юань улсын түүх, хатад татварын илтгэл”-д Өгөөдэй хааны нэрийн доор, хоёрдугаар байрт зургадугаар хатан Дөрэгэнэ бол Наймжин овогтон гэжээ.

92 “Тайхал хороо”-г “Нууц товчоон”-ы хажуугийн орчуулгад “Шань Динь Сай Цзы” гэжээ. “Биеэр дайлсан тэмдэглэл”-д “Тай ань сай” (монголчлогыг нь “Нууц товчоон”-той нэгтгэжээ) гэв. “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д газрын зургийг баримтлаж, Халхын Засагт хан аймгийн харьяат Урианхайн нутагт Тайрис (Тай-ли-сы), Тэрмид (Де-эр-ми-дэ) хоёр голын хооронд Тохан (То хань шань) уул гэдэг уул байдаг. Энэ “Тохан” гэдэг нь “Тайхал” гэсний “л” авиаг нь товчилсон хувирал гэж үзжээ. Энэ “Тайхал” бол “Тан улсын түүх, Уйгурын намтар”-т дурдагддаг Танхань (Тань-хань Шань) уул мөн гэжээ.


93 94 95 “Сохог усан”-д умард Найманы Хүчүгүд Буйруг ханыг устгасан байлдааныг “Нууц товчоон”-ы тавдугаар ботид шарагчин тахиа жил - 1199 оны явдлаар тэмдэглэж, “Биеэр дайлсан тэмдэглэл”-д улаан барс жил - 1206 онд Монголын хаант улсыг байгуулснаас дараахи учраар тэмдэглэж байна. Ту Цзи авгай үүний тухай нарийн магадлалт хийж, үүнийг хөхөгчин үхэр жил - 1205 оны хавар, Хүчүлүг-ийг нэхэн байлдахаас өмнөхөн болсон явдлаар тэмдэглэж байв. Бид үүнийг нь баримтлав.

Энэ “Сохог усан” бол Ховдоос баруун хойш байх Салайгам нуруу ба Хүйтэн уулын хоорондуур зүүн өмнөш урсч хоёр зуун газар дахи Ховд голтой нийлдэг “Сохог” голыг хэлж буй. Энэ нь Ховдоос баруун хойш таван зуун газарт буй, 1199 онд Чингис хаан ба Ван ханы цэрэг хамтран Хүчүгүд Буйругийг Кызылбаш хүртэл нэхэж байсан. Гэвч тэр үед Найманы өмнөд хэсгийг устгаагүй бөгөөд Ойрадын Хутуга бэхи ч орж өгөөгүй байсан юм. Нэгд замыг нь дайсан эрхшээж, хоёрт замчгүй байсан байдалд Сохог усанд хүрлээ гэдэг нь үнэхээр сэтгэгдэшгүй хэрэг юм. Ялангуяа “Биеэр дайлсан тэмдэглэл”-д дурдсанчлан, 1206 онд хаант улс байгуулагдсаны дараахи явдал гэвэл нэн ч сэтгэгдэшгүй хэрэг болно. Учир нь улс

байгуулагдсан ёслолыг дуусгасан нь 1206 оны арван хоёр сарын явдал болох бөгөөд Онон мөрний эхнээс Сохог усан хүртэл таван мянган газар хол байдаг тул мориор явбал хэдэн сарын хугацаа хэрэгтэй юм. Тиймээс Чингис хаан урьдаар Хүчүгүдийг мөхөөж цаашид Хүчүлүг, Тогтуга бэхи-г нэхсэн нь цагийн талаар зүйтэй бөгөөд газар байцын талаар ч зүйтэй юм. Учир нь Сохог усан болон Эрчисийн Бухдурам бол хоорондоо нэг л Хүйтэн уул - Арайн давааг алсалж байна. Иймээс “Нууц товчоон”-д Чингис хаан үхэр жилийн хавар Арайгаар давж, Хүчүлүг лүгээ байлдлаа гэж тэмдэглэсэн байна.

96 Энд дурдаж байгаа Мэргидийн Тогтуга бэхи-гийн дөрвөн хөвгүүний нэрийг “Юань улсын түүхийн зүйл ялгасан найруулал”-д “Биеэр дайлсан тэмдэглэл”-ээс эшлэжээ. Энэ нь “Юань улсын түүх”-ийн 122 дугаар ботийн “Баржуг Арт Тигиний намтар”-ын тэмдэглэлтэй адил юм. “Судрын чуулган”-д зургаан хөвгүүнээр тэмдэглэж буй: Төгүс, Түсэ, Худу, Чулуун, Чибүг, Хулдухан мэргэн зэрэг болно. Гэтэл “Нууц товчоон”-ы 198 дугаар зүйлд “Худу, Гал, Чулуун түүрүүтэн” (Баярын галиглалд) гэж, Дорнотивийн хятадчилга ба Элдэндэйн харгуулан зассан дэвгэрт “гад, гэ-ти” гэж хоёр янзаар тэмдэглэж буй. Бас 1198 онд Ван хан ганцаараа Мэргидийг довтолж, Тогтуга бэхи-гийн ахмад хөвгүүн “Төгс бэхи”-г алсныг дээр нэгэнтээ дурдаж билээ. Ийм бол Тогтуга бэхи нь таван хөвгүүнтэй байсан бололтой. Энэ нь “Судрын чуулган”-аас нэг дугуу.

97 “Бор Хулд” гэдгийг Ц.Дамдинсүрэн “Бор элээ” гэжээ. Дорнотив “Хэй Чао” гэж хятадчилаад, нэгэн зүйлийн хөдхи чадалгүй шувуу гэж тайлжээ.



ЧИНГИС ХААНЫ БАЙГУУЛСАН ИХ МОНГОЛ УЛС

38. Их Монгол Улсын хаант төрийг анх тунхагласан нь

Улаан барс жил, нийтийн он тооллын 1206 оноо Чингис хаан дөчин таван настай байв. Энэ үед Чингис хаан Алтан Хинганы Ногоон нарст даваанаас Алтай нурууны Мөнх цаст оргил хүртэл, тунгалаг байгалийн төвшин талаас элст говийн өмнөд зах түмэн газрын Урт цагаан хэрэм хүртэл, зүүнш баруунш мянга таван зуугаад км, өмнөш умарш мянгаад км-ийн өргөн уудам нутаг дэвсгэр дэх “Хоёр зуугаад түмэн хүн амтай, гучин нэгэн овог аймаг”¹-ийг багтаасан эсгий туургат монгол хэлтнээ хураан бөөгнөрүүлж, монгол үндэстний нэгдлийг анх биелүүлсэн байна. Нийтийн он тооллын 1206 оны баян намраас эхлэн өвлийн сүүл сар болтол², Их Монгол Улсын хаант төрийг тунхаглах анхдагч их хуралдайг Онон мөрний тэргүүнээ Дэлүүн Болдог дахи Чингис хааны их ордонд хуралдуулжээ.

Төрийн хуралдайн их ордонг Чингис хааны хүрээний төв дунд нь “Тэнгэрээс эрдэнээр үүдсэн орд харш байгуулав” (“Тэнгэрээс заяат Махасамади хаанаас уламжилсан бичиг” - Ц.Дамдинсүрэн: “Монголын уран зохиолын түүх”, 89 нүүр). Тэр нь алтан хөвөөтэй хөх хөлтрөгөөр чимэглэсэн цас шиг цагаан өнгөтэй том их монгол гэрийн хэлбэртэй ордон³ болох бөгөөд тооныг тулсан бат дөрвөн тулгуурыг нь бүр шижир алтаар чимсэн байлаа. Их ордны үүдэн гадна, нэг талд Монголын төрийн далбаа “Есөн хөхөлт цагаан туг”⁴-ийг өндөр мандуулж, нөгөө талд нь Чингисийн дайчин үйл явдлын бэлгэ дэмбэрэл болсон “дөрвөн хөхөлт хар сүлд”-ийг нь өндөр мандуулжээ. Их ордны өмнө байдаг өргөн уудам их талбайд нь цэрэг жагсаал, найр наадам хийдэг байна.

Энэ удаагийн их хуралдайд оролцогсдод, Чингис хааны “алтан ураг, анд нөхөр, сайд ноёд, баатар жанжин нар ба бүх Монголын язгууртад” байв. Эд нар Монголын эл газраас удаан өдрийн аян замыг туулж, өөрийн гэр ордон, гэргий хүүхэд, зарц дагалт зэргээ зохих тоо тогтоолоор дагуулан ирсэн байв. Эдгээрийн гэр ордныг мөн зохих дэс дараагаар байрлуулжээ. Түүрүү эгнээнд хааны алтан ургийнхны ордныг байрлуулж, дараа эгнээнд олон ноёд түшмэдийн гэрийг тэд нарын тушаал зэргийн их багаар дэс дараалан байрлуулж, түүний араар тэдний хатад гэргий ба зарц дагалтынхи нь гэрийг байрлуулжээ.

Төв ордны дотор, хойд талын гол орд, өндөр шиг тавцангийн дээр цагаан морины бүхэл арьсаар бүрхсэн хааны ширээг байрлуулж, дэргэд нь Бөртэ үжин хатны суудлыг байрлуулсан байжээ. Чингисийн баруун гараар баахан доор шиг байрт хааны хөвгүүд, төрөл төрөгсөд ба олон түшмэд жанжин нар дэс дараалан суужээ. Хааны зүүн гараар баахан доор шиг байранд Бөртэ үжинийг залган Өгэлүн эх, хааны бусад хатад ба охид нар дэс дараалан суужээ (зураг 48 ыг лавлаарай).

Хааны ширээний өмнө алтан эдлэл, мөнгөн эдлэл, халиу булга, хатгамал дурдан, хамба торго зэрэг эд эрдэнэсийг уул манх мэт овоолж, энэ өдөр эзэнд бараалхах хүн бүхэнд шагнахаар бэлтгэж байжээ.

Улсын баярын өв тэгш их ёслол эхэллээ.

Хааны алтан ураг төрөл ба олон удирдагч жанжин нар нэгэн цагаан эсгийг5 газар дэвсэж, Тэмүжинийг дээр нь суулган дамнаж, олноороо “Чингис, Чингис” гэж хашгиралдсан уриан дунд хааныг ширээнд нь залж суулгав. Дараа нь олон төрөл садан, түшмэд сайд нар нь хааны өмнө сөгдөж, есөнтөө (зарим тэмдэглэлд дөрвөнтөө гэдэг) мөргөж, хааны зарлигийг ёсчлон гүйцэтгэхээ тангараглав. Ингээд олноороо босч, Чингис хааныг хааныг ширээтэй нь мөрнөөсөө дээш өргөж, талбайг нэг тойром эргэлээ. Энэ үед хуралдайд оролцсон энгийн ард иргэн бүхэн сөгдөж мөргөн ёслолыг гүйцэтгэв.

Дараа нь хаан ордны бичгийн багш, тамгын сайд Тататунгаа-гаас цагаан хасын дээр шинэхэн сийлсэн хааны тамгыг6 хурагсадад үзүүлэн “Мөнх тэнгэрийн хүчин дор Их Монгол Улсын Далайн их хааны зарлиг ил булха иргэн дор хүрвээс биширтүгэй аюутугай” гэсэн тамганд сийлсэн зарлигийг хурсанд уншиж өгөн хас тамгыг хаанд өргөв (зураг 4 ийг лавлаарай).

Тэндээс эзэн зарлиг болруун: Мүндэнэн явж, нармайг зовон зохиж, зонхилон хураахуйяа мүнлэж зоволдон жаргалдан хүчээ үлэмж өгсөн, молор эрдэнэ мэт энэхүү бэд улс минь, мунгаа үзтэл зовбоос бээр, ерөнхийн гол болсноор хөдөлхүйн дээд хөх МОНГОЛ хэмээгдэхүйг > хэмээн зарлиг болсноос хойногшихи Хөх Улс Монгол хэмээжээ (“Эрдэнийн товч”).

Энэ үед сүр жавхлант хөгжмийн эгшиг цуурайтай зэрэг, олон төрөл садан, түшмэд сайд нар нь босч өөрсдийнхөө авч ирсэн үнэт ховор бэлэг сэлтээ хаан болон хатанд өргөн дэвшүүлэх ёслолоо гүйцэтгэлээ. Хаан бас хариу бэлэг өгч байв.

Энэ ёслол дууссаны дараа, архи барих зарлиг буумагц, хөгжмийн анги нь бас хөгжимдөж эхэллээ. Хаан хатнаас эхлэн, бүгдээр хэм өргөж саалийн дээж сархадаа зооглохын хамт,

олноороо босч, эрэгтэйчүүд нь хааны өмнө, эмэгтэйчүүд нь хатдын өмнө бүжиг бүжиглэлээ. Энэ үед Чингис хаан өөрийн өмнө тавьсан бүхэл хонины шүүсээс бөөн бөөнөөр огтлон авч, түүний өмнө ирж архи барин бүжиг өргөгсдөд шагнаж байв. Ийм шагнал хүртсэн хүнийг бүгдээрээ бахархан харж байсан бөгөөд тэр хүн энэ шагналыг маш нандигнаж, хэнд ч өгөлгүйгээр ганцаараа иддэг билээ.

Төв их ордонд архи сархад барьж найрлахын зэрэгцээгээр, талбайд хурсан энгийн ард иргэд ч мөн адилаар найрлалдаж байлаа. Эсэг цэгээ, архи сархад, болсон адууны мах жич үнэртэн амттан зэргийг тэрэг тэргээр тээж тасралгүй хангаж байжээ. Энэ үед Чингис хаан туйлын баяр баясангуй жавхлан ба өршөөнгүй талбиу овроор хурагсдын хамт инээлцэн ярилцаж байсан бөгөөд бүх хурагсадыг зочин ёсоор хүндэтгэж байсан юм гэнэ. Эсгий туургатан улсаа байгуулж, энх төрөө шударгатгасан энэхүү их хуралдай нь олон өдөр үргэлжлэн найрлалдаж хуримлахын хамт олон арвин төрийн хэргийг ярилцан тогтоосон билээ.

39. Гавьяатныг шагнаж, тушаалтныг томилсон

Энэ удаагийн их хуралдай дээр “есөн өрлөгүүд түрүүлэн, хүчээ өгөгсөдөд, нармай улсын төрийг засахын тул, гүн их цол, хүнд их яам (тушаал),хүртээл их өглөгийг, хүнд хөнгөн зэргээр нь соёрхож, зуутан, мянгатан, түмтэн, түг түмтний ноёд болгон нармай улсад их шанг түгээвэй” (“Эрдэнийн товч”). Эдгээр шагнагдагсадад наян найман гавьяатан буюу ерэн таван мянганы ноёдыг нэгд нэгээр нэр дурджээ. Энэхүү ерэн таван мянганы ноёдыг тус бүлгийн дагалдвар13-т тусгай танилцуулах тул энд товчиллоо. Одоо үүний дотор онцгойлон шагнаж, тусгай тушаалд томилсон хүмүүсийг дурдвал доорхи мэт.

Шигихутуху-д: “Чи миний зургадугаар дүү биш үү? өргөмөл дүү чамд, өөрийн дүү нарын адилаар өмч хувийг олгоё. Бас чиний ач тусын хариуд, есөн удаагийн алдал ослыг хэлтрүүлэе” гэж зарлиг болгосон бөгөөд “Мөнх тэнгэрийн ивээлээр гүр улсыг зүглүүлж бүхийд, чи үзэх нүд, сонсох чих болж яв. Бидний эх ба дүү нар, хөвгүүдэд эсгий туургатны дотроос эзлэх хувийг олгож, хавгас үүдтэн (байшинд суудаг тариачдыг хэлж байх мэт - эшлэгч)-ий дотроос харьяалах ардыг хувааж өг, чиний тушаасан үгийг хэн ч өөрчилж үл болмуй” гэж зарлиг болжээ. Ингээд Шигихутуху-г “Гүр (бүх) улсын доторхи хулгайг цээрлүүлж, худлыг мохоож, өгүүлэх ёстойг өгүүлж, яллах ёстойг яллаж бай” гэж Гүр улсын дээд заргач болгов. Бас “Гүр иргэний хувилсан хувийг, шийтгэсэн заргыг хөх дэвтэрт бичиж дэвгэрлэгтүн. Шигихутуху над лугаа зөвлөж, хөх бичиг цагаан цаасанд дэвтэрлэснийг ургийн ураг хүртэл хэн ч бүү өөрчлөтүгэй! Өөрчлөгсөдийг яллагугай” гэж зарлиг болов. Энэхүү “Дээд заргач” гэдгийг одоогийн үгээр хэлбэл дээд шүүх хорооны дарга юм.

Дараа нь Мүнлиг эцгийн ач тусыг дурдаж, ялангуяа Ван хан, Сэнгүм хоёрын мэхлэн дуудсан ов мэхийг нь илчилж, аюулаас гэтэлгэсэн ачийг дурдаж, ургийн ураг хүртэл үл мартахыг илтгэж, одоо энэ тэргүүн суудалд суулгаж, он бүр осолдохгүй, сар бүр саатахгүй сайшаал шагнал өгч байя гэж зарлиг болов.

Дараа нь Боорчу-гийн хар багаасаа ирж, хагацашгүй нөхөрлөн, хамаг дайсныг дарах тэмцэлд нь хатан зоригоор тэмцсэн хамаг гавьяа зүтгэлийг нь тоочиж, “одоо бүгдийн дээр суулгаж, есөн удаа осол гаргавч ял хэлэлцэхгүй болгоё” гэж зарлиг болоод, Боорчу-г баруун гарын Алтай дэрлэхүүн (Алтайн уулсыг түшин нутаглаж ахуй – хө.) түмний ноён болгожээ.

Дараа нь Мухулайд урьд Хурхунаг Жубурт бууж байхад Мухулай тэнгэрийн заарин (сүлд)-ы заасан үгийг тэмдэглэн хэлсний тул, эцгийг нь шийтгэж Мухулайтай үг барилдсан билээ. Одоо түүний ёсоор би их сууринд суусан тул Мухулайг ургийн ураг хүртэл гүр иргэний Гуй Он (энэ бол “Нууц товчоон”-ы тэмдэглэл болно. Чухамдаа Мухулайд Го ван цол шагнасан цаг бол 1217 оны наймдугаар сар билээ - зохиогч) болгоё гэж зарлиг болоод, зүүн гарын Харагун Жидүн дэрлэхүүний түмний ноён болгов.

Түүний дараа, Багарины Хорчи, Уругудын Жүрчидэй нарыг тус тус гавьяа зүтгэлийг нь сайшааж магтсан бөгөөд гурван мянган багарины дээр Тахай, Ашиг хоёрын хамт Адархины Чонос, Түгүлүс, Тэлэнгүд аймгийг нэгтгэж түмэн иргэн болгон Хорчи-д захируулж, Эрчис мөрний дагуу ойн иргэн хүртэлх нутаг ба ойн иргэнийг Хорчи-гийн түмэнд захируулжээ.

Чингис хаан бас өөрийн татвар хатан Ибагаг Жүрчидэйд соёрхож, Жүрчидэй-гээр дөрвөн мянган Уругудыг нь захируулжээ.

Дөрвөн хошууч (Сайн нохос)-ийн тэргүүнд явдаг Хубилай-гаар “Цэргийн үйл бүгдийг ахлах” ноён, одоогийн үгээр хэлбэл штабын ерөнхий дарга болгов.

Гэнигэс овогтны Хунан-гаар Гэнигэсийг түрүүлүүлж, Жочи-гийн доор түмний ноён болгов. Тэрчлэн Хунан, Хөхэчүс, Дэгэй, Усун өвгөн эд дөрөв бол үзсэнээ үл нуун, сонссоноо үл далдлах үнэнч шударга тул энэхүү чигч занг нь сайшаав. Үүнээс үзэхүл, Чингис хаан доорхи хүмүүсийнхээ санал, ялангуяа адил бус саналыг сонсч, санал тавигсдыг өшөөлөхгүй мөртөө харин сайшаадаг байна.

Дөрвөн хошуучийн дэдэд явдаг Зэлмэ-г есөн удаагийн осолд буруушаан яллахгүй гэж зарлиг болов. Бас Толун чэрби, Өнгүр багурчи нарыг тус тус нэр дурдан сайшаав.

Дараа нь дөрвөн хүлэг баатрын нэг нь болох Борухул-ын гавьяа зүтгэлийг нарийн тодорхой тэмдэглэж, есөн удаагийн ослыг яллахгүй гэж зарлиг болов.

Дараа нь, охин ураг (эмэгтэйчүүд)-ийнхаа гавьяа зүтгэлийг тусгайлан сайшаан хишиг соёрхол өгчээ.

Эмэгтэйчүүдийн тухай “Нууц товчоон”-ы энэ мэдээ хэдийгээр дөхөм хэдэн үг боловч, энэ нь харин Монголын нийгмийн онцлогыг харуулсан чухал нэгэн мэдээ болно. Эрэгтэйчүүд гаднахи ажлаа хийж, эмэгтэйчүүд нь гэр зуурын ажлаа хийдэг нь монгол үндэстэн одоо болтол уламжилж ирсэн заншил юм. Энэхүү гэр зуурын ажил гэдэг нь малжих орны байдлаар авч хэлбэл, хонь хурга хайчлах, эсгий ширдэг хийх, гэр тэргийг арчлах, аргал түлш бэлтгэх, сүү цагаа боловсруулах, идэш ууш бэлтгэх, үйл оёдол оёх, үр хүүхдээ сургах мэтийн аливаа ар талын ажлыг бүр эмэгтэйчүүд эрхэлдэг юм. Энэ бол монгол үндэстний уламжлал болно. Үүнийг Чингис хаан мэтийн агуу их хүн ч мэдэрч хишиг соёрхол өгсөн бөгөөд “Нууц товчоон” мэтийн баларшгүй тулгар бичигт тэмдэглэгджээ. Энэ тухай Березин ч маш их анхааран, нэлээд нарийн тэмдэглэжээ: “Цэрэг элсэх зарлиг буумагц, (Монголын) эрс нь арьсан малгайгаа сураар хийсэн дуулгаар сольж зүүгээд морддог. Байлдааны бэлтгэлд эрсийн хийх ажил бол гагцхүү зэр зэвсгээ л сайтар арчлан байдаг. Харин эмс нь, эрсийнхээ хэрэглэх дах, гутал, эсгий, оймс ба болгосон адууны мах, хатаасан хурууд эзгий болон арьсан уутанд

хийсэн эсэг зэргийг нь хэзээ мордовч бэв бэлхэн болгон байдаг. Эмэгтэйчүүдийн хоёрдугаар үүрэг бол өвлийн идшээ бэлтгэдэг юм”, “Чингис хаан, эрэгтэйчүүдээрээ тусгайлан дайн байлдаан хийлгэдэг бөгөөд мөн ашиг олохын төлөө эмэгтэйчүүдээ ч зохион байгуулдаг. Тэр, эмэгтэйчүүдэд эрх ашиг ба эрх чөлөөг олгож өгсөн явдал бол Азийн бусад орнуудад ер байгаагүй анхдагч жишээ болох юм”, “эм хүний хамгийн дээд үүрэг тушаал бол эрийнхээ итгэл хүндийг нь дээшлүүлэх явдал мөн” тул энэ нь Чингисийн билиг сургаалд хүртэл тэмдэглэлтэй юм гэжээ. Үүнээс гадна, алдарт жуулчин Марко Поло бас Монголын эмэгтэйчүүдийг нэлээд нарийн дүрслэгээр тэмдэглэсэн байв. Жишээлбэл: “Тэдний (Монголыг зааж буй - эшлэгч) эхнэр бүсгүйчүүдийн цэвэр ариун хийгээд хөдлөх аашлахын ёс ёслолтой сайхан нь ертөнц дээр тэднийг хэтрэгчидгүй, бас эр нөхөртөө янаг амраг хийгээд хүндлэн асрах нь мөн хосгүй” гэж ёс мораль-ийн талаар тэмдэглэснээр үл барам, “Аливаа худалдан авах буюу худалдан өгөх арилжааны ажлыг цөм эхнэр бүсгүйчүүд нь эрхлэн үйлдмүй. Бас эхнэр бүсгүйчүүд нь тэдний эр нөхрийн хийгээд гэрт нь хэрэглэх эл зүйлийн юмыг мөн цөм тэд бэлтгэмүй. Бүстэй хүн нь өдөр сараа цөм тайга (анч нохой - хө.) тавин харцгай нисгэх, ав авлах хийгээд цэргийн явдлын амьдарлагад хэрэглэмүй” гэж Монголын эмэгтэйчүүдийн тэсвэр хатуужилтай ажилч хөдөлмөрч байдлыг нь дүрслэн тэмдэглэв.

Дараа нь, монгол үндэстний төр ёс ба зан заншилд хамгийн ахмадаа бөө мөргөлийн дээд захирагч бэхи болгодог тул “Ниругун Монголчууд”-ын дотор ахмад овогтон бологч Багарины Усун өвгөнийг цагаан дээл өмсгөж, цагаан морь унуулан, бэхи өргөмжлөн дээд сууринд суулгав.

Дараа нь, бие үрэгдсэн баатар Хуйлдар, Цагаан гуа (энэ Цагаан гуа-г Арван гурван хүрээний байлдаанд Жамуха барьж алсан юм)-гийн гавьяа зүтгэлийг нь дурсгаж, үр ач нарт нь өнчинд олгох хишиг тэтгэмжийг өгөх зарлиг болгосон бөгөөд онцгойлон Цагаан гуа-гийн хөвгүүн Нарийн Тоорил-ыг Нэгүс (даруй Чонос овогтон) ах дүү нараа цуглуулж ургийн ураг хүртэл захирч яв гэж зарлиг болов.

Дараа нь Сорхан шар, Бадай, Хишилиг гуравт “Дархан” цол өгчээ. Энэ дархан цол гэдэг нь “Олон дайсанд мордвол олзоо өөрөө авдаг, ан гөрөөнд явбал алснаа бүрнийг эзэмшдэг, нутгийн сайнаар нүүх, усны тунгалагаар ундлах, есөн удаагийн ослыг үл яллах, аливаа алба гувчуурыг үгүйсгэх” онцгой эрхийг ганцаар эзэмшихийг хэлж байна.

Дараа нь Нүцгэн Багарины Шүргүгэтү өвгөний хөвгүүн Наяа-г “Тус хаанаа үл тэвчих их ёсыг мэдсэн хүн” гэж Боорчу, Мухулай-н адилаар төв түмний ноён болгов.

Дараа нь, дөрвөн хошуучийн нөгөө хоёр болох Зэв, Сүбээдэйд олсон зүүсэн иргэнээ мянгат болгон захирч яв гэж тушаажээ. Тэрчлэн хоньчин Тэхэй, модчин Хүчүгүр-т хүртэл энд тэндээс харьяат иргэдийг цуглуулж, мянганы ноён болгожээ.

Чингис хаан энэ мэтээр ач тус хүргэсэн хүмүүсийг алаглалгүйгээр шагнаж, гавьяа зүтгэл байгуулсныг зүй ёсоор зэрэг тушаалд томилжээ.

40. Хаант Монгол Улсын төрийн байгууламж Хаант Монгол Улсын тулгуур төрийн суурь ба шинж чанар

Чингис хааны байгуулсан Хаант Монгол Улсын төрийн байгууламж нь ямар байсан гэдэг асуудлыг тодорхойлоход, юуны урьд Хаант Монгол Улсын суурь ба түүний шинж чанарыг товч ч болтугай дурдах хэрэгтэй байна. Хэлэлгээнгүй энэ нь нийгмийн байгуулалд холбогдох асуудал тул тус товчооны гол үүрэг биш юм.

Арван гуравдугаар зууны эхний үед, манай бөмбөрцгийн төвшинд буй болсон Хаант Монгол Улс бол тэнгэрээс буусан “сум” биш, дэлхийгээс дэлбэрсэн “галт уул” ч биш, тэр бол тухайн үеийн Монголын нийгмийн орчин ахуйгаас мэндэлсэн “үр” юм. Өөрөөр хэлбэл, Чингис хааны байгуулсан Хаант Монгол Улс арван гуравдугаар зууны эхний үеийн монгол оронд л мэндэлж чадахаас биш, өөр цаг үе, өөр оронд байж болшгүй билээ. Нэг л үгээр хэлбэл, тэр үеийн Монголын нийгмийн байгуулал нь даруй хаант улсын үндсэн суур болж өгсөн юм. Баахан бодтой шиг хэлбэл гурван талын ахуй байдал дээр сууриллаа гэж хэлж болох мэт.

Хамгийн тэргүүнд дурдагдах үндсэн суурь нь эртний уламжлалт “Хуучин Монгол Улс” болно. Хэн бүхний мэдэж байхаар, Чингисээс өмнө бүх Монголын нэгдмэл төр гэж байгаагүй юм. Гэвч Монголын том аймгуудад арван нэгдүгээр зууны сүүлч буюу арван хоёрдугаар зууны эхээр тус тусынхи нь төрийн дээд байгуулал - “хан” гэгч ноёрхогч буй болжээ. “Хамаг Монголыг Хабул хаан захирч” байсан тэр үеэс хойш Хотала хаанд хүртэл, “хаан” (хан)-тай, ноёнтой, цэрэгтэй, засагтай (анхны) “Хамаг Монгол Улс” гэсэн ийм нэгэн нийгмийн ба улс төрийн хэлбэр бүхий “Ниругун Монголчууд”-ыг бид “Хуучин Монгол Улс” гэлээ. Энэ нь хэрэг дээр “Ниругун Монголчууд”-ын улс төрийн цогц болно. Энэхүү “Хуучин Монгол Улс” гэдэг нь чухам ямар шинж чанартай “улс” болох тухай өдий болтол нэгдэлтэй санал хараахан төвлөрч чадаагүй мэт. Тус товчоонд энэ асуудлыг шууд ярилцах хэрэгцээ тулгам тавьсангүй учраас би ч ийм бэлтгэлийг хийсэнгүй. Гэвч, бид гол сэдэвтэйгээ уялдуулж, алдаа оноог дурдсан зүйлээс манай саналыг бараг мэдэж болох юм. Баахан бодтой шиг хэлбэл, “Хуучин Монгол Улс”-ын энэхүү байгууламж нь аймгийн холбоо гэдэг овгийн байгууллын сүүлчийн хэлбэрээс цаашид нэг алхам хөгжсөн хэлбэр болох мэт. Одоо бид бас л Чингис хааны Хаант Монгол Улсын төрийн байгууламжид шууд холбогдох зарим асуудлуудыг товчхон дурдъя. Тэр үед “Хуучин Монгол Улс”-ыг захирч байсан ноёрхох байгуулал нь, “Ниругун Монголчуудын язгууртнаас түрүү хааны гэрээс буюу уламжлалт хууль ёсоор сонгон гаргасан” “хаан” болно. Тэр нь цэрэг дайн, ан гөрөө ба нийгмийн үйлдвэрлэл, хувиарлал зэрэг нийгмийн чанартай ажиллагааны хамгийн дээд удирдагч мөн. Бас “хаан”-ыхаа зарлиг захиаг биелүүлэх эл овог аймгийн түрүү ба эл шатны ноёд (нэр нь юу гэж байсан ч болтугай түүний тушаал чадал нь ноёрхох үйлдэлтэй юм) буй болжээ. Эднээр улс төрийн гүйцэтгэгч байгууллагыг бүрдүүлдэг. Түүнийг улс төрийн эрхэт байгууллага - хамт овгийн гишүүдээр бүрэлдсэн хуралдайгаар сонгон гаргана. Тэр үед Боржигид, Тайчигуд мэт Бодончарын залган төрлийн хамт овогтон ийм эрхэт байгууллагыг бүрэлдүүлжээ. “Хуучин Монгол Улс”-ын ноёрхох эрхийн бас нэгэн суурь бол “Ниругун Монголчууд”-ын ахмад овог (Багарин)-оос эрхэлдэг уламжлалт “сахиулсны эрх” болно. Тиймээс хуралдай, ноён (хан багтана), бэхи (шашны дээд хэргэмтэн) бол Чингис хааны Хаант Монгол Улсын үед буй болсон биш, харин “Хуучин Монгол Улс”-ын үеэс уламжилж иржээ. Энд бас онцгойлон дурдууштай нэгэн явдал гэвэл, “Ниругун Монголчууд” нь Хабул хааны үеэс эхэлж, аймгийн нийтийн эзэн - “хаан”-тай болсноор барахгүй, бусад монгол хэлтэн аймгуудад ч нийтийн эзэн - “хаан”-тай болсон юм. Жишээлбэл, Хэрэйдийн Ван ханы өвөг нь Маркус Буйруг хан гэдэг, эцэг нь Хурчакус Буйруг хан гэдэг билээ. Найманы “Таян хан” Тайбуха-гийн эцэг нь бас “Таян хан” Инанча билгэ

гэдэг билээ. Ван ханы өвөг эцэг Маркус Буйруг ханыг Татарын түрүү “Нуур Буйруг хан” барьж Алтан улсад хүргэжээ гэдгээс үзэхүл, Татарт бас хаан байжээ. Ингээд бид үүнийг Хаант Монгол Улсын төр байгууламжийнхи нь нэгэн суурь болсон гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, Хаант Монгол Улсаас өмнө бас өдий төдий жижиг “Хант Улс” бүрэлдээд байжээ. Чингис хааны гардан байгуулсан Хаант Монгол Улс нь эдгээр жижиг “хант улс”-уудыг нэгтгэн төвлөрүүлсэн юм.

Хоёрдугаарт дурдагдах үндсэн суурь нь хаант улсын бүрэлдэхүүн болсон адил бусын хөгжилтөт эл аймгууд болно. Чингис хааны нэгтгэсэн аймаг угсааг гучаад, дөчөөд буюу түүнээс илүү гэж янз бүрээр тэмдэглэдгийг бид тус бүлгийн дагалдварт дурдаж билээ. Түүний бодтой тоо нь хэдий байсан ч болтугай ерөнхий байдлаас нь үзвэл их төлөв гурван төрлөөр хувааж болох мэт. Нэгд, Боржигид, Тайчигуд зэрэг “Ниругун Монголчууд”-ын олон овогтон болон Хонгирад, Горлос зэрэг “Дүрлүгин Монголчууд”-ын олон овогтнууд болно. Энэ бол Монгол үндэстний гол цогц нь болох юм. Хоёрт, Хэрэйд, Найман, Мэргид зэрэг уйгур, Киргиз мэтийн түрэг төрлийн үндэстнүүдтэй нягт холбоотой байсан мөн түрэг гаралтай гэж хэлдэг монгол хэлтэн аймгууд болно. Эдгээр аймгууд нь Монголын бусад аймгуудыг бодвол аж ахуй, соёлын талаар нэлээд өндөр хөгжилттэй байв. Ялангуяа Найман бол хамгийн өндөр соёлтой аймаг байжээ. Бас Найман, Хэрэйд зэрэг нь несторианы Христосын шашныг шүтэж байсан нь өрнө дахинтай ямар нэгэн харьцаатай байсныг харуулж байна. Дундад Ази ба түүнээс баруунш буюу баруун өмнөш нэвтрэлцдэг Сартуул худалдаачид Монгол оронд нэвгэрсэн явдалд эдгээр аймгууд зангилааны чанартай холбоос болж байсан нь мөн мэдээжийн хэрэг юм. Тиймээс эдгээр аймгуудын бодтой байгууллууд нь Хаант Монгол Улсын төрийн байгууламжид идэвхтэй ач холбогдолтой юм. Гуравт, онгуд, Татар мэтийн Алтан улстай харьцаа холбоотой байсан аймгууд болно. Эдгээр аймгуудаас Хаант Монгол Улсын байгууламжид үзүүлэх нөлөө нь эдгээр аймгуудын хүчирхэг ихэд байсан биш, харин тэдний Алтан улс ба хятадын дотор газартай холбоотой байсанд оршино. Тэр үед хятад үндэстэн мянга гаруй жилийн феодалжсан түүхтэй үндэстэн байсан юм. Энэхүү гүн гүнзгий феодалын байгууллаас Хаант Монгол Улсад өгсөн анхны нөлөө нь түүнтэй харьцаа холбоотой байсан тэдгээр аймаг угсаагаар дамжих нь мөн хэн бүхний мэдэж байгаа хэрэг юм. Энд тэмдэглүүштэй нь Хаант Монгол Улсыг байгуулснаас хойш нэгтгэн авсан ойн иргэн мэтийн бас нэгэн төрлийн өвөрмөц хөгжилттэй овог аймгууд байдаг юм.

Гуравдугаарт дурдагдах үндсэн суурь нь Чингис хааны өөрийнх нь хүчис - “Хуучин Монгол Улс”, жижиг “Хант улс”-ын хүрээг ялан давсан Чингисийн цэрэгжлийн зохион байгуулалт болно. Энд, 1189 онд Чингис хаан анхдугаар удаа хаан өргөмжлөгдсөний дараа байгуулсан тугтам засгийн байгууллага ба “Наху гуны байлдаан”-аас өмнөх цэгцлэлт зэрэг нь онцгой анхаарууштай ажиллагаанууд болно.

Дээр товч дурдсан Хаант Монгол Улсын тулгуур төрийн үндсэн гурван суурь дахи түрүү хоёр зүйл нь гадаад нөхцөл болох бөгөөд сүүлчийн нэгэн зүйл нь сая Хаант Монгол Улсын тулгуур төрийн шинж чанарыг шийдвэрлэх үндсэн хүчис болно. Тиймээс Чингис хааны байгуулсан хаант Их Монгол Улсын тугтам тулгуур төр бол анхны феодал ёсны цэрэгжсэн хаант улс болох болов уу гэж би хувьдаа үздэг билээ. Гэвч тэр нь овгийн байгууллын ул мөр, аймгийн холбогдлын үлдэгдэл ба боол эзэмшлийн байгууллын им тамга зэрэг Монголын нийгмийн хөгжлийн өвөрмөц хэлбэрүүдийг бүр адилгүй хэмжээгээр хадгалж байсан нь мөн ч

маргаангүй хэрэг юм.

Хаант Монгол Улсын дээд эрхэт байгууллага

“Хуралдай”-н хэлбэр ба хааны харьцалшгүй эрх бол Хаант Монголын дээд эрхэт байгууллага мөн. Чингис хааны гардан байгуулсан Хаант Монгол Улс бол арван гуравдугаар зууны үед Азийн дотоод хуурайд байгуулсан тусгаар тогтнолт нүүдэлчний хаант улс гэдгийг дэлхий дахинаараа бүр зөвшөөрч байх юм. Чингэвэл энэхүү нүүдэлчний хаант улсын төрийн дээд эрхэт байгууллага ямархуу байсныг тодорхойлох хэрэгтэй байна.

Хаант Монгол Улсын ноёрхох байгууллын хамгийн дээд хэлбэр бол хаан эзний харьцалшгүй эрх болно. “Хуучин Монгол Улс”-ын үе дэхи олон жижиг “Хант улс”-ууд (Монгол, Хэрэйд, Найман, Татар, Онгуд мэт)-ын хаад нь тус тусын “хувь газар, харьяат газар”-таа онц эрхийг эдэлж байсан бол одоо - Чингис хааны Хаант Монгол Улсын үед, энэхүү эрх нь хэдэн арван аймаг угсааг хамарсан бүх Монголын хэмжээн дэхи туйлын дээд эрх болжээ. Тиймээс зөвхөн “хаан” гэж цоллоод зогсохгүй, “Их хаан”, “Далайн хаан”, “Чингис хаан” гэдэг. Марко Пологийн үгээр хэлбэл “Их хаан хэмээн өргөмжлөн дуудах буюу эсхүл олон түрүүлэгч эздийн түрүүлэгч эзэн” гэгч нь болно. Энэ үед Их Монгол Улсын “Далайн хаан” бол бүх Монголын феодал язгууртны эрх сүрийг төвлөрсөн илрэл нь бөгөөд төлөөлөгч нь юм. Тэр нь улс төр, аж ахуй, цэрэг дайны талаар бүр хамгийн дээд онцгой эрхтэй бөгөөд дайн байлдааныг зарлах ба зогсоох, олзолсон ард иргэд ба эд ашгийг шийдвэрлэх, сайд түшмэдийг томилох жич хаан орыг залгамлах мэт том чухал асуудлыг шийдвэрлэх (зарлиг буулгах) онц эрхтэй юм. Феодал ноёрхлын мөн чанарын талаар, Чингис хаан бусад аливаа улс үндэстний хаадтай бүр адилаар халдашгүй эрхтэй байжээ.

Гэвч, Монголын нийгэм бол нэгэн нүүдэлчний нийгэм болох бөгөөд энэхүү нийгмийн өвөрмөц орчин ахуйд оршин тогтнож, хөгжин улирч ирсэн монгол үндэстэн нь өөр улс үндэстэн лүгээ адилгүй өвөрмөц өв уламжлал ба зан заншилтай байсан аж. Энэхүү үндэстний онцлог нь Хаант Монгол Улсын төрийн байгуулалд зохих тусгалаа олж, Их Монголын хаант улс нь өөр энгийн “Хаант улс” (тэд ч мөн өөр өөрийн өвөрмөц онцлогтой юм)-аас ялгагдах илрэл болжээ.

Энэхүү онцлогийн төвлөрөнгүй илрэл бол Монголын хуралдайн дүрэм болно. “Хуралдай” гэдэг үгийг “хурал зөвлөгөөн” гэсэн утгатай түрэг гаралтай үг гэдэг. Уйгурчууд одоо болтол энэ утга, энэ хэлбэрээр нь хэрэглэж байна. Монголчууд энэ үгийг чухам хэдийнээс авч хэрэглэсэн тухай мэдээ харагдаагүй байсаар. Гэвч олонхи хүмүүсээс түүнийг эртний Монголын овгийн байгуулалтай холбож үздэг юмсан. Энэ нь татаж хэлэхэд энгийн жам ёс лугаа нийцэх юм. Овгийн байгууллын үе дэх овгийн гишүүд бүрмөсөн эрх тэгш байдал доор, овгийн доторхи том чухал асуудал - овгийн ахлагчийг эрх тааваараа сонгох ба огцруулах жич үйлдвэрлэл хувиарлалд холбогдох асуудлыг шийдвэрлэх нийгмийн байгуулал болох юм. Гэвч энэхүү “хуралдай” нь Монголын нийгмийн хөгжлийг дагалдаж, агуулгын талаар ба чанарын талаар хувирсаар ирсэн нь бас тодорхой байна. Манай мэдэж байх “хуралдай” бол харин олонхи нь бүр Монголын нийгэмд овгийн байгуулал задарсны дараахи үзэгдэл болох мэт. Ялангуяа Монголын нийгэмд “хаан”-тай болсноос хойш түүний чанар нь бүр хувирчээ. Хэлэлгээнгүй, “хаант байгуулал” нь ч боолт нийгэм ба феодалын нийгэмд бүр өөр өөрийн онцлогтой байдаг тул эдгээр үест “хуралдай” нь агуулга хэлбэрийн талаар мөн адилгүй

байсан нь мэдээжийн хэрэг. Жишээлбэл, Хабул хаан, Амбагай хаан, Хотала хааны үед хаан орыг залгамжлахад “ширах (энэ нь манж хэлний шираку буюу залгамжлагч, залгагч гэсэн утгатай үг бөгөөд Манжийн Чин улсын үед өвөрлөгчдийн зарим аман аялгуунд оржээ – хө.) дүрэм” бүрмөсөн батжаагүй байсан тул “хуралдайн дүрэм” нь нэлээд үйлдэлтэй байжээ. Ингээд Хабул хааны орыг түүний ахмад хөвгүүн Охин Бархаг залгамжласангүй, харин Хабул хааны төрлийн авга Сэнгүм Билгэ-гийн хөвгүүн Амбагай залгамжилжээ. Амбагай хаан Татарт баригдан Алтан улст хүргүүлж хорлогдох үедээ хаан ороо Хабул хааны долоон хөвгүүний дундахи Хотала болон өөрийн арван хөвгүүний дундахи Хадаан тайж хоёрын нэгээр залгамжлуулахаар нэр заажээ⁷. Ингээд “Хамаг Монгол, Тайчигуд нар Ононы Хурхунаг Жубур-т хурж (хуралдай хийж) Хотала-г хаан болгов”. Хотала хаанаас хойш Чингис хаанд хүртэл дөчөөд жилийн дотор Монголд хаан гарч чадсангүй учир нь, хаан орыг хуралдайгаар шийдвэрлэж чадахгүй, харин хүчээр тэмцэн авах нь гол болсныг харуулж байна.

Чингисийн үед, том чухал асуудлыг шийдвэрлэхэд олонхидоо хуралдайгаар ярилцдаг бололтой. “Нууц товчоон” зэрэг тулгуур бичигт тодорхой тэмдэглэлтэй нь бараг долоон удаа буй. Нэгдүгээр удаа нь 1189 онд “Ниругун Монголчууд”-ын язгууртад хуралдаж Тэмүжинийг анх удаа “Чингис хаан” өргөмжилжээ. Хоёрдугаар удаа нь 1202 онд Татар иргэний мөхөөсөн хойно, Чингис хаан алтан ургаа цуглуулж, Татар иргэнийг хэрхэн шийдвэрлэх тухай их зөвлөгөөн хийжээ. Гуравдугаар удаа нь 1204 онд Найман лугаа байлдах тухай авын газар их зөвлөгөөн хийжээ. Энэ удаагийн хуралдайд олон хүн оролцсон байна. Отчигин, Бэлгүтэй хоёрын саналыг зөвшөөрчээ. Дөрөвдүгээр удаа нь 1206 онд Хаант Монгол Улсыг байгуулсан их хуралдай болно. Тавдугаар удаа нь мөн 1206 оны их хуралдайгаас дараахан харьяат газар ба улс иргэнийг хувилсан зөвлөлдөөн болно. Энэ хурал дээр Өгэлүн эх ба Тэмүгэ Отчигинд түмэн иргэнийг өгсөнд эх нь чамлаж эс дуугарав гэдэг билээ. Бас авга Даритай Отчигин(Есүхэй баатарын төрсөн дүү)-оо Хэрэйдтэй нийлж явсан учраас нүднээс далд болго (ал) гэсэнд Боорчу, Мухулай, Шигихутуху гурвуул ятгаж зогсоожээ. Энэ зөвлөгөөнд нь зөвхөн алтан ураг нь оролцсон биш, харин шадар сайд нар нь ч оролцсон байна. Зургадугаар удаа нь 1216 онд Түмэд иргэний бослогыг дарангуйлуулахаар Борухулыг томилов. Борухул тэнд алагджээ. Ингээд Чингис хаан олон жанжин нараа цуглуулж, биеэрээ дайлахыг дурджээ. Гэвч Боорчу, Мухулай санал дурдан зогсоожээ. Энэ удаагийн хуралдаан нь 1204 оны хуралдаантай адил цэрэг дайны явдлын тусгай хуралдаан юм. Долдугаар удаа нь 1219 онд Чингис хаан баруунш дайлахын өмнө, Есүй хатны дуртгалаар, хаан ор залгамжлагчийг тогтоох их хуралдай хийжээ. Энэ удаагийн хуралдайд их хэрүүл зуурган болсон билээ. Хуралд оролцсон нь Чингисийн алтан ургаас гадна Боорчу, Мухулай, Хөхэчүс нар байсан бөгөөд хэрүүл зуурааныг шийдвэрлэхэд бүр санал тавьж байжээ. Энэ бол тэмдэглэлтэй хэдэн удаагийн хуралдай болно. Харин Тангуд, Алтан улс зэргийг дайлсан том явдлыг бүр хуралдайгаар шийдвэрлэх нь лав юм. Зөвхөн тэмдэглэл үлдээсэнгүй буюу тэмдэглэл нь үрэгдсэн төдий л билээ. Дээр дурдсан байдлаас үзэхүл: “Монголын хуралдайн дүрэм” нь Чингисийн үед хүрч ирээд, агуулгын талаар, оролцогсдын талаар шинэ онцлогтой болсон нь ч илхэн байна.

Чингис хаанаас хойш, Хаант Монгол Улсын хааны эрх улам төвлөрч, хаан орыг хааны ахмад хөвгүүнээс ширах дүрэм их төлөвдөө хуульчлан батлагджээ. Гэвч хуралдайгаар өргөмжлөх дүрмийг хэлбэр төдий ч болтугай нэлээд хойшид болтол хадгалсаар байв. Жишээлбэл: “Хөвгүүд ван нар, хүргэд нар, сайд түшмэд нар Хэрлэнгийн хөдөө аралд их хуралдай хийж, Тайцзун хаан (Өгөөдэй хаан - эшлэгч)-ыг нийтээр өргөмжлөн, сууринаа суулгав” (“Биеэр

дайлсан тэмдэглэл”): “Тайцзун хаан хальсан хойно, хааны хатнаас төрийг түр барьж, хөвгүүд ван нар ба сайд түшмэд нарыг цуглаан Далан Дабагас хэмээх газар хуралдай хийж, хаан өргөмжлөх явдлыг зөвлөжээ” (“Юань улсын түүх”, хоёрдугаар боть); “Динцзун хаан (Гүюг хаан - эшлэгч) хальсан хойно, төрөл ван Бат хаан ураг төрлийн их хуралдайг хийж Сяньцзун хаан (Мөнх хаан - эшлэгч)-ыг өргөмжлөх явдлыг зөвлөжээ” (“Юань улсын түүх”, 124 дүгээр боть); “Хубилай хаан үхсэн хойно, сонгуулийн их хурлыг Шаньду (дээд нийслэл)-д хийж ... Төмөр хаан орыг нь залгамжлав” (“Д’Оссоны Монголын түүх”, дээд дэвтэр) гэсэн тэмдэглэлүүд байдаг билээ. Энэ дүрмийг нэн цаашлуулан арван зургадугаар зуун болтол сүүлчийн Юань улсын хаад бас уламжилсаар байжээ. Жишээлбэл, Дарайсун Гүдэн хааны хөвгүүн Түмэн тайж 1558 онд хаан орыг залгамжилж, 1579 онд Зургаан түмнийг цуглуулан их цаазыг үүдээд, зүүн түмнээс Цахарын Амудай хунтайж, Халхын Үйзэн Субухай, баруун түмнээс Ордосын Хутугтай сэцэн хунтайж, Асудын Умдара Холачи ноён, Түмэдийн Амудай Чөрүхэ хунтайж эднээр засгийг бариулж, засагт хаан хэмээн хотол зүгт алдаршиж ... (“Эрдэнийн товч”, 135 нүүр) гэжээ. Дээрх тэмдэглэлүүд бүр адил бус үеийн “хуралдай”-н дүрмийг гэрчилж байна.

Багцлаад хэлбэл, Хаант Монгол Улсын төрийн дээд эрх нь бүр ганц хаан хүний гарт төвлөрч байсан боловч овгийн байгуулалаас уламжлалтай “Хуралдайн дүрэм”-ийг их урт хугацаанд залгамжилж иржээ. Гэвч энэхүү “хуралдай”-н дүрэм нь адилгүй нийгмийн байгуулал доор, адилгүй шинж чанартай байсан юм. Нэг л үгээр хэлбэл Хаант Монгол Улсын үеийн “хуралдай” бол феодал язгууртны ноёрхох багаж нь болж байсан билээ.

Хаант Монгол Улсын засаг захиргааны байгууллага

Ямар нэгэн улс гүрэн ч болтугай, тэр нь өчигдөрхөн байгуулагдсан тугтам төр байлаа ч гэсэн, түүнд заавал төрийн эрхэт байгууллага ба төрийн гүйцэтгэгч байгууллага - засаг захиргааны байгууллага (тэр нь ямар шинж чанартай, ямар хэлбэрийн ч байж болно) гэж байх хэрэгтэй. Хаант Монгол Улс ч ийм л байх ёстой.

Хаант Монгол Улсын засаг захиргааны байгууллага бол цэрэг, засаг хоёрын нэгтгэсэн түмэн, мянган, зуун, арван гэдэг зохион байгуулалт байжээ.

Энэ нь мөн ч тухай үеийн Монголын нийгмийн бодот ахуй ба монгол угсаатны өвөрмөц онцлог жич Чингис хааны тэмцлийн хэрэгцээнд тохирсон учраас буй болсон юм. Хаант Монгол Улс бол нүүдлийн мал аж ахуйгаар суурь болгосон өргөн уудам нутаг дэвсгэртэй улс байсан тул улс нийтээр маш тархай бутархай амьдарч байв. Ийм байдалд засаг захиргааны байгууллага нь суурьшсан улс үндэстэн лүгээ адил тийм их бөгөөд будлиантай байгуулалт байх нь тохиромжгүй юм. Монгол үндэстний аж ахуй, ялангуяа ан гөрөө хийх явдал нь цэргийн зохион байгуулалтын хэлбэрээр гүйцэтгэхийг шаарддаг бөгөөд Чингис хаан бүх Монголыг нэгтгэсэн урт хугацааны тэмцэл нь бүр зэвсэгт тэмцэл байснаар барахгүй, түүнээс өмнөх урт удаан түүхэн хугацаанд Монголын эл аймгууд ч бүр дайн байлдааныг тасраагүй хийж ирсэн уламжлалтай тул, энэхүү өвөрмөц онцлог нь Хаант Монгол Улсын төрийн байгууллагыг нөлөөлөхгүй байж үл чадах билээ.

Хаант Монгол Улсын төрийн гүйцэтгэгч байгууллагын ерөнхий байдлаас авч үзвэл: Чингис хаан бүх Монголыг нэгтгэх явцад гүйцэтгэгч байгууллага нь үгүйгээсээ байх болж, багаасаа

их болж, төгөлдөр бусаасаа төгөлдөржиж ирсэн түүхтэй юм. Чингис хаанаас өмнөх, өөрөөр хэлбэл “Хуучин Монгол Улс”-ын олон тархай бутархай жижиг “Хант улс”-ын засаг захиргааны байгууллага нь чухам ямар байдалтай байсныг нарийн тэмдэглэсэн материал ба тусгай судалсан мэдээ дэмий харагддаггүй бөгөөд бас ч тус товчооны агуулгад шууд үл холбогдох тул энд зөвхөн Чингис хааны үеийн байдлыг дурдах болно.

Хаант Монгол Улсын төрийн гүйцэтгэгч байгууллагын хөгжлийг их төлөв доорхи гурван шат үеэр хувааж болох мэт.

Нэгдүгээр шат үе нь, нийтийн он тооллын 1189 онд Тэмүжин анх удаа “Ниругун Монголчууд”-ын хаан - “Чингис хаан” хэмээх цолоор өргөмжлөгдсөнөөс нааш, 1204 онд Найман аймгийг нэгтгэн авсан “Наху гуны байлдаан”-аас өмнөх цэгцлэлт хүртэлх энэ арван таван жил бол Хаант Монгол Улсын төрийн үүслийн үе болно. Энэ үеийн гол онцлог нь “улсын тэргүүн” хаантай болж, дөхөм ч болтугай засаг захиргааны чанартай ажлын хуваарьтай болж тушаалтныг томилжээ (бодтой байдлыг тус товчооны гуравдугаар бүлэгт лавлаарай). Бас төрийн ёсоор элч томилж, Ван хан, Жамуха зэрэг зэргэлдээ аймагтаа мэдэгджээ. Ингээд түүнээс нааш аливаа төрийн том явдал, голдуу дайн байлдаанаар гол болгосон үйлдвэрлэл ба хувиарлалын том явдлыг энэхүү Чингис хаанаар төлөөлүүлсэн төрийн шинэ тушаалтад нь гүйцэтгэж ирсэн юм. Энэ хугацаанд тэд дайн байлдаан хийж, олон арвин аймаг угсаатай харьцаж явсан болохоор, төрийн байгууллагын талаар ч олон зүйлийг ойлгон мэдсэн бөгөөд өөрийн тэмцэл дундаа ч туршлага сургамжаа дүгнэн дээшлүүлжээ.

Хоёрдугаар шат үе нь, 1204 оны “Наху гуны байлдаан”-ы өмнөх цэгцлэлтээс эхэлж, 1206 онд Их Монголын Хаант Улс байгуулагдсан хүртлэх энэ хоёр жил гаруйн хугацаа болно. Энэ хугацаа хэдийгээр охорхон боловч үндэстнийг нэгтгэх байлдааны шийдвэрт ялалтыг олсон хугацаа болох бөгөөд Хаант Монгол Улсын тулгуур төрийн тогтносон хугацаа болох юм. Өөрөөр хэлбэл, удалгүй буй болох Хаант Монгол Улсын төрийн их асарыг энэ үед Чингис хаан ба түүний бодлогоч сайд нар нь нэгэнтээ зураглан төлөвлөжээ. Энэ үеийн гол онцлог бол цэрэг засгийг нэгтгэсэн мянгатын дүрмийг эхлэн тогтоосон явдал болно. Үүнээс өмнө, “Хуучин Монгол Улс”-т мянгат, зуут, аравтын дүрэм байсан эсэх тухай түүхэн тэмдэглэлд хараахан адилгүй бөгөөд дэмий нарийн мэдээ байдаггүй билээ. Түүхч Чжан Чжэнь Пэй-н “Чингис хааны шүүмжлэл шастир”-т: “Хаан (Чингисийг хэлж буй - эшлэгч) хэдийгээр аравтын ноёны гэрт төрж, зуут, мянгатын аймагт өссөн боловч...” гэж тэмдэглэж байсан бөгөөд “Монгол Татарын тухай бүрэн тэмдэглэл” гэдэг номд ч ийм дөхөм тэмдэглэл буй. Гэвч манай тулгуур баримт “Нууц товчоон”-д дурдсан нь 1204 оны эхний явдал болно. Энэ үед, Чингис хаан арван хэдэн жилийн үргэлжилсэн дайн байлдааны дунд цөөнөөсөө олширч, буурайгаасаа хүчирхэгжин, өөрийн бие нь агтын нуруун дээр боловсрогдон, алалдааны дунд хатуужиж, балчир бага хүүхэд байснаасаа баатар эрэлхэг нийтлэн захирагч болжээ. Ялангуяа тэр зохион байгуулалтын чухал ач холбогдолыг бүрмөсөн мэдсэн бөгөөд нүүдэлчин Монголын нийгэмд ямар хэлбэртэй төрийн байгууллагыг байгуулбал тохирно гэдгийг ч бүр мэдсэн байжээ. Ингээд тэр өөр аймаг угсаа, улс үндэстнийг үхмэлээр дуурайсангүй, өөрийн угсаатныхаа уламжлал ба өвөрмөц байдалдаа тохируулан “цэргээ хувиарлаж, мянганы ноён, зууны ноён, аравны ноён” ба түрүүлэн захирах их чэрби түшмэл зургааг томилжээ. Бас наян хэвтүүл, далан турхагуудыг тохируулжээ.

Энэ мянгатын байгуулал гэдэг нь өнгөрсөнд ямар ч зохион байгуулалтгүй тархай бутархай нүүдэллэн явдаг малчдыг хамгийн бага нүүдэлчний нэгж айлаар нэгэн байгал нэгж болгон, мөн нэгэн байгал нэгжээс нэг морьт цэрэг гаргаж чадахаар нөхцөл болгон, ийм арван байгал нэгжийг зохион байгуулж “арав” гэдэг бөгөөд нэг “арав”-д нь нэг ноён, есөн цэрэгтэй байдаг. Үүнийг үндсэн байгууламж гэж нэрлэж болно. Ойр зэргэлдээ ийм арван үндсэн байгууламжийг нийлүүлж нэгэн “зуу” гэдэг бөгөөд зууны ноёныг томилдог байна. Үүнийг бид орон нутгийн байгууламж гэж нэрлэж болно. Ийм арав орон нутгийн байгууламжийг нийлүүлж нэг “мянган”-ыг зохион байгуулдаг бөгөөд “мянга”-д нь мянганы ноёнттой. Энэ бол Хаант Монгол Улсын нийгмийн үндсэн нэгдэл болох бөгөөд байлдааны тусгаар нэгж гэж үзэж болно. Энэ бол овог аймгийн хүрээнээс давсан зохион байгуулалт болно. Өөрөөр хэлбэл, нэг “мянган”-ы дотор хэд хэдэн овог аймгийн иргэд байж болно.

Гуравдугаар шат үе нь, нийтийн он тооллын 1206 онд Хаант Монгол Улсын тулгуур төрийг байгуулснаас хойшхи хугацаа болно. Энэ хугацаа бол бүх Монголын нэгдсэн улсын тулгуур төр жинхэнээр тогтнож, мөн төгөлдөржиж бэхэжсэн үе юм. Энэ үеийн онцлог гэвэл доор дурдагдах хэдэн талаар илэрч байв.

Нэг, Монголын бүх орон нутгийг нэгтгэж, ерэн таван “мянган”-ыг хааны зарлиг (хуулиар)-аар баталжээ. Сүүлдээ зуу хорин есөн мянга болсон нь зөвхөн тооны талаар өргөтгөсөн явдал болно.

Хоёр, мянган гэгч энэхүү Монголын нийгмийн үндсэн нэгдлийн суурь дээр “түм” гэгч засаг захиргааны орон, цэрэг дайны хувиар хэлбэл байлдах бодлогын нэгжийг зохион байгуулжээ. Энэ нь Боорчу-гаар захируулсан Алтай орчмын баруун гарын түмэн, Мухулайгаар захируулсан Харагун Жидүн (Хянган даваа) орчмын зүүн гарын түмэн, Наяа-гаар захируулсан төв түмэн ба Хорчи-гоор захируулсан Эрчис мөрөн дагуу ойн иргэнд хүртэлх нутгийн умард түмэн зэрэг болно. Энэхүү “түмэн” гэдэг нь “зуу”, “мянга”-тайгаа адил нарийн тоогоор шаарддаг биш, харин орон нутгийн ерөнхий байдлыг нь үндэслэж, нэлээд чөлөөтэйгээр зохион байгуулдаг байдалтай мэт. Тэр нь орон нутгийн чанартай асуудлаа өөртөө эзэн мэдэж шийдвэрлэх нэлээд тусгаар чанартай байгууламж болох нь ч илэрхий байна. Энд Хорчи-гоор захируулсан умард “түмэн” нь маш сонгодог жишээ болж байна. Хорчийн түмэн бол “Гурван мянган Багарины дээр Тахай, Ашиг хоёр лугаа Адархины Чонос, Түгүлүс, Тэлэнгүд” зэрэг овог аймгаар бүрэлдэж, бас “Ойн иргэнийг Хорчи түмэн”-д захируулжээ.

Гурав, энэ үед орон нутгийн засаг захиргааны байгууллагыг цэрэг дайны зохион байгуулалттай уялдуулж улам төгөлдөржүүлснээс гадна, төв засгийн газраа бас ихээр чангатгасан байлаа. Тухайлбал, Шигихутуху-г бүх улсын заргачаар томилж, хууль цааз ба шүүх явдлыг эрхлүүлсэн; Хубилайг цэргийн явдлыг ерөнхийлөн захирах тушаалд томилж батлан хамгаалалтын ажлыг эрхлүүлсэн; Усун өвгөнийг бэхи-гээр томилж шашин мөргөлийн явдлыг эрхлүүлсэн; Дөдэй чэрби-гээр мал аж ахуйг эрхлүүлсэн; Тататунгаа-гаар тамга тушаа ба сурган хүмүүжлийн явдлыг эрхлүүлсэн зэрэг болно. Үүнээс гадна, тэрэг хөсгийг үйлдэх, гэр ордныг байгуулах, туг сүлд, зэр зэвсгийг хамаарах, хоол хүнсийг хангах ба ан гөрөөг хамаарах явдалд бүр тусгай тушаалтныг томилжээ.

Багцлаад хэлбэл, Хаант Монгол Улсын тулгуур төрийн байгууллага нь 1206 онд бүх Монгол орныг нэгтгэсэн явдлыг дагалдан төгөлдөржин бүрэлдсэн юм. Энэ нь аливаа нэгэн төрийн

байгууллагад байваас зохих эрх чадварыг бүрэн бүрэлдүүлжээ.

“Чингис хаан бүх Монголын хаан болсон явдлаар, Монгол үндэстний түүх шинэ шат үедээ шилжин орсныг тэмдэглэж байна. Олон зуунаас нааш Монголын эл аймгууд ер нэгдээгүй бөгөөд харилцан алалцаж, харилцан тэмцэлдэх явдал ер тасраагүй. Одоо тэд хүчирхэг чадвартай удирдагч Чингис хааны ноёрхол доор нэгдмэл цогцыг бүрэлдүүлэв. Ингээд Хөлөн Буйрын тал нутгаас баруунш Алтай нуруу хүртэлх өргөн уудам нутаг дахи үг хэл, аймаг угсаа, соёл боловсролын хөгжил байдал нь зөрөөтэй байсан эл аймгууд нэгдэж, тэдний хоорондохи соёл ба аж ахуйн харьцаагаа цаашид чангатгаснаас нийтийн хэл улмаар бүрэлдэж, эрэлхэг хөдөлмөрч Монгол үндэстний хамтын цогц эхлэн бүрэлдэв. Үүнээс эхлэн, агуу их монгол үндэстэн нь Дундад улсын түүхийн тавцан ба дэлхийн түүхийн тавцан дээр луг их үйлдлээ үзүүлсэн билээ” (Цю Шу Сэнь: “Юань улсын түүхийн тухай яриа”, хятад хэвлэл, 20-21 нүүр).

41. Чингисийн төмөр морьт цэрэг

Чингис хааны гардан байгуулсан Хаант Монгол Улс бол анхны феодал ёсны цэрэгжилсэн хаант улс болох бөгөөд түүний төрийн байгууллага нь ч цэрэг засгийг нэгтгэсэн “мянгатын байгуулал”-аар зохион байгуулсныг дээр нэгэнтээ тэмдэглэж билээ. Одоо цаашид дурдууштай нэгэн явдал гэвэл Хаант Монгол Улс нь тэр биеэрээ урт удаан хугацааны дайн байлдааны дундаас үүсч буй болсон юм. Өөрөөр хэлбэл, Чингис хаан арван хоёрдугаар зууны сүүлчээс арван гуравдугаар зууны эхний үе хүртэл, бүх монгол хэлтэн аймгуудыг нэгэн жолооноор хураан нэгтгэж, нүүдэлчний их гүрэн Хаант Монгол Улсыг байгуулсан ба цаашид “Дэлхийн дайлан дагуулагч”-ийн замд ороход хэзээд түүний захаас цэрэг салсангүй. Энэ цэрэг нь Азийн дотоод хуурайгаас Европын элгэн газар хүртэл, Монголын өндөрлөгөөс Персийн булан хүртэл хэчнээн олон улс гүрэн, угсаа үндэстнийг хэсэглэн дайрч байсан тул “Чингисийн төмөр морьт цэрэг” гэж дэлхий дахиныг донсолгосон алдартай юм.

Энэ цэрэг нь бас өөрийн үүсэл гарал, хөгжил хувиралттай байсаан. Энэ нь мөн ч ерөнхийдөө үгүйгээсээ байх болж, цөөнөөсөө олширч, буурайгаасаа хүчирхэгжиж ирсэн түүхтэй билээ.

Төмөр морьт цэргийн зохион байгуулалт

Чингис хаан чухам хэдийд цэрэг байгуулсан тухай тодорхой тэмдэглэл ерөөс харагддаггүй. Гэвч 1178 онд Боорчу, Зэлмэ нар ирж нөхөрлөсөн тэр үеэс эхэлж, цөөвтөр цэрэгтэй болсон гэхэд мөн зүй ёсонд нийцэх явдал юм. 1179 онд Ван хан, Жамуха-гийн тусламжтайгаар анх удаа Мэргидтэй байлдахад зохих хэмжээний цэрэгтэй байсан нь ч мөн дамжиггүй билээ.

Чингис хааны бүх цэрэг нь цөмөөр морьт цэрэг байсан нь маргаангүй хэрэг юм. Түүний зохион байгуулалтыг их төлөв дөрвөн шат үеэр хуваан үзэж болно. Нэгдүгээр шат үе нь, нийтийн он тооллын 1178 оноос эхэлж, 1189 онд Тэмүжин анх удаа хаан өргөмжлөгдөх хүртэл хугацаа болно. Энэ бол цэргийн байгуулалтынхи нь анхны шат үе болно. Энэ үеийн онцлог гэвэл, анд нөхөртэй нөхөрлөн, шинэ мандсан язгууртадтай холбоолж, цэрэг морийг элсэхээр гол үүргээ болгосон байжээ. Тиймээс зохион байгуулалтын талаар ч маш дөхөм бүдүүлэг байв. Их төлөв ан гөрөөнд хамтдаа мордож, бусад цагтаа гэр гэртээ тархан суудаг байжээ. Цэрэг цуглахдаа амуу хүнсээ авч болзооны цаг, болзооны газартаа цуглардаг бололтой. Энэ хугацаанд Мэргидтэй байлдаж, дайн байлдааны үйлдлэгийг анх удаа

өнгөрөөсөн явдал бол Чингисийн цэргийн байгуулалтад их ач холбогдлыг үзүүлжээ.

Хоёрдугаар шат үе нь, 1189 онд Тэмүжин анх удаа “Чингис хаан” хэмээн өргөмжлөгдөж, “Ниругун Монголчууд”-ыг захирснаас эхэлж, 1204 оны хавар цэргээ хувааж, “мянгат”, “зуут”, “аравт”-аар цэгцлэн зохион байгуулалтлах хугацаа болно. Энэ хугацааг цэргийн байгуулалтын бүх талаар өрнүүлсэн хугацаа гэж үзэж болно. Энэ үеийн гол онцлог бол нэг талаар байлдаж, нэг талаар цэрэг байгуулсан явдал болно. Энэ хугацаанд “Арван гурван хүрээний байлдаан” (1190 он)-аас эхэлж, 1203 оны намар “Жэжэгэр өндөрийн байлдаан”-аар Хэрэйдийг мөхөөх хүртэлх арван дөрвөн жилийн дотор, бараг арван таван удаагийн их байлдааныг хийжээ.

Энэ үе дэх Чингисийн цэргийн зохион байгуулалт бол “Овгийн өрх цэрэг болох бөгөөд хүрээгээр цуглуулдаг ба ялгагдаг байсан юм” (“Монголчуудын нийгмийн байгууллын түүх”) гэж Б.Я.Владимирцов үзэж байжээ. Энэ “хүрээ” гэдэг зохион байгуулалтын хэлбэр нь хэдийгээр овгийн байгууллын үеэс ирэлтэй боловч, Чингис хааны үед хүрч “түүний үзүүлэх үйлдэл жич “хүрээ”-г зохион байгуулах болон ангийн агуулгын талаар мөн чанарын хувиралт гарчээ” (Гао Вэнь Дэ: “Монголын боол эзэмшигч байгууллын судлал”). Энэ хувиралт гэдэг бол уулдаа зөвхөн хамтаараа нүүдэллэн малжих аж ахуйн зохион байгуулалт байсан “хүрээ”-ний зохион байгуулалт нь цэрэг дайны зохион байгуулалт болон хувирч хориглолт довтлолтын чухал хэлбэр болжээ. Энэхүү “хүрээ”-ний зохион байгуулалт нь цэрэг дайны зохион байгуулалт болж хувирснаас нааш боол эзэмшигч байгууллын үе (Хайду-гийн үе), феодалын байгууллын эхэн үе (Чингисийн үе) жич түүний өрнөлийн үед нь ч бүр оршиж байжээ. Жишээлбэл, Юань улсын Хубилай хааны үе (1287 он)-д төрлийн ван Наян Ляо Дун-ы газар урвалга гаргасан тул Хубилай биеэрээ дайлах үед “Наяны цэрэг нь тэрэгэр хүрээлэн буудаллаж”- (“Юань улсын түүхийн нөхвөр орчуулга”, 15 дугаар боть) байв гэдэг.

Зарим түүхэн тэмдэглэлээс үзвэл, энэхүү “хүрээ” гэгч зохион байгуулалтын хэмжээ нь их бага адилгүй байжээ. Бид Чингисийн “Арван гурван хүрээ”-нээс гурван түмэн цэрэг гарч байснаар бодвол, энэ үед нэг хүрээ нь мянгаас гурван мянган цэрэгтэй байсныг мэдэж болно.

Гуравдугаар шат үе нь, 1204 оны хавар “хүрээ”-ний зохион байгуулалтыг өөрчилж, “Мянгатын байгуулал” болгосноос эхэлж 1206 онд Хаант Монгол Улс байгуулагдсан хүртэлх хугацаа болно. Энэ хугацааг төв ёсны цэргийн байгуулалтын үе гэж хэлж болох байна. “Чингис хааны цэрэг үүнээс хойш байнгын цэрэг болон хувирах шинэ зохион байгуулалттай болжээ” (Владимирцов: “Монголчуудын нийгмийн байгууллын түүх”). Чингис хаан энэ үед цэргийн зохион байгуулалтаа өөрчлөдгийн учир гэвэл, бүр байлдааны шаардлага ба хэрэгцээнээс үндэслэсэн юм. “Хүрээ”-ний зохион байгуулалтын хэлбэр нь хориглох байлдаанд ашигтай байх нь яриангүй. Гэвч довтлох байлдаанд дэмий тохиромжгүй байсан нь ч лав юм. Ингээд гадаад фронтод довтлох байлдааныг гол хэлбэр болгон эрхэмлэж байсан Чингис хааны байлдах аргад нь тохирохгүй болсноос цомхон бөгөөд чанарлаг зохион байгуулалт болох бат чанга “мянгатын байгуулал”-аар орлуулсан байна.

Дөрөвдүгээр шат үе нь, 1206 онд Хаант Монгол Улсыг тунхагласнаас хойшхи хугацаа болно. Энэ үеийх нь онцлог гэвэл, “арав”, “зуу”, “мянган”-ы зохион байгуулалтаар чанга зохион байгуулсан, овог аймаг ба “Хуучин Монголын жижиг хаант улс”-ын хүрээ хэмжээг үндсэндээ дэвжсэн жинхэнэжсэн арван төмөр морьт цэрэг болон хөгжсөн явдал болно.

Энд дурдаж бүхий арван түмэн цэрэг гэдэг тоо бол манай аман үзүүр хэлдэг заншил тоо юм. 1206 онд Чингис хааны зарлигаар нийтэлсэн чухам бодтой тоо бол арван түм бөгөөд таван мянга болно. Энэ нь ерэн таван “мянган”-ы дээр түмэн торгон цэргийг нэмээд бүрэлджээ. Энэ бол “Нууц товчоон”-ы баримт юм. Персийн түүхч Рашид-ад-Диний мэдээг үндэслэвэл, Хаант Монгол Улсын бүх цэрэг нь арван хоёр түм есөн мянган хүн байжээ. Түүний бодот хувиарлал нь доорхи мэт:

- (1) Гол цэрэг нийт мянган хүн, үүнийг Цагаан ноён зэрэг найман зуутын ноён захирч байв.
- (2) Баруун гарын цэрэг нийт гурван түм найман мянган хүн, үүний ерөнхий захирагч нь Боорчу ноён, дэд ерөнхий захирагч нь Борухул ноён болно.
- (3) Зүүн гарын цэрэг нийт зургаан түм хоёр мянган хүн, үүний ерөнхий захирагчийн нэг нь Мухулай Го ван, нөгөө нь гучин хоёрдугаар гавьяатан, Багарины Наяа ноён (“Нууц товчоон”-д Наяа бол төв түмний ноён гэжээ) болно. Дээрх гурван замын цэргийг Чингис хаан нас барсны хойно түүний отгон хөвгүүн Тулуйд өгч захируулжээ.
- (4) Чингис хааны дүү нарын цэрэг нийт хоёр түм найман мянган хүн.

Энэ дөрвөн хэсэг цэрэг нийлвэл нийт арван хоёр түм есөн мянган хүн⁸ болно.

Энэ тоо бол үнэн тоо юм. Гэвч 1206 оны тоо биш, харин Чингис хааныг нас барах үеийн тоо билээ⁹.

Ялангуяа энэ үед өргөтгөн байгуулсан Чингис хааны түмэн торгон цэрэг бол Хаант Монгол Улсын бүх зэвсэгт хүчнийх нь охь манлай болж байсан бөгөөд Чингисийн ялагдашгүй төмөр морьт цэргийнх нь шувтлагч анги ба кадрын (мэргэжлийн – хө.) сургуулийн үйлдлийг үзүүлж байсан юм.

Төмөр морьт цэргийн зэр зэвсэг, сургуулил ба байлдах арга

Чингис хааны цэрэг, Хаант Монгол Улсыг байгуулах үед арван хоёр түм илүү байсныг бид баримттай мэджээ. Харин энэ арван хоёр түмэн цэрэг нь бүгдээрээ морьт цэрэг болно. “Монгол хүн дайнд мордоход хүн бүр хоёр, гурван унах морь бэлтгэх буюу зургаа, долоог ч бэлтгэх нь буй” гэж арван гуравдугаар зууны үед Монгол оронд биеэрээ жуулчлан явсан Сүн улсын элч Сюй Тин тэмдэглэсэн юм. Үүнээс үзэхүл, бүр морьт цэрэг байсан нь дамжиггүй бөгөөд олон тооны агт морь хэрэгсдэг байжээ. Энэхүү олон тооны агт морийг гагцхүү мал аж ахуйгаар гол болгосон Монголын нийгмээс л сая хангаж чадахаас биш, өөр үндэстэнд бол сэтгэгдэшгүй хэрэг юм. Монголын газар нутаг өргөн уудам, мал унаа, ялангуяа адуу морь арвин болохоор морьт цэрэг байгуулах хэрэгцээ ба бололцоог олгожээ.

Морь бол морьт цэргийн амьд зэвсэг болох бөгөөд арван гуравдугаар зууны үед зам харилцааны хамгийн хурдан багаж хэрэгсэл болж байснаас гадна, чухалтай үед амь гол залгах хүнс хоол болдог байв. Чингисийн цэрэг холын аян дайнд яваад, хүнс дутагдах “үес дор болбоос морины цусаар амьдарч, хүн бүр өөрийн морины нэгэн судлыг ханаад түүний цусыг сормуй” (“Марко Поло-гийн аяллын тэмдэглэл”).

Тэр үеийн монгол цэргийн гол зэвсэг гэвэл нум сум, төмөр шийдэм, дугариг илд, урт жад, охор жад, сэлэм, богино манчуурга, боомь, халх бамбай зэрэг болно. “Тэдний өмсөх хуяг дуулга бол гал дээр хатаасан усан үхрийн арьс хийгээд бус араатны арьсаар хийх тул туйлын бөх хатуу байдаг”, бас “удын навчит хуяг, цагираг хуяг (зургаан давхар хөм)” байдаг гэж Пэн Да Я мэдээлж байв. Эдгээр зэвсэг бол тэр үедээ мөн ч туйлын хурц зэвсэг болох юм¹⁰.

Зэвсэг бол дайн байлдааны хувь заяаг шийдвэрлэхэд чухал нэгэн хүчис (хүчин зүйл – хө.) болно. Гэвч тэр нь шийдвэрлэх хүчис биш, шийдвэрлэгч хүчис бол зэвсгийг эзэмшигч байлдагч юм. Тиймээс Чингис хааны төмөр морьт цэрэг дэлхий дахиныг донсолгосон нь голдуу түүний эрэлхэг баатарт байдаг билээ. “Тэд байлдахад болбоос туйлын баатар, өөрийн амь биеийг юун хэмээн ч бодохгүй тул ямар зэргийн түгшүүрээс ч үл хайхрамуй. Тэдний чанар нь догшин бөгөөд хэцүү буй”, “тэд элдэв зүдгүүрийг гашуун зүйлийг тэсвэрлэж чадмуй” гэж Марко Поло тэмдэглэж байлаа. Чингэвэл энэхүү эрэлхэг баатар дайчин зоригийг энгийн үедэх сургуулил боловсролоор бүрдүүлдэг байна. Хэлэлгээнгүй, монгол үндэстний үр хүүхэд нь “морины нуруун дээр өсөн бойжиж”, “уналга харвалгадаа дадамгай”, “мориндоо мордвол байлдаанд бэлхэн, мориноосоо буувал малаа хариулдаг” гэж тэр үеийн монгол үндэстний онцлогийг “Монгол Татарын тухай бүрэн тэмдэглэл”¹¹, “Юань улсын түүх” зэрэг түүх шастирт тэмдэглэж байдаг. Энэ нь нэг талын байдал, Монголын морьт цэргийн үндсэн суурь нь болно.

Нөгөө талаар, зохион байгуулалттай хийх сургуулил боловсрол бол цэрэг ангид дутагдаж болшгүй. Үүнийг биелүүлэхэд Монголчууд бараг доорхи хэдэн хэлбэрээр гүйцэтгэж байсан байна. Ан гөрөө хийхээр дамжиж сургуулилах явдал бол нийтэм хэрэгжүүлж байсан хэлбэр болно. Ан гөрөө бол нүүдэлчин Монголчуудын чухал нэгэн үйлдвэрлэл нь болох бөгөөд бас ч тэр биеэрээ цэрэг дайны сорилт болно. Учир нь ан гөрөөг туйлын их хэмжээгээр, нарийн нягт зохион байгуулалттай хийдгийг бид тус товчооны дөрөвдүгээр бүлэгт танилцуулж билээ. “Монгол хүнд авч хэлбэл, ан гөрөө хийх нь мөн ч цэргийн сургуулил юм. Тиймээс ан гөрөөний хугацааг бүр цэргийн сургуулилаар тохируулж жолооддог билээ. Арван таван наснаас жаран нас (Цю Шу Сэнь далан нас гэжээ)-ны хоорондохи эрэгтэйчүүд цэргийн алба хаах үүрэгтэй, байлдаанд шууд оролцдоггүй хүмүүс бол мал хариулах, зэвсэг үйлдэх, элмэг (эмнэг – хө.) үрээ сургах зэрэг ажлыг эрхэлдэг” гэж Березин тэмдэглэсэн юм. Энэ бол хүн бүхэн цэрэг дайнд мордох үүрэгтэй гэснийг харуулж байна. “Арван таван наснаас дээшхи иргэн даруй түүний (Монголын) цэрэг мөн” гэж “Хар Татарын тухай хэргийн товч”-д тэмдэглэж байсан нь дээрх мэдээтэй тохирч байна. Бас тухайлан цэргийн сургуулилыг хийх явдал ч байжээ. Үүнийг “Эр хүн сургууль хийх нь морины нуруун дээрээс хоёр шөнө хоёр өдөр буухгүй, морь нь өвс идэх үест даруй морин дээрээ унтаж боловсормуй” гэж Марко Поло тэмдэглэж байсан бөгөөд “Эрэлхэг зоригтой байлдагчид, түүний (Чингис хааны - эшлэгч) захад тасраагүй ирж байв. Тэр, тэднийг халуунаар угтаж, жанжны ордондоо үлдээдэг билээ. Ингээд тэд нар нь (Чингисийн) туйлын үнэнч шударга нөхөр болох Боорчу, Зэлмэ, Мухулай нарын жолоодлого доор, харвалт, маневрлалт, байлдааны нягт журам ба байлдах аргын сургуулилыг хүлээдэг юм” гэж Березин тэмдэглэж байв. Түүнчлэн “Энэхүү цэрэгжилсэн улсын бүх эрс нь энгийн ба байлдааны аль үед ч гэсэнгүй бүр цэрэг ангийн зохион байгуулалт дахи тогтсон байртай байдаг. Энгийн үед ч байлдааны бэлтгэлийг хийхээс өөр үүрэггүй байдаг юм” гэж Березин бас тэмдэглэжээ.

Монголын морьт цэргийн байлдааны бэлтгэл ба байлдааны эл талын хангалт ч мөн өөрийн товойсон онцлогтой байжээ. Одоо хэн бүхний мэдэж байхаар, хэдэн түмэн цэрэг дайн хийхэд, ялангуяа хол замын аян дайн хийхэд, түүний ар талын хангалтын ажил бол туйлын их хэмжээний хүн ба эд бодосын хүчнийг зохион байгуулах ажил юм. Чингэвэл Чингис хаан арван түмэн цэргийг дайчлан явахад энэ асуудлыг хэрхэн шийдвэрлэж байсныг дайн жолоодогч хүмүүс бүр судлах хэрэгтэй юм. Чингис хааны төмөр морьт цэрэгт нь тусгай үйлчилдэг том их ар талын хангалт гэж байсангүй бололтой. Гэвч Чингис хааны цэрэг ар талын хангалтгүй гэж хэлэхийн аргагүй, хэрвээ ар талгүй бол түүний цэрэг амьдрахын аргагүй, түүнчлэн дайн байлдаан хийх арга нэн ч үгүй юм. Тиймээс Чингис хааны морьт цэргийн ар талын хангалт гэдэг бол туйлын өвөрмөц онцлогтой байсан байна. Чингис хаан энэ асуудлыг яаж шийдвэрлэсэн буй гэвэл, Монголын цэрэг хаа хүрвэл ар талын хангалт нь ч мөн тэнд хүрдэг байна. Үүний тухай Марко Поло бидэнд нэлээд нарийн мэдээг үлдээжээ. Түүний тэмдэглэсэн нь: “Тэдний хол газар явах цэрэг нь хүрээ буух хийгээд будаа хийх сав хэрэгслийг цөм авч явахгүй .. нэгэн зүйлийн эсгийгээр үйлдсэн өчүүхэн майхан авч яван, үүгээр салхи борооныг халхламуй” (зураг 33-ыг лавлаарай), “чухалтай цаг үест болбоос гүүний сүүгээр нэгэн сар удтал амьдарч чадмуй. Эс бөгөөс бус араатныг олж бариваас мөн болмуй. Тэдний морь нь ганц өвсөөр гэжээмүй, арвай хийгээд бус үр буурцгийг хэрэглэхгүй”, “явдал шахам болж чухал түргэн цагт болбоос тэд гал шатаахгүй, хоол идэхгүйгээр арван хэдэн өдөр шалавлан явж чадмуй. Энэ үесд болбоос морины цусаа сорон амьдармуй”, “Тэд бас сүүг хатаан хөшөөж идэх юм болгомуй ...цэрэгт мордох үес, хүн бүр биедээ үүнийг арван фунт авч яван, өглөө бүр хагас фунтыг нэгэн арьсан хувинд хийж, өөрийн хэрэглэхийн хирээр ус нэмж холимуй. Тэд морио унасан хойно хувин нь шиглэгдэн (сэгсрэгдэн – хө.) хөдлөхөд тэр сүү нь нэгэн зүйлийн хоормог болох тул үүгээр хоол болгомуй” гэжээ. Баахан хураангуйлан хэлбэл, Чингис хаан аян дайнд мордох үед хүн бүр бараг хориод өдрийн хуурай хүнс авч явдаг, үүнийг энгийн үед хэрэглэдэггүй, чухал үед хэрэглэдэг. Энгийн үеийн үндсэн хангалт бол цэргийнхээ хамт хөөн явдаг хүрэлцэхүйц тооны адууны сүрэг болно. Энэ адуугаар тэд уналгаа сэлбэхийн хамт гүүгээ сааж, хүнс хоолоо хийдэг, туйлын бачим үед бол эдгээр адууныхаа судлыг нь ханаж, цусыг нь сорон амьдардаг. Зарим явж чадахгүй болсныг нь алж идэх нь дамжиггүй хэрэг. Бас аян дайны завсар, гол үүргийг нөлөөлөхгүй байдал доор, ан гөрөө хийж, хүнс хоолоо нөхвөрлөж болдог байна. Тэдний уналга ба хүнс хоолны хангалтын гол ирэлт болсон адуун сүргийг тэд тасраагүй нөхвөрлөж байсан нь ч мэдээжийн хэрэг ээ. Үүний ирэл нь голдуу дайсан этгээдээсээ олзлон авдаг байна. Чингис хааны морьт цэрэг нь “төмөр морьт цэрэг” гэж алдаршин, хол ойрыг дайлж, хандсан зүгийг хамарч, халдсан дайсныг сөнөөж байсан шалтгаан нь ар талын хангалтаа зохистой шийдвэрлэсэнтэй салшгүй холбоотой.

Одоо бид Чингисийн морьт цэргийн байлдах аргын тухай товч танилцуулья.

Чингис хааны хийж байсан дайн байлдаан нь 1203 онд Хэрэйдийг мөхөөсөн “Жэжэгэр өндөрийн байлдаан”-аас өмнө бол их төлөвдөө байлдах бодлогын талын дотоод фронт дахи хориглох байлдаан байсан боловч, байлдах аргын талаар гадаад фронт дахи довтлох байлдаан байжээ. Дотоод фронт гэдэг бол бусдад довтлогдсон этгээдийн хориглох байрт байхыг хэлдэг, ийм этгээдийн ажиллагаа бол хязгаартай байдаг. Гадаад фронт гэдэг бол довтлох этгээдийг хэлж байна. Ийм этгээдийн ажиллагаа нь чөлөөтэй байдаг юм. Энэ үед бүх хүчний харьцалаар авч үзвэл, Чингис хааны хүч нь буурай, дайсны хүч нь хүчирхэг байжээ. Ингээд

бараг удаа бүрийн байлдааныг бүр Чингисийн дайсан нь ирж довтолдог байна. Иймээс тэр байлдах бодлогын хориглох байрт оршиж байжээ. Гэвч бас удаа бүрийн байлдаанаас өмнө, Чингис хаан бараг бүр чимээ олж аваад, байлдааны бэлтгэлийг завдан хийдгээр барахгүй, өөрөө мордон гарч, ирж байгаа дайсныг хөдөлгөөний дунд тосон байлддаг байна. Ингээд байлдах аргын талаар - бодтойгоор байлдахдаа удаа бүр гадаад фронтод гарч довтолох байрыг эзэлдэг ажээ. Тэрчлэн Чингис хааны бараг удаа бүр (цөөн нэг хоёр удааг гаргавал)-ийн байлдаанд цөөнөөр олныг ялж, арван хэдэн жилийн тэмцэлдсэн шат үеийг өнгөрөөж, Чингис хааны хүч нь цөөнөөсөө олширч, буурайгаасаа хүчирхэгжсэн бөгөөд дайсан нь ч өдөр ирэх тутам доройтож буурсан тул 1203 оноос эхэлж, байлдах бодлогын их довтоллыг хийжээ. Энэ бол ерөнхий байлдах бодлого байлдах арга нь болно.

Одоо бид бодтой байлдах аргыг нь танилцуулья. Энэ талаар түрүүчийн бүлгүүдэд бодтой байлдааныг нь тэмдэглэх үед мөн тэр үеийнх нь бодтой байдлаар танилцуулж байсан билээ.

Гэвч дайн байлдааны үйлдлэг баялагжихыг дагалдан, цэрэг ангийн ажлын хуваарь, байлдааны тохируулалт зэрэг нь улам улам нарийлагжин төгөлдөржиж байв. Энгийн үед их төлөв “Хэвтүүл цэргээ дотоодод, сэргийлэх цэргээ гадаадад байрлуулдаг”, аян дайн хийх үед, бүх цэргээ зүүн, баруун гар ба гол цэрэг буюу төв цэрэг гэж хуваадаг бөгөөд хошууч цэрэг, гэзэг цэрэг ба өмнө харуул, ар хайгуул гэж нарийн хувиартай болжээ. Энэ тухай Марко Пологийн тэмдэглэлийг доор товчлон сийрүүлье.

“Цэрэг урагш орох үест, хоёр зуун хүнтэй цэрэг өмнөх хошууч болж, хоёр өдрийн урьд явмуй. Хоёр хажуу ба хойд этгээдэд болбоос цөм хамгаалах хайгуул цэрэг гаргаж, дайсны гэнэт байлдан ирэхийг сэргийлмүй”. Байлдаан хийхийн урьд Чингисийн цэрэг нь бүр туг сүлдээ тахиж, байлдааны дайчлалтыг хийдэг байна. Заримдаа Чингис хаан бас “түүний төлгөчдөө захиа буулгаж, хоёр цэргийн байлдах нь нүдний өмнө болов. Хэн нь дийлэхийг төлгөдөн үзэж хэлэгтүн” гэж шашны аргаар цэргээ зоригжуулдаг гэлээ.

Байлдах жагсаалаа жагсаж дууссаны хойно “Татар хүн (монгол хүнийг хэлж буй - эшлэгч)-ий заншил суртлаар байлдахын урьд зүйл бүрийн бишгүүр хөгжмийг зэргээр үлээн үүсгэж, залгавар дуу дуулж, цан хэнгэрэг цөөн дэлдэх үест сая эхлэн байлдмуй. Дуу дуулах, цан цохих, хэнгэрэг дэлдэх нь цөм маш сүрхий, сонссон хүн бүгд цочин сүрдмүй”, “Тэрхүү байлдааны хэнгэрэгийг дэлдэн эхэлсэнд, үүнээс хоёр этгээд харван эхэлж, сум зэвийн ирэх эчих нь бараг тэнгэр үзэгдэхгүй болж, маш олон хүн морь цөм алагдмуй”, “бас Татар хүмүүс нь байлдаан хийх үест болбоос дайсан лугаа ер үл хутгалдмуй, ганц дайсныг бүслэн аваад урьдаар нэгэн этгээдээс харваж, дахин нөгөө этгээдээс харвамуй, заримдаа хуурмагаар буруулан дутааж, дайсныг өдөөн дагуулж, нэхэн ирэх үес бие урван хойш харваж эсрэг этгээдийн хүн морийг алах нь тулалцан байлдах лугаа адил. Ийм байлдах аргад дайсан нь дийлсэн хэмээн санамуй, үнэнд тэр харин дийлэгджээ. Юун хэмээвээс Татар хүн дайсныг ийнхүү наадам хийсний хойно, эргэн ирж дахин байлдан, дайсны үлдсэн цэргийг даран сөнөөмүй. ...Тэдний морь иргэн урваж хөдлөх нь гайхалтай түргэн бөгөөд зарлал дохио гармагц даруй эргэж өөр нэгэн этгээдэд хүрч чадмуй. Тэд энэхүү шаламгай түргэнээр маш олон ялалтыг олжээ”.

Чингис хааны цэрэг нь бас байлдааны талбарын чанга хатуу сахилга цаазтай байдаг. Жишээлбэл, байлдааны явцад дайсны олзод хоргодон саатаж үл болдог, байлдаад сарнин

бутарвал заавал байлдаан эхэлсэн уул байртаа буцаж ирэх хэрэгтэй, эс ирэгсдийг цазаар шийтгэдэг билээ.

Чингисийн морьт цэрэг ба тэр үеийн дайн байлдаанд холбогдох бас нэгэн чухал асуудал бол “харилцаа холбоо”-ны асуудал болно. Үүнийг одоо үеийн дайнд бол цэргийн “чих, нүд”-ээр үздэг “холбооны хангалт” гэгч тусгай нэгэн байлдааны алба болно. Энэ асуудлыг эрт ба өдгөө ямар арга хэлбэрээр ч болтугай заавал шийдвэрлэх хэрэгтэй. Одоо үеийн дайны “холбооны хангалт”-д радио, дянь-хуа мэт цахилгаан холбоо байхаар барахгүй, янз бүрийн харилцааны багаж (нисдэл, машин, мотор, морь мэт)-ийг хэрэглэсэн “хөдөлгөөнт холбоо” гэж байдаг. Бас туг далбаа, бүрээ, дохион буу зэргээр бүрэлдсэн “дохиот холбоо” гэж байдаг. Чингэвэл Чингисийн үед энэ асуудлыг ямар аргаар шийдвэрлэж байсан буй? гэвэл, Чингис хаан эхлэнгүүтээ үүнийг анхаарч байжээ. Жишээлбэл, Чингис хаан 1189 онд анх удаа хаан өргөмжлөгдөх үед Архай Хасар, Тахай, Сүхэгэйжэгүн, Чагурхан дөрвийг “qola-yin qugucag oyir-a yin otur-a” (“хол ойрыг сурвалжлах газарч” гэж Ц.Дамдинсүрэн тайлжээ) гэсэн тусгай тушаалд томилсон нь одоогийн ухагдахуунаар хэлбэл “элч, холбоочин” болно. Энэ тухай Березин нэлээд нарийн тэмдэглэжээ. Шинэ өргөмжлөгдсөн хаан (Чингисийг хэлж буй - эшлэгч) нь зөвхөн түүний хүрээн дэхи арвин бус гэр өрхийг л бодолхийлдэг бус, харин түүний ноёрхол дахи улсаа бодолхийлдэг юм. Түүний харьяат ноёд сайд нарынхаа амар төвшний төлөө, чухал хэрэгцээтэй үед түргэн очиж тэднийг туслахын төлөө, түүний захиргаан дахи бүх суугуул ард нь чухал бачим байдлыг олж мэдвэл өдөр шөнийг ялгалгүйгээр даруй түргэн мордож холбоочин томилж мэдүүлэх хэрэгтэй гэж тогтоожээ. Тэр өөрөө ч мөн олон арвин сайн морьт холбоочныг бэлтгэж, хааны зарлигийг холын газарт “сум мэт түргэн” хүргэдэг билээ. Чингис хаан энэхүү “морьт холбоочин” гэдгээр дамжиж, түүний харьяатуудын дотор ямар шинэ чимээ, шинэ байдал, жишээлбэл “хэний нутаг хаашаа шилжсэн, эсхүл аль нөхөрсөг аймаг бүлгээс ямар хүн айлчлахаар ирсэн, эсхүл ямар арилжаа худалдаачид ирсэн мэт чимээг дор дор нь олж мэддэг байна. Ийм холбоочин ирсэн үед, Чингис хаан өөрөө буюу хүн томилж, дотноор хүлээн авч орон сууц, идэш ууш, ялангуяа цэгээг хүрэлцүүштэй хангадаг юм гэлээ. Энэхүү “морьт холбоочин” нь сүүлдээ хаант Монголын улсын харьцаа холбооны чухал систем болж, түүнчлэн дэлхий дахинд ч алдаршсан Монголын “өртөө”, “замчин” эсхүл “улаачин” гэдгийнх нь суурь болжээ. Энэхүү өртөө зам нь хэдийгээр Өгөөдэй хааны үед жинхэнээрээ байгуулагдсан боловч, Чингис хаан баруунш дайлах үед Монголын өндөрлөгөөс Дундад Ази ба монгол цэргийн хүрсэн газар нэвтрэх холбооны шугамыг нэгэнтээ байгуулсан юм. Сүн улсын бумбын шашны алдарт бясалгагч Чан-чунь арш ч Цю Чу Цзи гэгч яг энэхүү холбооны шугамаар нь явж, Дундад Азид очин Чингис хаантай учирсан юм.

Хэнгэрэг бол монгол цэргийн байлдааны сүр сүлд болохоор үл барам бас байлдааны дохио холбоо болдог байна. “Го ван (Мухулайг хэлжээ - эшлэгч)-д ганц нэгэн хэнгэрэгтэй, дайнд гарахуйд сая хэрэглэдэг” (“Монгол Татарын тухай бүрэн тэмдэглэл”) гэсэн ба “бутраад баглахуйд хө хүй (хэнгэрэг)-н дуунаар дохио болгоно” (“Хар Татарын тухай хэргийн товч”) гэсэн тэмдэглэл бол үүнийг нотолж байна. Юань улсын үед Хубилай сэцэн хаан бас том их хэнгэрэгээ заанд ачиж явдаг гэж Марко Поло тэмдэглэж байсан билээ. Монгол цэргийн хэнгэрэг бол хар бухын арьсаар бүрсэн гэж “Нууц товчоон”-д тэмдэглэж буй. Хар бухын арьсаар бүрдэг нь лав нэгэн ирэлттэй юм. Ямар нэгэн зан заншил буюу шашин суртахуун - бөө мөргөлтэй нь холбогдох ч магадгүй. Гэвч байлдаанд тусгайлан хэрэглэдэг хэнгэрэг бол

сүрхий бүдүүн юм байсан байна. Түүхэн зургаас үзэхүл Чингис хаан Дундад Ази өөд дайлахад хэнгэрэгээ тэмээн дээр ачиж байжээ. Ерийн бага хэнгэрэгийг бол нэгэн бүхэл ямааны арьсаар бүрдэг тул дэмий хол сонсдохгүй нь лав юм.

Үүнээс гадна, Монголын морьт цэргийн дайн байлдааны тухай олон зүйлийн тогтоол дүрэм байдаг юм. Жишээлбэл, “Монгол цэрэг дайнд мордохоос өмнө олон ураг төрлийн ван ноёд болон жанжин захирагчдын их хуралдайг хийж цэрэг дайны байгууламжийг тогтоох”, “дайсны хилд орохоос өмнө, дайсан улсын байдлыг нь тагнах”, “Чингис хаан нэгэн орныг эзлэн авахаас өмнө, заавал тэрхүү улсын эзэнд нь элч илгээж, бууж өгөхийг шаардах”, “Монгол цэрэг нь холын аян дайнд явах зуур, жил бүр хэдэн сар байрлаж, цэрэг морио амруулах” (“Д`Оссоны Монголын түүх”, нэгдүгээр боть, аравдугаар бүлэг) мэт. Энэ бүхэн бол Чингисийн төмөр морьт цэргийн ялалтыг батлагч нөхцөлд нь дутагдаж болшгүй зүйл мөн.

Одоо “Чингисийн төмөр морьт цэрэг” гэсэн энэ нэгэн сэдвээ дуусгах үед, эртний монгол улсын дөрвөн харьяатынхи нь нэг болсон Ил хант улсын дөрөвдүгээр хаан Аргуны бичээч байсан перс түүхч Джувейнийн зохиосон “Дэлхийг дайлан дагуулагчдын түүх” гэдэг номоос хэдэн бадаг эш татая: “Түүн (Чингисийг хэлж буй - эшлэгч)-ий цэргийн зохион байгуулалт нь Адам (Христосын шашныхны хүн төрөлхтөний өвөг дээдэс гэж үздэг тусгай нэр)-ын үеэс аваад, Чингис хааны үрс дэлхий ертөнцийн ихэнхийг эзэлсэн өдөрт тултал, ямар нэгэн улс гүрэн, ямар нэгэн эзэн хааны цэрэг боловч Татарын цэрэг лүгээ адил цэрэг түүхэнд ер байгаагүй, бичиг материалд тэмдэглээгүй. Энэ цэрэг бол аюул түгшүүртэй нугаршгүй тэмцдэг, ач өршөөлийг марташгүй хариулдаг, аливаа байдал доор захирлыг дагадаг. Энэ нь хишиг пүнлүү горилсонгүй мөртөө зэрэг цалинд ч дурласангүй юм”, “бүх дэлхийд ямар нэгэн цэрэг нь монгол цэрэг лүгээ дайсагнаж чадах аж? Дайны үед, байлдааны талбайд шувтлан дайрахдаа тэд, сургуулилттай арслан барс авын амьтанд довлох шиг ордог. Энгийн тайван өдрүүдэд тэд харин хонь шиг номхон, үнээ шиг өгөөмөрч, сүү цагаан идээ, арьс ноос, аливаа хэрэгтэй зүйлийг үйлдвэрлэдэг. Хүчир бэрхшээл аюул түгшүүртэй орчин байдалд, тэд ердөө уурлаж бухимддаггүй. Тэд бол тариачны адил цэрэг ...тэд мөн ч цэргийн алба хааж бүхий “тариачин”. Дайны дунд, өтгөс залуу, эрхэм доод гэсэнгүй бүр л байлдагч, хорчи ба сэлэмч болдог бөгөөд байлдааны хэрэгцээгээр урагш орж дайсныг алдаг юм” (зурагт нүүр дэхи зураг 32-42-т лавлаарай).

42. Чингис хааны түшлэг хүчин

Чингис хаан арван хоёрдугаар зууны сүүлчийн үеэс арван гуравдугаар зууны эхний үе хүртэл, бэрх түгшүүрт өдрүүдийг өнгөрөөн, Монголын олон аймгийг нэгтгэж, Их Монгол Улсын хаант төрийг байгуулах тэмцэлд бүх үндэстэн, бүх иргэний хүчинд түшиглэсэн нь лав юм. Гэвч түүний өөрийнх нь итгэл найдварт гол түшлэг хүч үгүй бол бүх үндэстний хүчийг бүлгэмдүүлж чадахгүй, зохион байгуулж ч чадахгүй билээ.

Ийм түшлэг хүчнийг Чингис хаан бүрэлдүүлж чаджээ. Энэ нь Чингисийн “дөрвөн хошууч”, “дөрвөн хүлэг”, “хоёр манлай”, “есөн өрлөг (буюу дотоод есөн сайд)”, “наян найман гавьяатан”-аар гол болгосон “нөхөр бүлгэм”; “хишигтэн”-ээр гол болгосон “шадар зэвсэгт бүлгэм” ба дотоод хуралдайгаар бүрэлдсэн “бодлогоч бүлгэм” эсхүл “зөвлөгч бүлгэм” нь болно. Түүх шастир ба шүүмжлэл өгүүлэлд хэдийгээр ингэж тодорхой дурдаагүй ч ийм учир хэрэг дээрээ бүр байсан.

Чингисийн “Нөхөр бүлгэм”

Чингисийн “Нөхөр бүлгэм” гэдэгт түүний дөрвөн хошууч, дөрвөн хүлэг, хоёр манлай, есөн өрлөг ба наян найман гавьяатныг нь танилцуулах болно.

Чингисийн дөрвөн хошууч (“Нууц товчоон”-д сайн нохос гэдэг) бол Хубилай, Зэлмэ, Зэв, Сүбээдэй дөрвийг хэлж байна. Энэ дөрвөн хошууч нь:

“Хүр гэсэн газар хүрч

Хөр чулууг хэмхлэн,

Халд гэсэн газар халдаж

Хад чулууг хагалан,

Цэгээн чулууг цуулан

Цээл усыг нядлан байдаг” тул, Чингис хааны чухал тушаалд томилж, сэтгэл амар байдаг итгэлтэй нөхөд нь юм.

Хубилай бол Барулас овогтон болно. Урьд 1180 онд Жамуха Тэмүжинээс салж явсан тэр үед, Тэмүжинийг дагаар ирсэн бөгөөд 1189 онд Тэмүжин анх удаа хаан өргөмжлөгдсөний дараа илдэчийн тушаалд томилогдож, хааны дүү Хасар нарын хамт Чингис хааныг хамгаалж байв. 1202 онд Чингис хаан дөрвөн Татарыг сөнөөх байлдаанд Чингисийн төрөл угсааны Алтан, Хучар, Даритай гурав байлдааны сахилга цаазыг зөрчиж дайсны эд ашгийг олзолсон тул хаан хилэгнэж, Хубилай ноён нарыг томилон олзолсон зүйлийг нь хураан авч олонд түгээн өгсөн билээ. Хубилай олон удаагийн байлдаан, ялангуяа Найманыг дайлсан байлдаанд хошуучлан орж гавьяа зүтгэл байгуулжээ. Ингээд 1206 онд улс байгуулагдсаны дараа наян найман гавьяатны наймдугаараар шагнагдсан бөгөөд баруун гарын ширах мянганы ноёноор томилогдов. Бас “Цэргийн үйл бүхнийг ахалж бай” гэж Чингис хаан соёрхсон байна. Үүний хамт Бүдүгүн (энэ бол “Нууц товчоон”-ы 120 дугаар зүйлд дурдагдсан дөрвөн овогтны Мөчи Бүдүгүн гэгч болно) мужирхаг (их дуулгаваргүй - Ц.Дамдинсүрэн, мужууд зантай - Ту Цзи) тул хаан буруушааж, мянганы ноён болгосонгүй билээ. Одоо Хубилайг хавсран мянганыг захирч явгугай гэж хаан зарлиг болжээ. Дараа нь Хубилай ноён 1208 онд Чингис хааны зарлигаар цэрэг дайчилж, Харлугуудыг дайлаар мордож, Харлугуудыг оруулан авсан байна. 1211 онд Харлугын Арслан хан Монгол улсад ирж Чингис хаанд бараадах үед Чингис хаан Хэрлэнгийн хөдөө арал дахи ордондоо хүлээн авч уулзсан билээ. Түүний дараа дэмий удсангүй Хубилай ноён үхлээ гэдэг юм.

Зэлмэ бол Жарчигудай Урианхад овогтны Төмөрчин Жарчигудай өвгөний хөвгүүн юм. Зэлмэгийн дээдэс Жарчигудай бол Бодончарын барьж авсан эм Жарчигудай Аданхан Урианхайжин гэгчийн гэдсэндээ авчирсан хөвгүүн болно. Тиймээс тэр болон түүний үр хойч нь харь овогтон болох юм. Гэвч Зэлмэ-г өөрөө хэрхэн үнэнч шударга зүтгэхээ :

“Үхэх амиа хайрлахгүй,

Үгүйрэх малаа харамлахгүй,

Үзэгдэх дайсныг үсэртэл нядарч,

Харагдах дайсныг халтиртал дайрч,

Замдаа тохиолдсоныг зад цохиж,

Мөртөө дайралдсаныг мөлт цохиж,

Хар тугийг нь хамран авч,

Барьсан хүнийг нь байлдан алж,

Хийсэх тугийг нь гишгэн дэвсч,

Уранхай тугийг нь уландаа гишгэж,

Дайсны сүрийг даран сөнөөж,

Дахин босох чадлыг нь мөхөөө” (“Лу. Алтан товч”) гэж илэрхийлж байсан бөгөөд мөн ч ингэж хийж чадсан тул, Чингис хаан:

“Ороо гөрөөсний отлого болсон*,

Омогт дайсны зүрхийг чичрүүлсэн,

Унах морьгүй болоход унаа авчирч өгсөн,

Ундаасан цангах цагт уух дарс өгсөн,

Сэргэг бага нойртой,

Сэцэн мэргэн ухаантай,

Улс төрийн төлөө урьд цагаас зүтгэсэн,

Урианханы сайн Зэлмэ минь” (“Лу. Алтан товч”) гэж магтаж байсан юм.

Зэв бол Чарахай Линху-гийн үр ач Бэсүд овогтон болно. Анхандаа тэр, Чингисийн дайсан этгээд Тайчигуд аймагт харьяалагдаж байсан бөгөөд 1202 оны “Хүйтэний байлдаан”-д Чингис хааныг хүзүүгээр нь харваж шархдуулсан хүн бол энэ Зэв юм. Тэр үед Зэв энэ явдлаа дарж далдалсангүй учраас Чингис хааны итгэл хүндийг олжээ.

Сүбээдэй-г ердөө Сүбээдэй баатар гэдэг. Тэр бол Жарчигудай Урайнхай овогтон билээ. Түүний дээдэс нь Нариви гэдэг хүн байжээ. Нариви нэгэн өдөр Онон мөрнөөр ав хийж

байгаад Чингис хааны тавдугаар үеийн өвөг Тумбиной сэцэнтэй учирч, анд бололцжээ. Нариви-гийн хөвгүүн нь Бухуту гэдэг. Бухуту-гийн ач нь Хачигун гэдэг, Хачигуны хөвгүүн нь Хабал гэдэг, Хабал бол Сүбээдэйн эцэг нь болно. Хабал хоёр хөвгүүнтэй. Их нь Хорухун гэдэг, хоёрдугаар нь Сүбээдэй болно. Сүбээдэй бол Зэлмэ лүгээ нэг овогтон болох бөгөөд арван дөрвөн настайдаа (1189 он) Зэлмэ-гийн дүү Чагурхай-н хамт Урианхайгаасаа салан (тэр үед Урианхай бол Жамуха-гийн харьяанд байжээ), Тэмүжинийг дагаар ирж, Зэлмэ лүгээ нийлсэн юм¹². “Нууц товчоон”-д зөвхөн “Урианхай” овогтон гэдэг. Хэрэг дээрээ Жарчигудай Урианхан бол Урианхай аймгийн нэгэн салбар болно. 1189 онд Тэмүжин анхдугаар удаа хаан өргөмжлөгдсөний дараа, хааны эд хөрөнгө, гэр орныг хадгалж хамгаалах тушаал (“Ту Цзигийн тэмдэглэл”-д “хошууч, хайгуулч” гэжээ)-д томилогджээ. Чингис хааны бүх Монголыг нэгтгэх байлдаануудад Сүбээдэй бүр оролцож, Чингисийн дөрвөн хошууч жанжин (сайн нохос)-ыхи нь нэг нь болж, гавьяа зүтгэл байгуулсан учраас 1206 онд Хаант Монгол Улсыг байгуулах үед наян найман гавьяатны тавин нэгдүгээрт шагнагдсан бөгөөд ширах мянганы ноёноор томилогджээ.

1211 онд Чингис хаан Алтан улсыг дайлахуйд Сүбээдэй урьдаар Хуаньчжоу балгас (Одоогийн Өвөр Монголын Шулуун хөх төвөөс баруун хойно байжээ)-ыг дайран эзэлсэн тул нэг тэрэг бөс бараа алт мөнгөөр шагнагджээ.

Чингисийн цэрэг өмнөш дайлсан энэ үед говийн умард цэрэггүй байсан болохоор Мэргидийн үлдэгдэл Худу нар (Тогтуга бэхи-гийн хөвгүүн) Найманы хилийн гадна цугларч, өшөө авах гэж байсан чимээг Чингис хаан сонсч, 1216 онд Хэрлэн мөрний ордонд олон жанжин нараа хуралдуулж хэн Мэргидийг дарахаар явна буй? гэж асуусанд, Сүбээдэй эчихийг гуйчилжээ. Чингис хаан түүнийг зөвшөөрсөн бөгөөд зам гудас уул бартаа арвин гэж, төмөр хүрдэт тэрэг үйлдүүлж өгсөн байна. Ингээд Сүбээдэйн цэрэг Мэргидийн үлдэгдлийг Чүй мөрнөө нэхэн гүйцэж, туйлбартай устгасан байна.

1219 онд Чингис хаан Дундад Азийг дайлахад Сүбээдэй анхандаа Жочи-гийн хамт дайлж байгаад Самаркандын байлдааны дараа Зэвийн хамт Мухаммедыг нэхэн гурван түмэн цэргээр Каспийн тэнгисээс умарш гүнзгийрч, Кавказын нурууг даван Орос, Кипчак, Булгар зэрэг олон газруудыг довтолж, гурван жил сүрхий ширүүн байлдаж, 1224 онд буцаж, Чингис хаанд өрнө дахинаас олзолсон түмэн агтаа өргөв гэдэг билээ.

1225 онд Сүбээдэй мөн Чингис хааныг дагалдан Тангудыг дайлжээ. 1226 онд нь шар Ёгор (бас Салар Уйгур гэдэг) ба Тао Хэ гол дагуу орнуудыг эзлэн авчээ. 1227 онд Чингис хаан Цин Шуй-д нас барсны дараа, хааны шарилыг Сүбээдэй нар хамгаалан умарш буцжээ.

1228 он (хулгана жил, “Юань улсын түүх”-д 1229 он, үхэр жил гэжээ. Энд “Нууц товчоон”-ыг баримтлав)-д Өгөөдэй хаан их орыг залгамжилсан хойно Түмэн гүнжийг Сүбээдэйд гэргийлэн өгчээ. Ингээд тэр, монгол цэргийн захирагч жанжин болж, Тулуйг даган Алтан улсын Хэнань оронд довтолжээ. 1233 онд Алтан улсын өмнөд нийслэл Бянянь (одоогийн Хэнань мужийн Кайфэн) хотыг эзэлж, хааныхи нь ураг төрөл, тайцзи хатдыг нь олзолсон байна. Сүүлд нь 1235 онд Жочи-гийн хөвгүүн Батын хамт хоёрдугаар удаагийн баруунш дайралтад оролцож, зүүн Европ хүрээд буцжээ.

1246 онд Гүюг хаан Хаант Монгол Улсын гуравдугаар далайн хааны орыг залгамжлах үед

Сүбээдэй их хуралдайд оролцож, Туул гол дахи ар гэртээ буцаж, 1248 онд далан гурван настайдаа нас нөгчив гэдэг. Ингээд бодвол, Сүбээдэй 1176 онд төрсөн байх ёстой. 1310 онд Хэнань ван цолыг нэхэмжлэн өргөмжилжээ. Чингисээс сүүлчийн үед асан алдарт жанжин Урианхадай бол Сүбээдэйн хөвгүүн болно.

Чингисийн дөрвөн хүлэг гэдэг бол Боорчу, Мухулай, Борухул, Чулуун дөрвөн дайчин баатар, шударга сайдыг нь хэлж байна. Чингис хаан “дөрвөн сайн нохос (хошууч)-оо зорьсон газраа явуулаад”, “Дөрвөн хүлэг баатараа дэргэдээ авч”, хатгалдах (байлдах)-ын тэргүүнд Уругуд, Мангудын Жүрчидэй Хуйлдар хоёрыг мордуулбаас “сая миний сэтгэл бүрнээ амардаг бөлгөө” гэж хэлж байв. Энэ дөрвөн хүлэг нь хэзээд Чингисийн дэргэдээс салдаггүй байжээ. Эд дөрөв бол Чингис хааны:

Амь биеийг нь аварсан хүлэг,

Аюул бэрхээс нь тусалсан анд,

Атаатан дайсныг нь дарсан байлдагч,

Алтан төрийг нь босгосон тулгуур нь болно. Тиймээс Чингис хааны өндөр хэргэм өвтэгш алдарыг энэ дөрвөн хүлэгтээ шагнаж, өршөөл хайр өнөр хишгийг үрийн үрд нь хүртэл соёрхож байснаар барахгүй, бэлгэтэй сайн үгээр ерөөж, уянгатай сайхан утгаар магтаж байсан юм.

Боорчу-г магтсан нь:

“Намайг залуу байх цагт

Найман шаргыг эрэх үед

Наран ургах хирд

Надтай уулзсанаас хойш

Насад үнэнээр зүтгэсэн

Наху баяны хөвгүүн

Найрт хүлэг Боорчу минь!

Айл зуур явахад

Алаг бяруу мэт номхон байвч

Алалцах дайсантай уулзахад

Арслан барс мэт догширч

Аюулт дайсныг дарахын төлөө

Амь биеэ үл хайрлагч

Ачит хүлэг Боорчу минь!

Ханилж явах цагт

Хар бяруу мэт номхон байвч

Хатгалдах дайсантай тулах цагт

Харцага шонхор мэт догширч

Харийн дайсныг дарахын төлөө

Халуун амиа үл бодогч

Хайрт хүлэг Боорчу минь!

...

Наадан явах цагт

Намрын унага мэт эелдэг боловч

Нанчилдах дайсантай учрахад

Начин шонхор мэт довтолж

Насан ямагт зүтгэсэн

Найз хүлэг Боорчу минь!

...” (“Лу. Алтан товч”) гэжээ.

Мухулайг магтсан нь:

“Дайсныг даралцаж

Олзыг оруулалцаж

Ирэх дайсны

Ирийг мохоож

Буцах дайсны

Борвийг хянгартаж

Хүлэг моринынхоо сүүл дээгүүр

Хүдэн манан татуулж

Унасан моринынхоо дэл дээгүүр

Ургах нарыг гийгүүлж

Дайсныг хөрөнгөнөөс

Тасархай утас орхилгүй

Хугархай зүү гээлгүй

Хураан авч ирсэн

Жалайрын сайн Мухулай минь!”

(“Лу. Алтан товч”) гэв.

Борухулыг магтсан нь:

“Хурдан аянд мордож

Хур шөнө тохиолдовч

Хоол ундгүйгээр

Хоосон хоноглосон удаагүй,

Яаралтай дайнд мордож

Ямар ч бэрхшээл тохиолдовч

Шөл тасалдуулж

Өл алдуулж байсангүй”

(“Нууц товчоон”).

“Харвах суманд

Халхавч болсон

Сурхирах суманд

Саравч болсон

Толгойгоо шархдахад

Тохомоо эс алдсан

Хүшин Үгүшний сайн Борухул минь!”

(“Лу. Алтан товч”) гэжээ.

Чулууныг магтсан нь:

“Хар бага насандаа

Халдан Тайчигудад баригдаж

Хал тамыг амсахуй үед

Ханилж тусалсан Чулуун минь!

Өстөн дайсныг дарахад

Өмөг түшиг болсон

Өлгий нутгаа нэгтгэхэд

Өрлөг хүчнээ зүтгэсэн

Харьтан дайсныг устгахад

Хатан зоригоороо хатгалдсан

Хамаг Монголыг тогтнуулахад

Халшралгүй тэмцсэн Чулуун минь!” гэжээ.

Чингисийн хоёр манлай бол Уругудын Жүрчидэй, Мангудын Хуйлдар хоёр болно. Энэ хоёрыг түүх шастирт Чингисийн дөрвөн хошууч, дөрвөн хүлэгтэй нь зэрэгцүүлж “хоёр манлай” баатараар дурдсангүй боловч хэрэг дээрээ ийм үйлдлийг үзүүлж байсан бөгөөд ингэж үнэлж байжээ. “Хатгалдах өдөр хамгийн тэргүүнд Уругуд, Мангудын цэргийг Жүрчидэй, Хуйлдараар толгойлуулан мордуулбаас сая миний сэтгэл бүрнээ амардаг бөлгөө” (“Нууц товчоон”, 209 дүгээр зүйл) гэж Чингис хаан үнэлж байсан бөгөөд

“Алалдах өдөр

Амиа хайрлахгүй

Ачийг хүргэж

Байлдах өдөр

Байраа алдахгүй

Баатарлан зүтгэсэн” гэж магтаж байсан юм.

Жүрчидэй бол Уругуд овогтны дээдэс Уругудай (Начин баатарын ахмад хөвгүүн)-н зургадугаар үеийн ач болно. Жүрчидэй бол эрэлхэг баатар, мэргэн харваач гэсэн алдартай юм. Тэр байлдаан хийхдээ алаг туг мандуулж, айхавтар сүрхий довтолдог сан. Жүрчидэй түрүүтэй Уругуд нар анхандаа Жамуха-д харьяалагдаж байжээ. гэвч “Арван гурван хүрээний байлдаан”-аас хойно тэр, Жамуха-гийн харгис хэрцгийг жигшиж, Хуйлдар түрүүтэй Мангудын хамт Жамуха-гаас салж Чингис хаанд дагаар ирсэн юм. Ингээд Чингис хаан Онон мөрөнд хурим бэлтгэн угтаж авсан билээ. Түүнээс хойш олон удаагийн байлдаанд Уругуд, Мангуд оройлон довтолдог байжээ. Ялангуяа 1203 онд болсон “Муу өндөрийн байлдаан”-д Чингис хаан гурван мянгаадхан цөөн цэргээрээ Хэрэйдийн хүчирхэг олон цэрэгт том их хохирол учруулсан явдал нь бүр Жүрчидэй Хуйлдар түрүүтэй Уругуд Мангудын гавьяа юм. Сүүлд нь Жэжэгэр өндөрт Жүрчидэй, Архай Хасар хошуучлан орж, гурван шөнө гурван өдөр ширүүн байлдаж, Хэрэйдийг хамаг эцэс мөхөөхөд мөн Жүрчидэй тэргүүн гавьяаг байгуулжээ. 1204 онд Найманыг дайлахад, Хуйлдар нэгэнтээ нас барсан тул Жүрчидэй Хуйлдарын хөвгүүн Мөнх, Халжа-гийн хамт Уругуд Мангудаа удирдан, дөрвөн хошуучийн гэээгт хоёрдугаар шатын цэргээр довтолж, их гавьяа бүтээсэн байлаа. Дараа нь Ван ханы дүү Жаха Гомбу нүүр дээрээ даган өгсөн боловч нууц далдуур хоёр сэтгэлийг өвөрлөж, эцэстээ урван явсныг Жүрчидэй уран аргаар барьж авсан билээ. Ингээд 1206 онд улс байгуулахад наян найман гавьяатны зургадугаараар шагнагджээ. Жүрчидэйн гавьяаг Чингис хаан тусгайлан дурдахдаа “Жүрчидэй чамайг би өндөр уулын нөмөр мэт өмөг болгон санаж явлаа” (“Нууц товчоон”, 280 дугаар зүйл) гэж үнэлсэн бөгөөд “Жүрчидэйн ачийг хариулж, гавьяаг тэмдэглэхийн тул” Чингис хаан татвар хатан Ибага бэхи-гээ Жүрчидэйд шагнажээ. Дараа нь Жүрчидэй дөрвөн мянган Уругудаа захирч, Алчи ноён, Толун чэрби-гийн хамт Чингис хааны дүү Хасарт харьяалагдаж, Алтан улсыг дайлах үед Хасарын хамт зүүн гарын цэргийг захиран зүүнш Цзичжоу болон Ляоши зэрэг газрыг эзэлсэн бөгөөд дараа нь Алтан улсын умард нийслэл Да Дин Фу (хуучин ор нь одоогийн Өвөр Монголын Баарин зүүн хошуунд байх Бор хот болно) хотыг дайран зүүнш нүүж, Жүрчидийн нутгаар нутаглаад, удсангүй өвчнөөр үхлээ гэдэг билээ. Жүрчидэй-н дүү Чанай мөн Чингис хаанд шударгаар зүтгэсэн тул хишигтний даргаар томилогджээ. Жүрчидэйн хөвгүүн Хэтэй ч мөн эрдэм чадвараар хэтийдсэн тул эцгийнхээ хамт мянганы ноён (тавин долдугаар)-оор өргөмжлөгдсөн бөгөөд Алтан улсыг дайлсны дараа Жүн вангаар өргөмжлөгджээ.

Хуйлдар бол Мангуд овогтны дээдэс Мангудай (Начин баатарын хоёрдугаар хөвгүүн)-н зургадугаар үеийн ач болно. Жүрчидэй түрүүтэй Уругуд лугаа төрөл угсаа юм. Урьд Жамуха-гийн хүч их байх үед, Хуйлдарын ах Үйеи гэгч харьяат нараа авч Жамуха-г дагаар явахад, Хуйлдар ятгавч сонссонгүй, буцаж очоод хоригловч нэхэж ирсэнгүй. Ингээд Хуйлдар ахаасаа салж, өөрийн харьяатаа дагуулан, Жүрчидэй-н хамт Чингис хаанд дагаар иржээ. Тэр үед Чингис хаан: “Ах чинь Жамуха-гийн тэнд байх атал, чи ганцаар ямар учраас энд үлдэх аж?” гэж асуусанд, Хуйлдар хэлэх үгээ олж ядан, нэгэн сумыг авч хугалаад: “Энэ биеийг эцтэл хаанд эс үйлчилбээс энэ сум мэт болтугай!” гэж хэлэв. Чингис хаан түүний үнэнч шударгыг

нь биширч, “сэцэн” цол өгч анд бололцжээ. 1203 оны “Муу өндөрийн байлдаан”-д орохдоо Хуйлдар сэцэн: “Андын өмнө би хатгалдваас, миний хойно хоцорсон үнэнч хөвгүүдийг минь асрахыг анд мэдтүгэй” гэж хэлээд Жүрчидэй-н хамт Уругуд Мангуд оройлон орж, Хэрэйдийн нэгэн салбар Жирхинийг дарав. Дараа нь Түмэн Түбэгэн-ийг Ачиг Ширүн лугаа байлдахад Хуйлдар толгойгоороо шархаджээ (“Нууц товчоон”-д хаагуураа шархадсаныг дурдсангүй). Ингээд Мангуд нар авран гаргаж, оройд нь Чингис хаан мянган лангийн ховор эмээ шаваж өгөөд майхандаа авч хонолоо гэдэг. Тус байлдаанаас сарын хойно, Чингис хаан Халх голоос нүүх үедээ зам зуур хүнс нөөвөрлөхийн тулд ав хийжээ. Энэ үед Хуйлдар хааны ятгахыг сонсонгүй, гөрөөсөнд довтолж, шархаа үтээрээд завшаан бусаар нас баржээ. Хаан гашуудун харамсаж, ясыг Халхын Орнугу-гийн хэлтгий хад гэсэн газар оршуулжээ. Чингис хааны цэрэг Хэрэйдийг сөнөөж, Ван ханы жанжин Хадаг баатарыг эзнээ тусласан (Ван ханыг тавин явуулсан) шударга хүн гэж соёрхон, зуун иргэнийх нь хамт Хуйлдарын эм хөвгүүдэд зарц болгон өгчээ. 1206 онд улс байгуулахад Хуйлдарын гавьяаг дуурсган, наян найман гавьяатны хорин нэгдүгээрт нэхэмжлэн өргөмжилсөн бөгөөд түүний хөвгүүн Мөнх, Халжа-г тавин хоёрдугаар гавьяатнаар шагнажээ.

Чингисийн есөн өрлөг гэдэг яриа бол маш өргөн уламжлагдсан яриа юм. Саган сэцэний “Эрдэнийн товч”-д “Есөн өрлөгүүд түрүүлэн хүчээ өгөгсдөд” гэж тэмдэглэж байсан боловч, “есөн өрлөг”-т хэн хэн багтах тухай бодтой дурдсангүй бөгөөд өөр түүхэн тэмдэглэлд ч хараахан харагддаггүй билээ. “Чингисийн есөн өрлөгтэй өнчин хөвгүүний сэцэлсэн шастир” гэдэг нэгэн уянгын хэлбэрт уран зохиолд есөн өрлөгийн нэрийг дурдсан байдаг. Тэр нь:

- (1) Сүлдэсүний Сорхан шар;
- (2) Жалайрдайн Го Мухулай;
- (3) Жүрчидийн Чуу мэргэн;
- (4) Аруладын хүлэг Боорчу;
- (5) Урианханы Зэлмэ;
- (6) Бэсүдийн Зэв;

(7) Ойрадын Хар Хирүгэ;

(8) Борухул;

(9) Шигихутуху зэрэг болно (“Чингисийн цадиг”).

Лувсанданзаны зохиосон “Алтан товч”-д “есөн өрлөг” гэсэнгүй, Чингисийн “дотоод есөн сайд” гэдэг тэмдэглэл байдаг. Ц.Дамдинсүрэн авгай одоогийн хэллэгээр орчуулсан “Монголын Нууц товчоон”-ыхоо 149 дүгээр зүйлийн өмнө хэсэгт нөхөн оруулсан байна. Түүнд: Суут богд Чингис хаан, зах нутаг нутаглаж явахын цагт нэгэн өдөр дотоод есөн сайдаа авч мөр хайж, бараа харж яваад зарлиг болруун: “Аль ч зүгээс ямар ч дайсан ирэх магадгүй есөн сайд минь, гурван хэсэг болж яв” гэж зарлиг болов. Эзний зарлигийг дагаж Зэлмэ, Чуу мэргэн, Шигихутуг гурвуул нэгэн хэсэг болов. Боорчи, Борохул, Мухулай гурвуул нэгэн хэсэг болов. Сүлдүсний Сорхан шар, Бэсүдын Зэв, Ойрадын Хар Хирүгэ гурав нэгэн хэсэг болж гэрт үлдэв гэжээ. Энэ нь “Чингисийн цадиг”-т дурдсан нэрстэй дэс дараа ба бичлэгийн талаар бага сага зөрөөтэй боловч агуулгын талаар адил байна.

Энд дурдаж бүхий Зэлмэ, Чуу мэргэн, Шигихутуху, Боорчу, Борухул, Мухулай, Сорхан шар, Зэв, Хар Хирүгэ зэрэг есөн хүний долоог нь бид бүр тусгай танилцуулж өнгөрсөн билээ. Үүний дотор “дөрвөн хүлэг”-ийн гурав нь (ганц Чулуун үгүй), “Дөрвөн хошууч”-ийн хоёр нь (Хубилай, Сүбээдэй үгүй) байхгүй бөгөөд түүний дээр олны мэддэгээс Шигихутуху, Сорхан шар хоёр байна.

Гэтэл хоёрдугаарт дурдсан “Чуу мэргэн”, есдүгээрт дурдсан “Хар Хирүгэ” гэдэг хоёр хүн, хүмүүсийн анхаарал сонирхлыг ихэд татаж байдаг. Учир нь энэ хоёр хүнийг “Нууц товчоон” зэрэг тулгар бичигт ер дурдсангүй билээ.

Чуу мэргэний тухай “Лу. Алтан товч”-ийн мэдээ бол өөрийнх нь хэлсэн ба Чингисээс магтсан шүлэг болно (Үүнийг бас “Гурван зуун Тайчигудыг дарсан домог” гэдэг).

Чуу мэргэн хэлсэн нь:

“Довтлон орох чадалгүй боловч

Тогтсоныг бататгах чадалтай би.

Эрчлэн дайрах чадалгүй боловч

Эвдэрснийг сэлбэх чадалтай би.

Уульхай зантай Чуу мэргэн би

Ухран зугатах магадгүйг

Урьдаас хаандаа хэлье.

Улс орноо тогтсон хойно

Учиртай үгээрээ тусалж чадна.

Харь дайсныг довтлох цагт

Хаан эзэн Чингис чамд

Хашир миний болгоомжлох үг

Хаяа боловч тус болмуй” гэв.

Чингис хаан Чуу мэргэнийг магтсан нь:

“Зарлигийг минь алдалгүй дагаж

Заасныг минь алдалгүй гүйцэтгэж

Дайсны тэргүүнийг

Тас харваж

Унасан зээрд морийг нь

Уулгалан булааж

Хатгалдах дайсныг

Хаг цохиж

Зөрчилдөх дайсныг

Цөм цохисон

Жүрчидийн Чуу мэргэн минь” гэжээ.

Энэ хэдэн бадаг шүлгээс бид юуныг олж мэдэв гэвэл, Чуу мэргэн бол Жүрчин хүн гэдгийг олж мэджээ. Бас Чуу мэргэн гэдэг хүн бол байлдаанд барагтай боловч, төр хүнийг засахдаа аргатай гэдгийг олж мэджээ. Энэ нь хэлэлгээнгүй нэгэн бичгийн сайд хүний дүр байна. Ийм болохоор, Ц.Дамдинсүрэн авгай түүний зохиосон “Монгол ардын уран зохиолын түүх” гэдэгтээ: ”Гурван зуун Тайчигудыг дарсан домог” гэдэг энэ шүлэглэлд бас нэг сонирхолтой зүйл гэвэл Чингисийн есөн өрлөгийн нэг Чуу мэргэний нэрийг дурдсан явдал болно” гэсэн бөгөөд “энэ дайчин баатар биш боловч дайсныг номхотгох арга ухаантай Чуу мэргэн бол мэргэн сайд Елюй Чүцай (бид Елюй Чүцай гэж галиглав - эшлэгч) мөн. Чингис 1215 онд Бээжин хотыг эзлэн авах үед Алтан улсын түшмэл Елюй Чүцай гэдэг хүнтэй танилцаад албаны тушаалдаа авч хэрэглэсэн байна. Чуу мэргэн уг хятад (нанхиад) хүн биш, хятан хүн юм. Хятан нар бол монгол угсаатан байсан болохоор Чуу мэргэн монгол угсаатны хүн байлаа

гэж тэмдэглэж байв. Дамдинсүрэн авгайн энэ тэмдэглэлд, “Лу. Алтан товч”-д дурдсан “Дотоод есөн сайд” гэдэг бол “Чингисийн есөн өрлөг” мөн, “Чуу мэргэн” гэдэг бол Хятаны “Елюй Чусай” мөн гэдгийг тодорхой зааж гаргажээ.

Дээрх шүлгийн агуулга ба Елюй Чусайн ерөнхий байдлыг харьцуулж зүйчилбэл, Чуу мэргэн бол Елюй Чусай мөн гэхэд тохирох нэгэн тал буй. Гэвч “Лу. Алтан товч”-ийн энэ тэмдэглэлийг түүхэн баримт гэж үзэхэд зохисгүй газар нэлээд буй. Нэгд, цагийн талаар нэлээд зөрж байна. Тайчигудыг дарсан байлдаан бол 1202 оны явдал юм, гэтэл Елюй Чусай-г тушаалд хэрэглэсэн нь харин 1205 оны явдал болно. Хоёрт, учир явдал нь зөрж байна. Елюй Чусай ерөөс биеэрээ дайн байлдаан хийж яваагүй. Гуравт, үндэс угсаа ба цол нь ч таарахгүй байна. Елюй Чусай бол жүрчин хүн биш, харин хятан хүн юм. Елюй Чусай-г Чингис хаан “нэрээр нь дууддаггүй, харин урт сахалт гэж дууддаг” гэж бичиг сударт өргөн тэмдэглэж буй. “Чуу мэргэн” гэсэн цол “Лу. Алтан товч”-оос өөр газар харагдахгүй. Тиймээс энэ Чуу мэргэн гэдгийг урлагийн дүрээр үзэж болохоос биш, түүхэн хүн Елюй Чусай гэж хэлэхэд хараахан баримтгүй мэт.

Хар Хирүгэ гэдгийг зөвхөн нэр дурдсанаас биш, өөр мэдээ үгүй.

Ингээд үзвэл, энэ “Дотоод есөн сайд” гэдгийг “Чингисийн есөн өрлөг” гэж үзэхэд арай баримт хүрэлцэхгүй шиг байна.

Дөрвөн хошууч, дөрвөн хүлэг, Жүрчидэй, Хуйлдар хоёр манлай бол үнэн өрлөг жанжны үйлдлийг үзүүлж байсан юм. 1203 онд Хуйлдар үхсэн хойно, хэрэг дээрээ есөн хүн байжээ. Гэвч үүнийг бас “есөн өрлөг” гэж хэлэх баримтгүй билээ. Зөвхөн “өрлөг” гэдэг ухагдахуун бол иймэрхүү баатарчууд байвал таарна гэж бодогдож байдаг бөгөөд үүнийг нэгэн мадагтай асуудал болгон тэмдэглэе.

Чингисийн наян найман гавьяатан 13 гэдэг бол 1206 онд Хаант Монгол Улсыг тунхагласан тэр үед, Чингис хаан нэр дурдан шагнаж, мянганы ноёноор томилогдсон бүх гавьяат хүмүүс болно, мөн Чингис хааны “нөхөр бүлгэм”-ийн төлөөлөгч нь болно. Наян найман гавьяатны нэрс, дэс дараа ба товч байдлыг тус бүлгийн “13”-т лавлаарай.

Чингис хааны өөрийнх нь түүхэн өнгөрөлт ба бүх монгол хэлтнийг нэгтгэсэн түүхэн явц бол Чингисийн “нөхөр бүлгэм”-ийн бүрэлдэн нэгдсэн явц мөн гэж үзэж болно. Энд Чингис хаан “нөхөр бүлгэм”-ээ байгуулахад ямар хүнийг сонгон хэрэглэсэн буй гэсэн асуулт тавигдаж байна. Энэ бол хүн хэрэглэх асуудал бөгөөд манай одоогийн үгээр хэлбэл, кадр хэрэглэх зарчим болно. Өөрөөр хэлбэл “нүүр талаар хэрэглэдэг” үү? “эрдэм чадвараар нь хэрэглэдэг” үү? гэсэн асуудал болно.

Чингисийн дөрвөн хүлэг, дөрвөн хошууч, есөн өрлөгийг багтаасан наян найман гавьяатны дотор, овог аймаг нь тодорхойгүй арав есөн хүнийг гаргавал, бусад нь гучин нэгэн овог аймгийн хүмүүс болно. Энэ нь Чингис хааны “нөхөр бүлгэм”-ийн хүрээ хэмжээг харуулж байна. Ялангуяа эдгээрийн дотор Жалайр, Урианхад, Сүлдүс, Баягуд, Дархад зэрэг унаган (өтгөс) боол овгийн хүмүүс; Татар, Мэргид, Тайчигуд, Хэрэйд зэрэг дайсан овог аймгийн хүмүүс; Онгуд, Ойрад, Ихирэс, Хонгирад, Горлос зэрэг харь овгийн хүмүүс багтаж байсан бөгөөд бас анхандаа биеэрээ Чингис хааныг дайсагнаж, сүүлд нь үнэн сэтгэлээсээ дагасан

хүмүүс ч буй. Жишээлбэл, Чингисийн дөрвөн хошууч жанжны нэг Зэв бол Чингис хааныг харван шархдуулсан дайсан нь байсан юм. Гэвч тэр үнэн үгээ хэлсэн учраас Чингис хааны итгэл хайрыг олж, туйлын шударга найдвартай нөхөр нь болжээ. Үүнээс гадна, Чингис хаан бас нэлээд олон Уйгур, Сартуул, Хятан, Жүрчин, Хятад, Тангуд зэрэг харь улс үндэстний эрдэмтэн чадвартныг хэрэглэсэн байна. Энд анхаарууштай нэг зүйл гэвэл, Чингис хаан өөрийнхөө төрөл садан жишээлбэл, дүү Хасар, Бэлгүтэй, Отчигин ба хөвгүүн Жочи, Өгөөдэй нар бүр чухал их зүтгэл гаргаж, цусан гавьяа байгуулсан боловч хүнд гавьяатнаар шагнаж, эрхэм зэрэгт томилсонгүй байна. Эдгээр байдлаас үзвэл, Чингис хааны хүн хэрэглэх зарчим нь “нүүр талаар хэрэглэдэг” хуучин ноёрхогчийн доройтлыг тусгасангүй, харин “эрдэм чадвараар нь хэрэглэдэг” шинэ ноёрхогч феодал ангийн мандал хөгжлийг харуулж байжээ. Энэхүү “эрдэм чадвар”-ыг эрхэмлэхийнх нь товойсон илрэл бол эзэндээ хязгааргүй үнэнч шударга байх феодалын үзэл ухамсар болно. Чингисийн энэхүү үзэл санааг бид тус товчооны аравдугаар бүлэгт тусгай сэдвээр зөвлөх болохоор энд дурдаад л тавья.

Чингисийн шадар зэвсэгт бүлгэм

Чингис хаан бүх Монгол үндэстнийг нэгтгэж, Хаант Их Монгол Улсыг байгуулахад, өөрийн хүчирхэг их зэвсэгт хүчин - төмөр морьт цэрэгтээ түшиглэснийг бид дээр дурдсан билээ. Тэрчлэн Чингис хаан гадаад дотоодыг дайлж, даян дэлхийг донсолгож байхдаа ч мөн түүний мохошгүй морьт цэрэгтээ түшиглэж байсан. Харин энэхүү төмөр морьт цэрэгт нь бас нэгэн шалгарсан голлогч зэвсэгт хүч байжээ. Үүнийг нь бид “шадар зэвсэгт бүлгэм” гэж нэрлэлээ. Тэр бол Чингис хааны түмэн хишигтэн нь болно.

Хишигтэн гэдэг бол хааны ордыг хамгаалах шадар бараа хүмүүсийг хэлж байна. Тэдний энгийн цагийн үүрэг бол хааны шадар хамгааллыг гүйцэтгэж, дайн байлдааны үед бол хааны шууд захиралаар хүнд чухал үүргийг гүйцэтгэдэг байжээ. Чингисийн үгээр хэлбэл: “энгийн өдөр ээлжлэх торгон цэрэг болгож, хатгалдан байлдах өдөр хамгийн тэргүүнд баатарлуулан явуулах” “их голын цэрэг болгох” явдал болно. Хишигтнийг “хэвтүүл”, “хорчин”, “турхаг” гэж ажил үүргээр нь нарийн хувиарладаг байна.

Чингис хааны хишигтэн нь урьд 1204 оны эхэнд Найманыг нэгтгэн авахын өмнө жинхэнээр байгуулагдсан бөгөөд тэр үед сая наян хэвтүүл, далан турхагтай байжээ. Одоо Чингис хааны “хүч аугаа нэмэгдэж, гүр улс (бүх улс)-ыг шударгатгаж (нэгтгэж) ганц жолоондоо оруулсан” тул энэхүү “шадар зэвсэгт бүлгэм” (их голын цэрэг)-ээ өргөтгөх чухалтай болжээ. Ингээд зарлиг буулгаж, турхагийг найман мянга, хэвтүүл, хорчиныг тус бүр мянга болгож, нийт түмэн хишигтэн болгожээ.

Чингисийн “шадар зэвсэгт бүлгэм” - түмэн хишигтнийг сонгоход бас чанга нөхцөл баримжаа ба дүрэм тогтоолтой байдаг байна. Тэр нь:

(1) Түм, мянга, зуу, аравны ноён жич дүрийн хүн (сул ард)-ий хөвгүүн (эрдэм чадвартай, бие шил сайтайг сонгон авах) нь нэгэн дүү ба тогтсон тооны нөхдөө дагуулж, хишигтэн цэргийн алба хаах хэрэгтэй. Бодтой хэлбэл, мянганы ноёдын хөвгүүд бол арван нөхөд, нэг дүүгээ, зууны ноёдын хөвгүүд бол таван нөхөд нэг дүүгээ тус тус дагуулан ирэх хэрэгтэй.

(2) Шадар цэрэгт орвоос зохих нөхцөлтэй хүн, өөрөө орох дургүй, өөр хүнийг орлуулан

явуулагсадыг хол газарт цөлөн яллана.

(3) Сайн дураасаа “Бидний дэргэд дотно явж суралцая гэж бидэнд ирэх ардыг бүү хориглотугай” гэж тогтоожээ.

Чингисийн түмэн хишигтний байнгын үүрэг тушаал гэвэл, турхагуудыг нийт дөрвөн ээлж хувааж, ээлж бүр гурван хоног алба хаадаг байна. Ээлжээ нэг удаа тасалсан хүнийг гурван бэрээс (peri'es - ташуур буюу бургас - зохиогч) занчиж, хоёр удаа тасласан хүнийг долоон бэрээс занчиж, гурван удаа тасалсан хүнийг гучин долоон бэрээс занчиж, хол газар цөлж явуулахаар тогтжээ.

Хааныг сэргийлэн хамгаалах тухай бас нарийн дүрэм тогтоолыг тогтоосон бөгөөд шадар цэрэг бологсдод онц эрхийг олгожээ. Жишээлбэл, Чингисийн хишигтэн нь “гадаад мянганы ноёдоос эрхэм тул”, гадаад мянганы ноёд хэрвээ Чингисийн хишигтэн лүгээ хэрэлдвэл, тэр мянганы ноёныг шийтгэх болно. Бас Чингисээс хойш хаан ор залгамжлагчид ургийн ураг хүртэл, Чингисийн түмэн хишигтнийг “аливаа гасланд хүргүүлэлгүй сайтар асрах хэрэгтэй” ба “эдгээр түмэн хишигтнийг миний эрхэмсэг хишигтэн гэж өргөмжлөх” онц эрхийг өгчээ.

Үүнээс гадна, хэвтүүлд бас онцгой үүрэг тушаалыг хариуцуулжээ. Жишээлбэл:

- (1) Шигихутуху-гийн зарга шийтгэхэд оролцож сонсох;
- (2) Ордны чэрби, охид, гэрийн хүмүүс, тэмээчин, үхэрчин нарыг эрхлэн мэдэх;
- (3) Ордны гэр тэрэг, туг хэнгэрэг, дөрөө жадыг хамаарах;
- (4) Нум, саадаг, хуяг, зэвийг хадгалах ба түгээх;
- (5) Аяга сав, идээ ундааныг хамааран захирах ба чэрби нарын хамт эд агуурсыг түгээх;
- (6) Орд гэрт орж гарах юмыг хамаарах;
- (7) Нутаг ус эрж, нүүж буухыг хамаарах;
- (8) Ав шувуу тавихад оролцох мэт.

Чингис хаан энэхүү түмэн хишигтнээ Их Нэгүрин (үүнийг Мүнлиг эцгийн хөвгүүн гэж Накамичиё авгай тэмдэглэжээ), Есөнтэгэ (Зэлмэ-гийн хөвгүүн), Өгэлэн чэрби (Боорчу-гийн дүү), Буха (Мухулай-н дүү), Алчидай (Илүгэй-н дүү, Чингисийн дүү Хачигуны хөвгүүнтэй нэр адил), Дөдэй чэрби, Догулху чэрби (Жадай-н дүү, Мангуд овогтон), Чанай (Жүрчидэй-н дүү Орунар овогтон), Ахудай (Хонгирад овогтон, Алчи ноёны дүү), Архай Хасар(Жалайр овогтон, Сача Домуг-ийн хөвгүүн) нарт тус бүр мянган хүн өгч зохион байгуулжээ.

Бас энэхүү өдрийн жишээний турхагуудаа дөрвөн ээлж болгож, Буха, Алчидай, Дөдэй чэрби, Догулху чэрби дөрвийг турхагуудын ахлагч болгожээ.

Багцлаад хэлбэл, Чингисийн “шадар зэвсэгт бүлгэм” түмэн хишигтэн бол зохих нөхцөл

баримжаагаар сонгон авч, чанга хатуугаар сургуулилан хүмүүжүүлж, нарийн тодорхой тогтоол дүрмээр ажилладаг шадар цэрэг болно. Үүнийг зарим материалд: “Чингис хааны хамгаалагч цэрэг нь их хааны хамгааллыг хариуцахаар барахгүй, тэр нь нэгэн цэргийн сургуулийн үйлдэлтэй юм. Чингис хаан цэрэг захирах жанжин нарыг шадар цэргээс сонгон дэвшүүлж байдаг юмсанжээ” гэж тэмдэглэж байдаг билээ.

Чингисийн “Бодлогоч бүлгэм”

Чингис хаан бол “Азийн их хаан”, “Нэгэн аугаа их, төрөлх авьяас билигт цэргийн ухаантан болохоор барахгүй, мэргэн гэгээн улс төрч болох юм” гэж дэлхийн хүмүүс үнэлцгээдэг. “Чингис хааны жолоонд өнөд ялалтын баталгаа агуулагдаж байдаг” гэж түүний харьяанд удаан жил ажиллаж байсан нэгэн сартуул худалдаачин Ялавачи гэгч хэлж байлаа гэдэг юм. Бас хэн бүхний мэдэж байхаар, Чингис хаан бол ямар ч орчин үеийн мэт сурган хүмүүжил ба боловсрол мэдлэгийг хүлээсэнгүй мөртөө үсэг бичиг ч мэддэггүй (хамгийн наад захдаа ийм тэмдэглэл олдоогүй байсаар) хүн юм. Чингэвэл тэр яагаад ийм их авьяас билгийг бүрэлдүүлсэн буй? Энэ асуултанд зөвхөн гүн ухааны томьёоллоор хариу өгөх юм бол тийм бэрх асуудал биш, “аливаа үнэн мэдлэг, авьяас билиг, арга ухаан цөм үйлдлэгээс ирдэг”, олон түмний дундаас ундардаг гэж хариулахад буруугүй биш үү. Гэвч энэ асуудал, ялангуяа Чингис хаан мэтийн түүхэн хүний тухай зөв оновчтой хариу өгөх бол тун бэрх бөгөөд хэдэн зуун оны холхи учир болохоор танин мэдэхүйд хүчиртэй юм. Гэвч хэдий хүчир бэрх ч болтугай, уншигчдад хэдэн үг хэлэх хэрэгтэй болжээ.

Чингис хааны авьяас билиг ба арга ухааны бүрэлдэхүүнд түүний өөрийнх нь төрөлх хүчис багтаж байхыг үгүйсгэж болшгүй. Гэвч түүний гол бүрэлдэхүүн нь бол тухайн цаг үеийн тусгал болно. Өөрөөр хэлбэл, Чингисийн бүх үйл явдал нь түүний ганц хүний биш, харин бүх угсаатны болох буюу хамгийн наад захад түүнээр гол болгосон нэгэн бүлэг хүмүүсийн болох ёстой. Булрин гэгчийн зохиосон “Чингис хаан” гэдэг товхимолд: “Чингис хааны дэргэд дэлхий ертөнцийн байдлыг нэвгэрхий мэддэг бичиг цэргийн түшмэд олон байжээ” гэж тэмдэглэж байсан юм. Эдгээр хүмүүсийг бид Чингисийн “Бодлогоч бүлгэм” (эсхүл “зөвлөгч бүлгэм” гэсэн ч болно) гэж түр цаг нэрлэжээ.

Чингис хааны “бодлогоч бүлгэм” гэдэг зохион байгуулалт байсан мэдээгүй боловч ийм үйлдлийг гүйцэтгэж байсан хүн буюу ямар нэгэн зохион байгуулалтын хэлбэр оршиж байсан нь түүхийн үнэн хэрэг юм. Өөрөөр хэлбэл, Чингис хаан ямар нэгэн том явдлыг шийдвэрлэхэд, юуны урьд хуралдай буюу ямар нэгэн хэмжээний зөвлөгөөнөөр дамжиж олны саналыг сонсдог байна. Энэхүү хэлбэр бол үндсэндээ тогтмол чанартай байжээ. Гэвч түүнд оролцох хүмүүс нь заавал тогтсон хэдэн хүмүүс байх ёсгүй, харин хувиралттай байсан нь ч илхэн юм. Ерөнхийд нь хэлбэл, ийм зөвлөгөөнд оролцсон нь хоёр зүйлийн хүмүүсээр бүрэлддэг байна. Нэг нь, Чингисийн алтан ургийнхан болно. Нөгөө нь Чингисийн дотоод сайд, шадар түшмэд нь болох бөгөөд энэ нь мөн ч “бодлогоч бүлгэм”-ийнх нь гол нь болох юм.

Алтан ургаас нь юуны урьд Өгэлүн эх, Бөртэ үжин, Бэлгүтэй, Отчигин нарыг дурдаж болно.

Өгэлүн эх бол Чингисийн авьяас билиг, арга ухаан, эрэлхэг зориг, тэсвэр хатуужилтай овор, нөхөр ханийг эрхэмлэх зэрэг бүх оюун ухааны талаар анхны нөлөө ба хүмүүжлийг хүртээсэн

хүн юм. Ялангуяа Чингис хаан мэт юунаас ч айдаггүй хүнийг гагцхүү Өгэлүн эх л дарж чаддаг билээ. Жишээлбэл, нэг удаа Чингис хаан, Дэв тэнгэр (Хөхэчү бөө)-ийн завсардуулгад унаж, дүү Хасараа барьж хүлээд шийтгэх гэж байхад, Өгэлүн эх нь чимээг сонсоод, цагаан тэмээ хөлсөн (хөллөсөн - хө) сүйх тэргэнд сууж, шөнө турш яван хүрж иржээ. Чингис хаан эхээ үзээд эмээн зайлсан гэлээ. Өгэлүн эх уурлаж тэргэнээсээ буумагц, Хасарын хүлээсийг өөрөө тайлж тавиад, малгай бүсийг нь Хасарт өгч, уур хилэнгээ даран ядаж завилан суугаад, хоёр хөхөө гаргаж хоёр өвдөг дээрээ барьж: “- Үүнийг харж байна уу? Хөхсөн хөх чинь энэ байна. Хавиргаа хадран хазагчид, хүйгээ хүчирхэн таслагчид! Хасар яав? ...Одоо дайсныг дарж төгсөв хэмээн Хасарыг үзэн ядаж байна уу?” гэж загнасанд Чингис хаан: “Эхээ хилигнэсэнд би айхын ихээр айж, ичихийн ихээр ичив. Бид одоо ингэхээ больё!” гэж хэлэв. Чингисийг есөн настай хүүхэд байхаас нь аваад бүх монгол хэлтнийг нэгтгэн Хаант Монгол Улсын анхдагч Далайн хаан - Чингис хаан суутал, Өгэлүн эх бүр салсангүй. Тиймээс тэр Чингисийн үйл явдалд лав олон талын сурган хүмүүжил, арга бодлого, сануулга зөвлөгөө тавьж байсан ёстой бөгөөд биеэрээ ч арвин ажил хийсэн байх ёстой. Учир нь Өгэлүн эх бол оюун ухаан сэргэлэн, арга бодлоготой мэргэн эх болохоор барахгүй, Есүхэй баатарын дайчин тугийг мандуулж дайн байлдаан хийж байсан (Тайчигуд-ыг нэхэж байсан ба “Арван гурван хүрээний байлдаан”-д нэгэн хүрээг захирч байжээ) баатар эх билээ. Гэтэл түүний сүүлчийн үеийн үйл ажиллагааг нь түүх шастирт тэмдэглэж үлдээсэнгүй нь тун харамсалтай явдал болно.

Бөртэ үжин бол Чингис хааны авааль гэргий, гол хатан бөгөөд хааны үр хөвгүүдийг нь өсгөн, айл өрхийг нь эрхэлж байснаар барахгүй, Чингистэй хамт зовол зүдгүүрийг эдэлж, үйл ажиллагааг нь үнэнчээр дэмжин, мартсаныг нь сануулж, унтсаныг нь сэрүүлж байсан юм. Тиймээс тэр бол Чингисийн найдварт бодлогочийнхи нь нэг байсан нь дамжиггүй. Өнгөрсөнд хүмүүс Бөртэ үжинийг дэмий анхаарсангүй учир гэвэл, энэ талын мэдээ яг үгүй байсан биш, харин эмэгтэй хүний нийгмийн байр суурь, жич түүний язгууртан гаралд нь халхлагдаж байсан ч магадгүй. Хэрэг дээрээ аль ч улс үндэстний түүхэн тэмдэглэлийг үзэхэд, яг энгийн ард олныг тэмдэглэсэн нь хараахан ховор байдаг. Тиймээс бид Бөртэ үжин мэт хүмүүст түүхийн бодосч үзлээр хандах хэрэгтэй. Чингэвэл Бөртэ үжиний мэргэн бодлого нь аль талаар илэрч байв гэвэл, доорхи хэдэн явдлыг дурдаж болно.

(1) Тэмүжин бага насандаа Бөртэ үжинтэй ханилсны дараахан, Бөртэ үжиний “эхийн шитхүл” гэж авчирсан үнэт нандин хар булган дахыг бэлэг болгон Хэрэйдийн Ван хан лугаа холбоолсон билээ. Хүүхэд бага байсан Тэмүжиний улс төрийн тавцан дээрх энэхүү анхдугаар ажиллагаа нь тун зөв бөгөөд маш их бүтэмжийг олжээ. Түүнчлэн Тэмүжиний бүх үйлст нь бүтэмжийн үрийг сацсан байна. Тэгвэл энэ ажиллагаа голдуу хэний бодлого болов гэснийг анхаарах хэрэгтэй. Би бодоход, энэ нь голдуу Бөртэ үжиний мэргэн бодлого гэж үзнэ. Учир нь Бөртэ үжин төрхөмдөө байхад, Дэй сэцэний гэрт арилжаа худалдаачин, элч зарлага байнга ирж явдаг гэсэн тэмдэглэл байдгаас үзэхүл, Бөртэ үжин бол бага наснаасаа олон юмыг үзэж сонссон өргөн мэдлэгтэй бүсгүй байсан нь дамжиггүй юм. Ялангуяа “эхийн шитхүл”-ийг өөр хүнд өгөхөд хэдийгээр феодалын нийгэм боловч Бөртэ үжин лүгээ зөвлөж, түүний зөвшөөрлийг олох хэрэгтэй.

(2) Мэргидийг анх удаа дайлсны дараа Жамуха Тэмүжин хоёр жил хагас хамт нөхөрлөж байгаад 1180 онд Жамуха Тэмүжинээс салан явахад, маш гүн ёгт утгатай салах үг хэлснийг

Тэмүжин ойлгож мэдсэнгүй байхад, юуны урьд Бөртэ үжин ухаж мэдээд: “Жамуха анд амархан уйддаг гэдэг бөлгөө. Өдгөө биднээс уйдах цаг нь болсон буй за, тугаар (сая)-ын Жамуха андын хэлсэн нь, биднийг жишээлсэн үг буюу, бид бүү бууя. ...” (“Нууц товчоон”, 118 дугаар зүйл) гэж хэлсэн бөгөөд хэрэг явдлын хөгжил ч Бөртэ үжиний жишсэн нь бүрэн зөв гэдгийг гэрчлэв.

(3) Чингис хаан Бөртэ үжинтэй хуримласны дараа, түрүү удаа авсан татвар хатан бол Мэргидийн Дайр усуны охин Хулан (буюу Хулан гуа) гэгч болно. Энэ бол “Нууц товчоон” зэрэгт тэмдэглэсэн түүхийн үнэн хэрэг болно. Гэвч “Нууц товчоон”-д дэмий нарийн тэмдэглэл байдаггүй. Энэ явдалд Бөртэ үжин хэрхэн хандсан тухай “Эрдэнийн товч”-д нэлээд тодорхой тэмдэглэж байна. Жишээлбэл, хаан хүн хэтэрхий дураар байвал төр улсад ямар нөлөө болохыг маш уран сэцнээр хэлсэн бөгөөд хааны нэр нүүрийг нь хамгаалан чаджээ. Тэр үед Чингис хаан Хулан хатныг авч харь газар удтал суусанд, Бөртэ үжин Аргасун хорчи (энэ бол “Нууц товчоон”-ы 202 дугаар зүйлд дурдсан арван есдүгээр гавьяатан Хоргусун байж мэднэ. Гэвч 275 дугаар зүйлд дурдагддаг Элжигэдэй-н хөвгүүн Аргасун лав биш юм)-оор хааныг болгоохоор илгээж:

“Сал модонд салбар шонхор өндөглөмүй

Сааралгүй модондоо итгэн асаар,

Сар шувуунаар үүрээ эвдээд,

Сайхан өндөг зулзагаа идэгдмүй.

Хулст нуураа хун галуу өндөглөмүй,

Хулсаа сүүдэр ирж итгэн асаар,

Хулд шувуунаа өндөг зулзагаа идэгдмүй.

Хутагт эзэн минь айлдтугай”

гэж хэлүүлжээ. Чингис: “Сэрүүлэн (анхааруулан – хө.) өгүүлэх энэ үг зөв буюу” гэж их аянаасаа буцаж ирсэн гэлээ. Ингээд Мухулайг томилж, Хулан хатныг авсан учрыг тодорхойлуулжээ.

Энэ үед Бөртэ үжиний хариулсан нь:

“Хатан Бөртэ жүшин (үжин)-ий дур буюу,

Харалмай их улсын зориг буюу,

Хаан эзний минь хүч буй за.

Ханилан нөхцсөнөө эзэн мэдмүй зэ.

Хулст нуураа хун галуу олон буй за,

Хуруугаа чилтэл харвахуйг эзэн мэдмүй зэ,

Хотол улсад охид эмс олон буй за,

Хувьтан хишигтнийг нь эзэн мэдмүй зэ.

Эм хүн дээрээ гэр автугай хэмээмү,

Эмнэг морь нуруундаа эмээл тохтугай хэмээмү,

Эртний үлгэрт эс мэнд илүүд сайн үгүй,

Эмгэг зовлон дутууд муу үгүй гэлээ,

Эзэн хааны алтан оосор баг болтугай,

Эхнэр хүн манаа юун хэмээвэй”

гэжээ. Ингээд эзэн маш зөвшөөрч алтан ордондоо буув гэдэг билээ.

Энэ нь хэдийгээр нэлээд уран дүрслэхүй аргаар бичсэн домгийн шинжтэй тэмдэглэл боловч, Бөртэ үжиний сэцэн мэргэн ба Чингист цаг ямагт сэрэмж сануулга болж байсныг харуулж байна. Их хүмүүс “ялимгүй” явдалд бүдрэх, тэрчлэн төр улсаа алдах явдал ч эрт өдгөөд цөөнгүй байсан юм. Энэ талаар эрх сүртний туйл болсон Чингис хааныг хүртэл хянамжлуулж бодуулсан нь үнэхээр мэргэн Бөртэ-гийн гавьяа билээ.

(4) Хэрэйдийн Ван хан болон Чингис хаан хоёр хамаг эцэс дайсагнасан явдал нь, Ван ханы охин Чагур бэхи-г Жочи-д гуйсан явдлаар илэрдэг билээ. Хэрэг дээрээ энэ нь хоёр этгээдэд авч хэлбэл бүр ил шалтаг болгосон явдал болно. Гэвч энэ нь учир явдлын мөн чанарыг илчлэх буюу далдлахад дайсагнагч этгээдийн байнга хэрэглэгэдэг арга юм.

Березиний мэдээлснээс үзэхүл, Ван хан, ялангуяа түүний хөвгүүн Нилха Сэнгүмийн Жамуха нартай сүлбээлдэж байсан өрнөдийн аюулыг юуны урьд Бөртэ үжин сэрж мэдсэн гээг, ингээд “Тэмүжин Бөртэ үжин хоёр урт цагаар ярилцсаны дүнд, Ван ханы дэргэд элч томилж, Чагур бэхи-г нь хөвгүүн Жочи-доо гуйлгав”. Энэ бол Ван ханы оврыг тэнссэн явдал болно. Сүүлд нь “багалзуур ид” гэсэн хуувилдлагыг нь илчилсэн нь Мүнлиг биш(Мүнлиг гэсэн нь “Нууц товчоон”-ы тэмдэглэл болно), харин Өгэлүн эх байлаа гэж Березин тэмдэглэжээ. Түүний тэмдэглэсэн нь: “Тэмүжиний дайсан бүр тэнд цугларан байх биш үү? Юуны чинь “багалзуур идүүлэх” буй? Энэ бол Өгэлүн эхийн хэлсэн үг юм. Өгэлүн үжин, тэрслүү ажиллагааг нэвгэртэл сайн мэддэг урт хугацааны туршлагатай тул заль мэхийг ер итгэдэггүй билээ. Тал нутагт өөрийн дайсагнагч этгээдээ устгахын тулд хор идүүлэх буюу хуримын ширээний доор нүх малтаж алах мэт хэрцгий аргыг хэрэглэдгийг Өгэлүн эх сайн мэддэг байна. Тэр одоо нэлээд ер бусын явдлуудыг ажиж сэрээд тийм үгийг хэлжээ. Ингээд Тэмүжин аргаа өөрчилж хагас замаасаа буцсан юм” гэжээ. Тиймээс сая Ван хан нарын ов мэхийг тууштай илчилж чаджээ. Мүнлигийн бүх ажиллагаанаас үзэхүл, түүнд тийм их мэргэн

бодлого байгаагүй тул тэр удаагийн аргыг Өгэлүн эх дурдлаа гэдэг нь нэлээд зүйтэй байна. Нэгэн хэргийг үл салгахын тул Өгэлүн эхийн учрыг энд тэмдэглэв.

(5) “Эрдэнийн товч”-ийн мэдээнээс үзэхүл, 1206 оноо Чингис хаан Их Монгол хаант улсыг тунхаглан байгуулж түмний манлай, төрийн зүтгэлтэн нарыг шагнахад, олноос онцгой зүтгэлтэй Боорчу-гийн гавьяаг дурдсангүй өнгөрсөнд бас сэцэн хатан Бөртэ үжин нь сануулсан гэдэг. Хэрэг дээрээ энэ явдлаар дамжиж, Чингис хааны холын бодлого, Бөртэ үжиний мэргэн ухаан, хүлэг Боорчу-гийн үнэнч сэтгэлийг нь харуулжээ. Зүтгэлтэй гавьяатанаа мартаж үл болох их ёсыг Бөртэ үжин сайн мэддэг байжээ.

(6) Бөртэ үжиний бас нэгэн гарамгай мэргэн бодлого гэвэл, бүх улсын ялалтыг олсон хойно, Мүнлиг эцгийн хөвгүүн Дэв тэнгэр (Хөхэчү) мэтийн шашны нөмөргөөр халхалсан дотоодод нуугдаж байсан аюулт дайсныг илчилсэн явдал болно. Бодтой учрыг нь тус товчооны зургадугаар бүлэгт тусгай сэдвээр танилцуулах болно.

Бэлгүтэй, Отчигины мэргэн бодлого нь Наймантай байлдахад товойн илэрч байжээ. Ялангуяа Чингис хаан 1219 онд Хорезмыг дайлаар морилоход Отчигин ноёныг их ордондоо үлдээж, хаант улсын засгийг түр захируулж байв.

Үүнээс гадна, татвар хатдын дотроос Есүй хатан бас дотоод зөвлөгөөнд оролцож, их бодлогыг дурдаж байжээ. Жишээлбэл, Чингис хаан баруунш Хорезмыг дайлахаас өмнө хаан орыг залгамжлах хүнийг тогтоох явдлыг Есүй хатан анх дурдан:

“Өндөр давааг давж

Өргөн мөрнийг гэтэлж

Урт аянд морилохдоо

Улс иргэнээ захирахыг

Урьтал болгож сэтгэмүй.

...

Уул мэт бие чинь

Нурж одвоос

Улс олон Монголыг чинь

Хэн захирах юм бэ?

...

Төрсөн дөрвөн хүүгээс чинь

Төрийг барих нь хэн буй?”

гэж хэлсэнд, Чингис хаан: “Хатан хүн боловч Есүйн үг зөвөөс зөв!” гэжээ. Ингээд дотоод зөвлөгөөнийг хийж Өгөөдэйг залгамжлагчаар тогтоосон юм. Дараа нь 1226 онд Чингис хаан Тангуд улс (баруун Ся улс)-тай эцсийн удаа байлдахаар явахад Есүй хатныг дагуулан явжээ. Энэ удаа Тангудыг дайлах замдаа Чингис хаан ав хийж байгаад мориноосоо унаж, бие нь маш их чилээрхсэнд, Есүй хатан хөвгүүд, ноёд нарыг хуралдуулж, хэрхэн шийдвэрлэхийг зөвлөж байв. Эдгээрээс үзэхүл, сүүлчийн үед Есүй хатны санал чухал байрыг эзэлж байсныг харуулж байна.

Чингис хааны “бодлогоч бүлгэм”-д нь оролцож байсан сайд түшмэдийг хэлбэл, цэрэг дайны талаар хэлэлгээнгүй Боорчу, Мухулай түрүүтэй дөрвөн хүлэг, дөрвөн хошууч буюу есөн өрлөгүүд нь оролцож байжээ. Бас зургаан чэрби нар ба Өгэлүн эхийн тэжээсэн дөрвөн хөвгүүн ч төрийн их хэрэгт нь идэвхтэй оролцож байжээ. Усун, Хунан, Хөхөчүс, Тахи дөрөв бол сонссон бодсоноо даран далдлалгүй хаанд хэлдэг гэдэг тул эд ч мөн төрийн зөвлөлд нь оролцох ёстой. Чингис хаан доорхи хүмүүсийнхээ саналыг сонсдог нэгэн товойсон жишээ гэвэл, 1204 онд Наймантай байлдахуйд Чингисийн их цэрэг Саарь хээр гэдэг газар хүрч буугаад, байлдааныг хэрхэн хийх тухай байлдааны талбайн зөвлөгөөн хийжээ. Энэ үед Дөдэй чэрби: “Бидний цэрэг цөөн бөгөөд замд чилж ядрав. Иймийн тул энд баахан саатаж, агтаа цаггая. Саарь хээрийг дэлгэн бууж амьд хүн тутам эр бүр шөнө таван анги галыг түлж галаар сүр бадруулъя. Найман нар олон хэмээхүй. Гэвч тэдний хаан нь гэрээс гарч үзээгүй танхи хүн хэмээмүй. Бид галаар сүрдүүлэн тэднийг гөлрүүлж байх завсраа бидний агт цадах буй за. Агтаа амрааж цадмагц, Найманы харуулыг дайрч гол хүчинд нь хүртэл хөөж оруулаад тэдний самгардах самбаанд байлдаж орвоос болох уу?” гэж дурдан айлтгажээ. Үүнийг Чингис хаан бүрмөсөн зөвшөөрч, чингэж хийснээс маш их бүтэмжийг олон Найманыг мөхөөжээ. Чингис хаан бас олны саналын зүйтэй, зүй үгүйг ялган тодорхойлж, адил бусаар ханддаг байна. Жишээлбэл дээр дурдсан Тангуд улсыг дайлах зам зуур Есүй хатны эрхлэн хуралдуулсан хөвгүүд, ноёдын тэр хуралдаан дээр, Мүнлиг эцгийн хөвгүүн Толун чэрби: “Тангуд иргэн ... байран (суурин – хө.) нутаг, Шавар хотоо хаяж тэд хаа очих буй. Бид буцаж хааны биеийг сайжруулан, жич дахин байлдахаар мордоё!” гэж хэлсэнд хөвгүүд, ноёд цөмөөр түүний үгийг зөвшөөрч байв. Гэвч Чингис хаан энэ саналыг зөвшөөрөхгүй байж: “Тангуд иргэн, биднийг зүрх шантарч буцав гэх болно. Бид элчийг илгээж, мөн элчийг иртэл энд Чугурхадад биеэ сувилж байгаад Тангудын хэлэх үгийг сонсч буцваас болмуй” гэж хэлжээ. Чингисийн энэ үзэлт нь бүр зөв байв. Гэвч тэр өөрийн биеийн эрүүл мэндийг бодсонгүй тул мөн энэ удаагийн байлдаанд нас барсан билээ.

Чингисийн “Бодлогоч бүлгэм” нь бас тасраагүйгээр төгөлдөржиж байсан юм. Найманы Таян ханы тамган сайд байсан уйгур бичгийн хүн Тататунгаа, Алтан улсын сургалтан Хятан хүн Елюй Чусай, Елюй Ахай нар ч бүр Хаант Монгол Улсын төрийн тулгуур бодлогоч түшмэд байсан байна.

Тататунгаа бол уйгур үндэстэн. Тэр төрөлх сэцэн сэргэлэн, үг ярианд сайн, тус улсынхаа үсэг бичгийг нэвтэрхий сайн мэддэг гэлээ. Бодоход түрэг төрлийн хэлүүд, жич монгол хэлийг ч лав сайн мэдэх ёстой. Тэр 1204 оноос өмнө Найманы Таян ханы багш нь бөгөөд алтан тамгыг хамаардаг тамган түшмэл нь байжээ. Тэр чухам хэдийд ямар газар төрсөн, хэдийд Найманд

ирсэн зэрэг нь тодорхой мэдээгүй байсаар. 1204 онд Чингис хааны цэрэг Найманыг мөхөөсөн тэр үед, Таяны аймгийн нэг хүн дутаав. Хасар түүнийг амьдаар барь хэмээсэнд Бат гүйцээд амьдаар барин ирвэй, үзвээс өвөрт нь нэгэн тамга буй. Хасар өгүүлрүүн: “Танай олон аймаг цэрэг цөм маньг дагаж байхад, чи энэ юмыг өвөрлөж хааш одмуй?” хэмээвээс, тэр хүн өгүүлрүүн: “Миний бие тушаалын газраа үхтэл сахимуй. Энэ тамгыг хуучин эзэндээ хүргэж өгье хэмээсэн билээ. Аз дутаж баригдав” Хасар өгүүлрүүн: “Чи аль овгийн хүн, ямар тушаалтай байсан буй?” Тэр хүн өгүүлрүүн: “Би язгуураас Уйгур газрын хүн, нэр Тататунгаа. Миний эзэн энэ тамгыг над тушааж, идшийг гаргах ба оруулах явдлыг над тушаасан билээ”. Хасар бас асууруун: “Энэ тамгыг юунд хэрэглэмүй?” Тататунгаа өгүүлрүүн: “Сайн хүнийг сонгож зарлиг бичиг явуулах аливаа үйлст хэрэглэмүй” хэмээвээс, Хасар сайшааж, шударга элбэрэлт хүн хэмээн Тэмүжинд мэдүүлж, аливаа бичиг явуулахад хэрэглэхээр тэр тамгыг мөн хүү Тататунгаа-д тушаав. Хасар, Тататунгаа-г багш барин бичиг хууль, цэргийн бодлого түрүүтэн олон зүйл бичиг утга заалгаж удалгүй сурвай (Ц.Дамдинсүрэнгийн одоочилсон “Нууц товчоон”-ы 196 дугаар зүйлээс дам эшлэв). Энэ бол “Лу. Алтан товч”-ийн мэдээ болно. Энэ тухай “Болор эрих” гэдэг сударт бас их төлөв “Лу. Алтан товч” лугаа адил тэмдэглэж буй. Энэ нь “Лу. Алтан товч”-ийг үндэслэсэн нь нэлээд тодорхой байна.

Гэвч “Юань улсын түүх”-ийн 124 дүгээр боть “Тататунгаа-гийн намтар”-ын тэмдэглэлээс үзэхүл Тататунгаа-г барьж аваад, түүнтэй ярилцсан нь Хасар биш, харин Чингис хаан биеэрээ ярилцсан гэж тэмдэглэж байх бөгөөд агуулга нь үндсэндээ адил байна. Баахан адилгүй зүйлийг доор нөхвөрлөө: “Тамгыг юунд хэрэглэмүй” хэмээн асуухуйд, хариу өгүүлрүүн: “Цалин хүнсийг хураан түгээх, чадвартныг тушаалд томилох ба аливаа явдал бүхэнд хэрэглэж үнэмлэхүй тэмдэг болгомуй”. Хаан сайшааж, дэргэдээ байтугай хэмээн зарлиг болов. Түүнээс хойш зарлиг нийтлэх бүр тамгыг эхлэн хэрэглэсэн бөгөөд Тататунгаа-гаар тамгыг хамааруулжээ. Бас уйгур үсгээр улсын үгийг бичүүлж, тайж ба олон ван нарыг сургав” гэдэг.

Өгөөдэй хаан их орыг залгамжласан хойно, Тататунгаа-гаар дотоод ордны хас тамга ба алт мөнгө эд барааг хамааруулахаар тушаажээ. Бас түүний гэргий уйгур овогтоор Өгөөдэй хааны хөвгүүн Карачарыг бойжуулан өсгөсөн тул хишгийг нэмэн хүртээсэн билээ. Тататунгаа хөвгүүдээ цуглуулж: “Хаан эзэн, эхээр чинь тайжийг бойжуулсан учраас хүнд хишгийг шагнасан билээ. Эс бөгөөс та нар хэрхэн хялбар хүртэх аж. Тиймээс юуны урьд тайжийн хэрэглэлийг хангаж, үлдвээс та нар хуваан хүртэж болмуй” гэж хэлжээ. Үүнийг Өгөөдэй хаан сонсч “Тататунгаа миний шагнасан хишгийг урьдаар тайжид өгсөн явдлаас түүний гоёч бусыг мэдэж болмуй” гэж хиа ноёддоо хэлсэн бөгөөд хишгийг хэд дахин нэмж шагнав гэдэг билээ. Сүүлд нь Тататунгаа өвчнөөр нас баржээ. Түүнийг нас барсан хойно, дөрвөн хөвгүүнийнх нь бага нь Сурухай гэгч эцгийнхээ тушаалыг шираж (залгамжилж – хө.), дотоод ордны хас тамга болон алт мөнгө эд барааг хамаарав гэдэг. Чжи Да-гийн гуравдугаар он (1310 он)-д Тататунгаа-г Чжун Фэн тайфу-гаар нэхэмжлэн өргөмжилсөн бөгөөд Янь Мэнь Цзюнь-ы гүн цолыг нэхэмжлэн өргөмжилжээ.

Чингис хаан Тататунгаа-г дотоод сайдаар хэрэглэсэн явдал нь монгол үндэстний бичиг соёлыг нэгтгэн хөгжүүлэхэд туйлын гүн гүнзгий ач холбогдолтой байсан юм.

Елюй Чусай (1190-1244), өргөсөн нэр Цзинь Цин, цол Кань Жаны-ий сул эрдэмтэн гэдэг,

Хятан үндэстэн. Ляо улсыг гардан байгуулагч Елюй Абаожи бол түүний есдүгээр үеийн дээдэс нь болно. Эцэг нь Алтан улсын баруун гарын эрхчин сайд байв. Елюй Чусай арван долоон нас хүрэхэд дэлхий дахины бичиг шастирыг нэвтгэртэл уншсан тул өргөн мэдлэг, холын бодлогыг бүрэлдүүлжээ. 1215 онд Чингис хаан Алтан улсын нийслэл Чжунду хот (одоогийн Бээжин)-ыг эзлэн авсны дараа, Елюй Чусайг элсэн уулзаад: “Хятан Жүрчин хоёр бол эртээс өшөөтөн улс юм. Өдгөө хаан би чиний өшөөг цагаатгав” гэсэнд: “Түшмэл миний өвөг эцгээс нааш цөм Алтан хааны хишгийг хүртэж, төрд үйлчилж байсан тул түшмэд бологсод хэрхэн эзнээ өшөөлж болох аж” гэж Елюй Чусай хариу айлтгасан гэлээ. Чингис хаан үүнийг нь сонсч, шударга сайд гэж сайшаан, дэргэдээ зөвлөгчөөр үлдээжээ. Елюй Чусайн биеийн өндөр найман тохой, сахлын урт цээж буух тул Чингис хаан нэрээр нь дууддаггүй. Харин “урт сахалт” гэж дууддаг гэлээ. 1219 онд Чингис хаан Хорезмыг дайлахад Елюй Чусайг дагуулан явсан бөгөөд олон зүйлийн учрыг асууж сурчээ. Елюй Чусай газар зүй, одон орны судлал ба зурхайн ухааныг нэвтэрхий мэддэг тул хэдийд наран саран хиртэхийг бүр урьдчилан мэддэг байна. Чингис хаан цэрэг мордох бүр Елюй Чусайгаар төлгө бариулдаг гэлээ. Чингис хаан Тангуд улсыг дайлахад Елюй Чусай бас дагалдан явжээ. 1226 оны өвөл Монголын их цэрэг Түрэмгий балгасыг эзэлсний дараа, олон ноёд жанжин нь алт мөнгө, эд барааг нь олзолж байхад Елюй Чусай харин хэдэн хайрцаг хаягдсан бичиг судар ба хоёр ачаа гишүүний үндсийг хураан авсан байжээ. Удалгүй цэргийн дотор хижиг өвчин тархсанд энэ гишүүний үндсээр эмнэж, хэдэн түмэн хүний амийг аварсан гэлээ.

Чингис хаан нас барсны хойно, Тулуй эзэн төрийг захирч байсан үе 1227 онд Яньцзин (өнөөгийн Бээжин) хотноо хулгай дээрэм дэгдэв. Зальхай ноёдын хүүхэд дүү нар сүлбээлдэж, гэгээн цагаан өдрөөр тэрэг гэлин (тэрэг хөтлөх - хө.) гарч ирээд иргэдийг дээрэмдэн, алж шулдаг боловч хэн ч айн халдаж чадахгүй байв. Үүнийг төвшитгөх ажлыг Елюй Чусайд тушаажээ. Тэр очоод эрх сүрээс айсангүй, хээл хахуульд унасангүй, төв голч засаглаж, зальхай түрүү арван зургаан хүнийг цаазаар шийтгэж, хортныг арилган, нийгмийг амаржуулав.

Өгөөдэй Их Монгол Улсын Далайн хааны орыг залгамжилсны хойно, тэр төв бичгийн яамны сайдаар томилогдож, төр гүрнийг засах, ард иргэдийг амаржуулах, аж ахуй соёл боловсролыг хөгжүүлэх талаар гарамгай үйлдэл үзүүлжээ. Чингис хаан нас барахаас өмнө, Елюй Чусайг зааж: “Энэ хүнийг тэнгэрээс манд соёрхов, хожим төр улс, ард иргэд, цэрэг засгийн явдалд томилон хэрэглэвээс зохимуй” гэж Өгөөдэй хөвгүүндээ зарлиг болсон гэдэг билээ.

Өгөөдэй хааны үед Елюй Чусай нэн их гавьяа зүтгэл гаргажээ. Елюй Чусайн сүүлч үеийн үйлдлээс Чингис хааны эрдэмтнийг тольдогч алс хэтийн мэргэн бодлогыг нэн тодорхой мэдэж болно. Елюй Чусай Монголын төрд гарамгай зүтгэл гаргасан учраас 1236 оны цагаан сар олон ван сайд түшмэдийг хуралдуулж, “Түмэн амгалант ордон”-ыг цогцолсон их хурим тавихад, Өгөөдэй хаан Елюй Чусайд хэм барьж: “Хаан би сайдыг түшмэл өргөсөн явдал болбоос эцэг хаан Чингисийн зарлиг болой. Түшмэл үгүй аваас төр улсын энэ өдөр үгүй болой. Хаан миний биеийн амгалан ахуй ч түшмэлийн гавьяа болой” гэж сайшаажээ. 1241 онд Өгөөдэй хаан нас барж, Наймжин хатан засаг барьж бүхийд, хөх луу жил (1244 он)-ийн зуны дунд сарын арван дөрөвний өдөр, Елюй Чусай тавин таван настайдаа Хар Хорум хотод нас баржээ.

Елюй Чусайн мэргэн бодлогыг тусгасан ийм нэгэн үлгэр байдаг сан: Чингис хааны захад нум үйлдэх мэргэжилтэй Чэмбэхин гэгч тангуд дархан байсан гэлээ. Тэр, нэгэн өдөр Елюй Чусайд: “Тус улс зэр зэвсгийг эрхэмлэх атал, мэргэн сайд утга уянгыг эрхэмлэх бодлогыг дурдах нь түшээ эс болох ажгуу?” гэж хэлсэнд, Елюй Чусай: “Нумыг үйлдэхүйд нумын дархан хэрэгтэй атал, дэлхий дахиныг засахүйд дэлхий дахиныг засагч дарханыг үл хэрэглэх ёс буй ажгуу?” (“Чо Гэнь Лу бичиг”, хоёрдугаар боть) гэж хэлсэн гэлээ. Энэхүү “дэлхий дахиныг засагч дархан” гэдэг үг бол Елюй Чусайн мэргэн ухаан, арга бодлогыг тусгажээ.

Елюй Ахай бол Хятан үндэстэн. Түүний өвөг Сабар гэгч Алтан улсад үйлчилж, Хуаньчжоугийн захирагчаар томилогдож, гэрээрээ тэнд нутаглаж байжээ. Эцэг нь Түдэр гэдэг, Алтан улсын бичгийн яаманд хэрэг эрхэлж байжээ. Ахай бага наснаасаа уналга намналгад дадамгай бөгөөд умардын эл үндэстний хэлийг сайн мэддэг гэлээ. Ингээд Алтан улсын Чжанцзун хааны үед Хэрэйдэд элчилж очоод, тэнд Чингис хаантай танилцлаа гэдэг билээ. Чингис хаан бол ер бусын хүн гэгчийг тэр, байдлаас нь үзэж мэдээд нөхөр бололцохоор шийдсэн бөгөөд Алтан улсын хилийн хамгаалал нь сул задгай, төр ёс нь доройтсон тул мөхөхийн эрмэгт хүрээд буй гэж хэлжээ. Чингис хаан түүнийг сонсч машид баярлан, чи хэрвээ надад үйлчлэх болбоос юунаар итгэмж болгох буй? гэсэнд, дуртайяа төрсөн дүүгээрээ барьцаа болгосугай гэж Ахай хэлсэн бөгөөд дараа жилд нь ирэхдээ түүний төрсөн дүү Елюй Тохуаг дагуулан ирж барьцаа болгон хааны турхагаар үлдээжээ. “Муу өндөрийн байлдаан”-ы дараа ах дүү хоёул “Балжуна-гийн тангараг”-т оролцлоо гэдэг. Чингис хаан Хэрэйдийг мөхөөсний хойно, Ахай удтал улстаа буцаж харьсангүй тул Алтан улсын хаан нь сэжиглэж, түүний гэр бүлийг нь барьж хорьжээ (хожим нь Чингис хаан 1214 онд Алтан улс лугаа эвслийн гэрээ тогтоох үед сая тавин буцаалаа гэдэг). Гэтэл Ахай мөн сэтгэл хувиралгүйгээр Чингис хаанд үйлчилж байжээ. Чингис хаан үүнийг нь сонсоод нэгэн эрхэм түшмэлийн охиныг гэргий болгон өгчээ.

Елюй Ахай олон үндэстний хэл мэддэг тул Чингис хааны гадаад явдлынхи нь зөвлөгч байсан нь дамжиггүй гэж Ли Цзэ Фэнь авгай үзэж байсан нь зүйтэй юм (“Чингис хааны шинэ намтар”, арван дөрөвдүгээр бүлэг). Ялангуяа Елюй Ахай ах дүү хоёр Алтан улсын дотоод байдлыг тодорхой ойлгож байсан тул, Чингис хааны Алтан улсын байдлыг ойлгох ба Алтан улсыг дайлах шийдвэр бодлогыг тогтоох нь энэ хоёр хүний зөвлөгөөн ба нөлөө дутаж болшгүй гэдэг нь илэрхий хэрэг юм.

Түүнчлэн Чингис хаан Алтан улсыг дайлахад Ахай ах дүү хоёул хааныг дагалцан дайнд оролцжээ. 1215 онд монгол цэрэг Алтан улсын нийслэл Чжунду-г эзэлсний дараа, тэр хоёрын гавьяа зүтгэлээр нь Елюй Ахай-д тайш цолыг, Елюй Тохуа-д тайфү цолыг тус тус шагнасан бөгөөд төрийн гүнгээр өргөмжилжээ.

1219 онд Чингис хаан Дундад Азийг дайлах үед Елюй Ахай хааныг дагаж дайнд оролцсон бөгөөд Самаркандыг эзэлсний дараа хааны зарлигаар Самарканд хотыг захирч байв. Монголын их цэрэг улстаа буцах үед түүнийг баруун орны ерөнхий даргачаар томилжээ. Түүний дүү Елюй Тохуа нь Дундад улсын умар дахины хятад цэргийг захирч, Мухулайн захиргааны доор Алтан улсыг залгалдаагаар дайлсан бөгөөд юаньшуай (цэргийн их удирдах цол – хө.) цолоор өргөмжлөгдөж, Сюань Дэ хот (одоогийн Хэбэй мужийн Сюаньхуа хот)-д сууж байв. Өгөөдэй Монголын хааны их орыг залгамжласны хойно, Тулуйн захиргаан доор Алтан улсыг дайлж мөхөөжээ.

Дээр дурдсан хүмүүс бол Чингис хааны “бодлогоч бүлгэм”-ийнх нь голлогч хүмүүс болж байсан бөгөөд байнгын чанартай бүрэлдэхүүн нь болно.

Чингис хаанд бас нэг бүлэг гадаад харилцааны зөвлөгчид байдаг гэж зарим хүмүүс үзэж байжээ. Үүнд дээр дурдсан хүмүүсээс гадна Жабар Хорчи, Арачан (энэ хоёр нэрийг хэрэг дээрээ нэг хүн гэж Ту Цзи үзжээ, гэтэл Ван Го Вэй, Ли Цзэ Фэнь нар хоёр хүн гэж үзжээ) хоёрыг бас мөн гэж Ли Цзэ Фэнь авгай тэмдэглэжээ. Энэ санал бол зүйтэй бөгөөд Архай Хасар, Лю Чжун Лу нарыг ч тоочиж болох мэт.

Үүнээс гадна, бас нэг бүлэг анхаарууштай хүмүүс гэвэл, “Нууц товчоон”-ы 182 дугаар зүйлд дурдсан Сартуулын баян худалдаачин Асан (энэ Асан бол дээр дурдсан Арачан мөн гэж Ту Цзи үзжээ) мэтийн хүмүүс болно. Березиний тэмдэглэлээс үзэхүл, ийм худалдаачин нь Асан ганц хүн биш, харин бүх Дундад улс ба бүх Дундад Азийн хоорондохи арилжааг ноёрхож байсан олон арвин том том худалдаачны бүлгэмүүд болно. Эдгээр худалдаачид нь эл улсын байдлыг, ялангуяа Алтан улс, Тангуд улс ба Хорезм улсын байдлыг нарийн мэддэг байна. Эдгээр худалдаачид нь Онгуд, Хонгирад, Хэрэйд, Найман зэрэг монгол аймгуудаар дамжиж явдаг байжээ. 1206 оноос хойш тэд хаашаа явсан ч бүр Хаант Монгол Улсаар дайрч явах болжээ.

Эдгээр худалдаачдын өргөн мэдлэг ба арилжаа наймаа хийх уран арга нь Чингис хааны сонирхлыг ихэд татсан тул тэдэн лүгээ уйдалгүй ярилцдаг гэлээ. Ингээд хөрш улсын дотоод байдал - нутаг орны хэмжээ, хот балгас, суугуул ард, зам нэвтрэлгэ, гаралт үйлдвэрлэл, зан ааль, эд эрдэнэ, сонин гайхамшиг зүйл, ялангуяа цэрэг зэвсэг мэтийн улсын хамгаалалтын хүчийг нь ойлгон мэджээ. Эдгээр нь Чингис хааны гадагш дайлах дайнд нь дутагдаж болшгүй өөр чухал мэдээ болох юм. Хэлэлгээнгүй, элч томилох аргаар ба нөгөө этгээдээс орж өгсөн буюу олзолсон хүмүүсээс бас энэ талын мэдээг олдог байжээ.

Багцлаад хэлбэл, Чингисийн “бодлогоч бүлгэм” нь түүний төмөр морьт цэргийн дайны талбайд гаргаж үл чадах үйлдлийг гаргадаг нь дамжиггүй билээ.

43. “Чингисийн их засаг” Хаант Монгол Улсын хууль

“Монголчуудад хууль дүрэм үгүй” гэдэг яриа бол монгол үндэстний түүхэн байдлыг мэддэггүй хүмүүсийн дур таавын яриа ба цөөн тоот үндэстнийг зэрлэг хөдхи гэж доромжилдог “лооеэ” (ноён гэсэн хятад үг - хө.) нарын чалчаа болно. Түүх шастирыг хянан үзэхүл, монгол үндэстэн нэлээд эртнээс хууль дүрэмтэй байжээ. Татаж хэлэхэд Монголын эл аймгуудад Хабул хаан мэтийн аймгийн ноёрхол бүрэлдсэн үеэс “дарангуйлах засаг”-ийн гол хэлбэр буюу багаж болсон хууль дүрэм буй болсон ёстой. Хэлэлгээнгүй, тэр үеийн хууль дүрэм нь анхны шатан дахи балас чанартай байсан нь ч мэдээжийн хэрэг ээ. Тэр үеийн хууль цааз бол голдуу эрүүгийн хуулийн хэлбэрээр илэрдэг байна. Монголын эрүүгийн хууль бол ард иргэдийн эсэргүүцлийг дарангуйлах ба дайсан этгээдээ дарангуйлах багаж болж байжээ. Тэмүжин бага насандаа Тайчигудад баригдаж, хүнд сүрхий эрүүгээр шийтгэгдэж байсан биш үү?

Чингисийн үе болоход энэхүү эрүүгийн хууль нь улам тодорхой бөгөөд төгөлдөр болсон байна. Өөрөөр хэлбэл, Чингис хаан шинэхэн байгуулсан Монголын хаант улсыг бэхжүүлэхийн

төлөө, өөрийн улс төрийн ноёрхлоо багатгахын төлөө, нийгмийн ёс дэглэмийг тогтоож, энэхүү төрөлх “асвар, зэрлэг, дүрэм ёсгүй” нүүдэлчин үндэстнээ хуулиар засахын төлөө Монголын ёс дүрмийн их товчоог тогтоож, үсэг бичгээр анх удаа тэмдэглэсэн хууль цаазын бичиг - “Их засаг”-ийг байгуулан, бүх улсын заргач түшмэлийг томилжээ. Жишээлбэл, энэ үед занчих, цөлөх, хорих, алах ба ураг угсаагаар нь сөнөөх (хүйс тэмтрэх) мэтийн эрүүгийн хуулийг хэрэгжүүлж байв. Ялангуяа алах хууль бол зөндөө байдаг.

Энэ тухай персийн алдарт түүхч Джувейни түүний зохиосон “Дэлхийг дайлан дагуулагчдын түүх” гэдэг зохиолдоо: “(Чингис хааны) өөрийнх нь бодлогоор бол янз бүрийн газар, янз бүрийн байдалд тохируулан тус бүр засаг тогтоож, бас янз бүрийн ялт ажиллагаанд тус бүр нэгэн цааз тогтоохыг зорьдог байна. Гэвч Татар хүн (Монголчуудыг хэлж буй - эшлэгч) өөртөө үсэг бичиг үгүй тул монгол хүүхдээ уйгуржин бичгийг сургахаар зарлиг буулгасан бөгөөд холбогдол бүхий засаг ба хууль зарлигийг хуйлааст бичүүлдэг, эдгээр хуйлаасыг “Их засгийн бичиг” гэдэг бөгөөд түрүү вангийн санд хадгалж байдаг. Шинэ хаан их ор залгамжлах (зурагт нүүр дэх зураг - 49-ийг лавлаарай), их цэргийг хөдөлгөх буюу олон ван нар хуралдай хийж төрийн хэргийг зөвлөх ба хурал чуулган хийх үед, эдгээр хуйлаасыг гаргаж, түүний дотор тэмдэглэсэн ёсоор гүйцэтгэдэг буюу түүний дотор тогтоож байх аргаар цэргээ байрлуулж, хот балгас ба муж аймгийг сөнөөдөг. Чингис хаан ноёрхсоныхоо эхээр Монголын эл аймгууд түүнд нэгдсэн үед, тэдгээр Монголын эл аймгуудын дотор зөвшөөрөгдсөн буюу явагдаж байсан хөдхи бүдүүлэг заншлыг эвдэж, онолын талаар үзсэн ч сайшаагууштай хууль дүрмийг тогтоожээ” гэж тэмдэглэв (“Дэлхийг дайлан дагуулагчдын түүх”, дээд дэвтэр, 28 нүүр).

Чингис хааны “Их засгийн бичиг” гэдэг нь их төлөв Чингис хааны сургаал үг, зар зарлиг, цэргийн сахилга, албан дүрэм зэргийг тэмдэглэн дэвтэрлэж уламжилсан зүйл болно. Энэ нь “Нууц товчоон”-ы 203 дугаар зүйлд тэмдэглэсэн лүгээ их төлөв нийцэж байна. Энэхүү хөндлөний тэмдэглэлээс бид “Нууц товчоон”-ы тэмдэглэлийн олонхи нь үнэн найдвартай гэдгийг бас мэдэж болно.

Чингис хааны “Их засаг” нь бичиглэсэн хууль цаазын хувьд чухам хэдийгээс буй болсон буй? гэвэл, хамгийн анхны хууль бол 1206 онд Чингис хаан их ор суух үед хуралдуулсан “хуралдай” дээр тунхагласан зүйл болох бөгөөдсүүлд нь 1210 он ба 1218 онд болсон хоёр удаагийн хуралдайгаар нөхвөрлөлөө гэж “Судрын чуулган” зэрэг номд дурдаж байдаг. Чингис хаан улс байгуулах үед Шигихутуху-т: “Гүр иргэний хувилсан хувийг, шийтгэсэн заргыг хөх дэвтэрт бичиж дэвтэрлэгтүн. Шигихутуху над лугаа зөвлөж, хөх бичиг цагаан цаасанд дэвтэрлэснийг ургийн ураг хүртэл хэн ч бүү өөрчлөтүгэй! Өөрчлөгсөдийг яллатугай” гэж зарлиг болсныг “Нууц товчоон”-д тэмдэглэж байдаг билээ. Тиймээс Шигихутуху-гийн тэмдэглэсэн зүйл нь Чингисийн “Их засаг”-ийн гол агуулга нь болох ёстой гэж эрдэмтдийн зөвлөн жишиж байдаг нь зүйтэй хэрэг юм. Жишээлбэл: Дундад улсын хятад үндэстний монголч эрдэмтэн Вэнь Ду Цзянь 1948 онд “Монгол ба Юань-ий үедийн хууль дүрмийн найруулал” гэсэн өгүүлэлийг нийтлүүлж, Чингис хаан хууль цаазтай байсныг нотолсон бөгөөд 1206 онд бичиглэсэн хуультай боллоо гэж үзжээ.

Гэвч энэ “Хөх дэвтэр”-т тэмдэглэсэн Чингисийн “Их засаг” нь бүрэн бүтэн агуулгаараа манай үе болтол хадгалагдаж чадсангүй. Түүний доторхи зарим зүйл нь “Монголын Нууц

товчоон” ба “Судрын чуулган”, “Дэлхийг дайлан дагуулагчдын түүх” зэрэг монгол, перс түүхчдийн зохиосон тулгар бичгүүдэд тэмдэглэгдэж байдаг бөгөөд сүүлчийн хүмүүсийн судалгааны гол баримт ч мөн эдгээр зүйлс болно. Хамгийн урьд эл ном судрын тэмдэглэлүүдийг эмхэтгэж, “Их засаг”-ийн бодтой агуулга гэж дурдсан хүн бол “Монгол ба Орос” гэсэн номын зохиогч Орнадский болно. Тэр гурван зүйлээр ангилжээ: (1) Ерөнхий хөтөлбөр; (2) Олон улсын харьцааны хууль; (3) Цэрэг, засаг ба засаг захиргааны хууль (үүнд эрүүгийн хууль, иргэний хууль, арилжааны хууль зэргийг багтаажээ) зэрэг болно. Энэ нь агуулгын талаар тун товч дөхөм байж, дэмий олон зүйл зурвас байдаггүй. “Их засаг”-ийг ангилсан дараа нэг хүн бол Ли Цзэ Фэнь авгай болно. Тэр нэлээд өргөн шиг хэмжээгээр эмхэтгэж, нийт найман бүлэг хуваан(хэдийгээр зурвас хуваасангүй боловч бараг дөчин нэгэн зурвасыг багтаажээ), Түүний зохиосон “Чингис хааны шинэ намтар” гэдэг номдоо нийтэлжээ. Тэр нь:

- (1) Ерөнхий хөтөлбөр;
- (2) Олон улсын харьцааны хууль;
- (3) Засгийн газар ба цэрэг ангийн тухай хууль;
- (4) Эрүүгийн хууль;
- (5) Цэргийн хууль;
- (6) Иргэний хууль;
- (7) Арилжааны хууль;
- (8) Энгийн хорио цааз зэрэг болно.

Би ч эл түүх шастирыг шүүн судалж, түрүүчийн эрдэмтдийн арга барилаар дууриал болгож, “Чингисийн их засаг” - Хаант Монгол Улсын хуулийн бодтой агуулгыг нийт зургаан бүлэг, арван хоёр зүйл, тавин дөрвөн зурвасаар хураангуйлав.

Бичиг үсгээр тэмдэглэсэн “Чингисийн их засаг” нь манай үе болтол бүтэн бүтнээрээ хадгалагдсангүй гэдгийг дээр нэгэнт тэмдэглэсэн билээ. Тиймээс энэ мэт төрөл хуваан эмхэтгэсэн зүйл бол зөвхөн уншигчдад баахан системтэй ойлголт өгье гэж зорьсноос биш, “Их засаг”-ийн уул хэлбэр ч ийм байлаа гэсэн явдал огт биш. Ялангуяа зохиогчийн мэдлэг мөхөс учраас сонгож авсан зүйлд оновчгүй агуулга байх буюу хураангуйлан эмхэтгэсэн нь зохисгүй газар лав байхыг энд онцгойлон тэмдэглэж, багш эрдэмтдийн засан залруулахыг хүсэж байна.

“Чингисийн их засаг” - Хаант Монгол Улсын хуулийг “Нууц товчоон”, “Биеэр дайлсан тэмдэглэл”, “Юань улсын түүх”, “Юань улсын түүхийн нөхвөр орчуулга”, “Дэлхийг дайлан дагуулагчдын түүх”, “Д’Оссоны Монголын түүх”, “Хар Татарын хэргийн тухай товч”, “Чингис хааны шинэ намтар”, Булрины зохиосон “Чингис хаан” зэрэг түүх шастираас хураангуйлан эмхэтгэв. Чухалтай цөөн хэдэн зурвасаас бусдыг нь нэг нэгээр ирлийг нь

тодорхойлсонгүйг хамтагтан тэмдэглэсүгэй.

“Чингисийн их засаг” - Хаант Монгол Улсын хуулийн эмхэтгэл нь доорхи мэт:

(Нэг) Ерөнхий хууль буюу үндсэн хууль

Хаант Монгол Улсын хууль цааз нь хэлэлгээнгүй юуны урьд феодал ноёрхогч ангийн ашиг сонирхлыг төлөөлж, тэдний ноёрхлыг бэхжүүлэн өргөтгөхөд зориулагдаж байсан бөгөөд феодал ноёрхогчийн халдашгүй төлөөлөгч хаан эзнийхээ зарлигаар хөтөлбөр болгох нь дамжиггүй. Иймээс Хаант Монгол Улсын дээд хуулийг түүний далайн хаан (их хаан)-ы тамга ба зарлигийн пайз 14-д сийлж бүхий тэдгээр агуулгаар төвлөрөнгүй жишээ болгож болох мэт.

1 дүгээр зурвас, “Мөнх тэнгэрийн хүчинд (дор) Их Монгол Улсын Далайн хааны зарлиг ил булха иргэнд (дор) хүрвээс биширтүгэй айтугай”(Монголын их хааны тамга, зураг-4)

2 дугаар зурвас, “Тэнгэрээс соёрхсон Чингис хааны зарлиг эргэлзээгүй” (Чингис хааны зарлигийн пайз, зураг - 6).

3 дугаар зурвас, Хөвгүүн нь эцгийн сургаалыг үл авагсад, дүү нар нь ахмадын ятгалыг үл сонсогсад, эр нь гэргийгээ сэжиглэж, гэргий нь эрээ эсэргүүцэгсэд, эрс нь гэрлээгүй гэргийгээ доромжилж, охин нь ураглаагүй эрээ гадуурчлагсад, ахас захас нь багачууд хүүхдээ үл хамааран, хүүхэд багачууд нь ахас захсынхаа хамаарлыг үл дагагсад, эрхэм ноёд ураг төрлөө дотночилж, үл таних хүмүүсийг гадуурхагсад, баян эрхэм гэрийнхэн хувийн хөрөнгөө нарийлж, албан эдийг хонжигсад эрх биш худал хуурмагийн замд орж, хулгай дээрэм болох бөгөөд өрх гэр доройтож, төр улс мөхөн, дайсны өмнө ялагдах болмуй. Эдгээр муу зүйлсийг хориглотугай хэмээн би чанга сэрэмжлүүлсүгэй, тэрчлэн ноёд түшмэд, цэрэг байлдагч жич хөтөч зарц хүртэл тус тусын тушаалаа гүйцэтгэн чадваас мөнх тэнгэрийн хүчинд их үйлс бүтэх ажгуу. Өвөл зундаа нүүдэллэн малжваас мал тарган идэш элбэг, цэрэг хүчирхэг болмуй. Тиймээс миний сургаалыг мянган онд хувиргалгүй, түмэн үедээ өөрчлөлгүй ургийн ургаараа мөрдөн журамлатугай (“Юань улсын түүхийн нөхвөр орчуулга”, нэгдүгээр боть).

(Хоёр) Хаан төрийн тухай хууль

4 дүгээр зурвас, Хаан орыг залгамжлахад эрхбиш эл аймгийн ахмад ба алтан ургийн “хуралдай”-гаар сонгох хэрэгтэй. Эл хаант улсын хаан ч мөн ийм байх ёстой (Ли Цзэ Фэнь-ий номоос эшлэв).

5 дугаар зурвас, Монгол хүмүүс түүний улсын эзэн ба эрхэм язгууртад, жишээлбэл хаан, хан, ноёдын нэрийн доор зөвхөн тушаал зэрэг нь нэмж дууддаг, өөр эрхэм хүндэт цол өргөдөггүй. Тэдгээрийн алтан ургийнхныг цөм уул нэрээр нь дуудмуй.

6 дугаар зурвас, Ноёд жил бүр хоёр удаа (зарим тэмдэглэлд нэг удаа гэх ч буй) цугларч, сургаал хүлээх хэрэгтэй бөгөөд буцаж хариад биеэр дүрэмлэн гүйцэтгэж захирснаа сайтар хамаарваас хамаг үйлс эеэр бүтмүй. Миний зарлигийг аман дээрээ дааж, алс далд зөрчиж, уснаа унасан чулуу, өвснөө гээсэн зэв мэт хөсөрдүүлэгсэд болбоос нийтийг захирч үл чадмуй.

7 дугаар зурвас, Аравтын даргын тушаалаа үл гүйцэтгэгчдийг огцруулж, арван хүний дотроос өөр нэгнийг сонгох хэрэгтэй. Аль нэгэн зарлиг захиаг буулгахад заавал гурван хүний хэлсэн адил байх хэрэгтэй. Тийм болбоос сая биелүүж болмуй. Гурван хүн хэмээгч өөрийн бие нэгэнд тооцогдмуй, өөрийн хэлсэн бусдын хэлсэн лүгээ, ялангуяа Мэргидийн яриа лугаа адилтгах хэрэгтэй. Эс бөгөөс зарлиг захиа буулгаж үл болмуй.

(Гурав) Цэрэг дайны тухай хууль

Хэдийгээр “Чингис хаан түүний төв голч ба энэрэл өршөөлөөрөө жанжин нарынхаа цаглашгүй хүрээллийг олсон” (“Чингис хааны хаант улсын түүх”) боловч, түүний байгуулсан Их Монгол Улс нь цэрэгжилсэн феодалын хаант улс болох тул “цэргийн хуулийг тун чанга явуулдаг” байна.

8 дугаар зурвас, Эр хүмүүс хорин нас (бас арван таван наснаас жаран нас гэх ч буй) хүрвээс цөм цэргийн алба хаах хэрэгтэй.

9 дүгээр зурвас, Мянгат, зуут, аравтын даргын хөвгүүдээс чийрэг бөгөөд чадвартадыг турхагаар сонгох хэрэгтэй.

10 дугаар зурвас, Авын ажиллагаагаар цэргийн сургуулийн суурь болгох хэрэгтэй бөгөөд төрийн дүрэм болгон тогтоох хэрэгтэй.

11 дүгээр зурвас, Дайны үед өтгөс залуус, эрхэм доод ялгалгүй байлдагч, хорчин, жадчин болж дайнд оролцох хэрэгтэй. ...Хүн бүрийн хэрэгсэх аливаа зэр зэвсэг ба унаа морь, ачаа хөсөгт хүртэл бүр аравт буюу зуутаар хувьтан өгөх хэрэгтэй бөгөөд цэрэг цуглааж шалган үзэх тэр өдөр, цэргийн хэрэгсэл бүгдээ авч гарах хэрэгтэй. Хэрвээ бага л дутаж эвдэрсэн аваас хариуцах хүнийг хүндээр яллах хэрэгтэй.

12 дугаар зурвас, Жанжин захирагчаас жирийн цэрэг хүртэл, дайсангүй ч дайны бэлтгэлийг хийх хэрэгтэй. Зарлиг буумагц даруй түргэн мордох хэрэгтэй. Бачим цуглах зарлиг буусан үед, жишээлбэл аль аль мянган энэ оройдоо буюу энэ оройн хэдий цагт ямар газар очиж цугла гэвэл, тэд өчүүхэн ч саатаж болохгүй бөгөөд урьдчилан хүрч ч болохгүй.

13 дугаар зурвас, Зарлиг захиаг цаглашгүй гүйцэтгэх хэрэгтэй. Жишээлбэл, арван түмэн цэргийн захирагч, хааны байх газраас наран гарахаас наран шингэхийн хоорондохи зайтай хол боловч, тэр хэрвээ осол алдаа гаргаваас хаан харин нэгэлхэн морьт цэрэг томилж тогтоол ёсоор шийтгэж чаддаг. Тухайлбал, толгойг нь цавчих ёстой бол толгойг нь цавчиж, алт мөнгийг нь хураах ёстой бол түүний бие дээрх алт мөнгийг нь хураан авдаг.

14 дүгээр зурвас, Хүмүүс өөрийн тогтсон зуу, мянга буюу аравны харьяанд л байж болохоос биш, өөр нэгжид шилжиж болохгүй, өөр газар очиж далдалж болохгүй. Тус зарлигийг зөрчиж шилжигсдийг цэргийн өмнө алах ялаар шийтгэж, хураан авагсадыг хүндээр шийтгэмүй.

15 дугаар зурвас, Байлдагчид байлдааны талбай дээр шархдагсадаа хамгаалалгүй орхиж огт болохгүй. Байлдаан явагдаж бүхийд цэргийн туг буухаас урьд хэн ч байлдааны талбайгаас салж болохгүй.

16 дугаар зурвас, Дайсныг дарсан хойно, олзлонд бүү хорогдон саат, байлдаан дууссан хойно хуваалцах хэрэгтэй.

17 дугаар зурвас, Урван тэрслэх буюу байлдааны талбараас дутаагсадыг алах ялаар шийтгэмүй.

18 дугаар зурвас, Зарлиг зааваргүйгээр эвдлэн шатаах буюу олзлогсодыг тааваараа шийдвэрлэгчдийг алах ялаар шийтгэмүй.

19 дүгээр зурвас, Байлдааны талбар дээр нөхдийнхөө унааг буюу байлдааны олзыг хулгайлагчдыг бас алах ялаар шийтгэмүй (Дээрх гурван зурвасыг “Чингис хааны хаант улсын түүх” гэдэг номоос эшлэв).

20 дугаар зурвас, Хэрвээ дийлэгдэн ухарвал, эхний довтолсон байрандаа буцаж ирэх хэрэгтэй. Өөрийн байрандаа үл буцаж ирэгсдийг алах ялаар шийтгэмүй.

21 дүгээр зурвас, Цэргийг даган явж бүхий бүсгүйчүүдийн эрс нь байлдаанд орвоос, тэдгээр бүсгүйчүүд эрсийнхээ ажлыг орлон хийж, алба тушаалыг нь гүйцэтгэх хэрэгтэй.

(Дөрөв) Ард иргэдийн хууль

22 дугаар зурвас, Хүн бүрийн ажил эрх тэгш, баян ядуу ба эрхэм доордоор ялгаж үл болмуй.

23 дугаар зурвас, Өтгөсийг хүндэлж, ядуучуудыг тэтгэх хэрэгтэй. Богд мэргэд ба бясалгагчдыг хүндлэх хэрэгтэй.

24 дүгээр зурвас, Үл харгис, үнэнч шударга, чигч журамтай, эрдэм гүн, билиг хурц хүмүүсийг эрхбиш сайшаан хүндлэх хэрэгтэй бөгөөд зусар харгис ба элбэрэл журамгүй этгээдийг жигшин занах хэрэгтэй.

25 дугаар зурвас, Эл шашны хэргэмтэн, шавь нар, эмч, сурагчаас бус ард иргэд гааль гувчуур тушаах (алба хаах) үүрэгтэй.

26 дугаар зурвас, Хөвгүүд охид эцэг эхээ үл хүндлэгсэд, дүү нар багачууд ахас ихэсээ үл хүндлэгсэд, гэргий нь эрийнхээ зарлигийг үл дагагсад буюу харьяат нь захирагчаа үл хүндлэгсэдийг хүндээр шийтгэмүй.

27 дугаар зурвас, Өв хөрөнгийг залгамжлах тухай хууль. “Нэгэн түшмэд ноёд буюу ард иргэд үхсэн хойно, түүний эд хөрөнгө хэдий байсан ч болтугай, хөндлөнгөөс ингэ чингэ гэж үл болох бөгөөд хэн ч энэ эд хөрөнгийг халдаж болохгүй. Үхсэнд залгамжлах үр хөвгүүд үгүй болбоос эд хөрөнгийг нь түүний шавь буюу зарцад нь өгч болохоос биш, улсын санд оруулж огт болохгүй”.

28 дугаар зурвас, Байлдааны талбайд бие үрэгдэгсэдийг боол зарц нь үүрэн гарч ирсэн бол үхэгсэдийн мал хөрөнгийг энэхүү боолд өгөх хэрэгтэй. Өөр хүн үүрч гарч ирсэн аваас үхэгсэдийн гэргий, боол зарц ба мал хөрөнгийг цөм энэ хүнд өгөх хэрэгтэй.

29 дүгээр зурвас, “Хүмүүс архи ууж согтвоос тэргүүнээ цохиулсан мэт аливаа оюун билиг цөм хэрэггүй болмуй” гэж Чингис хаан хэлж байсан бөгөөд “сар бүр гурван удаа архи уухаар хязгаар болгожээ”.

(Тав) Тусгай хууль

(1) Олон улсын харьцааны хууль

30 дугаар зурвас, Хаант Монгол Улс болбоос дэлхийн эл улсын нэг нь болох биш, харин цогцлон байгуулагдаж бүхий дэлхийн хаант улс болмой.

31 дүгээр зурвас, Элч заралгыг гутаан доромжилж үл болмуй.

32 дугаар зурвас, Улсын хоорондохи арилжаа худалдааг хамгаалах хэрэгтэй.

33 дугаар зурвас, Хоёр улс дайтахын өмнө дайсан этгээдийн цэрэг ардад: “Хэрвээ эсэргүүцэлгүй даган өгвөөс, та нарын сайн сайхан ба амар түвшин батлагдмуй. Хэрвээ эсэргүүцвээс ямар зовлон учрахыг гагцхүү мөнх тэнгэр мэдэхээс биш бид үл мэдмүй” гэж зарлана.

(2) Аж ахуйн хууль

34 дүгээр зурвас, Хаант Монгол Улс бол нүүдлийн мал аж ахуйгаар гол болгосон улс болохоор бэлчээрийг онцгой эрхэмлэж, бэлчээрийн тухай тусгай хууль тогтоолтой байжээ. Бэлчээрийг эвдэгсдийг хүндээр шийтгэдэг. “Өвс ногоорсон хойно газрыг нүхэлсэн ба гал алдаж бэлчээрийг шатаагсадыг нэгэн гэрийг алмуй”.

35 дугаар зурвас, Агт морь бол Монголын аж ахуйн чухал бүрэлдэхүүн, зам харилцааны чухал багаж, цэргийн чухал хүч болох тул агтын тухай тусгай хууль дүрэмтэй байжээ. “Цэрэг дайн зогсмогц, дайнд унадаг сайн морьдыг ус бэлчээрт хурлан тавиад, унах ба гүйлгэхийг цаазламуй”. Агт морийг сүйтгэгсэдийг ялладаг байна. Жишээлбэл, “Морины толгой нүдийг занчигсадыг алмуй” (дээрх хоёр зурвасыг “Хар Татарын тухай хэргийн товч”-оос эшлэв).

36 дугаар зурвас, Нүүдэлчин малчдын амьдрал тогтворгүй байдаг тул жилийн эл улирлын ажлын хувиарыг “засаг”-т тодорхой тогтоож байдаг: “Өвлийн анх их цаснаас эхэлж, дараа хавар ногоо соёолтол, Монголчууд их ав тавьж бөхөн, буга, чихтэй зэрэг зэрлэг араатныг авладаг. Хавар болмогц ноёд түрүү нарын хуралдай хийж, байлдааны тухай зөвлөдөг” байна.

37 дугаар зурвас, Их авд мөн авын хууль дүрэмтэй байдаг билээ. “Хаан их ав тавих бүрт (Энгийн байдалд өвлийн эхээр хийдэг) зарлиг буулгаж, ордны ойр орчим ба төвийн ойр орчимд суугаа цэрэг ангиар авын бэлтгэл хийлгэдэг бөгөөд эдгээр цэрэг нь зарлиг ёсоор арван хүн бүрээс хэдэн морьт цэргийг томилж, зэр зэвсэг ба авд хэрэглэх зүйлсийг түгээн өгдөг байна. Цэргийг зүүн гар, баруун гар ба голын цэрэг гэж хуваан жагсааж их им (захирагч) удирддаг. ...Тэд нэг сар, хоёр сар буюу гурван сарын цагийг хэрэглэж байгаад нэгэн их авын хүрээг хүрээлдэг бөгөөд хүрээгээ багасгадаг Хэрвээ хүрээлэгдэж бүхий амьтан хүрээг цөмлөн гарваас, гарсан шалтгааныг нарийн байцааж, тэндэх мянганы ноён,

зууны ноён ба аравны ноёныг занчих буюу заримдаа алах ялаар шийтгэдэг”.

38 дугаар зурвас, Өрхийн ба гааль гувчуурын хууль. “Тэд (Монголчуудыг хэлж буй - эшлэгч) эл улс угсаатныг ноёрхсоноос нааш, өөрийнхөө заншил аргаар өрхийн дүрмийг тогтоожээ. Ингээд хүн нэг бүрийг аравт, зуут ба мянгатдаа зохион оруулдаг. Тэрчлэн цэргийн алба, өртөөний алба жич үүний сүйтгэл хангалт зэргийг татварладаг. Үүнээс гадна бас энгийн гааль ба гувчуур гэдэг татвар байдаг”.

(3) Арилжаа худалдааны хууль

39 дүгээр зурвас, Арилжаа худалдаачдыг хамгаалах хэрэгтэй.

40 дүгээр зурвас, Итгэмжийн өртгөөр бараа таваар зөөвөрлөж байгаад үнэ өртгөө алдагсад, бас нэгэн удаа итгэмжийн өртөг олж, хоёрдугаар удаа бараа таваар зөөвөрлөж болно. Гэвч гуравдугаар удаа үнэ өртөгөө алдагсадыг алах ялаар шийтгэмүй (“Монгол ба Орос” гэдэг номоос эшлэв).

(4) Зам нэвтрэлгэ ба өртөөний хууль

41 дүгээр зурвас, “Өртөө бүрт зохих тооны хүн, унаа жич идэш ууш зэрэг хэрэгсэх зүйл ба зардал хангалт зэргийг нь тохируулжээ. Энэ бүхнийг тэд түмэндээ хувьтдаг. Тухайлбал нэгэн замын өртөөг хоёр түмнээс хангадаг. Түм нь мөн өрх бүрээс алба татварладаг. ... Энэхүү өртөөгөө жил бүр нэгэн удаа байцааж, дутах зүйлсийг иргэдээс нөхвөрлөдөг”.

42 дугаар зурвас, “Өртөө бүгдэд сар бүр түшмэл ирж (энэ бол баахан сүүлчээр Чжи Юань улсын үеийн дүрэм болно - эшлэгч) нэгэн удаа цагдан, тэдний захиран хамаарч бүхий байдлыг байцаан үзэж, аливаа алба чимээг хаагдуулсныг нь залхаан ялламуу” (“Марко Пологийн аяллын тэмдэглэл”-ээс эшлэв).

(5) Шашин суртахууны хууль

43 дугаар зурвас, Аливаа шашин суртахууныг хүндэтгэмүй. Гэвч ямар нэгэн шашин ч онц эрхийг эдэлж үл болмуй.

44 дугаар зурвас, “Тэд хэдийгээр нэг зүйлийн шашныг шүтдэг боловч, олонхидоо ямар нэгэн шашны хэнээрхэх үзэгдлийг гаргадаггүй, Чингис хааны засгийг зөрчдөггүй, өөрөөр хэлбэл, эл шашинд адилаар ханддаг”.

45 дугаар зурвас, “Эл шашны ахмад, хэргэмтэн, шавь нарыг энгийн алба ба гааль гувчуураас онцгойлон хэлтрүүлмүй”.

(6) Ургийн хууль

46 дугаар зурвас, “Эр хүн нь санаан зоргоороо хэдий олон эхнэр ававч болмуй”, “анхдугаар гэргий нь эрхэм хүнд онц эрхтэй байхыг нэгэн туйлын зүй зохистой явдал болгох бөгөөд энэхүү эрх хүндийг түүнээс төрсөн үр хөвгүүдэд хүртэл өргөтгөмүй”.

47 дугаар зурвас, ... Ах буюу дүү нь үхсэн хойно, дүү буюу ах нь бэргэн буюу бэрээ гэргий болгон авч болмуй. “Богтлон авах бүр нэгэн удаа их хуримын ёслол хиймүй” (дээрх зурвасыг “Марко Поло-гийн аяллын тэмдэглэл”-ээс эшлэв).

(Зургаа) Эрүүгийн хууль

48 дугаар зурвас, Хаан ба төр улсаас зөрчигсөдийг алах ялаар шийтгэмүй.

49 дүгээр зурвас, Шашин суртахуун, ёс мораль ба зан заншлыг халдан зөрчигсөдийг алах ялаар шийтгэмүй. Жишээлбэл:

I. Хүн алагсадыг алмуй (бас торгож болмуй);

II. Бусдын эхнэр лүгээ садарлагсад, эрс хоорондоо садарлагсадыг алмуй;

III. Оргосон боол ба түүнийг далдлагсадыг алмуй;

IV. Гажуу солгой аргаар бусдыг хорлогсодыг алмуй;

V. Ноцолдоонд ганц этгээдийг дэмжигсэдийг алмуй;

VI. Бусдыг гүжирлэн заалдагсдыг алмуй;

VII. Худал хэлэгсэдийг алмуй;

VIII. Бусдын хадгалуулсан эдийг гурав дахи удаа үрэгсэдийг, олсон эдээ нуугсадыг, байлдааны дунд олж авсан хувцас эд ба зэр зэвсгийг эзэнд нь үл буцаан өгөгсөдийг цөм алах ялаар шийтгэмүй.

50 дугаар зурвас, Хулгайлагсадыг алах бөгөөд түүний гэргий ба мал хөрөнгийг хурааж хулгайлагдагсадад өгмүй.

51 дүгээр зурвас, Морь хулгайлагсадыг үнэ ёсоор төлүүлэхээс гаднаас бас мөнгөөр торгомуй. Торгуулийн мөнгийг үл тушаагсадыг алах ялаар шийтгэмүй.

52 дугаар зурвас, Боол хүн бусдын юмыг хулгайлбал, тэрхүү боол ба боолын эзнийг цөм алах ялаар шийтгэж, тэдний гэргий ба мал хөрөнгийг хураан авмуй. Ийм хэрэгт холбогдогсодыг хэргийн эзэн хэмээмүй.

53 дугаар зурвас, Хулгайлсан эд нь чухал бус болбоос ташуурдан ялламуй.

Энэ тухай Марко Поло-гийн тэмдэглэлд нэлээд нарийн тэмдэглэж буй: “Хулгайсан юмын үнэ хийгээд хулгайлсан байдлаар ялгамуй”. Нэг зүйлийн ял бол “тогтсон тоотой ташуураар ялламуй. Үлгэрлэвээс: долоо, арван долоо, хорин долоо, гучин долоо, дөчин долоо, эсхүл зуу бөгөөд долоон ташуур ташуурдмуй”. “Гэвч хулгайч нь хулгайлсан юмандаа хэрвээр есөн давхар үнэ өгч чадах болбоос даруй ял бүгдийг хэлтрүүлмүй”.

54 дүгээр зурвас, Хааны алтан ургийнхан “Их засаг”-ийг зөрчвөөс, хүнд хөнгөний байдлаар гяндлах буюу цөлөх ялаар шийтгэмүй.

Үүнээс гадна, малыг өрцөлж алах, өрх бүр жилийн нэг хүн ураглаж, хүн амыг өсгөх ба голын усанд бие угааж үл болох хүртэл бүр хууль дүрэмтэй гэдэг билээ. Гэвч засаг төрийн тухай бодтой хууль дүрэм гэвэл, их төлөв дээр дурдсан тавин дөрвөн зурвасаар гол агуулгыг нь илтгэж болох мэт. Харин энэ бүхнийг цөм Чингис хаан биеэрээ тогтоосон гэж хэлэх баримтгүй, үүний дотор заншлын хууль ч багтаж байх нь илхэн байна. Гэвч тэр үедээ хэрэгжүүлж байсан боломж ихээхэн буй.

Эдгээр хууль дүрмийг хэрэгжүүлэх талаар, ялангуяа ялтныг шүүн байцаах талаар хуулийн дэс дараатай байжээ. Жишээлбэл, “Зарга заргалсныг хөх дэвтэрт бичиж дэвтэрлэсэн”-ийг ургийн ураг хүртэл өөрчлөж болдоггүй. Энэ бол хуулийг гүйцэтгэх баримт болно. Бас “ял хийгсэдийг тухайн газар нь эс баригсадыг шийтгэж болдоггүй, өчгөө үл өгөгсөдийг шийтгэж болдоггүй” тогтоолтой тул буруу хилс шийтгэх явдлыг сэргийлжээ.

Эдгээр нь хаан (язгууртан, ван нар ч багтаж буй)-ы халдашгүй онц эрхийг баталсан хууль цааз болохын хамтад нийгмийн энх тайван ба хөгжил дэвшилд зохих үйлдлээ үзүүлсэн нь ч лав юм. “Төдий Чингис хаан бээр улс төрөө номчлон тэтгэж, энэхүү умар зү дэхи иргэнийг амгаланд зохиохын тул, өршөөлт цааз хуулийг тогтоов. Хамаг улс нь богдын өршөөлд номхотгож бүрүүн. Дээдсүүд доордосыг дарлахгүй, доод ард дээдэс лүгээ мөчөөрхөхгүй, адил ард эсэргүүцэн тэмцэхгүй, Мэргид төр ёсыг өгүүлэлдмүй, мунхгууд цааз хуулийг дагамуй, гаднаас дайсан хөнөөлгүй, дотроо хэрэлдэх заалдах будлиангүй, хүнд өвчин тахалгүй, малд зуд гамшиггүйн тул, бүх их улс нь энхжин жаргав” (“Чингис Богдын дурсгалын түүвэр”, 4-5 дугаар нүүр) гэж баарин түүхч Рашпунцаг тэмдэглэж байв.

Бас “засаг”-ийг ард иргэн ба цэрэг ангид зарлигаар нийтэлж, цэрэг ангийн нааш цааш өнгөрөх замын хажуугийн чулуун дээр сийлэх мэтийн эл зүйлийн амжилттай аргыг хэрэглэж өргөнөөр ухуулдаг байв (“Чингис хааны хаант улсын түүх, тавдугаар бүлэг”).

Монголын хааны онц эрхийг баталсан ба Монголын нийгмийн хөгжлийн хэрэгцээнээс буй болсон энэхүү “Чингисийн их засаг” гэдэг хууль дүрэм нь Чингис хаанаас хойш ч нэлээд урт хугацаагаар уламжлагдаж байсныг бид тус товчоонд хавсруулсан хуучны судлалын баримт бологч зарлигийн пайз тэмдэгүүдээс мэдэж болно. Үүнд “Амудулла вангийн зарлигийн пайз” (зураг-50), “Зальхайг сэргийлэх зарлигийн пайз” (зураг-51) ба Юань улсын үе дэх дөрвөлжин үсгийн зарлигийн пайзууд: “Урталжин хэлбэртэй дөрвөлжин үсгийн зарлигийн пайз” (Оросын Минусинск-ээс олдсон - зураг - 52), “Дугариг хэлбэртэй дөрвөлжин үсгийн зарлигийн пайз” (Дундад улсын төвд ба Оросын Томскоос олдсон хоёр зүйл - зураг - 53 зэргийг дурдаж болно).





Чингис хаан "Хаан ор"-доо

саатаж бүхий зураг



Өгөөдэй хаанаас Чингис хааны их засгийг уламжилж бүхий зураг



Амадулла вангийн зарлигийн пайз



Зальхайг сэргийлэх зарлигийн пайз

А. Нүүр тал - В Ар тал



Урталжин хэлбэртэй дөрвөлжин үсгийн зарлигийн пайз




Дугариг хэлбэртэй дөрвөлжин үсгийн зарлигийн пайз


Оросын Томскоос олдсон пайз - Төвдөөс олдсон пайз






Монгол барилгачдын уран бүтээл





Монгол тариачдын хэрэглэж байсан онгоц тээрэм



Арван зүгийн Цзи Вэй Гун ордон дахи зарлигийн хөшөө



Шагимунийн хүрээний хөшөө тэмдэглэл



Өвөр Монголд хэвлүүлсэн

“Монголын нууц товчоон”-ы шинэ хэвлэлүүд

Энэ тухай Марко Поло маш нарийн тодорхой тэмдэглэж байсан билээ: “Пайзын дээр бичиж бүхий үсэг нь доорхи мэт: “Мөнх тэнгэрийн сүр хүчинд их хаан түмэн настыг хичээнгүйлэн, аливаа зарлигийг зөрчигсөдийг алан үл уучламуу” (ийм агуулгатай пайз байвч, яг ийм үсэгтэй пайз ер харагдаагүй - эшлэгч) хэмээжээ. Энэхүү зарлигийн пайзыг олсон аливаа цэргийн ноён нь хөхүүлэлийн пайзыг дагалдсан зүйл зүйлийн онцгой эрхийг эдэлмүй. Пайзын дээр түүний эрх тушаалаа явуулахын алба хийгээд эрх сүрийг цөм тодорхойлон бичиж амуй” (“Марко Поло-гийн аяллын тэмдэглэл”, Гириний монгол хэвлэл, 269 нүүр) гэжээ. Зарим пайзын агуулгын тухай баруун хойд орны үндэстний дээд сургуулийн ахлагч багш, Монголын судалгааны ажилтан нөхөр Хао Су Мин нарийн магадлалт хийж, “Монгол хэл бичиг” сэтгүүл (1981 оны хоёрдугаар хугацаа)-д нийтлүүлж байсныг анхааруштай.

“Чингисийн их засаг” - Хаант Монгол Улсын хуулийн тухай тархай бутархай тэмдэглэлүүдийг төвлөрүүлэн үздэг юм бол Хаант Монгол Улсад хууль дүрэмгүй гэж үзэж болохгүй бөгөөд хууль дүрэм нь төдий төгөлдөргүй гэж үзэж ч болохгүй биз.

44. Хамтын оюун, хааны сургаал

“Чингисийн билиг” буюу “Чингисийн сургаал” гэж монгол үндэстний дунд аль эртнээс бичгээр буюу амаар уламжлагдаж байсан аа. Хэлэлгээнгүй үүний дотор сүүлчийн хүмүүсийн нэмж нөхвөрлөсөн зүйл ч лав байх юм. Энэ нь юуг харуулж байх буй гэвэл, төр улсыг засахад гагцхүү дарангуйлах арга болсон хууль цааз байгаад болохгүй гэдгийг Чингис хаан мэдэж байжээ. Ингээд “Чингисийн сургаал” нь “Чингисийн их засаг”-тайгаа зэргээр буй болсон мэт.

Чингисийн “билиг” буюу “сургаал” гэдэг нь хэрэг дээрээ өрлөг жанжин, сайд түшмэд, эрдэмтэн мэргэд, жич ард иргэдийн уламжлалт зүйр сэцэн үгийг шингээн авч бүтсэн нь ч илэрхий юм. Ялангуяа баахан сүүлчийн үед тэмдэглэгдсэн нь бүр ч ийм шинжтэй билээ.

Чингис хааны “билиг” буюу “сургаал”-ыг нэлээд төвлөрөнгүйгээр тэмдэглэж манай үе болтол хадгаласан ууган тэмдэглэл (үүнээс өмнө бүрэн тэмдэглэл байсан нь лавтай боловч одоо болтол хадгалагдсангүй нь харамсалтай) бол перс түүхч Рашид-ад-Диний “Судрын чуулган” болно. Түүнд нийт гучаад зурвасыг тэмдэглэжээ. Үүнийг нь Чин улсын сүүлчийн үеийн түүхч ба элчин сайд Хун Цзюнь “Юань улсын түүхийн нөхвөр орчуулга” гэдэгтээ “Юань улсын түүх”-д тэмдэглэл бүхий дөрвөн зурвасыг нь хасаад, бусад хорин зургаан зурвасыг нь хятадчилан нийтэлжээ. Одоо манай нэлээд өргөн ашиглаж бүхий агуулга бол үндсэндээ Хун Цзюнь-ий энэ орчуулга болно. Энэ хорин зургаан зурвас дахи нэг хэсэг хууль дүрмийн чанартай зүйлийг нь тус бүлгийн “Чингисийн их засаг” гэдэг зүйлд найруулан оруулав. Бас нэг хэсэг нь энгийн яриа мэт зүйлс болно. “Билиг”, “сургаал”-ын чанартай арван дөрвөн зурвасыг нь тус зүйлд тэмдэглэв. Баахан сүүлчийн үе дэх монгол түүхчийн зохиолд Чингисийн “билиг”, “сургаал”-ыг тун гойд урнаар тэмдэглэж байдаг аа. Чингисийн “билиг”, “сургаал” олон зуун жил ард түмний дунд уламжлагдахдаа нэлээд баялагжин хөгжсөнийг эдгээр тэмдэглэлүүд харуулж байна. Үүний дотор Багарин түүхч Рашпунцагийн зохиосон “Дай Юань улсын болор эрих” хэмээх бичигт нэлээд бүрэн системтэй тэмдэглэж буй.

Тус зүйлд энэ хоёр зохиолын гол гол зүйлийг түүвэрлэн сонгож тэмдэглэв.

(Нэг) Рашид-ад-Диний тэмдэглэл: (бүх агуулгыг нь “Юань улсын түүхийн нөхвөр орчуулга”, нэгдүгээр боть, доод хэсгийн 24-26 дугаар нүүрт лавлаарай).

- Айл гэрээ дугамдаж чадагсад төр улсыг засаж чадмуй; арван хүнийг захирч чадагсад мянга, түмэн хүнийг захирч чадмуй; өөрийн хэргийг шийдвэрлэж чадагсад төрийн хэргийг шийдвэрлэж чадах бөгөөд дайсныг сэргийлж улсаа хамгаалан чадмуй.

- Сайн морь хэмээвээс, хур ахуйдаа хулан чихгий мэт, туранхай боловч дутаах чоно адил, тартай байваас талын туулай мэт буй за.

- Алан хатгалдахуй цагт алдар нэрээ бүү гутаагтун, үлгэрлэвээс их авд мөнх тэнгэрийн хүчээр асар ганзага олзловч алгуур хүртэх мэт.

- Иргэнийг асрах ёс нь эх үнээ мэт, дайсныг дарах ёс нь шаах (тонших – хө.) шувуу мэт.

- Хэлснээрээ хийгсдийн үг сайн; хий хоосон яригсдын үг муу. Өөрийн биеийг ухааран мэдвээс, өөр бусдыг тольдож чадмуй.

- Хэн боловч хол ойрыг гэрэлтүүлэгч нарны гэрэл бус тул, гэрийн хэргийг гэргийд найдмуй. Зочин ирвээс зочилж дайлах нь эхнэр хүний журам бөгөөд хол ойрд алдаршмуй. Гэрийг нь үзвээс эзнийг мэдэж болмуй.
- Бачим цаг Тархай-уха (ийм нэр өөр газар ер харагддаггүй - эшлэгч)-гаас сурах хэрэгтэй. Нэгэн өдөр, Тархай-уха хоёр хүн дагуулан гадагш гарсан ажгуу. Алсад хоёр дайсан явж байсныг олж үзжээ. Дагагсад нь өгүүлрүүн: “Бид гурвуул тул хоёр дайсныг довтолбоос лав дийлмүй”. Тархай-уха өгүүлрүүн: “Бид тэднийг олж үзсэн атал, тэд биднийг үл олж үзэх ёс буй ажгуу?” хэмээн довтлон буцаж олон цэрэг лүгээ нийлжээ. Харин тэр хоёр хүний нэг нь Татарын түрүү Төмөр-уха (энэ нь харин Татарын түрүү Төмөр гэгчийг хэлж байх бололтой - эшлэгч) гэгч уулын хавцалд таван зуун хүнийг бөхүүлж, ганцаар гарч ирэн дайсныг өдөөн, хүрэгсэдийг баривчлах хэмээсэн ажгуу.
- Авд араатныг олон барьж, алалдаанд дайсныг олон алах хэрэгтэй. Мөнх тэнгэр ивээвээс бид ялж дайсан мөхмүй.
- Баатар хэмээвээс Есөнтэгэ (уул эхэд Есөнбэй гэж байсныг Ли Цзэ Фэнь авгай Турхагийн ноён Есөнтэгэ гэж залруулсан нь зүйтэй мэт - эшлэгч) мэт, тэр өдөр турш байлдаад ядаж зүдэх, өлсч ундаасахыг мэддэггүй. Хэн ч түүн лүгээ үл тэнцмүй. Харин тэр сайн захирагч бус болой, тэр бусдыг биетэйгээ адил үздэг, гэтэл байлдагчийн өлсч ундаасах ба ядаж зүдэхийг мэддэггүй. Захирагч бологсод өөрийн зүдрэлийг мэдвээс, бусдын зүдрэлийг сая мэдмүй. Аян дайнд явахуйд замын хол ойроор цэрэг морины хүчийг мэдмүй. Доройгоор хэмжээ болговоос чадалтан хэрхэн мөхөсдөх аж.
- Худалдаачдын эд хураах чадвар болбоос өргөс хуримтлуулах арга болой. Эрхэм ноёдын хөвгүүд дүү нараа сургах нь мөн адил болой. Уналга харвалгыг мэргэжүүлэх нь чадвартай худалдаачид ашгийг олох мэт. Амь насанд адил хүндэтгэх хэрэгтэй.
- Үндэс язгуураа бүү мартсугай хэмээн үр хөвгүүдээ сургатугай. Тэд нарт гагцхүү өнгөт дээлийг өмсөн, амтат идээнийг идэн, тарган агтыг унан, тааламжтай гэргийг тэврэхийг мэдүүлж үл болох бөгөөд манай үйлсийн шургуу замыг мартуулж үл болмуй.
- Архинд автгаас сохор дүлий мэт, дотроо ухаангүй, гаднаа аргагүй, ажил үйлс цөм саармуй. Архи хэтийдвээс сайн мууг үл ялгамуй. Эзэн хаан архинд автгаас төр гүрнээ алдмуй; Сайд түшмэд архинд автгаас засаг дүрэм саармуй; хөтөч иргэд архинд автгаа хүнд ялд унамуй.
- Миний сургаалыг эс дагагсадыг түрүү хоёр удаа зэмлэн донгодмуй; Гутгаар удаа Балжин Хорчур (ийм нэр өөр тэмдэглэлд харагддаггүй, “Баргужины хязгаар” гэсэн үг ч байж мэднэ - эшлэгч)-т цөлмүй. Дахин эс дагагсадыг гянданд хоримуй; хэзээд үл дагагсадыг ураг төрлөөр ял хэлэлцмүй.
- Чингис хаан Боорчу нараас асууруун: “Юуг хамгийн их жаргал хэмээмүй?” Боорчу айлтгаруун: “Алдарт шонхорыг гартаа барьж, ажнай хүлгийг хөлөглөн давхиулж, өнгөт дээлийг биедээ өмсч, хаврын эцэс сард Хангай нутгаар ав тавих нь хамгийн жаргал болой” хэмээхүйд, Борухул айлтгаруун: “Гүн огторгуйгаас омогт шонхор нисэн бууж, өчүүхэн жигүүртнийг үзтэл дэлдэн буулгах нь үнэхээр жаргал болой” хэмээхүйд, Хубилай

айлтгаруун: “Ав тавихуйд араатад үргэн дугаахуйг үзэх нь хамгийн жаргал” хэмээхүйд, Чингис хаан өгүүлрүүн: “Цөм биш болой, хүний жаргал хэмээвээс, өшөөт дайсны тэргүүнийг өвс хадах мэт унагаж, эрхэн хүлгийг нь олзлон, эмс хатадыг нь гэргийлвээс тэр сая жаргал болой” хэмээжээ.

(Хоёр) Рашпунцагийн тэмдэглэл: (1925 онд Бээжингийн монгол бичгийн хорооноос хэвлүүлсэн “Чингис богдын дурсгалын түүвэр” гэдэг товхимолын 40-57 дугаар нүүрт лавлаарай). Онц зарим үсгээс бусад нь зөв бичлэгийн засалт хийсэнгүй.

“Бас шар барс арван гуравдугаар он (энэ нь Чингис хааны он тооллыг хэлжээ, нийтийн он тооллоор 1218 он болно - эшлэгч), зуны тэргүүн сард, Чингис хаан, Онон мөрний эхэнд гүүний өчиг сацал гаргаж их хурим хуримлахуйд, Чингис хаан бээр дүү нар хөвгүүд ба түшмэддээ сургаж зарлиг буулгаруун:

“Омог хүчээ дараад,

Онол билгээ хичээж бүрүүн,

Улсыг эрхтээ авсны тул,

Олны эзэн болмуй за.

Арга билиг хоёрыг мэдвээс эл,

Аливаа хүчтэнийг эрхтээ оруулж,

Арга билгийг эс ухваас эл,

Алгандаа бичсэнийг тогтоохуйяа бэрх.

Бие бөх бөгөөс ганцыг ялгаж (ялж),

Эе бөх (бүлгэмдэлтэй) бөгөөс олныг ялгаж,

Манд ижилдвээс баатар болюу,

Мэргэд лүгээ ханилбаас сэцэн болюу.

Аливаа хэрэгт хүнээс,

Асар мэргэн хүн дээр.

Түмэн түмэн ардаас,

Төр ёсыг мэдэгч хүн үлэмж.

Эдээр биеэ чимснээс,

Эрдмээр чимсэн нь дээр.

Хол хэмээн бүү цөх явбаас хүрч,

Хүнд хэмээн бүү зүрхшээ өргөвөөс дааюу.

Давшгүй давааг давбаас дээр нь гарюу,

Гэтлэшгүй мөрнийг гэтэлсүгэй хэмээн нэгдвээс тэртээ нь гарюу.

Эр хүн нэгэн сэтгэлт болбоос эрдэнэ,

Хоёр сэтгэлт болбоос эм лүгээ адил,

Эм хүн ганц сэтгэлт бөгөөс эр хүн лүгээ адил,

Хоёр сэтгэлт бөгөөс адгуус лугаа адил болой.

Өөрийн гэмийг бусдаас асууж мэд,

Төр ёсны ослыг сэцдээс асууж суралцахуй.

Сумны мөс хэдий шулуун боловч,

Они өднөөс ангид харваж үл болюу.

Хүн хэдийгээр сэцэн төрөвч,

Сургуулиас ангид мэргэн үл болмуй.

Сэцэн мэргэн түшмэл улсын эрдэнэ,

Сайн хатан хүн нь гэрийн эрдэнэ.

Хэрэг үйл хэдий өчүүхэн боловч,

Хичээлээс ангижирвал үл бүтюү.

Хүндлүүлэх ба хөнгөлүүлэх нь,

Хөвчин өөрийн авираас төрмүй.

Хэдий хайрлаваас бээр сайн мориныг хур махад үл болгогдохуй,

Ямар ба өршөөвч хөвгүүнээ хичээн халдаж сургагдахуй” хэмээв.

Чингис хаанд Го сэцэн айлтгаруун:

“Харц хүн жаргахуй нь,

Хаанаа сайнд жаргамуй.

Хаалгат гэрт суун жаргахуй хатан хүн нь,

Хайрт эрийнхээ хүчинд жаргамуй.

Харц хүн архийг ууваас,

Хаан хүн лүгээ сацуу санамуй.

Хатуу засаг хаагдваас эл,

Хар нохойноос муу болон ажгуу.

Хар хулгана хор амсваас,

Хамгаас дээр хэмээн омогломуй,

Хар хошуут үнэгний ирэхүйг үзвээс эл,

Харин нүхний амсарыг тэмцэн ажгуу.

Харавгар шувуу хадны өөд нисэн атал,

Харин жигүүрээ хугарагдмуй.

Харц хүн эзэнтэйгээ эсэргүүцрүүн,

Харин тэргүүнд нь гамшиг болюу.

Нохой хэдий цөөн гөлөглөвөөс дөрөв тавыг төрюү,

Өөр зуураа хэрэлдэхийн тулд,

Хамт нэгнээ сүрэглэн үл чадмуй.

Харцас иргэн нохой мэт тэмцэлдэхүйн тул,

Хаан эзнээ сэтгэлийг үл амаржуулах.

Хонь хэдий олон хургалавч,

Хоёроос илүү үл төрюү.

Өөр зуураа үл хэрэлдэхийн тул,

Мянга ба түм болж сүрэглэмүй.

Хонь мэт нийлэн явбаас эл,

Хутагтан дээдсийн сэтгэл хэр (хэрхэн) үл амумуй” хэмээсэнд, Чингис хаан бас өгүүл хэмээн зарлиг болбоос, баясан дахиж айлтгаруун:

“Хурц болд илд билүү үгүй үл даамуй,

Хурдан хүлэг махгүй гүйн үл чадюу.

Хүчит арслан өтөлбөөс,

Хүзүүний нүх сахим (сахинам – хө.) гэлээ.

Хүний сайд өтөлбөөс,

Хөвгүүдийн үг даган ажгуу.

Дээлийн сайн хуяг бөгөөтөл,

Хуримд үл өмсмүй.

Үгийн сайн тунгалаг бөгөөтөл,

Дуустал үл өгүүлжээ” хэмээв.

Чингис хаан, Лидэр сэцнээс асууруун: “Энэ ертөнцөд эцэсгүй хүлэг нь юун? Гүйцэшгүй сэцэн нь хэн буй?” хэмээн зарлиг болбоос, Лидэр сэцэн айлтгаруун:

“Алгуур аян нь,

Амьдын хүлэг.

Авираа өөрөө мэдэгч нь,

Гүйцэшгүй сэцэн” хэмээв.

Чингис хаан, Мэнгитэ сэцнийг нэгэн үг өгүүл хэмээн зарлиг болбоос, Мэнгитэ сэцэн баясч айлтгаруун:

“Нохой мэт нөхөр олохуйяа бэрх,

Нохой нь үгээгүү хүнд тэжээгдвээс,

Баян хүнийг үл дагамуй,

Харц хүнд асрагдваас,

Хаан хүнийг үл танимуй.

Эрт мянган түрүүт нэгэн могой ажгуу, олон түрүү нь зүг бүр булаалдсаар тэргэнээ дайрагджээ. Бас мянгат сүүл нэгэн могой ажгуу, ганц тэргүүнээ дагаж нүхэнд ороод тэргэнээ эс дайрагджээ. Тэр мэт бид мянган сүүл чинь болж хүчээ өгч дагасугай” хэмээсэнд Чингис хаан тэдний үгийг маш зөвшөөрлөө. Тэр хуримд өрлөг ноёны дээл нь тосдсонд өөрөө хямран арчваас, баян ноён өгүүллүүн:

“Тост хурим цуст бол хэмээхүйг эс сонсвоос (сонсов уу?) чи, эд нь хэврэг эзэн минь мөнх болтугай” хэмээсэнд, өрлөг ноён хариу өгүүллүүн:

“Төрсөн бие үхэн үхэлдэн хайран, үүдсэн эд элэн элтэл хайран хэмээхийг сонсов уу чи?” хэмээсэнд, Чингис хаан үе хоёулын үгийг зөвшөөж бүрүүн, тэр хоёроос асууруун:

“Та хоёул хэрхэж амраглан явмуй?” хэмээн зарлиг болбоос, өрлөг ноён айлтгаруун:

“Үнэн үгээ нууцгүй хэлэлцмүй,

Үгүй дутуугаа эсэргүүдэн өгөлцмүй”

хэмээвээс, Чингис хаан зарлиг болруун:

“Тэр нь сайн, тийм боловч айл хүний хутгаан үгэнд үл орогдохуй, амраг нөхрийн ингүүхэн үгэнд үл муулалдах бөгөөс, ах дүүгийн ёс тэр буй за” хэмээгээд бас зарлиг болруун:

“Төрийн эзэн хаан сэцэн болбоос,

Төрүүлсэн эцэг эх бүтэн болбоос,

Төрөгдсөн ах дүү бүрэн болбоос,

Төр ёсыг мэдэгч түшмэл болбоос,

Түрэмгий дайсныг дарагч цэрэгт болбоос,

Төв анх учирсан гэргий ба хөвгүүн үр мэт болбоос,

Түгээмэл эрхэт тэнгэр ивээх болбоос,

Төвшин их жаргалан тэр болой” хэмээн зарлиг болов.

Бас нэгэн цагт Чингис хаан хөвгүүнээсээ асууруун:

“Хуримын дээд аль?” хэмээвээс, Чагаадай өгүүллүүн:

“Хуучин жил хэнхэрсхийж (хангиран одож – хө.), шинэ жил шилжиж ирэв хэмээн, өлзий хутагт шинэ өдөр хуримлаваас хуримын дээд тэр буй за” хэмээсэнд, Чингис хаан зарлиг

болруун:

“Нярайгаас унаад, нэр эс олбоос

Хэвлийгээс унаад, хэвийг эс үзвээс,

Хэн за шинэлмүй? үүнээс хойш

Эцэг эхийнхээ төрсөн өдөр хуримлаваас

Хуримын дээд нь тэр буй за” хэмээгээд бас зарлиг болруун:

“Жаргалын дээд нь аль буй” хэмээсэнд, Жочи айлтгаруун:

“Олон адуугаа адуулж,

Орд гэрээ байгуулаад,

Олон даагыг уралдуулан хуримлаваас,

Жаргалын сайн энэ”

хэмээсэнд, Чагаадай айлтгаруун: “Би санаваас дайсныг дарж булха-ыг борчуулан, ботготыг буйлуулан, боол шивэгчнийг орилуулж авчирваас жаргалын сайн энэ” хэмээвээс, Өгөөдэй айлтгаруун:

“Би санаваас хаан эзний зөөсөн их улсыг амгалан, хөл хөсөр, гар газар тавиулж бүрүүн, улс иргэнийг уртад агуулж, төр ёсноо төвшнөө бариад, өтгөс ихэсийг жаргуулж, өсөх залуусаа тэтгэвээс, жаргалангийн сайн энэ” хэмээв. Тулуй айлтгаруун:

“Би санаваас хүлгээ засан төлүүлж,

Хөгшин харцгайгаа засаад,

Хөхөгчин нугасыг бариулан,

Хөдөөд авлан явбаас,

Жаргалын сайн энэ” хэмээсэнд,

Чингис хаан зарлиг болруун:

“Жочи Тулуй хоёр өчүүхэн хүний үг өгүүлжээ. Чагаадай над лугаа дайсанд олон явснаар ийнхүү өгүүлмүй зэ.

Хадар загасныг өчүүхэн хэмээснээр,

Харин ч гараа эсгүүлсэн олон,

Харь дайсныг басамжилснаар,

Халуунаа автсан олон бөлгөө.

Өгөөдэйн үг маш зөв” хэмээвэй.

Чагаадай өгүүлрүүн:

“Буулгаагүй модонд хурц сүх хэрэг,

Буулган дуусгаваас зохиогч сайн уран хэрэг.

Байгуулаагүй төрд баатар эр хэрэг,

Байгуулан дуусваас багшлагч мэргэн хүн хэрэг.

Эрдэмт бөгөөд эс хэлсэн сэцнээс,

Эрж олсноо хэлэгч тэнэг дээр.

Асар хол дахи найман эрдэмт нуураас

Амины тэжээл болсон алгамын усан дээр

Ухаан төгөлдөр бөгөөтөл эс хэлсэн мэргэдээс

Ухаж мэдсэнээ хэлэгч мунхагууд дээр

Учир цагт эд малаа заран ядагч баялагуудаас

Учир лугаа тохиолдон явагч

Үгээгүү хүн дээр” хэмээв.

Өгөөдэй өгүүлрүүн:

“Муу хүнд зургаан гэмшил буй, тэр нь:

Эс эрдэм сурваас хэрэглэх цагт гэмшюү,

Эрүүл биеэ эс асарваас эвдэрсний хойно гэмшюү,

Ноён бөгөөд ариун эс явбаас буурсны хойно гэмшюү,

Баян бөгөөд эдлэн эс чадваас үгүйрсний хойно гэмшюү,

Архи ууж муу авирлаваас сэргэсэн хойно гэмшюү,

Үйл үг хоёрын учир нөгчсөний хойно гэмшюү.

Ертөнцөд гурван хүнийг нигүүлсдэхүй, урьд ноён бөгөөд буурсан ба урьд баян бөгөөд үгүйрсэн лүгээ, мунхагуудын дотор дарагдсан ганц сэцнийг нигүүлсдэхүй, мэргэд эдгээрийг оюундаа хичээн шинжлэгдэхүй” хэмээсэнд, Чингис хаан биеэр үе хоёулын үгийг маш зөвшөөрлөө. Бас Богд Чингис хааны хөвгүүдийг сургаж өгүүлсэн нь:

“Хүйгэр (хүй нэгтгэн - хө.) хүн салж одвоос,

Хөндлөнд олз болно гэм.

Өнөр төрөл салж одвоос,

Өнчин хүний олз болно гэм.

Хүсэл бүхэн хямд олдох,

Хүйхэр төрөл үл олдох,

Аль хүсэл бүхэн олдох,

Ах дүү үл олдох.

Энэ мэт хүн болон төрөгсөд,

Эрдэм билиг ухаантай боловч

Элбэрэлийг осолдох болуузай.

Энэ чөтгөр омгоос болох буй,

Хүн мөнхүү адилаа тоомуй,

Хүчир сайн нь бус хэмээн сэтгэмүй.

Хүсэл омог шунахайг тэвчиж,

Хүмүүжих журам өршөөлийг сурагтун.

Энэ бие үхэхүйд хүрвэй,

Эрхэм аяс зүүн зүгт хандвай

Эрхгүй тэр мөрийг дагагтун,

Эрдэмтнийг нөхөрлөн явагтун.

Сайныг сурч явбаас мандмуй,

Самуунаар явбаас сөнөмүй.

Санааг үнэн чинд хүргэгтүн,

Саруул гэгээн бат мэргэн бологтун.

Дээдсийн алдар нэрийг илтгэ,

Дэргэдэх ах дүүг хураа,

Дэдэд нь иргэнээ асра,

Дэлхийг энх болгон баясга.

Хэрвээ муу харангуйд унаж,

Хэрэггүй харгис омог бариад,

Хэрүүл цуугил үйлдвээс хөвгүүн минь,

Хэзээ ч хүн бус болмуй.

Өршөөл журам бүхий хүнд,

Өлзий хутаг өгөх болой.

Тэнгэрийг үнэнээр сүсэглээд шүтэгтүн,

Үл мартан хичээж явагтун” хэмээжээ.

Чингисийн “билиг”, “сургаал” гэж уламжилж ирсэн зүйлс их төлөв ийм байна. Энэ бол төрийг засах, ардыг гэгээрүүлэх ба монгол үндэстний боловсон дэвшилд дутагч болшгүй агуулга болно.

Чингис хааны энэхүү “Бичиглэгдсэн заншлын хууль – их “засаг” болон “билиг”-ийг нь нийтэлж хэрэгжүүлснээс нийгмийн дэглэм, ёс мораль ба хувийн хөрөнгийг хамгаалах талаар идэвхтэй үйлдлийг үзүүлсэн бөгөөд хожмын Монголын эл хаант улсын хуульд нь суурь болж чаджээ” (“Дундад улсын монгол түүхийн эрдэм шинжилгээний нийгэмлэгийн 1980 оны ээлжит хурлын өгүүллийн түүвэр”). “Бидний мэдэж байх ёсоор, дэмий олон жил болсонгүй, “засаг”-ийг зөрчсөн үзэгдэл дахиж харагдахгүй болж, айл өрх бүр үүд хаалгаа оньсолж цоожлох хэрэггүй болсон бөгөөд Монголчууд хоорондоо болзоогоо бат баримтлах болжээ” гэж “Хар Татарын тухай хэргийн товч” ба “Чингис хааны хаант улсын түүх” гэдэг номд тэмдэглэж байна.

45. Тал дүүрэн мал сүрэг, ой дүүрэн ан гөрөө

Нийгмийн хөгжил бол нийгмийн үйлдвэрлэлийн харьцааны хураангуйлал болсон аж ахуйн

хөгжил болохыг хэн бүхэн бүр мэдэж байх юм. Нийгмийн ямар нэгэн байгуулал доор ч ийм байдаг. Тиймээс бид арван гуравдугаар зууны үед Чингис хааны байгуулсан Хаант Монгол Улсыг дурдахад, түүний суурь болсон аж ахуйг нь дөхөм ч болтугай дурдах хэрэгтэй. Хэдийгээр энэ нь тус товчооны гол үүрэг биш боловч, ингэх л ёстой байна.

Хаант Монгол Улсыг байгуулсан анхны үед монгол үндэстний аж ахуй нь мал аж ахуйгаар гол болгож, ан гөрөө, гар үйлдвэр зэргээр дагалдвар болгож байжээ.

Монголын мал аж ахуй

Мал аж ахуй бол эсгий туургатан Монголчуудын үйлдвэрлэл, амьдрал ба аливаа хэрэгсэлийнх нь ундрал болж байжээ. Мал сүргээ өсгөх, малын зүйл төрөл ба яс чанарыг сайжруулах, малын ашиг шимийг боловсруулах ба эдгээрт үйлчлэх зүйлийг эрхлэх явдал бол Монголчуудын гол үйлдвэрлэл болно. Хонь үхрийн мах ба сүү цагаан идээ бол Монголчуудын идэш уушийн гол ирэл нь болж байжээ. Арьс ноос зэрэг мал аж ахуйн гаралтыг шууд ашиглах буюу арилжих аргаар амьдралын хэрэгслээ хангадаг байна. Тэрчлэн зам нэвтрэлгэ, дайн байлдаанд хүртэл бүр мал сүргээс салдаггүй. Тэр үед Монголын мал аж ахуй нь таван хошуу мал болно. Гэвч гол нь адуу, үхэр, хонь болох бөгөөд тэмээ, ямаа цөөн байжээ.

Адуу морь нь тооны талаар таван хошуу малын дотор хоёрдугаар байрыг эзлэх боловч чухал үйлдэл ба ач холбогдлын талаар тэргүүн байрыг эзлэж байжээ. Морь бол мал сүрэг адуулах, ан гөрөө ба дайн байлдаан хийхэд жич аливаа зам харилцаанд унах чухал хөлөг болдог бөгөөд зундаа гүүгээ сааж цэгээ эсэг хийдэг. Адуу морины олон цөөн, агт хүлгийн тарган эцэнхий нь тэр үедээ байлдах хүчний хүчирхэг буурайг шалгах хэмжүүрийн нэг нь болж байв. Тэр үед цэрэг дайн ба зам нэвтрэлгэд морийг нийдэм хэрэглэж байсан явдал бол одоо үеийн машин техникийг хэрэглэж байхаас дооргүй ач холбогдолтой байжээ. Тэр үед Монголын адууны ерөнхий тоог тэмдэглэсэн материал байдаггүй боловч бодтой хэрэглэж байсан байдлаас үзэхүл, тун олон байсан гэдгийг мэдэж болно. Жишээлбэл, зөвхөн Монголын морьт цэрэг нь дайнд мордоход хүн бүр гурав дөрөв буюу тав зургаан морьдыг авч явдаг гэсэн тэмдэглэл аль олон буй. Чингис хаан баруунш дайлахад арван түмэн цэрэг (зарим тэмдэглэлд хорин түм гэдэг) морджээ. Бид хамгийн цөөн тоо, хүн бүр гурван морь авч явснаар бодоход гучин түмэн адуу авч явсан байх ёстой. Харин цэргийн хэрэгцээ нь бүх улс ардын аж ахуйд цөөн тоог эзэлж байсан тул, бүх улсын адуу хэчнээн байсныг барагцааж болно.

Үхэр нь тэр үед тооны талаар адууны хир олон байсангүй боловч, мал аж ахуйн дотор чухал байрыг эзэлж байжээ. Үхэр нь Монголчуудын хүнс хоолны гол ирлийн (эх сурвалжийн – хө.) нэг нь болж байсан билээ. Цагаан идээний гол нь үнээн сүүгээр хийдэг. Үйлдвэрлэх цаг урт, гарах тоо олон, зүйл төрөл ч арвин байдаг. Үхрийн махыг өвөл зунгүй иддэг бөгөөд цэргийн хүнсэнд хэрэглэх хатаасан борц бол гол нь үхрийн мах болно. Үхрийн арьс шир бол үйлдвэрлэл ба амьдрал хэрэглэлийн чухал материал болно. Түүнээр гутал, хуяг, сур хийдэг. Сур бол эмээлийн хэрэгсэл, хөлбөрийн (хөлөлгөөний – хө.) хэрэгсэл болно. Үүнээс гадна, үхэр бас нүүдэлчин Монголчуудын тээврийн чухал хөдөлгөх хүч нь болж байжээ. “Монгол үхэр бол бүр шар үхэр юм. ... Анжсанд хөлөхгүй, харин тэргэнд л хөлөх юм”, “үхэр морь ба тэмээгээр тэргээ чирүүлж, тэрэгний дээрх гэрт нь сууж хэвтэж болно, үүнийг хам тэрэг гэнэ” гэж “Хар Татарын тухай хэргийн товч”-д тэмдэглэж байдаг сан.

Хонь бол Монголын аж ахуйд тооны талаар тэргүүн байрыг эзэлж байжээ. “Тэдний улсад нэгэн морь агсадад адбиш зургаа долоон хонь байх ёстой” гэж “Монгол Татарын тухай бүрэн тэмдэглэл”-д тэмдэглэж байдаг. Энэ харьцлаар зүйчилбэл, хэрвээ зуун түмэн адуу байсан бол зургаа буюу долоон зуун түмэн хонь байх ёстой. Хонины өсөц хурдан, хэрэглэхүүн өргөн байдаг. Хонины арьс ноос бол Монголчуудын амьдралын чухал хэрэглэхүүн болно. Хонины мах сүү ч яриангүй чухал идэш болох юм.

Аргал, хөрзөн бол Монголчуудын шатаалгын гол материал нь болж байжээ.

Тэмээг голдуу ачаа буюу хөлбөрт л хэрэглэдэг байна. “Хар Татарын тухай хэргийн товч”-д тэмээ нь хос бөхтэй, ганц бөхтэй ба бөхгүй ч гэж тэмдэглэж байна. Хос бөхтэй тэмээ бол төв ази буюу монгол оронд гардаг, ганц бөхтэй тэмээ бол Араб, Энэтхэг ба Африкийн умард орноор гардаг. Тиймээс Монголчууд тэмээг баруун орноос оруулж малжсан бололтой. Чингисийн үед Тангуд улсаас өргөл болгож тэмээ хүргэдэг байжээ.

Ямаа бол нэн цөөн байсан бололтой. “Нууц товчоон”-д Ван хан ямаа сааж амьдарч байсан гэдэг мэдээ л байдаг. “Хятад ямааг гу-ли-ян гэнэ. ...Сүрэг бүрд нь “гу-ли-ян”-г хэд хэдийг тавина. Эдгээр ямаа зоригтойгоор сүргийн манлайд явж, ус тохиолдмогц тэргүүнд гэтлэхүйд олон хонь дагаж гарна”. Ямааг цөөн малждаг учир гэвэл, “Энэхүү Ли Янь-гийн мах хийтэй болохоор түүний махыг ер иддэггүй” (“Хар Татарын тухай хэргийн товч”), тэрчлэн ямааны ноос ч тун бага гардаг бөгөөд хэрэглэхүүн нь ч тун явцууханаас болжээ.

Мал аж ахуйн доторхи эл төрлийн мал сүргийн үйлдэл ба байр нь нийгмийн хөгжлийг дагалдан хувирч байдаг. Жишээлбэл, машин техник хөгжсөн одоо үед адуу морины үйлдэл нь ихээр багасч, бараг таван хошуу малын дотор нэлээд сүүлчээр байрлуулах болж, хонь үхрийн аж ахуйн өртөг нь харин тэргүүн байрыг эзлэх болжээ.

Арван гуравдугаар зууны үеийн Монголын мал аж ахуйн хэмжээ ба зүйл төрлийн талаархи байдал нь их төлөв дээрх мэт. Энэ нь мал аж ахуйн хөгжлийн нэгэн талын мэдээ болно. Нөгөө талаар мал аж ахуйн хөгжлийг үзэхэд түүний эзэгнэн хамаарах арга маягийг үзэх хэрэгтэй.

Тухайн үед Монголчууд тал дүүрэн бэлчсэн таван хошуу малтай байснаар үл барам, мал сүргээ эзэгнэн хамаарах аргын талаар ч нэлээд өндөр хэмжээнд хүрчээ. Үүний илрэл нь юуны урьд эл төрлийн малыг зүйл төрлөөр нь ас асад нь малждаг болжээ. “Нууц товчоон”-д адуучин, хоньчин, үхэрчин, тэмээчин гэдэг ажлын хуваарь байдаг нь үүнийг харуулж байна. Дараа нь Монголчууд бэлчээрийг тохируулж ашиглах талаар маш баялаг туршлагыг дүгнэжээ. “Тэд ... Өвлийн цаг хүрч ирэх үес даруй дулаавтар тал газарт нүүн, тэдний адуу малдаа нэгэн өвс ус хүрэлцэх газрыг эрэн суумуй. Зуны цаг болмогц бас нүүж, уулан доторхи сэрүүн тунгалаг бөгөөд ус бэлчээртэй, ...хөх түрүүгүй бөгөөд бус цус шимэгч хорт хорхойн зовлонгоос зайлан суумуй. Жич тэндээс хоёр гурван сарын дотор залгавар өндөр газарт өөдлөн явж, шинэ өвс бэлчээрийг эрмүй. Учир нь бараг зэргийн газрын өвс бэлчээр тэр их сүрэг малын тэжээлд үл хүрэлцэхийн тул болой” (“Марко Поло-гийн аяллын тэмдэглэл”). Гутгаарт малыг эдэлж хэрэглэх мэргэжил ба мал аж ахуйн ашиг шимийг боловсруулах мэргэжлийн талаар ч нэлээд өндөр хэмжээнд хүрчээ. Ан гөрөө бол тухайн үед Байгал далайн

хөвөө дагуу ба Енисей мөрний эхээр нутаглаж байсан “ойн иргэн”-ий гол аж ахуй нь болно.

Цул мал аж ахуйг эрхэлсэн малчид нь мал аж ахуйнхаа чөлөө зав буюу ан гөрөөний зохистой цагт ан гөрөө хийж байжээ. “Нууц товчоон” дахи “булгачин”, “хэрэмчин”, “загасчин” гэдэг тэмдэглэл бол эсгий туургатны доторхи нэг бүлэг тусгай ан гөрөөгөөр гол үйлдвэрлэлээ болгогсодыг хэлж байна. Энэ нь мал аж ахуйгаар гол болгосон “талын иргэн”-ий аж ахуйнхи нь нөхвөр бүрэлдэхүүн нь болж байжээ. Монголын морьт цэрэг ч дайн байлдааны завсар бас ан гөрөө хийдэг байна. Энэ нь аж ахуйн талаар нөхвөр үйлдлийг үзүүлэхийн хамт, цэрэг дайны талаар сургуулилийн үйлдлийг үзүүлдэг бөгөөд бас Монголчуудын нэгэн зүйлийн өвөрмөц хэлбэрийн наадам тоглоом болно. Энэ талын тэмдэглэл нэлээд олон бөгөөд нарийн байдаг. Бид ч дээр хэсгүүдэд өдий төдий танилцуулж өнгөрсөн тул энд дөхөм дурдаад өнгөрөө.

Монголын гар үйлдвэр

“Арван хоёрдугаар зууны үед Монголын нийгмийн үйлдвэрлэлийн хүч мэдэгдэхүйц хөгжсөн байв. Түүний түрүү нэгэн илрэл гэвэл, төмөр багаж хэрэгслийг үйлдэж чаддагт оршино” (Чжоу Цин Цзин: “Чингис хаан”). Энэ нь гар үйлдвэрийн хөгжлийг ахиулжээ. Тэр үед төмөрчин, модчин гэж тусгайлан төмөр модны үйлдвэрчин байсан бөгөөд тухайн үеийн Монголчуудын үйлдвэрлэл, амьдралд сүх, ооль, хөрөө, хутга, цүүц зэрэг төмөр багаж хэрэгслийг хэрэглэж байжээ. Дархад аймаг бол дархан олон гардаг байсан нь яриангүй. Монголчууд тэр үед нэлээд өргөн хэмжээгээр эсгий хийж чаддаг, арьс ширийг боловсруулж чаддаг, монгол гэрийг үйлдэж чаддаг бөгөөд бас тэрэг үйлдэх, хуяг дуулга, зэр зэвсэг үйлдэх, эмээл хазаарын хэрэгслийг үйлдэх, гэр зуураа багаж хэрэгслийг үйлдэх тусгай дархчуудтай байсан нь ч мэдээжийн хэрэг юм. Бас баяд язгууртадын хэрэглэх гар урлалын зүйлийг үйлдэх нэлээд өндөр мэргэжилтэй гар урчуудтай байсан байна. Жишээлбэл, Татарын Мэгүжин сүүлт, мөнгөн өлгий, тана эрдэнийн чимэгт хөнжлийг хэрэглэж байв. Шигихутуху багадаа алтан ээмэг дөрөвч зүүсэн ба булгаар доторлосон таж торгон элгэвч өмссөн байжээ. Ван хан бол алтан өргөөнд суудаг, алтан завьяа аяга хэрэглэдэг ба Ван ханы Идүргэн гэгч нэгэн элч нь алтан эмээлт хар морь унаж байсан юм. Ялангуяа Онгуд аймгийн хууч үлдэгдлээс үзэхүл, Монголчуудын барилгын мэргэжил ч маш өндөр хэмжээтэй байжээ (зурагт нүүр дэх зураг 54, 55-ыг лавлаарай). Чингис хаан гадагш дайж, Алтан улс, Тангуд улс ба Дундад Азиас олон тооны урчууд дархчуудыг авчирсан явдал нь Монголын гар үйлдвэрийг хөгжүүлэхэд идэвхтэй үйлдлийг үзүүлсэн нь яриангүй юм.

Монголын тариалан

Тухайн үед Монгол улс нь тариалан үйлдвэрлэлийг ч эрхлэж байжээ. Монголын тариалан нь голдуу Онгуд мэт дотор газар лугаа харилцаа явалцаатай байсан аймгуудад нэлээд хөгжиж байсан байна. Монголын тариалан нь маш их өвөрмөц онцлогтой байсныг одоо хуучны малтацаар нотолж болох юм (зураг 56). Хойд захын аймаг Мэргид тариалж байсан мэдээ буй. Чингис хаан 1206 онд улс байгуулсан хойно, “Үүд хавгастай, шавар хэрэмтэй иргэд” (тариачид)-ийг Шигихутуху-т соёрхжээ. 1212 онд шадар түшмэл Хингайг алтайн арын Абухан уул гэдэг газар томилж, атар халуун тариа тариалж байв. Энэ бол цэргийн тариалал буюу албаны тариалал болно.

46. Чингис хаан ба бичиг соёл – Хаант Монгол Улсын бичиг соёлын мэдээ

Чингис хааныг бичиг үсэг мэддэггүй гэж аль олон судалгааны мэдээ зэрэгт, тэмдэглэж байдаг бөгөөд аль олон эрдэмтэд, судалгаачид үзэж байдаг. “Хааны өөрийн бие нь ерөөс уншлага, бичлэгийг сураагүй, мөн ч өөрийн эх хэл – монгол хэлээсээ өөр ямар ч улсын хэлийг мэддэггүй” гэж Б.Я.Владимирцов тэмдэглэв. Хүмүүс энэ асуудалын тухай ер шинжлэл төрөөгүй, би ч мөн ингэж үзэж байсан аа. Гэвч бид эрхбиш мэдэх хэрэгтэй нэгэн зүйл гэвэл, Чингис хааныг бичиг үсэг мэддэг гэсэн тэмдэглэл ер байгаагүйн хамт, түүнийг бичиг үсэг мэдэхгүй гэсэн тэмдэглэл ч ер байгаагүй юм. Тиймээс Чингис хааныг үсэг бичгийн балай гэсэн дүн бол хүмүүсийн зүйлчилж жишсэн дүн болно. Энэ асуудлыг тус товчоонд дурдсан гол зорилго бол үүнтэй адил холбогдох хэдэн асуудлыг цаашид зөвлөхөд оршино.

Чингэвэл Чингис хаан үсэг бичгийн чухал ач холбогдлыг мэддэг үү? үгүй юу? гэвэл, мэддэг байжээ гэж хариулж болмоор байна. Жишээлбэл тэр 1204 онд Найманыг нэгтгэн авсан үед, Тататунгаа гэгч уйгур бичгийн хүнийг барьж авмагц: “Чи тус улсынхаа үсэг бичгийг сайтар мэдэх буюу?” (“Юань улсын түүх”, 124 дүгээр боть) гэж асуусан бөгөөд бас: “Уйгур үсгээр улсын үгийг бичихийг тайж олон ван нарт заан сурга хэмээн зарлиг болов” (дээрх ном) гэсэн тэмдэглэл байдаг. Энд дурдаж байгаа “Улсын үг” гэдэг нь яриангүй монгол үгийг хэлж байна. Гэтэл баахан мадагтай шиг нэгэн асуудал бол, тэрхүү “уйгур үсэг” гэдэг нь чухам Найманчууд уйгур үндэстнээс дам авч хэрэглэсэн Найманы үг аялгууд (энэ нь мөн ч яриангүй Монголын нэгэн нутгийн аялгуу болох юм)-ыг тэмдэглэж бүхий “уйгур үсэг” юм уу? эсхүл Тататунгаагийн эх хэл уйгур үндэстний хэлийг тэмдэглэж бүхий “уйгур үсэг” (хэрэг дээрээ бүр согд үсэг билээ) юм уу? гэсэн асуудал болно. Энэ асуудал бол эртний уйгуржин үсэг нь ганц Найманы үг аялгуунаар дамжиж ирсэн юм уу? эсхүл Тататунгаа 1204 оноос сая эхлэн өөрийн уйгур үсгээрээ монгол хэлийг шинээр тэмдэглэсэн юм уу? гэсэн асуудал болно. Энэ асуудал нь мөн Монголчууд хэдийд үсэг бичигтэй болсон явдалтай холбогдоно.

Чингэвэл монгол үндэстэн чухам хэдийгээс үсэг бичигтэй болсон тухай гол болох санал бол хоёр зүйл байна. Нэг зүйлийн санал бол 1204 онд Чингис хааны цэрэг Найманыг нэгтгэн авах үед Тататунгаа-г олзолсноос эхлээд, Монголчууд сая үсэг бичигтэй боллоо гэдэг. Энэ бол дотоод гадаадын аль олон эрдэмтдийн баримталсаар ирсэн бөгөөд хүмүүс ч тийм л байлгүй гэдэг санал болно. Түүний баримтлал гэвэл Тататунгаа-гийн тухай дээр дурдсан тэмдэглэлүүдэд суурилагджээ.

Энэ саналыг одоо бас нэлээд нарийн сүвэгчилж, гүнзгийрэн зөвлөцгөөж байна. Түүний зангилаа нь Тататунгаа чухам Чингис хааны хүүхэд дүү нарт бичиг үсэг заасан юм уу? Монгол үндэстэнд бичиг үсэг зохиож өгсөн юм уу? гэсэн асуудал болно. Энэ тухай монгол улсын алдарт эрдэмтэн, Монголын орчин үеийн бичиг соёлын ахмад зүтгэлтний нэг нь болох Ц.Дамдинсүрэн авгай: “Чингис хаан, Найман аймагтай байлдаж Тататунгаа-г олзолж аваад түүнээр хүүхэд дүү нартаа бичиг үсэг заалгасан тухай мэдээ Юань улсын судрын 124 дүгээр бүлэгт буй. ...Ганц энэ мэдээг баримталж Монголчууд арван гуравдугаар зууны эхэнд бичиг үсэгтэй болсон гэж хэлэлцдэг. Гэтэл Найман аймаг бол Монголын нэгэн аймаг бөгөөд хэдийд тэд нар бичиг үсэгтэй болсон тухай тодорхой мэдээгүй. Монголын баруун аймгууд

урьдаар бичигтэй болсон нь ер нь лавтай хэрэг юм” гэж түүний зохиосон “Монголын уран зохиолын түүх” гэдэг номдоо тэмдэглэжээ. Бас Өвөр Монголын Их Сургуулийн дэд профессор, үсэг бичгийн түүхийг тусгайлан судалж бүхий Бао-сян нөхөр: “Тататунгаа-д тулгарсан үүрэг бол уйгур үсгээр хэлийг тэмдэглэх л төдий байснаас биш, үсэг зохих үүрэг ерөөс тулгарсангүй байжээ” гэж тэмдэглэсэн юм. (“Монгол хэл утга зохиол” 1981 оны хоёрдугаар хугацаа). Эдгээр санал бол уулын суурь дээр нэг алхам гүнзгийрсэн нь илхэн байна. Тиймээс Тататунгаа-гийн тухай энэ мэдээ нь “Арвангуравдугаар зуунаас өмнө Монголд бичиг байгаагүй баримт болохгүй, гагцхүү түүхэнд анх тэмдэглэгдсэн мэдээ юм” гэж Ц.Дамдинсүрэн авгай бас тэмдэглэжээ.

Нөгөө нэг зүйлийн санал бол, Монголчууд үсэг бичигтэй болсон цаг бол 1204 оноос өмнө гэж үздэг байна. Энэ “өмнө” гэдэг нь чухам хичнээн урт хугацаа болох тухай бодтой баримт хараахан үгүй бололтой. Зүйчилж жишсэн санал гэвэл их төлөв ийм хэдэн зүйл буй: Нэг зүйлийн жишилт бол, Найман зэрэг баруун аймгууд хэдийд уйгур бичгийг авч хэрэглэсэн цагаар зааглах санал, гэтэл Найман чухам хэдийд үсэг бичигтэй болсон нь тодорхойгүй болохоор, Монголын бичиг үсэгтэй болсон нь тодорхой цаг нутлагдаагүй хэрэг. Энэ бол Ц.Дамдинсүрэн авгайн гол санал болно. Бас нэг зүйлийн жишилт бол, “манай улсын үсгийн тухай өгүүлбээс баруун Европ нийтээр хэрэглэн буй латин үсэгтэй адил эртний үсэг арай бус, монгол бичиг судрын зүйлийг хянан үзвээс “Алтан товч” хэмээх сударт Бодончар мэргэнийг Сүн төр лүгээ зохицож, бичгийн эрдмийг туулвай хэмээн тэмдэглэсэн нь, Бодончарын үеийг нэхэн бодвоос аравдугаар зууны үе оногдох болой. Тэр үес Уйгур улс нэгэнтээ монгол нутагт орших улс бөлгөө... Хоёрт хэл нь Монгол лугаа төрөл, гуравт хагас суурьшсан, хагас нүүдлийн байдалтай, ан зан монгол лугаа нэн ойр учир, уйгур хэлд тохирсон үсгийг монголоор тэмдэглэхэд дөхөмтэй учир, Уйгураас үсэг авч улмаар боловсруулан монгол үсэг болгосон нь, Уйгур улсын соёл төр мандах цагийн явдал болохоос бус, Уйгурын төр мөхөж соёл бууран хөсөрдөхийн үед мөхсөн улсын сөнөсөн соёл, гээгдсэн үсгийг Монголчууд авч хэрэглэх ёсгүй байна” гэдэг. Энэ бол монгол улсын одоо үеийн эх бичгийн хүн алдарт эрдэмтэн профессор доктор Б.Ринчиний хэлсэн үг болно. (“Монгол үсгийн гарал хөгжил”, “Монгол түүх хэл бичиг”-ийн 1958 оны тавдугаар хугацаа). Бас “Манай тооллын аравдугаар зууны хавиар Монголчуудын түрэгжих явцад уйгуртай зэргэлдээ бөгөөд нийгмийн аливаа талаар нягт харьцаатай байсан нэгэн монгол аймаг нь хамгийн тэргүүнд уйгур бичгийг авч монгол хэлэндээ тохируулан хэрэглэсэн байж болох юм” гэж Бао-сян нөхөр үзжээ. Эдгээр саналууд улам нэг алхам гүнзгийрч, цагийн хязгаарыг аравдугаар зуунаар жишжээ.

Эдгээр жишилтийг би хувьдаа зүйтэй гэж үздэг. Учир нь:

(1) Чингис хаан бичиг үсэг мэддэг гэсэн тэмдэглэл үгүй боловч, тэр нь бичиг үсгийн тухай мэдлэгтэй гэсэн тэмдэглэл байхыг дээр дурдаж билээ. Чингис хаан бичиг мэддэггүй ч болтугай, харин түүний дэргэд бичиг мэддэг хүн байсан нь Нууц товчоон зэргэд тэмдэглэлтэй юм. Жишээлбэл 1206 онд, Чингис хаан улс байгуулсан тэр үед Шигихутуху-г бүх улсын их заргач болгоод, шийтгэсэн зарга бүхнээ “Хөх дэвтэрт бичиж дэвтэрлэгтүн” гэж зарлиг болж байжээ. Үүнээр үзэхэд, Шигихутуху бичиг үсэг мэдэхээр барахгүй, хууль цаазыг тэмдэглэж чадах хэр хэмжээтэй байна. Хэрвээ 1204 оноос хойш Тататунгаа үсэг бичгийг зохиогоод Шигихутуху нар сурсан бол хоёрхон жилийн дотор, дайн байлдааны нөхцөл

доороос энэ хэмжээнд хүрнэ гэдэг нь үнэхээр сэтгэгдэшгүй хэрэг юм. Бас нэгэн зүйлийн явдал бол баахан сонихон шиг санагдуулдаг юм. Тэр нь Тататунгаа-г барьж авсан тэр даруйхан “Аливаа бичиг явуулахад хэрэглэхээр тэр тамгыг мөнхүү Тататунгад тушаав” (“Нууц товчоон”, Ц.Дамдинсүрэнгийн одоочлого, 163 дугаар нүүр, Юань улсын түүх, 124 дүгээр боть) гэсэн үед бүх монгол нь яриангүй үсгийн балай улс болох ёстой. Тийм бол энэ “Аливаа бичиг”-ийг хэнд явуулах буй? Хэн түүнийг нь мэдэх буй? гэсэн сэжгийг арга үгүй төрүүлнэ. Чингис хаан ч өөрөө “Далайн хаан”-ы тамгатай боллоо гэдгийг дээр нэгэнтээ дурдсан билээ. Үүнээс гадна, Монголын цэрэг Хорезмд байлдаж байх үед, 1220 оны 6 сарын 5-ны өдөр, Зэв ноён Нишاپур хотод очоод “уйгур үсэг”-ээр бичсэн Чингисийн зарлигийг уншиж байлаа гэдэг (Д’Оссон). Бас 1222 онд Чингис хаан Сүн улсын Бумбын шашны бясалгагч Чан-чунь арш Цю Чу Цзи гэдэгтэй уулзаж ярилцахдаа: “Аршийн энэ үг хаан миний бодол лугаа яг нийлэлцжээ” гэж баярлан хэлээд дэргэдэх хүмүүсээ уйгур үсэг (энэ нь даруй уйгуржин монгол үсгийг хэлж буй - эшлэгч)-ээр бичиглэж авсугуй гэж зарлиг болов” гэсэн тодорхой тэмдэглэл байдаг. (Чан-чунь аршийн “Баруунш зорчсон тэмдэглэл”). Харамсалтай нь энэхүү “уйгур үсэг”-гийн тэмдэглэл нь түүхийн гүн далайд живэн замхарчээ. Манай үе болтол хадгалагдаж ирсэн “Чингисийн чулууны бичиг” (буюу “Есөнхэ мэргэний хөшөөний бичиг”) гэдэг монгол үндэстний бичиг соёлын түүхэнд өнөд баларшгүй нэгэн чухал дурсгал бол мөн Чингис хааныг амьд сэрүүн байх үе 1225 онд сийлэгдсэн юм. Чингис хаан энэ үед үсэг бичгийн ерийн мэдлэгтэй байснаар барахгүй, харин чулуун дээр сийлж өнөдийн дурсгал болгох тусгай мэдлэгтэй байсныг нь тэрхүү боржин чулуу бодтой гэрчилж байна.

(2) Үндэстэн нийтэд үсэг бичиг зохиох явдал, ялангуяа түүнийг боловсруулж дүрэмжүүлэх явдал бол тийм хялбархан явдал биш, нэн ч хэдэн жил буюу хэдэн арван жилийн дотор биелэгдэх явдал огт биш гэдгийг эрт ба өдгөөгийн аль олон улс үндэстний бичгийн түүх цаглашгүй гэрчилж байна. Бид өөрийг хэлэх хэрэг үгүй, зөвхөн өөрийнхөө түүхийг үзвэл мэдэж болох юм. Жишээлбэл, Хубилай сэцэн хаан 1269 онд Пагба ламаар монгол дөрвөлжин үсгийг зохиолгож, бүх улсад хааны зарлигаар нийтлэн, хүчирхэг их Юань улсын эд бодос ба төрийн аливаа багажаар түшиг болгож, түүнийг түгээмэлжүүлэхээр зуугаад жилийн урт хугацаагаар оролдоод эцэстээ ялагджээ. Зая бандид 1648 онд уйгуржин монгол бичгийн суурь дээр тод үсгийг зохиосноос нааш одоо гурван зуун гучин хэдэн жил болж байна. Гэтэл тэр нь ойрад аймгийнхаа бяцхан хүрээг шувталж чадсангүй. Түүхэн байдал ийм байснаар барахгүй одоогийн байдал ч ийм байна.

“Их Монгол Улсын Далайн хааны тамгын бичиг”, “Чингисийн чулууны бичиг”, ялангуяа Чингис хааныг нас барснаас хойно арван гурван жил (зарим хүмүүс бас нэг л жил гэж үздэг)-гийн дотор зохиогдсон, одоо дэлхий даяарт монгол үндэстний түүх, уран зохиол, хэлний судлалын ноён оргил гэж үнэлэгдсэн, монгол соёлын өнөд баларшгүй хөшөө бологч “Монголын нууц товчоо” мэт бичиг соёлын түүхнээ холбогдох чухал дурсгалт зүйлүүдийг саяхан үсэг бичигтэй болгосон үндэстэн бүтээж гаргалаа гэхэд мөн ч сэтгэгдэшгүй юм. Үүнийг доктор Б.Ринчин бас: “Монгол бичиг үсгийн нэн эртний дурсгалын зүйлд ч чингэж самууран мунгинах нэг зүйлийг үзвээс, хэрхэвч монгол үсэг арван гуравдугаар зууны үес, Тататунгаа хэмээгч уйгур ганц хүнээр заалган, монгол улс даяарт тийм сүрхий нарийн дүрэм бүхий бичгийг агшин зуур боловсруулсан хэмээхэд итгэхүйеэ түмэн бэрх” гэж тэмдэглэжээ.

(3) Одоо нэлээд суурьтай шиг нэг санал гэвэл, Монголчууд Уйгураар дамжин согд үсгийг авч

(орчимд Монгол улсын Ц.Шагдарсүрэнгийн зохиосон “Монгол үсэг зүй” гэдэг номд уйгураар дамжсангүй гэж дурдсан нь баахан сонирхолтой зүйл байна), өөрийн хэлдээ тохируулан хэрэглэсэн нь, уйгуртай харьцаа холбоотой байсан зарим аймгууд, Ц.Дамдинсүрэн авгайн үзэлтээр бол Найман, Дөрвөд, Торгууд зэрэг аймгууд урьдаар авч хэрэглээд дараа нь бүх монголд түгээмэлжжээ гэдэг санал болно. Цагийн талаар авч үзвэл их төлөв аравдугаар зууны үеэс эхэлж, арван гуравдугаар зууны үе болоход бүх монгол үндэстний нэгдэлтэй үсэг бичиг-эртний уйгуржин монгол үсгийн шатанд шилжин орсон мэт. Үүнийг бас хуучин монгол үсэг гэдэг. Энэхүү хуучин монгол үсэгт торгууд хэлний нөлөө байх бололтой гэж Ц.Дамдинсүрэн авгай хэлний шинжлэлийн талаар тайлбарлаж байжээ. Энэ торгууд бол “Түрэгүүд” гэсэн үгийн хувирал ба Ван ханы хойч гэж би тус товчооны гуравдугаар бүлэгт хэрэйдийн тухай сэдэвт дурдаж өнгөрсөн билээ. Энэ нь Ц.Дамдинсүрэн авгайн тайлбартай ямар нэгэн дотоод харьцаатай байж мэднэ.

Энэхүү урьдаар хэрэглэсэн аймгуудад юуны урьд найман аймаг багтаж байсан тухай үндсэндээ санал зөрөөнгүй байдаг. Одоо би нөхвөрлөн дурдая гэж байгаа нэгэн зүйлийн санал бол, уйгур үсгийг урьдаар авч хэрэглэсэн монгол хэлтэн аймгийн дотор Найманы дараа Онгуд аймаг бас багтах ёстой гэж үзэж байна. Учир нь нэгд, Онгуд аймаг бол түрэг гарлын аймаг гэдэг болохоор Уйгур, Наймантай зан заншил, шашин шүтлэг, хөгжил дэвшлийн талаар нэлээд адилавтар байв. Хоёрт, Онгуд нь Цагаан хэрэм дагуу нутаглаж байсан болохоор нэлээд эртнээс соёлт үндэстнүүдийн нөлөөг хүлээж, үсэг бичгийн тухай мэдлэгийг Монголын бусад аймгуудаас урьдаар бүрэлдүүлсэн байх ёстой. Гуравт, Онгуд аймаг нь уйгур үндэстэн, ялангуяа найман аймаг лугаа нягт харилцаатай байжээ. Дөрөвт, Онгуд аймаг нь монгол хэлтэн аймгуудын дотроос аж ахуйн талаар хамгийн давшсан нэгэн аймгаар тооцогдож байжээ. Эдгээр зүйл бол Онгуд аймгийн урьдаар уйгур үсгийг авч өөрийн аялгуундаа тохируулж хэрэглэхийн бодослог ахуйн нөхцөл болно.

Энэхүү бололцоо нь түүхэн үнэн хэрэг болсныг одоо археологийн ололтоор гэрчилж байна.

Археологийн баримт нэг

“Төр захирагч гүнжийн гуулин тамга”

1979 оны 8 сард Өвөр Монголын төв Хөх хотод хуралдуулсан Дундад улсын монгол түүхийн эрдэм шинжилгээний нийгэмлэгийг байгуулах хуралдаан дээр Өвөр Монголын археологийн аймгийн Дин Сюань Юнь нөхөр “Төр захирагч гүнжийн гуулин тамгын тухай магадлалт тайлбар” гэдэг өгүүллийг дэвшүүлжээ. “Төр захирагч гүнжийн гуулин тамга” гэснийг дорозш “Гүнжийн тамга” гэж товчлов.

Тус өгүүлэлд тайлбарласан тамгыг 1958 онд Өвөр Монголын өөртөө засах орны Даланхар уулын ар дахь У Чуань Сянь-ий Дун То Чэн (Зүүн Шороо хот) нэгдлийн У Цзя Цунь (Таван хар тосгод) гэдэг газраас олжээ (Зураг 11). Энэ газар бол яг эртний онгууд аймгийн нутаглаж байсан газар болно. Ойр орчим нь Алтан улс буюу Юань улсын үеийн хот балгасын суурь ба хуучин булш онгон зэрэг байжээ.

Тус тамга бол уртаараа 10.8 см, өргөнөөрөө 10.7 см хэмжээтэй шар гуулин тамга болно. Тамга дээр нь хөрвийлгэн сийлсэн арван дөрвөн хятад жидир үсгийг гурван мөрөөр

байрлуулжээ. Төв дунд нь хоёр уйгуржин монгол үсгийг зэрэгцүүлэн сийлжээ. Хятад үсгийг нь “Төр захирагч гүнж бөгөөд голын умардын ерөнхийлөн захирах зарлигийн элчийн тамга” гэж Дин Сюань Юнь нөхөр уншин тайлбарлажээ. Монгол үсгийг нь Өвөр Монголын Их Сургуулийн Түүх судлах тасгийн Иринчин нөхөр магадлалт хийж, хятад үсэгтэй нь харьцуулан үзэхүл бараг “Ерөнхийлөн захирагчийн тамга” гэсэн үг бололтой гэжээ. Энэ тамгын хятад үсэг нь нэлээд тодорхой боловч монгол үсэг нь тун балархай, танигдахуйяа бэрх байв. Үүнийг үзэхүл тамгыг үйлдсэн хүн нь монголыг нь мэддэггүй, их төлөв дууриан үйлдсэн байж ч мэднэ. Хэрвээ үүнийг дараа дурдах баримттай харьцуулж үзвэл харин хоёрдугаар үсэг нь “тамга” гэсэн хятад үсгийн авиачлал “ина” (ян) болох нь дэмий сэжиглэлгүй гэж хэлж болмоор байна. Түрүү үсгийнх нь дүрсээс үзэхүл, харин “хаса” (хас) мэт байдалтай. Баахан сүүлчийн үед, жишээлбэл Саган сэцний “Эрдэнийн товч”-д “хасбуу тамга” гэдэг тэмдэглэл байдаг. Харин Монголчууд эрт дээр үедээ хааны тамгыг ингэж нэрлэж байсан ч магадгүй. Тиймээс энэ нь “хас ина” (хас ян - хас тамга) гэсэн үг болох болов уу гэж би үзэж байна.

Чингэвэл энэ тамга нь аль үеийн, хэний тамга буй? Дин Сюань Юнь нөхрийн тодолсныг үндэслэвэл, энэ нь 1207 онд Онгудад мордуулсан Чингис хааны охин Алага бэхи 15-гийн тамга болно. Тэр хэдийд “төр захирав” гэвэл, 1219 оноо Чингис хаан баруунш Хорезмыг дайлах үед “Гүнж Алага бэхи, хааны дүү Отчигин ноёноор тус тус говийн өмнө умрын төрийг хэргийг захируулахаар тушаажээ” (“Ту Цзи-гийн тэмдэглэл”, 3 дугаар боть) гэсэн тодорхой тэмдэглэлтэй юм. Алага бэхи гүнж төр захирсан тухай “Юань улсын түүх”-д хэдийгээр тэмдэглэл байдаггүй боловч, “Төр захирагч гүнж”-ийн үйл явдлын тухай хэд хэдэн тэмдэглэл байдгаар барахгүй, Чингис хааныг баруунш дайлан үед ч Алага бэхи-г “Төр захирагч гүнж” гэж нэрлэдэг байжээ. Энэ тухай өөр тэмдэглэлүүд ч нотолж байна. Жишээлбэл, 1221 онд Яньцзин хотод ирсэн өмнөд Сүн улсын элч Чжао Хун, “(Чингис хааны) хоёрдугаар гүнж нь Алихай баян (А-ли-хай) (энэ нь “Нууц товчоон”-д дурддаг А-ли-хай Бай-инь-ийг хэлж байна – эшлэгч) буюу ердөө Бижи (энэ нь бас “бэхи” гэсний хувирал болно – эшлэгч) хатан гэдэг. Тэр нь Алтан улсын үрэгдсэн түшмэл Бай Сы Бу (энэ нь Онгуд аймгийн түрүү Алахуши Дигит Хури-гийн ахмад хөвгүүн Буяншибал – (Бу-янь Ши-бань) гэгчийг хэлж байна - Ту Цзи-гийн тэмдэглэл) гэгчид мордоод, одоо бэлэвсэн болсон бөгөөд цагаан Татар (Онгудыг хэлж буй – эшлэгч)-ын улсын хэргийг захирч байна” гэж “Монголын Татарын тухай бүрэн тэмдэглэл” гэдэгтээ тэмдэглэв. Бас “Хүргэн Гуа Тан Чжун Сянь вангийн хөшөө”-д Алага бэхи-г “Гүнж бол сэцэн мэргэн бодлоготой, хаан ийш тийш аян дайнд морилохуйд төр улсын их засгийг зөвлөн захируулахаар үлдээдэг тул их цэрэг эргэлзээгүйгээр явахуйд гүнжийн гавьяа бага бус” гэж сайшаан тэмдэглэж байна.

Эдгээр тэмдэглэлүүдийг үндэслэвэл, энэ тамга нь яриангүй 1207 оноос 1219 оны хооронд үйлдсэн тамга болох бөгөөд “Чингисийн чулууны бичиг”-ээс бас өмнөх дурсгалт зүйл болно. Түүнчлэн энэ тамганд хэдийгээр хоёрхон монгол үсэг байдаг боловч, энэ үед онгуд аймаг нь уйгуржин монгол үсгийг ямар нэгэн хэмжээнээ хэрэглэж байсныг гэрчилж байна.

Археологийн баримт хоёр – “Зарлигийн элчийн бао”

Энэ тамгыг мөн онгуд аймгийн эртний нутаг Чжао вангийн хот - одоогийн Өвөр Монголын өөртөө засах орны дархан Муу мянганы хошууны Дүүрэн овоо нэгдлийн “олон сүм” (Чжао

вангийн хотын орыг сүүлчийн үед лам нар ингэж нэрлэжээ)-ээс зүүн өмнө арван км зайтай байх “Ширэгүү” гэдэг газраас 1976 оны хавар, Цагаан овоо нэгдлийн есөн настай хүүхэн Алтанхуар олж авчээ.

Энэ тамга урт, өргөнөөрөө 9.8 см шахам, их төлөв ам дөрвөлжин хэмжээтэй хүрэл тамга болно (зураг - 12). Тамгын үсэг нь хятад монгол хоёр зүйл, хятад нь “Шуань-чай Гуй-со Цзи-инь” гэсэн зургаан жидир үсгийг баруунаас зүүнш тамгын хоёр хөвөөгөөр байрлуулжээ. Энд дөхмийг бодож, Монголоор “зарлигийн элчин бао” гэж нэрлэлээ. Хятад үсгийн дунд нь хоёр мөр уйгуржин монгол үсгийг мөн хятад үсгийн мөрлөх ёсоор баруунаас зүүнш бичиглэжээ. Онцгойлон тэмдэглүүштэй нь нэгдүгээр баримтын хоёр үсэг ийм биш, тэрчлэн эртний уйгур үсэг болон монгол үсэг бүр дээрээс дорогш, зүүнээс баруунш бичиглэдэг юм. Тиймээс энэ нь бичиглэсний ташаа биш, харин тамгыг үйлдсэн хүн нь монгол бичиг мэддэггүйгээс болсон бололтой. Тус тамгын уйгуржин монгол үсгийг миний анх алхам уншсан дүн бол: “соншай гүй соо бао ина” гэсэн таван үсэг болох мэт. Одоогийн бичлэгээр бол: “Сюань-чай Гуй-со Бао-инь” болно. Энэ бол тамгын хятад үсгийг бараг тэр хэвээр нь авиачлан орчуулсан нь илэрхий байна. Хятад монгол үсгийг мөн “гүнжийн тамга”-тай адил хөрвийлгэн сийлжээ. Дээр бид “гүнжийн тамга”-ын хоёр уйгуржин монгол үсгийг “хас ина” (хас тамга) гэж жишсэн билээ. Энд харин “baо ina” (эрдэнэ тамга) гэжээ. Сүүлчийн үед энэ хоёрыг нийлүүлээд “хасбуу” нэрт тамга (“Эрдэнийн товч”, сударчилсан хэвлэл, 63 нүүр) буюу “хасбуу тамга” (дээрх номын 102 нүүр) гэж нэрлэж байжээ. Ялангуяа “Хар Татарын тухай хэргийн товч” дахи “гэдний тамга нь: зарлигийг тунхаглах эрдэнэ гэсэн тулгарын үсэг сийлсэн гурван ямх илүү тэгш дөрвөлжин тамга юм” гэсэн тэмдэглэл нэн чухал байна.

Чингэвэл энэ тамга чухам аль үеийн хэний тамга болох гэсэн асуудал тавигдана. Энэ асуудлыг шууд тэмдэглэсэн материал хараахан харагдаагүй. Тиймээс маш оновчтой хариу өгөхөд мөн ч бэрх асуудал юм. Гэвч би эл талын байдлыг задалж үзээд энэхүү “зарлигийн элчийн бао” тамга бол мөн ч “гүнжийн тамга”-тай бараг адил нэгэн үед, бодтойгоор хэлбэл 1207 оноос 1211 он (энэ бол Алтан улсыг дайлсан он)-ы хооронд үйлдсэн тамга болох болов уу гэж үзэж байна. Учир нь:

(1) Энэ хоёр тамгын олдсон газар нь бүр Онгудын нутаг болно. Тиймээс энэ тамга нь хэлэлгээнгүй энэ газар хэрэглэж байжээ. Онгудад тамга хэрэглэж байсан тухай “Юань улсын түүх” дэх тэмдэглэл бол Юань улсын Өлзийт хаан (Чэнцзун) 1295 онд Хубилай хааны их орыг залгамжласны дараа, Онгуд аймгийн түрүү Алахуши Дигит Хури-гийн жич хөвгүүн Хүрхист Гао Тан Ван цол өргөмжилж алтан тамгыг шагнажээ. Энэ нь олон ван нарт шагнах тогтоолоор араатан бариултай алтан тамга болох бөгөөд тэр нь хэрвээ монгол үсэг байсан бол заавал Пагба-гийн зохиосон дөрвөлжин үсэг байхаас биш, уйгуржин монгол үсэг байх ёсгүй. Учир нь тэр үед дөрвөлжин үсгийг албан ёсоор хэрэглээд хорин зургаан жил болжээ. Онгуд аймагт тамга хэрэглэж байсан өөр нэгэн бодтой мэдээ бол нэгдүгээр баримтад танилцуулсан “Гүнжийн тамга” болно. Тиймээс энэ тамга нь “Гүнжийн тамга”-тай нэгэн үе болохоос биш, Хүрхисийн тамгатай нэгэн үеийн биш.

(2) Энэ “Зарлигийн элчийн бао” тамга нь “Гүнжийн тамга”-тай хэлбэрийн талаар бараг бүр адил гэж хэлж болмоор байна. Нэгд, тамгын гадар байдал, үйлдсэн хэлбэр жич материал нь адил байна. Хоёрт, хятад үсгийн тиг нь бүр адил байна. Үүнийг хятад үсгийн есөн нугалааст

жидир үсэг гэдэг юм. Ийм хэлбэрийн эвхмэл үсэг бол Сүн улсын үеэс эхэлж, Юань улсыг дуустал дэлгэрч байсан юм. Гуравт, үсгийг байрлуулсан хэлбэр нь адил байна. Бүр хоёр талаар нь (буюу дөрвөн талаар нь) хятад үсэг, дунд нь монгол үсгийг байрлуулжээ (сүүлчийн үеийн тамга бол Монголыг нь зүүн талд нь Хятадыг нь баруун талд нь байрлуулдаг). Тус тамга бол хоёр төрлийн үсгийг хавсруулан хэрэглэсэн тамгын эхлэлт бөгөөд ууган хэлбэр байж мэднэ.

(3) Агуулгын талаар бас адил тал байна. Хоёр тамганд бүр Сюань Чай гэсэн агуулгыг багтаажээ. Энэ хоёр үсгийг Дин Сюань Юнь нөхөр “Монгол Татарын тухай бүрэн тэмдэглэл”-ийг үндэслэж, түүний утга нь манай байнга хэлдэг “зарлигийн элч” гэсэнтэй тэнцэх юм гэжээ. Уг тэмдэглэл нь: “Татарчууд элчинд гарагсадаа Сюань Чай (зарлигийн элч) гэнэ. Хааны дэргэдээс буюу Го ван (Мухулайг хэлж буй - эшлэгч)-гийн дэргэдээс ирэгсэдийг өнгөрөх газрын чжоу, сянь хийгээд цэргийн түрүү захирал нар, ирэгсэдийн зэрэг тушаалын эрхэм доодыг асуулгүй тэн сацуугаар хүндэлдэг. Ирэгсэд сарт зэвсгийн үүдээр өнгөрч, чжоу сянь-ий тинхимийн дээд суудалд суумуй” (“Монгол Татарын тухай бүрэн тэмдэглэл”, монгол хэвлэл, 93 нүүр, орчуулгыг нь баахан засав) гэжээ. “Чан-чунь аршийн баруунш зорчсон тэмдэглэл”-д Цю Чу Цзи-г хамгаалан буцсан Ян А Гоу-г зарлигийн элч гэжээ. Хааны зарлигаар томилогсодыг ингэж нэрлэдэг нь тодорхой байна. Чингис хааны гүнж Алага бэхи мөн Чингис хааны зарлигаар “Голын умардыг ерөнхийлөн захирах умардын элч” байжээ. Тиймээс “Го ван Мухулай боловч урьдаар мэдүүлэн зөвлөж, дараа нь сая хийдэг” (“Ту Цзи-гийн тэмдэглэл”, 36 дугаар боть, 2 нүүр).

“Зарлигийн элчийн бао” тамгыг эзэмшсэн тушаалтан чухам ямар ажлыг эрхэлдэг буй? Миний үзэхээр, энэ элчийн тушаал бол “Гуй Цо” гэдэг хоёр үсэгт гол агуулагдаж байна. Түүх шастирыг шүүж үзэхүл, үнэхээр ийм нэгэн албан байгууллага ба албан тушаал байжээ. Жишээлбэл “Алтан улсын түүх, түшмэдийн тэмдэглэл” (4 дүгээр дэвтэр, 1244 нүүр)-д: “Тохируулан хянагч түшмэл” гэдэг нэгэн жинхэнэ долоон дэсийн тушаалтан байдаг. Энэ нь гурван захиралынхи нь нэг тушаалтан болно. Бас “тохируулагч түшмэл, жинхэнэ долоон дэстэн тариалангийн услалтыг эрхэмлэмүй” (“Алтан улсын түүх”, 1322 нүүр) гэдэг тэмдэглэл байдаг. Дээр нэгэн жишээ бол “Юань улсын түүх”-ийн тэмдэглэл болно. Энэ нь Чжи Юань-ий хорин хоёрдугаар он (нийтийн он тооллын 1285 он)-ы хоёрдугаар сард, “Төв бичгийн мужийн түшмэл Лу Ши Чжун хаанаа айлтгаж, тохируулах газар байгуулахыг гуйчлав. Энэ газар болбоос тавдугаар дэсийн зэрэгтэй, амуу хүнс цалин зоосыг эзэгнэх үүрэгтэй тул хэрэглэх түшмэдийг цагаан ястнаар хязгаарлахгүй, арилжаа худалдаад чадамгайг гол болгомуй хэмээв. Хаан зөвшөөрөв” (“Юань улсын түүх”, 13 дугаар боть, 274 нүүр) гэсэн тэмдэглэл болно. Гэвч энэ хоёр тэмдэглэл манай баримттай дэмий холбогдолгүй гэж би үзэж байна. Учир нь манай энэ тамгын эзэн хэрвээ Алтан улсын түшмэл болоход хүрвэл, Алтан улсын тамгад, монгол үсэг бичих хэрэгцээ огт үгүй гэж хэлж болмуй. Дээр дурдсан Алтан улсын тэр “тохируулагч түшмэл” бол Цзин Чжао Фу, Яо чжоу, Сань Бай Цюй (бүр одоогийн Си Ань хот орчим буй) гурван газрын албан хэргийг тохируулдаг байна. Ялангуяа тамгын хэмжээ ч Алтан улсын тогтоолтой таарахгүй юм. Жишээлбэл, Алтан улсын долоон дэсийн түшмэлийн тамгын хэмжээ нь нэг ямх хоёр хувь, хүнд нь арван зургаан лан, гуулиар үйлддэг (“Алтан улсын түүх” (4), 1337 нүүр). Харин манай энэ тамга гурван ямх байх тул Пэн Да Я-гийн тэмдэглэлтэй тохирч байна. Чингэвэл тэр нь Юань улсын “тохируулах газар”-ын түшмэл үү? Гэвэл арай бас тийм биш байна. Юань улсын үеийн

энэхүү “тохируулах газар” гэдэг нь 1285 оны 2 сард, Шанду хот (Юань улсын дээд нийслэл - одоогийн Өвөр Монголын Шулуун хөх хошууны төвөөс зүүн хойш хориод км зайтай байдаг зуун найман сүм)-д байгуулагдсан бөгөөд 4 сард нь энэ газрыг эрхэмлэн байгуулсан төв бичгийн мужийн баруун гарын түшмэл Лу Ши Чжун-ы хийсэн зусар зальхай ажиллагаа нь илчлэгдэж, 11 сард нь алах ялаар шийтгэгдсэн билээ. Ингээд энэхүү “тохируулах газар” гэдэг нь ч эцэслэсэн бололтой, дахин ер дурдагдаагүй. Тиймээс энэ газарт тамга үйлдэж завдсан эсэх гэдэг нь бас ч тайлагдаагүй нууц юм. Тамгатай байснаар бодсон ч, Пагба үсгийн тамга байж болохоос биш, уйгуржин монгол үсэгтэй тамга байвал хуулийг зөрчсөн явдал болно.

Энд би нэг Алтан улс, нэг Юань улсын жишээг татсан зорилго бол энэ тамга Алтан улсын үеийнх ч биш, Юань улсын үеийнх ч биш, харин Чингис Хаант Монгол Улсын үеийн эд болохыг дам тодорхойлох бөгөөд тэр “Гуй Цо” гэдэг хоёр үсгийн утгыг тодорхойлохоор зорьсон юм. Үүнээс үздэг бол энэ “Гуй Цо” гэдгийг “тохируулах” гэж орчуулж болох мэт. Тэр нь Алтан улсын мэт тарианы услалтыг тохируулж байна. Юань улсын мэт амуу будаа цалин зоосыг тохируулж болох бөгөөд өөр ямар нэгэн алба гувчуур, гааль татвар зэргийг ч бүр тохируулж болно. Ингэвэл “Шуань чай гуй со цзи инь” гэснийг “тохируулах зарлигийн элчийн тамга” гэж орчуулж болох мэт. Энэ түшмэл нь Чингис хааны зарлигаар Онгуд аймагт ямар нэгэн тусгай үүрэг (Алтан улсыг дайлах явдлыг бэлтгэн тохируулж байсан ч магадгүй)-ийг гүйцэтгэж байсан зарлигийн элч болох нь илхэн байна.

Багцлаад хэлбэл, энэхүү “Тохируулагч зарлигийн элчийн бао” бол Дин Сюань Юнь нөхрөөс мэдээлж өнгөрсөн “гүнжийн тамга” лугаа адил үед үйлдэгдэж, адил газар, адил зорилгоор хэрэглэгдэж байжээ. Хэрвээ энэ хоёр тамгыг ингэж үздэг бол, онгуд аймаг уйгуржин үсгийг урьдаар авч хэрэглэсэн аймгийн нэгэн болохыг гэрчилж болох бөгөөд монгол үсэг бичгийн тухай одоо хүртэл хадгалагдаж бүхий Юань улсаас өмнөх хэдэн баримтуудын дэс дараалалыг доорхи мэт тохируулж болно:

(1) “Их Монгол Улсын далайн хааны тамга”, 1204 оноос 1206 оны хооронд үйлджээ (зураг - 14).

(2) “Гүнжийн тамга” ба “Зарлигийн элчийн бао”, 1207 оноос 1219 оны хооронд үйлджээ (зураг - 11,12).

(3) “Чингисийн чулууны бичиг” (буюу “Есүнхэ мэргэний хөшөө”), 1225 онд үйлджээ. Тус хөшөө одоо Ленинград хотод буй (зураг - 10).

(4) “Арван зүгийн их Цзы Вэй Гун ордон дахи зарлигийн хөшөө”, 1240 онд үйлджээ. Хөшөө нь Хэнань мужийн Цзий Юань Сянь-д буй (зураг - 57).

(5) “Шагимунигийн хүрээлэнгийн хөшөө тэмдэглэл” (буюу “Мөнх хааны гэрэлт хөшөө” - Хөшөөний бичээст Мөнх хаан гэсэн үсэг байснаар Намнандорж авгай ингэж нэрлэжээ), тус хөшөөг 1257 онд үйлджээ. Одоо Монгол улсад буй (зураг - 58).

(6) “Амудулла вангийн мөнгөн пайз”, энэ пайз чухам хэдийд үйлдэгдсэн нь тодорхой тэмдэглэлгүй. Үүнийг “Амудулла”-гийн пайз гэсэн нь энэхүү хоёр талдаа үсэг бүхий пайзын ар тал дахи түрүү нэгэн мөрийн “Амудулла” гэсэн үсгээр жишилт болгожээ. Үнэнхүү

“Амудулла ван”-гийнхи мөн бол, тэр нь Юань улсын хоёрдугаар хаан Төмөрийн үе лүгээ холбогдоно. Гэтэл тэр үед цул уйгуржин үсгээр пайз үйлдэх нь баахан сонирхолтой мэт. Ингээд би Амудулла вангийн товч гаралтай нь хамт хяналт болгож тэмдэглэв. Энэ Амудулла ван бол Өгөөдэй хааны жич хөвгүүн нь юм. Түүний өвөг эцэг нь Мири гэдэг, Өгөөдэй хааны долдугаар хөвгүүн нь болно. Тэр нь Мөнх хааныг өргөмжлөхийг дэмжсэн гавьяатан болохоор Эрчис мөрөн хавийн газрыг хувьдан өгчээ. Сүүлд нь түүний хөвгүүн Тоху (Амудулла-гийн эцэг) Хубилай хаанаас урваж, Чжи Юань-ий арван наймдугаар он (1281)-д дарангуйлагдлаа гэдэг. Энэ пайзыг 1845 онд Днепр мөрний орчмоос олсон байна. Юу болсон ч энэ нь одоо болтол хадгалагдсан уйгуржин үсгийн цорын ганц пайз болно (зурагт нүүр 39 дэхи зураг - 50 ийг лавлаарай).

Эдгээр дурсгалт зүйлүүд бол монгол үндэстний үсэг бичгийн ууган дурсгал биш, харин одоо болтол хадгалагдаж, манай үед олдсон Хаант Монгол Улсын үеийн дурсгалт зүйл төдий л юм. Тиймээс түүний дэс дараа гэдэг нь мөн ч хувиралгүй биш, харин шинэ ололтыг дагалдан тасралгүй хувирч байх ёстой.

Чингис хаан үсэг бичгийн тухай ерийн мэдлэгтэйгээр үл барам, нэлээд төгөлдөр мэдлэгтэй гэдгийг нотлох бас нэгэн баримт гэвэл, Чингис хаан бусад улс үндэстний үсэг бичгийг хэрэглэж, тэдгээр үндэстнүүдтэй харилцах зорилгоо гүйцэтгэж байжээ. Жишээлбэл, Чингис хааны зарлигийн пайз(зураг - 6) ба Чан-чунь аршид өгсөн хэдэн удаагийн зарлигийн бичиг (бүр хятад үсгээр бичсэн)-ээс үзэхүл, хятад үндэстэн ба Хятан үндэстэн лүгээ харилцахын төлөө ядахдаа хятад, Хятан үсгийг хэрэглэж байжээ. Тангуд, Жүрчин зэрэг үсэг бичгийг хэрэглэсэн баримт олоогүй боловч ийм боломжгүй биш юм.

Үсэг бичгийн тухай Чингис хаан лугаа холбогдсон мэдээ их төлөв ийм л байна.

Монгол үндэстний үсэг бичиг Чингис хааны үед зохиогдсон биш гэдгийг дээр дурдсан билээ. Гэвч уйгуржин үсгийг эхлээд Монголын хэсэг зарим аймгуудад хэрэглэж байсныг дээшлүүлж бүх үндэстний чанартай үсэг бичиг болгосон ба түүнийг монгол үндэстний төр улсын явдалд хэрэглэж, хууль ёсны байр суурийг нь баталсан явдал бол Чингис хааны гавьяа юм.

47. Хаант Монгол Улсын соёлын ноён оргил

“Монголын нууц товчоон”

“Монголын нууц товчоон” бол монгол үндэстний эртний түүхийн тулгуур бичгийн нэг нь болох бөгөөд монгол үндэстний эртний уран зохиолын гурван том оргилын ноён оргил нь болно гэж олонхи хүмүүс үнэлцгээж байна. “Дундад зууны үед нэг ч үндэстэн Монголын адилаар түүхч нарын анхаарлыг татсангүй гэж хэлж болох аваас, бас “Нууц товчоон”-ы адилаар жинхэнэ амьдралыг тодорхой дүрслэн үзүүлсэн дурсгалт бичгийг нэг ч нүүдэлчин үндэстэн үлдээсэнгүй гэдгийг тэмдэглэвээс зохимуй” гэж Б.Я.Владимирцов тэмдэглэж байв.

“Нууц товчоон” нь түүний гол хуудсаараа Чингис хааны үйл ажиллагаа ба амьдралыг тэмдэглэснээр барахгүй, монгол үндэстний үүсэл гарал, овог угсаа, аймаг бүлэг болон эртний Монголын аж амьдрал, зан суртахуун жич бусад үндэстэн лүгээ харьцаа зэрэг таван зуу гаруй жилийн түүхийг үнэн бодитой бөгөөд амьд дүрслэгээр тэмдэглэж үлдээжээ.

Ингээд түүнийг монгол үндэстний түүхийн тулгуур баримт, чухал дурсгал гэж үнэлдэг сэн.

“Нууц товчоон” бол түүхийн хэргийг уран зохиолын хэлбэрээр, тухайлбал түүхчлэн тэмдэглэх, үлгэрчлэн дүрслэх, уянгалан чимэглэх аргаар бичих монгол түүхийн өвөрмөц онцлогийг үүдэн бүтээв. Түүнчлэн “Нууц товчоон”-д олон арван эртний Монголын шүлэг дуулал ба үлгэр домгийг тэмдэглэн үлдээжээ. Ингээд “Нууц товчоон” нь эртний Монголын соёл урлагийн чухал сурвалж, баялаг өв гэж үнэлэгддэг билээ. Бас “Нууц товчоон” бол эртний монгол хэлийг тэмдэглэн хадгалсан хамгийн баялаг, хамгийн бүрэн, хамгийн их нэгэн хөмрөг болох бөгөөд монгол үндэстний цэрэг дайны анхны түүх гэж үзэж болох мэт.

Чингэвэл, сүмбэр уул шиг сүндэрлэн мөнхөрсөн өнөд баларшгүй агуу их хөшөө - “Монголын Нууц товчоон” нь Чингис хааныг нас барснаас хойнохи арван дөрөвхөн жил 16-ийн дотор, галт уул шиг дэлбэрээд бүтчихэв үү? Галбир зандан мод шиг ганцаараа ургаж уу? гэсэн асуулт тавигдах байсан. Одоо олонхи хүмүүсийн хариулт ийм биш байна. “Нууц товчоон” шиг дээд хэмжээни боловсронгуй зохиолыг олон зуун жилийн боловсон соёлгүй үндэстэн бол бүтээж чадахгүй гэж үзэцгээж байна. Энэ үзэлт бол зүйтэй юм. Хэлэлгээнгүй, энэхүү “Олон зуун жилийн боловсон соёл” гэдэг нь аман зохиол ба бичгийн зохиолыг багтааж болох юм. Ялангуяа ардын аман зохиол бол монгол үндэстний урт удаан түүхтэй соёлын өв хөрөнгө болсоор иржээ.

“Монголын нууц товчоон” нь Чингис хааны нэгэн үе лүгээ шууд холбогдохоор барахгүй, Чингис хааны дээд үетэй ч холбогдох тул энд Чингис хааны түүх лүгээ холбогдуулан дурдах нь ч зүйтэй билээ. Өөрөөр хэлбэл, Чингисийн үе бол монгол үндэстний балар харанхуй үе биш, харин феодалын анхны соёлын бадралт үе нь байсан гэж үзэж болох мэт. Тиймээс Чингис хааны үед “Нууц товчоон” адил зохиол ганцхан зохиогдсон биш, харин одоо болтол хадгалагдаж, манайд олдсон нь энэ ганцхан зүйл гэж үзэцгээдэг нь ч зүйтэй юм. Нэн ч Чингис хааны авьяас билигт их бодлого нь монгол үндэстний эртний соёл, эртний оюун билгээр зэвсэглэгдсэн нь тодорхой билээ. “Чингис хаан тухайн үеийн чадварт монгол хүнтэй адилаар, өөрийнхөө үзэл санаанд уянгын хэлбэрийг өгөх авьяастай байсан тул, түүний билиг сургаал нь амархан уламжлагдаж чаджээ. Энэхүү уянгын хэлбэр (шүлгийн хэлбэр)-ийг хэрэглэдгийг нь хэлбэл, (монгол үндэстэн) хол эртний үеэсээ уламжилж ирсэн нэгэн зүйлийн өв заншил болно. Тиймээс соёлын балай байсан ард түмэн нь ч өөрийн өвөг дээдсийнхээ сургаалийг хадгалж чаджээ” гэж Б.Я.Владимирцов тэмдэглэв.

Олон зуун жилийн тархай бутархай амьдрал ба дайн дажиныг туулсан монгол үндэстэн, арван хоёрдугаар зууны сүүлчээс арван гуравдугаар зууны эхний үе болтол Чингис хааны удирдлага доор, хэдэн арван жилийн шаргуу тэмцлийг өнгөрөөгөөд нэгтгэн байгуулсан монгол үндэстний ууган төр - Хаант Монгол Улс их төлөв ийм л улс байжээ.

Дагалдвар

1 Энд тэмдэглэж бүхий “Хоёр зуугаад түмэн хүн амтай, гучин нэгэн овог аймаг” гэсэн нь Березиний зохиосон “Чингис хаан” гэдэг товхимол дахи тоо бүртгэл болно. Чингис хааны хураан нэгтгэсэн аймаг угсаатны тоог олон янзаар тэмдэглэсэн байдаг. “Юань улсын түүх, Тайцзу-гийн шастир”-т “Дөчин улсыг мөхөөв” гэж, “Хураангуй Алтан товч”-д “Замбутивийн гурван зуун жаран нэгэн овогтон, долоон зуун хорин хэлтэн улсын алба гувчуур авч” гэж,

“Тангын урсгал”-д “Отгон Уйман Тайчигуд, Татар Уйгур Шархур тэргүүтэн хол дахины дөчин ес илүү улс эрхдээ хураагаад” гэж, “Чингис хааны байлдааны бичиг”-т “Тэр үе манай монгол угсаатны хүн амын тоо нь нэг мянган түмний төдий л асан буй за, тийн бөгөөтөл түүнд дурдсан угсаатан нь үнэнд зургаан сая хиртэй хүн ам ажгуу” гэж, Орнадскийн “Монгол ба Орос”-т зуугаад түм гэж тус тус адил бусаар тэмдэглэж буй. Эдгээрийн зарим Чингис хааныг нас барах үед тэмдэглэсэн тоо болно. Энэхүү тоо бүртгэлд чухам аль аль улс үндэстэн, овог аймгийг нарийвчлан жагсаасан бодтой тэмдэглэл ер харагдаагүй. Тиймээс эдгээр нь зөвхөн бүдүүвч тоо болохоос биш, оновчтой тоо баримт болж чадахгүй юм. Арван хэдэн түмэн цэрэг байснаар үзэхүл татаж хэлэхэд хоёр зуугаад түмэн хүн амтай гэдэг нь нэлээд зүйтэй тоо болох мэт.

2 Хаант Монгол Улсыг тунхагласан анхдагч их хуралдайн цагийг олонхи түүх шастирт жил он (улаан барс жил, 1206 он)-ыг нь тэмдэглэдгээс биш, сар өдөр байдаггүй. “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д “Чо Гэн Лу бичиг”-ийг үндэслэж “арван хоёр сар” гэж, “Тангын урсгал”-д “өвлийн сүүл сар” гэж тэмдэглэж байхад, “Д’Оссоны түүх”-д “1206 оны хавар” гэж тэмдэглэж байна. Би тус товчоонд энэ “арван хоёр сар”-ыг нь шууд ашигласангүй, “1206 оны баян намраас эхлэн өвлийн сүүл сар болтол” гэж чөлөөтэйхэн тэмдэглэсэн учир гэвэл: Монголын өндөрлөг дэх арван хоёр сар бол тэсгим хүйтэн цаг улирал болно. Ийм цагт тийм олон хүмүүсийг цуглаан хурал найр хийх явдал бол тэр үеийн нөхцөл байдалд байтугай одоо ч гээд тун бэрх юм. Тухайн үед Чингис хаан ч арай тийм цагийг сонгохгүй гэж хэлмээр байна. Бас зарим тэмдэглэлээс үзэхүл, тэрхүү их цуглаан дээр айраг цэгээ зэргийг ууж байснаар үзэхүл энэ лав өвөл цаг биш. Намар цаг бол жилийн дөрвөн улиралд хамгийн баян тарган цаг болно. Монголын эл газрын хүмүүс Онон мөрний эхэнд хүрэлцэн ирэхэд бас хоёр гурван сарын цаг орох юм. Тиймээс Д’Оссон эхлэн цугларсан цагийг тэмдэглэсэн магадгүй. Ингээд энэ удаагийн хуралдааныг намар цагаар жиших нь зүйтэй мэт. Хуралдаан нь дуусаад тархаж явгал бараг жилийн эцэс болсон байж мэднэ. Гэтэл, одоо яаж сайхан хэллээ ч гэсэн бас л жишилт болохоос биш, баримт болохгүй юм.

3 Чингис хааны энэхүү их ордныг Березиний зохиолд “Хатгамал хатгасан цагаан бөсийн том цацар” гэж тэмдэглэж байна. Би энд “Плано Карпини-гийн аяллын тэмдэглэл”-д хавсаргасан арван дөрөвдүгээр зууны үеийн зураг (тавдугаар бүлгийн нүүрийн зураг) болон “Богд Чингис хааны цадиг”-т хавсаргасан зураг (зураг-32) зэргийг үндэслэж, том монгол гэр гэж тэмдэглэсэн юм. Монголын хааны ордны тухай Плано Карпини, Марко Поло болон Пэн Да Я, Сюй Тин нар бүр тодорхой тэмдэглэлийг үлдээсэн юм. Карпини-гийн тэмдэглэлд: “Цагаан цэмбээр үйлдсэн нэгэн том бөгөөд өндөр ордныг босгожээ. Миний үзэхээр энэ ордонд хоёр мянган хүнийг уужуухан багтааж болно. Ордныг тойрсон модон хананд нь элдэв зураг зурж байлаа” гэж тэмдэглэж буй. Марко Поло-гоос Хубилай хааны аяны ордныг доорхи мэт тэмдэглэжээ: “Хааны төрийн чуулганы цацар нь туйлын уудам их, түүний дотор нэгэн түмэн цэргийн жагсаал жагсааж болох бөгөөд бас дээд зэргийн дарга түшмэд хийгээд бус эрхэм хүмүүсийн суух илүү газар буй. Үүд нь өмнө зүгт хандаж, зүүн талд бас өөр нэг цацар түүн лүгээ залгалдаж, нэгэн уудам их тинхим болгожээ”. “Хар Татарын тухай хэргийн товч”-д: “Гол орд нь өмнөш хандаж ганцаар өмнөд талд нь бууна. Хатад эмс дараад нь, хуурмаг торгон цэрэг хийгээд хуурмаг ноёд түшмэд нь бас түүний дараад нь бууна. Татарын эзний авын цацар бүхнийг цөм орд гэнэ. Түүний шар орд (баганыг алтадсаны учраар тийн нэрлэв - уул тайлбар) хийгээд хуурмаг хатад, бүлэг айлуудын багларан буусныг бол их орд гэнэ”. “Сюй

Тин Би монгол хүрэхүйд, шар орд босгов ...Нэг том монгол гэр л юм. Дээвэр ханыг эсгийгээр бүрж, тооныг уд модоор гэгээвч адил зохиож гэрэл оруулна. Бас мянга илүү дээсээр тэлж хадаад үүд босго ба баганыг бүр алтаар алтадсан болохоор ийн нэрлэв. Дотор нь хэдэн зуун хүнийг багтаамуй. Татарын эзний ордын дотор тавьсан монгол ор тавцан нь сүмийн их хуушааны суудал адил, мөн ч алтаар алтаджээ” (монгол хэвлэл, 152-154 нүүр) гэв.

4 “Есөн хөхөлт цагаан туг”-ийн тухай бас олон янзын тэмдэглэл, тайлбарлал байдаг. Манай ууган баримт “Нууц товчоон”-д: “Барс жил Ононы тэргүүнээ хурж есөн хөлт цагаан туг байгуулаад” (202 дугаар зүйл) гэж, “Эрдэнийн товч”-д: “Онон мөрөн(ий) тэргүүнээ байлган хатгасан есөн хөлт цагаан тугаа босгон, Дэлүүн Болдогт явуулан хатгасны дөрвөн хөлд хар сүлдээ босгож” (1962 оны сударчилсан хэвлэл, 63 нүүр) гэж, “Хураангуй Алтан товч”-д: “Суут Чингис хаан хар могой жилд буюу (“Хар морин жилтэй буюу” гэвэл зүйтэй - эшлэгч) дөчин таван насандаа бин барс жилд Онон мөрний тэргүүнээ есөн хөлт цагаан тугаа байгуулж хаан их ор суув” (1980 оны шинэ хэвлэл, 20 нүүр) гэж, “Гангын урсгал”-д: “Согд богд Чингис хаан, усан морин жилтэй, дөчин таван өлзийдөө гал барс жил, өвлийн сүүл сар, Онон мөрөний эхэнд есөн хөхөлт цагаан тугаа байгуулж тугтам хаан суув” (1981 оны хэвлэл, 49-50 нүүр) гэж их төлөв адилавтгар тэмдэглэж байдаг. Эдгээрээс гадна сонирхолтой шиг тэмдэглэл гэвэл, Березиний “Чингис хаан” гэдэг товхимолын тэмдэглэл болно. Түүнд “Цацарын үүдний нэгэн талд боржигид аймгийн тэмдэг болсон их цагаан туг намирч байлаа. Тугийн дээр нь нэгэн цагаан шонхор хар хэрээг атган барьсан зурагтай бөгөөд тугийн дээр нь есөн хошуутай, хошуу бүрд нь цагаан сарлагийн үсээр залаа уясан нь хүч чадлаа бэлгэджээ. Энэ есийн тоо бол Тэмүжиний есөн өрлөгийн шинж бэлгэ болно. Үүдний нөгөө талд Тэмүжиний байлдааны тэмдэг болсон “сүлд”-ийг газарт хатгаж байв. “Сүлд”-ийн үзүүрт нэгэн үхрийн эврийг тааруулж байх бөгөөд эврээс дорогш дөрвөн монцог хар морины сүүлийг унжуулж байв” гэж маш нарийн дүрслэгээр тэмдэглэж байна. Энэ нь “Эрдэнийн товч”-ийн тэмдэглэлийг боджуулсан мэт. Иргэн улсын хорин тавдугаар онд хэвлэгдсэн “Монгол үндэстний баатар Бат” гэдэг товхимолд: “Уудам их тал нутгийн дунд нүд гялсам гоё сайхан цацар ордныг босгож, ордны өмнө нь чигаан (туг хиур өлгөх багана - хө.) босгон түүний дээр нэгэн хар саран бүхий цагаан туг намирч, тугийн үзүүрт есөн хэсэг цагаан морины сүүлийг уяжээ. Үүнийг есөн хөлт цагаан туг” гэдэг гэж тэмдэглэж байна. Бас Кобаяши Такаширо авгайн зохиосон “Чингис хаан” гэдэг товхимолд энэхүү “Есөн хөлт цагаан туг”-ийг тайлбарлахдаа: “Монгол хүн бол цагаан өнгийг бэлгэтэй өнгө гэж, хар өнгийг муу ёрын өнгө гэж үздэг бөгөөд есийн тоог нандигнан эрхэмлэдэг билээ. Энэ тугаа амийг хамгаалагч “сүлд” гэж итгэдэг тул дайн байлдаан хийх бүртээ туг сүлдээ тахидаг бөгөөд дийлсэн хойноо шүүсээр тахидаг билээ. Бас Чингисийн хүндэт харуул нь цул цагаан их тугийг хэрэглэдэг, бусад ван нар нь голдоо хар сарыг зурсан есөн унжилгат цагаан тугийг хэрэглэдэг гэдэг домог яриа байдаг юм” (94 нүүр) гэж тэмдэглэв. Энэ нь “Монгол Татарын тухай бүрэн тэмдэглэл” дэх “Го ванд ганц нэгэн есөн сүүлт (хөл) дундаа хар сарантай цагаан туг босгож, дайнд гарахдаа дэлгэн хэрэглэмүй” гэсэн тэмдэглэлээс эшлэсэн бололтой. Сүүлчийн үе болоход Монголын их хааны туг нь наран сарны зурагтай болжээ. “Хубилай нь дөрвөн зааны дээр ачсан, модоор үйлдсэн цайзын дотор суун...цайзын орой дээр наран саран зурсан хааны тугийг хийсгэжээ” гэж Марко Поло тэмдэглэв. “Гангын урсгал”-д дурдсан “хөхөлт” гэдэг нь морины манлайн үс “хөхөл”-өөр үлгэрлэсэн мэт. Энэ нь харин морины дэлээр “хөхөл”-ийн хэлбэртэй хийдэг магадгүй. Энэ тухай тус товчооны хоёрдугаар бүлгийн дагалдвар11, “Гангын урсгал”-ын 50 дугаар нүүр дэх нөхөр Чойжи-гийн тайлбар ба

“Өвөр Монголын Багшийн Дээд Сургуулийн Эрдэм Шинжилгээний сэтгүүл”-ийн 1981 оны нэгдүгээр хугацаанд нөхөр Жагарын нийтлүүлсэн “Чингис хааны сүлд тугийн тухай” гэдэг өгүүлэл зэргийг лавлаарай.

5 Энд дурдаж бүхий “цагаан эсгий” гэдэг нь миний хувийн санал болно. Березиний тэмдэглэлд “хар эсгий” гэж бичиж байсан юм. Энэ тэмдэглэл нь чухам ямар баримттайг мэдээгүй. Гэвч монгол үндэстний эрт ба одоогийн зан заншлаас үздэг бол “хар” өнгийг маш цээрлэдгийг хэн ч бүр мэддэг юмсан. Энэ заншлыг нь Кобаяши Такаширо авгай хүртэл бүр сайн мэдэж байсныг дээр нэгэнтээ тэмдэглэсэн билээ. Тэрчлэн хар хонь олонгүй учраас хар ноосоор хийсэн эсгий бараг байдаггүй. Бодоход Березин авгай өөр үндэстний зан заншлын тухай тэмдэглэлийг хутгалдуулсан ч байж мэднэ. Ингээд би “хар эсгий”-г нь “цагаан эсгий” гэж өөрчлөснөө энд тэмдэглэе.

6 Тататунгаа-гаас Чингис хаанд хас тамга өргөсөн тухай мэдээг мөн Березиний товхимолд тэмдэглэж буй. Тэр тэмдэглэсэн нь: Уйгур хүн Тататунгаа гэгч хатуу хас чулуугаар сийлсэн хааны шинэ тамгыг гарган олонд үзүүлэв. Тамганд сийлсэн агуулгыг нь Монголчууд сонсоод ихэд цочицгоов! Тэр тамгын агуулга бол: “Тэнгэр дээр сахиулсан буй, дэлхий дээр хаан буй, сахиулсан ивээтүгэй. Бүх хүн төрөлхтний эзний тамга” гэжээ (Энд япон орчуулгаас нь дам эшлэв).

Березиний энэ тэмдэглэлийг нэлээд түүхэн баримттай гэж үзэж болно. Учир нь Тататунгааг 1204 онд Найманыг мөхөөсөн байлдааны талбай дээрээс олзолоход, түүний өвөрт нь Найманы Таян ханы тамга байжээ. Тэр үед “энэ тамгыг юунд хэрэглэмүй?” гэж Хасар асуухад, “Сайн хүнийг сонгож зарлиг бичиг явуулах аливаа үйлст хэрэглэмүй” гэж Тататунгаа хариулсан байна. Үүнийг нь Хасар шударга элбэрэлт хүн гэж Тэмүжинд мэдүүлж, “Аливаа бичиг явуулахад хэрэглэхээр тэр тамгыг мөнхүү Тататунгаад тушаав” (Ц.Дамдинсүрэнгийн одоочлого, 163 дугаар нүүр) гэсэн тэмдэглэл байдаг бөгөөд “Түүнээс хойш зарлиг нийтлэх бүр тамга эхлэн хэрэглэсэн бөгөөд Тататунгаа-гаар тамгыг хамааруулжээ” (“Юань улсын түүх”, 124 дүгээр боть) гэсэн тэмдэглэл ч байдаг билээ. Эдгээр мэдээнүүдээс бид хоёр зүйлийн учрыг мэдэж болно. Нэг нь Тататунгаа бол үсэг бичиг сайн мэддэг бөгөөд Найманы Таян ханы тамган түшмэл байсан нь лав байна. Дараа нь хаан хүнд тамга байдаг, тэрчлэн тамга гэдэг юм чухам ямар үйлдэлтэй гэдгийг Монголчууд 1206 оноос ядахдаа хоёр жилийн өмнө ойлгож мэдсэн бөгөөд тэр тамгыг цаашид “хэрэглэхээр” бас Тататунгаа-д нь тушаан өгчээ. Ингээд Тататунгаа нь тэр өдрөөс хойш Чингис хааны тамган түшмэл болсон нь илт байна.

Чингис хаан их ор суух үед тамгатай болсныг “Хаадын үндэсний эрдэнийн товч”-д: “Тэнд тэр чулуун (Чингисийн үүдэн дэхи дөрвөлжин чулуу - эшлэгч) гэнэт бөгөөд өөрөөсөө хагарсны дотроос хасбуу нэрт тамга уртуулжин ба өргөн нь нэг төө, ард нь яст мэлхийн дээр хоёр луу ороолдон асан, жидир (эвхмэл үсэг) нь сийлсэн мэт хурвилан (хөрвийн) бүхий гарвай” гэж Саган сэцэн тэмдэглэж байв. Энэ нь хэдийгээр мухар сүсгийн өнгөтэй тэмдэглэл боловч, Чингис хаанд тамга өргөсөн явдлыг харуулж байна. “Асрагч нэртийн түүх”-д: “Есүхэй баатар Татарын Тэмүжинийг олзолж ирэхүйд Өгэлүнээс нэгэн хөвгүүн шагайн чинээ хар нөж атгаж төрөв ... Түүний манагараас усны хойгт нэгэн чулууны дээр нэгэн шувуу гурван өдөр эргэж дуу гарав. Есүхэй баатар энэ хүүхэд төрөөд сац энэ шувуу нэгэн бэлгэт

ажгуу хэмээж, Есүхэй баатар тэр чулууныг хагалж үзвээс дотор нь хасбуу тамга асан ажгуу” (20-21 нүүр) гэж тэмдэглэж байв. Чингис хаанд тамгатай байсныг гэрчлэх мэдээ бас байдаг. Жишээлбэл, Сүн улсын Бумбын шашны алдарт бясалгагч Чан-чунь арш Чингис хаанаа баруун оронд бараадаж, 1223 оны 3 сарын 7-д улсдаа буцах үед нь “Доорд шавь нарт зарлигаар мэдэгдэн хэлтрүүлвээс зохимуй” хэмээн хаан айлдаж, хааны тамгыг дарсан зарлигийн бичгийг соёрхов (Зарлигийн бичгийг тус товчооны наймдугаар бүлэгт хавсаргасан зураг - 86, зурагт нүүрийн 62-63 дахи зургийг лавлаарай) гэж “Чан-чунь аршийн баруунш зорчсон тэмдэглэл”-ийн доод боть (“Дундад ба өрнөдийн харилцааны түүхэн материалын эмхэтгэл”, тавдугаар дэвтэр, 133 нүүр)-д тодорхой тэмдэглэж буй. Чингэвэл, Чингис хааны тамга яав? гэвэл, Өгөөдэй хаанд тушаан өглөө гэж Ту Цзи авгай тэмдэглэжээ. Тэр: Тулуй хаанаа хэм өргөж (Ту Цзи-гийн тайлбар: Чингис хаан нас барсан хойно Тулуй төрийг захирч байсан тул хааны тамгыг Тулуй авч байсан нь лав юм. Энэ үе хааны тамгыг өргөвөөс зохих билээ. Гэтэл өрнө дахины номд хэм өргөвэй гэсэн нь сэжиглэлтэй), олон сайд түшмэдийн хамтаар “хаан танаа” гэж сөгдөн мөргөв (“Ту Цзи-гийн тэмдэглэл”, 32 дугаар боть, 2 дугаар нүүрийн ард) гэжээ. Тэр үед Чингис хаанд тамгатай байснаар үл барам, 1217 онд “Мухулайг мужийн захирагч тайш, Го ван цол өргөмжилж, алтан тамга, есөн хөхөлт цагаан тугийг зарлигаар шагнав” (“Ту Цзи-гийн тэмдэглэл”, 3 дугаар боть, 18 дугаар нүүрийн ард) гэсэн тэмдэглэл ч байдаг. Тиймээс Чингис хаанд тамгатай байсан нь огт сэжиглэлгүй.

Чингис хааны тамгыг бэлтгэх, хаан суух үед нь өргөх ба хожим нь тамгыг хамаарах хамгийн зохистой хүн бол энэ Тататунгаа юм. Энэ Тататунгаа Чингис хааны тамгыг хамаарч барахгүй, Өгөөдэй хааны үед бас дотоод ордны тамга тушаа, алт магнигийг нь хамаарч байсан тухай “Юань улсын түүх” (3048 нүүр)-т тодорхой тэмдэглэж буй.

Чингэвэл Чингис хааны тамга бол одоо манай үед хүртэл үлдэж ирсэн “Гүюг хааны тамга” гэдэг тэр биеэрээ мөн гэж хэлж болно. Энэ тухай би “Монголын их хааны алтан тамга” гэсэн гарчигтай бяцхан өгүүлэлийг 1980 оны 8 сард “Монгол хэл бичиг” сэтгүүлийн зургадугаар хугацаанд нийтлүүлсэн билээ. Гэтэл тэр үед би Березиний энэ тэмдэглэлийг хараахан олж хараагүй байсан юм.

Гүюг хааны тамгын бичиг бол: “Мөнх тэнгэрийн хүчинд Их Монгол Улсын Далайн хааны (хааны) зарлиг ил булха иргэнд хүрвээс биширтүгэй айтугай” (зураг 4) гэж бичиж буй. Энэ нь “Тэнгэр дээр сахиулс буй, дэлхий дээр хаан буй, сахиулс ивээтүгэй. Бүх хүн төрөлхтөний эзний тамга” гэж Березиний тэмдэглэж байсантай хэлбэрийн талаар нэлээд зөрж байх нь ил байна. Гэвч манай одоогийн ашигласан Березиний зохиол бол Оросоос Франц, Францаас Япон мэт хэд хэд дамжсан орчуулга болох юм. Тиймээс орчуулагчид нь өөр өөрийн хэлнийхээ ухагдахуун ба заншлаар орчуулбал, яриангүй хэлбэрийн талаар өөрдөх юм. Хэлбэр нь хэдийгээр өөрчлөгдсөн боловч уул санааг нь бас харуулсаар байна. “Тэнгэр дээр сахиулс буй, сахиулс ивээтүгэй” гэсэн нь “Мөнх тэнгэрийн хүчинд” гэсэн санааг, “дэлхий дээр хаан буй” гэсэн болон “бүх хүн төрөлхтөний эзэн” гэсэн нь “Их Монгол Улсын Далайн хаан” гэсэн санааг тус тус харуулж байх мэт.


Энэ тамгийг “Гүюг хааны тамга” гэсэн учир гэвэл, Өгөөдэй хааны хөвгүүн Гүюг 1246 оны 7 сард Хаант Монгол Улсын гуравдугаар их хааны орыг залгамжлах үед, Европ дахины пап лам - Ромын шашны хааны элч Йохан, Плано Карпини нар Монголын хааны шар ордонд ирж,

Гүюг хааны хаан суурь суусан ёслолд оролцоод буцахдаа авч харьсан, Монголын их хаанаас Европ дахины пап ламд өгсөн төрийн бичигт энэ тамгыг дарсан байжээ. Ингээд түүнийг “Гүюг хааны тамгын бичиг” гэдэг бөгөөд одоо болтол ромын шашны хааны түүхэн эвхмэлд хадгалж буй гэдэг билээ. Тэр төрийн бичгийг 30 см өргөн, 120 см урталжин наамал цаасан дээр сарацин (перс) үсгээр бичсэн бөгөөд хааны тамгыг наасан уулзвар буюу бичгийн сүүлд нь улаан шунхаар дарсан байжээ (зураг 5).

Энэ зөвхөн Гүюг хааны л тамга биш, харин Монголын их хааны тамга, тухайлбал Чингис хаанаас Өгөөдэйд, Өгөөдэйгээс Гүюгт уламжилсан тамга болно. Учир нь Чингис хаан 1227 онд нас барсны дараа, Тулуй нэг жил засаг барьж, Өгөөдэй арван гурван жил (1229-1241 он) хаан сууж, Наймжин хатан таван жил (1242-1246 он) засаг барьж нийт арван найман жил болсон юм. Энэ арван найман жилийн дотор хааны тамга үрэгдэж сүйдэх ёсгүй. Ялангуяа хаан орыг залгамжилахад юуны урьд тамгаа залгамжлах нь мэдээжийн хэрэг билээ.

Энд тэмдэглүүштэй нэгэн зүйл гэвэл, “Плано Карпини-гийн аяллын тэмдэглэл”-ийн оросчилгод Шастина-гийн хавсаргасан тайлбар (150 дугаар)-т, энэ тамгыг Козьма гэдэг орос дархан (Монголчууд оросыг довтлох үед олзолж ирсэн хүн гэлээ) үйлдсэн гэж тэмдэглэж байхын хамт бас: “Оросын авьяаст дарханы мэргэжил ба тэр уран хоёр гараараа урлагийн дээд үнэт эдийг бүтээсэн нь тойромын хүмүүсийн магтаалыг олов” гэж тэмдэглэж байна. Энэ нь түүхэн тэмдэглэл биш, харин орос дарханыг товойлгосон тайлбар болох нь илхэн байна. Ийм нэгэн орос дархан байсан нь үнэн хэрэг байх болох бөгөөд тэр өөр зүйлийг дархалсан нь ч үнэн хэрэг байж болно. Гэтэл энэ тамгыг тэр сийллээ гэдэг мэдээг Плано Карпини ч тэмдэглээгүй юм.

7 “Хуучин Монгол улс”-ын Хабул, Амбагай, Хотала гурван ханы харьцааг доорхи хүснэгтээр лавлаарай.



Тайлбар:

А. 17-21 хүртэлх тоо бол Бөртэ чоноос дорогш үе уламжлалын дэс дараа болно.

В. “1” тэмдэгт нь хаан суужээ.

С. “Х” бол товчилсон тэмдэг болно.

8 “Судрын чуулган”-д дурдсан Чингис хааны цэргийн тоог Японы монголч эрдэмтэн Хонда Санаинобу “Нууц товчоон”-ы мянганы ноёдтой харьцуулан судалж, “Чингис хааны мянгат” гэсэн өгүүллээ 1953 оны 8 сард хэвлэгдсэн “Түүхийн ухааны сэтгүүл”-ийн 62 дугаар найрууллын наймдугаарт нийтэлжээ. Түүний доторхи бодтой тоо болон “Нууц товчоон” лугаа зөрөөтэй зүйлийг хураангуйлан эмхэтгэж лавлалт болгосугай:

(Нэг) Тулуйд хувьдсан цэрэг нийт 101.000 хүн, мянганы байгууламж 101, мянганы ноёд 48 хүн байжээ.

Үүний дотор:

(1) Гол цэрэг 1.000 хүн, зууны ноёд 8 хүнийг тэмдэглэжээ.

(2) Баруун гарын цэрэг 38.000 хүн, мянганы байгууламж 38, мянганы ноёд 23 хүнийг тэмдэглэжээ.

(3) Зүүн гарын цэрэг 62.000 хүн, мянганы байгууламж 62, мянганы ноёд 25 хүнийг тэмдэглэжээ.

(Хоёр) Жочи, Чагаадай, Өгөөдэй, Хөлгөн нарт хувьдсан цэрэг нийт 16.000 хүн, мянганы байгууламж 16, мянганы ноёд 16 хүн байжээ.

Үүний дотор:

Дөрвөн хөвгүүн тус бүр 4.000 хүн, мянганы байгууламж 16, нэр дурдсан мянганы ноён 12 байв.

(Гурав) Гурван дүү ба Өгэлүн эхэд хувьдсан цэрэг нийт 12,000 хүн байв (мянганы байгууламж ба мянганы ноёдыг тодорхой дурдаагүй).

Үүний дотор:

(1) Отчигинд хувьдсан 5.000 хүн.

(2) Хасарт хувьдсан 1.000 хүн.

(3) Алчидай (Хачигуны хөвгүүн)-д хувьдсан 3.000 хүн.

(4) Өгэлүн эхэд хувьдсан 3.000 хүн тус тус багтаж байв.

Багцлаад хэлбэл, Чингис хааны бүх цэрэг арван хоёр түм есөн мянган хүн, мянганы байгууламж нэг зуун арван долоо, мянганы ноёд жаран дөрвөн хүнийг тодорхой тэмдэглэжээ.

Энэхүү жаран дөрвөн мянганы ноёдын бодтой байдлыг ажиглавал доорхи хэдэн зүйлийг тэмдэглүүштэй:

(1) “Судрын чуулган” ба “Нууц товчоон”-д адил буюу их төлөв адил тэмдэглэсэн хүмүүс:

Боорчу, Борухул, Жадай, Хингиадай, Толун чэрби, Сүйхэтү чэрби, Бала чэрби, Содун ноён (Сорхан шарын ач, гэтэл “Нууц товчоон” дахи 27 дугаар мянганы ноён нь Сорхан шарын нэрээр тэмдэглэгдэв), Шигихутуху, Манхул торгон (энэ бол “Нууц товчоон”-ы 26 дугаар мянганы ноён, Багарины Алагийг хэлж буй), Хорчи, Булуган, Мүнлиг эцэг, Алахуши Дигит Хури (дээрх бол баруун гарын харьяат); Мухулай, Есүн буха тайш (“Нууц товчоон”-ы 9 дүгээр мянганы ноён Зэлмэ-гийн хөвгүүн), Буту хүргэн, Хуйлдар сэцэн, Наяа, Өнгүр, Сүбээдэй баатар, Ходус Халжан, Мөнх, Халжа (дээрх бол зүүн гарын харьяат); Мөнгүгүр, Хунан ноён (дээрх бол Жочи-гийн харьяат); Баруладай, Харачар, Мөхэ ноён (дээрх бол Чагаадайн харьяат); Өгөөдэйн харьяат Илүгэй болон Хөлгөний харьяат Хубилай ноён, Тоорил (Цагаан гуа-гийн хөвгүүн нарийн Тоорил) нар болно.

(2) Хоёр номд цол адил, нэр зөрөөтэй тэмдэглэсэн хүмүүс: Дусуха (“Нууц товчоон”-д 72 дугаар мянганы ноёныг Добсаха гэдэг), Сөнидийн Хадаан хэвтүүл (“Нууц товчоон”-д 63 дугаар мянганы ноёныг Хадаан гэдэг), Могату хиа (“Нууц товчоон”-д 62 дугаар мянганы ноёныг Мэгэтү гэдэг), Гэтэй ноён (“Нууц товчоон”-д 57 дугаар мянганы ноёныг Гэтэй гэдэг), Бужар-ноён (“Нууц товчоон”-д 38 дугаар мянганы ноёныг Бужар гэдэг), Хонгирадын Шихү-хүргэн (“Нууц товчоон”-д 83 дугаар мянганы ноёныг Ашиг хүргэн гэдэг) (дээрх бол баруун зүүн гарын харьяат); Өгөөдэйн харьяат Дайр (“Нууц товчоон”-д 36 дугаар мянганы ноёныг Дайр гэдэг) нар болно.

(3) “Судрын чуулган”-д мянганы ноён, “Нууц товчоон”-д өөр тушаалаар тэмдэглэгдсэн хүмүүс:

Архай Хасар (“Нууц товчоон”-д турхагуудын дарга), Есөн-Тууга-Дархи (“Нууц товчоон”-д Хорчины ахлагч Есөнтэгэ гэж байдаг - дээрх бол баруун гарын харьяат); Догулху чэрби (“Нууц товчоон”-д турхагуудын дарга), Бэлгүтэй (Чингис хааны дүү, “Нууц товчоон”-д мянганы ноён биш), Өгэлэн чэрби (“Нууц товчоон”-д Турхагуудын ахлагч) нар болно.

(4) Шинэ тэмдэглэгдсэн мянганы ноёд буюу бусад байдал бүхий хүмүүс:

Сүлдүсийн Түгрил (өөр тэмдэглэл харагдаагүй), Ойрадын Хутуга бэхи (сүүлд нь мянганы ноён өргөмжлөгджээ), Олхунудын Тайчу хүргэн (“Юань улсын түүх”-д “Та чу фу ма” гэж байдаг). Адархины Мухар Хуран (“Биеэр дайлсан тэмдэглэл”-д “Му-ху-эр Хао-лань” гэж байдаг), Татарын Их Хутагт ноён (Шигихутуху-г хэлсэн мэт, гэтэл Шигихутуху-г дээр нэгэнтээ тэмдэглэжээ), Хонгирадын Алчи хүргэн, Хадай, Бугудар, Тагудар, Шинху (эд тавын тухай өөр мэдээгүй), Хонхотаны Соду ноён (“Юань улсын түүх, хүнс цалингийн тэмдэглэл” дэх “Е Су Лу”-гийн мянгатаар харьцуулжээ), Жалайрдай Бисур (өөр мэдээгүй), Жалайрын Ухай халжа, Харажу (хоёулаа нэг л мянганы ноён, өөр мэдээгүй), Ойн Урианхадын Удажи (өөр мэдээгүй), Жалайрын Дайсун (“Биеэр дайлсан тэмдэглэл”-д “Дай-сун” гэж байдаг), Жажарадын Хошуул-зусуг (“Биеэр дайлсан тэмдэглэл”-д “Хо Цзю Лэ” аймгийн мянган морьт цэрэг гэж байдаг), хар Хятаны Уяр Ваньши (“Биеэр дайлсан тэмдэглэл”-д “У-е-эр Юань-

шуай” гэж байдаг), Жүржэ(Жөрчинийг хэлсэн бололтой - эшлэгч)-ний Тухан Ваньши (“Биеэр дайлсан тэмдэглэл”-д “Ту-хуа Юань-шуай” гэж байдаг) (дээрх бол баруун, зүүн хоёр гарын харьяат); Үгүшийн Үшитай, Байху (энэ хоёр бол Жочи-д хувьдсан дөрвөн мянганы хоёр нь болно); Сүлдүсийн Илжигидэй (Өгөөдэйд хувьдсан дөрвөн мянганы нэг); Нэгүсийн Тоорил (Хөлгөнд хувьдсан дөрвөн мянганы нэг); Чагаадайд хувьдсан дөрвөн мянганы хоёр мянга ба Өгөөдэй, Хөлгөний тус бүр нэг мянганы ноёны нэр тэмдэглэлгүй байдаг.

Гол цэргийн зууны ноёд нь:

- (1) Тангудын Цагаан (Jaghn), сүүлд нь Нуран ноён (“Нууц товчоон”-д Их Нэгүрин гэдэг),
- (2) Сөнидийн Ил-Төмөр буурч,
- (3) Дөрвөний Борхи-буурч,
- (4) Жалайрын Үлдэй-хорчи,
- (5) Хэрэйдийн Эйнхис-буурч,
- (6) Мэргидийн Жамал-Хуважа,
- (7) Их Хонгиатай,
- (8) Татарын Есүн-тогуга нар болно.

9 “Монголын Нууц товчоон”-ы 202 дугаар зүйлд дурдагддаг наян найман гавьяатан, 95 мянган гэдэг нь ерөнхийлөн хамарсан тоо болно. Гэвч “Нууц товчоон”-д хэд хэдэн хэвлэл (арван таван боть ба арван хоёр боть гэж хоёр хэвлэл байдаг. Арван хоёр ботийн хэвлэлийг нь бас Гу Гуань Ци-гийн хуулбар, Е Дэ Хуй-н хуулбар гэж ялгадаг) байдаг учраас бодтой нэрс ба тоо нь бас бага сага зөрөөтэй байдаг байна. Сүүлчийн жилүүдэд хэвлэгдсэн янз бүрийн шинэ хэвлэл одоо дөрөв болоод байна (А. Дамдинсүрэнгийн, В. Дорнотивийн, С. Элдэндэй, Оюундалай нарын, D. Баярын, доош А, В, С, D гэж товчлов). Энэ дөрвөн хэвлэл ч бас “Нууц товчоон”-ы хуучин хэвлэлүүдийн зөрөөг харуулсаар байна. Жишээлбэл С, D д 89 хүн, 96 мянган болжээ. А, В д 88 хүн, 95 мянган байх тул энгийн хэллэгтэй тохирч байна. Гэвч бодтой нэрс нь бас хоорондоо зөрөөтэй байдаг билээ. А, С, D гурван хэвлэлд 35 дугаар Бала, 36 дугаар Орунардай гэж хоёр хүн буй. Гэтэл В д 35 дугаар Бала Орунардай гэж нэг хүнээр тэмдэглэжээ. бас А, С, D д: 53 дугаар Мөнх, 54 дүгээр Халжа гэж хоёр хүн буй, гэтэл В д 52 дугаар Мөнх Халжа гэж нэг хүнээр тэмдэглэжээ; А, С, D гурван хэвлэлийн 62 дугаар гавьяатан бол Тугунтөмөр гэдэг нэг хүн болно. Гэтэл В д: 60 дугаар Тугун, 61 дүгээр Төмөр гэж хоёр хүнээр тэмдэглэжээ. В, С, D д: Хингиадай (В 80 дугаар, С, D д 81 дүгээр), Буха хүргэн (В д 81 дүгээр, С, D д 82 дугаар) гэж хоёр хүн буй, гэтэл А д: 81 дүгээрт Хингиадай Буха хүргэн гэж нэг л хүнээр тэмдэглэж буй. Иймээс 35 дугаараас хойшхи дугаарлал ч бүр зөрж байна. Тус товчоонд нөхөр Дорнотивийн дугаарлалыг баримтлав. Энэ учрыг наян найман гавьяатныг танилцуулсан хэсэгт лавлаарай.

“Судрын чуулган”-д дурдсан 129 мянган ($129 \times 1000 = 129,000$ хүн) нь Чингис хаан нас барах

үед хөвгүүд дүү нартаа хуваан өгсөн цэрэг гэдэг. үүний дотор 1206 оноос хойш бүрэлдсэн “мянган” ч бүр багтсан байна. Жишээлбэл, 95 мянганы дотор Турхагуудын ахлагчийг оролцуулсангүй. Тэдний дотор мянганы ноён болсон Архай Хасар, Есөнтэгэ, Догулху чэрби, Өгэлэн чэрби, Тэмүдэр нарын таван мянган; “Нууц товчоон”-д байдаггүй, “Биеэр дайлсан тэмдэглэл”-д: “Хужигул аймгийн мянган морьт цэрэг”, “Уяр Юань-шуай” “Тохуа юаньшуай”(Рашидын зүүн гарын 22, 23, 24, 25 дугаар нэр) гэж дурдагддаг гурван хүний удирдсан 23 мянган; 1207-1208 онд байлдсан Ойрадын дөрвөн мянган; бас гол цэргийн найман зуутын ноёдоор бүрэлдсэн нэг мянган ба Бэлгүтэйн нэг мянган нийлээд нийт 34 мянган болно. Үүнийг Рашидын 129 мянганаас нь хасвал “Нууц товчоон”-д дурдсан 95 мянгантай яг тэнцэж байна. Тиймээс Рашидын энэ тоог нэлээд баримттай гэж үзэж болно.

10 Тайвань-ий түүхч Юань Го Фан дотоод гадаадын маш олон материалыг ашиглаж, “Арван гуравдугаар зууны үеийн монгол байлдагчийн зэвсэг тоноглол” гэсэн гарчгаар өгүүлэл нийтлэж (“Их хуурай сэтгүүл”, 1969 оны 38 дугаар боть, нэгдүгээр хугацаа), эртний Монголчуудын зэвсэг тоноглолын тухай дөхөм бөгөөд нэлээд системтэй танилцуулжээ. Түүний гол гол зүйлийг нь доор лавлалт болгон дагалдуулав.

“Арвангуравдугаар зууны үеийн монгол байлдагч нэг бүр нь билүү, сийлүүр, шөвөг, зүү, утас жич майхан, сүх, арьс, тулам мэтийн өдөр тутмын хэрэглэхүүнийг авч явдаг”.

“Өвөлдөө арьсан малгай, нэхий дээл, эсгий оймс, савхин гутлыг өмсч хүйтнийг халхалдаг”.

“Сайн морь маш олон гардаг тул цөм морьт цэрэг болно. Явган цэрэг байдаггүй. ...Мориндоо бас хуяг нөмөргөж, эгэм цээжийг нь хамгаалдаг. ...бас хүн бүр ээлжлэн унаж хэд хэдэн хөтөлгөө морьтой тул морь нь зүдэрдэггүй”.

“Эмээлийн модоор үйлддэг, хүнд нь долоо найман жин, өмнө бүүрэг нь өндөр, ар бүүрэг нь тэгш тул маш хөнгөн мөртөө зөв буруу тийшээ хөдлөхөд гарыг шархдуулдаггүй. ... Дөрөө нь бас модоор ухаж хийдэг, дугариг бөгөөд өргөн, дөрөөний сурын урт нь зохислог тул мордож буух ба морин дээрээ зогсоход тустай байдаг”.

Морьт цэргээ хүнд хөнгөн гэж хуваадаг. Хөнгөн морьт цэрэг бүр нум хоёр, хоромсого хоёр, сум жараар тоноглож, холын довтлолт ба гэнэтийн дайралтад бэлтгэдэг. ...Хүнд морьт цэрэг нь сэлэм, жад, сүх, алх, сэрээ, боом зэргээр тоноглодог. ...буюу бамбай манчуургаар тоноглож гардан тулалдахад хэрэглэдэг”. “Заримдаа бас тэмээ унаж довтлох ч буй. Энэ бол морьт цэргийнх нь байдал болно”.

“Байлдаанд юуны урьд нум сумын мэргэжилийг эрхэмлэдэг, дараа нь саран сэлэм болно. ... Тиймээс нум нь цөм бэхлэг бөгөөд зүйл төрлөөр ч олон буй. ... Олонхи нь эвэр элгэт нум болох бөгөөд уртаараа гурван тохой байдаг. Гурван зуун ярд хол харвахад хэрвээ гартаа 166 фунтын хүчгүй хүмүүс бол татаж чаддаггүй. ... Бас есөн зуун алд харвах их тэлэлтийн нум, таван зуун алд харвах бага тэлэлтийн нум гэж байдаг. ... Дундад орныг эзэлснээс хойш чөдөр оньст нум гэдэг зэвсгийг үйлдэж, найман зуун алхам харвах болжээ. ... бас эвхүүр оньст нум, гүйзи оньст нум зэргийг үүдэн бүтээв. Тэдгээр нь хүч их бөгөөд ихэсгэж багасгахад хялбар тул дэлхий дахинд хосгүй гэж түүхнээ үнэлэгдэв”.

“Сумын зүйл төрөл ч бас маш олон буй. Тэмээн ясан зэвтэй сум, багц зүүний зэвтэй сум ... хатгуурт сум, тавгийн зэвтэй сум... шөвгөн үзүүрт сум, гурвалжин үзүүрт сум гэж буй”.

“Зэвийн олонхийг нь ясаар үйлддэг, бас хүрлээр үйлдэх ч буй. ...Сумын эш нь бургасаар хийж, бүргэдийн өдөөр сэрвээлдэг тул харвахууд гуйвалзахгүй бөгөөд оноц сайтай байдаг”.

“Бас янз бүрийн хэрэгцээнд тохируулж янз бүрийн сумыг хэрэглэдэг. Дуут сумыг сүрдүүлэх буюу жолоодоход хэрэглэдэг. ...Галт сумыг дайсныг шатаах буюу хотыг довтлоход хэрэглэдэг. ...Хөнгөн зэвээр холын дайсныг харвадаг. ...Хүнд зэвээр дайсныг шархдуулан хохируулахад хэрэглэдэг”.

“Саран сэлмийг бол Хотонгийнхийг дууриан үйлджээ. Түүний иш нь бяцхан бөгөөд хавтгай тул хэрэглэхэд хөнгөн эвлэг байдаг. ...сэлэм нь нимгэн мөөр бөгөөд хурц тул цавчихууд хөнгөн бөгөөд оновчтой байдаг сан”.

“Жад нь урт охор хоёр зүйл буй. Ир нь цүүцийн хэлбэртэй тул чичихэд гулгадаггүй. Төмөр хуягийг ч нэвтэртэл нүхлэдэг”.

“Хуяг тоногт дуулга, цээжмэг, хуяг, тоорын хуяг ... навчин хуяг, мяндсан хуяг, шөрмөсөн хуяг гэж байдаг. Олонхийг нь арьс сураар үйлддэг бөгөөд зургаан давхар зузаан буй. ... Бас гууль буюу төмөр утсаар гөрсөн хуяг байдаг. Эсхүл төмөр навчийг арьсан хуягийн дээрээ хаддаг байна”.

“Тэдний бамбайг морьт бамбай, явган бамбай, бууны бамбай гэж ялгадаг. Бүр сураар гөрж хийдэг буюу модоор хийдэг байна. ... Сүүлдээ төмрөөр үйлдсэн тул бамбай, эвүүр бамбай мэтийн бамбай буй болжээ. ... Бамбайн дээр барс, арслан мэт амьтдын толгойг сийлдэг байна”.

“Баруун орон өөд дайлах үед бэхлэлт цайзыг эвдэх зэвсэгтэй болжээ. Анхандаа чулуун саа харвах үхэр бууг хэрэглэж байжээ. Тэр нь гурван зуун фунт чулуун сааг харвадаг тул маш их сүр хүчтэй зэвсэг болж байв. ... Тэр нь дөрвөн зуун ярд хол тусдаг. ... Ямар зэргийн бэхлэг барилгыг боловч бут ниргэж, газарт долоон тохой гүн шигддэг гэдэг билээ”. “Хот өөд довтлох үед тэрхүү үхэр буугаа хэдэн зуугаар эгнүүлэн жагсааж... өдөржин шөнөжин тасралгүй ээлжлэн харвадаг гэлээ”.

“Дундад орныг эзэлсний дараа гал буу хэрэглэх болов. Түүнээ оодон буу гэх буюу пуужин буу гэдэг. Эсхүл, баруун орны буу гэдэг... Бас хурдан буу ба арван таван гуурс бүхий шувтлагч буу гэдэг олон зүйл төрлийн сүр хүч төгөлдөр их буунууд байдаг. ...Ялангуяа тэсрэгч бөмбөг гэдгийг нь тавимагц түүний дуу нь тэнгэр газрыг донсолгодог бөгөөд хагас мугийн газрыг шатаадаг гэлээ”.

“Эдгээрээс гадна, бас хот авирах шат байдаг. ... сахих ба нэхэхэд хэрэглэх нохой байдаг. ... бас хот өөд ойртоход хэрэглэх өөрийн үхрийн арьсан таар ба гол гатлахад хэрэглэх арьсан тулам байдаг бөгөөд уул хаданд явах төмөр хүрдэт тэрэг (Сүбээдэйд өгсөн мэт) байдаг”.

“Монгол цэргийн эдгээр арвин бүрэн бөгөөд хурц зэвсэг тоноглол нь холын дайралт ба ойрын

тулалдаанд хэрэгтэйгээр барахгүй, хээрийн байлдаан ба бэхлэлтийн байлдаанд ч бүр ашигтай байсан билээ” гэжээ.

11 “Монгол Татарын тухай бүрэн тэмдэглэл” гэдэг номыг 1221 онд өмнөд Сүн улсаас Хаант Монгол Улсад томилсон элч Чжао Хун зохиожээ. “Хар Татарын тухай хэргийн товч” гэдэг номыг 1237 онд мөн өмнөд Сүн улсаас Өгөөдэй хааны төрд томилогдсон элч Пэн Да Я, Сюй Тин хоёр зохиожээ. Энэ хоёр зохиолын онцлог гэвэл тухайн үеийн Хаант Монгол Улсын эл талын байдал ба Монголын зан заншил зэргийг тэмдэглэсэн тэмдэглэл болно. Энэ хоёр зохиол нь Монголын түүхийн судлалд лавлууштай хөндлөнгийн баримт болдог юм. Ялангуяа Чин улсын сүүлчийн үеийн түүхч Ван Го Вэй авгай энэ хоёр зохиолыг нарийн судалж харгуулаад лавлууштай тайлбар зүүлтийг хавсаргажээ. 1979 онд Хармөрөн мужийн ардын хэвлэлийн хороо үүнийг Хайлар хотод анх удаа монголоор хэвлүүлж тархаажээ.

12 Сүбээдэй (Су-бе-э-тай)-н тухай түүхэн тэмдэглэлүүд нэлээд самуурч байдаг. “Юань улсын түүх”-д “Су-бу-тай” (121 дүгээр боть), “Сюэ-бу-тай” (122 дугаар боть) гэсэн нэрээр нэг хүнд хоёр намтар бичжээ. Агуулга нь үндсэндээ адил, түрүүчийх нь дэлгэрэнгүйвтэр, сүүлчийнх нь хураангуйвтар төдий л юм. “Эрдэнийн товч”-д “Жорчидын Шибэгэдэй” гэжээ. Энэ “Жорчид” гэдэг нь “Жарчигудай буюу Жарчиуд” гэсний хувирал болно. “Шибэгэдэй” бол “Сүбээдэй” гэсний ташаарал болох нь илхэн байна. Сүбээдэй Чингис хааныг дагаар ирсэн цагийг “Нууц товчоон”-ы 120 дугаар зүйлээс үзэхүл 1180 онд Жамуха, Тэмүжин хоёр салсан тэр үе болно. Ингээд 1189 онд Тэмүжин анх удаа хаан өргөмжлөгдөөд Сүбээдэйд тушаал томилсон юм. Гэтэл “Сүбээдэйн намтар”-уудад: “Чингис Балжуна нуурт хүнсгүй гачигдаж бүхийд Сүбээдэйн эцэг Хабал нэгэн сүрэг хонь хөөн туслахаар ирэхүй зуур, дээрэмд учирч завдталаа Сүбээдэй, Хорухун ах дүү хоёр хойноос нь ирж дээрмийг жадлан унагасанд бусад дээрмүүд нь дугаасан байна. Эцгийгээ ингэж аварсан бөгөөд хонин сүргээ Чингис хаанд хүргэн иржээ. Түүнчлэн тэд эцэг хөвгүүн, ах дүү нар эрэлхэг баатар гэсэн алдартай билээ. Ингээд Сүбээдэй Чингисийн дэргэд барьцаа цэргээр үйлчилж, зууны ноён болсон бөгөөд Найман зэрэг аймгийг төвшитгөхөд оролцов. Улаан барс жил улс байгуулахад тавин нэгдүгээр гавьяатнаар шагнагдав” гэж тэмдэглэж байна. Ийм бол Сүбээдэйн ирсэн нь 1180 оноос 1189 оны хооронд биш, харин 1203 онд ирсэн явдал болно. Тус товчоонд түүний түрүүчийнх нь явдлыг “Нууц товчоон”-той нэгтгэв. Сүбээдэйн эцэг харин 1203 онд ирсэн байж мэднэ.

13 Чингис хааны наян найман гавьяатны товч байдал (А, В, С, D гэж товчилсон нь дагалдвар9-тэй адил):

(1) Мүнлиг (А-д Мэнлиг гэжээ. Нэрсийн бичлэгийг бид ерөнхийдөө D-г баримтлав), Хонхотан овогтон, Чарха өвгөний хөвгүүн.

(2) Боорчу (А-д Боорчу), Арулад овогтон, Наху баяны хөвгүүн, Чингисийн дөрвөн хулгийн нэг.

(3) Мухулай, Жалайр овогтон, Тэлэгэтү баяны хөвгүүн, Чингисийн дөрвөн хулгийн нэг.

(4) Хорчи, Багарин овогтон, “Нууц товчоон”-ы 120, 121 дүгээр зүйлээс үзэхүл “Хорчи” болон “Усун өвгөн” нь нэг хүн болох бөгөөд бөө юм. Гэтэл 207 ба 216 дугаар зүйлээс үзвэл бас хоёр

хүнээр тэмдэглэжээ. “Нууц товчоон”-д ийм зүйл нэлээд буй. Ту Цзи нэг хүнээр, Ли Цзэ Фэнь хоёр хүнээр үзжээ. Тус товчоонд сүүлчийн тэмдэглэлийг баримтлав.

(5) Илүгэй (А-д Илугай), “Нууц товчоон”-ы 226 дугаар зүйлээс үзэхүл, Алчидай бол Илүгэйн ураг болно. Алчидай бол Чингисийн дүү Хачигуны хөвгүүн гэдэг. Тийм бол энэ нь Хэлэлгээнгүй Чингисийн ураг болох юм. Гэтэл Накамичиё авгай: Жалайрын Архай Хасарыг бас “Архай” гэж товчилдог тул Илүгэй бол Архайн ондоо бичлэг гэж үзжээ. Ту Цзи авгай “Нууц товчоон”-ы 12 дугаар ботид Илүхэй, Архайн нэр хамтаар дурдагддагийг эшилж, Накамичиёгийн үзэлтийг таарахгүй гэсэн бөгөөд “Эрдэнийн товч”-д олон дурдагддаг Сөнидийн “Гилүгэн баатар” бол энэ “Илүгэй” мөн гэж үзжээ. “Судрын чуулган”-д “Илүгай ноён” жалайр овогтон гэснийг Хонда Санаинобу өгүүлэлдээ эшлэжээ. Илүгэй хожим нь Өгөөдэйн хоёр зөвлөгчийн нэг нь байжээ.

(6) Жүрчидэй (А-д Жорчидай, “Юань улсын түүх”-д Жүрчидэй гэж бичдэг), Уругуд овогтон.

(7) Хунан, Гэнигэс овогтон, Жочи-гийн захиргаанд түмний ноён байсан бөгөөд түүний гурван зөвлөгчийн нэг нь байв. Хунан бол хаанд зоригтой санал тавигч дөрвөн хүний нэг нь болно.

(8) Хубилай, Барулас овогтон, Чингисийн дөрвөн хошуучийн нэг.

(9) Зэлмэ, Урианхан овогтон, Жарчигудай өвгөний хөвгүүн, Чингисийн дөрвөн хошуучийн нэг .

(10) Түгэ, Жалайр овогтон. Энэ бол “Нууц товчоон”-ы 137 дугаар зүйлд дурдсан Тэлэгэту Баяны ач буюу Чулуун Хайчи-гийн хөвгүүн “Түнхэ” мөн гэж Ту Цзи магадлажээ.

(11) Тэхи, Бэсүд овогтон, Өгөөдэйн хоёр зөвлөгчийн нэг нь бөгөөд хаанд зоригтой санал тавигч дөрвөн хүний нэг нь болно.

(12) Толун, Хонхотан овогтны Мүнлигийн хөвгүүн, бас Толун чэрби гэдэг. Түүний мянган нь Тулуйн захиргаанд байжээ.

(13) Өнгүр, хиюуд овогтон, Бартан баатарын ахмад хөвгүүн Мэнгитэ Хиюуны хөвгүүн, “Судрын чуулган”-д баяд овогтон гэдэг бөгөөд Ли Цзэ Фэнь үүнийг нь баримталжээ.

(14) Чөлгэтэй, Сүлдүс овогтон. Үүнийг “Нууц товчоон”-ы 120 дугаар зүйлд “Чөлгэтэй” гэж тэмдэглэж байв.

(15) Борухул, Үгүшин буюу Унжин овогтон. Өгэлүн эхийн тэжээсэн дөрвөн хөвгүүний нэг нь бөгөөд Чингисийн дөрвөн хүлгийн нэг.

(16) Шигихутуху (А-д Шихихутуг), Татар овогтон. Өгэлүн эхийн тэжээсэн дөрвөн хөвгүүний нэг нь бөгөөд бүх улсын их заргач.

(17) Хөхэчү (А-д Хүчү, D-д Үхүчү, С-д “ху” үсэг нь хажуудаа “чжун”-тай, ингээд би “Үхүчү” гэснийг “Хөхэчү” гэж тэмдэглэлээ), Мэргид овогтон, Өгэлүн эхийн тэжээсэн дөрвөн

хөвгүүний нэг нь бөгөөд хааны дүү Отчигин ба Өгэлүн эхийн дөрвөн зөвлөгчийн нэг. “Нууц товчоон”-ы 114 дүгээр зүйлд “Хүчү” гэж тэмдэглэж байна.

(18) Хөхэчү, Бэсүд овогтон. Өгэлүн эхийн тэжээсэн дөрвөн хөвгүүний нэг нь бөгөөд хааны дүү Отчигин ба Өгэлүн эхийн дөрвөн зөвлөгчийн нэг.

(19) Хоргусун, овог нь дурдагдаагүй. “Нууц товчоон”-ы 243 дугаар зүйлд “Хоргасун” гэж дурдагддаг, энэ “Хоргусун”, “Хоргасун” хоёр, нэг хүн байж мэднэ. Тэр нь Өгэлүн эх ба Отчигин ноёны дөрвөн зөвлөгчийн нэг нь байв.

(20) Үсүн, Хэрэйд овогтон. Үүнийг бас “Юань улсын түүх”-ийн 122 дугаар ботид дурдагддаг Хасана гэдэг.

(21) Хуйлдар, бас Хуйлдар сэцэн гэдэг. Мангуд овогтон, 1206 онд нэгэнтээ үхсэн тул мянганы ноёныг нь нэхэмжлэж, хөвгүүнээр нь шаруулжээ.

(22) Шилухай (А-д Шилүхэй), Жэгүрэйд овогтон.

(23) Жэтэй (А-д Житэй), Мангуд овогтон. Тулуйн хоёр зөвлөгчийн нэг.

(24) Тахай, Сүлдүс овогтон. Үүнийг “Нууц товчоон”-ы 120 дугаар зүйлд дурдсан Чөлгэтэйн дүү Тахи мөн гэж Ту Цзи авгай нотложээ.

(25) Цагаан гуа, Нэгүс овогтон (бас Чонос овогтон гэдэг). Үүнийг “Нууц товчоон”-ы 120 дугаар зүйлд “Цагаан Ува” гэж, 129 дүгээр зүйлд “Цагаан гуа” гэж хэдэн янзаар галиглаж буй. Бид “Цагаан гуа”-гаар нь нэгтгэв. Энэ нь хэрэг дээрээ нэг л хүн юм. Тэр “Арван гурван хүрээний байлдаан”-д Жамуха-д алагдсан тул наян найман гавьяатанд нэхэмжлэн өргөмжилжээ. Дараа нь түүний хөвгүүн Нарийн Тоорил ширжээ (залгамжилжээ – хө.).

(26) Алаг, Нүцгэн Багарин овогтны Ширгүгэтү өвгөний хөвгүүн, төв түмний ноён Наяагийн ах. Энэ үед Ширгүгэтү өвгөн нэгэнт үхсэн тул ах дүү хоёр зэрэг өргөмжлөгджээ. Алаг бол Хубилай хааны үеийн баян Чинсаны өвөг нь болно.

(27) Сорхан шар, Сүлдүс овогтон Чингисийн дөрвөн хулгийн нэг болох Чулууны эцэг. Чулууныг 95 мянганы ноёнд дурдсангүй учир Сорхан шар амьд байж, мянганы ноёноо тэр хариуцаж байсанд оршино гэж Накаичиё авгай үзэж байв.

(28) Булуган, Барулас овогтон. “Юань улсын түүх, Хуринши-гийн намтар”-т “Булуган халжа” гэжээ.

(29) Карачар, Барулас овогтон, Суху сэцэний хөвгүүн. Чагаадайн дөрвөн зөвлөгчийн нэг.

(30) Хөхэчүс, Багарин овогтон. Чагаадайн дөрвөн зөвлөгчийн нэг нь бөгөөд хаанд зоригтой санал тавигч дөрвөн хүний нэг нь билээ. Тиймээс тэр Чагаадайг тун сүрхий шүүмжилж байжээ.

(31) Сүйхэтү, бас Сүйхэтү чэрби гэдэг, Хонхотан овогтон.

- (32) Наяа, Нүцгэн Багарин овогтны Ширгүгэтү өвгөний хөвгүүн, Алаг-ийн дүү, төв түмний ноён, удсангүй үхжээ.
- (33) Жуншуй (А-д Жуншу), ноёхин овогтон. “Нууц товчоон”-ы хятад галиглалуудад “Чжун-со, Чжун-сай, Чжун-шуай” гэж хэд хэдэн янзаар бичиж байдаг. Өгэлүн эх болон хааны дүү Отчигиний дөрвөн зөвлөгчийн нэг.
- (34) Хүчүгүр, Бэсүд овогтон, арван нэгдүгээр мянганы ноён Тахи-гийн дүү.
- (35) Бала Орунардай, Орунар овогтон. Жалайрын Бала лугаа адил нэртэй болохоор “Бала Орунудай” гэж овгийг нь дагалдуулан ялгаварлажээ. Гэтэл “Нууц товчоон”-ы А, С, D гурван хэвлэлд бүр (35) Бала, (36) Орунудай гэж хоёр хүн болгожээ. Ингээд (35)-аас дорогш дугаарлал нь ч зөрсөн байна.
- (36) Дайр, үүнийг “Увас Мэргидийн Дайр Усун” мөн гэж Накамиchie авгай үзжээ. Учир нь Дайр усун бол Чингисийн Хулан хатны эцэг тул гавьяатны адил хүндэтгэх ёстой гэв. Гэтэл “Биеэр дайлсан тэмдэглэл”-д Дайр усун дахин урван явсан тул Чингис хаан, Борухул болон Чимбай түрүүтэй баруун гарын цэргийг томилж сөнөөсөн гэдэг билээ. Бас “Судрын чуулган”-ы аймаг угсааны магадлалтад хэрэйд овогтны “Дайр баатар” гэгч Чингисийн хамт Дундад Азийг дайлахад хошуучилж байсан хүн бол 36 дугаар мянганы ноён мөн гэжээ. Хонда Санаинобу-гийн өгүүлэлд “Хонхотан овогтон” гэв.
- (37) Мөхэ, үүнийг Хонда Санаинобу Жалайр овогтон гэв. Гэтэл Накамиchie “Юань улсын түүх”-ийн “Бурушийн намтар”-аар эшилж, Бурунши-гийн дээдэс Хонгирадын “Ман гэ” гэдэг бол энэ “Мөхэ” мөн гэжээ. “Нууц товчоон”-ы 243 дугаар зүйлд дурдсан “Мөнх” бол энэ “Мөхэ” мөн гэж Ту Цзи авгай үзжээ. Тэр бол Чагаадайн дөрвөн зөвлөгчийн нэг нь болно.
- (38) Бужир, “Юань улсын түүх”-д гардаг “Бу-жи-эр, Ву-жи-эр” ба “Нууц товчоон”-ы 191 дүгээр зүйлд дурдагдсан “Бцчаран чэрби” бол бүр энэ “Бужир”-ын ондоо бичлэг гэж Ту Цзи авгай үзжээ. Гэтэл бүр баримтаар дутмаг байна.
- (39) Мөнгүгүр (А д Мөнгүүр), Хонда Санаинобу-гийн өгүүлэлд Сагашуд овогтон гэжээ. Гэтэл “Нууц товчоон”-д ийм овог байдаггүй билээ. Тэр бол Жочи-гийн гурван зөвлөгчийн нэг нь болно.
- (40) Долугадай, “Нууц товчоон”-д нэг л удаа дурдсан бөгөөд овог нь тодорхойгүй.
- (41) Бөхэн, Уругудай овогтон. “Юань улсын түүх”-гийн 135 дугаар боть дахи Худу-гийн эцэг Бү-кэн гэгч энэ “Бөхэн” мөн гэж Накамиchie авгай тэмдэглэжээ.
- (42) Худус, Барулас овогтон, Хубилай ноёны дүү. “Нууц товчоон”-ы 191 дүгээр зүйлд дурдагдсан “Худус халчан” гэгч мөн энэ “Худус” болох мэт.
- (43) Марал, зөвхөн гавьяатны нэрд л нэг удаа дурдагджээ. Өөр номд ч гардаггүй тул овог гарал зэрэг нь бүр тодорхойгүй.

- (44) Жэбхэ, Жалайр овогтон, Тэлэгэту Баяны хөвгүүн. Хасарын зөвлөгч.
- (45) Ёрухан (А д Ерүхэн), Жалайр овогтон. “Юань улсын түүх”-д “Сорухан” гэжээ. “Сорухан” бол Үнэгэн давааны байлдаанд үхсэн гэдэг билээ.
- (46) Хөх, Хөх бол “Алтан Татарын Хөх Бухын товчилбор” гэж Накамичиё-гийн үзсэнийг Ту Цзи сэжиглэлтэй гэжээ.
- (47) Зэв, Бэсүд овогтон. Чингисийн дөрвөн хошуучийн нэг болно. “Эрдэнийн товч”-д “Есүд овогтон” гэдэг. “Судрын чуулган”-д “Нууц товчоон”-ы “Бэсүд” гэснийг бүр “есүд” гэсэн нь “Эрдэнийн товч” лугаа нийцдэг байна гэж Ту Цзи авгай тодорхойлжээ.
- (48) Удугай, “Нууц товчоон”-д нэг л удаа дурдагдсан бөгөөд өөр номд бүр харагддаггүй.
- (49) Бала чэрби, жалайр овогтон, Сача Домуг-ийн хөвгүүн, Архай Хасарын дүү. Тулуйн хоёр зөвлөгчийн нэг нь болно.
- (50) Хэтэ, “Нууц товчоон”-д хоёр удаа л дурдагддаг. Овог нь тодорхойгүй. Жочи-гийн гурван зөвлөгчийн нэг нь болно.
- (51) Сүбээдэй, Урианхай овогтон, Хабалын хөвгүүн. Чингисийн дөрвөн хошуучийн нэг нь болно.
- (52) Мөнх, Халжа, Мангуд овогтон, Хуйлдарын хөвгүүн. Үүнийг “Нууц товчоон”-ы А, С, D гурван хэвлэлд бүр “Мөнх”, “Халжа” гэж хоёр хүнээр тэмдэглэжээ. “Биеэр дайлсан тэмдэглэл”-д “Му гэ хань цза” гэж, “Юань улсын түүх”-гийн “Өгөөдэй хааны шастир”-т “Мэн гу хань цза” гэж, Рашидын номд “Мункэ-калджа” гэж бүр нэг хүнээр тэмдэглэж буй. “Халжа” гэдгийг “Юань улсын түүх”-д “Хо чжэ” гэж тэмдэглэсэн харагддаг билээ. Тиймээс тэр нь “галч” гэсэн үг байсан ч байж мэднэ.
- (53) Хурчакус, “Нууц товчоон”-д нэг л удаа дурджээ.
- (54) Хөхи (А д Хүүхэй). “Нууц товчоон”-ы 277 дугаар зүйлд дурдагдсан “Жангги бол энэ “Хөхи” мөн гэж Накамичиё болон Ту Цзи авгай үзжээ. Хонда Санаинобу-гийн өгүүлэлд хиюуд овогтон гэв.
- (55) Бадай Орунар овогтон (Хонда Санаинобу-гийн өгүүлэлд), “Муу өндөрийн байлдаан”-д Чингист чимээ хүргэсэн хүн.
- (56) Хишилиг, Орунар овогтон (Ту Цзи-гийн тэмдэглэлд). Ли Цзэ Фэнь авгай 55 дугаар мянганы ноён Бадайн дүү гэжээ. Гэтэл “Нууц товчоон”-д ийм тэмдэглэл байгаагүй.
- (57) Хэтэй, Уругуд овогтон, Жүрчидэй-н хөвгүүн.
- (58) Чагурхан, Урианхан овогтон, Жарчигудай-н хөвгүүн. Энэ бол “Нууц товчоон”-ы 120 дугаар зүйлд дурдсан Зэлмэ-гийн дүү Чагурхан болно.

(59) Онгиран, (А д Хонгиран), “Нууц товчоон”-д нэг л удаа дурджээ.

(60) Тохун, Үгүшин (Үгүшин) (буюу Унжин) овогтон. Борухул ноёны хөвгүүн. “Юань улсын түүх, Борухулын намтар”-т Борухул үхсэн хойно хөвгүүн нь мянганы ноёныг нь ширлаа гэдэг нь таарахгүй юм. Хэрэг дээрээ эцэг хөвгүүн хоёул хамтдаа мянганы ноён өргөмжлөгджээ. “Нууц товчоон”-ы А, С хоёр хэвлэлд энэ “Тохун” болон (61) дүгээр дэх “төмөр” хоёрыг нийлүүлж “Тохун төмөр” гэдэг нэг хүн болгожээ.

(61) Төмөр, Сөнид овогтон (Хонда Санаинобу). “Гүюг хааныг үхсэн хойно, Хамиши хатны Алтайд хуралдуулсан олон ван нарын хуралдайд томилон оролцуулсан Хар Хорум хотын захирагч Төмөр гэгч энэ хүн мөн” гэж Накамичиё, Ту Цзи нар тэмдэглэжээ.

(62) Мэхэтү, хиюуд овогтон (Хонда Санаинобу). “Нууц товчоон”-ы 270 дугаар зүйлд: “Багдад лусын Халибай султанд аялсан Чурмахан хорчи-гийн гээг (хойноос) огтор Мэнгэтү хоёрыг аялуулав” гэж дурдсан “Мэнгэтү” бол энэ “Мэхэтү” мөн гэж Накамичиё тэмдэглэжээ.

(63) Хадаан, дархад овогтон. Энэ нь “Нууц товчоон”-ы 174 дүгээр зүйлд дурдагддаг “Хадаан-Далдурхан” (А, В, С, D ийн 120 дугаар зүйлд Хадаан, Далдурхан гэж хоёр хүнээр тэмдэглэжээ) болно. Гэвч энд “Далдурхан”-ыг нь товчилжээ. Бас тэмдэглүүштэй нь, Хонда Санаинобу авгайн “Чингис хааны мянгат” гэдэг өгүүлэлд Сөнид овогтон гэжээ. Энэ нь нэр нэгтэй хүнийг эндүүрсэн байж мэднэ.

(64) Мораха, “Нууц товчоон”-д гавьяатнаар нэг л удаа дурджээ, өөр мэдээ үгүй.

(65) Дори буха (А-д Дори бөхэ), “Нууц товчоон”-д гавьяатнаар нэг л удаа дурджээ. Өөр мэдээгүй.

(66) Идүй-Хадай, “Нууц товчоон”-д гавьяатнаар нэг л удаа дурджээ, өөр мэдээгүй. Чагаадайн дөрвөн зөвлөгчийн нэг гэж Ли Цзэ Фэнь тэмдэглэжээ.

(67) Ширахул, хэрэйд овогтон. “Юань улсын түүх” дэх Есөн буха-гийн дээдэс гэж Накамичиё тэмдэглэжээ.

(68) Дагун, овог нь тодорхойгүй. Хубилай хааны шастирт, Чжун Тун-гийн анхдугаар он (1260 он)-ы 8 сард 2.500 лан мөнгөөр шагнагдсан бичээч “Да-ун” гэдэг энэ “Дагун” бололтой гэж Ту Цзи авгай тэмдэглэжээ.

(69) Тамачи, “Нууц товчоон”-д гавьяатнаар нэг л удаа дурджээ, өөр мэдээгүй.

(70) Хагуран, “Нууц товчоон”-д гавьяатнаар нэг л удаа дурджээ, өөр мэдээгүй.

(71) Алчи, овог нь тодорхойгүй. “Юань улсын түүх”-ийн “Сүбээдэйн намтар”-т дурдагддаг “А-ли-чу” гэгч энэ “Алчи” бололтой гэж Накамичиё тэмдэглэжээ. Алчи бол “Алчидай”, 5 дугаар мянганы ноён Илүгэйн ураг гэж Ли Цзэ Фэнь тэмдэглэжээ.

(72) Тобсаха, дөрвөн овогтон (Хонда Санаинобу). “Нууц товчоон”-ы арван хоёр ботийн хэвлэлд “То-са-ха” гэж бичжээ.

(73) Тунхуйтай, үүний тухай хоёр янзын мэдээ буй. Нэг нь Накамичиё авгай “Чжэнь хай” (Хингай – Плано Карпинийн бичлэг)-ийг мөн гэжээ. Учир нь “Чжэнь хай”-г “Чан-чунь аршийн баруунш зорчсон тэмдэглэл”-д “Тянь Чжэнь Хай” гэдэг. Бас энэ “Чжэнь Хай” 1203 оны “Балжуна нуурын тангарагтан”-д байлцсан тул гавьяатнаар шагнагдах ёстой. Тиймээс “Тун-хуй-тай” гэдэг нь “Е-люй Ту-хай”-гийн хувирал байлгүй гэж тэмдэглэжээ. Гэтэл, Ту Цзи авгай үүнийг нь таарахгүй гэсэн бөгөөд энэ “Тун Хуй Тай” бол “Е-люй Ту-хай” (Елюй Тохуа) мөн гэжээ. Учир нь “Юань улсын түүх”-гийн “Елюй Ахайн намтар”-т: Елюй Ахайн “өвөг нь Савар гэдэг, Алтан улсад алба хааж, хуанчжоугийн түшмэл болжээ. Ингээд гэрээрээ Хуаньчжоу-д нутагласан билээ. Ахай олон улсын хэлийг мэддэг тул Алтан улсын сүүлчийн үед Ван ханд учрах элчээр томилогдож явахуйдаа Чингис хаантай учирчээ. ... Дараа жилд нь дахин элчээр ирэхүйд дүү Елюй Тохуа лугаа хамт иржээ. Түүнчлэн Тохуа-г барьцаа болгон (хааны) хэвтүүл болгожээ. Хар нохой жил (1202 он - чухамдаа 1203 он бол зүйтэй - эшлэгч) Ван хан андгайллаасаа урваж хааныг дайрсан билээ. Ингээд хаан гачигдсан учир ураг төрөл, сайд түшмэдийн хамт Балжуна нуурын усыг ууж тангараглахад Ахай ах дүү хоёул бүр оролцсон билээ. Тиймээс Ахай ах дүү хоёр, гавьяатны дотор байвал зохих юм. Гэвч “Нууц товчоон”-ы наян найман гавьяатанд тэр хочрын нэр үгүй нь сэжиглэлтэй учир билээ. Одоо харин “барьцаа” гэсэн утгатай То лу хуа (Доруха) гэдэг монгол үгийг магадлаж олжээ. Энэ нь “Тун хуй” (Тунхуй) гэсэнтэй ойртож байна. Елюй Тохуа бол ахынхаа барьцаа болон ирсэн тул Монголчууд “Тохувадай” (Ту-хуа-тай) гэж дууддаг. Тиймээс энэ “Тун Хуй Тай” бол “Е-люй Ту-хуа”-гийн хувирал гэж үзэж болно” гэжээ.

(74) Добуха, Хэрэйд овогтон, Ширахул (67 дугаар гавьяатан)-ын ах нь билээ.

(75) Ажинай, Хонгирад овогтон (Хонда Санаинобу).

(76) Түйтэгэр, “Нууц товчоон”-д гавьяатнаар нэг л удаа дурджээ, өөр мэдээгүй.

(77) Сэчэгүр (А д Сачагур), горлос овогтон.

(78) Жадар (А д Жидар), Өгөөдэй хааныг даган Кипчаг, Ханлин, Сартуул зэрэг улсад дайлж, гавьяатай явсан “Жи-то-эр” гэгч энэ Жэдэр (Чжэ-де-эр) мөн гэж Ту Цзи авгай тэмдэглэжээ. Гэтэл Накамичиё авгай “Алчидайн адуучин” - “Биеэр дайлсан тэмдэглэл” дэх “Е-де-эр” гэгч энэ “Чжэ-де-эр” мөн гэжээ.

(79) Улар хүргэн, энэ хүргэн “Нууц товчоон”-д нэг л удаа дурдагджээ. Хонда Санаинобу-гийн өгүүлэлд Хонгирад овогтон гэжээ.

(80) Хинхиадай, Олхунуд овогтон. Энэ хүн “Нууц товчоон”-ы 120 дугаар зүйл болон 202 дугаар зүйлд хоёр удаа дурдагджээ. А хэвлэлд (81)дүгээр гавьяатан Буха хүргэнтэй нийлүүлж “Хингиадай Буха хүргэн” гэсэн нэг хүн болгожээ. В хэвлэлд хаалтад “хүргэн” гэж тодорхойлжээ.

(81) Буха хүргэн, “Нууц товчоон”-ы 137 дугаар зүйлд дурдагддаг Жалайр овогтны Хүн гуагийн хөвгүүн, Мухулайн дүү “Буха” мөн гэж Накамичиё авгай тэмдэглэжээ. Гэтэл “Ту Цзи-гийн тэмдэглэл”-ийн 153 боть (Монголын овог төрөл)-д “Буха хүргэн бол жад (харь) Баяд овогтон” гэж тэмдэглэж байна. Энэ Баяд, Чаншигуд хоёр овогтныг Мэнгэтү хиюн-ий хөвгүүн

Өнгүр дагуулж, Чингис хаанд эрт нийлсэн бөгөөд “Арван гурван хүрээний байлдаан”-д Чингисийг дэмжиж байсан билээ.

(82) Хурил, энэ хүнийг Накамичиё болон Хонда Санаинобу бүр Тайчигуд овогтон гэж тэмдэглэж байх бөгөөд энэ хурал бол Онон мөрөнд Тайчигуд-тай байлдахад дурдагддаг “хорил жанжин” мөн гэж тодорхойлжээ. Гэтэл “Тайчигудын Хурил дийлэгдэж, Найманд дутаасан тул Монголын гавьяатанд байлцах ёсгүй, харин нэр адил хоёр хүн магадгүй” гэж Ту Цзи авгай тэмдэглэжээ. В хэвлэлд “хүргэн” гэж тодорхойлжээ.

(83) Ашиг хүргэн, үүний тухай мэдээнүүд адилгүй байна. “Нууц товчоон”-ы 207 дугаар зүйлд Хорчийг түмний ноён болгоход “Гурван мянган багарины дээр Тахай, Ашиг хоёр лугаа Адархины Чонос, Түгүлүс, Тэлэнгүд”-ийг нэмж түм дүүргэн захируулав гэдэг тэмдэглэл байдаг. Накамичиё дээрх тэмдэглэлийг үндэслэж “Ашиг” бол Тахайн хамт Сүлдүс овогтон болно гэж тэмдэглэжээ. Гэтэл Хонда Санаинобу-гийн өгүүлэлд “Ашиг хүргэн Хонгирад овогтон” гэж тэмдэглэж буй.

(84) Хадай хүргэн, энэ бол “Ойрадын Хутуга бэхи-гийн хөвгүүн” гэж Накамичиё тэмдэглэжээ. “Юань улсын түүх”-ийн “гүнжийн илтгэл”-д Янь Ань гүнж Хори (ор)-ын хүргэн гэжээ.

(85) Чихү хүргэн (Чи-гу Гу-ле-цзэнь, А-д Чигу), Хонгирад овогтон. Энэ “Чи-гү” гэсэн нэрийг “Биеэр дайлсан тэмдэглэл”-д “Чи-гу” гэж, “Юань улсын түүх, Тайцзу-гийн шастир”-т “Чи Цюй” гэж, “Өгөөдэй хааны шастир”-т “Чи Цзюй” гэж, “Гүнжийн илтгэл”-ийн Юнь Го гүнжийн байр дахи Түмэлүн (Ту-мань-лунь) гүнжийг “Чи Ку” хүргэнд богтлов гэж тус тус адилгүй бичлэгэр тэмдэглэж буй. “Гүнжийн илтгэл”-д энэ “Түмэлүн” нь аль хааны гүнж, “Чи-ку” хүргэн чухам аль овогтон зэргийг тодорхой тэмдэглэсэн мэдээгүй. Гэвч, Рашидын номд “Тайцзу-гийн дөрөвдүгээр охин Түмэлүн-ийг Хонгирад овогтны Алчи ноёны хөвгүүн Чихү хүргэнд богтлов” гэж тэмдэглэж буй. Алчи ноён гэдэг бол даруй Дэй сэцэний хөвгүүн, Чингисийн их хатан Бөртэ үжиний дүү (зарим тэмдэглэлд ах нь гэдэг) болно. Энэ бол “Юань улсын түүх”-д дурдагддаг төрийн нагац Алчи ноён мөн, Чихү бол Алчи ноёны их хөвгүүн, Учан, Начаны ах нь болно. Бас “Монгол Татарын тухай бүрэн тэмдэглэл”-д: “(Чингисийн) гуравдугаар гүнжийн нэр А Оу, Шан Шу Лин төрийн нагацын хөвгүүнд гарав” гэж тэмдэглэж байх бөгөөд “Ань Чи На Е (Алчи ноён – эшлэгч) Шан Шу Лин-гийн тушаалд хүрэв. Тэр бол Чингисийн авааль хатны дүү юм” гэж тэмдэглэж байна. Энэ тэмдэглэл нь Түмэлүн бол Чингис хааны охин, Алчи ноёны хөвгүүн Чихү-д богтлогдсоныг гэрчилж байна. Энэ тухай Хун Цзюнь авгай “Дэй сэцэний намтар”-аас эшилж: “Алчи-гийн хөвгүүн Учанд Тулуй-н охиныг богтолсныг тэмдэглээд, Түмэлүн-ийг Чихү-д богтолсныг товчилжээ. Энэхүү “А Оу” гэсэн ондоо нэрийн тухай магадлалт харагдаагүй, эсхүл энэ нь ташаа үсэг байж мэднэ” гэж тэмдэглэсэн бөгөөд бас “Д’Оссоны монгол түүх”-ийн “Хатад гүнжийн илтгэлийн нөхвөр найруулал” гэдгийг эшилж: “Богдын түшээ гэгээн сэцэн ивээлт Хуанхү (Бөртэ үжинийг хэлж буй – эшлэгч)-гийн дөрөвдүгээр охин Түмэлүнийг Хонгирад аймгийн ахлагч Ачи (А Чи) ноёны хөвгүүн Шэнь Гу-д богтлов. Түмэлүн бол Тулуйгаас насаар ах билээ. Шэнь Гу сүүлээр нь Хонгирадын дөрвөн мянган морьт цэргийг дайчилж, Түмэдийн газрыг сэргийлэв” гэж тэмдэглэжээ. Энэ тэмдэглэл дэхи “Ачи” гэдэг нь Алчи-г, “Шэнь Гу” гэдэг нь Чихү-г хэлж байна.

(86) Алчи хүргэн (А-ла-чи гу-ле-цзянь), үүнийг “Биеэр дайлсан тэмдэглэл”-д Хонгирад овогтны “Ань-чи На-янь” гэж, “Өгөөдэй хааны шастир”-т “Ань-чи На-янь” гэж, “Төмөр хааны шастир”-т “Юань Чжэнь-ий анх он (1295 он)-д “Ань-чи На-янь”-ийг хааны нагац хэмээв” гэж, “Лю Бо Линь-ий намтар”-т “Ань Чжэнь На Янь” гэж, “Дэй сэцэний намтар”-т “Хөвгүүн нь “Ань Чэнь” улаагчин гахай жил (1287 он) төрийн нагац цолыг шагнажээ” гэж “Алчи” гэдэг нэрийг нь тус тус ондоо үгсээр тэмдэглэж байна. “Гүнжийн илтгэл”-гийн Лу Го гүнжийн байр дахи “Лу Го эгчмэд гүнж Есүбуха бол Тулуйн охин, хааны нагац Лу Чжун Оу Алчи ноёны хөвгүүн Учан хүргэнд богтлов. Лу Го гүнж Сэчэхэн бол Тайцзу-гийн ач охин, Учан ноёны дүү Начан хүргэнд богтлов” гэжээ. “Алчид богтолсон хааны охин нь “Юань улсын түүх”-д гардаггүй. Алчид төрийн нагац цолыг шагнаагүй, түүнийг хүргэн гэдэг нь Тайцзу-гийн үеийн явдал болно” гэж Накамичиё авгай үзэж байв.

(87) Буту хүргэн, Ихирэс овогтон. Буту-д урьдаар хааны охин дүү Тэмүлүн гуа гүнжийг богтолж, Тэмүлүн гуа үхсэн хойно, Чингис хааны ахмад охин Хожин бэхи-г залган богтолжээ.

(88) Алахуши Дигит Хури хүргэн, Онгуд аймгийн ахлагч.

Наян найман гавьяатан гэдэг нь дээрх мэт. Ерэн таван мянганы ноён гэдэг бол: Алчи хүргэний гурван мянга, илүү хоёр мянга, Буту хүргэний хоёр мянга, илүү нэг мянга, Алахуши Дигит Хури хүргэний таван мянга, илүү дөрвөн мянга, нийлээд долоон мянга болох тул наян наймын дээр энэ долоог нэмвэл яг ерэн таван мянга болох юм.

14 Янз бүрийн зарлигийн пайз болон тэмдгийг Чингис хааны үеэс эхлэн хэрэгжүүлжээ. Энэ тухай Чжань Чжэнь Пэй авгайн тэмдэглэлд хураангуйлан тэмдэглэсэн байв. Түүний гол агуулга нь доорхи мэт.


“Алтан барсын тэмдэг”-ийг эхлээд Хингай, Чэрби нарт шагнаж, дараа нь Лю Бо Линь, Елюй Люгэ, Ши Тянь Ни зэрэг арваад хүнд шагнажээ. Энэхүү барсын тэмдэг гэдэг нь урьд урьдын төрүүдэдийн нэг барсын тэмдгийг хоёр хэсэг салгаад танилцах тэмдэг болгодогтой адилгүй, харин тусгаар нь хэрэглэдэг билээ.

Үүнээс гадна бас “Алтан тэмдэг”, “Мөнгөн тэмдэг” гэж байдаг. Түүний гадар хэлбэр, их багын хэмжээ нь “Алтан барсын тэмдэг”-тэй адилаар боловч пайзын өнгөн талд нь зөвхөн үсэг л сийлж буй, зураг байдаггүй. Энэ бол ондоо газар нь болно. Тиймээс түүнийг бас “Гөлгөр алтан пайз”, “Гөлгөр мөнгөн пайз” гэдэг. Энэ “Алтан тэмдэг” нь бас цул алтан пайз, шармал алтан пайз гэж хоёр хуваадаг бөгөөд бас хятад үсгийн, уйгуржин үсгийн, Пагба үсгийн (Хубилайгаас хойш) гэж ялгаатай байдаг.

Эдгээр пайз тэмдгийг хэрэглэх хэмжээ зэрэг нь бас нарийн тодорхой тогтоолтой байдаг юм. Их төлөв зарлигийн элч, цэргийн ноёд улаа уналгад хэрэглэхээс гадна, ширах ноёд бас уламжлан хэрэглэдэг ба хуучны төрийн эзэн, түшмэлд ч шагнадаг. Цэргийн бачим албанд дотоод гадаадын элчид улааны гэрч болгодог.

Түүний зүйл хуваарь нь:

Монголын пайз тэмдэг



Эдгээр пайз тэмдгийн олонхи нь одоо бүр үрэгджээ. Зарим нь бидний гарт зөвхөн зураг л буй. Тус товчоонд хавсаргасан зургууд бол түүний доторхи цөөн хэд нь болно

15 Алага бэхи бол Чингис хааны гуравдугаар охин нь болно. 1207 онд хаан түүнийг Онгудын түрүү Алахуши Дигит Хури-д богтлон өгөхүйд Алахуши нас өтлөв гэж өөрөө хүлээн авсангүй, ахмад хөвгүүн Буяншибал-даа өгчээ. Дараа нь 1211 онд Чингис хаан Алтан улсыг анх удаа дайлах үед, Алахуши Дигит Хури өөрийн цэргээ авч Чингисийн их цэргийг Алтан улсын хилийг өнгөртөл замчлав. Тэр үед Чингис хаан түүнийг өөрийн аймгаа захир гэж буцаажээ. Энэ үед Онгудын язгууртадын дотор хувьсал гарч, анхандаа Алахуши-ийг эсэргүүцэж байсан этгээд нь Алахуши, Буяншибал эцэг хөвгүүн хоёулыг алав. Ингээд Алага бэхи Алахуши Дигит Хури-гийн бага хөвгүүн Буюуха болон Алахуши-гийн ач хөвгүүн Жинхүй (Алахуши-гийн ах Найсуй-н хүү) хоёрыг авч амь зугтан гарч, Юнь Юнь Нэй (одоогийн орчинд байжээ) ээр тэнэн бэдэрч байсныг Чингис хааны цэрэг Юнь Юнь Нэй-г эзлэн аваад тэднийг таслан авч хүнд хишиг хүртээсэн байна. Тэр үед Буюуха нас бага байсан тул Жинхүй-д Бэй Пин Ван цол өргөмжилж Онгуд аймгийг захируулсан бөгөөд Монголын заншлаар Алага бэхи-г Жинхүй-д залган өгсөн билээ. Дараа нь 1219 онд Чингис хаан баруунш Хорезмыг дайлах үед Буюуха Чингисийг даган явж, жигүүр нь онгудын түмэн морьт цэргийг дайчилж, Го ван Мухулай-н захиргаанд дундад орон(Алтан улсыг хэлж буй)-г дайлаар мордож, дайны дунд үхжээ. Жинхүй-г дундад оронд мордсон үед Алага бэхи гүнж Онгуд аймгийг орлон захирч байсан бөгөөд говийн өмнөх Монголчуудыг хамтад нь захирч байв. Иймээс түүнийг “Төр захирах гүнж” гэдэг байна. Жинхүйг үхсэн хойно, хэдийгээр түүний хөвгүүн Нэгүд онгудын вангийн орыг ширсан боловч нас бага тул аймгийн хэргийг бас Алага бэхи гүнж захирч байжээ. Дараа нь Буюуха арван долоон настайдаа (1225 он) баруун орноос буцан ирж, Бэй Пин ван цол өргөмжлөгдсөн бөгөөд бас Монголын заншлаар бэргэн Алага бэхи-г залган авчээ.

“Нууц товчоон”-ы 239 дүгээр зүйлд Алага бэхи-г Онгудад өгөв гэж тэмдэглэснээс биш, чухам хэнд өгснийг тэмдэглэсэнгүй. Эхэндээ Алахуши Дигит Хурид өгөх гэсэн тул, Алхуши-ийг шагнахад түүнийг хүргэн гэжээ.

Рашидын ном, Д'Оссоны ном зэрэгт Бөртэ үжиний таван охиноос гуравдугаар Алага бэхи-онгуд аймгийн түрүү Алахуши Дигит Хурид өгөхөд Алахуши нас их гэж ахын хөвгүүн (энэ ахын хөвгүүн гэснийг Хун Цзюнь яриангүй ач хөвгүүн гэж орчуулжээ. Хэрэг дээрээ “ахмад хөвгүүн” гэсэн монгол дуудлагыг өрнө дахиныхан “Ахын хөвгүүн” гэж ойлгосон ч байж болно. Учир нь Буяншибал бол Алахуши Дигит Хури-ийн ахмад хөвгүүн нь юм)-д өгөв гэжээ. Энд Алага бэхи-г Алахуши өөрөө авсангүй ба бас Жинхүй-д өгсөн гэдэг нь бүр таарч байна. Гэвч эхэндээ Буяншибалд өгснийг нь орхигдуулжээ. Яагаад ийм буй гэвэл, өрнө дахиныхан энэ мэдээг сонсох үед, Алахуши Дигит Хури, Буяншибал эцэг хөвгүүн хоёр нэгэнтээ хорлогдож, Алага бэхи яг Жинхүйд гараад байсан цаг болохоор энэ үеийн мэдээгээрээ тэмдэглэжээ. Бас өмнөд Сүн улсын элч Чжао Хун-ы зохиосон “Монгол Татарын тухай бүрэн тэмдэглэл”-д: Чингис хаанд долоон охинтой, хоёрдугаарын нь нэр Алихай баян (энэ бол Алага бэхи гэснийг халгуу тэмдэглэсэн явдал болно – эшлэгч), ердөө бижи (бэхи – эшлэгч) хатан гэдэг, тэр нь Алтан улсын үрэгдсэн түшмэл Бай Сы Бу (энэ бол Буяншибалыг халгуу тэмдэглэсэн явдал болно - эшлэгч) гэгчид мордоод, одоо бэлэвсэн болсон бөгөөд цагаан Татарын улсын хэргийг захирч байна гэж тэмдэглэж буй. Чжао Хун ингэж тэмдэглэсэн учир гэвэл, тэр Яньцзин хотод хүрч, “Монгол Татарын тухай бүрэн тэмдэглэл” гэдгээ бичсэн цаг бол яг Чингис хаан баруун оронд байсан 1221 он (цагаагчин могой жил)-ы явдал болно. Энэ үед Алага бэхи-гийн түрүү эр Буяншибал үхсэнээр үл барам, хоёрдугаар эр Жинхүй ч үхсэн байжээ. Тиймээс Чжао Хун “бэлэвсэн” гэж тэмдэглэсэн нь таарч байна. Чжао Хун бол Чингис хааны дотоод учрыг нарийн мэдэх Мухулайтай уулзсан болохоор Алага бэхи эхлээд Буяншибалд мордсон үнэн байдлыг сонсч тэмдэглэжээ. Гэтэл Жинхүйд залгасныг тэмдэглэсэнгүйг үзэхэд, энэ явдлыг Чжао Хун-д хэлж өгсөнгүй бололтой. Тиймээс энэ тэмдэглэл нь өрнө дахины тэмдэглэлд нөхвөр болж болно.

Гэтэл Пэн Да Я, Сюй Тин нарын “Хар Татарын тухай хэргийн товч”-д: “Ба Сы Ма, нэгэн нэр Ба Сы Бу, цагаан Татарын Тайцзу, Тэмүжиний хүргэн бөгөөд гүнж Араханы түрүү эр буюу” (монгол хэвлэл, 279 нүүр) гэж тэмдэглэж буй. Энэхүү Ба Сы Ма гэдэг бол “Ба Сы Бу хүргэн” гэсний товчлол, “Ба Сы Бу” бол “Буяншибал” гэсний хувирал гэж Ту Цзи авгай тодолсон билээ. Энд Алага бэхи эхлээд Буяншибалд гарсныг бас нэг удаа гэрчилж байх бөгөөд тэр нь одоо өөр хүнд гарсан гэдгийг гэрчилжээ. Пэн Да Я, Сюй Тин нарын ирсэн цаг бол Өгөөдэй хааны үе 1237 оны хэрэг юм. Энэ үед Алага бэхи, гуравдахи эр Буюуха-д гараад арваад жил болж байжээ. Тиймээс Пэн Да Я, Сюй Тин нар Жинхүй-н учрыг мэдэхгүй байсан нь зохих юм.

Бас “Юань улсын түүх”-ийн “Гүнжийн илтгэл”-д: “Чжао Го эгчмэд гүнж Алахай бэхи бол Тайцзу-гийн охин, Чжао У Йи ван Буюуха-д мордов” гэж тэмдэглэж байдаг. Энэ “Алахай бэхи” гэсэн нь яриангүй “Нууц товчоон”-д дурдсан “Алага бэхи” юм. Энэ бол “Хүргэн Гао Тан Чжун Сянь вангийн хөшөө”-ний тэмдэглэлийг үндэслэсэн байна. Энд Алага бэхи Буюуха-д гарсныг гэрчлэв.

Энд тэмдэглүүштэй бас нэг учир гэвэл, тэрхүү “Хүргэн Гао Тан Чжун Сянь вангийн хөшөө”-д: “нөгчсөн эмэг эх Алахай” ба “нөгчсөн элэнц эмэг Алиг” гэж хоёр болгон тэмдэглэжээ. Энэ хөшөө бол Да Дэ-ийн есдүгээр он (1306)-ы барагаар Алахуши Дигит Хури-гийн жич хөвгүүн Хүрхист босгосон хөшөө болно. Түүнийг босгосон хүн бол Хүрхисийн дүү нь Жухунан гэгч билээ. Тиймээс өөрийн дээдсээ эндүүрэх ёсгүй, энэ нь харин Алага бэхи нэг хүн ах дүү ба

үеэлэд гурван хүнд гарсан “хөдхи заншлыг өөртөө жигшиж, зориуд өөрчилсөн” магадгүй гэж Ту Цзи авгай үзэж байжээ.

Бас нэгэн тэмдэглүүштэй явдал гэвэл, “Нууц товчоон”-ы 235 дугаар зүйлд Чингис хаан, Харлугийн Арслан ханд охиноо өгье гэж зарлиг болов гэсэн тэмдэглэл байдаг боловч, чухам аль охиноо өгсөн тухай дурдсангүй, гэтэл Ц.Дамдинсүрэн авгай “Лу. Алтан товч”-ийг үндэслэж, “Харлугуудын Арсланд Алха бэхийг өгч...” гэж нэмэн тэмдэглэжээ. Энэ нь 239 дүгээр зүйлд дурдсан Онгудад өгсөн Алага бэхи-тэй нэр адил болжээ. Энэ тухай өөр магадлалт харагдаагүй байсаар.


16 “Нууц товчоон”-ы бичигдсэн цагийг “Их хуралдаан болж, хулгана жилийн хулан сард Хэрлэнгийн хөдөө арлын Долоон болдог, Шилхинцэг хоёрын завсраа хааны орд бууж байхад бичиж төгсөв” гэж тус номын төгсгөлд бичиж байдаг. Энэ “хулгана жил”-ийг сүүлчийн үед олонхи судалгааны нотлолт нь цагаан хулгана жил, Өгөөдэй хааны арван хоёрдугаар он, нийтийн он тооллын 1240 он гэж үздэг. Ингэж үздэг гол баримт бол Өгөөдэй хааныг 1229 оны шарагчин үхэр жил их орыг залгамжиллаа гэсэн олонхи түүхийн тэмдэглэлийг баримталжээ. Гэвч “Нууц товчоон”-д Өгөөдэйг хулгана жил (1228 он) хаан орыг залгамжиллаа (269 дүгээр зүйлд) гэж тэмдэглэж байдаг. Иймээс зарим эрдэмтнээс “Нууц товчоон”-ы бичигдсэн цагийг шар хулгана жил, 1228 он гэж үзэж байх бөгөөд “Нууц товчоон” дахи Өгөөдэй хааны тухай сүүлчийн бүлгийг сүүлчийн хүмүүс нэмж, жинхэнэ зохиогдсон цагийг нь ард нь шилжүүлэв гэж үздэг байна.

Зурагдугаар бүлэг



ХААНТ МОНГОЛ УЛСЫГ БЭХЖҮҮЛЖ ӨРГӨТГӨСӨН ҮЕ

Чингис хаан эсгий туургатан Монголчуудаа нэгтгэж, Их Монгол Улсын хаант төрийг байгуулсан тэр үе - 1206 оны түүхэн дурсгалт өдрүүдэд, шинэхэн байгуулсан хаант улсаа бэхжүүлэх ба өргөтгөх явдлыг ер мартаагүй байсан юм. Энэ үед хэдийгээр олонхи Монголчууд эсгий туургатан гэж нэрлэгдсэн талын иргэнийг нэгтгэн авсан боловч, Монгол үндэстний өөр нэг салбар - Ойн иргэдийг нэгтгэн авч чадаагүй байсан. Эл аймгийн цөөн үлдэгдэл дайсан, жишээлбэл Мэргидийн Худу, Чулуун, Хэрэйдийн Нилха Сэнгүм, Найманы Хүчүлүг нар зугатан дугааж, аль нэгэн өдөр дахин сэргэхийг горьдож байсан, Алтан улсын ноёрхогчдоос үеийн үе дарлан талхидаж, өвөг дээдсийг алсан өшөө хорслоо аваагүй байсан. Энэхүү өшөөг авахад юуны урьд дотоодоо бэхжүүлж, ойр орчим дахи саад уршиг болохуйц улс угсаатныг урьдаар аргалах хэрэгтэй гэж Чингис хаан үзэж байсан бөгөөд мөн ч ингэж хийжээ. 1206 онд Харлуг-ийг дайлахаар Хубилай ноёныг, Хүчүлүг-ийг нэхүүлэхээр Зэв ноёныг тус тус томилжээ.



Жочи-гийн цэрэг ойн иргэдийг дайлсан зураг

48. Ойн иргэдийг нэгтгэн авсан нь

Чингис хааны хоёрдугаар он, улаагчин туулай жил буюу нийтийн он тооллын 1207 онд, Чингис хаан дөчин зургаан настай байв. Чингис хаан ахмад хөвгүүн Жочи-гоороо баруун гарын цэргээ захируулж, Ойн иргэдийг эзлүүлэхээр томилсон билээ¹. Жочи-гийн цэргийг

Буха хүргэн хошуучилж явжээ. Их цэрэг нь Ойрадад хүрмэгц Ойрадын түрүү Хутуга Бэхи Ойрад аймгаа авч өөрөө дагахаар ирсэн бөгөөд бас Жочи-гийн цэргийг замчилж, түмэн Ойрадын нутгаар явж, Шигшид гол² хүрч түмэн Ойрадыг оруулан авчээ. Дараа нь Алтан, Бугула хоёрыг түмэн Киргиз-д элчээр томилсонд Киргизийн түрүү Йэди Инал, Алдикэр, Өрөбэг Тигин нар элсэн орж цагаан шонхор, цагаан морь, хар булга зэргийг өргөл болгон авч ирээд орж өгчээ. Ингээд Сибирээс нааши түмэн Ойрад, түмэн Киргизийг багтаасан ойн иргэнийг цөм эзлэн авав. Энэхүү “Ойн иргэн” гэдэг нь, тухайн үедээ Монголын баруун хойд хязгаар Гүсэгүр нуураас Байгал нуур хүртэлхи өргөн уудам ой хөвч орнуудаар нутаглаж байсан аймаг угсааны ерөнхий нэр болно. Үүнд, Ойрад, Буриад, Түмэд, Барга, Урсуд, Хабханас, Ханхас, Тубас зэрэг аймаг ба Киргиз, Хэстием, Баяд, Тохас, Тэнлэг, Түкэлэс, Таш, Бажигид зэрэг аймгийг түмэн Ойрад, түмэн Киргиз гэж нэрлэж байжээ. Эдгээрийн дотор Ойрад, Барга, Буриад, Түмэд зэрэг нь яриангүй монгол хэлтэн аймаг болох юм. Бусад нь түрэг төрлийн хэлтэн байсан бололтой.

Доор, гол хэдэн аймгуудын тухай товч танилцуулъя.

Ойрад - Одоогийн Ойрад гэдэг ухагдахуун бол Дундад улсын Шинжааны Уйгурын Өөртөө Засах Орон, Хөх нуур муж, Өвөр Монголын Өөртөө Засах Орон жич Ганьсу зэрэг газраар нутаглаж бүхий Өөлд, Торгууд, Хошууд зэрэг аймаг болон Зөвлөлт Холбоот Улс дахи Халимаг Монгол зэргийг багтаан хэлдэг байна. Энэ аймгийн нэр ба ирлийн тухай янз янзаар хэлэлцдэг билээ. Зарим нь Ойр (ойр нутагт байдаг) гэсэн үгэнд олон тооны дагавар “-д” нэмж “ойрад” болсон гэж тайлбарладаг, зарим нь “ой” гэсэн үгнээ олон тооны дагавар “-д” нэмж “ойд” болсны улмаар сунжран “ойрад” болсон гэдэг. Буриад Монголын алдарт эрдэмтэн Доржийн Банзаров нар “Ойн иргэн буюу ойн ард” гэсэн үгнээс үүссэн гэж тэмдэглэжээ.

Арван гуравдугаар зууны үед Ойрад аймаг нь Ениссей мөрний дээд урсгал, Кэм мөрний орчим жич Гүсэгүр нуурын хавийн ой хөвчөөр нутаглаж,(Ц.Дамдинсүрэн орос Алтай гэжээ) байсан нь лавтай юм. Тиймээс “Ойн иргэн” (буюу ойн ард) гэсэн үгнээс үүслээ гэдэг нь зүйтэй мэт. Гэтэл Саган сэцэний зохиосон “Эрдэнийн товч”-д Ойрадын “Өөлд, Баатуд, Хойду, Хэрхэгүд” дөрвөн овогтон нь Бөртэ чонын арван хоёрдугаар үеийн үр ач Дува Сохорын үрс гэжээ. “Нууц товчоон”-д Дува Сохорын дөрвөн хүүхдийн үр ач нь Дөрвөн овогтон боллоо гэснээс биш, бодтой хүн ба бодтой овгийг дурдсангүй. Тиймээс энэ хоёр тэмдэглэлийг нэг гаралтай гэж үзэх баримт одоохондоо төгөлдөр бус мэт. Харин Ойрад аймгийн дотор ерөнхийдөө Дөрвөд, Торгууд, Хошууд, Цорос зэрэг овогтон багтдаг байжээ. Тэр үед Ойрад аймаг нь “хагас ан гөрөө, хагас малжил” (Юй баян-ы ном)-аар аж төрж байжээ.

Арван дөрөвдүгээр зууны сүүлч буюу арван тавдугаар зууны эхээр, Ойрад аймаг нь өмнөш Цзапэнь голын сав газар, Жунгар (зүүн гар гэсэн үгийн хувирал гэдэг)-ын хотгор ба Алтай нуруунаас баруунши тал газраар нүүн ирж мал аж ахуйг эрхлэжээ. Арван тавдугаар зууны дунджаар Ойрадын нэгэн салбар зүүн Жунгарын түрүү Тогоон, Эсэн тайш эцэг хөвгүүн хоёр охор хугацаанаа бүх Монголыг урьд хожид нэгтгэн захирсан түүхтэй юм. Чин улсын үед, Дөрвөд Ойрад гэж нэрлэдэг нь Дөрвөн, Жунгар (бас Чорос гэдэг), Торгууд, Хошуудыг хэлж байна. Хожим нь Торгуудууд баруунш Ижил мөрөн хавиар нүүсэн хойно, Хойдыг Ойрадын

дөрвөн аймагт тооцдог байжээ. Манжийн дайлан дагуулагчийн эсрэг Ойрадын ард түмэн урьд хожид зуу гаруй жилийн тэмцлийг явуулжээ. Энэхүү тэмцлийн дунд Ойрадын ард түмэн маш их үрэгдэл хохирлыг амссан бөгөөд өдий төдий үндэстний баатарууд гарч байсан.

Энд бас нэгэн тэмдэглүүштэй учир гэвэл, “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д Ойрадыг “Цагаан Татар” гэдэг бөгөөд түүний салбарыг тав гэж нэлээд ондоогоор тэмдэглэж буй. Тэр нь: “Ариг Усун, Сайд, Афу, Өрөнгөржин (Өрөнгүү голын эхэнд буй), Цагаан ийм таван салбар болно” гэжээ. Баримтлалыг нь ер мэдсэнгүй бөгөөд манай тулгар баримттай зөрөөнтэй тул зөвхөн хяналт болгон тэмдэглэв.

Баргудай - Баргудай бол Баргужин (бас Барга гэдэг), Хөл Баргужин, Хори, Түгэлэс, Буриад таван овогтныг нийлүүлж нэрлэжээ. Баргудай аймгийг Түмэд лүгээ нэг угсааны аймаг гэдэг бөгөөд хятад түүхэнд бас Цагаан Татар гэдэг юм. Тэд Сэлэнгэ мөрний зүүн эрэг дагуу Баргужин төхөмөөр нутагладаг байна. Гэвч сүүлчийн үед хүмүүс бараг Барга Буриад гэхээс биш Баргудай гэдэг нэрийг дэмий хэрэглэхгүй болжээ. Энэ Барга аймаг нь 1207 онд Монголд харьяалагдсанаас хойш, Байгал нуураас өмнөш, Хар мөрнөөс хойши орон (одоогийн Зөвлөлтийн хязгаар)-оор нутаглаж байгаад хожим нь Чин улсын Энх Амгалан хааны үед Оросын хязгаараас салж, Чин улсад харьяалагджээ. Чин улсын засгийн газраас тэднийг Мулан Хуйхан (Үзэмчин, Жирим, Хөлөн буйр ба Халхын уулзварт бүхий Соёолж уулан дахи хааны авын газрыг манжаар ингэж нэрлэдэг) (Манай архивын баримтуудад “Мураны авын газар” гэж гардаг бөгөөд “Муран” нь манж хэлээр бугын урамдал гэсэн үг болно – хө)-д байрлуулан малжуулж байв. Сүүлд нь Хянган даваанаас хойш одоогийн Хөлөн Буйрын тал нутаг өөд шилжжээ. Тэр үед Чин улсын засгын газраас Барга цэргийг найман хошууны цэрэгтээ элсүүлж, Айхуй, Чичигар зэрэг хотуудад урьд хожид суулгаж байсан билээ. Дараа нь Чин улсын Найралт төвийн үед нэг хэсэг халх Монголчууд ар Монголын Цэцэн хаан аймгаас Хөлөн Буйрт нүүн ирж нутаглажээ. Эдний хэл аялгуу нь Барга лугаа адил болохоор сүүлчийн ирэгдсэдийг нь шинэ Барга, уулын байсныг нь хуучин Барга гэж нэрлэх болсон байна.

Буриад - Буриад нь Ойн иргэдийн хамт 1207 онд Монголд харьяалагдсанаас хойш олон зуун жилийн турш үеийн үеэр Байгал нуур ба гадаад Хянган нурууны хоорондуур буюу Сэлэнгэ, Баргужин, Ангар мөрний сав газраар нутаглаж, аж төрөн амьдарч байжээ. Буриад Монголын бүх нутгийн зууны тал нь бүр ой шугуйт орон болно. Арван долдугаар зууны хориод оноос өмнө, Буриад Монгол нь Халх Монголын Түшээт хан аймаг болон Цэцэн хаан аймагт харьяалагдаж байжээ. 1620 оноос хойш Хаант Оросын түрэмгийлэгчид зэвсэгт хүчээр Буриад аймгийг нийт Монголоос таслан эзэлжээ. Дараа нь 1727 оны 8 сарын 31-ний өдөр (Чин улсын Найралт төвийн тавдугаар оны долоон сарын арван таван) Чин улсын доройтмол засгийн газар нь Хаант орос лугаа “Буурын гэрээ” гэдгийг байгуулж, Буриад Монголыг Орос улсад харьяалуулан өгсөн юм. 1923 оны 5 сарын 30-ны өдөр “Зөвлөлийн засагт нийгэм журамт өөртөө засах Бүгд Найрамдах Буриад Монгол Улс” гэж өөртөө засах улс болж Холбооны Орос Улсад харьяалагдсаар байна. 1976 оны бүртгэлийг үндэслэвэл, Буриад Монголын хүн амын тоо нь гучин түм таван мянга байна. Буриад монгол хэл бол алтай язгуурын монгол төрөл хэлний умард авианы оронд харьяалагдана. Ингээд Барга-Буриад аялгуу гэдэг. Буриад Монголчууд эртнээсээ уйгуржин монгол бичгийг хэрэглэж байгаад 1931 онд сая латин цагаан толгойгоор үсгээ өөрчилж, 1937 онд нь дахиад слав цагаан толгойгоор өөрчилжээ.

Түмэд - Түмэдийг зүүн баруун гар гэж хоёр хуваадаг бөгөөд зүүн гарыг нь Хорь Түмэд гэдэг. Тэр нь Баргудай аймагтай холилдон нутаглаж байжээ. Баруун гарыг нь Түмэд гэдэг, тэр нь Байгал нуурын баруун өмнүүр нутагладаг бөгөөд умарш Киргизийн харьяат лугаа зах нийлдэг байна. Рашидын номд Түмэдийг Баргужины нэгэн салбар гэжээ. Түмэд хүмүүс эртнээсээ дуу бүжигт бахтай. Дээл хувцаслал ба зан заншил нь Монголын бусад аймгаас нэн өвөрмөц онцлогтой юм. Тухайн үед Түмэдийн ноён нь Дайдухул сохор гэж байжээ. Жочи-д бууж өгсөн хойно Дайдухул сохор үхэж, түүний гэргий Ботухуй тарган гэгч Хорь Түмэдийг захирч байв. Хожим нь Монголын түмний ноён Хорчи Хорь Түмэдээс гучин гоё охидыг татварлана гэсэнд Түмэдийн ард түмэн Хорчи ноёныг эсэргүүцэн босолго гаргажээ. Энэ бослогыг нь дарахаар Чингис хаан дөрвөн хүлгийнхээ нэг Борухул ноёныг томилов. Борухул бас энд алагджээ. Дараа нь Түмэдийн бослогыг дарангуйлж, Борухулын хоёрдугаар хөвгүүн Тачарт зуун өрх Түмэдийг боол болгон өгчээ. Тачар энэхүү зуун өрх Түмэд иргэнийг авч одоогийн Далан хар уулын хавийн Гуанша гэдэг газар нутаглаж, эд Хөх хотын Түмэдийн дээдэс болов гэдэг. Хэлэлгээнгүй тэр уул орны төрөлхи аймаг - Онгуд аймагтай нийлж бүтсэн нь мэдээжийн хэрэг билээ. Арван тавдугаар зууны үед Даян хааны баруун гурван түмнийхи нь нэг нь Түмэд түмэн болно. Бас Алтайн арван хоёр Түмэд гэдэг. Даян хаан үхсэн хойно, түүний гуравдугаар хөвгүүн Барсболдын хөвгүүн Алтан хаан Түмэд түмнийг захирчээ.

Урсуд - Тухайн үед Кэм мөрнөөс умарш ус голоор нутаглаж байсан тул “ус”-аар аймгаа нэрлэжээ гэж “Юань улсын түүх, баруун хойдохи газрын хавсралт” гэдэгт тэмдэглэжээ. Кэм Кэм чжоу бол эртний Усун улс мөн гэж “Жадархайн намтар”-т дурдаж байдаг тул, энэхүү “Урсуд”-ыг эртний “Усун улс”-ын үр хойчоор үздэг байна. Эртний “Усун улс” нь Хань улсын үед одоогийн Ил Тарвагатай орчмоор байсан гэлээ. Сүүлд нь энэ аймаг баруунш нүүсэн боловч уулын нэрээ хадгалж байсан бололтой. Энэхүү ус гол нь Саяны нуруунаас ундарч, баруун өмнөш урсан Енисей мөрөнд нийлдэг байна. Кэм мөрний эх нь найман салбар байдаг, Ойрад аймаг зүүн талд нь ойролцоо нутаглаж, түүнээс зүүнш Урсуд, Тэлэнгүд, Хэстием гурван аймаг Байгал нуураас баруун биеэр Ойрад, Киргиз лүгээ зэргэлдээ нутагтай байжээ. Байгалиас зүүнш Хорь, Горлос, Буриад, Түмэд дөрвөн аймаг нутагладаг бөгөөд тэднийг ерөнхийд нь Баргууд гэдэг юм гэж Рашидын номд тэмдэглэжээ.

Хабханас гэдэг нь “ууг” гэсэн утгатай үг болох бөгөөд тус аймгийн оршиж бүхий газар нь “ууг” мэт хэлбэртэй болохоор аймгаа ингэж нэрлэжээ гэж “Юань улсын түүх, Лю Харбаатарын намтар”-т тэмдэглэжээ. Тус аймаг нь Урсудаас зүүнш Кэм мөрний эх, Гүсэгүр нуураас дээш нутаглаж байжээ. 1206-1207 оны үед Монголд харьяалагдсан бөгөөд 1217 онд дахин урваж, Жочи нэхэн даржээ. Ингээд Чингис хаан тэднийг хөвгүүд дүү нартаа хуваан захирууллаа гэдэг. Сүүлд нь Юань улсын Төмөр хааны Да Дэ-гийн онууд (1297-1307 он)-д Киргиз, Урсуд хоёр овогтноос тус бүр нэлээд өрхийг Хабханас аймгийн хүмүүсийн хамт Наяны уул нутаг Усун Татарын газар шилжүүлж, загас агнуулан өргөл бариулж байв гэдэг. “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д “Зэрлэг Татар” гэж нэрлэдэг байлаа.

Ханхас - Ханхасыг “Ту Цзи-ийн тэмдэглэл”-д Хангай нурууны араар нутагладаг “Зэрлэг Татар” гэжээ. Өөр мэдээгүй. Туvas - Туvasыг Сяньби угсаатны Тува аймгийн үр хойч гэдэг юм. Тэд нь Саяны нуруунаас өмнөш Тагна уулаас хойш хоёр уулын завсар дахи урталжин тал газраар нутаглаж байжээ. Ингээд энэ нутгийг сүүлчийн үед Тагна Урианхад гэдэг билээ.

Киргиз - Киргиз бол Түрэг угсаатан. Тэр нь өмнөш бага Алтайгаар Найман лугаа зах нийлж, зүүн өмнөш Сэлэнгэ мөрөн, зүүн хойш Ангар мөрөн лүгээ зах нийлэлцэх өргөн уудам орноор нутаглаж байжээ. Тан улсын үед Цзе Гу гэж нэрлэдэг бөгөөд Цзянь Гунь Фу-гийн харьяат байжээ. Тэр үед Киргизүүд одоогийн баруун Саяны нуруунаас хойш, Ениссей мөрөн, Абаган мөрний сав газраар нутаглаж байв. Ляо улс ба Алтан улсын үед Шагас гэж нэрлэж байсан бөгөөд Ениссей мөрний эхээр нутаглаж байжээ. 1207 онд Монголд харьяалагдсанаас хойш, Юань улсын үед Киргиз гэж нэрлэдэг бөгөөд Линьпэй мужид харьяалагдаж байжээ. Мин улсын үед Ойрадад харьяалагдаж байгаад 1639 онд Жунгар хан улсад харьяалагджээ. 1640 оноос эхлэн хаант Орос зэвсэгт хүчнээр эзэрхэглэн халджээ. “Рашидын номоос үзэхүл Киргизийн олонхи хүмүүс нь нүүдлийн мал аж ахуйгаар амьдардаг бөгөөд хот балгас бас цөөн бус байдаг” гэж Д’Оссон тэмдэглэжээ.

Хэстием - Хэстием-ийг бас Хэстими гэдэг. Тэр нь Киргиз, Кэм Кэм чжоу (Урсуд)-ын харьяат ой шугуйт орноор нутагладаг. Нутгийн ард нь аму ургамал ба эмийн чанарыг мэддэг бөгөөд өвчин эмнэж чаддаг гэлээ.

Баяд - (“Нууц товчоон”-д Баяид гэжээ) тус аймаг нь Сэлэнгэ мөрний эхээр нутагладаг байжээ. Тэр газар нь эртний Хүннүгийн хааны хот байж гэлээ, түүнийг нь Тан улсын үед Баян хот гэдэг тул Баяд нь энэ хотоор өөрийн аймгаа нэрлэлээ гэдэг юм.

Тохас - Тохасыг Хүннүгийн үрдэс гэдэг, тэд нь Түнгүс буюу Тохас голоор нутаглаж байснаас аймгаа “Тохас” гэж нэрлэжээ. Урусчууд Хүннүгийн үрдэсийг “Түнгүс буюу Дүнгүши” гэж нэрлэдэг тэмдэглэл байдаг билээ. Тэнлэг - “Нууц товчоон”-ы 207 дугаар зүйлд “Тэлэнгүд” гэж тэмдэглэж байна. Энэ нь Хань улсын үе дэх “Дин Лин” буюу Тан улсын үе дэх “Те Лэ”-гийн үрдэс мөн гэж Ту Цзи авгай тэмдэглэжээ. Тэлэнгүд нар Байгал нуураар нутагладаг юм. Сүүлчийн үед “Эрдэнийн товч”-д “Тэлэнгүс” гэж Жунгарын арван хоёр отгийн нэгээр дурдсан байна. Үүнийг эртний “Тэлэнгүд” аймаг мөн гэж Ван Го Вэй авгай тэмдэглэжээ.

Түкэлэс - Үүнийг Ту Цзи авгай Баргудай аймгийн нэгэн сурвалж гэж үзсэн бөгөөд Сэлэнгэ мөрний дээд урсгалаар нутагладаг гэлээ. Гэтэл Юй Баян авгай Те Лэ гэж үзсэн бөгөөд Алтайгаар нутагтай гэжээ.

Тэс - Тагна уулын өмнүүр баруунш урсч Увс нуурт цутгадаг “Тэс гол” гэж байдаг, энэ аймаг нь Тэс голын сав газраар нутагладгаас тийм нэртэй болов гэдэг билээ.

Бажигид - Бажигидийг Дорнотив нөхрийн шинэ хятадчилгад: Бажигид бол Ханлинаас хойш Волга мөрөн (Ижил мөрөн)-өөс зүүнш нутагладаг түрэг угсааны нэгэн салбар гэж тэмдэглэжээ. “Бажиги” гэдэг үг бол түрэг хэлний “долоо” гэсэн ургатай үг гэж Ту Цзи авгай мэдээлж байсан юм. Накамиchie авгайн хэлэхээр бол “Бажигид” гэдэг нь “Башгирт” гэсний халгуу дуудлага болох юм байна. Волга мөрний зүүн хавиар одоо болтол Башкир гэдэг угсаатан сууж байдаг гэнэ. Европын Унгар (Хунь-кэ Эр одоогийн Шун-я Ли буюу Хангари)-ын дээдэс бол энэхүү Башгиртаас үүслээ гэдэг. Плано Карпини “Барсхарт” гэж, Рубрук “Песхатир” гэж нэрлэж байв. Чингисийн ахмад хөвгүүн Жочи 1207 онд өргөн уудам нутагт Ойн иргэдийг оруулан эзлээд, Киргизийн түмний ноёд, мянганы ноёд ба ойн иргэний ноёныг авч, хаан эцэгтээ цагаан шонхор, цагаан морь, хар булгануудаа бэлэглэж уулзжээ.

Чингис хаан, Ойрадын Хутуга бэхи-г урьдаас угтан түмэн Ойрадоо дагуулан элсэж ирэв хэмээн соёрхож, түүний хөвгүүн Иналчид өөрийн охин Чэчэйхэн гүнжээ өгөв. Иналчийн ах Төрүлчид Жочи-гийн охин Улуйхан гүнжийг3 өгөв.


Энэ бол “Ойн иргэд”-ийг анх удаа нэгтгэн авсан өнгөрөлт болно. Гэтэл сүүлд нь 1211 оноос 1216 оны хооронд, Ойн иргэд дахин урвасан билээ. Энэ удаа тэдний урвасан учир гэвэл ийм байна:

1211 онд Чингис хаан гол хүчээрээ өмнөш Алтан улсыг дайлсан тул ар оронд цэрэг морь цөөн, хүчин сул байжээ. Үүнийг нь баруунш зугтсан Мэргидийн үлдэгдэл Худу зэрэг сонсч, нууцаар зүүнш буцаж, Найманы захад ирэн, цөлбөдөлүүдийг цуглаан дахин сэргэх оролдлого хийжээ. Энэ үед Найманы оргодол Хүчүлүг нэгэнт Хар Хятаныг булаан эзэлсэн байсан тул бас дахин сэргэхийг горьдож байсан юм. Ингээд тэд нар харилцан сүлбээлдэх нь ч яриангүй явдал билээ. Гэвч тэд Найманд халдаж чадсангүй учир гэвэл, тэр үед Чингис хаан Тогучар-аар гурван мянган морьт цэрэг захируулж, Найманы хилээр сэргийлүүлж байсанд оршино. Ингээд Худу нар ойн иргэн лүгээ сүлбээлэхийг оролджээ. Энэ үед Хорь Түмэдийн ноён Дайдухул сохорын гэргий Ботухуй тарган Түмэд иргэнээ авч босолго гаргаад байв. Эдний босолго гаргасан учир гэвэл, Чингисийн түмний ноён Хорчи-гийн ужид зусар ажиллагаанаас нь үүссэн юм. Хорчи урьд Чингис хааныг дагахад, хожим ялсан хойно түмний ноён суух ба гучин эм сонгож авах золионы нөхцөл дурдсаныг нь Чингис хаан зөвшөөрсөн бөгөөд 1206 онд Хорчи-г Эрчис мөрөн хавийн умард түмний ноён болгож, гучин эмсийг Хорь Түмэдээс сонгож авахыг нь зөвшөөрчээ. Ингээд Хорчи Түмэдээс гучин гуа охид сонгон авна гэсэнд Түмэдийн иргэд эсэргүүцэж, Хорчи-г барьж аваад босолго гаргасан нь энэ билээ.



“Хаан амгалан, ард тайван, ан элбэг”

Чингис хаан ордондоо буцаж ирэн саатаж байгаа



Ард тайван



Ан элбэг



1.Удган 2.Бөө 3.Төлгийн хэнгэрэг

Энэ чимээг нь Чингис хаан сонсч, Ойрадын Хутуга Бэхи Ойн иргэдийн байдлыг мэддэг болохоор түүнийг томилж, Түмэд нарыг буулган авахаар зарлиг өгчээ. Гэвч Хутуга бэхи очоод бас баригдсан байв. Дараа нь төв түмний ноён Наяаг томилъё гэхэд Наяа яг өвчинтэй байсан

тул Борухулыг томилжээ.

“Борухул ноён, тэнд очоод гурван хүнийг дагуулан их цэргийн тэргүүнд үдэш орой бэрх ойн дотор нарийн харгуйгаар явж байтал, Хорь Түмэдийн харуулын хүмүүс тэдний ард гарч замыг боогоод Борухул ноёныг барьж алжээ” (“Нууц товчоон”-ы 240 дүгээр зүйл). Энэ явдал бол бараг 1215 оны зун намрын явдал болно.


1215 оны намар Чингис хаан эдгээр чимээг сонсч, ар нутгийн үндсэн газарт нь амар түвшин үгүй болсон учраас маш хилиглэн намартаа цэрэг буцаж, Хэрлэн мөрөн дэхи ордондоо бууж, олон ноёд жанжин нараа цуглуулан, “өөрөө морилохыг завдвас, Боорчу Мухулай хоёул Чингис хааныг ятгаж болиулав”. Ингээд 1216 оны хавар Дөрвөдийн жанжин Дөрбэй догшиныг томилов. Дөрбэй догшин дараа жилийнх нь хавар болтол Хорь Түмэд иргэний бослогыг бүрмөсөн дарангуйлжээ.

Энэ байлдаанаас өмнө, Түмэдийн бослогыг дарангуйлахаар Чингис хаан Киргиз нараас цэрэг элсчээ. Гэтэл Киргиз нар цэрэг гаргасангүй мөртөө бас дахин урваж явжээ. Ингээд урвасан Киргизийг дайлахаар Чингисийн ахмад хөвгүүн Жочи бас Буха-аар замчлуулж нэхэн морджээ. Жочи-гийн их цэрэг Эмил гол хүрч, дахин зүүн хойш дайран, Кэм мөрний мөснийг даган явж, Урсуд, Тэлэнгүд, Хэстием болон Ойрад иргэнийг дахин урвагсдыг оруулан авсан байна. Ингээд дахин буулган авсныг Чингис хаан хөвгүүн дүү нартаа хуваан захируулжээ. Ойн иргэдийг хоёрдахи удаа бүрмөсөн эзлэн оруулсан учир ийм билээ.

49. Харлуг, Уйгурыг харьяалсан нь

1206 онд Чингис хаан улс байгуулсныхаа дараа, дөрвөн хошуучийн нэг Хубилай ноёныг Харлугуудыг дайлаар мордуулав.


“Харлуг” гэдэг үг бол ажнай хүлэг гэсэн утгатай түрэг үг гэдэг юм. Харлугууд ч мөн түрэг төрлийн угсаатан болно. Тэр нь арван гуравдугаар зууны үед Ци Хэ орон, одоогийн Зөвлөлт Холбоот Улсын Казакстаны Балхаш нуурын өмнүүр нутаглаж байв. Тан улсын үед Гэ Ло Лу гэж нэрлэдэг байжээ. “Ляо улсын түүх”-д “Арслан Уйгур” гэж нэрлэжээ. Түүний ирлийг “Хаяалиг” (буюу Хайяли) гэдэг газрын нэрээс “Харлуг” болсон гэж Джувейни, Д’Оссон нар тайлжээ. Сүүлд нь Хар Хятаны харьяат улс байв. Хубилай ноён очих үед Харлугийн түрүү нь Арслан хан гэж байжээ. Хубилай ноён Харлугийг дагуулаар эчсэнд Арслан хан Харлагуудаа аван өөрөө элсэн иржээ. Ингээд Харлуг аймгийг найрамдлаар оруулан авч, ирэх очихтойгоо нийлээд дөрвөн жил илүү болж, 1211 оны хаврын тэргүүн сард Чингис хаан Хэрлэнгийн их ордондоо ахуйд Хубилай ноён Харлугуудын Арслан ханыг дагуулан ирж Чингис хаан лугаа уулзжээ. Тэр үед “Чингис хаан, Арсланг байлдсангүй дагав хэмээн сайшаан соёрхож, охиноо өгье хэмээн зарлиг болов” (“Нууц товчоон”-ы 235 дугаар зүйл)⁴. Сүүлд нь Арслан ханы хөвгүүн Есөн буха, Есөн буха-гийн хөвгүүн Хундар зэрэг бүр Монголын төрд үйлчилж, хүргэн болж байсан бөгөөд Харлуг нь Өгөөдэй хааны ач Хайду вангийн харьяат газар байв.



Зэв Сүвээдэй баруунш шүүрдэлт хийсэн зураг

Харлугуудын Арслан ханы хамт Уйгурын Итүгүд хан бас Чингис хаанд харьяалагдахаар хүрч иржээ. Үүний урьд, 1208 онд Мэргидийн цөлбөдөл Худу нар Уйгурын Итүгүд лүгээ Цзяо Хэ гэдэг газар байлдаж дийлэгдэн дутаажээ. Дараа хавар нь Уйгурын Итүгүд хаан, Уйгурыг захирч байсан Хар Хятаны тайш Шаокэм (Schoukem) гэгчийг алж, Чингис хаанд Адхираг, Дарбай хоёр элчийг илгээж 5 хэлүүлсэн нь: “Үүл арилж гэгээн наран тодорсон мэт, мөс хайлж тунгалаг мөрөн урссан мэт, Чингис хаан соёрхвоос, алтан бүсийн чинь горхиноос барьж, ариун дээлийн чинь үрдсэнээс олж, тавдугаар хөвгүүн чинь болж хүч өгье” хэмээн өчиж илгээжээ (“Нууц товчоон”-ы 238 дугаар зүйл) гэжээ. Чингис хаан энэ үгийг нь сонсоод баярлаж, “Охиноо өгье. Тавдугаар хөвгүүн болтугай. Алтан, мөнгөн, сувд, тана, хоргой, хээт оёмол, торго агуурс авч иртүгэй” гэж элчийг нь буцаажээ. Ингээд 1211 оны хаврын тэргүүн сард “Итүгүд соёрхогдов хэмээн баясч, алт, мөнгө, сувд, тана, торго, хоргой зэрэг агуурс авч ирээд Чингис хаантай уулзав”. “Чингис хаан, Итүгүдийг соёрхож, Ал Алтун Бэхиб охиноо өгөв” (“Нууц товчоон”-ы 238 дугаар зүйл).

“Итүгүд” гэдэг бол хүний нэр биш, Уйгур үндэстний хан цол болно. Итүгүдийн чухам нэр нь Баржуг Арт Тигин гэдэг юм.



Зураг – 63. Хар Хятаны газрын зураг

Хар Хятаны газрын зураг

Уйгур бол алтай язгуурын түрэг төрлийн хэлтэй үндэстэн билээ. Уйгурчууд эртдээ бөө мөргөлийг шүтэж, сүүлд нь Буддын шашин ба Христосын шашин (несторианы бүлэг)-ыг шүтэж байв. Одоо олонхи нь Исламын шашныг шүтдэг байна. Уйгур үндэстэн эрт үедээ нүүдэллэн малжиж байснаасаа аажимдаа тариалан аж ахуйг гол эрхилэх болжээ. Уйгур үндэстэн бол урт удаан оны үсэг бичгийн түүхтэй бөгөөд Эртний Уйгурчууд согд үсгийн суурь дээр өөрийн авианы үсгийг зохиож, наймдугаар зуунаас эхлэн өргөнөөр хэрэглэж байв. Арван гуравдугаар зуунаас хойш араб үсгээр суурь болгосон “Чагаадай үсэг”-ийг зохион хэрэглэсэн юм. Тиймээс уйгур үндэстэн нь баялаг соёлын өвгэй. Эртний уйгур үндэстэн нь Орхон, Туул, Сэлэнгэ гурван голын сав газраар нутаглаж, Түрэг хаант улсад харьяалагдаж байв. Тан улсын Тайцзун хааны үе (нийтийн он тооллын 626 оноос 649 он)-д Тан улсад харьяалагджээ. Нийтийн он тооллын 745 онд Түрэг хаант улсын самуурлыг нь завдан, Түрэгийн харьяат газрыг нь эзлэн авч, Уйгур хаант улсыг байгуулжээ. Тэр үе Тан улсын хаанаас “Бөгү хаан” (Boqou khan) цол өргөмжилжээ. Энэ бол Орхон голын урсгалаар төв болгосон нүүдэлчин аймгийн феодал хаант улс болно. Тэр үед түүний нутаг дэвсгэр нь зүүнш их элсэн говь, баруунш Алтайн нуруу хүрч байсан юм. Уйгур хаант улс нь зуу илүү жил болоод 847 онд Киргиз болон Тан улсад мөхөгдсөн билээ. Ингээд хүчирхэг их Уйгур хаант улс нь зөвхөн Алтай хавийн бяцхан улсаа хамгаалж, Бишбалиг (Балиг гэдэг үг бол балгас гэсэн монгол үгийн түрэг гаралтай язгуур болно. Эртний хот нь одоогийн Жимиссайраас хойнохин буй)-т төвлөж, улсын эзнээ Итүгүн хаан гэх болов. Сүүлд нь баруунш нүүсээр байж, олонхи нь одоогийн Шинжаанаар нутагшжээ. Арван нэгдүгээр зууны сүүлчээр Хар Хятан улс эзлэн захирсан байна. Ингээд Хар Хятанаас захирагч ноён томилон ноёрхуулдаг байв. Итүгүд хаан Баржуг Арт Тигиний алсан Шаокэм бол Хар Хятаны хамаг сүүлчийн нэгэн захирагч болно.

Чингис хаанаас хойш, Уйгурын Итүгүд хаан Баржуг Арт Тигиний үр хойч нь ургийн ургаараа Монголын төр ба Юань улсын төрд үйлчилж, төрийн хүргэн болж байв.

50. Үлдэгдэл дайснаа цэвэрлэсэн ба Хар Хятаныг оруулан авсан нь

Чингис хаан 1206 оноо Бүх Монголыг нэгтгэх үед, цөлбөн зугтсан дайсан нь хоёр хэсэг хүчин

байв. Нэг нь Мэргидийн Тогтуга бэхи-гийн хөвгүүн Худу, Чулуун зэрэг нэг бүлэг мужууд дайсан болно. Нөгөө нэг нь Найманы Таян ханы хөвгүүн Хүчүлүг болно. Энэ бүлэг дайсныг бүрмөсөн цэвэрлэхийг Чингис хаан хэзээнээс анхаарч байв.

1206 онд улс байгуулсны дараахан Хүчүлүг-ийг нэхүүлэхээр Зэвийг томилжээ. Гэвч Хүчүлүг 1210 онд Уйгур, Харлуг-ийг дайрч, Хар Хятан өөд дутаасан тул Зэв буцаж иржээ. Энэ бол Найманы үлдэгдлийг нэгдүгээр удаа нэхсэн байлдаан болно. Дараа нь 1211 онд Найманы Хүчүлүг Хар Хятаны төрийг нь булаан авч, өөрийн ноёрхлоо сэргээхийг оролдож байсан бөгөөд Мэргидийн үлдэгдэл Худу зэрэг Чингисийн эсрэг этгээдүүд Найманы хилийн гадна сүлбээлэлдэн, Ойн иргэдийн босолго урвалга лугаа тохиролцон Хаант Монгол Улсын ар талд самуурал гаргахыг оролдож байв.

1216 онд Чингис хаан, Дөрвөдийн Дөрбэй догшин жанжинг томилж, Ойн иргэний урвалгыг дарахын хамт, Сүбээдэйд төмөр тэрэг өгч⁷ урьд томилсон Тогучарын гурван мянган морьт цэрэг лүгээ нийлэлдэн, Мэргидийн түрүү Тогтуга бэхи-гийн хөвгүүн Худу, Гал, Чулуун түрүүтнийг нэхүүлэхээр томилсон бөгөөд Найманы Хүчүлүгийг устгахаар Зэв ноёныг хоёрдугаар удаа томилжээ. Бас Жочи түрүүтэй баруун гарын цэргээр Сүбээдэй, Зэвийн цэрэгт түшиг сүр болсугай гэж зарлиг болсон бөгөөд гурван замын цэргийг Жочи-гоор ерөнхийлөн захируулжээ.

1217 онд “Сүбээдэй баатар, төмөр тэрэгтэй цэргээ авч яваад Мэргидийн Тогтуга бэхи-гийн Худу, Чулуун зэрэг хөвгүүнийг нэхэн довтолж, Чүй мөрөний тэнд гүйцэж сөнөөгөөд ирэв” (“Нууц товчоон”-ы 236 дугаар зүйл). Зэвийн удирдсан цэрэг бас Чүй мөрний өмнө хүрэхүйд Сартуул угсааны иргэд, тэднийг захирч байсан Найманы цэргүүдийг алж, Зэвийн цэргийг угтан бууж өгөв. Ингээд Цунлин нуруунаас умарших Хар Хятаны харьяат хотод зэр зэвсэг хөдөлгөсөнгүй даган өгчээ. Бас “Найманы Хүчүлүг ханыг нэхэж Сариг гун хэмээх газарт гүйцэж сөнөөгөөд ирэв” (“Нууц товчоон”-ы 237 дугаар зүйл).

Хар Хятан (баруун Ляо улс) ингээд хамаг эцэс мөхсөн юм. Хар Хятан бол Сүн улсын үед Хятан үндэстний байгуулсан төр болно. Хятад түүхэнд баруун Ляо улс гэдэг.

Манай тооллын 1125 онд Хятан үндэстний байгуулсан Ляо улсыг Жүрчин нар мөхөөсөн үед, Ляо улсын эцсийн хаан Елюй Яньси-гийн төрлийн Елюй Даши (Ляо улсын Тайцзу Елюй Абаожи-гийн наймдугаар үеийн хойч) гэгч хоёр зуун морьт цэрэг авч, уулын Ляо улсын харьяат баруун хойд орны арван найман аймгаас цэрэг морь элсэж түм шахам хүчирхэг морьт цэргийг цуглааж, баруунш Туркестаныг эзлэхээр довтолжээ. Замдаа Уйгурын Билиг ханыг оруулан аваад, цааш Кашгар, Яркент, Хотон зэрэг газрыг оруулан авч, Туркестан улсыг эзлэн авав. Энэ үед Туркестаныг Эфрассияабэс төрийн хоёрдугаар ван Махмуд гэгч захирч байжээ. Тэр Туркестанаа алдаж, ганцхан Хэ Чжун-ы газартайгаа үлдсэн боловч дэмий хэдэн жил болсонгүй бас Хар Хятаны харьяат улс болов. Түүнчлэн Елюй Даши-гийн цэрэг нь Хорезм улсыг бас эзлэн авч, жил бүр гурван түмэн алтан зоосны өргөл бариулахаар тогтжээ. Ингээд алсын их говиос Аму мөрөн (одоогийн Аму-Дарья мөрөн) хүртэл, Төвдийн уул нууруудаас Сибирийн уул нуруу хүртэлх өргөн уудам нутаг - гол нь одоогийн Шинжаан болон түүнээс барууншихи уудам их орон газар нь цөм Елюй Даши-гийн эрх харьяанд захирагдаж, 1124 он (энд Дундад улсын түүхэн он тооллыг үндэслэв. Д’Оссон: 1125 он гэж, шинэ “Үгсийн далай”-д 1132 он гэжээ)-д биеэ Гүр хан өргөмжилж, Хар Хятан улсыг байгуулав. Тухайн

үедээ Кирманд нийслэж, дараа нь Хос орд (одоогийн Зөвлөлтийн Киргизийн Токмакаас зүүнш Чүй мөрний өмнөд эргэд байжээ, бас Беласагун гэдэг юм)-д нийслэжээ. Елюй Даши бол Буддагийн шашныг шүтдэг бөгөөд түүний эзэлсэн газар нь Ислам зэрэг бусад шашныг шүтдэг билээ. Елюй Даши 1136 онд үхжээ. Тэр үед түүний орыг залгамжлагч хөвгүүн нь Илэй гэгч нялх бага байсан тул хатан Табуянаар төрөө захируулахаар гэрээслэсэн гэлээ. Табуян долоон жил Хар Хятаны төрийг захирч 1142 онд Илэй-д тушаав. Илэй 1155 онд үхжээ. Илэй-н хөвгүүн Жүрүхү бас нялх бага байсан тул Илэй-н охин дүү Босуан гэгч 1167 он болтол төрийг захирч байв. Жүрүхү 1167 оноос Хар Хятаны Гүр ханы орыг залгамжилж, Найманы Хүчүлүг-т төрөө булаагдтал эрх барьж байв.

1204 онд Найманы Таян ханы хөвгүүн Хүчүлүг, Чингис хаанд дийлэгдэн амь зугатан дутааж, 1208 онд Хар Хятаны Жүрүхү хааныг түширэхээр очив. Гэвч Жүрүхү уулзахгүй буюу ямар нэгэн аюул учрахаас болгоомжлож, нэхэн дагаснаараа өөрийн биеийг орлуулж, өөрөө дагагсад болон гадаа нь зогсож байхад, Жүрүхү хааны хатан Хэрэбэс (зарим материалд хааны охин нь гэдэг) гаднаас ирэх лүгээ учирчээ. Хүчүлүгийн төрсөн байдал гоё сүрлэг, энгийн хүнтэй адил бус тул хатан дотогш дагуулан орж, үнэн байдлыг нь ойлгон мэджээ. Ингээд Жүрүхү хаан нь Хүчүлүг-ийг эрхэм зочноор хүндэлснээр үл барам, журмын хөвгүүн таньж, бас өөрийн охиноо өгч гурван хоног болсонгүй Найманы оргодол Хүчүлүг, Жүрүхү хааны хүргэн нь болжээ. Энэхүү гүнжийнх нь нэр нь Хонхугэдэг, Хэрэбэс хатны төрсөн охин (зарим материалд Жүрүхү-гийн ач охин гэдэг), тэр үед арван таван настай байжээ. Энэ охин бол сэцэн бөгөөд хулжин, эцгийнхээ занг сайн мэддэг тул эцгийгээ бялдуучлах аргыг эрдээ зааж өгчээ. Ингээд Хүчүлүг Жүрүхү хааны итгэл хайрыг олж, дотно хүн нь болов.

Гэвч Хүчүлүг тэрхүү ач тус хийсэн хадам эцгийнхээ амийг нь зааж, төрийг нь булаахаар далдуур оролдлого хийжээ. Ингээд тэрээр Жүрүхү хааны доорхи жанжин нараас заримыг нь бие зүгээ өдөөн татаж, бас Найман, Мэргидийн үлдэгдэл оргодлуудыг цуглаасан бөгөөд Жүрүхү хааны харьяат улс Хорезм, Самарканд, Осман зэргийг мэхлэн өдөөж, 1211 он буюу 1212 он (Хотонгийн он тооллын 608 он)-д гэнэтийн хувьсал гаргаж, Хар Хятаны төрийн эрхийг нь булаан авсан байна. Түүнчлэн Елюй Даши баруунш нүүснээс нааш, Хүчүлүгт төрөө булаагдтал, Хар Хятан улс нь таван хан ор залгамжилж, нийт наян найман жил болжээ.

Хүчүлүг Хар Хятаны төрийг булаан эзэлснээс нааш бас “Хар Хятан” гэсэн нэрийг нь ашиглажээ. Гэвч түүний харьяат улс ба ард иргэд, ялангуяа Исламын шашинтныг хэрцгий харгисаар дарангуйлсан байна. Чухамдаа Найман аймгийн олонхи хүмүүс нь Христосын шашны Несториан бүлгийг шүтдэг юм. Гэвч одоо тэр, эм (Жүрүхү-гийн охин)-ийнхээ аяыг дагаж Буддын шашныг шүтжээ. Ингээд тэр эзлэн захирсан Хотон ардыг албадан, Исламын шашныг нь орхиулж, Христосын шашин буюу Буддын шашныг шүтүүлэхээр оролджээ. Хүчүлүг нэгэн өдөр, Исламын шашны хэргэмтдийг хотын гаднахи талбайд цуглааж, “Хэрвээ энэхүү шашны ёсыг маргалцах хүн байвал гарч ир” гэж зарлиг буулгасан гэнэ. Энэ үед Исламын шашны Имам (тэргүүлэгч) Ала-Үд-Дин Мухаммед гэгч урагш гарч, Хүчүлүгийн өмнө хүрэн маргалдахуйяа, Хүчүлүг зарлигийг эсэргүүцэв хэмээн сахиулсан Мухаммедыг нь хараасан гэлээ. Ингэхлээр “Эзэн тэнгэрийн дайсны хэл нь шороонд булхатугай!” гэж Имам их дуугаар хашгирсан гэнэ. Тиймээс Хүчүлүг түүнийг барьж аваад эрүүдэн тамлаж, шашнаа өөрчлө гэсэнд Имам дагасангүй байв. Дараа нь Хүчүлүг Имамыг сүмийнх нь үүдэн дээр хадаж алсан гэлээ.

1218 он (Хотоны тооллын 615 он)-д Чингис хааны томилсон Зэв ноёны захирсан хоёр түмэн их цэрэг Хар Хятаны Хүчүлүг-ийг дайлаар хүрэхүйд Хүчүлүг Кашгар өөд дутаажээ. Зэв ноён хотод нь ормогц “ямар шашныг боловч өөр өөрийн дураар шүттүгэй” гэж тунхагласан тул суугуул ардууд нь тэднийг эзлэн захирч байсан Хүчүлүгийн цэргийг алж, монгол цэргийг угтан дагажээ. Зэв ноёны их цэрэг нь Хүчүлүг-ийг нэхэж Бадахшан (“Нууц товчоон”-д “Сариг гун” гэжээ. Энд “Дэлхийг дайлан дагуулагчдын түүх”-ийг баримтлав) гэдэг газар гүйцэн барьж алсан бөгөөд Зэв баруун орны ам цагаан сайн андаас мянгыг сонгож Чингис хаанд бэлэг болгон хүргэв гэдэг билээ. Монголын үлдэгдэл дайсан ба түүний шургаж байсан газар нь ч ингээд дуусчээ. Эдгээр нь бүр Монгол орноос оргон зугатсан ил дайснаа цэвэрлэж, шинэхэн байгуулсан Хаант Монгол Улсын нутаг дэвсгэрээ өргөтгөж бэхжүүлсэн явдал болно. Ийм ажиллагааг аль нэгэн төрийн ноёрхогчид ч бүр гүйцэтгэж байдаг.

51. Дотоодоо бэхжүүлсэн нь

1206 онд Их Монгол Улсыг байгуулсны дараахан, Чингис хаан Алтан улсад эртний өшөө хорслынхоо хариу сөнөөгч цохилт өгөх санаатай байсан юм. Гэвч, тэр үед Ойн иргэд Их Монгол туургатны зарим аймгийг нэгтгээгүй, үлдэгдэл дайсныг бүрэн устгаагүй, дотоодоо сайтар бэхжүүлээгүй байснаас энэ явдлыг түр хойшлуулжээ. Энэ хэдэн жилийн дотор, түрүү хоёр үүрэг - Ойн иргэдийг нэгтгэн авах ба үлдэгдэл дайсныг устгах үүргийг үндсэндээ биелүүлсэн байна.

Одоо дотоодоо бэхжүүлэх үүрэг Чингис хааны өмнө түүхэн ёсоор тавигджээ. Энэ нь мөн ч ямар нэгэн шинэ ноёрхогчдын зайлуулж болшгүй үүрэг юм. Ялсан этгээд дотоодоо бэхжүүлэхэд, эрх гавьяагаа зохистой тэгшитгэж, олз ашгаа тохиромжтой хуваах ба дотоодоос гарч дайсныг сэрэн мэдэж зохистой арга хэмжээ авах хэрэгтэй байдаг.

Урьд 1206 онд мянга, түмний ноёд ба бусад тусгай ноёд түшмэлийг томилж, гавьяатан нарыг шагнасан явдал бол хэрэг дээрээ шинэ ноёрхогчдын эрхийн тэгшитгэл болно.

Олз ашгаа хувилсан нь

Дараа нь Чингис хаан алтан ургийн дотроо олз ашгаа хуваах нь чухал явдал болж байсныг “Нууц товчоон” (242 - 243 дугаар зүйл)-д хангамжтай тусгаж байна. Өгэлүн эх ба дөрвөн дүү (Хасар, Алчидай - Хачигуны хөвгүүн, Бэлгүтэй, Отчигин), дөрвөн хөвгүүн (Жочи, Чагаадай, Өгөөдэй, Тулуй) 8 тус бүрд зохих тооны ард иргэд ба газар нутгийг хуваан хувь өгчээ. Чингис хааны ингэж хувь хувьдсан, тухайлбал хэн нь илүү олох, хэн нь дутуу олохыг нүүдэлчин үндэстний зан заншил ба хүн нэг бүрийн гавьяа зүтгэл, байр суурь зэргийг үндэслэж хийжээ. Ингэж хийх нь хаант улсын нэгдэлд саад харш болохгүй гэдгийг Чингис хаан лав тодорхой мэдэж байсан юм. Учир нь энэхүү нэгдмэл хаант улс нь хаан эзний халдашгүй дархан эрх ба түүний тогтоосон “их засаг”-аар нь батлагдаж байсанд оршино.

Гэвч энэ удаагийн хувь хувьдлагад бас хоёр зүйл зөрөлдөөн үүсчээ. Нэг нь, хувь хувьдлага зохисгүйдсэн явдал болно. Жишээлбэл, “Дүү нарын минь бага Отчигин буй за хэмээгээд эх Отчигин хоёрт нэгэн түмэн иргэн (түмэн өрх)-ийг өгвөөс эх чамлаж эс дуугарав” (“Нууц товчоон”, 242 дугаар зүйл). Нөгөө нэг нь, хувь хувилсангүй мөртөө ял асуусан явдал болно. Есүхэй баатарын бага дүү, Чингисийн авга Даритай Отчигинийг “Хэрэйдтэй нийлж явсан

хэмээн нүднээс далд болгоё” гэж Чингис хаан хэлжээ. Гэвч “Өөрийн голомтыг сөнөөх мэт, өөрийн гэрийг эвдэх мэт болох биш үү. Сайн эцгийн чинь гэрээс болж үлдээсэн ганц авга чинь биш үү. Түүнийг үгүй хийж яаж болно? Түүнийг ухаж мэдсэнгүйг уучлатугай” гэж Боорчу, Мухулай, Шигихутуху гурав “халуун сэтгэлээр ятгаж, хамраасаа утаа гартал хэлсэн” сайнаар түүний амь нь сая мултарсан гэлээ.

Энэ бол харьяат иргэнээ хувьдсан анхны хувьдлага болно. Нутаг газраа хуваасныг нь сүүлчийн бүлэгт бас тэмдэглэх болно. Энд тэмдэглүүштэй нэгэн зүйл бол энэ удаагийн хувьдлага чухам аль онд болсон гэдэг асуудал болно. “Нууц товчоон”-д бол Ойн иргэдийг нэгтгэн авсны дараа, Алтан улсыг дайлахаас өмнөхйн учраар тэмдэглэж буй. Тийм бол 1211 оноос өмнөх явдал болох ёстой. Гэтэл Түмэдийн бослогыг дарангуйлсныг бас энэ хугацаанд тэмдэглэж байдаг. Энэ нь хэрэг дээрээ 1216 - 1217 оны явдал юм. Ийм хувь хувьдлагыг ялсны дараахан, гадагш дайлахаас өмнө гүйцэтгэх нь зүйд нийцэх хэрэг юм.

Чингис хаан ба “Дэв тэнгэр”

Дэв тэнгэр гэгч бол Хонхотны Мэнлиг эцгийн долоон хөвгүүний дөрөвдүгээр нь болно. Түүний нэр нь Хөхэчү гэдэг. Тэр бол бөө болохоор “Дэв тэнгэр” гэсэн нь бөө мөргөлийн цол болно. Энэхүү цолын тухай эрдэмтэн нар ч янз бүрээр тайлдаг юм. “Нууц товчоон”-ы уг галиглал нь “Те-бу” гэдэг, үүнийг нь сүүлчийн үед “Дэв” гэж монголчлоод заншжээ. Миний үзэхээр үүнийг “Тив” гэж галигласан ч болох мэт, тийм бол “Тив тэнгэр” гэснийг “газар тэнгэр” буюу “Эх дэлхий, эцэг тэнгэр” гэсэн бөөгийн ёсоор тайлж болох юм. Гэвч энд бас “Нууц товчоон”-ыг баримтлав.

Дэв тэнгэр нэг үе Чингис хааны итгэл найдварыг ихээр олж, хааны захад хамаагүй орж гардаг байв. Чухам гавьяа зүтгэлээр нь хэлбэл, түүнд ямар ч гавьяа зүтгэлгүй юм. Энэ хүний “гарамгай чадвар” бол мухар биширлийг ашиглан цуурхал тавьж, “хүний гараар могой барих” ажлыг сайтар хийж чаддаг байна. Анхандаа тэд эцэг хөвгүүн бүгдээрээ Жамуха-гийн талд үйлчилж байжээ. Сүүлд нь “Арван гурван хүрээний байлдаан”-ы дараа сая Жамуха-гаас салж Чингис хааныг дагаж ирсэн билээ. Гэтэл яагаад ийм итгэл найдварыг олсон буй гэвэл, гол нь түүний эцэг Мүнлиг-ийн байр суурьтай холбогдоно. Мүнлиг бол Есүхэй баатарын анд нь бөгөөд Есүхэй баатарын өнчин өрөөсөн гэр бүлийг нь харгалзах гэрээсийг хүлээсэн хүн юм. Хэдийгээр Мүнлиг эцэг хүчиртэй үед гуйвалзаж, нэг үе зайлан явсан боловч Чингис хаан түүнийг хэзээд “эцэг” ёсоор хүндэлж байсан бөгөөд наян найман гавьяатны тэргүүнд шагнажээ. Тиймээс Мүнлигийн хэдэн хөвгүүнд ч Чингис хаан мөн дотноор хандаж байсан билээ. Нөгөө нэгэн шалтгаан нь бол шашин шүтлэгийн харьцаа болно. Дэв тэнгэр бол “байнгадаа нүцгэн биеэрээ хөдөө гадаагүй явдаг” (“Дэлхийг дайлан дагуулагчдын түүх”) бөгөөд үүнээс бас “Тэнгэрт гарлаа” гэж дөргүүлж явдаг бөө хүн юм. Тухайн үед олонхи Монголчууд байтугай, Чингис хааны өөрийн бие нь ч нэгэн бөө мөргөлийн шүтэгч байсан юм. Чингис хаан нэлээд явдлыг хэдийгээр бодосч үзлээр шийдвэрлэж байсан боловч, түүний үзэл санааг нь “Мөнх тэнгэрийн хүч”-ийг шүтэх сэтгэлч үзэл байсан нь гарцаагүй хэрэг. Тиймээс Дэв тэнгэр бөөгийн итгэл найдвар нь Чингисийн дэргэд онцгой байр суурийг эзэлж байсан билээ.

Дэв тэнгэр гагцхүү мухар бишрэлийг хөөцөлдсөн “мунхаг бөө” биш, харин энэхүү мухар бишрэлийн багажийг ашиглаж байгаад өөрийн улс төрийн зорилго - Монголын ноёрхох

эрхийг атгах зорилгоо биелүүлэхээр хэнээрэн тэлчилж байсан төрийн завшигч болно. Гэвч тэр үед Чингис хаантай хүчээр халдахыг оролдох байтугай, тэгж сэтгэх хүн ч цөөн байсан юм. Дэв тэнгэр бол өөр нэгэн фронтоос Чингисийн байр суурь өөд довтолж хийжээ. Энэ бол дэлхий дахиныг донслогосон нэгэн үеийн агуу их баатар Чингисийн нүд чихийг хүртэл бүрхсэн Хөхэчү бөөгийн “тал хэнгэрэг” (бөөгийн хэрэглэдэг хэнгэрэг бол ганц талдаа бүрээстэй байдаг)-ийн чадал болно.

Тэр, энэхүү зэр зэвсэггүй фронтод хэлэн байлдаан (голдуу мухар бишрэлийг ашиглаж цуурхал тавьдаг)-ы аргаар нэлээд амжилтыг олсон байлаа: “есөн хэлтэн (хамаг) улс, Дэв тэнгэрт хуралдан очсон ба Чингис хааны агтны хорооноос ч олон хүн Дэв тэнгэрт очиж захирагдав. Бас Отчигин ноён, Тэмүгэ-гийн харьяат иргэн Дэв тэнгэрт очжээ” (“Нууц товчоон”-ы 245 дугаар зүйл) гэдэг. Энэ чадлыг бага гэж үзэж болохгүй биз? Хэрэг явдал нь эцэстээ Чингис хааны алтан урагт нь халдаад сая илчлэгдсэн юм. Үүний тухай хэдэн будлиантай үлгэр үүсчээ.

Нэгдүгээр нь: Харгис бөө Хасар баатарыг занчиж, хайрт Өгэлүн эх хөвгүүнээ аврав

Нэгэн өдөр, Мүнлигийн долоон хөвгүүн нийлж, Чингис хааны дүү Хавт Хасарыг элбэж занчсан байна. Ингээд Хасар, долоон Хонхотанд занчигдсан явдлаа Чингис хаанд мэдүүлжээ. Энэ үед Чингис хаан өөр нэгэн явдалд хилэнлэж байсан тул, энэ уураараа Хасарыг “Амьтанд дийлэгддэггүй хүн гэдэг биш бил үү чи? Яагаад дийлэгдэв?” гэж зэмлэжээ. Хасар нулимсаа унагаж гараад, гомдсондоо гурван өдөр хаантай уулзсангүй гэлээ. Дэв тэнгэр энэхүү завшааныг нь далимдуулж, Чингисийн дэргэд очоод: “Мөнх тэнгэрийн сахиулсан, нэгэн удаа Тэмүжин улсын эрхийг баримуй. Нэгэн удаа Хасар улсын эрхийг баримуй гэж зөн мэдэгдэв. Хасараас эс болгоомжилбоос юу болохыг мэдэхгүй” (“Нууц товчоон”-ы 244 дүгээр зүйл) гэж завсардуулга хийжээ. Чингис хаан энэ үгийг нь итгэж, шөнө дүлээр явж, Хасарыг барин ирэв. Энэхүү бачим чимээг нь Өгэлүн эхийн тэжээсэн хөвгүүн Хүчү, Хөхэчү хоёр Өгэлүн эхэд түргэн мэдэгдсэн учраас, Өгэлүн эх цагаан тэмээ хөлөглөн хөлсөн сүйх тэргэндээ сууж, шөнө турш явж, өглөөгүүр хүрч ирэхэд нь Чингис хаан Хасарыг хүлж, малгай бүсийг нь аваад байцаан асууж байжээ. Өгэлүн эх тэргэнээсээ буумагц Хасарын хүлээг нь өөрөө тайлж тавиад, малгай бүсийг нь Хасарт өгч, уур хилэнгээ дарж ядан завилан суугаад хоёр хөхөө гаргаж, хоёр өвдөг дээрээ барьж, Чингисийг сүрхий донгодон зэмлэсэн тул Чингис хаан эхийн өмнө өөрийн буруугаа мэдэж, Хасарыг тавив. Гэвч Чингис хаан “эхдээ хэлэлгүй далдуур Хасарын зарим иргэнийг булаан авч Хасарт мянга дөрвөн зуун иргэнийг үлдээв” (“Нууц товчоон”-ы 244 дүгээр зүйл) гэдэг билээ.

Дэв тэнгэр юуны учир Хасарыг урьдаар үгүй хийхийг оролдов? гэвэл, Чингис хааны хэдэн дүү нарын дотор, Хасар хүч чадлаар хамгийн их, гавьяа зүтгэлээр аль арвин бөгөөд олны итгэл хайрыг олсонд оршино. Иймээс Өгэлүн эх:

“Хасар хав хүчтэй тул

Хатгалдан зайлагсдыг

Харвах сумын хүчээр

Хамж авчирдаг билээ.

Огшиж дутаагсадыг

Онох сумын хүчээр

Оруулан авчирдаг билээ”

гэж магтаж байв. Энэ явдлын дараа дэмий удсангүй, Өгэлүн эх өвчнөөр нас барав (Ли Цзэ Фэнь-ий ном) гэдэг билээ.

Хоёрдугаар нь: Мэхт Хөхэчү давшуурч Отчигинийг сөгтгөв, мэргэн хатан ятгаж хааныг сэрүүлэв

Дэв тэнгэр, Хасар ба Чингис хаан хоёрыг завсардуулсныхаа хойно, улам давшуурч, Чингисийн отгон дүү Отчигин ноёнд халджээ. Отчигиний харьяат иргэдийг нь Дэв тэнгэр өдөөн авчирсан тул, Отчигин ноён одсон иргэнээ авчруулахаар Сохор гэгч элчийг илгээсэнд Дэв тэнгэр элчийг зодож, эмээлийг нь үүрүүлэн явган буцаажээ. Маргааш нь Отчигин ноён биеэрээ очиж, элч Сохорыг зодож, явган буцаасан учрыг асууж, харьяат иргэнээ авна гэсэнд, Мүнлиг-ийн долоон хөвгүүд Отчигин ноёныг энд тэндээс нь хааж бүслэн аваад, “элч илгээсэн нь буруу” гэж шахан өчүүлж, “Дэв тэнгэрийн хойноос сөгдүүлжээ”. Ингээд Отчигин ноён маргааш өглөө нь Чингис хааныг босохоос өмнө ирж, хааны орын өмнө сөгдөөд Дэв тэнгэрийн аашлан дарлаж бүхий эдгээр явдлыг нэг нэгээр өөлөн мэдүүлсэн байна.

Чингис хаан үг хэлэхийн өмнө, мэргэн хатан Бөртэ үжин өндийн сууж, нулимсаа унагасаар:

Тэд Хонхотан нар яасан хэцүү хүмүүс билээ? Урьд Хасарыг бүслэн занчсан бөлгөө. Одоо бас энэ Отчигинийг яагаад хойноосоо сөгдүүлэв? Энэ ямар ёс буй? (чамайг бэлээхэн амьд байхад - А.Т) ойн нарс мэт олон сайхан дүү нарыг чинь ингэж дарлаж байна.

Үүнээс хойш тэд

Үүл мэт биеийг чинь

Үгүй болж одвоос

Үлсэн их улсыг чинь

Үр хүүхдээр чинь мэдүүлэх үү?

Сүүлчийн цагт тэд

Сүлд гэгээн биеийг чинь

Сүүдэр болж одвоос

Сүрэг их улсыг чинь

Шийтгэхэд хүрэх биш үү.

...

Яасан хэцүү Хонхотан нар билээ? Дүү нараа ингэж дарлахыг үзсээр байгаад зүгээр өнгөрүүлэх үү чи? (“Нууц товчоон”-ы 245 дугаар зүйл) гэж хэлжээ. Бөртэ үжиний энэ үгийг Чингис хаан зөвшөөрч, Отчигин-д: Дэв тэнгэр одоо ирмүй. Өшөөгөө яаж авахыг чи өөрөө мэд! гэж хэлэв.

Гуравдугаар нь: Эрх сүрт бөөг эцэслэж, элдэв хоёр сэтгэлтнийг цээрлүүлэв

Ингээд Отчигин ноён гурван аварга хүчит бөхийг бэлтгэж, үүдэн гаднаа зогсоов. Үнэхээр удалгүй Мүнлиг эцэг долоон хөвгүүнээ дагуулан ирж бүгдээр гэрт орж, Дэв тэнгэр сүнгийн баруун этгээдэд суужээ. Энэ үед Отчигин ноён босч ирээд “Өчигдөр чи намайг наминчлуулсан бил үү? Хүчээ үзэлцэе” гэж Дэв тэнгэрийн дээлийн захаас барьж үүд тийш гадагш чирэв. Тийнхүү тэр хоёр зууралдан ноцолдож байхад, Чингис хаан: “гадагш гарч бөх хүчээ тэмцэлдэгтүн” гэв. Отчигин, Дэв тэнгэрийг босго дээгүүр чирч гаргахад урьд бэлтгэсэн гурван бөх угтаж, Дэв тэнгэрийн нурууг нь хугалаад, зүүн этгээдийн угсарсан тэрэгний үзүүрт орхиж, Отчигин орж ирээд: “Дэв тэнгэр намайг наманчлуулж байсан билээ. Одоо хүчээ үзэлцэе хэмээвээс үл зөвшөөрч баширлан хэвтэж байна” гэж хэлсэнд Мүнлиг эцэг учрыг нь мэдэж нулимс унагажээ.

Ингээд Мүнлиг-ийн зургаан хөвгүүн үүдийг хааж голомтыг тойрон ханцуй шамлан босч, их зодоон болохыг завдахад, Чингис хаан гэрээс гарч, хорчин, турхаг нар нь хамгаалж авчээ. Дэв тэнгэрийн нурууг нь хугалаад орхисныг Чингис хаан үзэж, араас нь нэг бор гэрийг авчруулж, Дэв тэнгэрийн дээр нь бариулаад, тэндээс нүүн явжээ.

Дэв тэнгэрийг тавьсан тэрхүү гэрийн өрхийг бүтээж, үүдийг нь дарж хүнээр сахиулж байсан боловч, гуравдугаар өглөө болоход өрх нь нээгдэж, Дэв тэнгэрийн хүүр нь үгүй болсон гэлээ. Ингээд Чингис хаан: “Дэв тэнгэр, миний дүү нарт гар хөл хүрсэн ба миний дүү нарын хооронд оргүй хов үгийг хэлсний тул тэнгэрийн таалалд эс нийлж, түүний амь бие хоёулыг тэнгэр авч одов” гэж хэлсэн бөгөөд “Та нарын ийм зан гаргахыг мэдсэн бөгөөс та нарыг хэдийн Жамуха, Алтан, Хучар нарын адил болгох билээ” гэж Мүнлиг болон түүний хөвгүүдийг донгодон цээрлүүлэв. Үүнээс хойш Хонхотаны хөвгүүд номхров гэдэг билээ. Энэ явдал 1219 оны барагаар үүссэн бололтой.

Энэ бол Чингис хаан дотоодын дайснаа дарсан нэгэн сонгодог жишээ болно. Тэр үед бөө мөргөлийн шашин нь Чингис хааныг багтаасан бүх Монголчуудын оюун санааг чанга эрж байсан хүлээс юм. Тиймээс Дэв тэнгэрийг эцэслүүлэхэд Чингисийн оролцоогүй болохгүй, түүнийг дарсан явдал нь бусад буруу санаатанд ч сүрхий цохилт болох ёстой.

Багцлаад хэлбэл, тус бүлэгт Хаант Монгол Улсыг өргөтгөсөн ба бэхжүүлсэн явдлуудыг дотоод гадаад хоёр талаас хураангуйлан дурдсан юм. Үүний олонхи нь 1206 онд Хаант Монгол Улсыг байгуулсны дараа, 1211 онд Алтан улсыг дайлахаас өмнө явагджээ. Гэвч зарим нь тэр үед эхэлсэн боловч 1219 онд баруунш дайлахаас өмнө сая биелэгдсэн байна. Монгол орноо бүрэн нэгтгэж, үлдэгдэл дайсан ба дотоодын дайснаа цэвэрлэсэн явдлыг Чингис хааны

гадагш дайлахын байлдах бодлогын чухал бэлтгэл гэж үзэж болно.

Одоо Хаант Монгол Улсын хил нь шууд Гуули улс (Солонгос улс), Алтан улс, Тангуд улс, Хорезм улс зэрэг улс гүрэн лүгээ залгалдах болов. Ингээд Чингис хааны гадагш дайлах дайны хөшиг ч нээгдэв.

Дагалдвар

1 Чингисийн цэрэг 1205 онд умард Найманыг мөхөөж, Мэргидийн Тогтуга бэхи-г Бухдурма гэдэг газар алснаас нааш, Жочи-гийн цэрэг тэндээ үлдэж, Алтайн ар хавийг сэргийлж байжээ. Хэрэг дээрээ энэ үеэс эхлээд, Ойн иргэдийг эзлэх ажиллагаагаа явуулсан бөгөөд Хутуга бэхи ч энэ хооронд бууж өгсөн бололтой. Тиймээс энэ удаагийн байлдаан нь 1205 оноос эхэлж, 1207 онд дууссан нь зүйтэй юм. Гэвч түүхэн тэмдэглэлд адил бусаар тэмдэглэж байна. “Нууц товчоон”-д туулай жил (1207 он) цэрэг мордсоноор тэмдэглэж буй. “Биеэр дайлсан тэмдэглэл”-д:

“Улаан туулай жил” (1207 он) урьд Алтан, Бугула хоёрыг Киргиз аймагт элчээр илгээв. Киргиз аймгийн ноён Орос Инал ба Алдикэр, Яди Иналаас Илхэ Төмөр, Адхираг хоёрыг элчээр томилж, манай элчийг дагуулан ирж цагаан шонхор өргөж найрамдав гэж тэмдэглэж байх бөгөөд Жочи-г томилсон явдлыг шар барс жил (1218 он)-ийн явдал болгон тэмдэглэж: “Урьд Түмэд аймаг урвасанд, Чингис Киргиз аймгаас цэрэг элссэнд Киргизчүүд цэрэг гаргасангүй урваж дайсагнажээ. Чингис хаан их хөвгүүн Жочи-гоор байлдтугай хэмээн зарлиг болж, Буха-ыг хошуучаар явуулав. Киргиз нарыг Инал гол хүртэл нэхэж буцаав. Жочи-гийн цэрэг Ениссей мөрнийг гаталж, голыг дагасан аймаг улсыг элсэн дагуулав. Ингээд Урсуд, Хабханас, Тэлэнгүд, Хэстием зэрэг Ойн иргэдийг эзлэж авчээ” гэжээ. “Судрын чуулган”-ы тэмдэглэл нь бас “Биеэр дайлсан тэмдэглэл”-тэй адилаар. Энэ хоёр тэмдэглэлийг Ту Цзи авгай сэжиглэлтэй гэж үзжээ. Тус товчоонд “Нууц товчоон”-ы тэмдэглэл болон Ту Цзи авгайн саналаар гол баримт болгов.

2 Шигшид гол бол Алтай нурууны умар дахи Гал хүрээт уулаас ундарч, хойш Ховд голд нийлдэг Сагсай гол мөн гэж Ту Цзи авгай тэмдэглэжээ. “Одоо “Шигшид гол” гэнэ. Саяны нуруунаас эх авна (уртраг нь 98° , өргөрөг нь 51°)” гэж Х.Пэрлээ тэмдэглэж байсан нь Ту Цзи-гийн тэмдэглэл ба Дундад улсын газрын зургийн хэвлэлийн хорооноос 1957 онд хэвлүүлсэн “Дэлхийн газрын зураг” лугаа нийцэж байна.

3 Чэчэйхэн, Улайхан хоёр гүнжийн тухай тэмдэглэлүүд хоорондоо маш их зөрөөтэй байж байна. Тус товчоонд “Нууц товчоон”-ы тэмдэглэлийг эшлэжээ.

Рашид-ад-Диний номд: “Бөртэ хатны хоёрдугаар охин Чичиганыг Ойрадын Хутуга бэхи-гийн хөвгүүн Торалчи-д өгөв гэжээ. Энд “Чичиган” гэдэг нэр нь “Чэчэйхэн” лугаа ойртож байвч “Торалчи”, “Иналчи” нь огт таарахгүй байна. Энэхүү “Торалчи” гэдэг нь “Нууц товчоон”-д дурдсан Иналчи-гийн ах “Төрүлчи” гэдэгтэй нэг хүн гэж үзэж болно.

“Юань улсын түүх, гүнжийн илтгэл” дэхи Янь Ань гүнжийн байрт, “Хүхүгэн гүнжийг Тойлчи гэгч хүргэнд мордуулав” гэж тэмдэглэж буй. Энд гүнжийн нэр зөрөөнтэй боловч өөр талаараа Рашид-ад-Диний тэмдэглэлтэй адилаар байна. Бас тус илтгэлд, Хүхүгэн гүнжийн

өмнө, “Хулу гүнжийг Хада гэгч хүргэнд мордуулав” гэж тэмдэглэж буй. Энэ “Хулу” гэдгийг Жочи-гийн охин Улуйхан гэсэн нэрийн хувирал магадгүй гэж Накамиchie, Ту Цзи нар жишиж байлаа. Гэтэл “Хада”-гийн тухай хангамжтай тайлбар хийсэнгүй.

“Ту Цзи-гийн тэмдэглэл”-д:

Киргиз хүн ахлагчаа “Инал” гэж нэрлэдэг гэж Д’Оссоноос Рашидын тэмдэглэлийг үндэслэж хэлсэн нь “Нууц товчоон”-той адил байна. Ойрад хэлэнд бас ингэж нэрлэдэг ч магадгүй. Хэрвээ тийм бол “Иналчи” гэсэн нь Хутуга бэхи-гийн хөвгүүний нэр биш, цол нь болно. Чэчэйхэн-ийг Төрүлчи-д өгсөн нь таарах бөгөөд Төрүлчи-гийн ах нь Хадай (Хадай болон Хада-г нэг хүнээр үзжээ - эшлэгч) болно гэжээ.

4 “Нууц товчоон”-ы 235 дугаар зүйлд Чингис хаан, Харлуг-ийн Арслан хаанд охиноо өгье гэж зарлиг болсноос биш, чухам аль охиноо өгсөн тухай тэмдэглэлгүй. “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д “Чингис хааны охин Тулай гүнжийг өгч Жүн ван өргөмжлөв” гэж тэмдэглэж байх бөгөөд Арслан хан үхсэн хойно түүний хөвгүүн Есөн буха бээр “Жүн ванг нь ширүүлж, бас Тулай гүнжийг залгав” гэж тэмдэглэж буй (150 дугаар, 154 дүгээр боть). “Юань улсын түүх, гүнжийн илтгэл” дэх Тулай гүнжийн байрт “Тулай гүнжийг Арсланы хөвгүүн Есөн буха хүргэнд өгөв” (190 дүгээр боть) гэж тэмдэглэж байх бөгөөд Тулай бол хэний охин гэснийг дурдсангүй билээ. “Д’Оссоны Монголын түүх”-д “Арслан ханд бас Чингис хааны төрийн гүнжийг өгөв” гэж л тэмдэглэж буй. “Лу. Алтан товч”-д: Харлугуудын Арсланд Алага бэхи-г өгч Чингис хаан соён зарлиг болруун:

Харайхад минь хөл болж

Хазайхад минь түшиг болж

Халтирахад минь тах болж

Халамж тусыг хүргэхээ

Хайрт Алаха минь мэдтүгэй.

.... гэсэн тэмдэглэл байдаг бөгөөд энэ хэсгийг нь Ц.Дамдинсүрэн авгай түүний одоочлосон “Нууц товчоон”-ынхоо 235 дугаар зүйлийн сүүлд нь нөхвөрлөн оруулжээ. Гэтэл “Нууц товчоон”-ы 239 дүгээр зүйлд “Алага бэхи охиныг Онгудад өгөв” гэж тэмдэглэж буй. Энэ тухай өөр тэмдэглэлүүд ч бүр хөндлөнгөөс гэрчилж байдаг юм (тус товчооны тавдугаар бүлгийн дагалдвар14-г лавлаарай). Тиймээс “Лу. Алтан товч”-ийн энэхүү тэмдэглэлийг багтай баримт гэж хэлэхийн аргагүй, лавлалт болгож энд тэмдэглэв.

5 “Нууц товчоон”-ы тэмдэглэлийг үндэслэвэл, “Адхираг, Дарбай” хоёр бол Уйгурын Итүгүд хаанаас Чингис хааны дэргэд томилон илгээсэн элч болно. Гэтэл “Д’Оссоны Монголын түүх”-д: 1209 оны хавар, Хар Хятаны томилсон ноён Шаокэм гэгч хүнд алба гувчуураар хяхаж мөлжиж байсан тул Баражу (Итүгүд хаан Баржуг Арт-ыг хэлж буй - эшлэгч) тэсч ядахдаа Шаокэмийг Хар Хожо гэдэг газар алжээ. Чингис хааны энэхүү учрыг нь сонсч, 1210 оны зун Алб-отог, Дарбай хоёр элчийг илгээв. Итүгүд эрхэм ёсоор зочилж, дотоод сайд хоёр

хүнийг элчийн хамт Чингис хааны төрд илгээв” гэж тэмдэглэж байна. Ингээд үзвэл энэ нь Уйгурын элч биш, Чингисийн элч болжээ. Би “Нууц товчоон”-ы тэмдэглэлийг баримтлав.

6 Уйгурын Итүгүд хаан Баржуг Арт Тигинд Чингисийн охин Ал Алтун гүнжийг өгөөд, ураглаж завдаагүйгээр үхэв гэж Ту Цзи авгай тэмдэглэжээ. “Юань улсын түүх, гүнжийн илтгэл”- дэхи Гао Чан гүнжийн байрт: “Е-ли Ань-дунь гүнж, Тайцзу-гийн охиныг Итүгүд Баржуг Арт Тигинд өгөв” гэж тэмдэглэж буй. Энэ “Е-ли Ань-дунь” гэдэг нь “Ал алтун” гэсний хувирал болох нь тодорхой байна. “Нууц товчоон”-ы хятад галиглалыг “Ал алтун” гэж монголчилбоос болох юм. “Ал” гэдэг үг бол “улаан” гэсэн утгатай түрэг гарлын үг юм. Гэтэл Б.Я.Владимирцовын зохиосон “Чингис хаан” гэдэг товхимолд “Чингис хаан өөрийн охин Алчалтун (Alchaltun)-ыг түүнд гэргий болгон соёрхов” гэж тэмдэглэж буй.

7 Сүбээдэйд төмөр тэрэг хэлхэж өгөөд Мэргидийн үлдэгдлийг устгахаар явуулсныг “Нууц товчоон”-ы (199 дүгээр зүйл)-д “мөн үхэр жил” гэж 1205 оны явдлаар тэмдэглэж байдаг билээ. Гэтэл “Биеэр дайлсан тэмдэглэл”-д: “улаагчин үхэр жил (1217 он) Чингис ану их өрлөг Сүбээдэй баатарыг төмөр бүрсэн хүрдтэй тэрэгтэйгээр Мэргидийг байлдуулж....” (монгол орчуулга, 59 нүүр) гэж тэмдэглэж байна. Бас энд “Ту Цзи-гийн тэмдэглэл”-ийг үндэслэж 1216 оны явдлаар тэмдэглэв. Энэ тэмдэглэлийн зүйтэй тал гэвэл, 1216 онд Түмэдийн бослогыг дарангуйлахаар томилсон Дөрбэй догшины цэрэг ба Зэв, Сүбээдэй нарын цэргийг хамтад нь Жочи-гийн баруун гарын цэрэгт захируулж байсан нь бүр тэмдэглэлтэй юм. Харин Сүбээдэй Мэргидийг устгасан нь 1217 оны үхэр жилийн явдал болно. Тиймээс “Биеэр дайлсан тэмдэглэл” нь устгасан жилээр нь тэмдэглэсэн байж бүр болох юм. Чингэвэл “Нууц товчоон”-ы тэмдэглэл нь бас энэ 1217 оны үхэр жилийг түрүүчийнх нь үхэр жилтэй нийлүүлээд тэмдэглэсэн шиг байна. Учир нь “Нууц товчоон”-д он жилийг эхлэн хэрэглэсэн нь 1201 оноос сая харагджээ. Тиймээс жилийн зүсийг ер тодорхойлсонгүй байдаг тул адил жилийг хутгахад тун хялбар юм.

8 Чингис хаан хөвгүүн дүү нартаа хувь хувилахдаа “Нууц товчоон”-д дөрвөн хөвгүүний нэрийг дурджээ. Энэ дөрвөн хөвгүүн бол бүр Чингисийн их хатан Бөртэ үжинээс төрсөн хөвгүүд болно. Гэвч “Юань улсын түүх, хааны угсааны цадиг”-ийг үндэслэвэл, Чингис хааны татвар хатнаас төрсөн Үрүчи, Хөлгөн гэдэг хоёр хөвгүүн байдаг юм. Энэ хоёрыг “Нууц товчоон”-д дурдсангүй, хувь хувилсангүй явдал бол татвараас төрсөн учир гэж нөхөр Дорнотив тайлбарлажээ. Гэтэл Хонда Санаинобу-гийн өгүүлэлд, Хөлгөнд дөрвөн мянган цэрэг хувилж өгсөн гэж тэмдэглэж буй.

Table of Contents

[Чингис хааны товчоон](#)

[Зохиогчийн товч тодорхойлол](#)

[Нэгдүгээр бүлэг](#)

[Хоёрдугаар бүлэг](#)

[Гуравдугаар бүлэг](#)

[Дөрөвдүгээр бүлэг](#)

[Тавдугаар бүлэг](#)

[Зурагдугаар бүлэг](#)